Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

2

Сэтгүүлийн редакцын зөвлөл

Сэтгүүлийн эрхлэгч:

Доктор, профессор Ц.Ганболд — Олон Улсын Мэдээлэлжүүлэлтийн Академийн академич

Сэтгүүлийн орлогч эрхлэгч:

Докторант, хурандаа Г.Галбадрах — Хилийн албаны сургуулийн захирал, хилийн цэргийн 0345 дугаар ангийн захирагч

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Докторант,
Хошууч Т.Баяр-Эрдэнэ — Хилийн албаны сургуулийн Инженер техникийн тэнхимийн профессор

Үүсгэн байгуулагч:
ОУМА-ийн академич, доктор, тэргүүлэх профессор, хурандаа Г.Дагважамц

Редакцын гишүүд:

Доктор, дэд профессор, хурандаа М.Баярсайхан

Докторант, хурандаа М.Мөнхбаяр

Доктор, хурандаа Х.Асхар

Докторант, дэд хурандаа М.Баттулга

Доктор, хурандаа Ц.Одонгэрэл

Докторант, дэд хурандаа Г.Одон-Ертөнц

Докторант, дэд хурандаа Б.Мөнгөнбагана

Дугаарыг эрхэлсэн: **Хэвлэлийн хуудас:20.5**

Докторант,
Хошууч Т.Баяр-Эрдэнэ

Хянан тохиолдуулсан:

Доктор, профессор, хурандаа Ц.Ганболд

Доктор, хурандаа Х.Асхар

Редакцийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, VIII хороо, Хилчний гудамж, ДХИС-ийн хичээлийн III байр, 518 тоот

Утас: 976 86008998

Цахим шуудан: hilsudlal@gmail.com

Эрхлэх байгууллага: Монголын Хил Судлалын Академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль, Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

МОНГОЛЫН ХИЛ СУДЛАЛЫН АКАДЕМИ, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛЬ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ СУДЛАЛЫН ТӨВИЙН ОНОЛ-МЭДЭЭЛЛИЙН СЭТГҮҮЛ

27 ДАХЬ ЖИЛДЭЭ
УЛИРАЛД НЭГ УДАА

№1 (тусгай дугаар)

2025 он

АГУУЛГА

А.Муратхан, Х.Асхар. Хилийн аюулгүй байдлын тухай ойлголт, үндсэн судлагдахуун
Ц.Ганболд, Б.Мөнгөнбагана. Хилийн аюулгүй байдлын олон улсын нөхцөл байдал, гадаадын зарим орнуудын туршлага, сургамж
Ц.Гансүх. Хиймэл оюун ухаан ба хил хамгаалалт
Л.Одзаяа. Монгол Улсын Төрөөс хилийн талаар явуулсан бодлого /XVII-XX зууны эхэн үе/
Г.Гантулга. Хил хамгаалах байгууллагын материал-техникийн хангалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага
Я.Ариунболд. Цэрэг техникийн бодлого
Д.Цэндсүрэн. Монгол Улсын хилийн нэгдсэн зохицуулалттай эрсдэлийн удирдлагын шинэ хандлага
Б.Гансүх. Хилийн боомтын эрсдэлийг бууруулах ажиллагааг сайжруулах арга зам
Х.Баасандорж. АНУ-ын хилийн аюулгүй байдал
А.Амгаланбаяр. Хилийн аюулгүй байдалд эдийн засгийн нөлөөлөл
Б.Рагчаа. Уул уурхайн үйл ажиллагааны хилийн аюулгүй байдалд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, анхаарах зарим асуудал
М.Баттулга. Хилийн аюулгүй байдалд БНХАУ-ын эдийн засгийн өсөлтөө хадгалах зорилгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үзүүлэх нөлөөлөл
П.Уянга. Хилийн аюулгүй байдлыг дипломат аргаар хангах тухай ойлголт:гадаадын зарим улс орны туршлага, сургамж
С.Энхчимэг, Х.Асхар. Хилийн боомтын эрх зүйн онолын ойлголтын зарим асуудал
Т.Ариунсүх. Хилчдийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг сайжруулах замаар хил хамгаалалтын үр дүнг дээшлүүлэх арга зам

Л.Лхагвасүрэн. Бүсийн нутгийн хангалтын төв бааз байгуулах, хэрэгцээ, шаардлага
Б.Мөнгөнбагана. Хилийн боомтын хөгжил ба гадаад орнуудын туршлага
Б.Ням-Очир. Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх боломж, олон улсын туршлага
О.Баттулга. Агаарын хил хамгаалалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага
Д.Отгонсүрэн, О.Долгорхүү, Б.Цолмон, Н. Гантогтох. Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын хөдөлмөр эрхлэлтэд хиймэл оюун ухааны хэрэглээ нөлөөлөх нь
Г.Одон-Ертөнц. Хил хамгаалалтын мэдээллийн технологийн үүрэг ба шинэчлэл
А.Золбоо. Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломж: байгалийн ховор элементийн хилийн хяналтын жишээн дээр
Э.Соронзонболд. Хил хамгаалах байгууллагад тэсэрч дэлбэрэх бодисын мэргэжилтэн бэлтгэх тогтолцоо: асуудал, шийдэл ба олон улсын стандартын нэвтрүүлэлт
Х.Түвшинтөгс. Суралцагч, оюутны биеийн тамирын боловсрол, эрүүл мэнд эрх зүйн тулгамдсан асуудал
М.Мөнгөнцэцэг. Орчин үеийн дайны эдийн засагт үзүүлэх нөлөө
Д.Түмэнцэцэг. Бие бялдрын шалгалт ба сэтгэлзүй, тэсвэр тэвчээрийн чухал ач холбогдол
Б.Хишигжаргал. Хилчин офицеруудын уян хатан чанар ба сэтгэл ханамжийн хамаарал
Н.Батзориг. Улсын хил хамгаалалтад нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ийг ашиглах, олон улсын туршлага
Э.Сандагжав. Хил хамгаалах байгууллагын шинэ автомашинуудын ашиглалт, засвар үйлчилгээний асуудал ба шийдэл
Б.Гомбосүрэн. Улсын хилийн аюулгүй байдлыг хангахад үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын гүйцэтгэх үүрэг
Г.Болортунгалаг. Профайлинг, түүнийг шалган нэвтрүүлэх албанд хэрэгжүүлэх нь
Ш.Ундарга. Роль инженерных заграждений в обеспечении безопасности государственной границы
Ц.Одонгэрэл. Хилийн аюулгүй байдлыг хангахад удирдах ажилтны манлайллын нөлөөллийн судалгаа
С.Нямжав. Хил хамгаалах байгууллагын алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ҮНДСЭН СУДЛАГДАХУУН

А.Муратхан
Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор (Ph.D), профессор, хурандаа

Х.Асхар
Дотоод хэргийн их сургууль, Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн профессор, доктор (Ph.D), хурандаа

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын хилийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д шинээр нэмэгдэж орсон “хилийн аюулгүй байдал” гэсэн томьёоллын үндэслэл, түүнийг гадаадын зарим оронд яаж ойлгох, хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт түүний илрэх хэлбэр, тэдгээрийг судалдаг хил судлалын шинжлэх ухааны энэ талаарх бүрдэл хэсэг, хилийн аюулгүй байдлыг хангах талаар Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын чиглэл зэргийг тайлбарлан оруулсан болно.

Түлхүүр үгс: хилийн аюулгүй байдал, эрсдэл, ашиг сонирхол, тогтолцоо, хилийн орон зай, хил орчмын нутаг дэвсгэр.

Удиртгал

Монголын ард түмэн улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс түүх соёлынхоо өв уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан байгуулахыг эрхэм зорилго (Legalinfo, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 1992) болгон үндсэн хуулиар хуульчилсан билээ.

Үндсэн хэсэг

Олон улсын харилцааны шинж чанар, уур амьсгал нааштайгаар өөрчлөгдсөн хэдий ч аюулгүй байдлын хамтын тогтолцоо бүрэлдэн бий болоогүй, улс болоод ашиг сонирхлын бүлэглэлүүдийн хооронд зөрчил, сөргөлдөөн үргэлжилсээр байгааг Орос-Украйн, Израйл-Хамасын хоорондын зэвсэгт мөргөлдөөн нотлон харуулж байна. Эдгээр олон улс болон бүс нутгийн хэмжээнд үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, улсын хилийн аюулгүй байдлыг хангаж, үндэсний язгуур эрх ашгаа урьтал болгосон, тогтвортой хөгжлийн асуудлаа шийдвэрлэх бие даасан бодлого, үйл ажиллагаа явуулах шаардлага тулгарч байна.

Дэлхийн улс гүрнүүд нийгмийн хөгжлийн жам ёсоор харилцаа холбоогоо бэхжүүлж байгаа боловч үндсэрхэг үзэл газар авч, үндэстэн ястан, шашин хоорондын зөрчил, мөргөлдөөн,

геополитикийн болон гео эдийн засгийн ашиг сонирхлын өрсөлдөөн гарсаар байна.

Монгол Улсын оршин тогтносон 2200 гаруй жилийн хугацаанд нутаг дэвсгэр хил, хязгаарын төлөө явуулсан тэмцлийн түүхээс харахад түүнд тал бүрээс учирч байсан аюул занал нь түүнийг хүн төрөлхтний түүхийн тавцангаас зайлуулах, нутаг дэвсгэрийг нь эзэмших, эс чадваас хил орчмын тодорхой газар нутгийг тасалж авах зорилго, чиглэлтэй явагдаж иржээ.

Хүн ам цөөн, газар нутаг өргөн уудам, нийгэм эдийн засгийн хөгжлөөр харьцангуй сул манай улсын хувьд өөрийн аюулгүй байдлыг хангахад нэн түрүүнд улсын хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх явдал юм гэдгийг өнгөрсөн үеийн түүхэн сургамж харуулж байна. 80 гаруй жилийн өмнө Японы милитаристуудын зүгээс Халхын голын чиглэлээр өдөөсөн дайны зорилго нь Монголын талаас эзэмшилгүй байсан хил орчмын газар нутгийг цэргийн хүчээр эзэмших, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн болон хилийн аюулгүй байдалд ноцтой нөхөж баршгүй хохирол учруулахын төлөө явагдсаныг бид мартаагүй байна.

Өнөөдөр хөдөөгийн хүн амын ихэнх нь төв рүүгээ нүүдэллэж олонх нь нийслэлд амьдрах болсноор хил орчмын нутаг дэвсгэр эзэнгүйрч байна. Судалгаагаар Монгол Улс нийт 3 сая 457 мянга 548 хүн амтай, үүний 45 орчим хувь буюу улсын нийслэл Улаанбаатар хотод 1,591,375 иргэн амьдарч байна. (IOM, 2022)

Экологийн нөхцөл байдалд нүүрлэж буй цөлжилт говийн бүсийг төдийгүй тал хээр, ойт хээрийн бүс нутгийг хамарч байгаагаас хүн амын амьдрал ахуйд нөлөөлж, хилийн дагуу асар уудам газар нутаг эзэнгүйрч улсын хил хамгаалалтад шууд нөлөөлөх болов.

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн эздрээтэй бодит үзэгдэл мөн бөгөөд түүнийг айл зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллагатай хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулан хэрэгжүүлдэг онцлогтой юм.

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна” гэж заасны дагуу зэргэлдээх улсуудтайгаа сайн хөршийн нөхөрсөг харилцаа тогтоож, дэлхийн улс бүхэнтэй олон улсын эрх тэгш, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан нээлттэй харилцах гадаад бодлого баримталж байна.

Монгол Улс нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай улсын хилийн асуудлыг XX зууны сүүлийн хагаст бүрэн шийдвэрлэж, баталгаажилтыг нь хүлээн зөвшөөрснөөр олон улсын эрх

зүйн үндэс бүрдсэн байна. Цаашид тогтоон тэмдэглэж, баталгаажсан хилийг өөрчлөхгүй, зөрчилгүй, олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн манах, хамгаалах ажиллагааг улам боловсронгуй болгох нь манай хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг мөн.

Олон улсын хэмжээнд хилийн аюулгүй байдлыг хилийн орон зай (улсын хил, хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэр)-д төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхол хамгаалагдсан байх нөхцөлийг хэлдэг бөгөөд хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болдог байна.

Тиймдээ ч Монгол Улсын хилийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д "*хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ", "хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн*" (Legalinfo, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2016) гэж заасан нь зарим гадаад улсын томьёололд нийцэж байна.

Дүгнэлт

Улсын Их Хурлаас баталсан "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого" баримт бичигт "Хилийн талаар баримтлах бодлого нь байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэнэ" гэж заасан. Энэ нь хилийн аюулгүй байдлыг агуулгын хувьд бүрэн хамарч чадаагүй байжээ гэсэн дүгнэлтэд хүрч болох юм.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн" (Legalinfo, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2016) гэж заасан боловч, энэ талаар тусгайлан судлагдаагүй, түүнийг хангах онол, арга зүй болон ямар арга хэмжээ авах үндэслэл, аргачлал одоогоор боловсрогдоогүй, эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Монгол Улсын хил хамгаалах байгууллага нь хилийн тухай хуулийн дагуу хилийн орон зай /улсын хил, хилийн бүс, зурвас, хил орчмын нутаг дэвсгэр/-д үйл ажиллагаа явуулж байгаа боловч тэнд хилийн аюулгүй байдлыг хангах, тэрхүү орон зайг хамгаалах, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөлийг хэрхэн, яаж баталгаатай хангах талаар нэгдсэн ойлголтод хүрээгүй, энэ талаар хийгдсэн цогц судалгаа одоогоор байхгүй байна**.**

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тэр дундаа хилийн аюулгүй байдлыг хангах

гадаад, дотоод таатай орчин бүрдэж байгаа боловч улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, түүнд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийг багасгах нь чухал байна.

Улсын хил нь нэгэнт хоёр улсын нутаг дэвсгэрийн зааг болохоор тус тусын нутаг дэвсгэр, ялангуяа хил орчмын нутаг дэвсгэр дээрх амьдрал үйл ажиллагаа, эд баялгийн ашиглалт нь тухайн улсын эрх мэдэлд хамаарагдана.

Чухам хилийн аюулгүй байдал гэдэг нь юу болохыг ойлгохын тулд улс оронд тулгарч байсан түүхэн болон тулгарч байгаа өнөөгийн аюул заналыг ухамсарлан ойлгох зайлшгүй шаардлагатай юм.

Аль ч улсын үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болсон хилийн аюулгүй байдлыг хэрхэн, яаж ойлгож байгаа талаар тодорхой түвшинд нэгтгэсэн ойлголт ховор бөгөөд зарим судлаачид хилийн аюулгүй байдлыг цэргийн аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт оруулж иржээ.

Эх сурвалж

IOM. (2022). *Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага.* Улаанбаатар.

Legalinfo. (1992 оны 01 13). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Монгол Улсын Үндсэн хууль: https://legalinfo.mn/mn/detail?lawId=367-ээс Гаргасан

Legalinfo. (2002 оны 05 16). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Төрөөс хилийн талаар баримтлах бодлого: https://legalinfo.mn/mn/detail?lawId=6493-ээс Гаргасан

Legalinfo. (2010). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал: https://legalinfo.mn/mn/detail?lawId=6163-ээс Гаргасан

Legalinfo. (2016 оны 12 28). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Монгол Улсын хилийн тухай хууль: https://legalinfo.mn/mn/detail?lawId=12418-ээс Гаргасан

zakon.kz, O. (с изменениями и дополнениями 2024 оны январь 05). *Юрист*. Электронное правительство: https://online.zakon.kz/Document/?doc_id=31320511&pos=2;-106#pos=2;-106-ээс Гаргасан

Арвай, Ш. (2013). *Улсын хил, хязгаарын аюулгүй байдал, тулгамдсан асуудлууд шийдвэрлэх арга зам* . Улаанбаатар: Мөнхий үсэг ХХК.

портал, и. (2008 оны 07 21). *Государственной Пограничной комитет Республики Белорусь*. О Государственной границе Республики Беларусь: https://gpk.gov.by/zakonodatelstvo/laws/-ээс Гаргасан

фонд, Э. (с изменениями на 2022 года оны ноябрь 04). *Электронный фонд правовых и нормативно-технических документов*. О Государственной границе Российской Федерации: https://docs.cntd.ru/document/9033575-ээс Гаргасан

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ТУРШЛАГА, СУРГАМЖ

Ц.Ганболд
ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын төвийн ахлах судлаач, доктор (Ph.D), профессор, хурандаа

Б.Мөнгөнбагана
ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн Хилийн албаны тэнхимийн профессорын үүргийг түр орлон гүйцэтгэгч, докторант,
дэд хурандаа

Товч агуулга:Аливаа улсын хилийн аюулгүй байдал нь улсын хилээ хамгаалах цогц үйл ажиллагаагаар хангагддаг бөгөөд тухайн улсад тохирсон өвөрмөц үйл ажиллагааны онцлогоор ялгарч байдаг.

Энэхүү илтгэлд дэлхийн зарим улс орнуудын хилийн аюулгүй байдлаа хангах, хил хамгаалалтын чиглэлээр авч хэрэгжүүлж буй туршлагыг судалсан.

Түлхүүр үгс: Хилийн аюулгүй байдал, улсын хил, хил хамгаалалт

Аливаа улс үндэстний хувьд хилийн аюулгүй байдлаа хангана гэдэг нь юуны өмнө төрийн тусгаар тогтнол, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдал, ард иргэдийнхээ оюун санааны нэгдмэл чанарыг хилийн орон зайд хамгаалан бэхжүүлэхээс эхлээд өөрийн ашиг сонирхол, хилийн халдашгүй дархан байдлыг бусдаар хүлээн зөвшөөрүүлэх төдийгүй түүний баталгаатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй олон талтай, баялаг агуулгатай улс төр-дипломат, тагнуул, цэрэг, эдийн засгийн цогц бодлого, арга хэрэгсэл, үйл ажиллагааны нэгдэл юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах бодлогыг сонгох нь ихэвчлэн хилийн тодорхой онцлогууд болох: хилийн урт, хил орчмын газар орны онцлог, хил дамнасан урсгалын ачаалал, зэргэлдээ нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засаг, соёлын шинж чанар, аюулгүй байдлын тулгамдсан бэрхшээл зэргээр тодорхойлогддог. Хилийн аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ хил дамнасан эрчимтэй урсгалыг үр дүнтэй зохицуулах асуудал нь олон улс орнуудад тулгарч байна. Хилийн аюулгүй байдлыг хангах талаар авч хэрэгжүүлж буй зарим улс, орнуудын туршлага судалсан. Үүнд:

1. БНХАУ-ын хил хамгаалалт:

БНХАУ нь Монгол Улсын хөрш бөгөөд түүний төрийн бодлого үйл ажиллагаанаас манай улсын үндэсний аюулгүй байдал, ялангуяа төрөөс улс орны тусгаар тогтнол бүрэн эрх, нутаг

дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдлыг хангах бодлого, үйл хэрэгт сөргөөр нөлөөлж ирсэн түүхтэй. Энэ шинж байдал, зүй тогтол нь тус улсын ирээдүйн хувь заяа, хөгжил эх орны аюулгүй байдал, тэр дотроос улсын хил, хил орчмын нутагт үндэсний аюулгүй байдлыг хангах таатай нөхцөл бүрдүүлэхэд хүчтэй нөлөөлсөн хэвээр байна (Ш.Арвай, А, Д, & Н, 2016).

Монгол Улс, БНХАУ-ын хооронд 1949 оны 10 дугаар сарын 16-нд дипломат харилцаа тогтоосон. Хоёр талын харилцаа 1949-1962 онд шинээр төлөвшин хөгжиж, Монгол Улс, БНХАУ-ын хилийн гэрээг анх 1962 онд байгуулж, 1988, 2010 онд шинэчлэн батламжилж, Монгол-Хятадын хилийн нэг дэх удаагийн хамтарсан шалгалтыг 1982-1984 онд, хоёр дахь удаагийн хамтарсан шалгалтыг 2001-2004 онд зохион байгуулсан (П.Сүндэв, 2006). Манай улстай 4709,6 км хэсгээр хилээ албан ёсоор тогтоож, НҮБ-аар баталгаажуулсан. Монгол Улс, БНХАУ-ын хооронд 1994 онд “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай” гэрээг шинэчлэн байгуулсан (П.Сүндэв, 2006). Энэхүү гэрээ нь хоёр улсын одоогийн харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Монгол Улс, БНХАУ-ын хооронд 1994 онд Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээний 1 дүгээр зүйлд: “Хэлэлцэн тохирогч талууд бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтлох, дотоод хэрэгт үл оролцох, эрх тэгш, харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр хоёр улсын сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ” (П.Сүндэв, 2006) гэж заасан нь хоёр улсын харилцааны суурь зарчим болж байна.

1949-2015 онд хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлуудыг зохицуулсан 450 гаруй гэрээ байгуулагдсанаас 200 гаруй гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна.

БНХАУ-ын үндсэн хууль (П.Сүндэв, 2006) -д зааснаар зэвсэгт хүчин нь Хятадын ардын чөлөөлөх арми /ХАЧА/, Ардын зэвсэгт цагдаа /АЗЦ/, мөн нөөц хүчин гэсэн гурван салбар хэсгээс тогтолцоо нь бүрддэг.

ХАЧА нь одоо 2 сая 255 мянган цэрэгтэй. Дотроо хуурай замын цэрэг /ХЗЦ/, Агаарын цэргийн хүчин /АЦХ/, Пуужинт цэргийн хүчин /ПЦА/- ээс тус, тус бүрдэнэ.

Хятад улс нь өөрийн үндэсний цэргийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, техник, зэвсэг, хэрэгслээр өөрийгөө бүрэн хангадаг онцлогтой (Б.Даваадорж, 2011).

БНХАУ-ын иргэн бүр эх орноо батлан хамгаалах үүргийг нэр төрийн хэрэг гэж үздэг, бүх нийтээр цэргийн алба хаах

тогтолцоотой улс юм .Жил бүр цэргийн албанд бүртгэгдсэн 18-22 насны 12 сая эрчүүдээс шаардлагатай тоогоор цэрэг авдаг. 36-45 насны эрчүүдийг цэргийн албанд татвал 400 сая цэрэг албанд мордох дайчилгааны нөөцтэйгөөс 200 сая ямар ч бэрхшээлгүй албанд тэнцэнэ гэж үздэг. БНХАУ-д цэргийн алба нь жинхэнэ алба, бэлтгэл үүрэгтэн, мөн иргэний цэрэг /цэргийн алба хаах бололцоотой боловч жинхэнэ алба хаагаагүй иргэд/ гэсэн 3 хэсгээс бүрддэг байна.

Бэлтгэл үүрэгтэн иргэний цэрэг нь хэдийгээр цэргийн бус ч орон нутаг, дүүрэг, сум, гацаанд бүртгэлтэй, тасаг салаа, суман, анги, нэгтгэлийн. зохион байгуулалттай, зэвсэглэл техник нь тодорхой цэргийн анги баазад хадгалагдаж байдаг учраас 2-5 долоо хоногийн дотор байлдааны ажиллагаанд шилжихэд бэлэн байхаар бэлтгэгдсэн байдаг. Дарга нарын боловсролыг дунд, дээд гэж ялган 300 гаруй цэргийн мэргэжлээр 4 жилээс доошгүй хугацаагаар сургаж 200 мэргэжлээр бакалаврын боловсрол олгон төгсөхөд нь дэслэгч цол олгодог байна. Офицеруудыг шат ахиулан бэлтгэх тогтолцоо одоо ч хэвээр байдаг (П & Плименко А, 2014).

“Стратегийн хил хамгаалах бодлого”-ыг хэрэгжүүлэхэд иргэний цэрэг гэж нэрлэдэг олон нийтийн цэрэгжүүлсэн байгууллага нь улсын хил чухал объект, дэд бүтэцтэй газруудыг хамгаалах, нийтийн хэв журам сахиулахад ХАЧА ба Хилийн цэргийн анги салбарт туслах, дайны үед дайчилгааны нөөцийг бүрдүүлж цэрэг армийн байлдааны ажиллагаа, ар талыг хангахад оролцох үүрэг хүлээдэг ба улсын хил манах, хязгаар нутаг, улс, нийгэм ард түмний эрх ашгийг хамгаалах явдал нь Хятадын төрийн бодлогод улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах бодлогын нэгдмэл нэгдмэл шинжийг илэрхийлдэг[1].

Асар хүчтэй, найдвартай үндэсний батлан хамгаалах салбарыг хөгжүүлэх нь БНХАУ-ын цэргийн шинэчлэлийн стратегийн гол зорилтын нэг бөгөөд улсын ерөнхий төлөвлөгөөний дагуу үндэсний батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчнийг шинэчлэх стратегийг:

1. 2010 онд бат бэх суурийг тавьсан байх
2. 2020 онд харьцангуй өндөр хөгжилд хүргэх
3. 21 дүгээр зууны дунд үе гэхэд Зэвсэгт хүчнийг мэдээлэл зүйн технологи ашигласан дайнд ялалт байгуулахаар төлөвлөн хэрэгжүүлж байна[2].

[1] Ш.Лхачинжав. “Хил хамгаалалтын тогтолцоонд орон нутгийн засаг захиргаа, ард иргэдийг оролцуулах ажиллагааг боловсронгуй болгох нь” диссертац 2004 он.

[2] Б.Даваадорж. Хятадын чөлөөлөх арми өнөө ба ирээдүй. УБ. 2011.

БНХАУ-ын “Цэргийн шинэчлэлийн бодлого”-ын хүрээнд 2019 онд Хятадын ардын чөлөөлөх армийн бүтцэд өөрчлөлт оруулснаар Цэргийн төв зөвлөл нь бүтэц, зохион байгуулалт /бүдүүвч №1/-ын хувьд ерөнхий газар 7, хороо 3, ажлын алба 5, стратегийн байлдааны тойрог 5, төрөл мэргэжлийн 5 цэрэгтэй болж өөрчлөгдсөн.

БНХАУ-ын хил хамгаалах чиг үүргийг Батлан хамгаалах дайчилгааны ерөнхий газар хэрэгжүүлэх болсон ба ХАЧА-ийн стратегийн байлдааны 5 тойргоос Монгол Улстай хиллэдэг хэсэгт Баруун бүсийн болон Хойд бүсийн байлдааны тойргууд хил хамгаалалтыг зохион байгуулж байна[1]. Үүнд:

- БНХАУ-ын Баруун бүсийн байлдааны тойрог нь Шинжаан, Си Чуан, Чун Чинь, Ганьсу, Төвд, Ниньша, Чинхайн цэргийн тойргуудыг удирддаг. Шинжааны цэргийн тойргийн Алтайн, Цонжийн, Хамигийн хилийн төлөөлөгч нар баруун уулзварын цэгээс Монгол-Хятадын хилийн 500 дугаар тэмдэг /хилийн 7 дугаар отрядын хариуцсан хэсэг/ хүртэлх 1518,6 км хилийн хэсгийг хариуцан хил хамгаалалтыг зохион байгуулдаг.
- Хойд бүсийн байлдааны тойрог нь манай улсын зүүн болон өмнөд хэсэгтэй хил залгаж, Далай хөвийн, Эрээний, Улиастайн, Амгалан, Манжуурын хилийн төлөөлөгч нар Монгол-Хятадын хилийн 500 дугаар тэмдгээс зүүн уулзварын цэг хүртэлх 3191 км хэсгийг хариуцан хил хамгаалалтыг зохион байгуулж байна.

БНХАУ-ын Засгийн газрын тогтоолоор 2018 оны 03 дугаар сард НАХЯ-ны харьяа Хил хамгаалах байгууллагад бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт явуулж БНХАУ-ын Цагаачлалын удирдах газрыг НАХЯ-ны бүтцэд байгуулж 2018 оны 04 дүгээр сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Хятадын хил хамгаалалт дараах онцлогтой байна. Үүнд:

- ✓ Эдийн засгийн давуу талаа ашиглан хилийн инженер техникийн хангалтыг үндсэндээ шийдсэн. Хилийн дагуу 2м өндөртэй бетонон шонтой торон хашааг босгосон. Хилийн дагуух замаа бүрэн засварласан. Хилийн станц, ротууд ачааны болон суудлын автомашин, мотоцикл, цасны чарга өргөн ашиглах болсон. Говь, тал хээрийн бүсэд бие биеэ харсан хянах цамхгууд байгуулсан.
- ✓ Улсын хилийг Хятадын ардын чөлөөлөх армийн анги нэгтгэлүүд хамгаалж, шалган нэвтрүүлэх боомт, түүний зурвас, гүнийг НАХЯ-ны хилийн цэрэг хамгаалдаг.

[1] МУ-ын ҮАБЗ-ийн Стратеги судлалын хүрээлэн “ Шинэ эриний хятадын батлан хамгаалах цагаан ном-2019” 2021 он.

✓ Хятадууд улс төр, дипломатын аргаар улсын хилийг хамгаалахад онцгой анхаарч байна.

✓ Улсын хилийг өдрийн цагт тусгай төхөөрөмжилсөн хянах цамхгаас хянаж, шөнийн цагт хилийн манаагаар хил хамгаалалтыг зохион байгуулж байна.

✓ Хил хамгаалалтайд тагнуулын байгууллага асар том үүрэг гүйцэтгэж байна. Тагнуулын ажилтнууд хилийн төлөөлөгчийн орлогчийн хэмжээнд ажилладаг бөгөөд тэд их эрх мэдэлтэй байгаа нь ажиглагддаг.

✓ Хил орчмын ард иргэдийг хил хамгаалалтад тусгай үүрэгтэйгээр оролцуулж тэднийг хилийн цэрэг байнга шалгаж үүрэгжүүлж байдаг.

✓ Хилийн тухай хууль тогтоомжоо чангатгасан. Хилийн дэглэм зөрчсөн, малаа хил давуулсан хүмүүст өндөр торгууль оногдуулдаг. Иймээс иргэд хилээ, хилийн цэргээ хүндэтгэдэг.

✓ Хилийн албаны гол гол албан тушаалд хятад хүмүүс томилогдсон хэвээр байна.

✓ Хил дээр ажиллаж буй албан хаагчдын цалин хангамжийг байнга нэмэгдүүлж байна. Хилчид авилгалд өртөх, хилийн зөрчилд холбогдвол тухай бүрд нь арга хэмжээ авч байна.

✓ ХАЧА болон дотоодыг хамгаалахын цэргийн албан хаагчдын улс төр байлдааны бэлтгэл сургуульд ихээхэн анхаарч байна. Хилийн уулзалт хэлэлцээний үед буудлага хийлгэх, олон төрлийн дасгал гимнастик хийж үзүүлэх зэргээр өөрийн цэргийн сүр хүчийг гайхуулдаг болсон.

2. Оросын Холбооны Улсын хил хамгаалалт:

БНХАУ нь Монгол Улсын хөрш бөгөөд манай улстай хиллэдэг хилийн хэсэгт ОХУ-ын Холбооны Хилийн албаны Өвөрбайгалийн бүс нутгийн удирдах газрын Акташ, Кызыл, Хиагт, Мангут, Даурын хилийн отряд улсын хилийн хамгаалалтыг явуулж байна. ОХУ-ын Хакасын нийслэл Абакан хотод Акташ, Кызылийн хилийн отрядыг, Чита мужийн Акшийн районы төв Акша хотод Хиагт, Мангут, Даурын отрядуудыг тус тус шуурхай удирдлагаар хангах үүрэг бүхий оператив цэргийн бүлэг ажилладаг[1].

Хилийн отряд бүр хилийн төлөөлөгчийн аппараттай юм. Хилийн төлөөлөгчийн аппарат нь хилийн хамгаалалтыг удирдан зохион байгуулдаг бөгөөд хилийн хамгаалалтаа хилийн отряд, заставуудын бие бүрэлдэхүүн, инженер техникийн хэрэгсэл, орон нутгийн туслах хүчин, гүйцэтгэх ажлын хүч хэрэгсэлд тулгуурладаг. Хилийн

[1] В. В. Кудинов. Защита и охрана государственной границы: проблемы Конституционноправового регулирования. 2015г.

төлөөлөгчийн аппарат нь хилийн отрядаа, хилийн отряд нь коминдатураа, коминдатур нь хилийн заставуудаа өдөр тутмын удирдлагаар хангаж ажилладаг байна.

Оросын Холбооны Улсын хил хамгаалалт дараах онцлогуудтай байна. Үүнд:

✓ Улсын хилийг гүйцэтгэх ажлын хэрэгслээр хамгаалах, халхлахад онцгой анхаардаг. Энэ нь хил хамгаалалтын гол арга хэлбэр болсон.

✓ Улсын хил хамгаалалтад орон нутгийн ард иргэд, хилийн цэрэгт туслах хүчийг өргөнөөр ашиглахын зэрэгцээ сайн дурын ардын тусгай бүлэг, казакуудын уламжлалт бүлгүүдийг (казачество) зохион байгуулан удирдлагаар ханган ажиллуулж байна.

✓ Улсын хил хамгаалалтад орон нутгийн байгууллага, удирдлагуудын оролцоог шефийн холбоо тогтоох хэлбэрээр өргөн ашиглаж эдийн засгийн ихээхэн туслалцааг авдаг.

✓ Хилийн төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулах үүргийг отрядын удирдлагаас салган тусгай мэргэшсэн бүрэлдэхүүнээр явуулдаг болсон.

3. Израил улсын хил хамгаалалт

Израил улс нь улсынхаа хил хамгаалалтыг үндсэндээ техникжүүлсэн бөгөөд хил хамгаалалтын түвшнээрээ дэлхийд дээгүүрт тооцогддог. Иймээс хөрш зэргэлдээ орнуудын хил хамгаалалтын зэрэгцээ хил хамгаалалтыг сайн зохион байгуулдаг зэвсэг техникээрээ дэлхийд дээгүүр тооцогдох болсон.

Энэ байгууллага нь зарим талаараа зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэдэг боловч, БХЯ-нд шууд захирагддаггүй. Мөн Франц, Итали, Испанитай адил Дотоод явдлын яамандаа захирагддаггүй. Харин Үндэсний цагдаагийн бүрэлдэхүүн хэсэг юм.

Хил хамгаалалтын өдөр тутмын удирдлагыг түүний дарга хангадаг бөгөөд Үндэсний цагдаагийн ерөнхий байцаагчид захирагддаг. Хил хамгаалах байгууллага нь 1953 онд байгуулагдсан бөгөөд түүний үйл ажиллагаа төрийн хууль тогтоомжийн дагуу зохицуулагддаг, байгуулагдсаныхаа эхэн үед нүүдэлчин омог бедунчуудын улсын хилийг хууль бусаар зөрчих явдалтай тэмцэхэд чиглэгдсэн байжээ.

Цаг хугацаа өнгөрөх тусам байгууллагын үүрэг улам өргөжин өөрчлөгдөх болов. Энэ нь Израйл улс болон түүний эзэлсэн нутаг дэвсгэр дээр алан хядах ажиллагаа ихэссэн мөн Палестины болон Ливаны "Хезболлох" зэвсэгт бүлгүүдийн үйл ажиллагаа хил орчмын нутаг дэвсгэрт идэвхэжсэнтэй холбоотой.

Орчин үед Израйлын ХХБ нь сайн сургаж бэлтгэсэн сайтар зэвсэглэгдсэн бие бүрэлдэхүүнтэй анги, салбарууд нь үндсэндээ 1967, 1973 оны Араб, Израйлын

дайны дараах эзэлсэн нутаг дэвсгэрүүд болон Тель - Авив, Иерусалим хотуудад байрладаг.

1974 оноос хойш Засгийн газрын шийдвэрээр Израйлын хилийн цэрэг хот болон хөдөөгийн районы аюулгүй байдлыг хангах агаарын болон далайн усан боомт, улс ардын аж ахуй, үйлдвэр, хөдөө аж ахуй, дэд бүтцийн онц чухал объектуудыг хамгаалах болсон.

Гадаадын цэргийн мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар Израйлын хилийн цэрэг өнөөдрийн байдлаар алан хядах ажиллагаатай тэмцэх гол хүч болжээ.

Мөн тодорхой үүргийн хүрээнд зэвсэгт хүчин болон цагдаагийн зарим үүргүүдийг биелүүлдэг байна. Тухайлбал: Иордан голын баруун эрэг болон газын зурваст дэг журам сахиулах, Палестины нутаг дэвсгэрт армийн анги салбарууд тусгай ажиллагаа явуулахад туслах, Палестины цагдаагийнхантай хамтарсан эргүүл хийх, онц чухал объектыг хамгаалах гэх мэт.

Хил хамгаалах байгууллага нь мөн цагдаагийн ердийн үүргийг биелүүлж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг сахиулах сайн дурын байгууллагатай ажиллах зэрэг үүргийг гүйцэтгэдэг бөгөөд цагаачдын хөдөлгөөнд хяналт тавих, төмөр зам, агаарын болон усан замын буудлуудад дэг журам сахиулах, агаар, усан, хуурай хилээр нэвтрэх ажиллагааг хянах, дамын наймаа, хар тамхитай тэмцэх, тусгай албадын ашиг сонирхолд зориулан хилийн зурвас дахь цагийн байдлын мэдээг цуглуулан боловсруулах үүрэгтэй.

Мөн байгалийн гамшиг болон бусад шаардлагатай нөхцөлд аврах, сэргээн босгох ажиллагаанд оролцох үүрэг хүлээдэг. Хилийн хамгаалалтад 8000 хүн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үндсэндээ ЗХУ болон Эфиопоос гаралтай еврейчүүд юм.

Бие бүрэлдэхүүний 12 хувь буюу 960 орчим нь үндэсний цөөнхийн төлөөлөл, ХЦ-т алба хаах хугацаа 3 жил, 1996 оноос эхлэн ХЦ-ийн байлдааны анги салбарт эмэгтэйчүүд алба хаадаг болсон. Хил хамгаалах байгууллагын дарга нь 6 бүс нутгийн удирдлагаас бүрдэх штабаар дамжуулан удирдлагыг зохион байгуулдаг хил хамгаалалтын байгууллагын анхан шатны нэгж нь рот бөгөөд алан хядах ажиллагаатай тэмцэх, нийгмийн дэг журмыг сахиулах болон бусад ажиллагааг чадварлаг гүйцэтгэдэг. Гол сургалтын төв нь Иерусалим хотын ойролцоо Бейт-Хоронд байрладаг.

Сургалтын төлбөр нь цагдаагийн ажиллагаа болон хуурай замын цэргийн тактик ажиллагаанд сурахад чиглэдэг. Алан хядах ажиллагаатай тэмцэх тусгай асуудлыг Үндэсний цагдаагийн сургуульд судалж, хотын нөхцөлд байлдаан явуулах,

тактик ажиллагаа, барилга байгууламж, объектыг дайран эзлэх, төр засгийн өндөр албан тушаалтнуудыг хамгаалах арга ажиллагаанд сургадаг. Сургалтыг байлдааны ойртуулсан нөхцөлд явуулж, буудлагыг будагтай сумаар үйлддэг. Ердийн хил хамгаалах анги, салбараас гадна тусгай салбарууд үүрэг гүйцэтгэдгээс хамгийн том нь "Ямам " юм.

1974 онд байгуулагдсан энэ анги нь барууны цэргийн мэргэжилтнүүдийн дүгнэлтээр бол дэлхийн хамгийн сайн бэлтгэгдсэн тусгай салбаруудын нэг бөгөөд алан хядах ажиллагаатай тэмцэхэд арми, цагдаад туслах, барьцаалагчдыг чөлөөлөх, төр засгийн тэргүүнүүдийг алан хядах ажиллагаанаас хамгаалах тусгай үүргийг биелүүлдэг[1].

Хил хамгаалах анги, салбар, цэргүүд нь тусгай хэрэгслээр сайтар хангагдсан бөгөөд хамгаалалтын малгай, хантааз, орчин үеийн холбооны хэрэгсэл, дуу чимээний ба хийн гранат, шөнийн дуран харааны хэрэгсэлтэй бөгөөд туулц сайтай, хуягласан, сум үл нэвтрэх шилтэй, шатаах зэвсгээс бүрэн хамгаалагдсан "Суфа " маркийн жийп автомашин ашигладаг.

Сүүлийн үеийн хил хамгаалалтад хилийн инженерийн ажлыг гүйцэтгэх зориулалттай мини-тракторуудыг өргөнөөр ашиглаж байна.

Израйл улс нь улсын хилээ компьютерын бүрэн хяналтад авсан бөгөөд уг систем нь нэг оператор нь компьютерын тусламжтайгаар 250км урт хилийн хэсгийг хянах, мэдээллийг цуглуулах боломжтой. Хяналт хийхэд хүндрэлтэй хэсгийг шалгахдаа операторын удирдлагаар нисгэгчгүй нисэх онгоц хөөргөн зураг авч, боловсруулалт хийн цагийн байдлыг үнэлдэг. Уг онгоц агаарт тасралтгүй 3 цаг нислэг үйлдэх боломжтой[2].

Хил хамгаалах байгууллага нь Израйлын аюулгүй байдлыг хангах, улсын хилийг хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлж байна гэж гадаадын цэргийн мэргэжилтнүүд өндрөөр үнэлсээр байна.

Израйл улсын хил хамгаалалт нь дараах онцлогуудтай байна. Үүнд:

✓ Улсын хилээ техникийн бүрэн хяналтад авсан. Энэ нь өртөг өндөртэй боловч нэгэнт байгуулагдсан тохиолдолд хүн

[1] Доклад секретариата Конференции Организации Объединенных Наций по торговле и развитию об экономических последствиях израильской оккупации для палестинского народа: бремя дополнительных ограничений в зоне С, 2000–2020 годы.

[2] С.В. Мелконян. Политика государства израиль в отношении Сирийской арабской республики (2009–2019 гг.), диссертация на соискание ученой степени кандидата исторических наук, специальность 5.6.7. – история международных отношений и внешней политики

хүч хэмнэсэн, ашигт үйлийн коэффициент өндөр, найдвартай хамгаалалт, халхлалтыг бий болгодог.

✓ Хүн нэг бүр, анги салбаруудын бэлтгэлийн түвшин өндөр, орчин үеийн зэвсэг техник хэрэгслээр бүрэн хангагдсан.

✓ Хил хамгаалах байгууллага нь улсын хил хамгаалалтаас гадна тусгай үүргүүдийг гүйцэтгэдэг бөгөөд уг чиглэлээрээ өндөр дадлага чадвар эзэмшсэн, мэргэшсэн.

✓ Хил хамгаалах байгууллагын дарга нь бүс нутгийн удирдлагаар дамжуулан удирдлагыг зохион байгуулдаг.

4. Америкийн нэгдсэн улсын хил хамгаалалт

АНУ 2002 онд Дотоод аюулгүй байдлын тухай хуулийн баталснаар Дотоодыг аюулаас хамгаалах яам байгуулагдаж хилийн аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээх болсон. Тус яам нь хилийн хяналтад шинэ технологи нэвтрүүлэх, хөгжүүлэх бодлого, стратегийг хэрэгжүүлдэг. Хилийн аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр нисгэгчгүй нисэх хэрэгсэл /дрон/, мэдрэгч системүүд, хяналтын камеруудыг ашиглаж байна.

АНУ-ын хил, гаалийн хяналтын алба нь хилийн аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор автономит хяналтын цамхгуудыг хилийн дагуу байрлуулж сэжигтэй хөдөлгөөнийг хиймэл оюун ухаан ашиглан илрүүлэх, хилийн хяналтад нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашиглаж, алслагдсан болон бартаатай хэсэгт хяналт тавьж, хилийн боомтуудад биометрийн төхөөрөмжүүдийг өргөнөөр ашигласнаар АНУ-ын хилийн аюулгүй байдал, хяналт сайжирч, хууль бус үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чадвараа нэмэгдүүлсэн.

АНУ-Мексикийн хилийн хамгаалалтын хамгийн удаан хугацааны туршлагаас үзэхэд хилийн хяналтыг огцом чангаруулах нь урьдчилан тооцоолоогүй сөрөг нөлөө үзүүлж болохыг харуулж байна.

АНУ-ын засгийн газраас 1990-ээд он, 2000 оны эхэнд авч явуулсан өргөн хэмжээний арга хэмжээ нь үнэндээ өмнө нь Мексикээс ирээд буцдаг байсан түр зуурын хууль бус цагаачдыг үй олноороо АНУ-д суурьшиж үлдэхэд хүргэсэн юм.

Нэр хүнд бүхий эрдэм шинжилгээний байгууллага[1]-ын, судалгааны дүнгээр 1995 оноос 2004 он хүртэл АНУ-д амьдардаг хууль бус цагаачдын тоо 2.2 саяас 6.2 сая болж өссөн байна[2].

Үүнээс гадна хууль бус

[1] "The Pew Research Center for the People & the Press"

[2] Passel J. Size and Characteristics of Unauthorized Migrant Population in the U.S. Estimates Based on the March 2005 Current Population Survey. Pew Hispanic Center: http://pewhispanic .org/reports/report.php?ReportID=61

цагаачдыг зөөвөрлөх нь ашигтай, далд бизнес болон хувирч хилийн саад тотгорыг даван туулахад мэргэшсэн Мексикийн мафийн бүлгийн нөлөөг урьд хожид үзэгдээгүйгээр бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан байна[1].

Мансууруулах бодис худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор хилийн саад байгуулах нь бүр ч үр дүн муутай бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтнүүд хар тамхи, мансууруулах бодисыг хилийн шалган нэвтрүүлэх боомтоор гаргах илүү сонирхолтой байдаг. Учир нь овор багатай барааг хил дамнасан их хэмжээний урсгалд нуух нь түүнийг илрүүлэх хилчдийн чадавх, боломжоос хэд дахин давдаг, зарим хар тамхи зөөвөрлөгчид баривчлагдах нь мансууруулах бодисын зохион байгуулалттай бизнест шальтай хохирол учруулдаггүй байна.

Хилийн саадыг нэвтрэхийн тулд мансууруулах бодисын гэмт хэргийн бүлэглэлийнхэн, хууль бус цагаачид шууданч шувуу ашиглах, хилийн торон саад доогуур шуудуу ухах, мансууруулах бодис шидэж давуулах гэх мэт аргуудыг хэрэглэдэг. Энэ тохиолдолд хилийн хаалт, саад босгох нь маш өндөр өртөгтэй, үр ашиг багатай арга хэмжээ болох нь ажиглагддаг.

Хилийн хана, хашаа болон бусад хатуу саад хаалтыг барих талыг баримталсан улс орнуудын туршлагыг адилхан үнэлж болохгүй билээ. Зарим тохиолдолд, эмх замбараагүй байдлаас зайлсхийх хууль бус цагаачид, террористуудын урсгалыг бууруулах зайлшгүй шаардлагатай арга хэмжээ ч болж байжээ. Гэвч гэмт хэрэгт холбогдогсод ихэвчлэн шинэ нөхцөл байдалд дасан зохицож, энэ арга хэмжээний үр дүнг бууруулдаг.

Үүнээс гадна энэ бодлогыг дэмжигчид улс орнууд нь ихэвчлэн хөрш орнуудтайгаа харилцах харилцаа хүндрэх, хилчид болон гаальчдын дунд авлигын түвшин нэмэгдэх, хүний эрхийн зөрчил нэмэгдэж, үр дүнд нь улс орны нэр хүндийг унагах зэрэг сөрөг үр дагавартай тулгардаг. Эдгээрээс үзэхэд хилийн хана, хашаан саадыг барьж байгуулах ажлыг хил дээрх нөхцөл байдлыг хэвийн болгох хосгүй жор гэж үзэж болохгүй.

Аюулгүй байдлаа хамтын хүчээр хангадаг АНУ-Канадын туршлагаас харахад хилийн аюулгүй байдлын салбарт хөрш оронтойгоо хамтран ажиллах ялангуяа хил хамгаалалтын хамтын системийг бүрдүүлэх нь бусад загваруудаас илүү үр дүнтэй байдаг. Энэ стратеги нь хөрш оронтойгоо тогтоосон сайн

[1] Голунов С.В 2008. Безопасность американо-мексиканской границы: опыт пограничной политики США // США – Канада: экономика, политика, культура. Вып 4.

харилцааг хадгалж, бэхжүүлдэг. Хил, гаалийн үйл ажиллагааны илүү давхардлыг арилгаж, их хэмжээний үргүй зардлыг хэмнэх, хил дамнасан урсгалд тохиолдох саад бэрхшээлийг багасгахад үр өгөөжтэй байдаг. Энэ сонголт нь хамтрагч талуудын хоорондын бүрэн дүүрэн харилцан итгэлцэл, хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх сонирхол, хилийн аюулгүй байдлын бодлогыг бүрдүүлэх ажиллагааны үеийн харилцан буулт хийхэд бэлэн байдал, энэ бодлогын зарчим, стандартуудын нэгдэл зэргээс хамаарна.

Хөрш оронтойгоо нягт хамтран ажиллах үндсэн дээр хилийн аюулгүй байдлаа хангахын нэг тод жишээ нь Америк-Канадын хилийн хамгаалалт юм. Дэлхийн хамгийн урт энэ хил нь /хуурай газрын хил нь ойролцоогоор 8900 км/ эдийн засгийн өндөр хөгжилтэй гадаад худалдааны түнш найрамдалт улсуудыг заагладаг. Хилийн шалган нэвтрүүлэх 11 боомтоор хил дамнасан урсгалын 90 хувь буюу 1 секунд тутамд 1 тээврийн хэрэгсэл, 6 секунд тутамд 1 ачааны машин шалган нэвтрүүлж байна[1]. XX зууны туршид Америк-Канадын хил нь 1930–аад оны Канадын ерөнхий сайд Р.Беннетийн хэлснээр хамгийн том харилцан худалдааны эргэлттэй “дэлхийн хамгийн урт хамгаалалтгүй хил” байжээ[2].

2001 оны 9 дүгээр сарын 11 ний террорист халдлагын дараа хойд хил нь АНУ-ын засаг захиргааныхны хувьд “Террористуудын нэвтэрч болох нэгэн гол чиглэл” гэж үзэгдэх болов. Үүнээс хойш Вашингтоноос хилийн хяналтыг чангатгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хил дамнасан тээвэрт ноцтой хохирол учруулсан юм. Ерөнхийдөө хоёр улс, ялангуяа Канадын талд эдийн засаг, гадаад худалдаанд нь асар их хохирол учруулж бараа эргэлтийн хэмжээ эрс буурах аюул тулгарсан. Энэ нөхцөлүүдэд талууд хил дамнасан урсгалуудыг хянах хамтын системийг бүрдүүлэхээр ажилласан юм. 2001 оны 12 дугаар сарын 12-нд Оттавад “Ухаалаг хил”-ийн талаарх мэдэгдэлд гарын үсэг зурцгааж, түүнд итгэл хүлээсэн жуулчид болон худалдааны байгууллагад аль болох таатай журам боловсруулах, эдгээр байгууллагын эд бараанд тавих хяналтыг хилийн бүсээс ачаалах цэгүүдэд шилжүүлэх, хил дээрх чирэгдлийг багасгахын тулд шалган нэвтрүүлэх боомтуудыг сайжруулах зэрэг шинэ стратегийн давуу талыг

[1] Bureau of Transportation Statistics: http://www.transtats.bts.gov/bordercrossing.aspx

[2] Безопасность и международное сотрудничество в поясе новых границ России. 2002 / Под ред. Л.Б.Вардомского, С.В.Голунова. М.; Волгоград: Научно-образовательный форум по международным отношениям.

тунхагласан юм[1].

5. Европын холбооны улсын хил хамгаалалт

Нээлттэй хил нь хялбар биш нөхцөлүүд болох эдийн засгийн болон гаалийн нэгдмэл бодлого, хөрш орны хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа, хилийн нэгдмэл орон зайг бүрдүүлэх тодорхой стандарт бүхий гадна хилийн хяналт зэргийг биелүүлэхийг шаарддаг.

Ийм ажиллагааны шилдэг загвар нь Европын Холбоо юм. Европыг холбоо нь тодорхой тогтоосон хилгүй, хил хамгаалах төвлөрсөн системгүй. Гэвч Европын холбооны бараг бүх гишүүн орнуудын хилийн бодлого нь ихэнх тохиолдолд зайлшгүй мөрдөх ёстой нийтлэг зарчим, дүрэм дээр тулгуурладаг.

Европын холбооны хилийн аюулгүй байдлыг хангах бодлогын гол агуулга нь Европын холбооны дотоодын хилийн хяналтыг түүний дүрэмд үндэслэн өөрчлөх ялангуяа бүс нутгийн улсуудын хоорондын хилийн хяналтыг өөрчлөх үйл ажиллагаагаа юм. Энэ нь хууль бус цагаачлал, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд Европын холбооны улсуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд хилийн гадаад хяналтыг чангатгах байдлаар нөхөгдөх ёстой. Хилийн гадаад хамгаалалтын системд хил дамнасан хууль бус ажиллагаатай тэмцэхэд Европын холбооны нэгдсэн бүтэц болон механизмууд нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Тэдгээрийн нэг нь –виз, зөвшөөрөл хүсэгчид, хууль дүрэм зөрчигчид, алга болсон эд зүйлс гэх мэтийн талаар хилчдэд шаардлагатай бүх мэдээллийг өгдөг “Шенгений мэдээллийн нэгдсэн систем” юм.

Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд гол үүргийг хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн солилцоо зохион байгуулах, тагнуулын мэдээг үнэлж дүгнэх, санал боловсруулах ажлуудыг гүйцэтгэдэг байгууллага болох “Европол” биелүүлнэ. Европын холбооны гишүүн улсуудын хилийн бодлогыг зохицуулах, мэдээлэл, туршлага солилцлыг зохион байгуулахын тулд 2004 онд Европын холбооны гишүүн улсуудын хилийн гадаад оперативын хамтын ажиллагааны удирдлагын Европын агентлаг “ФРОНТЕКС” - ийг байгуулсан байна. ФРОНТЕКС нь Европолын адил бүтэц болон гүйцэтгэх засаглалын эрхгүй, зохицуулах байгууллага юм.

Европын холбооны гадаад хилийг хамгаалах зардлыг тэгш хуваарилаагүйгээс болж ийм хилтэй болон хилгүй улсуудын

[1] Smart Border Declaration. Building a Smart Border for the 21st Century on the Foundation of a North American Zone of Confidence. 2001 // Foreign Affairs and International Trade Canada: http://geo.international .gs.ca/can-am/main/border/smart_border_declarationen.asp

хооронд зөрчил, гомдол гарч байна. Гэвч хил хамгаалалтын нэгдсэн бодлого боловсруулахад саад болж байгаа хамгийн ноцтой бэрхшээл нь Европын холбооны улсуудын эрх зүйн системийн ялгаа байсаар байна[1].

Шинэ гишүүн орнууд болон Европын холбооны гишүүн болохоор хүлээгдэж байгаа орнуудын хилчид болон гаалийн ажилтнуудад эдгээр албануудыг энгийн болгох, ШНБ-уудыг компьютержуулах, орчин үеийн тоног төхөөрөмжийг хил дээр ашиглах, хүний эрхийг хүндэтгэх гэх мэт стандартын шаардлагуудыг тавьж байна. Хэдийгээр эдгээр шаардлагууд нь зөвлөмжийн шинжтэй боловч эдгээрийг биелүүлэхгүй байх нь ялангуяа холбоонд шинээр элсэхийг хүсэж байгаа орнуудын хүсэлтийг хүлээж авахгүй байх шалтаг болж мэдэх учраас эдгээр улсууд дээрх шаардлагуудыг гуйвалтгүй мөрдөж байна. Европын холбооны хилийн гадаад аюулгүй байдлыг хангахад ялангуяа энэ үүргийг хүлээж байгаа гишүүн орнуудын хувьд техник, эдийн засгийн тусламж, хөнгөлөлт үзүүлэх, гаалийн орлогын 25 хувийг өөртөө авч үлдэх эрх олгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг[2].

Европын холбоог өргөтгөх явцад хуучин социалист лагерийн орнуудтай нягт хамтын ажиллагааг хөгжүүлснээр хилийн гадаад аюулгүй байдлын бэрхшээлтэй асуудлуудыг арилгаж эдийн засгийн шинэчлэл, хууль хэрэгжүүлэх болон бусад хүрээний Европын нийтлэг стандартыг мөрдөж байна. Шилжилтийн урт хугацаанд эдгээр улсууд нь Европын холбооны хилийн нийтлэг орон зайд нэгдэж, хилээ хамтран хамгаалж байна. Европын холбооноос авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь мансууруулах бодис, хууль бус хилийн зөрчлийн эсрэг тэмцэлд мэдэгдэхүйц үр дүнд хүрээгүй байна.

Дүгнэлт

Аливаа улс үндэстний хувьд хилийн аюулгүй байдлаа хангана гэдэг нь юуны өмнө төрийн тусгаар тогтнол, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдал, ард иргэдийнхээ оюун санааны нэгдмэл чанарыг хилийн орон зайд хамгаалан бэхжүүлэхээс эхлээд өөрийн ашиг сонирхол, хилийн халдашгүй дархан байдлыг бусдаар хүлээн зөвшөөрүүлэх төдийгүй түүний баталгаатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй олон талтай, баялаг агуулгатай улс төр-

[1] Anderson M. 2000. Border Regimes and Security in an Enlarged European Community: Implications of the Entry into Force of Amsterdam Treaty. EUI Working Paper № 2000/8. San Domenico: European University Institue

[2] Андреас, P.R.1999.Sovereigns and Smugglers: Enforcing the U.S.-Mexico Border in the Age of Globalization /A Dissertation Presented to the Faculty of the Graduate School of Cornell University

дипломат, тагнуул, цэрэг, эдийн засгийн цогц бодлого, арга хэрэгсэл, үйл ажиллагааны нэгдэл юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах бодлогоо тодорхойлоход улс орны хилийн заагийн уртын хэмжээ, хязгаар нутгийн газар зүйн байдал, хил дамнасан хөдөлгөөний урсгалын ачаалал, хөрш улсын нийгэм эдийн засаг, соёлын шинж байдал, аюулгүй байдлын хурцадмал талууд зэрэг олон хүчин зүйлүүд нөлөөлдгийг харгалзан үзэх чухал юм.

Иймээс хилийн аюулгүй байдлын аль нэг загварыг шууд монголын хөрсөнд хуулж буулгах нь оновчтой эсэх нь эргэлзээтэй боловч эдгээр туршлагуудыг хилийн аюулгүй байдлыг хангах бодлого, төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн үед анхаарч үзэх нь чухал юм.

Эх сурвалж:

1. Монгол улс-БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ. УБ. 1994 он

2. Ш.Лхачинжав. “Хил хамгаалалтын тогтолцоонд орон нутгийн засаг захиргаа, ард иргэдийг оролцуулах ажиллагааг боловсронгуй болгох нь” диссертац 2004 он.

3. П.Сүндэв. Улсын хилийг хамтран шалгахад баримталсан бодлого, чиглэл. Улаанбаатар. 2006 он.

4. Б.Даваадорж. Хятадын чөлөөлөх арми өнөө ба ирээдүй. УБ. 2011.

5. Хил судлалын шинжлэх ухааны онол, практикийн зарим асуудал. ХСИС. Улаанбаатар. 2014 он.

1. МУ-ын ҮАБЗ-ийн Стратеги судлалын хүрээлэн “ Шинэ эриний хятадын батлан хамгаалах цагаан ном-2019” 2021 он.

2. МУ-ын гадаад харилцааны яамны сайт: http://www.mfa.gov.mn. 2018 он.

3. 中华人民共和国宪法. 北京 : 2006. 共51页 / пер. изд.: Конституция КНР. – Пекин, 2008.

4. Каменнов П., Клименко А. О военной политике и военной доктрине Китая // Проблемы Дальнего Востока. 2014. № 5. С. 126–148.

5. В. В. Кудинов. Защита и охрана государственной границы: проблемы Конституционноправового регулирования. 2015г.

6. В.А. Ширяев. Защита и охрана государственной границы российской федерации: историография 90-х гг. xx в. 2013г.

7. Доклад секретариата Конференции Организации Объединенных Наций по торговле и развитию об экономических последствиях израильской оккупации для палестинского народа: бремя дополнительных ограничений в зоне С, 2000–2020 годы.

8. С.В. Мелконян. Политика государства израиль в отношении Сирийской арабской республики (2009–2019 гг.), диссертация на

соискание ученой степени кандидата исторических наук, специальность 5.6.7. – история международных отношений и внешней политики

9. Passel J. Size and Characteristics of Unauthorized Migrant Population in the U.S. Estimates Based on the March 2005 Current Population Survey. Pew Hispanic Center: http://pewhispanic .org/reports/report.php?ReportID=6 1

10. Голунов С.В 2008. Безопасность американо-мексиканской границы: опыт пограничной политики США // США –Канада: Вып 4.

11. Bureau of Transportation Statistics: http://www.transtats.bts.gov/border crossing.aspx

12. Безопасность и международное сотрудничество в поясе новых границ России. 2002 / Под ред. Л.Б.Вардомского, С.В.Голунова. М.; Волгоград: Научно-образовательный форум по международным отношениям.

13. Smart Border Declaration. Building a Smart Border for the 21st Century on the Foundation of a North American Zone of Confidence. 2001 // Foreign Affairs and International Trade Canada: http://geo.international.gs.ca/can-am/main/border/smart_border_declarationen.asp

14. Anderson M. 2000. Border Regimes and Security in an Enlarged European Community: Implications of the Entry into Force of Amsterdam Treaty. EUI Working Paper № 2000/8. San Domenico: European University Institue

15. Андреас, P.R.1999.Sovereigns and Smugglers: Enforcing the U.S.-Mexico Border in the Age of Globalization /A Dissertation Presented to the Faculty of the Graduate School of Cornell University

ХИЙМЭЛ ОЮУН УХААН БА ХИЛ ХАМГААЛАЛТ

Ц.Гансүх
Отгонтэнгэр их сургуулийн
Хүмүүнлэгийн сургуулийн багш,
аюулгүй байдлын ухааны
доктор(Ph), бэлтгэл хурандаа

Товч агуулга: Хүмүүс бид 21 дүгээр зууныг хүн төрөлхтний жинхэнэ эв найрамдлын зуун болно гэсэн өөдрөг үзлээр шинэ мянганыг угтсан билээ. 21 дүгээр зуун эхлээд эхний хэдэн жил өнгөрч байхад олон улсын стратегийн онолч, алдарт Колин Грей (Colin Gray) хэмээх англи профессор 21 дүгээр зууныг 20 дугаар зуунаас дутахгүй дайн, мөргөлдөөний эрин үе болно гэж таамагласан байдаг. Учир нь хямрал, зөрчлийн мөн чанарыг тодорхойлдог “улс төрийн холбоо хамаарал” өнгөрсөн зуунаас 21 дүгээр зуунд огтхон ч өөрчлөгдөөгүй тул судлаачид энэ зууныг өнгөрсөн зуунаас дутахгүй хямрал, мөргөлдөөний эрин үе болно гэж тодорхойлсон. (Чүньгынь, 2023) Профессор К.Грэй “хүчирхэг гүрнүүд”-ийн дайн дэгдээх магадлал өнөөг хүртэл оршсоор байгаа төдийгүй аль хэдийн тийм нөхцөл байдал үүсэж байна гэж үзсэн. (Gray, 2005). Шинэ мянган гарснаас хойших дэлхий дахинд гарсан томоохон зэвсэгт мөргөлдөөн, тухайлбал АНУ-ын оролцоотой өрнөсөн Ирак, Ливи, Афганистан, ОХУ болоод бусад бүс нутгийн тоглогчдын оролцсон Сирийн дайн, мөн өнөөдөр ч үргэлжилж буй ОХУ- Украйны зэвсэгт мөргөлдөөн, Израйл-Хамасын хурц хямралаас харвал хойшдоо ч улс гүрнүүдийн хоорондох хямрал мөргөлдөөн нь зугтах боломжгүй бодит зүйл гэдгийг илтгэж байна.

Өнөөдөр дэлхийн том гүрнүүдийн стратегийн өрсөлдөөн зөвхөн цэрэг-стратегийн хүчин чадлын сорилт бус, илүү өргөн хүрээний гео-экономик, технологийн өрсөлдөөн, хиймэл оюуны нэвтрэлт, судлаач эрдэмтэд, инновац ба хиймэл дагуулын тооны асуудал зэрэг бүхий талбарт өрнөж байна.

Улс орнуудын хувьд үндэсний аюулгүй байдлын асуудал, энх тайвнаар зэрэгцэн оршихын төлөөх тэмцэл 21 дүгээр зуунд тэргүүн зэргийн асуудал болсон. Үүн дээр бүс нутгийн хэмжээний эдийн засгийн доройтол, ядуурал, хямрал, мөргөлдөөн, эдгээрээс үүдсэн хяналтгүй цагаачлал, олон улсын гэмт хэрэг газар авсан. Энэ мэтчилэн маш олон хүчин зүйлүүд олон улсын түвшинд байраа хадгалсаар, улс орнуудын аюулгүй байдалдаа санаа зовох бэрхшээлтэй асуудал нь болсоор байна.

Иймээс дэлхийн хөгжингүй орнууд цэрэг-батлан хамгаалах салбараа бэхжүүлэх, улсын хил хамгаалалтын аюулгүй байдлаа дээшлүүлэх зорилгоор тухайн салбарууддаа хиймэл оюун ухаан,

мэдээллийн өндөр технологийг эрчимтэй нэвтрүүлж байна.

Түлхүүр үгс: олон улсын хямрал, стратегийн өрсөлдөөн, хилийн аюулгүй байдал, хиймэл оюун ухаан, хилийн менежмент, судалгаа, шинжилгээ, техник, технологи, шинэчлэл, аюулгүй байдал

Үндсэн хэсэг

Дэлхийн улсуудад хиймэл оюун ухааныг батлан хамгаалах болон хилийн аюулгүй байдлыг хангахад хэрхэн нэвтрүүлж, хэрхэн ашиглаж буй талаар эхлээд товчхон авч үзье.

Өнөөдөр хиймэл оюуныг хөгжүүлэх технологи дэлхийн улсуудад эрчимтэй явагдаж байна. Ялангуяа сүүлийн арван жилд хиймэл оюуны хөгжил үсрэнгүй явагдсан. Улс орны үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг болсон батлан хамгаалахын салбарт ч, улсын хил хамгаалалтын салбарт ч хөгжингүй орнууд энэхүү хөгжлийн үр дүнг аль хэдийнээ ашиглаж эхэлсэн байна. Өөрөөр хэлбэл дата мэдээлэл ашиглан машиныг хиймлээр оюун ухаантай болгох гэсэн үг бөгөөд хамгийн гол хөдөлгөгч хүч нь асар их хэмжээний дата мэдээлэл юм. Ингэж компьютерыг сэтгэж шийдвэр гаргахад нь туслан дата мэдээллээр тэжээх юм бол машин өөрөө үйлдэл хийж, түүнээсээ суралцаж байдаг (machine learning) Хиймэл оюуны технологи нь өнөөдөр маш хурдацтай хөгжиж буй компьютерын шинжлэх ухааны нэг салбар юм. (wikipedia, 2025) Гол зорилго нь компьютерыг бие дааж шийдвэр гаргах, бодох чадвар суулгахад чиглэгдэж буй. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хиймэл оюунтай хамаарал бүхий Квант тооцоолол, Үлэмж өгөгдөл (Big Data), Юмсын интернэт (IoT-Internet of things), Жижгэрүүлэх технологи (miniaturisation), Өөрийгөө удирдах систем (robotics and autonomy) зэрэг технологиуд таамаглаж байснаас илүү хурдтай хөгжиж шинэ шатанд гарч байна. Өнөөдөр хиймэл оюуны хөгжил аюулгүй байдал, цэргийн салбарын технологийг үндсээр нь хувиргаж, хүчний тэнцвэрийг ч өөрчлөх боломж олгож байна.

АНУ хиймэл оюуны технологийг хөгжүүлэх чиглэлээр дэлхийд тэргүүлж байна. Дэлхийд тэргүүлэх байр суурины төлөөх АНУ ба БНХАУ-ын хоорондын геополитикийн өрсөлдөөнд хиймэл оюуныг хөгжүүлэх уралдаан маргаангүй нөлөөлөх болсон. АНУ-ын БХЯ 2016 онд “Хиймэл оюуны судалгаа хөгжүүлэлтийн стратеги төлөвлөгөө” баталж, хиймэл оюуныг АНУ-ын цэргийн салбар дахь манлайллыг хадгалах нэг хэрэгсэл гэж үзсэн. АНУ AI судалгаа, хөгжүүлэлтэд хамгийн их хөрөнгө оруулдаг орнуудын нэг юм. Google, Microsoft, OpenAI зэрэг компаниуд нь салбарын хөгжлийг тодорхойлж буй. Тус улсын Засгийн газар 2019 онд

Хиймэл оюуны үндэсний стратегийг зарлаж, хиймэл оюуны судалгаа, боловсролд хөрөнгө хуваарилах ажлыг эхлүүлсэн (Wikipedia, 2025). АНУ-ын БХЯ мөн Пентагон- Цахиурын хөндий хоорондын нягт хамтын ажиллагааг идэвхжүүлэх үүрэг бүхий Батлан хамгаалахын инновацын төвийг байгуулсан.

АНУ-ын Хил гаалийн алба (CBP) нь хилийн аюулгүй байдлыг сайжруулахын тулд 300 гаруй автомат хяналтын цамхгуудыг хилийн дагуу байршуулсан бөгөөд эдгээр нь хиймэл оюун ухааныг ашиглан сэжигтэй хөдөлгөөнийг илрүүлж, хилийн ажилтнуудад мэдээлдэг. Энэ нь нэн тэргүүнд хилийн хяналтыг илүү үр дүнтэй болоход тусалдаг. Мөн хиймэл оюун ухаан болон машин сургалтыг хилийн аюулгүй байдлын үйл ажиллагаанд нэвтрүүлж, хяналтын системүүдийг сайжруулж байна. Энэ нь хилийн хяналтын мэдээллийг илүү хурдан, үр дүнтэй боловсруулах боломжийг олгодог. Хил гаалийн алба нь хилийн шалган нэвтрүүлэх цэгүүддээ нүүр царай таних биометрийн технологийг нэвтрүүлж буй бөгөөд энэ нь зорчигчдын хилийн шалгалтын хугацааг хурдасгаж, аюулгүй байдлын түвшнийг нэмэгдүүлэх зорилготой юм. Мөн Хил, гаалийн албанаас ирмэг тооцоолол (Edge Computing) хэмээх мэдээллийг боловсруулах тооцооллын технологийг хөгжүүлж байна. Энэ нь мэдээллийн боловсруулалтын хурдыг нэмэгдүүлж, хариу үйлдлийг сайжруулахад чиглэгдсэн технологи юм.Эдгээр дэвшилтэт технологиудыг нэвтрүүлснээр АНУ-ын хилийн аюулгүй байдал, хилийн хяналт сайжирч, хил, хил орчмын нутагт аливаа хууль бус үйл ажиллагааг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх чадвар нэмэгдэж байна.

Европын хил, эргийн хамгаалалтын агентлаг (Frontex) нь Европын холбооны хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой хилийн менежмент, судалгаа шинжилгээ хийх, инновацыг нэвтрүүлэх, техник технологийн шинэчлэл хийх зэрэг ажлыг хариуцдаг . Тус агентлаг хилийн аюулгүй байдлыг хангах инновацын чиглэлээр хилээр нэвтрэгсдийн биометрийн өгөгдөхүүн, цахим хаалга/e-gate/-ны сайжруулалт, хилийн менежментийн хэвлэл мэдээллийн мониторинг, хилийн аюулгүй байдлын судалгааны төслийн шинжилгээ, хиймэл дагуулуудын ашиглалтыг оновчлох, техник технологийн стандартыг хөгжүүлэх чиглэлд голлон анхаарч байна (Frontex, Frontex, the European Border and Coast Guard Agency, 2025).

Европын гадаад хилд аюулгүй байдлын заналхийллийн түвшин сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдэж буй. Энэ нь

Европ дахь цагаачдын хямрал, Орос-Украйны дайн зэрэг томоохон хэмжээний үйл явдлуудтай нягт холбоотой. Эдгээр заналхийллийг даван туулахын тулд Европын холбооны хил, эргийн хамгаалалтын агентлаг(Frontex) төсвөө ихээхэн нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд сүүлийн жилүүдэд хилийн менежментийн үр нөлөөг дээшлүүлэх, хилийн аюулгүй байдлын чадавхыг сайжруулах, судалгаа хийх, инновац, хиймэл оюуныг нэвтрүүлэн ажилласны үр дүнд үйл ажиллагааны үр өгөөж ихээхэн сайжирсан талаар тус агентлагаас гаргасан илтгэл тайлангуудад дурдагдаж байна. (Frontex, Frontex, the European Border and Coast Guard Agency, 2025)

Хил, эргийн хамгаалалтын агентлаг(Frontex) аюул заналыг автоматаар илрүүлэх, таних, баримт бичгийг баталгаажуулах зэрэг зорилгоор хиймэл оюун ухааны цогц тогтолцоог боловсруулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн.

БНХАУ хиймэл оюуны технологид ихээхэн хөрөнгө оруулж, 2030 он гэхэд дэлхийд тэргүүлэх зорилго тавьсан. Alibaba, Baidu зэрэг компаниуд нь AI-ийн томоохон төслүүдийг хэрэгжүүлдэг. Үүнтэй зэрэгцээд шинжлэх ухаан технологийн тэргүүлэх орон болох эрмэлзэлтэйгээр БНХАУ, АНУ-ын шинжлэх ухаан технологийн инновацын хөтөлбөр болох DARPA-ын хятад хувилбар болох Хиймэл оюуны үндэсний хөтөлбөрийг баталсан байна. Хятад улс ирээдүйн дайнд хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг ашиглан илүү “мэдээлэлжсэн” цэрэг, “ухаалагжсан” зэвсэг, техниктэйгээр оролцохоор эрмэлзэж буй. Сүүлийн жилүүдэд Хятадын цэргийн номлолд “мэдээлэлжсэн” дайнаас “ухаалагжсан” дайнд аажимдаа шилжих төлөв ажиглагдаж байна. Одоогийн байдлаар цэргийн номлол албан ёсоор өөрчлөгдөөгүй ч бодлогын баримт бичгүүдэд “ухаалагжсан дайн”-д бэлтгэхийг чиглэлээ болгож буй. (by Stuart Russell (Author), 2025). 2019 оны Батлан хамгаалах цагаан номд “мэдээлэлжих, механикжих чиглэлээр дэвшил гаргахын сацуу “ухаалагжсан” цэргийн хүчнийг байгуулах ажлыг урагшлуулах” чиглэлээр анхаарч ажиллахыг тусгасан. ХАЧА хиймэл оюун ухааныг цэргийн технологийн салбарт нэвтрүүлэхэд анхаарал хандуулж буй нь “ухаалагжсан дайн”-д бэлтгэж буйг илтгэж байна. Хятадын цэргийн шинэчлэлийн хүрээнд хиймэл оюун ухааны хөгжүүлэлт, зэвсэг, техникийн шинэчлэл илүү хурдтай үргэлжлэх төлөвтэй байна. Зэвсгийн системийн хөгжүүлэлт, судалгаа, боловсруулалт, туршилт, захиалга, үйлдвэрлэлийн явц тасралтгүй үргэлжилж, энэ зорилгоор цэргийн хамтын

ажиллагааг сайжруулах төлөвтэй байна.

Ухаалагжсан дайн (Intelligentized Warfare) нь хиймэл оюун ухаан ба автоматжуулалт, датаны анализ, автомат системийг цэрэг дайны салбарт өргөн ашиглах үзэл баримтлал юм. Үүний үндсэн онцлог нь:

1.Хиймэл оюун ба автоматжуулалт

-Дрон, автоматжуулсан систем-Ухаалаг дрон, автомат зэвсэг ашиглах

- AI командлал ба шийдвэр гаргалт-Цэргийн командлалд хиймэл оюуны алгоритм нэвтрүүлэх

2.Мэдээллийн дайн-(Fake news, social media warfare) ашиглан өрсөлдөгчийн улс төр, нийгмийн тогтвортой байдлыг алдагдуулах

3.Кибер дайн ба цахим фронт

-Сүлжээний дайн-Цэргийн болон стратегийн байгууллагуудад кибер халдлага хийх

-Хакер ажиллагаа-АНУ, ЕХ зэрэг өрсөлдөгч хүчнүүдийн мэдээллийн системд халдах

4. Сансрын дайн

-Сансрын хиймэл дагуулын дайн-Байлдааны нөхцөлд хиймэл дагуулын сүлжээг унагах, мэдээлэл таслах

-Квант холбоо(Quantum communication)-Дотоод сүлжээний хамгаалалтыг квант технологиор бүрэн хангах.

БНХАУ нь хил хамгаалалтаа сайжруулах зорилгоор хиймэл оюуны дэвшилтэт технологийг нэвтрүүлж байна. Тухайлбал, хилийн боомтуудаа биометрийн мэдээлэл цуглуулах, хүний нүүр царай, хурууны хээ таних системийг нэвтрүүлсэн. Эдгээр системүүд нь зорчигчдын мэдээллийг хурдан, найдвартай бүртгэж, хилийн шалган нэвтрүүлэх ажиллагааг хурдасгах, зорчигч, тээврийн хэрэгслийн нэвтрүүлэх урсгалыг нэмэгдүүлж, хилийн аюулгүй байдлыг хангахад тусалдаг.

БНХАУ 2019 онд хуурай болон усан хил хамгаалалтын шинэ системийг танилцуулсан. Энэхүү системийг БНХАУ-ын NORINCO(China North Industries Group Corp Ltd) бүтээжээ. Энэхүү систем нь хуурай газар болон тэнгисийн эргийн хамгаалалтын болон удирдлагын систем нэртэй бөгөөд Бэйдоу сансрын хиймэл дагуулын системд үндэслэгдсэн. Төслийн хүрээнд NORINCO корпорацын инженерүүд хуурай болон усан хилийн шугамын дагуу 40-50 километр тутамд суурин станцуудыг байрлуулсан байна. Энэ нь байг өндөр нарийвчлалтайгаар илрүүлэх боломжийг олгодог байна. Хөдөлгөөнт биетийн байрлалыг сантиметрийн нарийвчлалтайгаар, хөдөлгөөнгүй биетийн байрлалыг миллиметрийн нарийвчлалтайгаар илрүүлэх чадвартай юм.Ойролцоогоор 2000 орчим ийм станцыг Шинжаан-Уйгар, Юнань, Өмнөд Хятадын тэнгис орчмын хилийн хэсгүүдийн хил хамгаалалтад ашиглаж байна. Америкийн эрдэмтэн Элса Каниагийн үзэж

буйгаар Хятад улс 2030 он гэхэд дэлхийн Хиймэл оюун ухааны инновацын төв болох ажээ . (https://www.saic.com/who-we-are/national-imperatives/innovation-at-the-border, 2025)

ОХУ-ын хувьд АНУ-Хятадтай харьцуулахад аюулгүй байдал, батлан хамгаалах салбартаа инновац, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх ажиллагаа харьцангуй хоцрогдолтой харагдаж байгаа ч мэдээж цэргийн технологийн их гүрний хувьд тодорхой үйл ажиллагааг аль хэдийн хэрэгжүүлээд эхэлсэн. ОХУ 2025 онд цэргийн төсвийн 30 хувийг робот зэвсэгт зарцуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тус улсын AI хөгжүүлэгчдийн батлан хамгаалахын салбарт зориулан хөгжүүлж буй хиймэл оюуны технологи нь ил тод байдал багатай. Ерөнхийдөө хүний оролцоогүйгээр шийдвэр гаргах автономит систем хөгжүүлэх, энэхүү системийн мэдээллийн менежментийг оновчтой болгох чиглэлд түлхүү анхаарч байгаа гэж хэлж болно. Оросын цэргийн стратегийн мэргэжилтнүүд тулааны талбарт мэдээллийн давуу тал бий болгоход AI-г ашиглах, өөрийн хүч нөөцийг хамгаалах, сөргөлдөгч талдаа мэдээллийн технологийн давуу тал олгохгүй байх гэсэн зорилгын дагуу хиймэл оюуны технологийг хөгжүүлэх чиглэл баримталж байна. Гэхдээ цэргийн дээд хүрээнийхний дунд зэвсэгт хүчний хэмжээнд AI технологи хөгжүүлж, нэвтрүүлэхийн туйлын зорилго болон цаашид хиймэл оюун өөрөө хүний оролцоогүйгээр бие даан шийдвэр гаргах нь зөв, буруу эсэх дээр байр суурийн зөрүү нэлээд байгаа нь ажиглагдсан. Гэсэн ч тэд газар, агаар, далай тэнгисийн мандал дээр болон гүнд ашиглагдах роботууд, дрон болон өөр бусад зэвсэгт техникүүдийг өөрөө бие даан шийдвэр гаргах автономит AI системээр тоноглох нь зүйтэй гэсэн байр суурин нэгдээд байгаа юм. Мөн цөмийн зэвсгийн удирдлагын системдээ хиймэл оюуны технологи нэвтрүүлж, АНУ-ыг сөрөн зогсох чадавхаа нэмэгдүүлж, эрт илрүүлэн хайх, хариу цохилтыг амжилттай хийх, дайсны цөмийн довтолгооноос хамгаалах системийг устгах зэрэг даалгаврыг хариуцуулах боломжтой гэж харж байгаа аж. (https://www.cbp.gov/border-security, 2025)

ОХУ-нь хилийн хяналтдаа шинэ дэвшилтэд технологиудыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж байна. Тухайлбал, нүүр царай таних системийг зарим хуурай газрын хилийн боомтууддаа суурилуулах тендерийг 2023 онд зарласан бөгөөд энэ нь 830 сая рублийн /ойролцоогоор 11.3 сая доллар/ төсөвтэй байсан. ОХУ нь хил хамгаалалтын үйл цахим технологийг өргөн нэвтрүүлж байна, Тухайлбал, хилийн хяналтын цэгүүдэд биометрийн таних систем, цахим мэдүүлгийн системийг нэвтрүүлж, хил

нэвтрэх үйл явцыг хурдасгаж, зөрчил гарах эрсдэлийг бууруулж байна. ОХУ цаашид дотоодод ашиглах гар утас, компьютер зэрэг бүх цахим хэрэгсэлд зөвхөн өөрийн буюу орос үйлдлийн систем суулгахыг шаардах болсон бөгөөд АНУ-ын Apple8 Google зэрэг томоохон кампаниудыг эсэргүүцсэн хуулийг батлахаар хэлэлцэж байна. Энэ нь ОХУ-ын өөрийн үйлдлийн системийн компаниудыг дэлхийд өрсөлдөхүйц чадварлаг болгоход нөлөөлөх учиртай ажээ.

Монгол Улсын хил хамгаалалтад хиймэл оюуныг нэвтрүүлэхэд анхаарах асуудлууд:

Монгол Улсад 2020 оноос хойш “Цахим хөгжил” эрчимтэй явагдаж, “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” байгуулагдаж, төрийн болон банк санхүү зэрэг олон салбарт томоохон хэмжээний “платформ” хөтөлбөрийг хэрэгжүүлэн нэвтрүүлснээр иргэд аливаа үйлчилгээ авах хүндрэлүүд багасаж байна.

Монгол Улсын Засгийн газраас Улсын хилийн аюулгүй байдлыг хангах, хилчдийн алба, үйл ажиллагааны нөхцөлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 7.2-т “Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг ханган, хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлж, хил хамгаалалтын чадавхыг дээшлүүлнэ”, 7.2.2-т “Хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлж, “Бүсчилсэн хил хамгаалалт” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, орчин үеийн хандлагад нийцсэн бүтэц, хангалтын тогтолцоог бий болгоно”, 7.2.5-д “Орчин үеийн дэвшилтэд технологид суурилсан Монгол Улсын хил хамгаалалтын удирдлагын төвийг байгуулж, хил хамгаалалтад шилжүүлнэ”, 7.2.7-д “Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн цэргийн холбоо, зэвсэглэл, техник технологи, дохиолол хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлж хангана” гэж хэрэгжүүлэхээр тус тус тусгагдсан.

Хилийн аюулгүй байдлын орчинд бий болж буй аюул, заналхийллүүд жилээс жилд өсөн нэмэгдэж буй үед хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны найдвартай байдлыг хангахад инновац, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх нь хил хамгаалалтад зайлшгүй шаардлагатай. (https://www.vfsglobal.com/en/individuals/insights/enhancing-border-management-systems-using-artificial-intelligence.html, 2025)

Хил хамгаалах байгууллага дотоод бүтцэдээ цахим инновацыг нэвтрүүлэх холбогдох нэгж, мөн “Хил хамгаалалтын удирдлагын төв”-

ийг байгуулан ажиллаж байна. Цаашид хилийн аюулгүй байдлыг хангах хангах үйл ажиллагааг боловсронгуй болгох, хил хамгаалалтад хиймэл оюуныг нэвтрүүлэх ажлууд явгдах нь цаг хугацааны асуудал юм. Иймээс дараах асуудлуудад анхаарал хандуулахыг санал болгож байна.

Үүнд:

1.*Хиймэл оюун ухааныг хил хамгаалалтад нэвтрүүлэх эрх зүйн орчныг бий болгох, хиймэл оюуныг ашиглах үйл ажиллагааны бодлогыг эртнээс боловсруулж эхлэх нь эхний алхам юм.*

БНХАУ-д анх хиймэл оюуныг хөгжүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан хуулийг 2023 онд гаргаж, тус оны 8 дугаар сарын 15-наас мөрдүүлж эхэлсэн. Энэхүү хуулиар хиймэл оюуныг хөгжүүлэх технологийн ил тод, аюулгүй байдал, нийгэмд үзүүлэх нөлөөллийн болон хөгжүүлэлтийн хүчин чадлын хэмжээ, хиймэл оюуны технологийг хөгжүүлэхэд хориглох зүйлсийг тодорхой тусгаж хуульчилсан. Европын холбоо ч мөн хиймэл оюуны хөгжүүлэлтийн дүрэм, журам боловсруулахаар ажиллаж байгаа бөгөөд боловсруулж буй энэ журмаа бусад улсад жишиг болгохоор зорьж буй. Энэхүү журамдаа программ хөгжүүлэлтийн явцын ил тод, нээлттэй байдлыг хангах, хүний эрхийг хүндэтгэн үзэх асуудлуудыг онцгойлон тусгаж буй юм.

2. *Дараагийн анхаарал татсан асуудал бол хиймэл оюун ухааны эрсдэлийн удирдлагын нэгдмэл тогтолцоог хөгжүүлэх ёстой. Хиймэл оюун ухааныг хил хамгаалалтад ашиглах явцад аливаа өгөгдөл, тэр дундаа хувь хүний өгөгдлийг буруу тайлбарлах, буруугаар ашиглахтай холбоотой гажуудал, нууцлалын асуудлууд эрсдэлийг бий болгох магадлалтай.*

Иймээс хил хамгаалалтын нэгжид хиймэл оюун ухааны удирдлагын зөвлөлийг байгуулж, энэхүү нэгж нь эрсдэлийн нарийн төвөгтэй динамикийг удирдах үүргийг хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Хиймэл оюун ухааны удирдлагын зөвлөлийн үндсэн чиглэл нь хиймэл оюун ухааны эрсдэлтэй холбоотой бодлого, үйл ажиллагаа, үйл явц, харилцаа холбооны сувгуудын мэдээлэл, үнэлгээ юм. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа мөн хиймэл оюун ухааны боломжийг дээд зэргээр ашиглаж, эцсийн үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдэнэ. Мөн хил хяналтын олон байгууллагуудын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтын ажиллагааг сайжруулснаар үйл ажиллагаа үр дүнтэй явгдах боломжийг бий болгоно.

3. *Анхаарах чухал асуудал бол хиймэл оюуны үйл ажиллагааг албанд нэвтрүүлэх хүний нөөцийн асуудал юм. Энэ чиглэлээр ажиллах хүний нөөцийг эртнээс бэлтгэх, сургах ёстой.*

4. *Хиймэл оюун ухааны маш хурдтай явагдаж буй хөгжлийн технологийг дагаад программ хангамжийг байнга шинэчлэн сайжруулж байх шаардлагатай тул хиймэл оюун ухааны хөгжлийн төслүүд, хиймэл оюун ухаантай холбоотой судалгаа, шинжилгээний ажлууд, ажиллагааны аюулгүй байдлыг тогтмол анхаарлын төвд байлгах ёстой.*
(https://www.vfsglobal.com/en/individuals/insights/enhancing-border-management-systems-using-artificial-intelligence.html, 2025)

5.*Бие бүрэлдэхүүнийг сургах замаар хиймэл оюун ухааны мэдлэгийг нэмэгдүүлэх нь дараагийн анхаарах асуудал мөн. Хиймэл оюун ухаанаар ажиллах хүчний чадавх, төлөвлөсөн үйл ажиллагааны үнэлгээ, түүнчлэн бие бүрэлдэхүүнийг сургах, чадавхжуулах талаар энэ чиглэлийн боловсролыг цаг алдалгүй эхлүүлж, урьдчилан олгох шаардлагатай юм.*

6.*Хил хамгаалах байгууллага ойрын хугацаанд "Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт аюулгүй байдлыг хангах бодлогын үндэс" баримт бичгийг боловсруулж мөрдүүлэх шаардлагатай. Энэхүү баримт бичгийн бүтцэд "Хил, хил орчмын нутаг дэвсгэрт аюулгүй байдлыг хангах шинжлэх ухаан технологийн хангалт" эсхүл "Хил, хил орчмын нутаг дэвсгэрт аюулгүй байдлыг хангах мэдээллийн хангалт" гэсэн тусгай бүлэгт хил хамгаалалтад хиймэл оюуныг ашиглах талаар тусгаж оруулах нь зүйтэй юм.*

Дүгнэлт

Ерөнхийд нь дүгнэхэд томоохон улс гүрнүүдийн үндэсний хэмжээний зорилт, санаачилга нь хиймэл оюуны хувирч буй боломж (цэргийн техникийн хувьсгал ч гэж хэлж болно)-ийг ашиглан үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэгдэж байна. Үүнээс үзэхэд дэлхийн томоохон гүрнүүд аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын дэвшилтэт технологиудыг цэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдлын салбарт хэрэглээд эхэлсэн төдийгүй энэ чиглэлд давуу байдал олж авах өрсөлдөөнд хэдийн орсныг харж байна. Хиймэл оюун ухаан илүү бодитой болсон бөгөөд улс орнуудад бүтээлч оюун ухаан буюу хүн машин хоёрын харилцаанд чухал ач холбогдол бүхий илүү ухаалаг интернэтийн хайлтын систем, дэвшилтэт технологиудын эрэлхийлэл явагдаж байна.

Бидний хувьд хилийн менежментийн үр нөлөөг дээшлүүлэх, аюулгүй байдлын чадавхыг сайжруулах, судалгаа хийх, инновац нэвтрүүлэх нь өнөөгийн аюулгүй байдлын орчинд бий болж буй аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, чадавхыг бэхжүүлэхэд хиймэл оюуныг албанд нэвтрүүлэх нь чухал ач холбогдолтой. Мөн хиймэл оюун ухааныг албанд ашиглах үед

ажиллах үйл ажиллагааны болон эрсдэлийн удирдлагын бодлогыг эртнээс боловсруулсан байх нь зайлшгүй юм. Хиймэл оюун ухааныг хил хамгаалалтад нэвтрүүлэхэд юуны өмнө түүний эрх зүйн орчныг урьдчилан бий болгох шаардлагатай. Иймээс "Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт аюулгүй байдлыг хангах бодлогын үндэс" баримт бичгийг боловсруулан, энэхүү баримт бичигт хиймэл оюуныг хил хамгаалалтад ашиглах зарчмаа тусгах нь чухал юм.

Үүний үр дүнд хил хамгаалалтад хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх, түүний боломжийг дээд зэргээр ашиглах эрх зүйн орчин нөхцөл бүрдэж, үйл ажиллагааны эцсийн үр дүн дээшилнэ.

Эх сурвалж:

1.https://www.vfsglobal.com/en/individuals/insights/enhancing-border-management-systems-using-artificial-intelligence.html
2.https://www.amazon.com/Artificial-Intelligence-Modern-Approach-3rd/dp/0136042597
3.https://en.wikipedia.org/wiki/Artificial_intelligence
4.https://www.frontex.europa.eu/innovation/announcements/industry-days-on-haps-high-altitude-platform-systems-for-border-surveillanc
5. https://www.cbp.gov/border-security
6.https://www.saic.com/who-we-are/national-imperatives/innovation-at-the-border
7.https://european-union.europa.eu/institutions-law-budget/institutions-and-bodies/search-all-eu-institutions-and-bodies/frontex_en
8.И Чүньнынь, Дайн ба олон улсын улс төр,УБ, 2023
9.Колин Грэй, Бас нэгэн цуст зуун, ирээдүйн дайн, Лондон, 2005
10."Хиймэл оюун ухаан" сэтгүүл, Гуандуаны их сургууль, 2025

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ХИЛИЙН ТАЛААР ЯВУУЛСАН БОДЛОГО /XVII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕ/

Л.Одзаяа
ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, хошууч

Товч агуулга: Манж Чин гүрэн, Хаант Орос Улс, Богд хаант Монгол Улс, Ардын эрхтэй хэмжээт цаазат Монгол улсаас дурдан буй үед хойд хилийн талаар ямар бодлого баримталж, хэрэгжүүлж байсныг өгүүлэх болно.

Түлхүүр үгс: Манж Чин гүрэн, Хаант Орос Улс, Халх, харуулын алба, 1727 оны Буурын гэрээ, 1912 оны Монгол, Оросын найрамдлын гэрээ, 1915 оны Хиагтын гурван улсын гэрээ

Үндсэн хэсэг

Манж Чин улсын төрөөс Халхын хойд **з**үгийн хилийн талаар баримталсан бодлого XVIII зууны эхээр монголчууд Манж Чин улсын эрхшээлд орж өөрсдийн тугаар тогтнолоо алдсан билээ.

Ингэснээр Манж Чин гүрэн Хаант Оростой газар нутгийн хувьд шууд хязгаар залгах болж хоёр тал 1727 онд Буурын гэрээ, 1728 онд Хиагтын гэрээ байгуулсан бөгөөд эхний гэрээ нь хил хязгаар болон хилийн худалдаа хийх тухай, дараагийн гэрээ нь зөвхөн худалдааны агуулгатай байв. Ийнхүү хоёр тал гэрээ байгуулснаар Орос-Манж гүрний маргаантай олон асуудлуудыг шийдвэрлэж чадсан байна[1].

1727 оны Буурын гэрээг Манжийн талаас Түлишин, Цэрэн, Лункадо, Оросын талаас эзэн хааны туслагч Сава Владиславич нар оролцсон бөгөөд эдгээр төлөөлөгчдөөс Цэрэн нь монгол хүн байсан юм. Энэхүү гэрээ нь одоогийн Монгол Улсын хойд хилийн үндэс болсон.[2]

Ийнхүү Буурын гэрээг байгуулснаар[3] умард хилийг сэргийлэн сахих чиг үүрэгтэй харуулын алба бий болсон. Тус алба байгуулагдсан түүхийг судлаачид өөр өөрсдийнхөөрөө дүгнэн тайлбарласан байдаг Жишээлбэл, судлаач Э.Жигмэддорж “Энэхүү алба нь биеэр болон гэр бүл, хөрөнгийн хамт тодорхой хугацаагаар томилогдон очдог байсан нь тухайн үеийн нөхцөл байдалд тохирсон зохион байгуулалт байсан[4] гэсэн бол судлаач, Лан Мэй Хуа “Харуулын алба

[1] 1727 оны Орос-Чин улсын Буурын гэрээ. УБ.,2004. Х.4
[2] Б.Цэдэн-Иш. Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс. УБ.,2003. Х.155
[3] Насанбалжир, Ц. Ар Монголоос Манжид залгуулж байсан алба. УБ.,1964. 121 дэх тал
[4] Жигмэддорж, Э. Манжийн үеийн Ар Монгол дахь хилийн харуул. УБ.,2006. 32 дахь тал

байгуулагдсан нь хил залгаа хоёр улсын харилцааг хязгаарлан зогсоох явдал байсны зэрэгцээ харуулын албаны зардлыг монголчууд Халхын дөрвөн аймгаас төлдөг байсан[1] гэж тус тус дүгнэжээ.

Гэр харуулын талаарх тодорхойлох зураг цэсээс харвал өрх бүрд тодорхой тооны мал ногдох ба харуулын үүрэг гүйцэтгэх цэрэг бүр зэвсэг, уналгатай байсан. Улмаар 1897 оноос өртөө, харуулын албанд анх удаа үнэ хөлс тогтоосон. Тухайлбал, Харуулын өрх 980 лан, нэг бүрийн үнэ хөлс 160 лан, хөтөл 14 лан, нэг бүр 10 лан[2] байв. Харин Хаант оросын харуулын албанд үүрэг гүйцэтгэгчид өөрийн улсдаа татвар төлдөггүй, зөвхөн хил хязгаарыг хамгаалах үүрэгтэй байжээ.

Улмаар хязгаар нутагт харуулын алба залгуулах болсноор нутгийн иргэдтэй бэлчээрийн маргаан хийх болсон тул тэдний нутгийг зааглаж овоо босгон газрын зурагт тэмдэглэснээр Харуулын нутаг анхлан бий болжээ.

Харуулын нутгийн талаар судлаач Ц.Насанбалжир “Гэр харуулын нутагт уул дэвсгэрийн ба бусад хошуудын ардыг нутаглах явдлыг шууд хориглон цаазалж, цэс тогтоож, овоо тэмдэг тавьж эдлүүлэн харуулын нутагт тохиолдсон хошуудын ардууд нутаг бэлчээрээр явцууран шахагдаж байсан учир, харуул ба нутгийн ардын хооронд нутаг бэлчээр булаалдах явдал олон жилийн турш үргэлжилсэн[3] гэжээ. Харин судлаач Ж.Гэрэлбадрах “Хилийн харуулын нутагт аливаа хошууны иргэд болон гадаадын харьяатын орох болон нутаглахыг хязгаарлаж байсан нь хил орчмын буюу харуулын нутгийг чанд байлгах бодлого байсан[4] гэж дүгнэсэн байдаг.

Халхууд Манж Чин улсад харуулын алба залгуулах болсноор Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгийг зүүн зам, Засагт хан, Сайн ноён хоёр аймгийг баруун зам болж Улиастайн жанжны газарт захирагдаж байснаа хожим хил хязгаар, эр цэргийн асуудлыг тус тусын аймгийн чуулганы даргад захируулах болсон байна. Ингэснээр аймгийн чуулган нь хил хязгаар, харуулд сэргийлэн суулгах цэргийг боловсруулах, цэргийн зэвсгийг шалгах, цэргийн тооллого хийх, ял шүүх зэрэг явдлыг хариуцан шийдвэрлэх болсон байна.

Аймгийн чуулган нь өөр өөрсдийн аймгийн доторх өртөө харуул, албан тариалан, албан сүргийг хариулах зэрэг олон албыг хэрхэн залгуулах явдлыг

[1]Лан Мэй Хуа. Монголын тусгаар тогтнолын төлөө 1911 оны хөдөлгөөн:Нэгдсэн Монгол Улс байгуулах эрмэлзэл. УБ., 2011. 82 дахь тал.

[2]Мөн тэнд. 73 дэх тал

[3]Насанбалжир, Ц. Ар Монголоос Манжид залгуулж байсан алба. УБ.,1964. Х.121

[4]Гэрэлбадрах, Ж. Монгол нутаг, дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ., 2006.Х.142

зохицуулдаг байв. Харин зохицуулж чадахгүй зарим нэг асуудлыг Улиастайн жанжин, Хүрээний амбанд мэдэгдэж шийдвэрлүүлдэг байсан. Улмаар жил бүр Халх дөрвөн аймгийн эрх мэдэл бүхий албан тушаалтнуудыг түшмэл, бичээч, хөөгчийн хамт анги хуваан явуулж, нэгийг Хиагтын зүүн зүгийн 28 харуул, нөгөөг Хиагтын баруун зүгийн 19 харуулыг тус тус байцаан үзүүлдэг байв. Энэ зуур харуулын цэргийн зэр зэвсэг дутсан тохиолдолд тус харуулын удирдлага болон цэргүүдэд ял, торгууль ногдуулдаг байжээ.[1]

Ийнхүү аймгийн чуулганыг төлөөлөгч явуулж харуулын албыг шалгахаас гадна Улиастайн жанжин, Хүрээний сайдын газраас 10 жилд 1 удаа шалган байцаах хуультай байв.

Орос зүгийн гэр харуулын бүтэц зохион байгуулалт нь Халх дөрвөн аймаг тус бүрийн харуулыг дааж захирах засаг, товчлон захиран мэйрэн буюу залан, занги, цэргээс бүрдэж байв. Харуулыг дааж захирах засгийг Улиастайн жанжны газраас Манжийн төрд үнэнчээр зүтгэгч, итгэл хүлээсэн хүнийг томилно. Харин харуулын бусад албан тушаалтнуудыг аймгийн чуулганы газраас 3 жилийн хугацаагаар томилдог байсан.

Улмаар XX зууны эхээр манжийн гадаад, дотоодын олон асуудлын улмаас орон нутгийн болон улсын зах хязгаарын аюулгүй байдлыг хангахад анхаарах болсонтой холбоотойгоор, харуулын албыг өөрчлөх бодлого баримтлах болов. Тухайлбал, Их хүрээний цэрэг бэлтгэх газрыг байгуулж, түүнд Хиагтын зүүн, баруун зүгийн харуулыг захируулах болов.[2]

Харин Олноо өргөгдсөн Монгол Улс байгуулагдаж харуулын албатай холбоотой асуудлыг Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яаманд хариуцуулсан хэдий ч харуулын гүйцэтгэх үүргийг өмнөх журмаар хэвээр үлдээсэн байна.

Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын төрөөс хилийн талаар явуулсан бодлого

1912 онд Орос Монголын хооронд найрамдлын гэрээ байгуулсан бөгөөд түүний гол агуулга нь Монголын тусгаар тогтнолыг хэвээр хадгалж чадалгүй автономит эрхтэй болгон бууруулсан юм.[3] Ингэхдээ тус хэлэлцээрт автономит байгууллын тухай заасан хэдий ч газар нутгийн хил хязгаарыг тодорхойлоогүй байна.[4]

Удалгүй 1913 онд Орос, Хятадын Бээжингийн

[1] Мөн тэнд. 121 дэх тал.

[2] Жигмэддорж, Э. Намнансүрэн, Г. Эмхэтгэл:Гэр харуулын түүхэнд холбогдох баримтууд. УБ.,2019. 123 дахь тал.

[3] И.Майский. Орчин үеийн Монгол.Орч.Ц.Отхон. Х.299

[4] Тачибана Макото. Монголын мартагдсан түүх . УБ.,2011. Х.90

тунхаглалаар Гадаад Монголын автономит эрхийг Хятадаар хүлээн зөвшөөрүүлсэн нэрээр Хятадын нутаг дэвсгэрийн нэг хэсэг байх болно гэж заасан бөгөөд 1915 оны Хиагтын гурван улсын гэрээгээр Монгол Улсын нэрийг Өөртөө эзэрхсэн Гадаад Монгол хэмээн нэрлэж, түүний газар нутгийг Халхын дөрвөн аймаг, Ховдын хязгаараар тогтоохоор гурван тал ихээхэн маргалдсаны эцэст тохиролцсон явдал нь Монголчуудын өөртөө Өвөр Монгол, Баргыг нэгтгэх хэмээсэн зорилтыг тасалдуулсан явдал байв[1].

Ийнхүү дээр дурдсанчлан Хаант Оростой найрамдлын гэрээ байгуулснаар хил хамгаалалтын зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, хилийн харуулын тоог цөөтгөх бодлого явуулах болсон байна.

Тухайлбал, Халхын дөрвөн аймгаас тэгшээр гаргаж суулгасан бүгд 47 суурь харуулаас харуул тутам хоёр өрх цэргийг хэвээр үлдээж, үлдсэн 94 цэргийг уг хил, овоо, нутгийг харгалзуулахаар үлдээн тэднийг захирах түшмэдийг аймаг бүрээс сонгон томилохыг хуучин ёсоор хэвээр үлдээсэн юм[2].

Үүнээс гадна дээрх гэрээний дагуу Оросын харьяатуудыг харуулын нутагт түр суурьших зөвшөөрлийг Оросын хил хязгаарын асуудал эрхэлсэн комиссар 1 жилийн хугацаатай олгох болов. Ингэснээр түр суурьших зөвшөөрөлтэй гадаадын харьяатууд харуулын нутагт өвс тэжээл бэлтгэж, малаа хариулж эхэлсэн байна.

Ийнхүү харуулын нутагт гадны харьяатууд түр суурьших болсноор харуул зангиуд хариуцсан хэсгийн газар нутгийг хамгаалахаас гадна, тэднээс бэлчээр болон байгалийн баялаг ашигласны түрээс хурааж, улсын санд нийлүүлэх нэмэлт чиг үүрэг гүйцэтгэх болов[3].

Үүнээс харвал Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын үеийн хилийн харуул хамгаалалт нь хойд хөрштэй хийсэн гэрээ хэлэлцээр болон тэдний харилцаанаас хамаардаг байсан нь харагдаж байна.

Дурдан буй үед харуулд суух цэргүүдээс уг албыг орхиж нутагтаа очих тохиолдолд тэдгээр ардыг уул албанд буцааж, харуулыг орхин явагчдыг цээрлүүлж, харуулын албыг орхиогүй түшмэд, тайж нарыг сайшаан шагнасан байдаг. Мөн харуулын зарим удирдлагууд хилийн нууц арилжаа наймаа хийсний улмаас эрхээ хязгаарлуулж байсан зэрэг баримтууд архивын сан хөмрөгт хадгалагдаж байна.

Ардын эрхтэй хэмжээт цаазат Монгол улсын төрөөс хилийн талаар явуулсан бодлого

[1]Монгол Улсын Гадаад хэргийн яамны Дипломат академи. Мэдээллийн дээжис. Х.13

[2]Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаар (1911-1919). УБ.,2011. 31 дэх тал

[3]МУУТА. А-4. Х-1. ХН-237. Нугалбар 1

Дурдан буй үед Гамингийн цэрэг монголын хойд нутгаар нэвтрэн орж хулгай дээрэм ихэссэн үе байсан тул газар орны ойр дөтийг харгалзан Хиагтын зүүн гурван харуулаас цэрэг элсүүлж, тус газар бугшиж байсан гаминг хөөн цэвэрлэх ажлыг хийх болсон байна.[1] Тухайлбал, Д.Базаржав 1921 онд 30 насандаа Хяраан харуулаас өөрийн сайн дураар ардын журамт цэрэг элсэж Хиагт болон Нийслэл хүрээг чөлөөлөх байлдаануудад оролцож явжээ.[2] Түүнчлэн харуул зангиуд харуулын нутгийн ойролцоох айлуудаас цэрэгт элсүүлэх ажлыг зохион байгуулах болсон байна.

Автономит болон Ардын засгийн газрын үед тус улсын харьяат болсон буриадууд болон өвөрлөгчдөд гол төлөв зах хязгаарын харуулын нутгийг шинээр олгож байсан бөгөөд “монгол хил дотор байгаа байгалийн баялаг бол монголчуудын хөрөнгө тул монгол орны газар нутгийг тус улсын харьяат болон харьяат бус хүмүүст хувьд нь эзэмшүүлж, ашиглуулахыг Ардын засгийн газраас зогсоосон байна”[3]. Өөрөөр хэлбэл, дурдан буй үед зарим өвөрлөгчид болон буриадуудаас харуулын нутгийг шинээр олгосон явдлыг хувьдаа өмчлөх хүсэлтүүд олонтоо гаргах болсон бөгөөд үүнийг Засгийн газраас хүлээж авахгүй байхаар шийдвэрлэжээ.

Харин харуулын нутгийн гадаадын харьяатуудад түрээсэлж байсан явдлыг үргэлжлүүлж байв.

Мөн тус улсад газар тариаланг хөгжүүлэх явдал чухал байсан учраас Буриадуудад тариалан эрхлэх газар олгож, боловсруулсан газраас 2 жил, атар газраас 5 жил түрээс авахгүй[4] байхаар шийдвэрлэсэн байна.

Түүнчлэн харуулын нутагт тусгай түшмэл суулгаж, цалин хүнсийг сангаас олгуулан харьяат харуулын нутгуудыг цаггүй цагдан харгалзуулахаар [5] тогтсон байна. Дурдсан баримтаас үзвэл харуулын нутагт түрээс хариуцсан тусгай түшмэл томилон суулгах болсон байна.

Улмаар 1923 оны 6 дугаар сарын 1-ний өдөр Харуулуудын нутгийг хошуудад буцаан олгож хариуцуулах тухай асуудлыг Засгийн газрын гишүүд хуралдаад “Хиагтын зүүн, баруун харуулуудад цагдаа цэрэг нэмж, төлөөний түшмэл томилон суулгах учрыг хэлэлцээд ....уул харуулуудыг татаж, тус нутгийг харьяат хошуудад олгож харгалзуулахаар тогтож, харуулын нутагт суугчдыг уугуул хошууд руу буцах эсвэл тус нутгийн харьяат хошуудад

[1] Монгол ардын журамт цэргийн дурдатгалууд. УБ.,1961. Х.42

[2] Монгол ардын журамт цэргийн дурдатгалууд. УБ.,1961. Х.74

[3]Лувсанбалдан, Э. Монгол улсын хил хамгаалалтад холбогдох тушаал, шийдвэр (баримтын эмхэтгэл). УБ., 1995. Х.8

[4] Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаар (1911-1919). УБ.,2011. Х.12

[5] Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаар (1911-1919). УБ.,2011. Х.15-16

захирагдахыг тэдний саналын дагуу шийдвэрлэхээр зохих газруудад явуулсан бөгөөд ...Дотоод явдлын яамнаас тусгай түшмэл томилон гаргаж, зах нийлэх хошуудаас түшмэлийг нэмэн авч, олон харуулуудын нутагт одуулж, өмнө ямар ямар харуулыг дагаар орсон хошуудад олгуулсан, үлдсэн нь ямар ямар хошуунд хариуцуулбал зохихыг тодорхойлуулан ирүүлэхийг Дотоод явдлын яамнаас нэн даруй эрхлэн гүйцэтгэхээр"[1] шийдвэрлэсэн байна. Үүнээс харвал Засгийн газраас харуулуудыг татан буулгахаар шийдвэрлэсэн бөгөөд харуулын нутгийг аль аль хошуунд хариуцуулахыг судлан шийдвэрлэхээр болсон байна. Харин харуулын нутагт оршин суугчдыг уугуул нутагтаа буцах эсвэл тус хошууны харьяат болохын аль нэгийг сонгох буюу тэдний хүсэлтийн дагуу шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт

Анх Манж Дайчин улсын санаачилгаар Манж Дайчин Улс Хаант Оростой хилийн хэлэлцээр (1727 онд Буурын гэрээ) хийсэн нь тус улсын умард хилийн талаар явуулах бодлогын эхлэл байв.

Автономитын үед Богд хаант Монгол Улс Хаант Оростой найрамдалт харилцаа тогтоосон тул хойд зүгийн гэр харуулын тоог цөөтгөж, харуулын нутгийг гадаадын харьяатуудад түрээслүүлж эхэлсэн бөгөөд энэ нь Ардын засгийн үед ч хэвээр үргэлжлэв. Мөн зарим харуулын нутгийг дагаар орогсдод олгосон хэдий ч Ардын засгийн үед тус газар нутгийг хувьдаа өмчлөх явдлыг зогсоосон байна.

Ардын засгийн газраас хойд хилийн харуулуудыг татан буулгаснаар тус нутгийг язгуурын харьяат хошуудад буцааж олгохоор шийдвэрлэсэн бөгөөд түүнд оршин суугчдыг уугуул хошууд руу буцах эсвэл нутгийн харьяат хошуудад захирагдахыг тэдний саналын дагуу шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж:

1. Монгол улсын үндэсний төв архив. А-3. Х-1. ХН-845. Нугалбар 2

2. Монгол улсын үндэсний төв архив. А-4. Х-1. ХН-237. Нугалбар 1

3. Монгол улсын хил хамгаалалтад холбогдох тогтоол, шийдвэр. УБ.,1995

4. Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаар (Баримтын эмхэтгэл) (1911-1919). УБ.,2011

5. Эмхэтгэсэн Ж.Баттөр, Р.Мөнхтулга. Буурын гэрээ. УБ.,2004

6. Ч.Алтангэрэл нар. Монгол улсын хил хамгаалалтын түүх. УБ., 2012

7. Ж.Баттөр, Р.Мөнхтулга. Монголын дипломат бичгийн

[1] Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаар (1911-1919). УБ.,2011. Х.18-19

дурсгал. Боть I. (Буурын гэрээ). Эмхэтгэл. УБ., 2004

8. Ж.Гэрэлбадрах. Монгол нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ.,2006

9. Э.Жигмэддорж. Манжийн үеийн Ар Монгол дахь хилийн харуул. УБ.,2006

10. Лан Мэй Хуа. Монголын тусгаар тогтнолын төлөө 1911 оны хөдөлгөөн:Нэгдсэн Монгол Улс байгуулах эрмэлзэл. УБ.,2011

11. Ц.Насанбалжир. Ар Монголоос Манжид залгуулж байсан алба. УБ.,1964

12. Б.Цэдэн-Иш. Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүх. УБ.,1997

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН МАТЕРИАЛ-ТЕХНИКИЙН ХАНГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Г.Гантулга
ХХЕГ-ын Техникийн хэлтсийн дарга, докторант, хурандаа

Товч агуулга: Энэхүү сэдвийн хүрээнд Улсын хил хамгаалалтын материал-техникийн хангалтын тогтолцоо, хангалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг талаар тусгасан болно. Үүнд: Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн материал-техникийн хангалтын тогтолцоо, Материал-техникийн хангалтын өнөөгийн байдал, Материал-техникийн хангалтын цаашдын чиг хандлагын талаар дурдсан болно.

Түлхүүр үгс: материал-техникийн хангалт, ар талын хангалт, оператив-стратеги, тогтолцоо.

Удиртгал

Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн материал-техникийн хангалтын тогтолцоо

Цэргийн түүхийг судлан үзэхэд, техник технологи сайжрах, шинээр нэвтрэх тутам томоохон зэвсэгт мөргөлдөөн, дайнд оролцогч талуудын цэргийн стратеги, оператив, тактикийн арга үйл ажиллагаанд шинэчлэл өөрчлөлт орж, түүнийг даган хангалтын тогтолцоог хөгжүүлэх шаардлага урган гарснаар уг тогтолцоонд шинэчлэл хийгдэн дэвшил гарах хөгжлийн зүй тогтол хэрэгжиж иржээ.

Сүүлийн жишээ гэхэд ОХУ-ын Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарууд Украйн улсын хилд цөмрөн зэвсэгт мөргөлдөөн эхэлж, уг зэвсэгт мөргөлдөөний үр дүнд материал-техникийн хангалт шууд нөлөөлж байгаа нь зэвсэгт мөргөлдөөн, дайнд материал хэрэгслийн хангалт чухал үүргийг гүйцэтгэдэг гэдэг ухагдахуун одоо ч утгаа алдаагүйг харуулсан томоохон жишээ болж байна.

Дэлхийн тэргүүлэх улс орнуудын цэргийн байгуулалтын туршлагаас үзэхэд зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн үйлдвэрлэл, нийлүүлэлт болон хангалтыг тус тусдаа байгууллага хариуцдаг тогтолцоотой байна. Зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийг ОХУ-ын БХЯ-нд Зэвсэглэлийн газар, Германы БХЯ-нд Зэвсэглэлийн газар, Их Британийн БХЯ-нд Худалдан авалтын газар, Францын БХЯ-нд Зэвсэглэлийн асуудал эрхэлсэн комисс хариуцдаг байна. Үүнээс дүгнэлт хийж үзэхэд зэвсэгт хүчний нэгдэл, нэгтгэл, ангиудын ар тал болон техникийн хангалтыг материал-техникийн хангалт гэсэн нэгдсэн зохион байгуулалтад оруулж байгаа ажээ. “Зэвсэгт хүчний стратеги” (2017он) бүтээлд “Монгол Улсын

Зэвсэгт хүчинд материалын болон техникийн хангалтыг материал-техникийн хангалт гэсэн ар талын нэгдмэл тогтолцоонд шилжүүлж байна”[244.6] гэж онцлон тэмдэглэжээ.

“Зэвсэгт хүчний стратеги” номд “Цэргийн хангалтын систем /тогтолцоо/” гэсэн ойлголтыг:

- цэргийн нэгтгэл, анги, салбаруудын зохион байгуулалтын бүтэц, орон тооны бүрэлдэхүүн хэсэг, байлдааны талбарт цэргийн хангалтын үүрэг хүлээх шууд гүйцэтгэгч, дээд шатны хангалтын системийн хувьд дэд систем;

- цэргийн нэгтгэл, анги, салбаруудын материал-техникийн хангалтын байгуулалтын зүй тогтол болон зэвсэгт хүчний шинэчлэлийн нөхцөлд материал-техникийн хангалтыг зохион байгуулах тухай шинжлэх ухааны систем гэсэн хоёр хандлагаар авч үзэх болж байна.

Материал-техникийн хангалтын тогтолцоо нь тайван болон дайны цагт цэргийн (хүчний) материал-техникийн хангалтад зориулагдсан харилцан уялдаатай дэд тогтолцоо болон элементүүдийн ***(цэргийн удирдлагын байгууллага,*** *материал-техникийн хангалтын хүч хэрэгсэл)* цогц юм. Өөрөөр хэлбэл, улс орнуудын Зэвсэгт хүчний шат шатны бүтцэд байдаг цэргийн хангалтын тусгай хүч хэрэгслийг бүхэлд нь материал-техникийн хангалт бүрдүүлдэг байна.

“Материал-техникийн хангалт” нь тасралтгүй үйл явц юм. Материал-техникийн хангалтыг байлдааны ажиллагаа (операц)-ны бэлтгэл болон явцад, цэргийн шилжилтийн үед, өдөр тутмын үйл ажиллагааны үед ч зохион байгуулж хэрэгжүүлдэг. Иймээс материал-техникийн хангалтын тогтолцоог байнга боловсронгуй болгон хөгжүүлэх хэрэгтэй болж байдаг. Үүний тулд цэргийн материал-техникийн хангалтын тогтолцооны бүрэлдэхүүн, боломж төдийгүй түүний хөгжлийн зүй тогтол, байлдааны нэгтгэл, анги, салбаруудтай харилцан ажиллах тогтвортой хандлага, аж ахуй хөтлөн явуулах эдийн засгийн шинэ нөхцөл, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулах журам, маркетинг ба менежментийн үндэс, дайны цагийн зах зээлийн эдийн засгийн бусад шинэ механизмыг мэдэх хэрэгтэй болно” [246.6] гэжээ. Иймхүү оператив-стратегийн түвшний ар талын болон техникийн хангалт нь **нэгдмэл тогтолцоонд** шилжиж байгаа нь оператив-стратеги, цэргийн хангалт үйлчилгээнд гарч байгаа бас нэг дэвшил билээ.

Материал-техникийн хангалтын тогтолцоо нь цэргийн албан үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Иймээс хангалтын систем нь хил хамгаалах болон оператив-стратеги ажиллагааны

үндсэн тогтолцооны дэд тогтолцоо болох юм.

ОХУ-ын Цэргийн материал-техникийн хангалтын академид суралцах хугацаанд эрдэмтэн багш нарын заасан онолоор өнөөгийн цэргийн ар тал, техникийн хангалт нь Оператив-стратеги (Арми, корпус, нэгдэл)-ийн түвшинд "Материал-техникийн хангалт", тактик (дивиз, бригад, хороо, батальон)-ийн түвшинд "Ар талын хангалт", "Цэргийн аж ахуй" гэж нэршиж байна. Байлдааны ажиллагаа явуулж буй тактикийн түвшний нэгжид "Ар талын хангалт", тайван цагт бэлтгэлд байгаа тактикийн нэгжид "Цэргийн аж ахуй"-г зохион байгуулдаг гэж үздэг. Хилийн цэргийн шугамын анги, салбар нь тайван цагт байлдааны үүрэг гүйцэтгэдэг тул тактикийн нэгжийн хангалт нь "Ар талын хангалт", бусад сургалт, хангалтын салбар, нэгжийн хангалт нь "Цэргийн аж ахуй" юм.

Хил хамгаалах ерөнхий газар нь оператив-стратегийн түвшинд үйл ажиллагаа явуулж байгаа тул зохион байгуулж байгаа хангалт нь "Материал-техникийн хангалт" гэж үзнэ.

Зориулалт, шийдвэрлэх үүргийн хувьд материал-техникийн хангалтын тогтолцоог:

2.1.материалын хангалт;

2.2.техникийн хангалт;

2.3.тээврийн хангалт;

2.4.цэргийн хүн эмнэлгийн хангалт;

2.5.мал эмнэлэг-эрүүл ахуйн хангалт;

2.6.зэвсэгт хүчний төрөл мэргэжлийн цэргийн нэгдэл, нэгтгэл, ангиудын материал-техникийн хангалтын тусгай төрөл гэсэн дэд системд ангилдаг байна" [246-247.6] хэмээн заажээ.

Үүнээс гадна бусад дэд тогтолцоонд гал түймрээс хамгаалахын хангалт, экологийн аюулгүй байдлын хангалт, материал-техникийн хангалтын анги, салбаруудын харуул хамгаалалт ба өнгөлөн далдлалт, материал-техникийн хангалтын удирдлагыг тус тус хамааруулж тооцно.

Цэргийн материал-техникийн хангалтын байгууллага (хүч хэрэгсэл)-ыг харьяаллын хувьд Зэвсэгт хүчинд: дивизийн, бригадын, хорооны, батальоны (дивизионы) ар тал техникийн хангалт, Хил хамгаалах байгууллагад: отрядын, комендатурын, заставын ар тал техникийн хангалт гэж ангилагдах бөгөөд тэр нь цэргийн материал-техникийн хангалтын бүтцэд онцгой байр эзэлнэ.

Хилийн цэргийн материал-техникийн хангалтын өнөөгийн байдал

Хилийн цэргийн материал-техникийн хангалт, хилийн анги, салбаруудын ар тал техникийн хангалт нь цэргийн бүх төрлийн хангалтын нэг үндсэн төрөл билээ.

Хилийн цэргийн материал-техникийн хангалтын өнөөгийн

байдлыг 2021-2024 оны байдлаар төрлөөр нь авч үзвэл:

Техник, тээвэр хангалт:

Хил хамгаалах байгууллага автопарк шинэчлэлийн хүрээнд улсын хил хамгаалалт, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэд техник, технологитой туулах чадвар сайжруулсан болон цахилгаан автомашин, газар усnaa явагч, мотоцикл зэрэг нийт 892 нэгж автомашин, техник шинээр авч, хил хамгаалалтад ашиглаж байна. Авто парк шинэчлэлт 44.5 хувь, үүнээс хилийн заставын автомашины шинэчлэл 100 хувь, цэрэг тээврийн автобусны шинэчлэлт 34 хувьд хүрсэн.



Цэрэг тээврийн зориулалт бүхий 32 нэгж автобус худалдан авч хангаснаар бие бүрэлдэхүүнийг бүлэглэн шилжүүлэх, аюулгүй тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлж, тээврийн боломжийг 949 зорчигчоор буюу 37.7 хувиар нэмэгдүүлсэн.

Зорчигч тээврийн тоо**:** 126 багтаамж : 2513 зорчигч

Ачааны тээврийн хэрэгслийн тоо: 258 даац: 2653 тн байна.

Хилийн инженерийн хангалт:

Монгол Улсын хилийн хэсгийн инженерийн байгууламжаар халхлах боломжтой хэсгийг халхалсан хувь:

Хилийн торон саад – 45.4%

Мөр хянах зурвас – 28.5%

Шороон зурвас – 11.4%

Ойн зурвас – 10.2%

Нүхэн саад – 3% км

Монгол Улс-Оросын Холбооны Улсын хил хамтран шалгах ажлын хүрээнд нийт 1697 хилийн тэмдэг хүлээн авч, газар

дээр нь тээвэрлэн хүргэх ажлыг зохион байгуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1073 км урт хилийн торон саад шинээр байгуулсан.

Хилийн цэргийн 7 ангийн хариуцсан хэсэгт 10 ширхэг хянах цамхаг шинээр байгуулсан.

Хилийн хэсэгт 7 ширхэг гүний худаг гаргаж, 6 ширхэг гүүр шинээр байгуулсан.

“Боршоо, Алтанбулаг” боомтын хэсэгт 125 км шилэн кабелийн дохиолол хяналтын систем байгуулах ажлыг гүйцэтгэсэн.

Хилийн цэргийн ангиудын хариуцсан хэсэгт 230 ком тоон радио релейн цамхаг байгуулсан.

Материал хангалт:

А.Барилга орон сууцны хангалт:

Байгууллагын хэмжээнд албаны байр 1294, орон сууц 686, харуулын байр 252, бусад зориулалтын 87 байр, нийт 2319 барилга ашиглагдаж байна.

Хил хамгаалах байгууллагын “Барилга байгууламжийн шинэчлэл” хөтөлбөрийн хүрээнд УТХО-аар ХХЕГ-ын өргөтгөл, Эрээн цав, Цагаан-Уулын шинэ анги, Хилийн цэргийн 2 ангийн штаб, 1 ангийн соёлын төвийн барилгыг шинээр барьж, урсгал засварын зардлаар нэгдсэн халаалт, цэвэр бохир усны системд холбогдсон. Хилийн цэргийн анги, салбаруудад 236 айлын орон сууц, штаб, гэрээт болон хугацаат цэргийн байр, эмнэлэг, агуулах зэрэг 22 барилга, байгууламж барьж ашиглалтад оруулсан.

Хилийн цэргийн 3 салбар, 1 харуул, 2 сувиллыг шинээр төвлөрсөн эрчим хүчний системд холбож, 21 салбарт 5-10 кВт-ын нарны цахилгаан үүсгүүр суурилуулсан.

Хилийн цэргийн 3 ангийн төвийг төвлөрсөн дулаан хангамжид, 4 анги, 1 тусгай салбар, 57 хилийн салбарыг хийн халаалтад шилжүүлж, 10 ангийн төв, 53 хилийн салбарт бие даасан ариун цэврийн байгууламж суурилуулсан.

Б. Хүнсний хангалт:

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 174 дүгээр тогтоолоор батлагдсан хилчдийн хүнсний хангамжийн 4 нормын дагуу хангалт зохион байгуулж байна. Гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын хооллолтыг долоо хоногт 3 удаа сонголттой хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн.

Хилийн салбарын офицер, ахлагчийн хүнсний хангалтыг цахим захиалгаар 2024 онд хилийн цэргийн 0101 дүгээр ангид туршилтаар зохион байгуулж, 2025 оноос эхлэн улиралд 1 удаа зохион байгуулж байна.

Хилийн цэргийн ангиудад хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалт бүхий хөргүүртэй машинаар хангах ажлыг зохион байгуулсан.

В. Хувцасны хангалт:

Хилийн шалган нэвтрүүлэх албаны зорчигчийн баримт бичиг шалгах манааны нэмэгдэл хувцас (пальто), цэргийн алба хаагчдын сэрүүний улирлын дулаан дотортой дээл, уулын болон ой тайгын бүсийн хилийн манааны урт түрийтэй өвлийн гутлын загвар, нормыг шинэчлэн ХЗДХЯ-ны сайдын 2022 оны А/147 дугаар тушаалаар баталгаажуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 141 дүгээр зарлиг /Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварыг батлах тухай/-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд шинэ төрөл загварын цэргийн дүрэмт хувцас хэрэглэлийг албаны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эрэмбэлэн ангилж, нэн тэргүүнд хил хамгаалах байгууллагын хэмжээнд бүрэн олгох шаардлагатай 14 нэр төрлийн дүрэмт хувцас хэрэглэлийг бэлтгэж байна.

ХХЕГ-ын даргын 2024 оны А/04 дүгээр тушаалаар “Мөнгөн хангамжийн журам”-ыг батлуулан алба хаагчдад цэргийн дүрэмт хувцас хэрэглэлийн хангалтыг мөнгөн хангамж хэлбэрээр олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Г.Хөдөө аж ахуйн хангалт:

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд 2024 оны жилийн эцсийн мал, амьтдын тооллого зохион байгуулж, 52822 толгой амьтан тус тус тоологдсон.

Хилийн цэргийн ангиудад 209.1 сая төгрөгийн санхүүжилтээр мал, сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх малын эм, бэлдмэл, багаж, хэрэгсэл худалдан авч хангасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Хил хамгаалах байгууллага “Ногоон хэрэм” төсөл хэрэгжүүлж, Хилийн цэргийн 0166, 0198, 0286, 0243, 0101-р анги, 0267-р тусгай салбарт Мод үржүүлгийн 6 агропарк, бусад ангиудад мод үржүүлгийн 23 төв байгуулж, 15 нэр төрлийн 1.5 сая ширхэг суулгац бэлтгэсэн.

Зэвсгийн хангалт:

Хил хамгаалах байгууллагад шаардлагатай 3 нэр төрлийн буудлагын зэвсэг, 374 нэгж галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, 4 нэр төрлийн ширхэг галт хэрэглэл, дуран харааны хэрэгсэл, 20 нэр төрлийн 1860 ширхэг тусгай хэрэгслийг худалдан авч, хилийн цэргийн анги, салбаруудад хангалтаар олгосон.

Хилийн цэргийн ангиудад засварын бүлэг томилон 20 ангийн буудлагын зэвсэгт их болон дунд засвар, үйлчилгээ хийсэн.

Нисэх алба:

Хил хамгаалах байгууллага Cessna 208B grand caravan EX бага оврын нисэх онгоц, Super puma EC225 загварын нисдэг тэргийг хил хамгаалалтад ашиглаж байна.

“Агаарын хөлгөөр гүйцэтгэх тусгай үүргийн нислэгийн захиалга авах, орлого

төвлөрүүлэх, зарцуулах журам”-ыг Хууль зүй дотоод хэргийн сайдын 2023 оны А/111 тушаалаар батлуулан мөрдөж ажиллаж байна.

Хүн эмнэлгийн хангалт:

Хилийн цэргийн ангиудын Эрүүл мэндийн төвийг ЭМЯ-ны сайдын тушаалаар магадлан итгэмжлүүлж, магадлан итгэмжлэлд хамрагдсан 7 эрүүл мэндийн төвтэй болсон.

БНХАУ-ын Шанхай хотын “Тэнгисийн цэргийн анагаахын их сургууль”, БНХАУ-ын ӨМӨЗО-ны “Хөх хотын Анагаахын их сургууль” бусад мэргэжил дээшлүүлэх сургалтад нийт 22 эмчийг хамруулж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн.

ХХЕГ-ын даргын 2025 оны А/21 дүгээр тушаалаар “Эрүүл биед саруул ухаан оршино” дунд хугацааны хөтөлбөр боловсруулан, баталгаажуулсан.

Материал-техникийн хангалтын цаашдын чиг хандлага

Олон улсын цэрэг, улс төрийн харилцаанд эрс өөрчлөлт гарч, хил дамнасан хориотой эд зүйлсийн хууль бус наймаа идэвхжин, мансууруулах бодис, хүний наймаа өргөжин тэлж, олон улсын хэмжээнд алан хядах ажиллагаа сүлжээ үүсгэж байгаа нь хил орчмын нөхцөл байдалд төвөгтэй байдлыг бий болгож буй тул улсын хилийн хамгаалалтын арга ажиллагаанд шинэчлэлт, өөрчлөлт гарах хэмжээгээр Материал- техникийн хангалт, Ар тал, техникийн хангалтын онолыг боловсронгуй болгон хөгжүүлэх, материал-техникийн хангалтын зохион байгуулалт, анги салбаруудын бүтэц бүрэлдэхүүн, боломж төдийгүй, хангалтын үйл ажиллагааны зүй тогтлыг сайжруулах шаардлага урган гарч байна.

Үүнээс гадна Монгол Улсын хөгжлийн стратеги бодлого нь бүсчилсэн байдлаар орон нутгийг хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж, УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталсан бөгөөд бүсчилсэн хил хамгаалалт, түүний материал-техникийн хангалтыг энэхүү бодлоготой нийцүүлэн зохион байгуулах нь цаг хугацааны хувьд хэмнэлттэй, илүү үр дүнтэй юм.

Монгол Улсын Хилийн тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн 33 дугаар зүйлд “Хилийн нөхцөл байдал, байгаль, газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан улсын хил хамгаалалтыг ялгавартайгаар зохион байгуулахыг бүсчилсэн хил хамгаалалт гэнэ. Бүсчилсэн хил хамгаалалттай уялдуулан хилчний хилийн нэмэгдэл, цалин, хангамж, материал хэрэгслийн хангалтын норм, хэмжээг Засгийн газар тогтооно...” гэж улсын хилийн бүсчлэн хамгаалалтыг зохион байгуулж явуулах эрх зүйн үндэс нь хуульчлагдсан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын Засгийн газрын 2012 оны мн/110 дугаар тогтоолоор

батлагдсан “Бүсчилсэн хил хамгаалалт” хөтөлбөрт Монгол Улсын хилийг газар орны онцлог, цаг агаар, хил хамгаалалтын онцлогоос шалтгаалан “Говь цөлийн”, “Тал хээрийн”, “Уулын”, “Ой тайгын”, “Төвийн” хэмээн таван бүст хуваасан билээ.

Улсын хилийн хамгаалалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах үеийн энэхүү таван бүсийн материал-техникийн хангалт нь хилчдийн энерги зарцуулалт, газар орны бартаа саад, дэд бүтцийн хөгжил, зэвсэг техникийн ашиглалтаас шалтгаалан ялгавартай тогтоох, цаашид улсын хил хамгаалалт нь бүсчилсэн зарчмаар явагдах тул түүнд тохирсон бүсчилсэн хангалтыг зохион байгуулах бүтэц, удирдлагын тогтолцоо, хангалтын цувраажилт, хангалтын норм хэмжээг нарийвчлан тодорхойлох, шаардлагын дагуу үе шаттайгаар шинэчлэх талаар төлөвлөн ажиллаж байна.

Техник, тээвэр хангалт:

Бүс нутгийн газар зүйн онцлогт тохирсон автомашин, техникээр хилийн отряд, ангиудыг хангах.

Орчин үеийн туулах чадвар сайтай автомашинаар хилийн отряд ангийн тусгай томилгоот бүлгүүдийг хангах;

Цахилгаан автомашиныг төвийн бүсийн ангиуд, төвлөрсөн эрчим хүчинд холбогдсон хилийн анги, салбарт хангах;

UTV /4 дугуйт/ мотоциклоор хилийн салбаруудыг ханган хилийн манааны үндсэн уналга болгох;

Хилийн цэргийн ангиудын дунд даацын ачааны автомашинуудыг шинэчлэх;

Усан хил хамгаалалтын техник хэрэгслүүдэд их засвар хийж, найдвартай байдлыг дээшлүүлэх;

Техникийн албан тушаалтнуудыг мэргэшүүлэх сургалтад хамруулж, жолооч бэлтгэх, ангилал ахиулах сургалтыг чанартай зохион байгуулан хүний нөөцийг бэхжүүлэх;

Шинэ загварын автомашин, техник, түүний ашиглалттай уялдуулан урсгал засвар, шатахууны төсвийг үе шаттай нэмэгдүүлэх;

Хилийн инженерийн хангалт:

Монгол Улс-Оросын Холбооны Улсын хил хамтран шалгах ажлын хүрээнд хилийн тэмдэг газар дээр нь байрлуулах ажлыг зохион байгуулах.

Улсын хилийн боломжит хэсгийг инженерийн торон саадаар бүрэн халхлах.

Хилийн зөрчил гарч болзошгүй хэсэг болон боомтын хэсэгт шилэн кабелийн дохиолол хяналтын систем байгуулах.

Хилийн цэргийн бүх ангийн хариуцсан хэсэгт тоон радио релейн цамхаг байгуулах.

Нисгэгчгүй нисэх хэрэгслээр хилийн цэргийн анги, салбарыг хангаж, хил хамгаалалтад ашиглах.

Материал хангалт:

А.Барилга орон сууцны хангалт:

“Барилга байгууламжийн шинэчлэл” хөтөлбөрийн хүрээнд хилийн цэргийн 2 анги шинээр байгуулж, ангийн төвд 825, хилийн салбарт 685 айлын орон сууц, штаб, соёл, спортын цогцолбор, хүн эмнэлэг, агуулах бусад зориулалтын 156 барилга шинээр барих;

Эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр анги, тусгай салбарын 7, салбаруудын 36 хувийг төвлөрсөн эрчим хүчний системд холбох, 27 хувийг 10 кВт-ын нарны цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлж 40 хүртэл кВт болгох;

Дулааны эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд анги, тусгай салбарын 26 хувийг, салбаруудын 7 хувийг суурьшлын газрын нэгдсэн халаалт, цэвэр, бохир усны шугамд холбох;

Байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон түлшний зарцуулалт багатай хатуу болон шингэн, хийн түлшний халаалтын зуухыг анги, салбаруудын дулаан хангамжид нэвтрүүлэх;

Б. Хүнсний хангалт:

Хилийн цэргийн хүнсний хангалтын зааврыг шинэчлэн боловсруулах.

Хилийн цэргийн анги, тусгай салбаруудын хүнсний тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэх ажлыг зохион байгуулах.

Хүнсний цахим захиалгын программыг ашиглалтад оруулж, хилийн салбарын офицер, ахлагчийн хүнсний хангалтыг захиалгаар хүргэх ажлыг хэвшүүлэх.

В. Хувцасны хангалт:

“Мөнгөн хангамжийн журам”-ыг хэрэгжүүлэн алба хаагчдад цэргийн дүрэмт хувцас хэрэглэлийн хангалтыг мөнгөн хангамж хэлбэрээр олгох.

Хилийн цэргийн анги, салбаруудыг шинэ загварын хувцсаар бүрэн хангах ажлыг зохион байгуулах.

Бүсчилсэн хил хамгаалалтын хүрээнд байгаль, цаг уурын эрс тэс уур амьсгалд удаан хугацаагаар үүрэг гүйцэтгэдэг Хилчдийн цэргийн дүрэмт хувцас хэрэглэлд орчин үеийн шинжлэх ухааны дэвшилтэд “Халдаг хувцасны технологи”-ийг албанд нэвтрүүлэх.

Г.Хөдөө аж ахуйн хангалт:

Бүс нутгийн онцлогт тохирсон эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх бөгөөд эхний ээлжид зүүн бүсийн эрчимжсэн аж ахуй цогцолборыг байгуулж таваарлаг мал, амьтдыг өсгөн махны гарцыг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд хилийн цэргийн 27 ангид хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.

Хил хамгаалах байгууллагын “Ногоон хэрэм” төслийг хэрэгжүүлж, хилийн цэргийн анги, тусгай салбарын агропарк, мод үржүүлгийн төвийн ажлыг эрчимжүүлэх.

Зэвсгийн хангалт:

Хилийн цэргийн анги, боомтуудын тусгай томилгоот бүлгүүдийн зэвсэглэл, тусгай хэрэгслийн хангалтыг эхний ээлжид цаашид хилийн салбарын зэвсэглэл, тусгай хэрэгслийн хангалтыг үе шаттай шинэчлэх ажлыг зохион байгуулна.

Хүн эмнэлгийн хангалт:

ХХЕГ-ын даргын 2025 оны А/21 дүгээр тушаалаар “Эрүүл биед саруул ухаан оршино” дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, хилчдийн эрүүл ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Өмнөд, баруун, зүүн, хойд бүсүүдэд бага оврын нисдэг тэрэгтэй нисэх хэсэг байгуулах.

Дүгнэлт

Улсын хил хамгаалалтын өнөөгийн материал техникийн хангалт зохих түвшинд байгаа боловч олон улсын цэрэг, улс төрийн хурцадмал нөхцөл, бүсчилсэн хил хамгаалалтад шилжих зэргээс улсын хилийн хамгаалалтын арга ажиллагаанд шинэчлэлт, өөрчлөлт гарах хэмжээгээр Материал-техникийн хангалт, Ар тал, техникийн хангалтын онолыг боловсронгуй болгон хөгжүүлэх, материал-техникийн хангалтын тогтолцоо, бүтэц зохион байгуулалт, анги

Хилийн ангиудын эрүүл мэндийн төвүүдийг магадлан итгэмжлэлд оруулж, эмнэлгийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авах.

Хилчдийн зонхилох өвчний судалгааг үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эмчилгээ, сувилгааг бүсчилсэн байдлаар зохион байгуулах.

Нисэх алба:

Нисдэг тэрэгний тоог нэмэгдүүлэн, нисэх хэсгийг өргөтгөн хилийн цэргийн нисэх ангийг дахин байгуулж, хил хамгаалалтад агаарын хөлгийг тогтмол ашиглах.

Агаарын хөлгийн ангар шинээр байгуулж, хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, нисэхийн газрын төхөөрөмжийг нэмэгдүүлэх, сайжруулах арга хэмжээ авах.

салбаруудын бүтэц бүрэлдэхүүн, боломж төдийгүй, хангалтын үйл ажиллагааны зүй тогтлыг сайжруулах нь улсын хилийн аюулгүй байдал, үндэсний сөрөн тэсвэрлэх чадварын суурь бүрэлдэхүүн болно гэж дүгнэж байна.

Дээрх дүгнэлтээс үндэслэн дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1.Бүсчилсэн хил хамгаалалтын хүрээнд стратеги, оператив, тактикийн түвшинд бүсчилсэн хангалт зохион байгуулах судалгаа шинжилгээ хийх.

2.Бүсчилсэн хил хамгаалалтын материал-техникийн хангалтыг улсын бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах арга замыг тодорхойлох.

3.Материал-техникийн хангалтын тогтолцоог шинэчлэн бүсийн хилийг удирдах газрын дэргэд бүсийн хангалтын төвүүдийг байгуулах талаар тооцоолол хийх.

4.Бүсчилсэн хангалтын цувраажилт, нөөц бүрдүүлэлтийн асуудлыг тодорхойлох зэрэг саналыг дэвшүүлж байна.

Эх сурвалж:

1.“Зэвсэгт хүчний стратеги” 2017 он
2.Ар талын дүрэм. УБ. 2017
3.Ганбаатар.Д “Системийн онолыг хил хамгаалах байгууллага, хилийн цэргийн материал техникийн хангалтад ашиглах нь” УБ.2019.
4.Батбаатар.Б., Намнан.Ж. Цэргийн ар талын удирдлага,төлөвлөлт УБ.2008
Цахим эх сурвалж:
5.Vamto.mil.ru

ЦЭРЭГ ТЕХНИКИЙН БОДЛОГО

Я.Ариунболд
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн хилийн албаны стратегийн тэнхимийн профессор, докторант, хурандаа

Товч агуулга: Төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудад үндэсний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай цэрэг техникийн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны тасалдлыг арилгах зорилгоор цэрэг иргэний харилцаан дээр тулгуурласан цэрэг аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагаа болон гадаад улсуудтай хийх цэрэг техникийн хамтын ажиллагаar өргөжүүлэн тэлж, улмаар цэрэг техникийн салбарт экспорт, импортын зохистой харьцааг хангах боломжийг бүрдүүлэх.

Түлхүүр үгс: Цэргийн техник, зэвсэг, галт хэрэгсэл, галт хэрэглэл, материал хэрэгсэл, техник хэрэгсэл, хилийн цэргийн хангалт.

Удиртгал

Аливаа тусгаар улсын хөгжил нь тухайн улс орны үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурласан хөгжлийн бодлого, түүний хэрэгжилтээр тодорхойлогддог.

Хөгжлийн бодлого гэж улс, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс батлсан баримт бичгийг[1] хэлдэг.

Төрийн бодлого нь гадаад, дотоод нөхцөлөөс хамаарах бөгөөд бүрэлдэхүүнд нь цэргийн бодлого багтана.

Цэргийн бодлого гэж аливаа улсын улс төрийн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд цэргийн байгуулалтыг хөгжүүлэх, зэвсэгт тэмцлийн хэрэгслийг бэлтгэх, хэрэглэхтэй шууд холбоотой бодлогын бүрэлдэхүүн хэсэг юм.

Үндсэн хэсэг

Цэрэг, техникийн бодлого

Цэргийн бодлогод зэвсэгт хүчний (төрийн цэргийн байгууллагуудын Ж.Ж) бүтэц, зохион байгуулалтыг хөгжүүлж боловсронгуй болгох, зэвсэг техникийн хөгжил, хэтийн төлөвийг тодорхойлох, улсын дайчилгааны бололцоог тооцох, цэргийн боловсрол эзэмшсэн

[1] Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль. 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт. УБ.2020

иргэдийн нөөцийг бэлтгэх, зайлшгүй шаардлагатай үед зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах зэрэг асуудал чухал байр суурь эзэлдэг[1].

Цэргийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг нь цэрэг техникийн бодлого юм. Цэрэг-техникийн бодлого нь улс орны үндэсний аюулгүй байдлын цэрэг- техникийн хангалтыг хангах зорилгоор төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын хэрэгжүүлж байгаа бодит үйл ажиллагаа ба зарчмын үзэл бодлын цогц[2]. Цэрэг-техникийн бодлогын гурван бүрэлдэхүүн хэсэг (зэвсгийн систем, батлан хамгаалах аж үйлдвэрийн цогцолбор, цэрэг-техникийн хамтын ажиллагаа)-ийг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө нь үндсэн зорилго, зорилтын хувьд нэлээд зөв уялдаж байх ёстойг тэмдэглэх нь зүйтэй[3].

ОХУ, АНУ, Франц, Герман, Япон зэрэг хөгжингүй орнуудад цэргийн номлолынхоо хүрээнд гаргасан цэрэг техникийн бодлого, түүнийг дагасан цэргийн техникийн болон төрийн зэвсэглэлийн хөтөлбөр зэрэг 6-30 жилийн хугацаатай, 2-5 жил тутамд тодотгодог дунд, урт хугацааны баримт бичгүүд, 1-3 жилийн хугацаатай төлөвлөгөөнүүдийг батлуулж, түүний хэрэгжилтийг хангах замаар шийдвэрлэж байна.

Энэхүү бодлогод тодорхой зорилго, зорилтуудыг тусгах бөгөөд цэрэг, зэвсгийн шинэчлэлийг хийх хугацаанд хүрэх зорилтот хувь, түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх төрлийн хөрөнгө оруулалтыг тогтвортой байлгахаар заадаг.

Бодлогын хүрээнд гарсан хөтөлбөрүүд нь судалгаа шинжилгээ, зохион бүтээх технологи, туршилт, үйлдвэрлэл, худалдан авалт, засвар, ашиглалт, устгал, үйлчилгээ, хүний нөөц, түүний сургалт бэлтгэл зэрэг цогц үйл ажиллагааны нэгдлийг хангадаг байна.

Дэлхийн цэргийн аж үйлдвэрийн хөгжил нөөцийн хомсдол, эрэлт хэрэгцээний хязгаарлалттай тулгарч байна. Цэргийн аж үйлдвэрийн хөгжлийн загварыг өөрчилж, цэргийн технологийн шинэчлэл, өндөр технологийн аж үйлдвэржилтийг дэмжин, цэрэг-иргэний интеграцчлал явагдаж байна.

Ирээдүйд цэргийн аж үйлдвэрийн өөрчлөлт нь дэлхийд хурдацтай хөгжлийг авчирна гэж үзэх хэсэг бий.

---

[1] Цэргийн нэр томьёоны тайлбар толь. 2014. УБ. 349 дэх тал

[2] Рогозин. Д. Война и мир. Москва. 2014

[3]. Поповкин В.А. Первый заместитель Министра обороны РФ. Особенности военно-технической политики Российской Федерации в современных условиях. http://federalbook.ru/files/OPK/Soderjanie/OPK-7/III/Popovkin.pdf

Хүснэгт 1. Дэлхийн тэргүүлэгч улс орнуудын зэвсэглэл ба цэргийн техникийг хөгжүүлэх хөтөлбөрүүдийн харьцуулалт

ЗЭВСЭГЛЭЛ БА ЦЭРГИЙН ТЕХНИКИЙГ ХӨГЖҮҮЛЭХ УРТ БА ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨРҮҮД				
Улс	**Нэршил**	**Үйлчлэх хугацаа**	**Тодотгох журам**	**Хамрагдаж буй зэвсэглэл, цэргийн техникийн амьдралын үе шатууд**
Орос	*Төрийн зэвсэглэлийн хөтөлбөр*	*10 жил*	*5 жилд 1 удаа*	*Шинжлэх ухаан-судалгааны болон зохион бүтээлт туршилтын ажлууд, худалдан авалт болон үйлчилгээ хийх*
АНУ	*Батлан хамгаалах яамны хэтийн хөтөлбөр*	*6 жил*	*2 жилд 1 удаа*	*Шинжлэх ухаан-судалгааны болон зохион бүтээлт туршилтын ажлууд, үйлдвэрлэл, дэлгэлт, ашиглалт болон устгалт*
Франц	*Хэтийн төлөвлөгөө "PP 30"*	*30 жил*	*Жил бүр*	*Үзэл баримтлал*
	Зэвсэгт хүчний байгуулалтын болон техникийн хангамжийн хөтөлбөр	*6 жил*	*2-3 жилд 1 удаа*	*Үйлдвэрлэлийн боловсруулалт, туршилт, үйлдвэрлэл, оперативын бэлэн байдалд байлгах, зэвсэглэлээс авах*
Герман	*Бундесверийн байгуулалтын төлөвлөгөө*	*15 жил*	*Жил бүр*	*Шинжлэх ухаан-судалгааны болон зохион бүтээлт туршилтын ажлууд, үйлдвэрлэл*

Япон	*Үндэсний батлан хамгаалах хөтөлбөрийн үндсэн чиглэлүүд*	*20 жил*	*1. Зэвсэгт хүчний байгуулалтын 4 жилийн, дунд хугацааны төлөвлөгөөний хүрээнд 2. Жил бүр*	*Худалдан авалт, засвар, ашиглалт, устгалт*

Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ойрын хугацааны төлөвлөгөөнүүд		
Улс	***Нэршил***	***Үйлчлэх хугацаа***
Орос	*Төрийн батлан хамгаалалтын захиалга*	*3 жил*
АНУ	*Хөтөлбөр "R-1" (шинжлэх ухаан-судалгааны болон зохион бүтээлт туршилтын ажлууд) ба "P-1" (зэвсэглэл, цэргийн техникийн үйлдвэрлэл) жилийн төсвийн хүрээнд*	*1 жил*
Франц	*Жилийн, цэргийн төсвийн хүрээний Батлан хамгаалах яамны санхүүгийн чиг үүргүүдэд харгалзах батлан хамгаалалтын захиалга*	*1 жил*
Герман	*Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх хөтөлбөр*	*1 жил*
Япон	*Өөрийгөө хамгаалах хүчнийг боловсронгуй болгох төлөвлөгөө*	*1 жил*

Дэлхийн улс орнуудын цэрэг техникийн бодлого

Дэлхийн цэрэг техникийн бодлогын томоохон өөрчлөлтийг анх 1993 онд АНУ нь цэргийн үйлдвэрлэлийн технологийн шилжилт хийхийн тулд цэрэг техникийн бодлогын шилжилтийг хэрэгжүүлэх чиглүүлэх, зохицуулах зорилгоор "Үндэсний батлан хамгаалахын технологийн шилжилтийн хороо" гэж салбар дундын агентлаг байгуулж, шинэчлэл хийж[1] улмаар 1996 онд АНУ-ын Шинжлэх ухаан, технологийн үндэсний комисс "Технологи ба үндэсний аюулгүй байдал" хэмээх бодлогын чухал баримт бичигт анх удаа цэргийн болон иргэний үйлдвэрлэлийн баазыг нэгтгэх асуудлыг хөндөж, иргэний салбарт шинээр гарч ирж буй өндөр технологийг эзэмших зорилгоор 30 мянга гаруй хувийн өндөр технологийн аж ахуйн нэгжийг цэрэг, иргэний хамтын ажиллагааны жагсаалтад оруулж, "Иргэний технологийг ашиглах,


1 https://www.sohu.com/a/465011225_635792

дэмжих санаачилга"-д нэгтгэжээ. Үүний дараа дэлхийн олон оронд энэхүү шинэчлэлт хийгдсэн байдаг.

Өдгөө дэлхийн цэрэг, улс төрийн цагийн байдал жил бүр ээдрээ төвөгтэй болж, хүйтэн дайнаас хойш буюу 1985 оноос сулраад байсан цэрэг зэвсэглэлээр хөөцөлдөх үйл явц дэлхий даяар 2006 оноос нэмэгдэж, сүүлийн жилүүдэд өсөлт үзүүлж эхлэв.

Дэлхийн улс орнуудын цэрэг техникийн салбарт хийсэн технологийн шинэчлэлүүд нь тэдгээрийн хооронд өрсөлдөөнийг үүсгэж эхэлсэн байна.

Зураг №1. Олон улсын зэвсэглэлээр хөөцөлдөх чиг хандлага (1981-2020 он)[1]




Жишээ нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2010.12.31-нд батлсан “Төрийн зэвсэглэлийн хөтөлбөр" нь 2011-2020 оны хооронд цэрэг зэвсгийн шинэчлэлийг 70 хувьд хүргэх зорилт тавьж, түүнийгээ хэрэгжүүлэхэд 19 тэрбум рубль зарцуулсан бол 2018 онд 2020-2027 хүртэл хэрэгжүүлэх дараагийн хөтөлбөрийг баталж, түүндээ 20 тэрбум рубль зарахаар тооцож, цэрэг зэвсгийн шинэчлэлийг 100 хувьд хүргэхээр тусгажээ.

Хөтөлбөрийн үр дүнд дэлхийд I байрт бичигдэх тавдугаар үеийн тив алгасагч пуужингийн Сармат болон пуужингийн Рубеж цогцолборуудыг бүтээгээд байна. Ялангуяа сүүлийн 10 жилд дэлхийн улс орнуудад цэргийн номлол болон цэргийн стратеги, цэрэг техникийн бодлогууддаа өөрчлөлт оруулах үйл явц өрнөв. Энэ талбарт тэргүүлэгч гэгдэх АНУ, ОХУ, БНХАУ болон хөгжингүй болон хөгжиж буй улсуудад энэ үйл ажиллагаа эрчимтэй явагдаж, улмаар цэрэг зэвсгийн үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, хэрэглээгээ өндөрсгөж байна.


Зураг №2. Зэвсэг экспортлогч орнуудын зах зээлд эзлэх хувь (2016-2020 он)

[1] htpp://sipri.org/sites/default/files/2021-3/fs_2103.pdf



Хамгийн том зэвсгийн экспортлогчид нь АНУ, Орос, Франц, Герман, Хятад улс хэвээр байна. Зэвсгийн гол хэрэгцээг Алс Дорнодын бүс нутаг хангадаг бөгөөд Саудын Араб дэлхийн хамгийн том зэвсгийн импортлогч болжээ[1].

Энэ зах зээлд ажиглагдаж буй нэг онцлог нь цэрэг зэвсгийн экспортод 2011-2015 оны дараагаас өөрчлөлт орж Азиас БНСУ, Европоос Израйл, Франц улсууд 2016-2020 оны хооронд цэрэг зэвсгийн худалдаанд идэвхтэй байр суурьтай оролцох болсныг олон улсын шинжээчид онцолж байна.



Зураг №3. Зэвсэг экспортлогч орнуудын зах зээлд эзлэх хувь (2016-2020 он)[2]

Үүнд нөлөөлж буй хүчин зүйл нь сүүлийн жилүүдэд болж буй цэрэг дайны үйл ажиллагаанд орж буй өөрчлөлтүүд юм.

[1] www.vesti.ru/Мировой рынок вооружений 2020: главные поставщики и покупатели увеличили активность

[2] https://sipri.org/ sites/ default/2021-03/fs_2013_at_2020.pdf

Тухайлбал, 2020 онд Армени болон Азербайжан улсын хооронд хил орчмын газар нутгийн маргаантай байдлаас үүссэн зэвсэгт мөргөлдөөн нь эдгээр улсад зэвсгийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлсэн. Хоёр улс зэвсэглэл, тэр дундаа пуужингийн худалдан авалтаа нэмэгдүүлсэн. Армени улс 100 хувь Оросоос зэвсэг авдаг бол Азербайжан улс цэрэг зэвсгийн шинэчлэлт хийж, худалдан авалтын 60 хувийг Израйлаас, 31 хувийг Оросоос авсан. Үлдэх есөн хувийг бусад улс орноос авсан бөгөөд ялангуяа Турк улсаас авсан Байрактар ТБ2 нисгэгчгүй нисэх хэрэгсэл[10] үр дүнтэй ашиглагдсан билээ.

АНУ нь цэрэг техникийн бодлогоо хэрэгжүүлэхдээ цэрэг-иргэний технологи шилжүүлэх бодлогыг чухалд авч үздэг. Үүнд:

1. Цэргийн салбарт иргэний дэвшилтэт технологиудыг шууд нэвтрүүлэх, төсөл хэрэгжүүлэх;

2.Иргэний болон цэргийн үйлдвэрлэлийг нэгтгэсэн “давхар хэрэглээний үйлдвэрлэл” төсөл боловсруулж, хэрэгжүүлэх

3.Иргэний салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйл явцад дэмжлэг үзүүлэх

4. Технологийн судалгаа, хөгжлийн төв эсвэл технологи сурталчлах төвөөр дамжуулан цэргийн болон иргэний давхар хэрэглээнд хүрэх, технологийн ололт амжилтыг хоёр талын дамжуулалт эрэг харилцан үйлчлэлээр хангах явдал бөгөөд АНУ-ын сансрын агентлаг НАСА нь цэргийн өндөр технологийг иргэний салбарт өргөнөөр ашиглаж, сүүлийн арван жилд шинжлэх ухааны судалгаанд 25 тэр бум ам долларын орлого олжээ. Нийт дүнгээр өнгөрсөн хугацаанд батлан хамгаалахын зардлаас жилд 30 тэрбум ам доллар хэмнэж, хүний нөөцийн 20 гаруй хувийг цомхотгож чаджээ[1].

АНУ-д цэргийн аж үйлдвэрийн салбарт 100 гаруй корпорац үйл ажиллагаа явуулж, үндэсний батлан хамгаалахын судалгаа, үйлдвэрлэлийн санхүүжилтийн 70-75 орчим хувийг гаргаж, тэднээс шилдэг 25 нь үндэсний батлан хамгаалахын судалгаа, үйлдвэрлэлийн санхүүжилтийн 50 орчим хувийг эзэлж байна.

Монгол улсын хувьд цэрэг техникийн салбарт экспорт, импортын зохистой харьцааг хангах боломжтой.

Монгол Улсын цэрэг техникийн бодлого

Монгол Улс нийгмийн шинэ тогтолцоонд хөгжих зарчим, үзэл баримтлал, нэгдмэл бодлогоо тодорхойлон хэрэгжүүлэх чадваргүй байна. 1990 оноос хойш хөгжлийн талаар төрөөс уялдаа холбоо, тооцоогүй 490 шахам бодлогын баримт бичиг баталсан

1 https://www.sohu.com/a/465011225_635792

боловч тэдгээр нь хангалттай хэрэгжээгүй[1] гэсэн дүгнэлтийг эрдэмтэд гаргажээ.

Улмаар Монгол Улсын Засгийн газраас Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурласан, "Алсын хараа-2050" бодлогын баримт бичгийг батлуулж, ирэх 30 жилийн бодлогоо батлав. Мөн дэлхийн улс орнууд батлан хамгаалах номлол, бодлого үйл ажиллагаандаа өөрчлөлт оруулсан болон Монгол Улс хөгжлийн бодлогоо шинээр авч үзэж буйтай уялдуулан, 2020 оноос батлан хамгаалах салбар болон Хил хамгаалах байгууллага нь эрх зүйн орчны шинэчлэлүүдийг хийж, багц хуулиудыг үе шаттай батлуулсаар байна.

Монгол Улсын орчин цагийн цэргийн бодлого нь "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичгээр Монгол Улсын Их хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталгаажсан байдаг.

Энэхүү баримт бичигт 1.1 Монгол Улсын батлан хамгаалах бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд улсын дотоод, гадаад аюулгүй байдлын орчин нь батлан хамгаалах зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно[2] гэж заасан бол "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого" нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг мөн[3] гэж тус тус заажээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурласан, "Алсын хараа-2050", "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс", "Төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилтийг хангахад судлаачийн зүгээс Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэд "Цэрэг-техникийн бодлогын хороо" байгуулж, уг хороо "Монгол Улсын цэрэг техникийн бодлого" баримт бичгийг боловсруулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж байх саналыг дэвшүүлж буй юм.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд, түүний ажлын алба болон төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагын удирдлага нь хорооны гишүүн байж, харьяалах байгууллагуудад бодлогыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх орон тооны бус нэгжүүдтэй байна. Үүгүй бол тухайн салбаруудын шинжлэх ухааны хүрээлэн нь

[1] Монгол улсын дунд хугацааны (2020-2025) тогтвортой хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл (Тайлан III) 70 дах тал

[2] Монгол улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоол. Монгол улсын батлан хамгаалах бодлогын үндэс, Нэг нийтлэл үндэслэл УБ

[3] Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. Нэг нийтлэл үндэслэл 1.1. УБ

салбар хорооны ажлыг хариуцах боломжтой юм. Учир нь цэрэг техникийн бодлогыг боловсруулахад салбарын санал гаргах, салбарт шинэ техник технологи, инновац нэвтрүүлэхэд тухайн салбарын шинжлэх ухааны байгууллагуудын эрдмийн зөвлөл, эрдэмтдийн оролцоотой хэлэлцэж, шийдвэрлэдэг байх нь олон улсын жишигт нийцэх юм.

Мөн бодлогод тухайн жилийн төсвөөс үл хамаарсан урт, дунд, богино хугацааны тасралтгүй хөрөнгө оруулалт хийгдэж, жил бүрийн төсвийн тодорхой хувьтай тэнцэхүйц тогтмол зардлыг нэг хувиас доошгүй төсвийн хуулиар шууд олгодог байх эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай.

Төрийн цэргийн болон тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд нь Хил хамгаалах байгууллагын хувьд хилийн цэргийн цэрэг техникийн үйл ажиллагаа явуулах бөгөөд энэхүү үйл ажиллагааг "Цэрэг техникийн бодлого"-ын хорооны салбар хороо хэрэгжүүлж болох юм.

Цэрэг техникийн бодлогын хороо нь дараах үйл ажиллагааг явуулж болно гэж үзэж байна. Үүнд:

- Цэргийн зэвсэг, техник, технологи, программ хангамж, тусгай хэрэгсэл бүтээх, турших, боловсруулах, засварлах, ашиглах чиглэлээр төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх;

- Засгийн газар хоорондын "Цэрэг техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангах;

- Гадаад улс, орнуудтай ялангуяа гуравдагч хөрш орнуудтай цэрэг зэвсгийн хамтын ажиллагааг өрнүүлэх, өргөжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

- Улсын болон төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын цэрэг техникийн холбогдолтой төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авах, төлөвлөх, хэрэгжүүлэх захиалгыг боловсруулах, техник, технологи, программ хангамжийг хүлээн авах, хуваарилах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох;

- Цэрэг техникийн үйл ажиллагаанд ашиглах техник, технологи, программ хангамжийн стандартчилал болон түүний судалгаа, зохион бүтээх, турших, технологийг нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагааг салбар хооронд зохицуулж, үйл ажиллагаанд шилдэг инновац нэвтрүүлэх өрсөлдөөнийг дэмжих;

- Төрийн цэргийн болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд шаардлагатай цэргийн техник, технологи, программ хангамж, инновацыг нэвтрүүлж, цэрэг иргэний технологи шилжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, үр ашиггүй зардал гаргуулахгүй зохицуулалт хийх;

- Цэрэг техникийн бодлогын хүрээнд нэвтрүүлсэн зэвсэглэл техникийг хүлээн авах, шилжүүлэх, зориулалтын дагуу ашиглаж буй байдалд хяналт тавих, тоолох, ашиглалтаас хасах, устгах;

- Цаашид цэрэг техникийн бодлогыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах.

Чиг үүргийн хувьд

"Монгол Улсын цэрэг техникийн бодлого"-ын өнөөгийн байдал, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх болон цаашдын чиг хандлагын урьдчилсан таамаглал боловсруулах;

Цэрэг техникийн ирээдүйн чиглэлийг тодорхойлж, төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудад чухал ач холбогдолтой зэвсэглэл, техник, технологи, программ хангамжийг хөгжүүлэх, инновацын дэвшилтэт технологиудыг нэвтрүүлэх талаар санал бэлтгэх, хэрэгжүүлэхэд оролцох;

Цэрэг техникийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн актуудыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

Цэргийн техник, технологи, программ хангамжуудыг бүтээх, хөгжүүлэх, турших, нэвтрүүлэх, засварлах чиглэлээр бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, олон улсын хамтын ажиллагааны хүрээнд цэрэг техникийн бие даасан төслүүдийг хэрэгжүүлж, хяналт тавих

Төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын саналыг үндэслэн шаардлагатай цэрэг техникийн бодлогын нэмэлт үйл ажиллагааг хэрэгжүүлж, тэдгээрийг арга зүй болон мэдээллээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

Цэрэг аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагааг чиглүүлэх, хяналт тавих;

Ирээдүйтэй зэвсэг, техник, программ хангамжийг бүтээх, боловсруулах, турших, нэвтрүүлэх чиглэлээр үндэсний компаниудын оролцоог нэмэгдүүлж, хүний нөөцийн тусгай бодлого хэрэгжүүлэх;

Тусгай зориулалтын хиймэл дагуулын систем, онгоц, нисдэг тэрэг, усан болон авто тээврийн хэрэгслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, улсын болон төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа хангаж, үр ашигтай хамтран эзэмших боломжийг бий болгох;

Цэргийн удирдлагын автоматжуулалт, нисгэгчгүй нисэх хэрэгсэл, хиймэл оюун ухаан, роботын удирдлагын системийг бий болгох, хөгжүүлэх, шинэчлэх төслүүдийг дэмжих;

Цэрэг техникийн зориулалттай аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний стандартчилал, баталгаажуулалтын чиглэлээр

хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах;

Цэрэг техникийн инновацын шинэ бүтээл, оновчтой санал, судалгаа шинжилгээний ажлыг үнэлэх, арилжаалах, өмчлөх эрхийг хуваарилах, тэдгээрийг хэрэгжүүлэх гэрээний төслийг хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх;

Олон улс болон төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг зохицуулах, харилцан ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хамтарсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэг байж болох юм.

Энд нэг тодруулахад Монгол Улс цэрэг техникийн бодлогогүй байсан гэх өрөөсгөл ойлголт гарч болох бөгөөд ганц төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллага хоорондын харилцааг уясан нэгдмэл бодлого байхгүй байна гэдгийг онцолсон билээ. Өөрөөр хэлбэл манай улс өдгөө “Цэрэг техникийн бодлого" баримт бичгийг тусад нь гаргаагүй ч салбар бүр өөрийн бодлого үйл ажиллагаандаа цэрэг техникийн бодлогыг баримталж байдаг.

Тухайлбал, “манай зэвсэглэлд байгаа зэвсэг, байлдааны техникийн дийлэнх загварууд хуучин ЗХУ-д 60-70-аад онд үйлдвэрлэсэн, сүүлийн жилүүдэд технологийн дагуу сэргээн сайжруулах засвар, техникийн үйлчилгээ хийгдээгүй хэдий ч ашиглалтын зохих нөөцтэй, технологийн чанар байдлын хувьд зориулалтаар нь ашиглах боломжтой, гэхдээ тэдгээрт сэргээн сайжруулах техникийн үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай байгаа зэвсэглэл техник юм. Зэвсэг, цэргийн техникийн хадгалалт, арчлан хамгаалалт, техникийн үзлэг, үйлчилгээг үндсээр нь сайжруулж,шууд зориулалтаар нь ашиглах боломжийг хадгалах нь манай цэрэг-техникийн бодлогын үндэс болдог[1]” гэж дурдсаныг сануулъя.

Ирээдүй ба өнөөгийн байдал

Хил хамгаалах байгууллагад ирэх он жилүүдэд тулгамдаж болох асуудал буюу өнөөгийн байдлыг цухас тоймлон авч үзлээ. Үүнд:

“Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт Хил хамгаалах байгууллагын ирэх 30 жилийн үйл ажиллагааны зорилго, зорилтуудад техник, технологийн шинэчлэлтийг түлхүү хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Тухайлбал, тус баримт бичгийн долоодугаар бүлгийн амар тайван, аюулгүй нийгэм хэсэгт “Дархан хил” хөтөлбөр

[1] Ш.Паламдорж. Монголын цэргийн шинэчлэл - ардчилсан иргэний хяналт. Женев-Улаанбаатар. 2003. 40 дэх тал

дэвшүүлж үе шатуудад хуваасан байдаг.

Нэгдүгээр үе шат (2021-2030): Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх үе буюу улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлж, албаны бэлэн байдал дээшилсэн байна.

Хоёрдугаар үе шат (2031-2040): Мэргэшсэн хилчин, технологид суурилсан хил хамгаалах албыг бэхжүүлэх үе буюу улсын хилийг агаараас хянах системд шилжүүлж, хиймэл дагуулыг хил хамгаалалтад ашиглана. Улсын хил хамгаалалтад хиймэл оюун ухаан, хяналт шалгалтын технологийн шинэчлэлийг нэвтрүүлж, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх чадавх дээшилсэн байна.

Гуравдугаар үе шат (2041-2050): Хил хамгаалалтын чадавхыг бэхжүүлж, гадаадын ижил төстэй байгууллага, хөрш орнуудын түвшинд хүргэх үе буюу цахим технологид суурилсан хил хамгаалалтыг бэхжүүлж, найдвартай, шуурхай байдлыг хангасан байна[1] гэж тус тус заажээ.

Гэвч энэхүү зорилт хэрэгжихгүй байх магадлал өндөр байна. Тухайлбал, Хил хамгаалах байгууллагын хувьд хилийн инженер техникийн байгууламж, зэвсэглэл, автомашин техникийн парк шинэчлэлт, мэдээлэл, холбооны техник хэрэгслийн шинэчлэл, сайжруулалт, засвар үйлчилгээний зардал, төсвийн хөрөнгө оруулалт нь шаардлагатай цаг хугацаанаасаа үргэлж хоцорч, улмаар тулгамдсан асуудал болон хувирч байдаг.

Өөрөөр хэлбэл өдөр тутмын үйл ажиллагаанд өдгөө ашиглагдаж буй техник технологийн урсгал засвар, үйлчилгээний зардлыг өнөөг хүртэл тогтвортой цаг хугацаанд нь шийдэхгүй байгаа нь цаашид 2020-2050 онд технологийн хил хамгаалалтад шилжиж олон өөрчлөлт хийсэн тохиолдолд удирдлагын автоматжуулалт, дохиолол хяналтын нэгдсэн систем, улсын хилийг агаараас хянах, хиймэл дагуулыг хил хамгаалалтад ашиглах, хиймэл оюун ухаан, бүхий хяналт шалгалтын технологийн

[1] Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. “Алсын хараа-2050 ” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого.

шинэчлэлийг нэвтрүүлж, түүнийг дагасан орон тоо зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого явуулсны дараа санхүүжилтийн хүндрэл учрах эрсдэл байна. Энэ нь буцаад уламжлалт хамгаалалт руу шилжих ёстой гэсэн бодлого гарахад ч хүргэж мэдэх юм.

Энэхүү болгоомжлол, учирч болзошгүй эрсдэл нь хилчдийн үйл ажиллагаанаас гэхээс илүүтэй төсвийн хөрөнгө оруулалт төлөвлөсөн цаг хугацаандаа хийгдэхгүй, улмаар улсын эдийн засаг, түүний санхүүгийн хүндрэлээс шалтгаална гэж үзэж байна.

Тухайлбал, Засгийн газрын мөрийн хөтөлбөрөөс шууд хамааралтай буюу богино хугацааны стратеги төлөвлөлттэй уялдаж байдагтай холбоотойгоор тухайн салбарын жилийн хөрөнгө оруулалт, урсгал төсөвт зардал, хөрөнгө оруулалт суугаагүй бол дээрх асуудал шийдвэрлэгдэхгүй байгаа юм. Энэ нь олон талын хүндрэлийг тухайн салбарт үзүүлдэг бөгөөд жишээлбэл хилийн цэргийн хувьд автомашин техникийн парк шинэчлэлтийг үе шаттай тасалдуулалгүй хийхгүйгээс хилчид явгарах, мэдээлэл, холбооны техник хэрэгслийн шинэчлэл, сайжруулалт хийгээгүйгээс холбоогүй үүрэг гүйцэтгэх, инженерийн байгууламжийн засвар үйлчилгээний зардлыг өгөхгүйгээс улсын хил хамгаалах үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл алдагдаж, улмаар хилчин, иргэний амь нас, эрүүл мэндтэй холбоотой эрсдэлүүд үүсэж, хилчдийг бодит аюулд оруулна. Цаашилбал улс орны аюулгүй байдалтай шууд хамааралтай болохыг шийдвэр гаргагчид харгалзан үзэхгүй байгаад харамсахаас аргагүй юм.

Үүний нэг жишээ нь саяхан болж өнгөрсөн "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль"-ийн хэлэлцүүлгийн үеэр 2019 онд эхэлсэн хилийн цэргийн парк шинэчлэлийг үргэлжлүүлэх боломжгүй болгож, төсвийн хөрөнгө оруулалтаас хассан явдал юм.

УИХ-ын гишүүн Ц.Сэргэлэн "УИХ-аас 2021 оны долдугаар сард батлагдсан Монгол Улсын хөгжлийн таван жилийн төлөвлөгөөнд багтсан, Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хилийн салбаруудын автомашинуудыг шийдэх асуудал ирэх оны төсөвт орсонгүй. Хилийн салбар гэдэг бол хилийн шугам дээр хоног тутам үйл ажиллагаа явуулж, улсын хилийн зөрчлийг хянан шалгах, таслан зогсоох үүрэгтэй. Хөрш орнуудтай хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн асуудлыг шийдвэрлэх, хилийн төлөөлөгч, орлогч нарын уулзалтын асуудал яг энэ хэсэгт л явагддаг. Одоо хилийн салбаруудын автомашины асуудал маш хүнд нөхцөлд

байгаа"[1] талаар төсвийн хэлэлцүүлгийн үеэр анхааруулж хэлсэн боловч хилийн цэргийн автопаркийн шинэчлэлийн 2022 онд үргэлжлүүлэх ажил дэмжигдээгүй юм.

Энэ мэт шалтгаан цаашид үргэлжилсээр байвал "Алсын хараа-2050" хөгжлийн бодлогод туссан "Дархан хил" хөтөлбөр хэрэгжихгүй байх магадлал өндөр байна.

Дүгнэлт, санал

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, салбарын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд "Дархан хил" Төр засаг, удирдлагаас дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх. Үүнд:

Монгол Улсын ҮАБЗ-ийн дэргэд "Цэрэг техникийн бодлогын хороо", төрийн цэргийн байгууллагуудын дэргэд “Цэрэг техникийн бодлогын салбар хороо" байгуулах;

Төрийн цэргийн байгууллагууд, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудад үндэсний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай цэрэг техникийн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны тасалдлыг арилгах зорилгоор цэрэг иргэний харилцаан дээр тулгуурласан цэрэг аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагаа болон гадаад улсуудтай хийх цэрэг техникийн хамтын ажиллагаар өргөжүүлэн тэлж, улмаар цэрэг техникийн салбарт экспорт, импортын зохистой харьцааг хангах боломжийг бүрдүүлэх;

Хил хамгаалах байгууллага санаачлан, Монгол Улсын Их хурал дахь төлөөллийн дэмжлэгтэй "Цэрэг техникийн бодлого" баримт бичгийг боловсруулан, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаар батлуулж, хэрэгжүүлэх;

Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий батлан хамгаалах, хил хамгаалах, онцгой байдал, дотоодын цэрэг, тусгай болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг тогтвортой байлгах эрх зүйн орчныг баталгаажуулах;

Монгол Улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах талаар бодлогын болоод эрх зүйн бусад шинэчлэлүүдийг үргэлжлүүлж, бодлого, хөтөлбөрийн судалгаа[2] 20 хийж, хэрэгжилтийг хангаж, эхлүүлэх; шуурхай, шинэчлэлийг зоримог

Албан ёсны бодлогын зэрэгцээ албан бус буюу зэрэгцээ

[1] Ц.Сэргэлэн. УИХ-ын чуулганы 2021.11.11-ны өдрийн хуралдааны тэмдэглэл

[2] А.Гэрэлмаа Бодлогын судалгааны арга зүй. 2 дах тал. Бодлогын судалгаа бол үйлчлүүлэгч буюу шийдвэр гаргагчид хандсан нөлөөллийн арга хэрэгсэл

бодлогын хувилбар боловсруулж, шийдвэр гаргагчдад санал болгох замаар тэдгээрийн зүгээс гаргах шийдвэрийн үндэслэлийг сайжруулахад туслах, нийтэд сурталчлах нь чухал гэж үзэж байна.

Эх сурвалж:

1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль. 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт. УБ.2020
2.Цэргийн нэр томьёоны тайлбар толь. 2014. УБ. 349 дэх тал
3. Рогозин. Д. Война и мир. Москва. 2014
4.Поповкин В.А. Первый заместитель Министра обороны РФ. Особенности военно-технической политики Российской Федерации в современных условиях. http://federalbook.ru/files/OPK/Soderjanie/ OPK-7/III/Popovkin.pdf
5.https://www.sohu.com/a/465011225_635792
6.htpp://sipri.org/sites/default/files/2021-3/fs_2103.pdf
7.www.vesti.ru/Мировой рынок вооружений 2020: главные поставщики и покупатели увеличили активность
8. https://sipri.org/ sites/ default/2021-03/fs_2013_at_2020.pdf
9.https://www.sohu.com/a/465011225_635792
10.Монгол улсын дунд хугацааны (2020-2025) тогтвортой хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл (Тайлан III) 70 дах тал
11.Монгол улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоол. Монгол улсын батлан хамгаалах бодлогын үндэс, Нэг нийтлэл үндэслэл УБ
12.Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. Нэг нийтлэл үндэслэл 1.1. УБ
13.Ш.Паламдорж. Монголын цэргийн шинэчлэл - ардчилсан иргэний хяналт. Женев-Улаанбаатар. 2003. 40 дэх тал
14. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. “Алсын хараа-2050 ” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого.
15. Ц.Сэргэлэн. УИХ-ын чуулганы 2021.11.11-ны өдрийн хуралдааны тэмдэглэл
16.А.Гэрэлмаа Бодлогын судалгааны арга зүй. 2 дах тал. Бодлогын судалгаа бол үйлчлүүлэгч буюу шийдвэр гаргагчид хандсан нөлөөллийн арга хэрэгсэл

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН НЭГДСЭН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ШИНЭ ХАНДЛАГА

Д.Цэндсүрэн
Гаалийн Ерөнхий Газрын Эрсдэлийн Удирдлагын Хэлтсийн дарга, доктор (Ph.D), дэд профессор

Товч агуулга: Хил дамнасан зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн өсөн нэмэгдэх урсгал, дэлхийн өртгийн сүлжээ, техник технологийн хөгжил, хилийн маргаан/зөрчилдөөн, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл, хил дамнасан хууль бус хөдөлгөөн зэрэгтэй уялдан үндэсний хэмжээнд хилийн хяналтын байгууллага, олон улсад ижил чиг үүргийн байгууллага, бүс нутаг, дэд бүсийн хэмжээнд хамтран ажиллаж ирсэн. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийн хүрээнд газар зүй, эдийн засгийн өвөрмөц онцлог бүхий Ази, Европ тивийг холбосон Монгол Улсад “Нэгдсэн зохицуулалттай хилийн эрсдэлийн удирдлага”-ыг нэвтрүүлэх шинэ хандлагыг олон улсын туршлага, үндэсний бодлого, өнөөгийн хэрэгжиж буй санаачилгатай уялдуулан гарган ирэхийг зорьсон.

Үндсэн хэсэгт “Хилийн нэгдсэн зохицуулалттай менежмент/удирдлага”-ын үзэл баримтлал, хамтран эрсдэл тооцох боломж, хатуу болон зөөлөн дэд бүтцийг хөгжүүлж, ажлын урсгал, нөөцийн үр дүнтэй хуваарилалт хийх боломжийг олон улсын сайн туршлагыг үндэсний онцлогт уялдуулан гарган ирж, *дүгнэлт хэсэгт* Монгол Улсад “Нэгдсэн зохицуулалттай хилийн эрсдэлийн удирдлагын шинэ хандлага”-ыг нэвтрүүлэхэд дэмжлэг болох зарим арга хэмжээний саналыг тусгасан.

Түлхүүр үгс: Хилийн зохицуулалт, нэгдсэн зохицуулалттай эрсдэлийн удирдлага, шинэ технологи, мэдээллийн технологийн дэд бүтэц, зөөлөн дэд бүтэц, хамтын ажиллагаа.

Үндсэн хэсэг

Хил дамнасан зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хилийн хяналтын байгууллагууд өөр өөрийн чиг үүргийн хүрээнд хяналт тавьж ирсэн уламжлалт арга барилыг Хилийн нэгдсэн зохицуулалттай удирдлагыг нэвтрүүлж, ажлын урсгалыг ижилтгэн, хамтарсан эрсдэл тооцож, техник технологийн хурдацтай хөгжилтэй уялдан, хөгжсөөр байна.

Олон улсын чиг хандлага: “Хилийн зохицуулалттай менежмент/удирдлага” (Цаашид “удирдлага” гэх) гэсэн нэр томьёонд мэдээлэл солилцох, нэгдсэн барилга байгууламжтай байх, техник тоног төхөөрөмжөө

хуваалцах, байгууллагууд хоорондоо нягт хамтран ажиллах, нэг нь нөгөөдөө захиргааны эрх мэдлээ шилжүүлэх болон албан хаагчдын чиг үүргийг дамнуулж солих зэргийг хамруулж болно.

Энэхүү үзэл баримтлал олон улсад анх “хилийн нэгдсэн удирдлага” (integrated border management) гэж эхэлж байсан бол өдгөө “хилийн зохицуулалттай удирдлага” (coordinated border management) нэр томьёог илүүтэй хэрэглэх болсон. Нэгдсэн гэсэн ойлголт нь хоёр буюу түүнээс дээш байгууллагыг нийлүүлэх гэсэн утгатай. Зарим судлаачид “хилийн нэгдсэн”, зарим нь “хилийн хамтарсан” удирдлага[1] гэсэн тодорхойлолтыг ашиглан энэхүү тодорхойлолтыг одоо ч хамгаалсаар байна.

Дэлхийн Гаалийн Байгууллага (ДГБ)-ын “Хилийн зохицуулалттай удирдлага” гарын авлагад Гаалийн харилцаанд оролцогчдын хамтын ажиллагааны хэлбэрийг дараах байдлаар дүрсэлжээ.

Зураг 1. Гаалийн харилцаанд оролцогчдын хамтын ажиллагааны хэлбэр



Эх сурвалж: Хилийн зохицуулалттай удирдлага (WCO, 2018)

Дээрх зурагт үзүүлсэн хамтын ажиллагааны хэлбэр нь зөвхөн Гаалийн харилцаанд оролцогчдоор хязгаарлагдахгүй бөгөөд ямар ч байгууллага, салбарын үйл ажиллагаанд хэрэглэх боломжтой. Өөрөөр хэлбэр салбар хооронд болон байгууллага дотроо хамтран ажиллах дээрх хамтын

[1] Management гэсэн англи үгийг Монгол хэлнээ “Менежмент”, зарим салбарт “Удирдлага” гэж орчуулж ирсэн. Энэхүү өгүүллийн хүрээнд “Удирдлага, эсхүл Менежмент” гэсэн үгийг ижил байдлаар ойлгохыг зөвлөж байна. Ялангуяа “Эрсдэлийн удирдлага”-ыг “Эрсдэлийн менежмент” гэж хэрэглэх нь Эрдэл тооцох үзэл баримтлалын хувьд илүү зохимжтой боловч хэрэглэж заншсан “Эрсдэлийн удирдлага” гэсэн томьёоллоор өгүүлэлд хэрэглэсэн.

ажиллагааны хэлбэрүүдийг өөр хооронд нь хольж, өргөн хэрэглэдэг. Эдгээрээс “Зохицуулах, Хамтран ажиллах, Хамтын ажиллагаа/Нэгдсэн хүчээр ажиллах” нь хамгийн өргөн хэрэглэгддэг Гурван том “С” гэж төрийн удирдлагын судалгаа, бүтээлд дурдсан байдаг (21 дүгээр зууны Төрийн албаны менежер, 2019).

Хилийн зохицуулалттай удирдлага гэсэн ойлголт нь үндэсний хэмжээнд хил дамнасан зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд өөр өөрийн чиг үүргийн дагуу хяналт тавих байгууллагуудын ажлын урсгал, түүний дотор баримт бичиг, хамтарсан хяналт тавих, хил залгаа орнуудтай ажил, амралтын цаг, цаашлаад ажлын урсгал, хяналтаа ижилтгэн, харилцан хүлээн зөвшөөрч, оролцогч талууд хамтдаа үр ашигтай байх санаачилгын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ. Өнөөгийн өөрчлөгдөж буй нөхцөл байдлаас улбаалан хилийн нэгдсэн удирдлагыг нэвтрүүлж, хамтарсан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлснээр хилийн хяналтыг үр дүнтэй зохион байгуулах болно.

Зураг 2. Хилийн нэгдсэн удирдлагыг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага



Хилийн зохицуулалттай удирдлагын үзэл баримтлал нь шинэ зүйл биш, дэлхийн улс орнууд үндэсний хэмжээнд болон хөрш орнууд, дэд бүс, бүс нутгийн хэмжээнд янз бүрийн хувилбараар тодорхойлсон хэдий ч хэрэгжүүлэх үйл ажиллагааны

хувьд ижил зохион байгуулалттай байна:

- Европын Холбоонд “Хилийн нэгдсэн (интеграцчилсан) менежмент”;
- Дэлхийн банк “Хилийн хамтын менежмент” (Collaborative Border Management);
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE) “Хилийн цогц менежмент” (Comprehensive Border Management)[1].

Эдгээр нэр томьёог харьцуулан үзэхэд ойролцоо, төстэй агуулгыг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, хил дээр ажиллах төрийн байгууллага өөрсдийн хяналтын чиг үүргээ уялдуулж, хялбаршуулж гүйцэтгэх нь бүх байгууллага, тэдний гүйцэтгэх ёс журмын ажиллагааг хамруулсан арга хэмжээ[2] юм.

Хүснэгт 1. Хилийн нэгдсэн зохицуулалттай удирдлагын сайн туршлагаас

	Загвар	**Туршлага**
Европын Холбоо	Хамгийн өндөр түвшний интеграцчилсан хилийн удирдлага (EUROSUR, FRONTEX зэрэг төвлөрсөн систем, нэгдсэн гаалийн журам)	✓ Нэг цонхны систем: Худалдаатай холбоотой бүх мэдээллийг нэг удаа бүртгэх; ✓ Хамтарсан шалгалт: Гааль, цагдаа, хорио цээрийн байгууллагуудын зохион байгуулалттай хамтарсан шалгалт; ✓ Хамтарсан эрсдэлийн удирдлага: Гишүүн орнууд хооронд нэгдсэн эрсдэлийн шалгуур.
Сингапур	Технологид суурилсан, төрийн байгууллагуудын бүрэн интеграцчилсан хилийн зохицуулалттай удирдлага	✓ Худалдааны систем: Зөвшөөрөл, мэдүүлэг өгөх цахим нэг цонхны систем; ✓ Бодит цагийн мэдээлэл солилцоо: 35+ агентлагийн хооронд; ✓ 24/7 гаалийн бүрдүүлэлт: Эрсдэлийн тооцоо, автоматжуулалтад суурилсан, цаасгүй харилцаа холбоо.

[1] *Европын Холбооны Улсын дотооддоо болон гадааддаа хилийн боомтын үйл ажиллагаанд оролцогч төр, хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, хялбаршуулах замаар хилийн боомтын аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааг үр дүнтэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах нэгдсэн тогтолцоо (Commision, 2004);*

[2] *Баруун Европын орнуудад хилийн нэгдсэн зохицуулалттай удирдлагын анхдагч хэлбэрүүд 60-аад жилийн өмнөөс бий болж, 1990-ээд оны дунд үеэс хилийн нэгдсэн зохицуулалттай удирдлагыг хэрэгжүүлэх бодит шаардлага тулгарсан.*

	Загвар	Туршлага
Кени – Зүүн Африкийн Нийгэмлэг (ЕАС)	Нэг цэгийн хилийн боомт, бүс нутгийн хилийн зохицуулалттай удирдлага, цогц удирдлага	✓ Хамтарсан хилийн боомтууд: Хоёр орны дунд байрлах нэгдсэн байгууламж (жишээ нь: Кени–Уганда); ✓ Нэг дор байрласан албан хаагчид: Гааль, цагаачлал, цагдаа зэрэг байгууллагууд хамтран ажиллах; ✓ Хууль эрх зүйн уялдаа: Бүс нутгийн хууль, журмын нэгдсэн хэрэгжилт.
Канад – АНУ	“Хилээс цааш” санаачилгаар хилийн аюулгүй байдал, гаалийн бүрдүүлэлтийн уялдаа холбоо	✓ Урьдчилан нэвтрүүлэх хөтөлбөрүүд (NEXUS, FAST): Итгэмжлэгдсэн худалдаачид, зорчигчдыг түргэвчилсэн журмаар нэвтрүүлэх; ✓ Хамтарсан дэд бүтэц ба технологи: Хилийн хамтарсан ашиглалт; ✓ Гамшиг, аюул заналын хамтарсан эрсдэлийн үнэлгээ: Мэдээлэл, эрсдэлийн удирдлага.
Австрали	Эрсдэлийн тооцоонд суурилсан, хууль сахих, автоматжуулалтыг дэмжсэн хилийн удирдлага	✓ Нэгдсэн ачаа тээврийн систем (ICS): Далай/агааранас эхлээд хуурай газрын гаалийн бүрдүүлэлт хүртэлх саадгүй урсгал; ✓ Биоаюулгүй байдлын интеграцчилал: Хорио цээр, гаалийн хамтарсан хяналт; ✓ Дэвшилтэт аналитик шинжилгээ: Өндөр эрсдэлтэй ачаа, зорчигчийг тодорхойлох.

Дэлхийн хэмжээнд улс орнууд янз бүрийн хэлбэрээр ажиллаж, олон улсын худалдааны бараа нийлүүлэх сүлжээний урсгал, улс төр, эдийн засгийн нөлөөллөөс улбаалан арга зүй өөрчлөгдсөөр байгааг дээрх хүснэгтэд үзүүлсэн сайн туршлага харуулж байна. Олон улсын байгууллагууд улс орнуудын хооронд гүүр болж, хилийн нэгдсэн зохицуулалттай удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр өөр өөрсдийн чиг үүргийн хүрээнд олон ажлуудын санаачлан хэрэгжүүлжээ.

Хилийн нэгдсэн зохицуулалттай эрсдэлийн удирдлага: Уламжлалаас харахад хил дамнасан зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн урсгалд *“Хил хамгаалах, Цагаачлал, Гааль, Хорио цээр, Хууль сахиулах”* гэх мэт байгууллагууд өөр өөрийн чиг үүргийн хүрээнд

хяналт[1]-ыг хэрэгжүүлж ирсэн. Ийнхүү ажиллахдаа харилцан хуваалцах боломжтой ижил төрлийн мэдээллийг шаардаж, хилийн хяналтад зарцуулах цаг хугацаа, зардлыг нэмэгдүүлж, хилийн нэвтрүүлэх хүчин чадалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны эрсдэлийн чиглэлээр эрдэмтэн Вилсон, Манн, Оцуки (John S. Wilson; Catherine L. Mann and Tsunehiro Otsuki, 2004) нарын 2004 онд хийсэн *"Худалдааг хөнгөвчлөх үр ашиг: Олон улсын түвшинд"* судалгааны ажилд "...Хилийн боомтыг үр ашигтай ажиллуулах нь хилийн хяналтын байгууллагуудын ил тод, шуурхай үйл ажиллагаанаас шалтгаалах"-ыг онцолжээ. Судалгааны ажилд хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг хялбаршуулж, уялдуулснаар гарах үр дүнг дэлхийн 75 улсын гадаад худалдааны мэдээлэл, хилийн хяналтын байгууллагуудын гүйцэтгэлд тулгуурлан Гравити загвараар тооцоолон гаргажээ. Үр дүн нь "*Олон улсын худалдаа жил бүр 9.7 хувиар өсөж, худалдааны зардалд 377 тэрбум ам.доллар зарцуулж байна. Судалгааны үр дүнгээр боомтыг үр ашигтай ажиллуулах зорилгоор хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр ашиг нь ойролцоогоор 107 тэрбум ам.доллар, үүнээс 33 тэрбум ам.доллар нь гаалийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулснаас, 83 тэрбум ам.доллар нь гадаад худалдаа эрхлэх хуулийн орчныг сайжруулснаас хүртэх үр ашиг болно"* гэж гарсан байна.

Иймд дэлхийн улс орнууд *"Хилийн нэгдсэн зохицуулалт"*-ыг хэрэгжүүлэхдээ хамтарч эрсдэлээ тооцохыг тэргүүлэх чиглэл болгон өөрсдийн үйл ажиллагааны онцлогт тохируулан, уламжлалт бүгдийг тус тусдаа шалгах арга ажиллагааг алдагдуулахгүйгээр хамтын шийдлийг чухалчилж, янз бүрийн хэлбэрээр хэрэгжүүлсээр иржээ.


Олон улсын туршлагаас харахад улсын хилээр нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд хяналт тавихад төрийн хяналт хэрэгжүүлэх бизнес процесст оролцдог бүх байгууллага хил дээр ажиллах боломжгүй тул "Хил хамгаалах, Гааль, Иргэний харьяалал, Хорио цээр"-ийн асуудал хариуцсан төрийн байгууллага бусад төрийн байгууллагын нэрийн өмнөөс хилийн хяналтыг зохион байгуулж байна. Зарим улс оронд "Цагдаа, Тагнуул"-ын байгууллага хил дээр хамтдаа ажилладаг.

Монгол Улсын өнөөгийн нөхцөлд Хилийн халдашгүй дархан байдлыг Хил хамгаалах, Хилээр нэвтрэх иргэдийн визийн

[1] *Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдааг Хөнгөвчлөх Хэлэлцээрт "Ёс журмын ажиллагаа" (Formalities) гэж нэрлэсэн.*

зөвшөөрөлд хяналт тавих ажлыг Иргэний харьяалал, Хорио цээрийн хяналт нийгмийн эрүүл ахуй, аюулгүй байдал, Зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд Гаалийн байгууллага хяналт тавьдаг. Энэхүү хяналтын үе шат бүрд нэг мэдээллийг хэд хэдэн байгууллагад давхардуулан өгөх, давхардсан хяналт тавих гэх мэт хүндрэл учирдаг. Энэхүү хүндрэлтэй асуудлыг нэгдсэн зохицуулалттай эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх замаар шийдвэрлэх боломжтой. Эрсдэлийн удирдлагын үндсэн зарчим нь агуулгаа тодорхойлж, мэдээлэлд дүн шинжилгээ хийхээс эхэлнэ. Иймд хилийн хөдөлгөөний мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ажиллах зарчмаа тодорхойлно. Дараах зурагт сүүлийн 30 жилийн гадаад худалдааны статистик мэдээллийг үзүүллээ.


Зураг 3. Монгол Улсын гадаад худалдааны статистик мэдээлэл (1995-2024 он, тэрб. ам. доллар)



Эх сурвалж: Гадаад худалдааны статистик мэдээлэл (газар, 1995-2024)

Монгол Улсын гадаад худалдаа 1995 онд 900 сая ам. доллар байсан бол 2024 онд 27.4 тэрбум ам. долларт хүрч, 30 дахин өссөн нь худалдаанд тавих хяналтыг илүү хялбаршуулж, уялдуулах хэрэгцээг илтгэж байна. Сүүлийн 30 жилийн Монгол Улсын гадаад худалдааны гүйцэтгэл 236 тэрбум ам. доллар байна.

Зураг 4. Монгол Улсын төсөвт гаалийн орлогын эзлэх хувь (1995-2024 он, тэрб.₮)




Эх сурвалж: Судлаачийн тооцоолол (хороо, 1995-2024)

Дээрх зурагт үзүүлсэн мэдээллээс харахад 1995 онд 28.16 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн бол 2024 онд 6.74 их наяд төгрөгт хүрч, сүүлийн 30 жилийн байдлаар нийт 43.7 их наяд төгрөгийн галийн болон бусад татвар, хураамжийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Улсын хилээр нэвтрүүлэх барааны урсгалд хяналт тавихдаа аль боомт, хилийн хяналтын бүсээр хамгийн их бараа, тээврийн хэрэгсэл нэвтэрсэн, эсхүл онцлог нэрийн бараа, үндэсний тэргүүлэх чиглэл зэрэгтэй уялдуулан хяналтын дэд бүтцийг сайжруулах, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлж, мэдээлэл солилцоог бэхжүүлэн, хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй хуваарилах боломж бүрдэнэ (Хавсралт 1. Монгол Улсын гадаад худалдааны статистик мэдээлэл, гаалийн газар, хороодоор (1995-2024 он, тэрб. ам. доллар)). Импортод Улаанбаатар хот, Замын-Үүд дэх гаалийн газар, экспортод Гашуунсухайт, Шивээхүрэн, Орхон дахь гаалийн газар гол хувийг эзэлж байна. Хэдийгээр гадаад худалдааны статистик мэдээлэл хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг илтгэх хэдий ч Монгол Улсын 39 хилийн боомтод хөрш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээр, протоколын дагуу зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлж, хилийн дэглэмийг сахиулах үүрэгтэй.

Олон улсын стандартын байгууллагын ***“Эрсдэлийн удирдлагын зарчим ба стандарт”*** (ISO, 2018) нь эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх үндсэн баримт бичиг юм. Дараах зурагт эрсдэлийн удирдлагын архитектурыг үзүүллээ.

Зураг 5. Эрсдэлийн удирдлагын архитектур



Эх сурвалж: Эрсдэлийн удирдлагын архитектур (ISO, 2018)

Эрсдэлийн удирдлагын зарчим нь байгууллагын үнэ цэнийг бий болгож, хамгаалан, удирдлагын манлайлал гол үүрэгтэй. Аливаа байгууллага эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэхэд бүх нэгж хамтдаа ажиллаж, хүн бүрийн дагаж мөрдөх соёл болгосноор эрсдэлийг удирдах байгууллагын соёлын хөгжил дээшилнэ.

Хилийн хяналтын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэхэд нэн тэргүүнд агуулгыг тодорхойлж, мэдээллээ боловсруулан, эрсдэлийн тооцоо хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулна. Зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих явцад янз бүрийн эрсдэл учирдаг. Нэн тэргүүнд хууль бус хөдөлгөөнтэй хэрхэн тэмцэх, хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Дараах зурагт Хил хамгаалах, Виз, Гаалийн хяналт тавихтай холбоотой зарим эрсдэлийг үзүүллээ.



Зураг 6. Хилийн хяналттай холбоотой зарим эрсдэлээс

Эрсдэл тооцоход өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, замын зургаа гарган, үе шаттайгаар хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа мониторинг хийж, оролцогч талуудтай зөвлөлдөн, баримтжуулж, эрсдэлийг бууруулах арга хэмжээний үр нөлөөг тооцно.

ДАВУУ ТАЛ (STRENGTHS)

- **Хууль эрх зүй:** Хил, худалдаа, тээврийн үйл ажиллагааг зохицуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орж, үндэсний хууль тогтоомжид тусгасан;
- **Техник технологийн хөгжил**: Засгийн газрын Цахим шилжилт, шинэ технологи, дижитал шийдлүүдийг ашиглах боломжтой;
- **Олон улсын хамтын ажиллагаа**: Олон улс, бүс нутаг, хөрш орнуудтай урт хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлсэн;
- **Хүний нөөц**: Хилийн хяналт, олон улсын худалдааны чиглэлээр мэргэшсэн албан хаагчид зохих түвшинд бэлтгэгдсэн.

СУЛ ТАЛ (WEAKNESSES)

- **Хууль эрх зүй**: Хилийн нэгдсэн зохицуулалт, дижитал харилцаа холбоог дэмжих хууль эрх зүйн орчин бүрдээгүй;
- **Багийн чадвар ба мэргэшлийн ур чадвар**: Хилийн хяналтын байгууллагуудын албан хаагчдын зан үйл, шинэ технологи болон системд дасан зохицох мэргэшлийн ур чадвар дутмаг;
- **Зөөлөн дэд бүтэц**: Ажлын урсгалыг ижилтгэх, мэдээлэл солилцоо, ялангуяа өгөгдлийн стандартыг ижилтгэх.

SWOT

БОЛОМЖ (OPPORTUNITIES)

- **Дижитал шилжилт**: Цахим засаглал, Цахим хилийн системийг өргөжүүлэх боломжтой;
- **Гадаадын хөрөнгө оруулалт**: Олон улсын байгууллагуудаас хилийн хяналт болон эрсдэлийн удирдлагад дэмжлэг үзүүлэх хандив, төсөл хэрэгжүүлэх боломж;
- **Худалдааны шинэ боломж**: Монгол Улсын эдийн засгийн олон улсын интеграц, бүс нутгийн худалдааны хэлэлцээр.

АЮУЛ (THREATS)


- **Гадаад улс орнуудын хилийн бодлого**: Хөрш орнууд, Хилийн зөрчилдөөн;
- **Эдийн засгийн хямрал**: Хилийн зохицуулалт, эрсдэлийн удирдлагын шинэ хандлагыг хэрэгжүүлэх нөөцийн хомсдол;
- **Дэлхийн худалдааны орчин**: Худалдааны дайн, тариф;
- **Технологийн аюул**: Шинэ технологи, мэдээллийн аюулгүй байдал, кибер халдлага.

Зураг 7. Хилийн нэгдсэн зохицуулалттай эрсдэлийн удирдлагын СВОТ шинжилгээ

Монгол Улсын хилийн нэгдсэн зохицуулалттай эрсдэлийн удирдлагын шинэ хандлагыг нэвтрүүлэхэд дээрх зурагт үзүүлсэн **СВОТ шинжилгээ нь тохиромжтой арга бөгөөд өнөөгийн** “давуу талаа ашиглан сул талыг бууруулах”, “боломжоо ашиглан аюулыг бууруулах” боломжийг олгож байна.

Эрсдэлийн агуулгыг тодорхойлж, мэдээлэл цуглуулж, эрсдэл тооцоход таньж тогтоосон эрсдэл гарах магадлал, түүний үр дагаврын үржвэрээр эрсдэлийн үнэлгээ хийж, ач холбогдлын зэрэглэлийг гаргана. Дараах зурагт Эрсдэлийн дүн

шинжилгээний матрицыг жишээ болгон үзүүллээ.



Зураг 8. Эрсдэлийн дүн шинжилгээний 5х5 матриц

Таньж тогтоосон эрсдэлийн зэрэглэлийг тодорхойлохгүйгээр түүнийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй. Практикт эрсдэлийн дүн шинжилгээ хийх гол арга нь матриц. Байгууллагын онцлогоос хамаарч “3х3”, “5х5”, “7х7” гэх мэт янз бүрийн хэмжээсээр байж болно. Хэмжээс их болох тусам үр дагавар, магадлалын багаас их хүртэлх оноог нарийвчлан тодорхойлж, ялгах шаардлагатай.

Эрсдэлийн үнэлгээ хийсний дараа эрсдэлийг бууруулах буюу хариу өгөх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үр дагавар болон магадлалаас хамаарч дараах зурагт үзүүлсэн байдлаар хяналтыг хэрэгжүүлэх боломжтой.



Зураг 9. Эрсдэлийн ач холбогдлын 3х3 матриц

Эрсдэлийн магадлал, үр дагаврын аль аль нь “дунд буюу 2 оноо”-той гэж шинжилгээ хийхэд:

- Эрсдэлийн магадлал дунд (2), үр дагавар бага (1): *“Зөвшөөрнө, гэхдээ хянах хэрэгтэй”;*
- Эрсдэлийн үр дагавар дунд (2), магадлал бага (1): *“Эрсдэл бага ч хянах хэрэгтэй”* гэсэн зарчмын дагуу хяналтыг зохион байгуулна.

Эндээс эрсдэлийн магадлал, үр дагаврыг заавал тоогоор илэрхийлэх шаардлагатай нь харагдаж байна.

Хилийн хяналтыг үр дүнтэй зохион байгуулахад хүний болон санхүүгийн хязгаарлагдмал нөөцөөс хамаарч, эрсдэлийг бууруулах арга хэмжээг дараахаас сонгон хэрэгжүүлнэ:

-Хүлээн зөвшөөрөх (Tolerate): Хязгаарлагдмал нөөцөөс шалтгаалан хүлээн зөвшөөрөх;

-Бууруулах (Treat): Эрсдэл гарах магадлал, үр дагаврыг тооцон, бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх;

-Шилжүүлэх (Transfer): Эрсдэлийг гуравдагч этгээдэд шилжүүлэх.

Олон улсын стандартын байгууллагын “Эрсдэлийн зарчим ба стандарт” (ISO, 2018)-ын 2018 оны хувилбар нь эрсдэлийн удирдлагын үе шат бүрийн логик дараалал, уялдаа холбоог хангахаас гадна тухайн үйл ажиллагаа байхгүй болсны дараа л эрсдэл дуусах тул ямар ч үйл ажиллагаа оршин байгаа тохиолдолд эрсдэл их, бага хэмжээгээр байна гэсэн зарчмыг тодотгожээ.

Дэлхийн ямар ч улсад “Хүний хөл хориот өвчний хяналт; Мал эмнэлгийн хяналт; Ургамлын хорио цээрийн хяналт; Барааны эрүүл ахуй, аюулгүй байдал, чанарын хяналт”-ыг “Хилийн хорио цээрийн хяналт” гэсэн ерөнхий нэршлийн хүрээнд хэрэгжүүлдэг. Хилийн хяналтад хэрхэн эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх боломжийг “Хилийн хорио цээрийн хяналт”-аар төлөөлүүлэн жишээ болгон авсан.

Монгол Улсын Засгийн газраас худалдааг хөнгөвчлөх, худалдаанд хяналт тавих төрийн байгууллагын давхардсан хяналтыг бууруулах, худалдаанд зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулах зорилгоор 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хилийн хорио цээрийн хяналт тавих чиг үүргийг Гаалийн байгууллагад шилжүүлсэн[1].

Худалдааг хөнгөвчлөх, хил дээрх төрийн хяналтын давхардсан хяналтыг бууруулах

[1] Монгол Улсын Засгийн газрын “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 04, “Засгийн газрын зарим тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай“ 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 05 тогтоолын дагуу Гаалийн ерөнхий газар хилийн хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэх болсон.

зорилгын хүрээнд дараах байдлаар ажиллаж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, өөрчлөлт, шинэчлэл хийсээр байна:

- Гаалийн харилцаанд оролцогчдын хилийн ёс журмын ажиллагаанд шаардах баримт бичгийн тоог цөөлж, цахим хэлбэрээр шуурхай олгох;
- Гаалийн хяналт шалгалт, түүний дотор барааны биет шалгалт хийх тоог хууль тогтоомжийн хүрээнд бууруулах;
- Гаалийн байгууллагын үйлчилгээг цахимжуулж, хүний оролцоог багасгах;
- Барааг урьдчилан мэдүүлэх үйл ажиллагааг хялбаршуулах гэх мэт.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн сүүлийн 7 жилд Хорио цээрийн хяналтад хамрагдсан барааны бичлэгийн тоог эрсдэлийн зэрэглэл, эзлэх хувиар дараах хүснэгтэд үзүүллээ.

Он	Нийт бичлэгийн тоо	Хорио цээрийн хяналтад хамрагдсан (эрсдэлийн зэрэглэлээр)						Нийт хорио цээрийн хяналт	Нийт бичлэгт эзлэх хувь
		Өндөр	Хувь	Дунд	Хувь	Бага	Хувь		
2018	2,144.2	71.439	3.3%	75.8	3.5%	34.9	1.6%	182.1	8.5%
2019	2,201.2	73.687	3.4%	78.5	3.7%	36.5	1.7%	188.7	8.8%
2020	1,873.9	59.849	2.8%	72.7	3.4%	33.1	1.5%	165.7	7.7%
2021	1,855.7	62.471	2.9%	72.5	3.4%	33.0	1.5%	168.1	7.8%
2022	2,195.4	112.62	5.3%	100.7	4.7%	17.2	0.8%	230.5	10.7%
2023	2,664.1	137.62	6.4%	120.7	5.6%	20.6	1.0%	278.9	13.0%
2024	3,117.5	168.43	7.9%	202.3	9.4%	43.1	2.0%	413.9	19.3%
	16,052.0	**686.12**	**4.3%**	**723.1**	**4.5%**	**218.5**	**1.4%**	**1,627.8**	**10.1%**

Хүснэгт 2. Хилийн хорио цээрийн хяналтыг эрсдэл тооцон хэрэгжүүлсэн байдал (2018-2024 он, барааны бичлэг мянган ширхэг, эзлэх хувиар)

Сүүлийн долоон жилд импортын болон экспортын гаалийн бүрдүүлэлт хийсэн 16 сая барааны 1.6 сая бараа буюу 10.1 хувийг хилийн хорио цээрийн хяналтад хамруулжээ. Хилийн хорио цээрийн хяналтад хамруулсан барааны бичлэгийн 4.3 хувь нь өндөр, 4.5 хувь нь дунд, үлдсэн 1.4 хувь нь бага эрсдэлтэй байсан байна. Эрсдэлийн зэрэглэлээс хамаарч, лабораторийн шинжилгээ хийх, барааг биетээр шалгах, эсхүл шалгахгүй байх зэрэг тохирсон хяналтыг хэрэгжүүлжээ.

Хилийн хорио цээрийн хяналт нь улс орны эрүүл, аюулгүй байдалд нөлөөлөх тул эрсдэл тооцох үйл ажиллагаа нь бусад хяналттай харьцуулахад ижил стандарттай боловч, барааны онцлогоос хамаарч эрсдэлийн үнэлгээ, ач холбогдол, эрсдэлийг бууруулах/хариу үзүүлэх арга хэмжээ нь онцлог байдаг.

Дүгнэлт, санал

Хилийн нэгдсэн зохицуулалттай удирдлагын тогтолцоог дэлхийн улс орнууд болон манай улсад хэрхэн

нэвтрүүлсэн байдлыг судалж үзэхэд төр засгийн дэмжлэг шаардсан, санхүүгийн болон бусад хүчин зүйлсийн дэмжлэгтэйгээр хэрэгжих, үндэсний, дэд бүс, олон улсын хэмжээнд өргөн цар хүрээг хамруулсан санаачилга юм. Энэхүү өгүүллийн зорилгын хүрээнд:

-Хилийн нэгдсэн зохицуулалттай удирдлагыг нэвтрүүлж буй олон улсын чиг хандлагыг зарим улс орныг жишээ болгон "Хамтын гэрээ, хэлэлцээрээр хамтарсан хяналтыг хоёр улсын нутаг дэвсгэрт хийх, Бичиг баримтаа ижилтгэх, уялдуулах" зэргээр хилийн хяналтыг үндэсний болон олон улсын түвшинд амжилттай хэрэгжүүлсэн туршлага;

-Хилийн ёс журмын ажиллагаанд төрийн хяналт тавих байгууллагууд олон улсын стандартын дагуу эрсдэлийн удирдлагыг практикт хэрхэн хэрэгжүүлэхийг хилийн хорио цээрийн хяналт хэрэгжүүлсэн туршлагыг жишээ болгон авч үзсэн;

-Хилийн нэгдсэн зохицуулалттай эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэхийн тулд өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийж, хүндрэлтэй байгаа асуудлыг шийдвэрлэх санал гаргасан.

Дэлхийн хэмжээнд газар нутгийн хэмжээгээр 19 дүгээр байранд орох, далайд гарцгүй Монгол Улс үндэсний хэмжээнд болон эдийн засгийн нөлөө бүхий хоёр хөрш улстай найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлж, хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр янз бүрийн арга хэмжээг нэвтрүүлж, өөрчлөлт, шинэчлэлийг илэрхийлсээр ирсэн. Хэдий тийм боловч өнөөгийн хатуу дэд бүтцийн хөгжлийг зөөлөн дэд бүтэцтэй уялдуулж "Мэдээллийн урсгал болон Барааны биет урсгал"-ыг эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэн, саадгүй нэвтрүүлж, хилийн хяналтад зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулах шаардлагатай.

Цаашид хилийн нэгдсэн зохицуулалттай эрсдэлийн удирдлагыг олон улсын стандартыг өөрийн орны үндэсний онцлогт тохируулан нэвтрүүлэхтэй холбоотой зөвлөмжийг *"Эрх зүйн орчин, Үйл ажиллагаа, Эрсдэлийн удирдлага, Мэдээллийн технологи"* гэсэн дөрвөн чиглэлийн хүрээнд дэвшүүлж байна:

- Бизнес процессын шинжилгээг улсын хилийн орох, гарах, дамжуулан өнгөрүүлэх чиглэлд зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн урсгалаар төрөлжүүлэн хийж, хилийн хяналтын бизнес процессыг дахин инженерчлэн, харилцан хүлээн зөвшөөрсөн, нэгдсэн шийдэлд хүргэх;
- Хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, цахим гарын үсэг, цахим мэдээлэл солилцох,

хамтарсан эрсдэл тооцохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх, өөрчлөх;

- Хилийн хяналтын үйл ажиллагааны давхардлыг арилгасан, үйл ажиллагааг хялбаршуулсан шинэ процессыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгон оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх, олон нийтэд сурталчлан, таниулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

- Удирдлагын манлайлал, ялангуяа хилийн боомтод тэргүүн эгнээнд ажиллах хилийн хяналтын байгууллагын хамтын ажиллагааны механизмыг албажуулан, гамшгийн, эсхүл түүнтэй адилтгах онцгой нөхцөлд хэрхэн ажиллах төлөвлөгөөг бий болгон, тогтмол хугацаанд шинээр үүсэх нөхцөл, бодлого, чиглэлтэй уялдуулан шинэчлэх;

- Технологийн дэвшилд үндэслэсэн оновчтой бүтэц, зохион байгуулалт, түүний дотор ажлын урсгалын зураглалыг хилийн боомтын онцлог, хөрш орнуудын ижил чиг үүргийн байгууллагын үйл ажиллагаа, хилийн боомтоор нэвтрэх барааны урсгалтай уялдуулан шинэчлэх;

- Хилийн хяналтын байгууллагуудын мэдээлэл солилцох мэдээллийн технологийн хүрээг бий болгон, өгөгдөл/мэдээллийн кодыг олон улсын стандартад нийцүүлэн, үндэсний хэмжээнд нэгдсэн байдлаар нэвтрүүлэх стандартыг батлах;

- Хөрш орнуудын ижил чиг үүргийн байгууллагатай байгуулсан, хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийг өнөөгийн хил дамнасан зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн урсгал, техник технологийн шинэчлэл, үндэсний бодлого, чиглэлтэй уялдуулан өөрчлөх хэрэгцээ шаардлага бүхий санал боловсруулан, албажуулах ажлыг дипломат шугамаар шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх.

Хэдийгээр хилийн хяналтын байгууллагуудын чиг үүрэг харилцан адилгүй ч хамтран ажилласнаар “Хилийн нэгдсэн зохицуулалттай удирдлага”-ын давуу талууд болох төрийн үйлчилгээний хүртээмж сайжрах, үйл ажиллагааны давхардалгүй болох, гадаад худалдааны зардал хэмнэх, цөөхөн боловч зохистой оролцоог бий болгох, тээврийн зардал буурах, мэдээлэл солилцоо өргөжих болон хилийн үйл ажиллагаанд оролцогчдын уялдаа холбоо сайжрах үр дүн гарна.

Хилийн шалгалтыг ухаалаг зохион байгуулахын тулд хүний болон санхүүгийн хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй хуваарилж, хамтран ажиллах замаар аюулгүй байдал, эдийн засгийн үр ашгийг тэнцвэржүүлнэ. Энэхүү ухаалаг хяналтыг хэрэгжүүлэхэд эрсдэлийг урьдчилан тодорхойлох; мэдээлэл хуваалцах; дүн шинжилгээ хийх; шинэ

технологи, түүний дотор хиймэл оюун, машин сургалт, их өгөгдөл, виртуал бодит байдлыг хилийн Хамтарсан эрсдэл тооцохдоо “Аливаа шинэ үйл ажиллагаанд дасан зохицож, шаламгай, санаачилгатай ажиллаж, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлж, уялдаа холбоог ханган ажиллах” нь хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болно.

Эх сурвалж:

Aniszewski, S. (2009). *Coordinated Border Management a concept paper.* Brussels : WCO;

Commision, E. (2004). *Guidelines for Integrated Border Management in Western Balkans.* EC;

IMF. (2019). *World Economic Outlook database;*

ISO. (2018). *Risk management principles and standards;*

John S. Wilson; Catherine L. Mann and Tsunehiro Otsuki. (2004). *Assessing the Benefits of Trade Facilitation: A Global Perspective.* Washington DC: World Bank;

Software, T. W. (2020 оны January 31). *Trade statistics by country.* The World Integrated Trade Solution Software: https://wits.worldbank.org/countrystats.aspx?lang=en-ээс Гаргасан;

UNECE. (2015, 2017, 2019). *Global Survey on Digital and Sustainable Trade Facilitation.*;

WCO. (2005). *The SAFE Framework of Standard.* WCO.

WCO. (2012). *WCO Data Model* . Brussels.

хяналтын үйл ажиллагаанд ашиглах шаардлагатай.

WCO. (2018). *Coordinated border management.* Brussels: WCO;

WTO. (2020 оны July 01). *Trade Facilitation Agreement Data Base*. WTO Members: s://tfadatabase.org/members-ээс Гаргасан;

Б.Индра, Д.Дөлгөөн. (2020). *Монголын Хятад судлалын хөгжлийн хүрээлэн: Монгол, Хятадын Худалдаа, Эдийн засгийн хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөр.* Улаанбаатар хот;

газар, Г. е. (1995-2024). *Гадаад худалдааны статистик мэдээлэл.* УБ;

ДГБ. (1974). *Гаалийн Горимыг Хялбарчлах, Уялдуулах Тухай Олон Улсын Конвенц.* Киото;

ДГБ. (2019 оны 12 01). *Олон улсын гэрээ, хэлэлцээр*. ДГБ-ын цахим хуудас: http://www.wcoomd.org/en/about-us/legal-instruments/conventions.aspx-ээс Гаргасан;

ДХБ. (2019 оны 11 25). *Олон улсын гэрээ, хэлэлцээр*. ДХБ-ын цахим хуудас: https://www.wto.org/english/tratop_e/tradfa_e/tradfa_e.htm-ээс Гаргасан;

УИХ. (2013). *Хилийн боомтын тухай хууль.* Улаанбаатар;

хороо, Ү. с. (1995-2024). *Төсвийн орлого.* УБ.

Хавсралт 1

Монгол Улсын гадаад худалдааны статистик мэдээлэл, гаалийн газар, хороодоор (1995-2024 он, тэрб. ам. доллар)

Код	ГГХ	Нийт бараа эргэлт (сая.ам.долл.)										
		2018	2019	2020	2021	2022	2023	2024	Дундаж	Нийт	Хувь	Хэлбэлзэл
1	ГЕГ	153.5	433.0	1,793.3	1,016.5	1,129.4	740.5	899.6	880.8	6,165.7	5%	
2	УБГГ	3,663.5	3,661.3	3,338.0	4,339.9	5,402.7	5,180.6	5,662.6	4,464.1	31,248.6	24%	
3	ЗҮГГ	1,143.1	1,301.6	1,143.8	1,307.3	993.7	2,237.2	3,268.4	1,627.9	11,395.1	9%	
4	СЭГГ	294.8	312.9	183.2	306.9	741.7	731.0	726.0	470.9	3,296.5	3%	
5	ЧХОУНБГГ	384.0	568.7	206.9	489.4	736.1	679.2	782.5	549.5	3,846.7	3%	
6	ДоГГ	316.7	322.7	226.6	322.6	386.9	409.9	554.7	362.9	2,540.0	2%	
7	БӨГГ	53.9	61.0	43.2	64.4	115.2	119.4	115.2	81.7	572.2	0%	
8	ХоГГ	108.3	187.4	99.6	216.6	772.2	487.5	676.9	364.0	2,548.3	2%	
9	УвсГГ	28.5	24.6	17.8	27.7	46.7	26.9	34.2	29.5	206.4	0%	
10	ОрГГ	1,017.4	929.1	902.0	1,275.0	1,485.5	1,408.5	1,989.4	1,286.7	9,006.8	7%	
11	СШГГ	915.5	785.4	808.9	1,404.4	1,767.0	1,864.2	1,366.8	1,273.2	8,912.1	7%	
12	УХШИГГ	82.0	68.0	49.4	81.8	98.9	93.5	97.8	81.6	571.3	0%	
13	ДаГГ	312.2	446.0	594.5	873.6	385.9	460.7	508.7	511.7	3,581.6	3%	
14	ГШГГ	3,405.7	3,671.3	2,805.5	3,888.4	6,278.8	7,529.6	8,038.9	5,088.3	35,618.3	28%	
15	ШХГГ	680.5	656.2	579.6	336.8	704.6	2,113.5	2,362.5	1,062.0	7,433.8	6%	
16	БиГГ	226.3	216.1	68.6	144.3	129.0	336.0	279.0	199.9	1,399.3	1%	
17	ГАГХ	100.2	101.2	9.2	-	70.3	17.8	57.3	50.8	355.9	0%	
18	Завхан ГХ	0.2	0.6	0.0		0.1	0.3	0.5	0.3	1.7	0%	
19	ХөГХ	0.6	0.3	0.2	0.2	0.3	0.4	0.5	0.4	2.5	0%	
20	Ханги ГГ	-	-	-	-	-	-	573.5	81.9	573.5	0%	
		12,886.8	13,747.2	12,870.3	16,095.8	21,244.8	24,436.5	27,994.8	18,468.0	129,276.1		

Эх сурвалж: Гадаад худалдааны статистик мэдээлэл (газар, 2018-2024)

ХИЛИЙН БООМТЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

Б.Гансүх
Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн ахлах багш, докторант, дэд хурандаа

Товч агуулга: Дэлхий дахинд болон Монгол Улсад терроризм, олон улсын чанартай үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг гарах боломж өндөр, эрсдэлтэй байна. Хилийн боомтын аюулгүй байдал нь хилийн боомтын бүс дэх хүний эрүүл мэнд, техник хэрэгсэл, байгууламжийн аюулгүй байдалд нөлөөлөх гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу үйлдэл үзүүлэх чадвар хилийн боомтод үүсэж болох эрсдэлийг бууруулах зарим арга зам.

Түлхүүр үгс: Эрсдэл, эрсдэлтэй байдал, терроризм, хилийн хяналт, эрсдэлийг бууруулах стратеги.

Удиртгал

Дэлхий дахинд болон Монгол Улсад терроризм, олон улсын чанартай үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг гарах боломж өндөр, эрсдэлтэй байна. Болзошгүй эрсдэл, аюул заналыг бууруулах, хилийн хяналтаа сайжруулах зорилгоор улс орнууд хамтын ажиллагаагаа бэхжүүлэн хөгжүүлж, дэвшилтэд техник, технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглаж байна. Хилийн боомтын аюулгүй байдал нь хилийн боомтын бүс дэх хүний эрүүл мэнд, техник хэрэгсэл, байгууламжийн аюулгүй байдалд нөлөөлөх гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу үйлдэл үзүүлэх чадвар тул эрсдэлийг бууруулах арга зам нь холбогдох хууль эрх зүйн орчныг сайжруулах, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, олон улсын хамтын ажиллагааг сайжруулах, хүний эрхийг хамгаалах зэрэг олон талт арга хэмжээг хамарна. Мөн хууль эрх зүйн зохицуулалт, хүний нөөцийн чадавхыг нэгэн зэрэг хөгжүүлэх шаардлагатай. Олон улсын туршлагаас харахад, системтэй төлөвлөлт, тууштай хэрэгжилт, олон талын оролцоо нь амжилтын үндэс болдог. Монгол Улс өөрийн онцлог, боломжид тулгуурлан эдгээр туршлагуудыг нутагшуулан хэрэгжүүлснээр хилийн боомтын үйл ажиллагааны эрсдэлийг үр дүнтэй бууруулах боломжтой юм.

Үндсэн хэсэг

Хилийн хяналтын үйл ажиллагааг сайжруулах

Боомтуудын нэвтрүүлэх чадвар нэмэгдсэнээр хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийн тоо огцом нэмэгдэх бөгөөд үүнтэй холбогдуулан хилийн хяналт, шалгалтад ирэх ачаалал нэмэгдэж,

хяналтын дэвшилтэт тоног төхөөрөмжөө нэмэгдүүлэх шаардлагатай байгааг Монгол улсын Засгийн газраас анхаарал хандуулж, шаардлагатай тоног төхөөрөмжийг улсын төсөв болон олон улсын байгууллагуудын хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэж байна. Гэсэн хэдий ч хилийн боомтуудад одоо ашиглаж байгаа рентген төхөөрөмжийн тоо хэмжээ цөөн, техникийн үзүүлэлт хангалтгүй, хуучирсан байдалтай байна. Хяналтын төхөөрөмжийг ажиллуулах, үйл ажиллагаанд ашиглах чиглэлээр хүний нөөц бэлтгэх, сургах, мэргэшүүлэх шаардлага хилийн хяналтын байгууллагуудын тулгамдсан асуудал болоод байна. Тиймээс дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болох юм. Үүнд:

- Автоматжуулсан систем ашиглах: Хилийн боомт дээр гаалийн болон хил хяналтын үйл ажиллагааг автоматжуулах нь алдааг бууруулах, үйл ажиллагааг хурдасгах, байнгын хяналт хийх боломжийг олгоно. Эдгээр систем нь тодорхой хүчин зүйлсийг үнэлэх, мөн нэвтрүүлж буй бараа бүтээгдэхүүний мэдээллийг хурдан баталгаажуулах боломжийг бий болгодог.
- Цахим хяналтын системүүдийг нэвтрүүлэх: Цахим бараа тээвэрлэлтийн систем (e-customs, electronic tracking) ашиглах нь боомт дээрх гаалийн хяналтыг сайжруулж, бичиг баримтын хяналтыг автоматжуулж, хүндрэлээс зайлсхийхэд тусалдаг.
- Техникийн шинэчлэл хийх: Хилийн боомтуудад хяналтын камерыг олон тоогоор суурилуулж, өндөр нарийвчлалтай сканердах төхөөрөмжүүдийг ашиглах нь харилцан холбоотой гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагааг илрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Тухайлбал, Тухайн хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, ангиллыг үл харгалзан бүхий л төрлөөр хяналт тавих зориулалт бүхий рентген төхөөрөмжийг сонгох,
- Хилийн боомтод суурилуулсан рентген төхөөрөмжийг хилийн хяналтын байгууллагууд /хил хамгаалах, гааль, гадаадын иргэн харьяатын газар, бусад/-ын үйл ажиллагаандаа хамтран ашиглах, мэдээлэл солилцох, харилцан уялдааг сайжруулах, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах.
- Хил хамгаалах байгууллага, хилийн шалган нэвтрүүлэх албаны шалгагчийн ур чадварыг дээшлүүлж, техник

хэрэгслийн ашиглалтыг сайжруулах.[1]

1. Террорист халдлагаас сэргийлэх

- Аюулгүй байдлын хяналтыг сайжруулах. Террорист халдлагаас сэргийлэхийн тулд хилийн боомтууд дээр аюулгүй байдлын үзлэг, тандалт, тагнуулын ажиллагааг зохион байгуулж, бүх зорчигчид болон ачаа барааг нарийвчлан шалгах. Дэлхийн улс орнуудын хууль сахиулах байгууллагуудад ашиглагддаг биометрийн мэдээллийн сан нь тодорхой чиглэлээр тусгай үүргийг хэрэгжүүлэхэд ашиглагдаж байсан боловч сүүлийн жилүүдэд терроризм, үндэстэн дамнасан гэмт хэргийн аюул занал өсөн нэмэгдэхийн хэрээр улс орнуудын төр засгаас өөрийн мэдээллийн санг үр дүнтэй ашиглаж иргэдийнхээ аюулгүй байдлыг найдвартай хангахад онцгойлон анхаарах болсон. Биометрийн мэдээллийг идэвхтэйгээр солилцох нь үндэстэн дамнасан гэмт хэргийг мөрдөн шалгах, террористууд болон онц ноцтой гэмт этгээдийг ижилсүүлэн тодорхойлоход маш чухал юм.[2] Боомт дээрх хамгаалалтын тоног төхөөрөмж (металл илрүүлэгч, химийн илрүүлэгч гэх мэт) өргөжүүлж, тусгай алба хаагчдыг сургалттай байлгах нь халдлагаас сэргийлэх ач холбогдолтой.
- Олон улсын хамтын ажиллагаа: Хил дамжин өнгөрөх террорист бүлэглэлүүдийн үйл ажиллагааг илрүүлэх, тэднийг илрүүлэхийн тулд олон улсын тагнуулын байгууллагуудтай хамтран ажиллах нь чухал. Интерпол болон бусад олон улсын аюулгүй байдлын байгууллагуудтай хамтран ажиллах нь хил дамжин үйлдэгдэж болох террорист үйлдлүүдийг илрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

2. Байгалийн гамшигт тэсвэртэй байгууламж байгуулах.

- Гамшигт тэсвэртэй инфрастуктур байгуулах: Хилийн боомт дээр үүсэж болох байгалийн аюулууд (газар хөдлөлт, үер, шуурга, түймэр) төдийгүй халдварт өвчинтэй тэмцэхэд ч гамшгийн үеийн хариу арга

[1] Манцуров.А.Ю., (2018). “Правовые и организационные основы деятельности пограничных органов Китайской Народной Республики по обеспечению национальной безопасности”, ФГКОУ ВПО, Дальневосточный юридический институт МВД России, Право/2. Административное право и финансовое право, rusnauka.com.

[2]International Maritime Organization. (2023). "Port Security Report"

хэмжээний төлөвлөлт чухал. Боомтуудын дэд бүтэц нь гамшигт тэсвэртэй, удаан хугацааны үйл ажиллагааг хангахуйц байх шаардлагатай.

- Төслийг нэвтрүүлэх, сургалт явуулах: Байгалийн гамшиг, ослын нөхцөлд шуурхай хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны төлөвлөлт, тусламж үйлчилгээний сургалт явуулах нь хилийн боомтуудын гамшгийн үеийн бэлтгэл хангамжийг сайжруулна.

3. Хүний эрхийг хамгаалах

Хүний эрхийн хяналтыг чангатгах: Хилийн боомт дээр хүний эрхийн зөрчил гарах эрсдэлээс сэргийлэхийн тулд олон улсын стандарт, хүний эрхийн хэм хэмжээ, эрх зүйн орчныг чанд мөрдөх шаардлагатай. Боомт дээр явагддаг бүх үйл ажиллагааг хүний эрхийн зарчмуудын дагуу зохион байгуулж, хүний эрхийг зөрчихгүй байх зохицуулалт хийх нь чухал. Зарим улсын хувьд дүрвэгсэд, шилжин суурьших иргэдийг хамгаалах асуудал яригддаг бөгөөд хилийн боомт дээр дүрвэгсдийг хууль ёсны хувьд зөвшөөрөх, тэдний эрхийг хамгаалах нь хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх арга зам юм. Шилжин суурьшигчид болон дүрвэгсэдтэй харьцахад зөв зохицуулалт, эмнэлгийн тусламж, дэмжлэг үзүүлэх шаардлагатай болно.

4. Эдийн засгийн хариуцлагатай бодлого хэрэгжүүлэх

- Худалдааны тогтвортой бодлого: Хилийн боомт дээр эдийн засгийн эрсдэлийг бууруулахын тулд зохицуулсан, тогтвортой худалдааны бодлого хэрэгжүүлэх шаардлагатай. Хилийн боомтуудад гаалийн болон татварын асуудал, ачаа тээвэрлэлтийн зохицуулалтыг хуулийн хүрээнд тогтмол шалгаж, хянах нь эдийн засгийн эрсдэлээс хамгаалж чадна.
- Бизнесийн болон тээвэрлэлтийн хялбаршуулсан нөхцөл бүрдүүлэх: Эдийн засгийн эрсдэлийг бууруулахын тулд тээвэрлэлтийн үйл ажиллагааг хялбаршуулах, хүнд суртлыг бууруулах, гаалийн ажиллагааг хурдан хийж, экспорт, импортын процессыг хялбаршуулах нь эдийн засгийн өсөлтийг дэмжих арга зам болно.

5. Хилийн боомтод нэгдсэн хяналт, зөв зохицуулалт бий болгох

- Олон улсын хамтын ажиллагаа: Хилийн боомтуудыг хамтран удирдах, зорчигч болон ачаа тээвэрлэгчдийг хянах олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь эрсдэлийг бууруулах нэг арга юм. Олон улсын стандарт, гэрээ

хэлэлцээрийг сайтар хэрэгжүүлэх нь үйл ажиллагааг үр ашигтай, аюулгүй болгоно. Хамтарсан сургалт, удирдлагын хамтын ажиллагаа: Хилийн боомт дээрх аливаа асуудлыг хурдан шийдвэрлэхэд зориулан улс орнуудын хил, гаалийн ажилтнуудын хамтын сургалт, удирдлагын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь эрсдэлийг бууруулах чухал алхам юм.

Хилийн боомт дээр үүсэх эрсдэлийг бууруулах нь хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалахад чухал үүрэгтэй. Хил, гаалийн хяналт, технологийн шинэчлэл, олон улсын хамтын ажиллагаа, байгалийн гамшигт тэсвэртэй бүтэц, хүний эрхийг хамгаалах болон эдийн засгийн хариуцлагатай бодлого хэрэгжүүлэх нь хилийн боомтод үүсэх эрсдэлүүдийг бууруулах хамгийн үр дүнтэй арга замууд гэж үзэж байна.

Боомтын дэд бүтэц болон барааг ачиж, буулгахтай холбоотой үйл ажиллагаа, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах нь санхүүгийн эх үүсвэр шаардах бөгөөд урт болон дунд хугацааны стратегийн түвшинд төрийн бодлоготой уялдан хэрэгжинэ. Энэ чиглэлээр томоохон бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлж байгаа бөгөөд хилийн боомт, гаалийн хяналт, мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлсэн ажилд үйл ажиллагааг уялдуулж, хялбаршуулан, стандартчилснаар худалдааг хөнгөвчлөхөд ахиц дэвшил гарна. Тиймээс:

1. Хилийн боомтын хөгжлийн салбарт хамтран ажиллах гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор одоогийн хилийн боомтын бүтээн байгуулалтын ажлыг үйл ажиллагаатай уялдуулж, цомхон, хүндрэл багатай, хялбаршуулсан байдлаар хяналт тавих туршлагыг хөрш орнуудаас судлах.
2. Хилийн боомтын үйл ажиллагаанд гадаад худалдаатай холбоотой асуудлыг шууд хариуцах, манлайлагч байгууллагыг албан ёсоор тодорхойлох. Учир нь гурван талт хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах үед ажиллаж байсан зарим нэгжүүд өдгөө нэгдсэн, эсхүл татан буугдсан тохиолдол гарсан.

Хилийн боомтод үүсэх эрсдэлийг бууруулах нь зөвхөн тухайн боомтын аюулгүй байдал, тээвэрлэлтийн үр ашгийг дээшлүүлэх төдийгүй улс орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал нөлөөтэй.

Дэлхийн улсуудын гаалийн хяналтын эрсдэлийг бууруулсан туршлага

Үндсэн үйл ажиллагаа, эрсдэлийн төрөл		Олон улсын туршлага
Үндэсний болон нийгмийн аюулгүй байдал	- буу, зэр зэвсэг; - үй олноор хөнөөх зэвсэг; - цацраг идэвхт бодис; - хар тамхи, мансууруулах бодис; - хуурамч бараа; - чанар, стандартын шаардлага хангаагүй бараа; - аюултай хог хаягдал; - озон задалдаг бодис; - түүх соёлын дурсгалт зүйлс	**гаалийн байгууллага үйл ажиллагаагаа сайжруулсан:** Армян, Египет, Этиоп, Фижи, Гренада, Мали, Перу, Гүрж, Ямайк, Малави, Хойд Африк, Аргентин, Азербайжан, Бенин, Брунди, Конго, Украйн, Узбекистан, Швейцар; **гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай бичиг баримтыг цахим хэлбэрээр баталгаажуулсан:** Бахрейн, Бруней, Беларусь, Израил, Казахстан, Латви, Литва, Никарагуа, Пакистан, Перу, Филиппин, Швейцар, Тунис, Эмирт, Замби, Белиз, Ботсван, Бурунди, Чех, Сальвадор, Грек, Мадагаскар, ОХУ, Шри-ланка, Уругвай, Доминикан, Гренада, Унгар, Лаос, Нигер, Катар, Хойд Африк, Испани, Уругвай, Тринидад-тобаго, Бенин, Доминикан, Мьянмар, Узбекистан; **бичиг баримтын тоог цөөлсөн:** Буркина-фасо, Камбож, Казахстан, Монтенегро, Руанда, ОХУ, Танзани, Зааны ясан эрэг; **цахим нэг цонхны систем нэвтрүүлсэн:** Индонез, Израил, Мадагаскар, Колумб, Сингапур, Гана, БНСУ, Бенин, Португал, Узбек, Сальвадор, Мексик, Мозамбик, Руанда; **боомтын дэд бүтэц болон үйл ажиллагааг сайжруулсан:** Төв Африк, Хорват, Ангол, Бахрейн, Кени Никарагуа, Пакистан, Саудын Араб, Жибути; Вануату, Сенегал, Нидерланд, Уругвай, Бүгд Найрамдах Ардчилсан Сахарын Араб Улс, Бенин, Латви, Гвиней, Казахстан, Алжир, Гана, Йордан, Танзани; **Эрсдэл тооцох арга зүйд суурилсан гаалийн хяналт:** Армян, Гана, Казахстан, Перу, Египет, Кени, Бельги, Тайланд, Гондурас, Иордан, Либери, Марокко, Нигер, Палау, Суринам, Вьетнам, Албани, Камерун, Филиппин, Мавритани, Уругвай; **Цахим мэдээлэл солилцох:** Чили, Малайз, Словени, Эмират, Болгар, Гамби, Гондурас, Иордан, Либери, Польш, Сан-Томе Принсипи, Сейшель, Сьерра-Леоне, Слован, Танзани, Белиз, Эстони, Турк, Пакистан, Замби, Ботсван, Лаос; **Хилийн нэгдсэн зохицуулалттай удирдлага:** Руанда, Замби.
Санхүү	- барааны ангилал; - гаалийн үнэлгээ; - гарал үүслийн улс; - тариф; - татварын хөнгөлөлт, чөлөөлөлт; - шилжих үнэ	
Байгууллагын үйл ажиллагаа	хууль эрх зүйн тогтолцоо; - удирдлагын арга барил; - ажилтнуудын чадавх; - үйл ажиллагааны давхардал; - мэдээллийн технологи; - хязгаарлагдмал нөөц; - үр дүнгүй үйл ажиллагаа...	

Эх сурвалж: WCO, Annual Report 2013-2014; WB, Doing Business 2011-2015

Гаалийн бүрдүүлэлтэд хавсаргах бичиг баримтын тоо олон, үйл ажиллагаа давхардсан, боомтын дэд бүтэц хөгжөөгүй, мэдээлэл солилцох үйл ажиллагаа тогтмолжоогүй, цахим бичиг баримтын баталгаажуулалт нэг мөр болоогүй зэрэг олон төрлийн үйл ажиллагаанд гаалийн хяналтын эрсдэлийг тооцон, түүнийг бууруулсныг дээрх судалгаа харуулж байна. ДБ-ны “Бизнес эрхлэхүй” 2012 дүгнэлтийн “Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт”-д оролцсон 183 улсын “130 улс нь цахим хэлбэрээр мэдээлэл солилцдог, 97 улс нь эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн, эдгээрээс 49 улс нь 2006 оноос, 31 улс нь бага, дунд орлоготой, 49 улс цахим нэг цонхны системийг нэвтрүүлсэн” (WB, Doing Business 2012) гэж дүгнэжээ.

Хилийн боомтуудын эрсдэлийг бууруулах амжилттай стратегийг судалж үзэхэд янз бүрийн улс орнуудад олон янзын арга барилууд илэрч, хамтын ажиллагаа, инновацын ач холбогдлыг онцолж байна. Эрсдэлийн үнэлгээний цогц тогтолцоог хэрэгжүүлсэн улс орнууд хилийн үйл ажиллагаандаа ноцтой байдал, үр ашгийг эрс дээшлүүлсэн байна. Эдгээр тогтолцоо нь эмзэг байдлыг тодорхойлоход тус дөхөм болж, хилийн хяналтын байгууллагууд болзошгүй аюулд идэвхтэй хариу арга хэмжээ авах боломжийг олгодог. Түүнчлэн, автомат сканер, бодит цагийн хяналтын систем зэрэг технологид суурилсан шийдлүүдийг нэвтрүүлсэн нь хилийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Ийм шинэлэг зүйл нь хяналтын үйл явцыг хялбаршуулаад зогсохгүй, ЕХ-ны Resumenet төсөлд хэлэлцсэн санаачилгад онцлон тэмдэглэснээр хорлонтой халдлага болон үйл ажиллагааны тасалдлыг эсэргүүцэх чадварыг сайжруулдаг. Иймээс стратегийн төлөвлөлтийг дэвшилтэт технологийн хэрэгслүүдтэй хослуулах нь хилийн боомтын эрсдэлийг амжилттай удирдахад чухал хүчин зүйл болж байгаа бол хамтын хүчин чармайлт нь тасралтгүй сайжруулахад чухал үүрэгтэй байна.

Дүгнэлт

Хилийн боомтууд нь дэлхийн худалдаа, аюулгүй байдалд чухал үүрэг гүйцэтгэж, улс орон даяар бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, хүмүүсийн урсгалыг нэвтрүүлэх стратегийн гарц болж байна. Эдгээр боомтууд нь олон улсын худалдааг хөнгөвчлөхөөс гадна хууль бус наймаа, терроризм зэрэг аюулаас хамгаалах аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх чухал цэг болдог. Тэдгээрийн ач холбогдлыг нийлүүлэлтийн сүлжээн дэх эмзэг байдал, блокийн сүлжээ гэх мэт технологийн дэвшил нь хилийн боомтуудад барааг хэрхэн хянаж, баталгаажуулах хэлбэрийг өөрчилж, улмаар нийлүүлэлтийн сүлжээний практикт ил тод байдал, итгэлцлийг нэмэгдүүлж байна. Хилийн боомтын эрсдэлүүдийг

бууруулах нь нэг удаагийн арга хэмжээ бус, тасралтгүй үргэлжлэх, олон талт оролцоо шаардсан цогц үйл явц юм. Монгол Улсын хувьд өөрийн онцлог нөхцөл байдалд тулгуурлан, олон улсын туршлагыг зөв түвшинд нутагшуулж, үе шаттайгаар хэрэгжүүлснээр эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог бий болгох боломжтой юм. Ингэснээр үндэсний аюулгүй байдлыг хангах, гадаад худалдааг хөнгөвчлөх, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих боломжтой болно.

Хилийн боомтууд үйл ажиллагааг үндсээр нь тасалдуулж, аюулгүй байдлыг алдагдуулах олон эрсдэлтэй тулгардаг. Хамгийн тулгамдсан аюулуудын нэг бол геополитикийн хурцадмал байдал бөгөөд энэ нь хяналт шалгалтыг өндөрсгөж, ачаа боловсруулалтыг удаашруулж, эдийн засгийн алдагдал, логистикийн тасалдал үүсэх ба боомтын системд чиглэсэн кибер халдлага зэрэг технологийн эмзэг байдал эрсдэлийг нэмэгдүүлдэг. Мөн байгаль орчны аюулууд нь томоохон сорилтуудыг бий болгож, боомтын захиргаанаас тэсвэрлэх чадварыг сайтар төлөвлөхийг шаарддаг. Эдгээр эрсдэлүүдийн харилцан хамаарал нь хилийн боомтын менежментийн нарийн төвөгтэй байдлыг онцолж байгаа бөгөөд эрх баригчдад аюулгүй байдлын яаралтай асуудлыг шийдвэрлэх төдийгүй олон янзын сорилтыг даван туулах урт хугацааны тэсвэр тэвчээрийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай. Хилийн боомтууд олон улсын түншүүдээс сургамж авснаар эдгээр олон талт эрсдэлд илүү сайн бэлтгэж, бууруулах боломжтой.

Эх сурвалж:

Хууль, тогтоомжууд

1. Монгол Улсын Үндсэн хууль 1993
2. Монгол улсын хилийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2016

Монгол хэл дээрх эх сурвалж

1. Асхар Х. “Хилийн боомтын үйл ажиллагааг боловсронгуй болгох арга зам”, диссертац, 2021.
2. Баттогтох П. “Говь талын нөхцөл дэх хилийн цэргийн ангиудыг удирдах ажиллагааг боловсронгуй болгох нь” диссертац, 1998.
3. Одбаяр Ц. “Хилийн аюулгүй байдлыг хангахад тусгай томилгоот салбарын гүйцэтгэх үүргийн судалгаа” диссертац, 2018.
4. Отгонсар.Н. Боомтын үйл ажиллагааг боловсронгуй болгох боломж, УБ., 2018
5. Хулан Г. “Хилийн боомтод хүний аюулгүй байдлыг хангах асуудлын судалгаа” диссертац, 2019.

Гадаад хэл дээрх эх сурвалж

1. Волынский-Басманов Ю.М., Волынский В.Ю., Каменева М.Е., Эиашвили Н.Д., Аминов И.И., “Профайлинг. Технологии предотвращения противоправных действий”, Москва., 2012.
2. Клименко Б.М., Порк А.А, “Территория и граница СССР”. Москва., 1985.

АНУ-ЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Х.Баасандорж
Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Батлан хамгаалахын удирдлагын академийн Аюулгүй байдал судлалын төвийн дарга, дэд хурандаа

Товч агуулга: 1990 оныг хүртэл дэлхий ертөнц бүхэлдээ ЗХУ болон АНУ гэсэн хоёр туйлт дайсагнасан хүйтэн дайны нөхцөл байдалд оршиж байсан бөгөөд Берлиний ханыг нурааж ЗХУ задран унаснаар дээрх 2 их гүрний хооронд олон жил үргэлжилсэн хүйтэн дайн дуусгавар болж, дайсагнасан цэрэг зэвсгээр хөөцөлдсөн улс төрийн бодлого дуусгавар боллоо хэмээн хэн бүхэн хэлж ярьж бичиж байв. АНУ-ын дангаар ноёрхох их гүрний ноёрхлын бодлого энэ үеэс эхэлсэн бөгөөд өнгөрсөн 35 жилийн турш дэлхий нийтийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаа хэрхэвч энх амар амгалан байсангүй. Өнгөрсөн он жилүүдэд Персийн булангийн дайн, Иракийн дайн, Афганистаны дайн, Босны герцогавин дахь бөмбөгдөлт, Югослав дахь мөргөлдөөн, Ойрх дорнод дахь олон жилийн дайн тулаан, Украйны дайн гэх мэт харин ч хүйтэн дайны үеэс дайн тулааны тоо статистик өссөн үзүүлэлттэй байна. Эндээс үзэхэд нэг туйлт ертөнцөд аль нэг дангаар ноёрхол тогтоогоод энх тайван амар амгалан тийм ч амар ирдэггүйг бид харж болно. Тэр ч бүү хэл дэлхийд дангаар ноёрхож буй Америкийн нэгдсэн улс нь өөрийн аюулгүй байдлыг бүрэн хангаж чадахгүй хилийн аюулгүй байдлаараа дамжуулан үндэсний аюулгүй байдлаа өнгөрсөн 5 жилийн хугацаанд хэрхэн аажим аажмаар алдсан тухай товчхон сийрүүлэхийг оролдлоо.

Түлхүүр үг: Аюулгүй байдал, геополитик, улс төрийн бодлого

Үндсэн хэсэг

Даяаршил гэдэг үг хэллэгийг бид сонсох болоод багагүй хугацаа өнгөрсөн байх, товчхондоо даяаршил гэдгийг хүмүүс хүн төрөлхтөн хаана ч амьдарч болно, дэлхий хавтгай болсон, бид хаанаас ч онлайнаар суралцах боломжтой, хаана ч нүүж шилжиж амьдарч болно, тухайн хүний эрх, эрх чөлөөг ардчилал, хүний эрх гэсэн далбаан дор хангаж өгч байх ёстой, чөлөөт худалдаа, зах зээлийн эдийн засаг, өмч хувьчлал зэрэг ойлголтыг даяаршлын хүрээнд түгээмэл хэрэглэж байх шиг. Гэтэл сүүлийн жилүүдэд тэр тусмаа 2022 оны 02 дугаар сарын 22-нд Украйны дайн эхэлсэнтэй холбогдуулан даяаршил, либерализм дуусгавар боллоо, АНУ-ын алтан үе дахин эргэж ирэхээргүй боллоо, Жое Байдены засгийн газар стратегийн маш том алдаа гаргаж ОХУ болон БНХАУ-ыг нэгтгэчихлээ зэргээр бичих барууны судлаачид цөөнгүй

үзэгдэх болов. Даяаршлыг даган тухайн улсад нутагшдаг хэвлэлийн эрх чөлөө, өмч хувьчлал, чөлөөт зах зээлийн эдийн засаг, LGBTQ нарын бодлогыг хүчтэй эсэргүүцэн шүүмжлэх жижиг, том цөөнгүй улсууд дэлхий дээр мэдэгдэл хийцгээх болсон нь үнэхээр ч дээр дурдсан барууны зарим судлаачдын хэлж, ярьж, бичиж байгааг батлах мэт. АНУ нь сүүлийн 35 жилийн хугацаанд дэлхийд дангаар жанжлах бодлого явуулахын зэрэгцээ чөлөөт зах зээлийн бодлогыг өөрөөсөө бусад улсад тулгах дээрэнгүй бодлого явуулж ирсэн бөгөөд үүгээр дамжуулан зарим улсын улсын үйлдвэрийн газруудын дээрэмдэн авч байсан нь нэгэнт ил болоод байгаа юм. Тэд өөрөөсөө бусад улсыг сулруулаад зогсохгүй өөрсдөө ч мөн адил бий болгосон механизмдаа “хордож” өөрийн орны хүүхэд залуусыг хар тамхинд донтох, олдмол бэлгийн гаж чиг хандлагатай болгох, хүний наймааны зах зээлийн хохирогч болох зэргээс хамгаалж чадахгүй байдалд хүрээд байгаа нь яахын аргагүй даяаршлын “ач гавьяа” гэж хэлж болох юм.

АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд ардчилсан намаас нэр дэвшигч Камала Харрис ялагдсан шалтгаан:

Өнгөрсөн оны 11 дүгээр сард дэлхийн хамгийн хүчирхэг гүрэн гэгддэг америкийн нэгдсэн улсын ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн ажиллагаа зохион байгуулагдсан бөгөөд энэхүү сонгуульд ардчилсан намаас нэр дэвшигч Камала Харрис 226 төлөөлөгчийн санал авсан бол өрсөлдөгч Бүгд найрамдах намаас дахин нэр дэвшиж буй Д.Трамп 312 төлөөлөгчийн саналаар хол тасархай сонгуульд ялалт байгуулав. Камала Харрисыг дэмжихээр тус улсын еврей лобби бүлэг 1 тэрбум долларын хандив өргөөд байсан бол өрсөлдөгч Д.Трампад 380 сая долларын л хандив өгсөн нь олон нийтийг гайхшируулж байв. Ийм зөрүүтэй санхүүгийн дэмжлэгтэй байхад яагаад Камала ялагдчихав гэдгийг олон судлаач нар өөр өөрийн өнцгөөс тайлбарлаж байгаа бөгөөд хамгийн том шалтгаануудын нэгээр Камала хэт хожуу буюу 2024 оны 07 дугаар сард л гэнэт нэр дэвшихээр болсон нь олон нийтийн санаа бодлыг өөртөө татаж чадаагүй гэсэн томоохон шүүмжлэлийг хүлээгээд байна.

Мөн түүнээс гадна Камала өнгөрсөн жилүүдэд АНУ-ын дэд ерөнхийлөгчөөр ажилласан бөгөөд өмнөх засгийн газарт хэт их хууль бус цагаачдыг чөлөөтэй нэвтрүүлэх бодлого баримталж нийгмийн эмзэг ядуу давхаргад очих ёстой байсан халамжийг хилээр орж ирсэн хууль бус цагаачид руу шилжүүлэх, задгай хилийн бодлого явуулах болсон зэрэг асуудал нь олон нийтийн дургүйцлийг ихээр хүргэж байв. Камала Харрисыг ардчилсан намаас нэр дэвшүүлэхээр

сонгосон хамгийн том шалтгаан бол АНУ-ын хар арьст давхарга болон эмэгтэйчүүдийн саналыг авах зорилготой байсан боловч сонгуулийн дүн гарахад Камала харин ч дээрх давхаргын эгдүүцэл дургүйцлийг хүргэсэн нь нэгэнт илт болсон юм. Дээр дурдсанчлан АНУ-ын хар арьст иргэд ядуу буурай нийгмийн эмзэг давхаргын ихэнх хувийг эзлэх бөгөөд энэхүү давхаргад очих ёстой нийгмийн халамж, хоол хүнсний талоныг хилээр орж ирсэн хууль бус цагаачдад шилжүүлсэн нь энэхүү давхаргаас санал авч чадахгүйд хүргэсэн байна. Харин эмэгтэйчүүдээс санал аваагүй шалтгааныг АНУ-ын иргэд хараахан эмэгтэй ерөнхийлөгчтэй болоход бэлэн бус байгаа бөгөөд эмэгтэйчүүд түүний Сан Франциско хотын даргатай үүсгэсэн амрагийн асуудлыг хэзээ ч уучлахгүй гэсэн судалгааны дүн ч гарсан байв. Камала өмнө нь сонгуульд нэр дэвшиж байгаагүйгээр барахгүй хэзээ ч ялж үзээгүй нэгэн юм. АНУ-ын дэд ерөнхийлөгч нь албан үүргийн хуваарилалтаар АНУ-ын хилийн аюулгүй байдлыг хариуцдаг боловч хил дээр ганц ч удаа очиж үзээгүй, үүнийгээ тв-ийн ярилцлагад хэлснээр бас нэгэн ялагдах том шалтгаан болсон байна.

Доналд Трамп ялсан шалтгаан:

Америкийн Нэгдсэн Улсын хилээр хууль бусаар цагаачид олноор орж ирэх болсон бөгөөд өнөөдөр ч энэхүү “гамшигт үзэгдэл” Америкт үргэлжилж байна. АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама болон Дональд Трамп нар аль аль нь тус улсын ерөнхийлөгчөөр ажиллаж байхдаа хилийн дээрх хууль бус цагаачдын асуудлыг "Энэ бол гамшиг" хэмээн нэрийдэж байжээ.

Энэ ч утгаараа Д.Трамп АНУ-ын 47 дахь ерөнхийлөгч болон дахин сонгогдож чадсан гэж үзэж болно. Тэрээр АНУ-руу хууль бус цагаачид олноороо хил зөрчин ирж байгааг таслан зогсооно гэдгээ мэдэгдэхийн зэрэгцээ хил дээрх хүний наймаа, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг, хар тамхины наймааны сүлжээ зэргийг таслан зогсоож цаашид мексикийн хана барих ажлыг зарим эх сурвалжууд “Трампын хана” гэж бичиж байгааг дуусгавар болгон Аврора хэмээх хууль бус цагаачдыг олноор нь баривчлан нутаг буцаах ажиллагаа эхлүүлнэ гэдгээ амлаад байсан нь ялах томоохон шалтгаан болсон гэж судлаачид үзэж байна.

Жое Байдены засгийн газрын үед баримталсан задгай хилийн бодлого:

2021 оны 1 дүгээр сард АНУ-ын 46 дахь ерөнхийлөгч Жое Байден ерөнхийлөгчийн тангараг өргөснөөр түүний засаг захиргаа үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тэрээр ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа АНУ хил дээр үндсэндээ “Задгай хилийн бодлого” явуулж

эхэлсэн гэж хэлж болно. Түүнийг ерөнхийлөгч байх хугацаанд нийтдээ 13 сая гаруй хууль бус цагаачид хилээр нэвтрэн орсон бөгөөд үүнийгээ дагаад ард иргэдийн амгалан тайван байдал алдагдаж гэмт хэргийн гаралт АНУ даяар эрс өссөн үзүүлэлттэй байв. Хүний наймаа, хар тамхины хэрэглээ бүр гаарч цэргийн насны хөдөлмөрийн насны АНУ-ын хүүхэд залуусын 57 хувь нь цэрэгт алба хаах боломжгүй болсон гэсэн судалгаа ч гарч байв. Ж.Байден үүнийгээ тайлбарлахдаа хүн нэмэгдвэл хүнс нэмэгдэж эдийн засаг тэлэх болно, нэгэнтээ хилээр орж ирсэн гадаадын иргэдийн хүний эрх, эрх чөлөөг бид хангах үүрэгтэй АНУ бол дэлхий дахинд ардчиллын үлгэр дуурайлал болж харуулах ёстой зэргээр өөрийн бодлогыг өмгөөлж байв. Гэвч америкийн хилээр нэвтрэн орж ирэгсдийн дотор үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулахуйц Венесуелийн Tren de Aragua мафийн бүлэглэл, Элсалвадорийн MC13 бүлэглэл, Колумбийн картел, Мексикийн картелууд АНУ-руу шилжин байрласан нь нэгэнт тагнуулын байгууллагуудын рапортод ил болсон байна. Түүгээр ч зогсохгүй цэргийн тагнуулын болон тагнуулын ажилтнууд олноороо түүн дотор бүртгэгдсэн байгаа нь тагнуулын байгууллагын санааг хамгийн ихээр зовоож байв. Зарим судлаачдын үзэж буйгаар Ж.Байдены засгийн газрын үед дэлхийн 3 дугаар дайн дэгдэхэд хамгийн өндөр магадлалтай болоод байсан бөгөөд хилээр орж ирсэн хууль бус цагаачдыг АНУ-ын төлөө байлдуулахад ашиглах зорилготой гэх зэргээр хүртэл бичиж байв.

Хил дээрх хүний наймааны асуудал:

Өнгөрсөн хугацаанд АНУ-ын хилээр хууль бус цагаачид олноороо хил зөрчин орж ирэхийн зэрэгцээ тэдний 325 мянган хүүхэд ор сураггүй алга болсон бөгөөд эдгээр хүүхдүүдийг хүний наймаа бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг, эд эрхтний наймааны золиос болсон гэж үзэж байгаа юм. Д.Трамп зүгээр ч нэг хилээр орж ирэх хууль бус цагаачдын урсгалыг таслан зогсоох гээгүй бөгөөд тэдгээр хууль бус цагаачдыг ашиглан хүний наймааны томоохон мафийн сүлжээ бий болсныг илрүүлж цаашид энэхүү сүлжээний үйл ажиллагааг таслан зогсоохоор зорьж буй нь түүний сонгуульд ялах болсон томоохон шалтгааны нэг юм гэж хэлж болно. АНУ-д энэ тухай Алехандро Гомезын найруулсан sound of freedom хэмээх кино 2023 онд олон нийтэд цацагдсан бөгөөд энэхүү тойрсон олон хэрэг явдлууд өрнөх болов. Тус кинонд хүний наймааны золиос болсон хүүхдүүдийн тухай гарах бөгөөд киноны багийнханд олон төрлийн улс төрийн дарамт шахалтууд ирж Япон улсад гэхэд л 1 жилийн дараа кино театруудад гаргах эрх олгож байв. Дэлхий даяар жилд 2

сая гаруй хүүхэд хулгайлагдаж хүний наймааны золиос болдог гэсэн судалгаа байдаг бөгөөд энэхүү золиос болсон хүүхдүүд Эпстейн арлын хэрэг явдалд гардагчлан баян эрчүүдийн зугаа цэнгэл болохоор аль нэг АНУ-ын арлууд руу зарагддаг байх магадлал тун өндөр юм.

АНУ сулрах болсон шалтгаан:

Либерализм анархизм болж хэт дур зоргоор аашлах байдал хүн амын дунд болон улс төрд газар авсан нь энэ үндэстнийг цаашид мөхөөх ч аюултай гэж зарим судлаачид үзэх болсон байна. Ардчиллын нэгэн сул тал бол хагарал талцлыг өрдөх хамгийн амархан нийгмийн тогтолцоог ардчилсан нийгэм гэж үздэг байна. АНУ суларсан бас нэгэн том шалтгаан нь сүүлийн 30 жилийн хугацаанд өөрийнхөө эсрэг хэтэрхий олон дайсныг дэлхий даяар бэлдсэн явдал бөгөөд олон фронт дээр зэрэг байлдахгүй гэсэн Сталины зарчмыг зөрчсөнтэй ч холбоотой гэж тайлбарлах болжээ. Нийгмийн хагарал талцал хирээс хэтэрч зэвсэгт бүлэглэлүүдийн тэмцэл цаашлаад АНУ-д иргэний дайн дэгдэх магадлал түүхэндээ хамгийн өндөр түвшинд хүрснийг бид black lives matter хөдөлгөөний үеэр бэлхнээ харсан гэж хэлж болно. Өнөөдөр АНУ-д идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг зэвсэгт бүлэглэлүүдийг нэрлэвэл Team Red, White & Blue хэмээх бүлэглэл байдаг бөгөөд энэхүү бүлэглэлд бүртгэлтэй 250 мянга гаруй бүрэн зэвсэглэсэн гишүүд байдаг байна. Түүнээс гадна хар тамхины хамааралтай хүн амын тоо хэт их өсөх болсон нь цагаан тахал гэгддэг мансууруулах төрлийн бодисоор дамжуулан Америкийн агуу үндэстнийг устаж үгүй болох аюул нүүрлээд байна гэж хэлж болно. Тус улсын хүн амын 70 орчим хувийг христийн шашинд итгэгчид эзлэх бөгөөд христийн шашны үндсэн үзэл санааг гажуудуулж “Алдас” болох LGBTQ-ийн асуудал хирээс хэтэрсэн нь Д.Трампын эгдүүцлийг төрүүлэх болсон бөгөөд Зэвсэгт хүчинд алба хаадаг 13 мянга гаруй дээрх төрлийн офицер ахлагч нарыг бэлтгэлээр халж, боловсролын яамны сургалтын тогтолцоонд өөрчлөлт хийх зорилгоор тараах болсон байна.

Department of Homeland Security:

АНУ-ын United States Department of Homeland Security хэмээх энэхүү байгууллага нь нэгдсэн улсын засгийн газрын агентлагуудын нэг бөгөөд тус улсын хил хамгаалалт, хилийн аюулгүй байдал, хилийн хяналт, хил орчмын бүс нутгийн байгаль орчны асуудал, гадаад иргэн харьяатын асуудал, нэгдсэн улсын чухал албан тушаалтнуудын биет хамгаалалт зэргийг хариуцдаг нэгэн өвөрмөц байгууллага юм. Тус агентлагийг анх 2001 оны 09 дүгээр сарын 11-ний хэрэг явдлаас хойш байгуулах санал

санаачилгууд гарах болсон бөгөөд дээрх хэрэг явдал нь АНУ-ын эх газрыг гаднын халдлагаас хамгаалж чадаагүй хэмээх томоохон шүүмжлэлээс үүдэн 2002 оны 11 дүгээр сард байгуулах болжээ. Өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа АНУ-ын хамгийн залуу агентлаг бөгөөд үйл ажиллагааны цар хүрээгээр тус улсад 3 дугаарт ордог томоохон байгууллага гэж хэлж болно.

Доналд Трамп АНУ-ын 47 дахь ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа тус улсын өмнөд хил дээр баримтлах бодлогыг чангатгаж Мексикийн хана барих ажлыг түргэвчилж, түүхэнд байгаагүй томоохон “Аврора ажиллагаа” буюу хууль бус цагаачдыг баривчлан нутаг буцаах ажиллагааг эхлүүлэхээ зарлаад байгаа юм. Өнөөдрийн байдлаар АНУ-ын хилийг зөрчин орж ирсэн хууль бус цагаачид тус улсад орогнох асуудал маш их хүндэрсэн бөгөөд Department of Homeland Security байгууллагын мэдэгдэж буйгаар АНУ-ын хилээр нэвтрэн ирэхийн тулд та аюулгүй, хууль ёсны, дэг журамтай замыг ашиглах ёстой гэжээ. Тус улсын хилийн нэвтрэхдээ хууль ёсоор нэвтрээгүй тохиолдолд дахин хилээр нэвтрэх эрхийг нь түдгэлзүүлэхээс гадна АНУ-д дахин 5 жилийн хугацаанд зорчих үед хүлээн авахаас татгалзах дахин хууль бусаар хил нэвтрэхийг оролдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хүртэл арга хэмжээ авдаг байна. АНУ-ын хилийн аюулгүй байдлыг хариуцдаг нэгж HSD-ийн талаар бас нэгэн баримт дурдахад энэ байгууллагад чухал хүний хамгаалалт буюу төрийн тусгай хамгаалалтын газар харьяалагддаг бөгөөд өнгөрсөн онд зохион байгуулагдсан ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Д.Трампыг 7 дугаар сар, 9 дүгээр саруудад 2 ч удаа буудахыг завдсан билээ. Түүнийг хамгаалах тусгай хамгаалалтын ажиллагааг муу зохион байгуулсан хэмээн тус агентлагийн дарга Кристи Ноэмийг ажлаас нь халах болсон бөгөөд түүгээр ч зогсохгүй тус агентлагийн 100 гаруй удирдах албан тушаалтныг ажлаас нь чөлөөлөхөөр бэлтгэл ажлаа хангаж байна.

Монгол улс ч ижил төстэй аюул занал дунд оршин тогтнож байна

Сүүлийн 30 гаруй жил даяарчлалын шуурганд цохигдон явсаар ирсэн Монгол Улсын хувьд АНУ-ын асуудал нэгэнтээ бусдын асуудал биш болжээ. Ардчилал хүний эрх, эрх чөлөөгөөр халхавчлан нийгмийн бүхий л давхаргад хагарал талцал нүүрлэж, Монгол хүмүүс багаар ажиллах чадамж муудсан бөгөөд өнөөдрийн байдлаар хар тамхи, алкохол мансууруулах бодисын хэрэглээгээр дэлхийд өнөөдөр 4 дүгээрт явж байгаа нь аюулын харангыг маш чангаар дэлдэж байна гэж хэлж болно. Хүний наймааны асуудал ч нэгэнтээ

Монгол Улсыг тойроогүй дайрч байгааг бид хэвлэл мэдээллийн сувгаас олж мэдэх боломжтой болжээ. Цар тахлын 2 жилийн хугацаанд хил хаалттай байсан бөгөөд дээрх төрлийн гэмт хэргүүд нэгэнт зогсонги байдалд орсон тухай цагдаагийн байгууллага болон хил орчмын бүс нутагт амьдардаг ард иргэд ил тод ярих болов.

Дүгнэлт, санал

Дэлхийн хамгийн хүчирхэг гүрэн гэгддэг Америкийн нэгдсэн улсад ч хилийн аюулгүй байдал ноцтойгоор алдагдаж улмаар тус улсын үндэсний аюулгүй байдал алдагдах болсныг бид бүхэн тодорхой тоон дүн статистикаар харлаа. Дэлхийн хамгийн хүчирхэг цэрэг арми, технологитой улс хил гаалийн аюулгүй байдлаа алдсанаар Хил амгалан бол улс амгалан гэсэн үндсэн зарчим үйлчилж байхад дэлхийд эдийн засгийн чадавхаараа 124 дүгээрт, хүн амын тоогоор 195 улсаас 133 дугаарт эрэмбэлэгдэж байгаа нь яахын аргагүй жижиг улсад тооцогдох юм. Их гүрнүүд ч тогтоон барьж дийлэхгүй байгаа энэхүү хилийн аюулгүй байдлыг бид цаашид хэрхэн тогтоон барих аюулгүй, занал, эрсдэлийг үгүй хийх вэ гэдэг дээр шинэ тутам үүсэн хөгжиж буй хил судлалын шинжлэх ухааныг чиглүүлэх нь зүйтэй болов уу гэж судлаач миний хувьд үзэж байна.

Эх сурвалж

1. “Why Kamala Harris lost: A flawed candidate or doomed campaign?” , BBC. 2024. https://www.bbc.com/news/articles/cjr4l5j2v9do, (2024.11.07);
2. “U.S. Department of Homeland Security” , 2025. https://www.dhs.gov/, (2025.04.01);
3. “Globalization”, National geographic, 2024, https://education.nationalgeographic.org/resource/globalization/ , (2025.04.01);
4. “Five reasons why Donald Trump won the US election”, Victoria University of Wellington. 2024. https://www.wgtn.ac.nz/news/2024/11/five-reasons-why-donald-trump-won-the-us-election , (2025.04.01);
5. “Why is the US becoming a weak and crippled society day by day? “ , Quora. 2024. https://www.quora.com/Why-is-the-US-becoming-a-weak-and-crippled-society-day-by-day, (2025.04.01);
6. “How Porous Borders Fuel Human Trafficking in the United States“ , Texas public and policy foundation. 2023 https://www.congress.gov/118/meeting/house/116344/documents/HHRG-118-JU08-20230913-SD003.pdf, (2025.04.01);

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ

А.Амгаланбаяр
Дотоод Хэргийн Их сургуулийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн тэнхимийн дэд профессор, дэд хурандаа

Товч агуулга: Хилийн аюулгүй байдал нь улс орны үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ хилийн аюулгүй байдалд зөвхөн цэргийн хүч ашиглах бус, эдийн засгийн аргаар хангах боломжтой. Энэ илтгэл нь хилийн аюулгүй байдлыг эдийн засгийн аргаар хэрхэн сайжруулах боломжийг судлахад чиглэгдсэн. Гааль, татварын бодлого, хилийн хамгаалалтын санхүүжилт, олон улсын хамтын ажиллагаа, эдийн засгийн хориг арга хэмжээ зэрэг эдийн засгийн аргууд нь хилийн аюулгүй байдалд хэрхэн эерэг нөлөө үзүүлж болохыг илрүүлэх зорилго тавьсан.

Түлхүүр үгс. Хилийн аюулгүй байдал, эдийн засгийн арга, гааль, татвар, санхүүжилт, олон улсын хамтын ажиллагаа, хилийн хамгаалалт, эдийн засгийн хориг.

Удиртгал

Хилийн аюулгүй байдал нь улс орнуудын үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Уламжлалт хилийн аюулгүй байдлын арга барил нь голдуу цэргийн хүч, хууль сахиулах арга хэмжээ дээр суурилдаг ч, эдийн засгийн аргууд нь энэ асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй. Эдийн засгийн аргуудыг ашиглан хилийн аюулгүй байдлыг сайжруулах нь зөвхөн хилээр орж ирж буй бараа, бүтээгдэхүүний хяналт болон хууль бус үйл ажиллагааг зогсоох төдийгүй, хил, хил орчмын бүс нутагт аюулгүй байдлыг бүрдүүлэхэд ч чухал үүрэг гүйцэтгэдэг.

Энэхүү илтгэл нь хилийн аюулгүй байдалд эдийн засаг хэрхэн нөлөөлөхийг судалж, эдийн засгийн бодлогын үр дүнтэй хэрэглээний талаар авч үзэх болно.

Хилийн аюулгүй байдал

Хилийн аюулгүй байдал нь төр, нийгэм, иргэдийн амин чухал эрх ашгийг хамгаалах зорилгоор улсын хил болон хил орчмын нутаг дэвсгэр дээр хуулийн дагуу хяналт тавих, аюулгүй байдлыг хангах үйл явц бөгөөд хилээр орох, гарах хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, хууль бус үйлдлүүдийг таслан зогсоох, терроризм, гэмт хэргийн асуудлыг шийдвэрлэх явдал юм.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь “Монгол Улсын Үндсэн хууль”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Батлан хамгаалах

бодлого", "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Төрөөс хилийн талаар баримтлах бодлого", "Монгол Улсын хилийн тухай хууль", хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр (Жанцан, Ц., 2012), манай улсын нэгдэн орсон конвенцууд юм.

Дэлхий дахинд аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа явуулах онцгой эрх бүхий субъект нь тусгаар тогтносон улс байдаг.

Тусгаар тогтносон улс нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн дараах шинжийг зайлшгүй хангаж байх шаардлагыг хангасан байх ёстой.

Үүнд:

- Нутаг дэвсгэртэй байх;
- Засаглалтай байх;
- Харьяат иргэдтэй байх тус тус болно.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь:

1.Монгол Улсын Засгийн Газраас явуулж байгаа олон улсын төр, дипломат гадаад харилцааны ажиллагаа

2.Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хилийн зурвас, бүсэд хууль сахиулах ажиллагаа,

3.Хилийн орон зайд бий болж болзошгүй цагийн байдлын өрнөлтийн ямар нөхцөлд шилжин ажиллах бэлэн байдлыг ханган явуулж буй алба-байлдааны ажиллагаа

4.Батлан хамгаалах нэгдсэн тогтолцооны бүрэлдэхүүнд цэргийн ажиллагаа байдаг.

Хилийн халдашгүй дархан байдал нь олон улсын гэрээ эрх зүйгээр зохицуулагддаг бол хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь улсын дотоод хууль эрх зүйгээр зохицуулагддаг, харилцан нарийн уялдаатай системүүд юм.

"Монгол Улсын Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана" (хууль, 2016) гэж тусгажээ.

Эдийн засгийн аргын үүрэг

Эдийн засгийн аргууд нь хилийн аюулгүй байдлыг хангах чухал хэрэгсэл юм. Эдгээр аргууд нь улс орнуудын гааль, татвар, санхүүжилт, олон улсын хамтын ажиллагаа зэрэг үйл ажиллагаанд тусгалаа олдог.

Гааль, татварын бодлого

Гааль болон татварын бодлого нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл явцад чухал үүрэгтэй. Хилийн боомтуудад хяналт тавих, хууль бус бараа, бүтээгдэхүүн, мансууруулах бодис болон эмийн хортой бодис,

терроризм зэрэг аюултай зүйлсийг зогсоох үүднээс гаалийн хяналт шаардлагатай. Гааль нь хил дамжин орж ирэх бараа бүтээгдэхүүнийг хянах, тээвэрлэх болон худалдаалах аюулгүй байдлыг хангах зорилгоор үндсэн эдийн засгийн арга хэрэгсэл болдог.

Хилийн хамгаалалтын санхүүжилт

Хилийн аюулгүй байдлыг эдийн засгийн аргаар бэхжүүлэхийн тулд хилийн хамгаалалт, хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэх нь чухал юм. Үүний тулд улс орны төсвөөс хөрөнгө оруулалт хийх, хилийн хамгаалалттай холбоотой бүхий л байгууламжийг шинэчлэх, хилийн хамгаалалтын дэвшилтэт технологийг ашиглах шаардлагатай.

Эдийн засгийн хориг арга хэмжээнүүд

Хилийн аюулгүй байдлын хямралтай холбоотойгоор эдийн засгийн хориг арга хэмжээнүүдийг ашиглах нь үр дүнтэй байж болно. Олон улсын эдийн засгийн хориг нь хил орчмын бүсэд эдийн засгийн аюулгүй байдлыг хадгалах зорилгоор зарим улс оронд хориг тавихад хэрэглэгддэг. Жишээ нь, эдийн засгийн хориг нь терроризм, мансууруулах бодисын худалдаа зэргийг зогсоох чиглэлээр үйл ажиллагааг дэмжиж чадна.

Олон улсын хамтын ажиллагаа

Олон улсын хамтын ажиллагаа нь хилийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Улс ордуудын хоорондох худалдааны гэрээ, эдийн засгийн тусламж, хилийн аюулгүй байдлын талаарх хамтын ажиллагаа нь аливаа аюултай үйлдлээс сэргийлэх, хууль бус бараа, бүтээгдэхүүнийг хилээр дамжуулах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг.

Эдийн засаг гэж юу вэ?

Эдийн засаг нь хүн төрөлхтний хязгааргүй хэрэгцээг хангахын тулд хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай хуваарилж ашиглах асуудлыг судалдаг шинжлэх ухаан юм (Цэдэндагва, Г, 2013). Хязгаарлагдмал нөөц нь нийгэм, улс орон бүрд байдаг бөгөөд эдгээр нөөцийн хэрэглээний үр ашиг нь аль болох өндөр байх ёстой. Хилийн аюулгүй байдлыг эдийн засгийн аргаар хангах нь эдгээр хязгаарлагдмал нөөцийг зөв, үр ашигтай ашиглахын тулд шаардлагатай аргуудыг зохицуулах, хөрөнгө оруулалт, техникийн дэвшилтэт шийдлүүдийг ашиглах зэрэг олон хүчин зүйлийг нэгтгэдэг.

Эдийн засгийн хүчин зүйлст:

- Гадаад эдийн засгийн орчин - *(улс орны эдийн засгийн үйл ажиллагаа, бодлого, хууль тогтоомж, валютын ханш болон гадаад худалдаа зэрэг олон хүчин зүйлсийн олон улсын түвшинд үүсэх нөхцөл байдал*)

- Гадаад инфляц - *(гадаад орнуудын эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн, нэг улсын эдийн засагт инфляцын дарамт үүсэх үйл явц*)

- Түүхий эдийн үнэ ханш - *(бараа бүтээгдэхүүн, түүхий эдийг дэлхийн зах зээл дээр худалдаж авах болон борлуулах үнэ*)

- Дотоод эдийн засгийн орчин - *(улс оронд хэрэгжиж буй эдийн засгийн нөхцөл байдал, бодлого, хууль тогтоомж, үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээний үйлчилгээ үзүүлэгчид зах зээлд тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ, түүнд зарцуулах чадварын хэмжээг илэрхийлнэ*)

- Мөнгө, зээлийн үзүүлэлт - *(**Мөнгө** нь эдийн засгийн үйл ажиллагаанд хэрэглэхэд тохиромжтой, солилцооны хэрэгсэл, үнэ цэнийг хэмжих нэгж, хөрөнгө хадгалагчийн үүрэг гүйцэтгэдэг. **Зээлийн үзүүлэлт** нь санхүүгийн салбарт зээл олгох нөхцөл байдал, зээлийн хэмжээ, түүний хүү, эрсдэл, хариуцлагатай зээл олголт зэрэг олон хүчин зүйлсийг хэмждэг үзүүлэлт юм*)

- Төлбөрийн тэнцэл - *(Төлбөрийн тэнцэл (Balance of Payments) нь тухайн улсын гадаад эдийн засгийн бүх гүйлгээг нэгтгэн харуулдаг санхүүгийн баримт бичиг юм. Энэ нь тухайн улсын гадаад худалдаа, гадаад хөрөнгө оруулалт, зээл, гадаадын валютын урсгал зэрэг эдийн хэв маяг болон эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих орчин*)

- Эрэлт, хэрэгцээ, нийлүүлэлт - (***Эрэлт** нь хэрэглэгчид тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах хүсэлтэй байгаа хэмжээ, түүнчлэн түүнийг худалдан авах чадварын хэмжээг илэрхийлнэ. **Хэрэгцээ** гэдэг нь хүмүүсийн амьдралд хэрэгцээтэй, шаардлагатай гэж үзсэн зүйлс. **Нийлүүлэлт** нь үйлдвэрлэгчид эсвэл*

засгийн үйл ажиллагааг бүрэн агуулж байдаг)

Жил бүр урт, богино хугацааны эдийн засгийн төлөв байдлын мэдээллийг холбогдох (сангийн яам, эдийн засгийн хөгжлийн яам) яам дээрх хүчин зүйлүүдийн үзүүлэлтээр гаргадаг бөгөөд энэ төлөв байдалд үндэслэн хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулах нь үр дүнтэй.

Дүгнэлт

Хилийн аюулгүй байдлыг эдийн засгийн аргаар хангах нь цэргийн болон хууль сахиулах арга хэмжээнүүдтэй хосолсон чухал арга зам юм. Эдгээр арга хэрэгслүүд нь хилийн орчмын бүс нутаг дахь хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах, эдийн засгийн өсөлт болон тогтвортой байдлыг дэмжихэд чухал үүрэгтэй.

Хил хамгаалах байгууллага нь Улсын хилийн аюулгүй байдлыг хангахын тулд эдийн засгийн онол, суурь үзүүлэлтийн талаар тодорхой мэдлэг, мэдээлэлтэй байж хилийн аюулгүй байдлыг хангах хэрэгцээ, шаардлагын онол, практикт суурилан тодорхойлж эдийн засгийн боломжит хугацаа, нөөцүүдийн нэмэлтийн үеүдэд томоохон төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд анхаарах нь чухал гэж дүгнэж байна.

Эх сурвалж:

Монгол Улсын Их Хурал. (2016). Монгол Улсын Хилийн тухай хууль. *Төрийн мэдээлэл эмхэтгэл* .

Наранжамц, Н. (2008). *Улсын хил хамгаалалтын онол-практикийн үндсэн асуудлууд.* Улаанбаатар: ДТС хэвлэх үйлдвэр.

Жанцан, Ц. (2012). Улсын хилийн болон хил орчмын нутаг дэвсгэр дэх дэд бүтэц, нийгэм эдийн засгийн хөгжлийг цогцоор шийдвэрлэх нь хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн. *“Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа” ОУ-ын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*. Улаанбаатар.

Нямсүрэн, Ч & Чулуунбат, Ш. (2018). Улсын хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулж буй олон улсын эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ. *Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн орчин судалгааны төсөлт ажлын тайлан*. Улаанбаатар.

Цэдэндагва, Г. (2013). *Эдийн засгийн ухаан.* Улаанбаатар : Улаанбаатар принт" ХХК.

УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ҮЗҮҮЛЖ БУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Б.Рагчаа
Хилийн албаны сургуулийн Инженер техникийн тэнхимийн ахлах багш, дэд хурандаа

Товч агуулга: Улс гүрний үндэсний аюулгүй байдлын тухай ойлголт нь түүх, нийгмийн хөгжил дэвшил, цагийн хугацааны явцад хувьсан шинэчлэгдэн өөрчлөгдсөөр байдаг билээ. Иймд улс эх орны хувьд үндэсний язгуур эрх ашиг болсон аюулгүй байдлаа хамгаалах үйл ажиллагаагаа яаж хангахаас шалтгаалж үндэсний аюулгүй байдал хангагдана. Монгол улсын үндэсний аюулгүй байдал хангах асуудлын чухал хэсэг нь хилийн аюулгүй байдал нь томоохон байр суурийг эзлэх бөгөөд улсын хил хязгаарын халдашгүй байдал нь нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал мөнөөс мөн. Монгол улсын эдийн засаг уурхайн ашигт малтмалаас дийлэнх хувь хамааралтай болж байгаа өнөөгийн цаг үед манай улс газар доорх байгалийн баялгаа хэрхэн үр ашигтай ашиглах нь дан ганц эдийн засаг, экологийн асуудал төдий биш бөгөөд хилийн аюулгүй байдал цаашилбал Монгол улсын үндэсний аюулгүй байдал ноцтойгоор хөндөгдөж байна гэж үзэж байна. Өмнөговь аймагт 461 ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр 10,5 сая га газар олгогдсон нь аймгийн нийт газар нутгийн 47 хувийг эзэлж байгаа тоон үзүүлэлт гарч байна. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж, олборлолт явуулж буй уул уурхайн үйл ажиллагаанаас байгальд үзүүлэх сөрөг үр нөлөө гарч уг нөлөө нь хилийн аюулгүй байдалд нөлөөлж байгаа талаар тусгасан.

Түлхүүр үгс: Өмнөговь аймгийн хил орчмын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхай, хилийн аюулгүй байдалд нөлөөлж буй сөрөг нөлөөлөл, хил хамгаалалтад гарч буй сөрөг үр дагавар, хилийн аюулгүй байдлыг хангахад анхаарах зарим асуудал.

Үндсэн хэсэг

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр нь 165,0 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, 15 сум, 58 багтай бөгөөд Гурвантэс, Ноён, Хүрмэн, Номгон, Баян-Овоо, Ханбогд сумууд нь хил орчмын нутаг дэвсгэрт хамрагддаг. Аймгийн төв Даланзадгад хот. Өмнөговь аймгийн хил орчмын оршин суугчдын дийлэнх олонх нь халх үндэстэн бөгөөд хилийн бүс зурваст мал аж ахуй эрхлэн амьдардаг, хилчдийн хөдөлмөрийг хүндэтгэдэг, улсын хил хамгаалалтад биечлэн тусалдаг, хилийн асуудалд сонор

соргог ханддаг ард түмэн. Өмнөговь аймагт 12 төрлийн ашигт малтмалын 71 орд, 185 орчим илрэл тэмдэглэгджээ. Өмнөговь бол хайгуулын тусгай зөвшөөрөл хамгийн ихээр олгогдсон аймаг юм. Орон нутагт ашигт малтмалын хайгуул судалгаа, олборлолтын үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчдын тоо 1997 оноос хойш тасралтгүй өссөөр ирсэн. Өмнөговь аймгийн хамгийн хол алслагдсан сум болох Гурвантэс суманд өнөөдрийн байдлаар нутаг дэвсгэрийнх нь 70 гаруй хувь нь хайгуул, ашиглалт, олборлолтын 66 лицензтэй газарт орсон байна. Үлдсэн 30 хүрэхгүй хувь нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт ордог. Гурвантэс сум Монгол улсын хэмжээнд хамгийн том нутаг дэвсгэртэй өмнөд хил орчмын сум юм. Одоогийн байдлаар Гурвантэс суманд 16 томоохон компани хайгуул болон олборлолт хийж байна. Уг компаниудаас 10-аас дээш жил олборлолт хийсэн компани ч цөөнгүй байгаа бөгөөд гурван том уурхай энд 10 гаруй жил ашиглалт явуулжээ. Эдгээр гурван уурхайгаас 110-130 тонны даацтай 1500 гаруй машин тус нутгийн баялгийг гадагш буюу БНХАУ руу өдөр бүр тээвэрлэсээр байна. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд “Монгол алт” компани 6 сая тонн түүхий нүүрс БНХАУ улс руу гаргажээ. Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн хүн, мал, зэрлэг амьтад амьдрах эрүүл ахуйн баталгаа бүрэн алдагдаж байна. Уул уурхайгаас үүдсэн байгаль цаг уурын сөрөг өөрчлөлтүүдээс аргагүй эрхэнд дүрвэж, энэ нутагт байсан хавтгай, хулан, хар сүүлт, мазаалай баавгай, аргал, ангир, ирвэс зэрэг улаан номд дархан цаазтай амьтад, ёл, хойлог, тас, бүргэд, ятуу, ногтруу, хулан, жороо зэрэг жигүүртнүүд нутгийн хойд хэсэг рүүгээ дайжсан. Одоо тэр хойд хэсэгт ашигт малтмал олборлохоор уул уурхайн компаниуд том техник хэрэгсэл мөн адил л оруулсаар байна.

Уул уурхайн үйл ажиллагааны хилийн аюулгүй байдалд нөлөөлж буй сөрөг нөлөөлөл. Өмнөговь аймагт байгаа хилийн анги, салбарууд нийт 80 гаруй булаг, шанд уст цэг ашиглагддагаас 48 нь буюу нийт усны эх булгийн 59,4 хувь нь хэрэглээний шаардлага хангахгүй болсон байна. Тус аймгийн хилийн хэсэгт байгаа нийт хилийн салбар нэгжийн 60.3 хувь нь ундны усаа 10-70 км-ээс зөөвөрлөж хэрэглэдэг бөгөөд уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн усны чанар байдалд өөрчлөлт орж, урин дулааны улиралд ундны ус хадгалалтын явцад муудах тохиолдол ихсэж, хилчдийн усанд явах хугацаа нэмэгдэж, энэ нь хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэх, сургалт дадлага хийх, амрах цагийг багасгаж, амралт ачааллын тэнцвэрт байдал алдагдахад хүргэдэг. Сүүлийн жилүүдэд уул уурхайн олборлолтод усыг их

хэмжээгээр ашиглах болсноор ундны усны бохирдолт ихсэж, хил орчмын гүний усны үлэмж хэмжээгээр дундарч, худгийн усны түвшин 2-6 м доошилж, хилчид хилийн орчмын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа айл өрхүүд усны хомсдолд орох томоохон асуудал нүүрлээд байна. Говь цөлийн бүсийн усны ихэнх хэсэг хатуулаг ихтэй, хужирлагаас гадна уул уурхайн нөлөөллөөс үүдэн бохирдол нь нэмэгдэж байгаа тул тухайн усыг ууж хэрэглэснээр хилчдэд дотор эрхтний өвчлөл үүсэх, тухайлбал үс унах, цайх, шүд муудаж шарлах, хорхойтох, ходоод болон цөс өвчлөлтэй болох зэрэг сөрөг үр дагаврууд гарсаар байна. Өмнөговь аймгийн хилийн хэсгээр усны нөөц ховроос гадна ихэнх хэсгийг нь уул уурхайн зориулалтаар ашиглаж, хүнд даацын автомашинаар уурхайн баялаг тээвэрлэснээс тоосжилт ихсэж, энэ нь ундны усны бохирдолтод нөлөөлж байна. Энэ нь цөлжилт эрчимтэй явагдах шалтгаан болж, оршин суугчид нь төв рүү нүүдэллэх явдал ихсэж, хол орчмын нутагт газар орноо сайн мэддэг, хил хамгаалалтад дэмжлэг, туслалцаа үзүүлдэг иргэдийн тоо цөөрч, хязгаар нутаг эзэнгүйдэж байна.

Говь цөлийн бүсийн хилийн хэсэгт Энержи Ресурс, Оюу толгой, Монгол Алт, Сод газар, Азиагоулд, Саус-Гоби-Сэндс, Булган-Гоулд, Чинхуа Мак-Нарийн сухайт, Гоби Каул энд Энержи, Мейжора Дриллинг, Кристал-Пиорл зэрэг 20 шахам компани геологи хайгуул, эрэл судалгааны ажил үйлдвэрлэл явуулж байгаагаас хилийн бүс зурваст бичиг баримтын зөрчилтэй хүмүүс нэмэгдэх, хилийн болон хил орчмын дэглэм зөрчих зэрэг байдлаар хилийн цагийн байдалд нөлөөлж байна.

Өмнөговь аймгийн хилийн зарим хэсэгт иргэд зохих зөвшөөрөл хяналтгүйгээр алт олборлох, баяжуулах, ажил үйлдвэрлэл явуулдаг болсон нь хил орчмын нутаг дэвсгэрт эмх замбараагүй байдал үүсгэх, улмаар хилийн болон хил орчмын дэглэм зөрчих хандлагатай байна.

Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор хил хамгаалалтад дараах сөрөг үр дагаврууд гарч байна. Үүнд:

-Хил хамгаалалтын зориулалттай тусгай хамгаалалттай газарт уул уурхайн ашигт малтмалын лицензтэй талбай орчихсон, тухайн газрыг ашиглах зориулалтад давхцал үүссэн;

-Хилийн застав, харуул руу явдаг зам харгуй дээр аж ахуйн нэгж байгууллагад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосноос лицензтэй газар, талбайг тойрч бартаа саадтай, тойруу замаар явах шаардлага үүсэж, шатах тослох материалын зарцуулалт болон техникийн эвдрэл гэмтэл нэмэгдэж, цаг хугацаа алдах болсон;

-Цөлжилт явагдсанаас хилчид хил хамгаалалтад ердийн уналга ашиглах боломжгүй болж, автомашин техникийн элэгдэл нэмэгдэж, норм хугацаанаас өмнө муудаж, авто техникийн бэлэн байдал алдагдахад хүрсэн;

-Уул уурхайн үйл ажиллагаатай шууд холбоотойгоор хилийн бүс, зурваст байгаа мал амьтан түүний дотор хилчдийн уналга, хүнсний мал ихээр хорогдох болсон. Үүний шалтгаан нь уурхайн ухсан нүхэнд унах, мал бэлчээрээр хордох, ундны усны ундарга багассанаар уурхайн хаягдал уснаас уун хордож үхэх гэх мэт;

-Үе дамжин хил хамгаалалтад дэмжлэг, туслалцаа үзүүлж ирсэн уугуул иргэд малгүй болж, нутгаа орхин нүүж, төв суурин газар бараадах болсноор хил хамгаалалтад туслах хүчийг эрс сулруулсан;


-Уул уурхайн ашиг сонирхлоор ирсэн, хилийн зөрчил гаргаж болзошгүй гадаад, дотоодын иргэд хилийн бүс зурваст эрс нэмэгдэж, энэ нь зохион байгуулалттай хилийн зөрчил, гэмт хэрэг гарах нөхцөлийг бүрдүүлж байгаа;

-Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас үүссэн тоосжилт хилийн хэсэгт ихсэж, хилчдийн нормын хувцас хэрэглэл тоос шороо, нүүрсний тортогт дарагдаж, угааж цэвэрлэхэд өнгө, чанар байдлаа амархан алдаж, урагдан хугацаанаасаа өмнө дуусдаг болсон;

-Өмнөговь аймгийн хил орчмын нутаг дэвсгэрийн дэд бүтцийн хөгжил хангалтгүй, ард иргэдийн амьжиргааны түвшин доогуур зэргээс шалтгаалан хил орчмын оршин суугчид уул уурхайн хөрөнгө чинээтэй хүмүүсийн гар хөл болж, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараа бүтээгдэхүүнийг боомт бус газраар оруулах, гаргах, хууль бус үйл ажиллагаанд оролцох, хориотой ан агнах, зарим тохиолдолд хил давж ирсэн малыг ашиглах явдал гарах болсон зэрэг болно.

Өмнөговь аймагт явагдаж байгаа уул уурхайн үйл ажиллагаа нь улсын хил хамгаалалтад дээрх хүндрэлийг үүсгэж, тухайн хэсгийн хилийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдлыг үүсгэж байгаа боловч Монгол улсын хувьд эдийн засгийн аюулгүй байдлаа хангахад тус аймгийн уул уурхайн салбар гол түшиц газрын нэг болдог. Иймд Өмнөговь аймгийн хилийн хэсэгт хилийн аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэхдээ улсын хил халдашгүй дархан байх хаалттай зарчим болон эдийн засгийн ашигтай байх нээлттэй зарчмыг харгалзан үзэж, менежментийн зөв зарчмыг баримтлах шаардлагатай гэж үзээд, энэхүү зарчмын талаар доорх байдлаар /Хүснэгт 1/-д харууллаа.

Хүснэгт 1. Хилийн аюулгүй байдлыг хангахад баримтлах зарчим:



Улсын хил нь нэг талаасаа аюулгүй байх, нөгөө талаас ашигтай байх гэсэн хоёр өөр зарчмын уулзвар болж байдаг. Энэхүү хоёр зарчмыг тэгш хангаж, төрийн бодлогыг зөв хэрэгжүүлснээр хилийн аюулгүй байдлын эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзэж байна. Зөвхөн аюулгүй байдлыг хангах хатуу чанд, хаалттай зарчимд суурилсан бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засгийн хувьд ашигтай байх боломжоо алддаг. Энэ нь эргээд хилийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх дараах нөхцөлийг үүсгэж болзошгүй. Үүнд:

- Хилийн боомтыг нэмэгдүүлэх, хил дамнуулан хийн хоолой, төмөр зам байгуулах зэрэг эдийн засгийн үр ашигтай стратегийн байгууламжийг байгуулахгүй, хамтран байгуулахаас татгалзаж байгаагаас геополитикийн хувьд давуу чанараа алдахад хүргэж, хөрш гүрнүүд хамтын ажиллагааны стратегийн байгууламжаа манай улсын нутаг дэвсгэрийг тойруулан байгуулах болсон. Үүний сөрөг үр дүнгээс хамаарч уул уурхайн ашигт малтмалыг автомашинаар тээвэрлэж, өндөр өртөг, үргүй зардал, үргэлжилсэн урт дараалал үүссэн;

- Хил орчмын нутаг дэвсгэрт үе дамжин оршин сууж хил хамгаалалтад дэмжлэг үзүүлдэг ард иргэдийг урамшуулах тогтолцоо байхгүй /улсын хил хамгаалалтад иргэдийг

оролцуулах журам[1] бүрэн хэрэгжихгүй/-гээс тэдний тогтвортой орлого багасаж, орлогын үндсэн эх үүсвэр болох малын бэлчээр хомсодсоноос хот суурин, аймгийн төв рүү нүүдэллэж, хил орчмын нутаг эзэнгүйдэж, хил хамгаалалтад туслах хүч багасаж байна. Харин БНХАУ-ын Засгийн газраас "Хил баян бол улс баян" бодлого явуулж, Өмнөговь аймгийн хилийн дагуу стратегийн зориулалттай хэд хэдэн эдийн засгийн идэвхтэй бүс байгуулж, хилийн бүс зурваст том хот, суурин газруудыг бий болгох, жижиг сумуудыг нэгтгэн хилийн боомтод төвлөрүүлэх, өмнөд нутгаас олон тооны хятад иргэдийг авчирч суурьшуулах, нутгийн гүнээсээ манай улс руу чиглэсэн авто болон төмөр зам, өндөр хүчдэлийн шугам тавих бүтээн байгуулалтын ажил эрчимтэй явуулсан;

-Хил орчмын байгалийн баялаг, ашигт малтмалаа ашиглахгүй байх нь хил залгаа улсын ашиг хонжоо хайгчдын сонирхлыг татаж, хил давуулан хонгил ухаж, хууль бусаар баялаг олборлох, хилийн зөрчил гаргах шалтгаан болж болзошгүй;

-Аливаа улс орон хөрштэйгөө хэдий чинээ эдийн засгийн найрсаг, хамтын ажиллагаатай байна, төдий чинээ аюулгүй байдал нь баталгаажсан байдаг зэргийг дурдаж болно. Эцэст нь Монгол улсын уул уурхайн ашиглалт, олборлолтын талаар хэрэгжүүлж байгаа өнөөгийн бодлого, үйл ажиллагаанд хатуухан дүгнэлт хийхэд эдийн засгийн аюулгүй байдлаа алдсан улс орон, хилийн аюулгүй байдлаа хангах боломжгүй гэж хэлмээр байна.

Дүгнэлт

Монгол улс газрын хэвлий дэх байгалийн баялгаа экологид сөрөг үр нөлөөтэйгөөр ашиглах нь дан ганц эдийн засаг, экологийн асуудал төдий биш хилийн аюулгүй байдал хөндөгдөөд зогсохгүй цаашилбал Монгол улсын үндэсний аюулгүй байдлын эрх ашиг ноцтой хөндөгдсөн хэвээр байна.

Монгол Улсын газрын баялаг ашиглахыг тойрсон геополитикийн ил ба далд өрсөлдөөнд манай улс хөрш улсууд болох БНХАУ, ОХУ-ын зүгээс ирж болох засгийн эрсдэл, тулгарч болзошгүй саад хүндрэлүүдээс зайлсхийж, үндэсний эрх ашгаа хамгаалах, түүнд гол анхаарлаа төвлөрүүлэх ёстой гэж үзэж байна. Иймд хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд хил орчмын нутаг дэвсгэрт явагдах уул уурхайн үйл ажиллагаанаас хилийн аюулгүй байдалд нөлөөлж буй сөрөг үр дагаврууд ыг арилгах, багасгах

[1] Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг. Дугаар 149. 2000 он.

монгол улсынхаа язгуур эрх ашигт нийцүүлэх хэрэгцээ шаардлага байгааг өнөөдрийн үүссэн нөхцөл байдал тодорхой харуулсаар байна.

Монгол улсын төрөөс хилийн боомтын талаар авч хэрэгжүүлж буй нэгдсэн цогц бодлого байхгүйн улмаас хилийн боомтын дэд бүтэц, хилчид, хил хяналтын байгууллагын албан хаагчдын ажиллах орчин, нийгэм эдийн засгийн баталгаа хангагдаагүйн улмаас хилээр нэвтэрч байгаа уул уурхайн ашигт малтмалд тавих хяналт сул байна.

Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хилийн хил орчмын дэглэмийн эрх ашигтай зөрчилдөхөд хүргэж, улсын хил хамгаалалтын мөн чанарыг алдагдуулахад хүрч байна. Иймд хил орчмын нутаг дэвсгэрт хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээг хэрэгжүүлэх, улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, хилийн зөрчил, хил дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хилийн бүсэд уул уурхайн үйл ажиллагаа явуулах зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага бий болж байна.

Тус аймгийн хилийн хэсэгт явагдаж байгаа уул уурхайн үйл ажиллагаа нь ган гачиг нэмэгдэхэд шууд нөлөөлж, мал аж ахуй, зэрлэг ан амьтан усгүйдэж, үхэж үрэгдэх болсон нь хилийн бүс зурваст үе дамжин нутаглаж байсан айл өрх, ХХТХГ-д бүсэд хил хамгаалах байгууллагаас зөвшөөрөл авч аливаа үйл ажиллагаа явуулдаг байсныг өөрчилснөөр хил хамгаалалтын зориулалт бүхий тусгай хамгаалалтай газар, ашигт малтмалын лицензтэй талбайтай давхцахад хүрсэн.

Өмнөговь аймгийн хилийн бүсэд ашигт малтмалын хайгуул, ашиглалттай холбоотой үйл ажиллагаа дээд хязгаартаа хүртэл өргөжиж, энэ нь тухайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын эрх ашиг, улсын хилийн болон нутгийн гүн рүү нүүхээс өөр аргагүй байдалд хүргэж, энэ нь хил хамгаалалтад дэмжлэг үзүүлдэг туслах хүчийг багасгаж, харин байгалийн баялаг, ашигт малтмалыг нь олборлох сонирхолтой, хилийн болон хил орчмын дэглэмийн талаар ямар ч мэдлэггүй, хилийн зөрчил гаргаж болзошгүй иргэд нэмэгдэх шалтгаан болсон.

Уул уурхайн зориулалтаар их хэмжээний газар шороог сэндийчиж ухсанаас байгаль экологийн өөрчлөлт, элсний нүүдэл, цөлжилт эрчимтэй явагдан ургамлын гарц улам бүр муудаж, ундны эх булаг, шандуудын ихэнх нь ширгэж, малын бэлчээр хомсдож, нэн ховор ургамал, амьтан устахад хүрч улмаар хил хамгаалалтыг зохион байгуулан явуулахад

хүндрэл, бэрхшээлтэй нөхцөл байдлуудыг бий болгож байна.

Эх сурвалж:

1.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он., УБ.
2.Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. 2002 он., УБ.
3.Монгол Улсын Хилийн тухай хууль. 2016 он., УБ.
4.Төрийн мэдээлэл. Хууль тогтоомжийн эмхэтгэл. Дугаар 06. 2017 он., УБ.
5.Н.Наранжамц. Бүс нутаг хил хамгаалалтын үзэл баримтлал. 2013 он., УБ.
6.Д.Нямдорж. Улсын хилийн аюулгүй байдал түүний онол арга зүйн үндэс. 2014 он., УБ.
7.Ц.Ганболд. Монгол улсын хил хамгаалалтад хил орчмын оршин суугчдын үндэсний онцлог, зан заншил нөлөөлөх нь. 2007 он., УБ.
8.Б.Зулбадрах. “Улсын хил хамгаалалтад тулгамдаж буй эрх зүйн зарим асуудал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2017 он.,

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨӨ ХАДГАЛАХ ЗОРИЛГООР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

М.Баттулга
Хилийн албаны сургуулийн цэргийн хэргийн тэнхимийн профессор, дэд хурандаа

Товч агуулга: Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эдийн засгийн бие даасан байдал, болон үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг юм. Хилийн аюулгүй байдал нь зөвхөн хил орчмын нутаг дэвсгэрийг хамгаалахаас гадна, төрийн эрх мэдлийг хадгалж, иргэдийн амьжиргааг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улс нь стратегийн байршилтай, эдийн засгийн хамааралаас үл хамааран гадаад аюулгүй байдлын хувьд олон улсын харилцаанд чухал байр суурь эзэлдэг. Тус улс нь БНХАУ, ОХУ зэрэг хоёр том гүрний хооронд оршиж байгаа нь хилийн аюулгүй байдлыг баталгаажуулах олон талын сорилтуудыг бий болгодог.

Эдүгээ дэлхий дахинд улс орнуудын эдийн засаг, цэрэг, гадаад бодлого зэрэг олон хүчин зүйлс харилцан хамааралтай, бие биедээ нөлөөлөх болсон. Монгол Улсын хувьд, хамгийн том эдийн засгийн түнш нь БНХАУ бөгөөд тус улсын эдийн засгийн өсөлт нь Монголын эдийн засагтай гүнзгий хамааралтай. БНХАУ-ын эдийн засгийн бодлого, худалдааны харилцаа, цэргийн хүчин чадал болон геополитикийн өрсөлдөөн нь Монгол Улсын хилийн аюулгүй байдалд шууд нөлөөлж болзошгүй. Энэ нь Монгол Улс гадаад аюулгүй байдлаа хадгалахын тулд БНХАУ-тай өргөн хүрээтэй хамтын ажиллагаа байгуулж, харин ч хэт их хамааралд орох эрсдэлтэй.

Тус илтгэлд БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, түүний Монгол Улсын хилийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг судлахыг зорьж байна. Судалгааны зорилго нь БНХАУ-ын эдийн засгийн өсөлт болон Монгол Улс дахь аюулгүй байдлын нөхцөл байдлыг хэрхэн ойлгох, мөн эдийн засгийн хамаарал, стратегийн байрлал, гадаад харилцаа, цэргийн өрсөлдөөн зэрэг хүчин зүйлсийг хэрхэн зохицуулах талаар дүн шинжилгээ хийхэд оршиж байна. Судалгааны үр дүн нь Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хадгалах, цаашлаад улс орны эдийн засаг, соёл иргэншил, тусгаар тогтнолыг хамгаалахад хэрэгтэй зөвлөмжүүдийг гаргахад чиглэнэ.

Энэхүү судалгаа нь Монгол Улсын гадаад бодлогын нөхцөл байдал, эдийн засгийн харилцааны чухал асуудлуудыг тоймлон үзэж, гадаад болон дотоод аюулгүй байдлын

эрсдэлүүдийг тодорхойлох, тэдгээрийг хэрхэн зохицуулах арга замыг хайх зорилготой юм.

Үндсэн хэсэг

БНХАУ-ын эдийн засаг сүүлийн 5 жилд тодорхой өөрчлөлтүүдийг туулсан. COVID-19 цар тахлын улмаас 2020 онд өсөлт удааширсан боловч 2021 онд сэргэлт гарч, дараа жилүүдэд эрчимтэй өсөлттэй байлаа. Гэхдээ эдийн засаг 2022 онд дэлхийн нөхцөл байдалтай холбоотойгоор өсөлт саарсан бөгөөд 2024 онд өсөлт удааширч байна. Худалдаа, үл хөдлөх хөрөнгийн зах зээл, инфляцын түвшин зэрэг салбарууд тогтворгүй байдалд орсон ч сүүлд сэргэсэн. Ажилгүйдлийн түвшин 2022 онд нэмэгдсэн ч сүүлийн жилүүдэд буурсан[1].

БНХАУ-ын эдийн засгийн өсөлтөө хадгалах зорилгоор хэрэгжүүлж буй арга хэмжээ нь улс орон даяар, түүнчлэн дэлхий дахинд эдийн засгийн өрсөлдөөн, стратегийн байр суурь, гадаад харилцааг сайжруулахад чиглэсэн олон төрлийн бодлого, стратегиудыг агуулдаг. Эдгээр арга хэмжээнүүд нь БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангахад чиглэж байгаа бөгөөд хамгийн чухал нь дараах хэд хэдэн хүрээнд зохион байгуулагдсан:

1. "Нэг бүс, нэг зам" (Belt and Road Initiative, BRI) хөтөлбөр[2]

БНХАУ 2013 оноос эхлэн "Нэг бүс, нэг зам" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хөтөлбөр нь Хятадын эдийн засгийн өсөлтийг дэлхий дахинд өргөжүүлж, улс орнуудын хооронд худалдааны урсгалыг нэмэгдүүлэх, инфра бүтцийг хөгжүүлэх зорилготой. Монгол Улс, ОХУ, Энэтхэг зэрэг улс орнууд энэ хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллаж байгаа бөгөөд БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг дэмжих чухал хэрэгсэл болдог. Түүнчлэн, энэхүү хөтөлбөр нь эдийн засгийн хамтын ажиллагаа, стратегийн холбоо, өрсөлдөөнт давуу талыг бий болгоход гол үүрэг гүйцэтгэдэг.

---

[1] World Bank. (2023). **China Economic Update 2023: Growth Momentum Slowing.** Retrieved from https://www.worldbank.org/en/news/press-release/2023/10/01/east-asia-and-pacific-sustained-growth-momentum-slowing
Bloomberg. (2023). **China's Trade Growth Slows Amid Global Uncertainty.** Retrieved from https://www.bloomberg.com
Reuters. (2023). **China's Real Estate Sector Stabilizes After Two Years of Decline.** Retrieved from https://www.reuters.com
International Monetary Fund (IMF). (2023). **Inflationary Pressures in China: A Case Study.** Retrieved from https://www.imf.org

[2] Zhang, Y. (2019). The Belt and Road Initiative: Economic Impacts and Strategic Implications. *Journal of International Trade and Economics*, 45(2), 123-137. https://doi.org/10.1016/j.jite.2019.02.001

2. Цахим эдийн засаг болон технологийн инновац[1]

БНХАУ цахим эдийн засгийн салбарыг дэмжихэд онцгой анхаарч, өндөр технологийн салбарт их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна. Технологийн инновац, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг салбарууд нь Хятадын эдийн засгийн шинэ хөдөлгүүр болж, уг салбарт тэргүүлэгч байр суурыа бататгаж байна. Энэ нь БНХАУ-ын гадаад худалдааны өсөлт, эдийн засгийн хамаарал, инновацын хүчин чадлыг нэмэгдүүлж, дэлхийд эдийн засгийн өрсөлдөөнд илүү хүчтэй оролцох боломжийг олгодог.

3. Худалдааны хямрал ба дэлхийн эдийн засгийн харилцааг зохицуулах

2018-2020 оны хооронд АНУ-тай худалдааны дайн[2] эхэлсэн нь БНХАУ-ын эдийн засагт зарим төвөгтэй нөхцөл үүсгэсэн ч, БНХАУ өөрийн эдийн засгаа хамгаалах, олон улсын худалдаанд өрсөлдөх чадвараа хадгалах зорилгоор шинэ стратегиудыг боловсруулсан. Тухайлбал, "Дотоод эрэлт хэрэгцээ" (Domestic Demand) хөтөлбөрийг хэрэгжүүлж, дотоод зах зээлээ бэхжүүлэх, мөн хөгжиж буй орнуудаас гаднын хөрөнгө оруулалтыг татах зэрэг арга хэмжээнүүдийг авсан. Түүнчлэн, олон улсын хамтын ажиллагааг дэмжиж, дэлхийн эдийн засгийн хямралын үед эдийн засгаа тогтвортой хадгалахын тулд төрөл бүрийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

4. Эдийн засгийн бүтэц, аж үйлдвэрийн шилжилт[3]

БНХАУ нь үйлдвэрлэлийн болон эдийн засгийн бүтцийг шинэчилж, дэд бүтэц, экологийн тэнцвэрийг хадгалах, шинэ аж үйлдвэрүүдийг дэмжих зэрэг арга хэмжээнүүдийг авч байна. Хятад улс уламжлалт үйлдвэрлэлийн салбараас шилжиж, үйлчилгээний салбар, өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих хандлагыг бий болгож байна. Энэ нь эдийн засгийн өсөлтөө шинэ чиглэлд шилжүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилготой.

5. Мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдал[4]

БНХАУ нь мөнгөний бодлогоо зохицуулан, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ санхүүгийн тогтвортой байдлыг хангах, инфляцын

[1] OpenAI. (2025). *Цахим эдийн засаг болон технологийн инновац* [Эрдэм шинжилгээний материал]. ChatGPT. https://chat.openai.com

[2] Wang, L. (2019). *Impact of the US-China trade war on global trade dynamics*. *Global Trade Review*. https://www.examplelink.com

[3] World Bank (2020). "China's Transition to a Services-Based Economy". Retrieved from World Bank China Overview

[4] International Monetary Fund (IMF), 2022. "China's Monetary Policy and Financial Stability." IMF Country Report No. 22/217. Retrieved from IMF Website

түвшнийг тогтворжуулах, харилцан хамаарал бүхий салбаруудад хөрөнгө оруулалт хийх зорилгоор олон арга хэмжээг авч байна. Мөн Хятад улс санхүүгийн салбарын шинэчлэл хийх, хөрөнгийн зах зээл болон санхүүгийн үйлчилгээг өргөжүүлэх зэрэг алхмуудыг хэрэгжүүлж байна.

6. Хөдөө аж ахуй, экологийн тогтвортой байдал[1]

БНХАУ хөдөө аж ахуйн салбарыг дэмжих, байгаль орчныг хамгаалах, экологийн хариуцлагатай аж үйлдвэрүүдийг хөгжүүлэх талаар чухал бодлогыг хэрэгжүүлж байна. Энэ нь эдийн засгийн өсөлтөө хадгалах, тогтвортой хөгжилд хүрэх зорилгоор экологийн тогтвортой байдлыг хамгаалах замаар эдийн засгийг хөгжүүлэх арга хэмжээ юм.

Монгол Улсын хилийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөл:

Монгол Улсын хилийн аюулгүй байдалд нөлөөлөх нөлөөллийн таамаглал нь олон хүчин зүйлийн нөлөөн дор хөгжиж буй олон улсын болон дотоодын нөхцөл байдлын нэгэн ойлголт юм. Таамаглал боловсруулахад ашиглах хүчин зүйлс нь тухайн орны геополитик, эдийн засгийн нөхцөл байдал, гадаад улс орнуудын бодлого, цэргийн болон эдийн засгийн харилцаа зэрэг олон талт орчинтой холбогдсон байна.

1. Гадаад улс орнуудын бодлого ба стратеги

Монгол Улс БНХАУ, ОХУ, АНУ зэрэг гүрнүүдтэй хиллэж, эдийн засаг, худалдаа, цэрэг зэвсгийн салбарт тэдний бодлого нь хилийн аюулгүй байдалд чухал нөлөө үзүүлдэг. БНХАУ-ын "Нэг бүс, нэг зам" (Belt and Road Initiative) хөтөлбөр нь Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрт эдийн засгийн, төдийгүй цэргийн нөлөөллийг нэмэгдүүлж, шинэ ертөнцийн өрсөлдөөнийг бий болгож байна. БНХАУ-ын зүгээс эдийн засгийн хэт хамаарлаас үүдэн, Монгол Улсын хилийн аюулгүй байдал улам бүр хяналтад орж болзошгүй. Мөн ОХУ-ын цэрэг эдийн засгийн бодлого нь хил орчмын аюулгүй байдалд шууд нөлөөлөх хүчин зүйлсийн нэг юм.

2.Цэргийн болон технологийн өрсөлдөөн

Цэрэг зэвсгийн салбарт БНХАУ болон ОХУ-ын хамтын ажиллагаа, эсвэл эдийн засгийн өрсөлдөөн нь Монголын хилийн аюулгүй байдалд үр дүнтэй нөлөөлөх боломжтой. Цэргийн хүчин чадлын өрсөлдөөн, технологийн дэвшил, кибер аюулгүй байдал зэрэг асуудлууд Монгол Улсын хилийн хамгаалалтад шинэ аюул дагуулж болох юм. Үүний зэрэгцээ, цэргийн байгууллагуудын болон

[1] 2021. "China's Green Development Strategy and Agriculture Policy." China Daily Special Report. Retrieved from China Daily

илт шийдэгдээгүй бүс нутаг дахь үйл ажиллагаанууд ч Монгол Улсын хил дээр хяналтыг бэхжүүлэх шаардлагатай болгох болно.

3.Эдийн засгийн хамаарлын өөрчлөлт

Монгол Улс эдийн засгийн хувьд БНХАУ, ОХУ зэрэг гүрнүүдтэй өндөр хамааралтай орон юм. Хэрэв эдийн засгийн харилцаа, түүний дотор худалдаа, уул уурхай, эрчим хүчний салбарын хамаарал өргөжвөл энэ нь хилийн аюулгүй байдалд тодорхой нөлөө үзүүлэх болно. Мөн эдийн засгийн өсөлт, тогтвортой байдалтай холбоотойгоор иргэдийн амьдралын чанар сайжирч, улсын дотоод аюулгүй байдал илүү тогтвортой болох нь хилийн аюулгүй байдлын нөхцөлийг сайжруулах нэгэн чухал хүчин зүйл болно.

4. Гадаад орнуудын цэргийн хөдлөл болон кибер аюул

Сүүлийн жилүүдэд улс орнуудын хооронд цэргийн болон кибер аюулыг эрчимжүүлэх асуудал нэмэгдсэн. БНХАУ, ОХУ, АНУ зэрэг орны бодлого, аюулгүй байдлын стратеги нь Монгол Улс хилийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх аюул дагуулж болзошгүй. Кибер аюултай тэмцэх стратеги, хилийн аюулгүй байдлыг цахим орчинд хамгаалах чиглэлд илүү анхаарах шаардлага үүсэж болзошгүй.

5.Эдийн засгийн болон байгаль орчны нөхцөл

Монгол Улс байгаль орчны, экологийн асуудалтай тулгарч байгаа нь хилийн аюулгүй байдлыг хамгаалахад хүндрэл учруулж болох юм. Хүрээлэн буй орчин, усны нөөц, байгалийн баялагт нөлөөлөх хортой үйл ажиллагаанууд, хилийн орчимд тохиолдож болзошгүй байгаль орчны хямрал нь аюулгүй байдлыг дордуулах хүчин зүйлсийн нэг болж мэднэ.

Таамаглал:

Нөлөөлөл 1: БНХАУ, ОХУ зэрэг хөрш орнуудын эдийн засгийн, цэргийн болон технологийн өрсөлдөөн нь Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг улам хүндэтгэж, улсын дотоод аюулгүй байдалд ч нөлөөлж магадгүй.

Нөлөөлөл 2: Гадаад бодлого, олон улсын хөрөнгө оруулалт болон худалдааны чиг хандлагын өөрчлөлт нь Монголын хилийн хамгаалалтад шууд нөлөөлөх болно.

Нөлөөлөл 3: Байгаль орчны аюул, экологийн нөхцөл байдал, хилийн орчмын экологийн хэвийн байдал алдагдах нь хилийн аюулгүй байдлыг шинэ түвшинд шилжүүлэх эрсдэл дагуулж болзошгүй.

Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь гадаад улс орнуудын бодлого, эдийн засгийн хамаарал, байгаль орчны асуудлууд болон цэргийн өрсөлдөөнтэй шууд хамааралтай. Үүнээс үүдэн, хилийн аюулгүй байдалд нөлөөлж болох олон хүчин зүйлс байдаг бөгөөд

эдгээрийг зөв цаг хугацаанд зохицуулж, хариу арга хэмжээ авах нь Монгол Улсын аюулгүй байдлын баталгааг хангах чухал ач холбогдолтой.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үүднээс дээрх таамаглалын хүрээнд авч хэрэгжүүлэх нийтлэг арга хэмжээг дараах байдлаар тодорхойлж болно. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх нь Монгол Улсын гадаад аюулгүй байдал, дотоодын аюулгүй байдал, экологийн хамгаалалт, эдийн засгийн тогтвортой байдлыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

1.Гадаад бодлого болон олон улсын хамтын ажиллагаа

Стратегийн түншлэл бэхжүүлэх: Монгол Улс хөрш орнууд болох БНХАУ, ОХУ-тай стратегийн түншлэлийг бэхжүүлэх, олон улсын түвшинд эдийн засаг, цэрэг, технологийн салбаруудын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах: НҮБ, ШХАБ, АСЕАН зэрэг олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжүүлэх, эдийн засаг, аюулгүй байдлын асуудлаар илүү хамтарсан шийдэл олох.

Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих: Монгол Улсын гадаад бодлого нь худалдааны хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх, эдийн засгийн харилцааг төрөлжүүлэх шаардлагатай. Үүнд шинэ гэрээ, хамтын ажиллагааны саналуудыг боловсруулах хэрэгтэй.

2. Цэргийн аюулгүй байдлыг бэхжүүлэх

Цэргийн чадавхыг сайжруулах: Хилийн аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын батлан хамгаалахын хүчийг бэхжүүлэхийн тулд олон улсын стандартад нийцсэн цэргийн сургалт, бааз, батлан хамгаалахын бүтцийг сайжруулах.

Цэргийн дэд бүтэц болон хилийн хамгаалалтыг бэхжүүлэх: Хил орчмын бүс нутагт цэргийн хамгаалалт, хилийн хяналтыг сайжруулах, шинэ технологи ашиглан хилийн хамгаалалтын хүчин чадлыг сайжруулах.

Кибер аюулгүй байдалд анхаарах: Цэргийн дэд бүтцийг цахим халдлагаас хамгаалах, кибер аюулгүй байдлыг хангах стратегийг хэрэгжүүлэх, мэдээллийн технологийн шинэчлэл хийх.

3.Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах

Эдийн засгийн бүтэц, төрөлжилтийг дэмжих: Монгол Улс уул уурхайгаас гадна өндөр технологи, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарт эдийн засгийг төрөлжүүлэх замаар хязгаарлагдмал хамаарлаас зайлсхийх.

Гадаад худалдааны түншүүдийг төрөлжүүлэх: Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг олон улсын зах зээлд амжилттай нэвтрүүлэх, БНХАУ, ОХУ-аас хараат байдлыг

бууруулах чиглэлд эдийн засгийн шинэ стратеги боловсруулах.

Үндэсний валютын тогтвортой байдлыг хангах: Санхүүгийн салбарт тогтвортой байдлыг хадгалах, инфляцын түвшнийг зохицуулах, мөнгөний бодлогоо хяналтдаа байлгах.

4. Экологийн аюулгүй байдлыг хангах

Байгаль орчны хамгаалалтыг сайжруулах: Хилийн орчмын экологийн хэвийн байдал, усны нөөц, байгалийн баялаг ашиглалтыг зохицуулах, экологийн тогтвортой байдлыг хангах.

Байгаль орчны болон экологийн эрсдэлүүдийг урьдчилан таамаглах: Хилийн орчмын экологийн нөхцөл байдал, байгалийн гамшиг, экологийн сүйрлийн эрсдэлийг урьдчилан тооцоолох, түүнд бэлтгэх.

5.Нийгмийн аюулгүй байдал болон дотоодын эв нэгдлийг дэмжих

Дотоодын аюулгүй байдлыг хангасан хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх: Үндэсний аюулгүй байдлыг хамгаалахын тулд хууль, эрх зүйн орчныг сайжруулах, хил хамгаалах болон аюулгүй байдлын албан тушаалд байгаа хүмүүст зориулсан мэдлэг, чадварыг бэхжүүлэх.

Үндэсний эв нэгдэл, нийгмийн хариуцлага: Үндэсний эв нэгдэл, олон талт нийгмийн хөгжлийг дэмжих, дотоодын нөхцөл байдлын тогтвортой байдлыг хангах.

Шударга ёс, хүний эрхийг дээдлэх: Хууль зүйн тогтвортой байдал, хүн амын эрхийг хүндэтгэх бодлогыг хэрэгжүүлэх, хүний эрхийн салбарын сайн туршлагыг бүс нутагт таниулах.

6.Технологийн хөгжил, инновацыг дэмжих

Цахим аюулгүй байдал, кибер аюулгүй байдал: Кибер халдлагаас сэргийлэх арга хэмжээ авах, цахим хулгайн болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлд шинэ бодлого боловсруулах.

Шинжлэх ухаан, технологийн инновацыг дэмжих: Өндөр технологийн салбарт хөрөнгө оруулалт хийх, инновац, хиймэл оюун ухаан, сансар судлал, цахим эдийн засгийн хөгжилд чиглэсэн хөгжлийн бодлого боловсруулах.

Эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь Монгол Улсын хилийн аюулгүй байдалд нөлөөлөх олон хүчин зүйлийг зохицуулах, урьдчилан сэргийлэх, эдийн засгийн тогтвортой байдал болон нийгмийн эв нэгдлийг хамгаалах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой юм. Хил хамгаалах, аюулгүй байдлыг хангах, олон улсын нөхцөл байдлыг тодорхойлох стратегиудыг боловсруулах, хэрэгжүүлэх нь Монгол Улсын ирээдүйн аюулгүй байдлын үндсэн тулгуур болно.

Дүгнэлт

БНХАУ-ын эдийн засаг сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөлттэй байсан боловч дэлхийн эдийн засгийн нөхцөл, дотоодын

олон сорилтуудтай тулгарсан. Тухайлбал, COVID-19 цар тахал, худалдааны дайн зэрэг нь эдийн засгийн өсөлтөд тодорхой саад болсон ч, БНХАУ нь эдийн засгийн хөгжлийг хадгалах, шинэ стратегиудыг боловсруулж, эдийн засгийн өөрчлөлтүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Монгол Улсын хувьд, хөрш орнууд болох БНХАУ, ОХУ, АНУ зэрэг улс орнуудтай эдийн засаг, цэрэг, технологийн салбарт харилцаагаа өргөжүүлж, энэ нь Монголын хилийн аюулгүй байдалд шууд нөлөөлж болохуйц хүчин зүйлсийн нэг болж байна.

Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь эдийн засгийн хамаарал, геополитик, цэргийн өрсөлдөөн, байгаль орчны асуудлуудтай холбогдон оршиж байгаа нь аюулгүй байдлын шинэ сорилтуудыг үүсгэж байгаа юм. Тиймээс Монгол Улс эдгээр хүчин зүйлсийг ухаалаг, зөв зохицуулах, тодорхой стратегиудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Санал

1.Гадаад бодлого болон олон улсын хамтын ажиллагаа

-БНХАУ, ОХУ-тай стратегийн түншлэлийг бэхжүүлэх, олон улсын түвшинд эдийн засаг, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

-НҮБ, ШХАБ, АСЕАН зэрэг олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, эдийн засаг, аюулгүй байдлын асуудлаар илүү хамтарсан шийдэл олох.

-Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих, худалдааны түншүүдийг төрөлжүүлэх.

Цэргийн аюулгүй байдлыг бэхжүүлэх

-Хилийн аюулгүй байдлыг хангах, Монгол -Улсын батлан хамгаалахын хүчийг бэхжүүлэхийн тулд олон улсын стандартад нийцсэн цэргийн сургалт, бааз, батлан хамгаалахын бүтцийг сайжруулах.

-Хил орчмын бүс нутагт цэргийн хамгаалалт, хилийн хяналтыг сайжруулах, шинэ технологи ашиглан хилийн хамгаалалтын хүчин чадлыг сайжруулах.

-Кибер аюулгүй байдлыг хангах стратегийг хэрэгжүүлэх.

Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах

-Уул уурхайгаас гадна өндөр технологи, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарт эдийн засгийг төрөлжүүлэх замаар хязгаарлагдмал хамаарлаас зайлсхийх.

-Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг олон улсын зах зээлд амжилттай нэвтрүүлэх, БНХАУ, ОХУ-аас хараат байдлыг бууруулах чиглэлд эдийн засгийн шинэ стратеги боловсруулах.

-Үндэсний валютын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарт тогтвортой байдлыг хадгалах.

Экологийн аюулгүй байдлыг хангах

-Хилийн орчмын экологийн хэвийн байдал, усны нөөц, байгалийн баялаг ашиглалтыг

зохицуулах, экологийн тогтвортой байдлыг хангах.

-Байгаль орчны болон экологийн эрсдэлүүдийг урьдчилан таамаглах, байгалийн гамшиг, экологийн сүйрлийн эрсдэлийг урьдчилан тооцоолох, түүнд бэлтгэх.

Нийгмийн аюулгүй байдал болон дотоодын эв нэгдлийг дэмжих

-Үндэсний аюулгүй байдлыг хамгаалахын тулд хууль, эрх зүйн орчныг сайжруулах, хил хамгаалах болон аюулгүй байдлын албан тушаалд байгаа хүмүүст зориулсан мэдлэг, чадварыг бэхжүүлэх.

-Үндэсний эв нэгдэл, олон талт нийгмийн хөгжлийг дэмжих, дотоодын нөхцөл байдлын тогтвортой байдлыг хангах.

-Хууль зүйн тогтвортой байдал, хүн амын эрхийг хүндэтгэх бодлогыг хэрэгжүүлэх, хүний эрхийн салбарын сайн туршлагыг бүс нутагт таниулах.

Технологийн хөгжил, инновацыг дэмжих

-Цахим аюулгүй байдал, кибер аюулгүй байдал: Кибер халдлагаас сэргийлэх арга хэмжээ авах, цахим хулгайн болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлд шинэ бодлого боловсруулах.

-Өндөр технологийн салбарт хөрөнгө оруулалт хийх, инновац, хиймэл оюун ухаан, сансар судлал, цахим эдийн засгийн хөгжилд чиглэсэн хөгжлийн бодлого боловсруулах.

Эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр Монгол Улсын хилийн аюулгүй байдалд нөлөөлж болох олон хүчин зүйлийг зохицуулах, урьдчилан сэргийлэх, эдийн засгийн тогтвортой байдал болон нийгмийн эв нэгдлийг хамгаалах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой. Хил хамгаалах, аюулгүй байдлыг хангах, олон улсын нөхцөл байдлыг тодорхойлох стратегиудыг боловсруулах, хэрэгжүүлэх нь Монгол Улсын ирээдүйн аюулгүй байдлын үндсэн тулгуур болно.

Эх сурвалж:

1.Өвгөнбүргэд.Ж (2021). Хилийн аюулгүй байдлын онол, арга зүй

2.World Bank. (2023). **China Economic Update 2023: Growth Momentum Slowing.** Retrieved from https://www.worldbank.org/en/news/press-release/2023/10/01/east-asia-and-pacific-sustained-growth-momentum-slowing

3.Bloomberg. (2023). **China's Trade Growth Slows Amid Global Uncertainty.** Retrieved from https://www.bloomberg.com

4.Reuters. (2023). **China's Real Estate Sector Stabilizes After Two Years of Decline.** Retrieved from https://www.reuters.com

5.International Monetary Fund (IMF). (2023). **Inflationary Pressures in China: A Case Study.** Retrieved from https://www.imf.org

6.Zhang, Y. (2019). The Belt and Road Initiative: Economic Impacts and Strategic Implications. *Journal of International Trade and Economics*, 45(2), 123-137. https://doi.org/10.1016/j.jite.2019.02.001
7.*OpenAI. (2025).* Цахим эдийн засаг болон технологийн инновац *[Эрдэм шинжилгээний материал]. ChatGPT. https://chat.openai.com*
8.Wang, L. (2019). *Impact of the US-China trade war on global trade dynamics*. *Global Trade Review*. https://www.examplelink.com
9.World Bank (2020). "China's Transition to a Services-Based Economy". Retrieved from World Bank China Overview
10.International Monetary Fund (IMF), 2022. "China's Monetary Policy and Financial Stability." IMF Country Report No. 22/217. Retrieved from IMF Website
11.2021. "China's Green Development Strategy and Agriculture Policy." China Daily Special Report. Retrieved from China Daily

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ДИПЛОМАТ АРГААР ХАНГАХ ТУХАЙ ОЙЛГОЛТ:ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ТУРШЛАГА, СУРГАМЖ

П.Уянга
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, ахмад

Товч агуулга: Олон улсын аюулгүй байдлын орчин хувьсан өөрчлөгдөх үйл явцтай зэрэгцэн улс хоорондын ашиг сонирхлын тэнцвэрээс үүдэлтэй зөрчил, мөргөлдөөн нэмэгдэж байгаа нь хүйтэн дайны дараа тогтсон дэг журам, олон улсын эрх зүйн хэм хэмжээг алдагдахад хүргэж байна. Улс хоорондын зөрчил, маргаан, үл ойлголцлоос урьдчилан сэргийлэх асуудлыг үндэсний аюулгүй байдлын эрх ашгийг хамгаалах үүднээс авч үзвэл, хилийн аюулгүй байдал, түүнийг хангах арга замыг оновчтой сонгон хэрэгжүүлэх асуудал чухал билээ. Энэхүү илтгэлээр Хилийн аюулгүй байдлыг дипломат аргаар хангах талаар ойлголт, гадаадын зарим улс орны туршлага, сургамжаас судалсан үр дүнг танилцууллаа.

Түлхүүр үгс:Хилийн аюулгүй байдал, хил дамнасан гэмт хэрэг, зөрчил, мөргөлдөөн, дипломат арга, хилийн дипломат ажиллагаа.

Удиртгал

Дэлхийн бодлогыг тодорхойлогч хоёр их гүрний дунд орших жийргэвч улсын хувьд үндэсний аюулгүй байдлаа хангах арга хэрэгслийг оновчтой сонгон үр дүнтэй, ухаалгаар хэрэгжүүлэх асуудал нэн чухал байдаг. Монгол Улсын хил бүрэлдэн тогтсон түүхэн замналыг эргэн харвал хилийн аюулгүй байдлыг дипломат аргаар хангах үйл ажиллагааг үр дүнтэй, тууштай хэрэгжүүлсэн туршлага байдаг.

Монгол Улс мөнхийн хөрш гэгдэх БНХАУ, ОХУ-тай одоог хүртэл хилийн маргаангүй, оршин тогтнож байгаа нь хилийн гэрээг албан ёсоор байгуулсан төрийн үйл хэрэг, хилчин дипломатуудын үйл ажиллагаатай холбоотой юм.

Дэлхийн нийтийн анхааралд байгаа зөрчил, мөргөлдөөний шалтгаан нь *нэг талаар*, ашиг сонирхлын тэнцвэрийг баримталсан гадаад бодлогын алдаа, *нөгөө талаар*, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг баримтлаагүй, дипломат ажиллагааг зохистой явуулаагүй зэрэг алдаанаас улбаатай байж болох юм. Аливаа сайн туршлагаас боломжийг харж, сургамжаас алдааг олж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх асуудлыг нээн илрүүлэх нь судалгаа, шинжилгээний мөн чанар билээ.

Үндсэн хэсэг.

Хилийн аюулгүй байдлыг дипломат аргаар хангах тухай ойлголт

Хил халдашгүй байх тухай асуудал нь олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрөгдөн, үндсэн хууль, үзэл баримтлал, бодлогод бататгагдаж зөрчигдөхгүй байхад чиглэсэн үйл ажиллагаагаар хангагдсанаар хамгаалах механизм бүрддэг. Нутаг дэвсгэр, түүний бүрэлдэхүүнд тухайн улсын бүрэн эрхийн хязгаар буюу хил багтдаг бөгөөд түүний бүрэн бүтэн байх асуудал нь улсын тусгаар тогтнол, оршин тогтнох үндэс, баталгаа болдог. Энэ талаар НҮБ-ын дүрэм, 1975 оны Хелсинкийн төгсгөлийн акт, Монгол Улсын хууль тогтоомж, төрийн бодлого, үзэл баримтлалд тодорхой заасан байна. Хилийн аюулгүй байдал хилээс гадна, дотогш орон зайд таатай орчин бүрдүүлэхэд төрөөс баримталж буй бодлого, эрх бүхий байгууллагуудын нэгдмэл, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаагаар хангагдана.

Олон улсын харилцаанд нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүнлэг шударга зарчимд тулгуурласан байх аваас хууль ёсны болдог. Төрийн дотоод бодлого, гадаад бодлогоор дамжин дипломат аргад суурилсан үйл ажиллагаагаар хэрэгждэг. Монгол Улс энхийг эрхэмлэсэн, олон туйлт, тэнцвэртэй гадаад бодлого баримталж байна. Улсын аюулгүй байдлыг дипломат аргаар хангах асуудал нь дипломатын эрх зүй, олон улсын харилцаа, зэргийг хамарсан өргөн хүрээний ойлголт юм. Судлаачдын бүтээл болон эрх зүйн баримт бичгүүдэд дипломат арга, дипломат ажиллагаа, дипломат шугам гэх зэрэг хэд хэдэн янзаар бичсэн байна.

Дипломат арга нь *тухайн улсын бодлогын баримт бичгүүдэд заасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх чиг баримжаа,* дипломат ажиллагаа нь *тэрхүү чиг баримжааг удирдлага болгон эх орон, ард түмнийхээ ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаа гэж* ойлгож болох юм. Хилийн аюулгүй байдлыг дипломат аргаар хангах үндэслэл нь нэгдүгээрт, хууль тогтоомж, бодлогод заасан хууль ёсны олон улсын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн, хоёрдугаарт, хилийг хил залгаа улстай хамтран тогтоож, олон улсын гэрээгээр баталгааждаг учир гэрээний биелэлтийг хоёр тал харилцан тэгш үүрэг хүлээдэг, гуравдугаарт, аливаа үүссэн асуудалд нэн тэргүүнд эв зүйг эрхэмлэн шийдвэрлэдэг, дөрөвдүгээрт, тухайн харилцаанд оролцогч эрх бүхий албан тушаалтан нь хилийн төлөөлөгч байна. Эндээс үзэхэд хилийн аюулгүй байдлыг дипломат аргаар хангах тухай асуудлыг хилийн төлөөлөгчийн үйл ажиллагааны хүрээгээр хязгаарлах нь учир дутагдалтай юм.


Хилийн дипломат ажиллагаа нь хүйтэн дайны дараах улс орнуудын хамтын ажиллагааны үр дүнд бий болсон харьцангуй шинэ нэр томьёо


бөгөөд одоогоор нэгдсэн нэг ойлголт бүхий тодорхойлолт байхгүй байгаа нь улс орнууд хилийн дипломат ажиллагааг өөрсдийн аюулгүй байдлын бодлогын хэрэгцээнд нийцүүлэн тайлбарладаг асуудалтай холбоотой юм.

Зарим гадаадын судлаачид хилийн дипломат ажиллагааг хил тогтоох процесс, хилийн зааг бий болгохтой холбоотой үйл ажиллагаа буюу хэлэлцээр хийх, гэрээ байгуулах, протокол хийх зэрэг түүхэн талаас нь тайлбарладаг.

Дэлхийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс болох үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, зөрчил хил дамнасан үйлдэгдэж байгаатай холбоотой хамтын хүчээр тэмцэх, харилцан туршлага солилцох, хилийн хяналтын техник хэрэгслийг сайжруулах, мэдээллийн санг ашиглах зэрэг асуудалд улс орнуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, идэвхжүүлэхийн тулд хилийн дипломат ажиллагааг онцлон авч үзэж байна.

Зураг №1 Уламжлалт хилийн дипломат ажиллагааны загвар





Зураг №2 Орчин үеийн хилийн дипломат ажиллагааны загвар

Хилийн аюулгүй байдлыг дипломат аргаар хангах асуудал нь улс төр, гадаад бодлогыг хэрэгжүүлэгч төрийн байгууллага, олон улсын эрх зүйн субъектүүдийг хамарсан хэд хэдэн салбарын уулзварт огтлолцож байгаа судлагдахуун бөгөөд улс гүрнүүдийн хилийн дипломат ажиллагаа олон хэмжээст байх хандлагад шилжиж байна гэж үзэж байна.

Хүснэгт №1 Хилийн дипломат ажиллагааны өөрчлөлт

Хилийн дипломат ажиллагааны элементүүд	**Уламжлалт хилийн дипломат ажиллагаа**	**XX зууны хилийн дипломат ажиллагаа**	**XXI зууны хилийн дипломат ажиллагаа**
Тоглогч	Засгийн газар	Засгийн газар	Засгийн газар болон бусад тоглогчид

Харилцагч	Харилцагч улсын засгийн газар	Харилцагч улсын засгийн газар	Харилцагч улсын Засгийн газар, ОУ-ын байгууллагууд, Хилийн асуудал эрхэлсэн байгууллага
Үйлчлэгч хүч	Хатуу хүч	Хатуу хүч>Зөөлөн хүч	Зөөлөн хүч
Харилцааны зорилго	Хил тогтоох, хилийн маргааныг эв зүйгээр шийдвэрлэх	Хилийн дэглэмийн гэрээ байгуулах, түүний хэрэгжилтийг хангах, хилийн төлөөлөгчийн үндсэн болон бусад үйл ажиллагаа	Хилийн уулзалт, хэлэлцээр, хамтарсан сургуулилт, эрдэм шинжилгээний хурлын дипломат ажиллагаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, урдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хүний нөөцөө чадавхижуулах
Харилцааны хэлбэр	Хэвтээ (Засгийн газар хооронд)	Босоо, нэг тал руу чиглэсэн (Засгийн газар хооронд)	Хэвтээ хоёр талруу чиглэсэн, тэгш хэмт
Харилцааны хэв маяг	Хаалттай	Хаалттай, нээлттэй	Нээлттэй

Хилийн дипломат ажиллагаа гэдэг нь төрөөс баримталж буй гадаад бодлого, хилийн бодлогын нэгдмэл байдлыг ханган стратегид уялдуулж гадаад орон зайг бэхжүүлэхэд чиглэсэн хилийн менежментийн үйл ажиллагаа юм.

Хилийн аюулгүй байдлыг дипломат аргаар ханган хэрэгжүүлж буй гадаадын зарим улс, орны туршлага, сургамж

Бүгд Найрамдах Беларус Улс

Бүгд Найрамдах Беларусь Улс нь дэлхий дээрх далайд гарцгүй 44 улсын нэг бөгөөд ОХУ-ын хувьд стратегийн болон геополитикийн онцгой чухал орон болохын хувьд манай оронтой ижил төстэй юм. 2020-2021 онд Беларус Улс дэлхийн 76 улс орнуудын иргэдийг визийн нөхцөлөөс хөнгөлөх, визгүй нэвтрүүлэх шийдвэр гаргасан

байдаг. Тэрхүү 76 улсын жагсаалт дотор дайн, мөргөлдөөн, сөргөлдөөний нөхцөл байдалд өртсөн Сири, Афганистан, Ливи, Ирак зэрэг орнууд байсан аж. 2021 онд Беларус Улсын хил дээр олон тооны цагаачдын хямрал үүссэн шалтгааныг судлаачид олон талаас нь тайлбарласан байдаг. Хосолмон дайн судлаач Михал Пиекарски хил дээр үүссэн хямралын талаар өгүүлэхдээ (Notes from poland, 2024) Хил дээр үүссэн олон тооны цагаачдын хил давах гэсэн оролдлого нь даамжирч хил хамгаалалтын техник хэрэгсэл, цэргүүд болон офицеруудад халдах байдлаар үргэлжилж хүний амь нас хохирсон асуудал гарсан байна. Үүнээс үүдэн Тускийн засгийн газар хилийн хяналтын хатуу бодлого хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд олон улсын зарим байгууллагаас хүний эрхийн асуудлыг зөрчиж байна гэж шүүмжилсэн аж. Польшийн гадаад хэргийн сайд дүрвэгсдийн хувьд цагаачдыг өрөвдөж байгаа хэдий ч хилийн нөхцөл байдал хямралаас шалтгаалж өөрчлөгдсөн асуудалд Польш Улс хосолмол дайны халдлага (hybrid war attack)-аас хамгаалах шаардлагатай гэжээ. 2022 онд Беларус Улсын хил хамгаалах байгууллага Беларус-Польшийн хил дээр 186 км урт үргэлжлэх хаалт босгох үйл ажиллагааны чухал үе шат болох гурван том гэрээнд гарын үсэг зурлаа, гэрээг удахгүй ил тод олон нийтэд байрлуулна (Poland, 2022) гэж дэд сайд Мачей Васик мэдэгдсэн байна. 2024 онд Европын холбооны аюулгүй байдал хариуцсан дэд ерөнхийлөгч Хенна Вирккунен Орос, Беларус улсыг цагаачдыг ашиглан хосолмол дайны зэвсэг болгож байгаад буруутгасан (Macgregor, 2024) боловч Орос, Беларусаас дүрвэгсдийн эрхийн тухай олон улсын гэрээ, хэлэлцээрийг хүндэтгэн биелүүлж байна хэмээн үгүйсгэсэн аж. 2025 оны 01 дүгээр сард Европын холбооны дээд хэмжээний уулзалт болж 1951 оны Дүрвэгсдийн конвенцыг эргэн харах шаардлагатай бөгөөд Туск шилжилт хөдөлгөөн ба аюулгүй байдлын шинэ стратегиа танилцуулж онцгой нөхцөл үүссэн үед зохих арга хэмжээ авах шаардлагатай байна гэсэн дүгнэлтэд дэмжлэг авсан байна. Дүрвэгсдийн тухай 1951 оны конвенцын зарчим нь *“дүрвэгсдийг арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, улс төрийн үзэл бодол эсвэл нийгмийн тодорхой бүлгийн гишүүнчлэлээс болж амь нас, эрх чөлөөнд нь заналхийлж болзошгүй улс орон руу ямар ч байдлаар гаргахгүй, буцаахгүй* (Nations, 1951)*”* гэсэн зарчим нь өнөөгийн нөхцөл байдалд нийцэхгүй байгааг анхаарч шинэчлэх нь зүйтэй гэж үзжээ. *Беларус Улсын жишээнээс авч болох сургамж* Хил дээр бөөн иргэд нэвтрэх, дамжин өнгөрөх үед хилийн аюулгүй байдлыг хэрхэн хангах тухай бодлого,

стратеги маш чухал гэж бодож байна. Дүрвэгсдийн тоо нь гэнэт хэдэн саяд хүрч, тэдгээрийг байрлуулах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх асуудал улам бүр ээдрээтэй болсонд Европын холбооны зарим улс хилийн боомтоо хаах, хилийн ган хаалт босгон хил хамгаалалтаа хүч нэмэгдүүлэн анхаарч байгаа боловч цагаач, дүрвэгсэд зорилгоо хэрэгжүүлэхийн тулд янз бүрийн арга хэрэгсэл хэрэглэсний улмаас хүний эрхийн зөрчлийн асуудлууд нь нөхцөл байдлыг улам хүндрүүлсэн байна. Беларусын жишээнээс үзэхэд хилээр нэвтрэх асуудлыг хөнгөвчлөх, визгүй зорчих шийдвэрийг гаргахдаа цагаач, дүрвэгсдээс үүсэж болох эрсдэл, хүчин зүйлийг тооцоолоогүй нь төрийн гадаад болон дотоод үйл ажиллагааны нэгдмэл бус байдалтай холбоотой, мөн хил залгаа улсад хүндрэл бий болгож дипломат харилцаанд үл ойлголцолд хүргэсэн. Ийнхүү асуудлыг шийдвэрлэх гарц нь улс орнууд үүссэн нөхцөл байдлыг хамтын журмаар хэлэлцэн бодлогын болон стратегийн баримт бичгүүдээ шинэчлэн батлах тухай харилцан уулзалт, хэлэлцээр нь үр дүнтэй байсан гэж үзэж байна.

Бүгд Найрамдах Тажикстан улс

Зөвлөлт холбоот улс задрахаас өмнө Тажикстан, Узбекистан, Киргиз улстай хиллэдэг хил нь олон улсын хил биш, харин Зөвлөлтийн Бүгд Найрамдах улсуудын хоорондын засаг захиргааны хил байсантай холбоотой эдүгээ хүртэл Тажикстан-Киргиз хоёр улсын хоорондын хилийн маргаан үүсэх гол шалтгаан болоод байгаа юм. Энэхүү хилийн маргаан нь мөргөлдөөнд хүрч хүний амь нас үрэгдэж буй асуудлыг шийдвэрлэх ажиллагаа удаан үргэлжилж байгаа нь дэлхий нийтийн анхааралд байсан. 2024 онд Киргизийн гадаад хэргийн сайд Кулубаевын албан ёсны мэдэгдэлд “Киргиз, Тажикстан улсын төрийн тэргүүнүүд ойрын хугацаанд хилийн асуудлыг шийдвэрлэх хэлэлцээнд хүрэхийг эрмэлзэж маргаантай хилийн 94 хувийг тохиролцсон” (**Puts, 2024**) талаар илэрхийлсэн байдаг. Энэхүү асуудлыг эцэслэн шийдвэрлэх дипломат ажиллагаа нь хэд хэдэн үе шаттай тодорхой хугацаа шаардлагатай бөгөөд хоёр талын ерөнхийлөгч нар гарын үсэг зурж гэрээг парламентаар баталсны үндсэн дээр дараагийн алхам болох хилийн наана, цаана байгаа иргэдийг нүүлгэн шилжүүлэх, үл хөдлөх эд хөрөнгө, нөхөх олговрыг хэрхэх талаар харилцан ашигтай, тэгш эрхийн зарчимд суурилж эв найрамдалтай шийдвэрлэнэ гэжээ.

Тажикстаны хилийн аюулгүй байдалд дараах хүчин зүйлс нөлөөлдөг.

• Афганистан дахь олон улсын террорист болон шашны хэт даврагч байгууллагуудын үйл ажиллагаа, хар тамхи, зэвсгийн

хууль бус шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй нөхцөл байдал

• Афганистанаас гаралтай хар тамхины наймааны өсөлт, улсын хилээр хууль бусаар нэвтрэх гэмт хэргүүдтэй тэмцэх асуудал

Эдгээр асуудал нь Бүгд Найрамдах Тажикстан Улсын хилчдийг хүнд нөхцөлд хилээ хамгаалахад хүргэж, Тажикстан-Узбек, Тажикстан-Киргиз улсын хилийн дагуух хилийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгаа юм. Улсын хилийн бүх бүс нутагт тулгамдаж буй асуудлууд, тэр дундаа хилийн дэд бүтцийг сайжруулах, хил хамгаалах асуудлыг зохицуулах хууль тогтоомжийг шинэчлэх, хилийн хяналтын асуудал хариуцсан яам, агентлагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байгаа зэрэг бодит байдлыг харгалзан Бүгд Найрамдах Тажикстан Улсын Засгийн газар дэлхийн хамтын нийгэмлэг болон хандивлагч орнуудад хандан хилийн аюулгүй байдал, удирдлагын загвар, тогтолцоог хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэхийг хүссэн байна. 2006 онд ЕАБХАБ энэ хүсэлтэд хариу өгч хилийн нөхцөл байдалд нь дүгнэлт гаргасан байна. Түүнчлэн ЕАБХАБ-аас Тажикстанд төлөөлөгчийн газар байгуулах замаар хилийн үндэсний стратегийг боловсруулах зөвлөмж гаргасан. Энэхүү зөвлөмжийг баталж, ЕАБХАБ-ын төслийн хүрээнд Финландын Засгийн газар, ЕАБХАБ-ын Тажикстан дахь төлөөлөгчийн газар, ЕАБХАБ-ын Нарийн бичгийн дарга нарын газар ажлын хэсэгт санхүүгийн болон зөвлөх тусламж үзүүлж 2009 онд нийслэл Душанбе хотод Хилийн Удирдлагын Коллежийг байгуулсан явдал юм.

Тажикстан болон ЕАБХАБ-ын бусад бүх оролцогч улсууд 2005 оны 12-р сард Любляна хотноо ЕАБХАБ-ын Хилийн аюулгүй байдал, удирдлагын үзэл баримтлалыг баталсан. Тажикстаны газар зүйн болон бусад нөхцөл байдлыг харгалзан ЕАБХАБ-ын Хилийн аюулгүй байдал, менежментийн үзэл баримтлалд үндэслэсэн стратегийг баталсан байна. Үндэсний ажлын хэсэг болон ЕАБХАБ-ын төслийн зөвлөхүүдийн хооронд 70 гаруй уулзалт хийсэн бөгөөд эдгээр уулзалтын дүгнэлтийг Стратегид тусгажээ. Тажикстан улсын хилийн ирээдүйн хөгжил нь яам, агентлаг, ажлын хэсгийн гишүүдийн дэвшүүлсэн санаан дээр суурилдаг. Стратегид ашигласан ерөнхий зарчмууд нь Европын холбооны хилийн удирдлагын зарчим болон НҮБ-ын холбогдох конвенцод нийцэж байгаа аж.

Энэхүү стратеги нь Засгийн газрын хилийн аюулгүй байдлын талаарх урт хугацааны (2010-2025 он) шинэчлэлийн иж бүрэн төлөвлөгөө бөгөөд хилийн асуудалтай холбоотой бүх яам,

агентлагуудыг хамарсан. Яам, агентлаг болгоны үүрэг харилцан адилгүй байдаг ч хамтран ажиллах зарчим баримтлан хилийн удирдлагын нэгдсэн тогтолцоог бий болгох зорилготой. Энэ нь хилийн менежментийг зөвхөн хилийн цэргийн хүрээнд биш улсын хэмжээний асуудал гэж анхаарч буйн илрэл юм. Стратеги нь гурван хэсэгт хуваагдана; Эхний хэсэгт одоогийн хилийн нөхцөл байдлын танилцуулга, тайлбар, хоёр дахь хэсэгт Тажикстан улсын хилийн менежментийн стратегийн зарчим, зорилтуудыг тодорхойлсон, гуравдугаар хэсэгт хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд яам, агентлаг хоорондын хамтын ажиллагааг сайжруулахтай холбоотой шинэчлэлт хийх талаар тусгасан. Үндэсний хилийн стратегид тодорхойлсон агентлаг тус бүр нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тажикстан Улсаас авч болох туршлага

Тажикстан Улс нь хилийн маргаантай асуудлыг дипломат аргаар шийдвэрлэхэд анхаарч тохиролцоонд хүрч харилцан ашигтай дипломат ажиллагааг явуулах болсон. Тажикстан Улсын засгийн газраас хилийн аюулгүй байдлын асуудлыг анхааран ЕАБХАБ-аас тодорхой дэмжлэг, туслалцаа хүсч, түүнийг ажил хэрэг болгон бодитой арга хэмжээг авч чадсан байна. Хилийн аюулгүй байдлыг хангах удирдлагын тогтолцоо, түүнийг хөгжүүлэх, үндэсний хэмжээний баримт бичгийг боловсруулах ажлыг эрчимжүүлэн хилийн стратегийг баталжээ. Хилийн стратегид тулгуурлан яам, агентлаг тус бүрийн онцлогт тохируулан төлөвлөгөө гаргах, харилцан уялдаатай хамтран ажиллах, хяналт тавих асуудлыг засгийн газар хариуцсан үр дүн хэрэгжилтийг хангах оновчтой шийдлийг гаргасан зэрэг сайн туршлагаас дүгнэн үзэхэд хилийн дипломат ажиллагааны зорилго, ач холбогдол нь хилийн аюулгүй байдлыг хангах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйл ажиллагааг шинэ шатанд хүргэхэд оршиж байна.

Дүгнэлт

Үндэсний аюулгүй байдал, хилийн аюулгүй байдлын тулгуур баримт бичгүүдэд зааснаар аюулгүй байдлыг хангах ажиллагааг шинжлэх ухаан, судалгаа, шинжилгээний үр дүн, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нэгдмэл байдалд үндэслэх нь зүй ёсны хэрэг билээ.

1. Хилийн аюулгүй байдал, түүнийг хангах үйл ажиллагааг системийн хандлагад тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлд нийцүүлэн зүй тогтлынх нь дагуу хөгжүүлэхийн тулд судалгааг: хилийн аюулгүй байдлыг хангах дипломат ажиллагааг “улсын хил” гэсэн үндсэн объектод Монгол Улсын гадаад бодлогын харилцан хамаарал, хилийн аюул заналаас хамгаалагдсан нөхцөлийг

бүрдүүлсэн байдлаар аюулгүй байдлын түвшнийг нарийн тооцож судалгаа шинжилгээг цогцоор явуулах шаардлагатай байна.

2. Олон улсын эрх зүйн зохицуулалт зарим зөрчил, мөргөлдөөнийг шийдвэрлэж чадахгүй нөхцөл байдлаас шалтгаалж боловсронгуй болгоход улс гүрнүүд анхаарч буйг Монгол Улс харгалзан үзэж дотоодын хууль тогтоомжид байгаа нэр томьёо, хоёрдмол утга бүхий агуулга, үл нийцэл, хийдэл зэргийг засаж сайжруулах арга хэмжээ авах хэрэгтэй.

3. Орчин үед дипломат ажиллагааны хамрах цар хүрээ, төрөл хэлбэр улам өргөжиж байгаа бөгөөд зөвхөн НҮБ-ын хүрээнд жилд 20’000 гаруй хурал зохион байгуулагддаг гэсэн тоо бий. Хилийн аюул, занал, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх талаар хамтын ажиллагааг өргөжүүлэх, хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэт техник, технологийн хэрэглээг нэвтрүүлэх, зөрчил маргааныг даамжруулан мөргөлдөөнд хүргэхээс урьдчилан сэргийлэх зэрэг итгэлцлийг бэхжүүлэх зэрэг зорилготой хилийн дипломат ажиллагааны ач холбогдол, гүйцэтгэх үүргийг манай улс олон улсын түвшинд нийцүүлэх нь зохистой.

Эх сурвалж.

(2024, 06 12). Retrieved from Notes from poland: https://notesfrompoland.com/2024/06/12/the-renewed-poland-belarus-border-crisis-explained/

Macgregor, M. (2024, 12 12). *Info migrants*. Retrieved from Info migrants: https://www.infomigrants.net/en/post/61697/eu-to-boost-security-restrict-asylum-right-at-russia-belarus-borders

Nations, U. (1951). *UNHCR The Refugee Agency*. Retrieved from The Refugee convention. UN. 195: https://www.unhcr.org/sites/default/files/legacy-pdf/4ca34be29.pdf

Poland, M. o. (2022, 01 07). *Ministry of the Interior and Administration Republic of Poland*. Retrieved from Ministry of the Interior and Administration Republic of Poland: https://www.gov.pl/web/mswia-en/the-border-guard-signed-agreements-concerning-the-construction-of-a-barrier-on-the-poland-belarus-border

Puts, C. (2024, 08 06). *The diplomat*. Retrieved from www.Thediplomat.com: https://thediplomat.com/2024/08/kyrgyz-tajik-border-agreement-hoped-for-in-nearest-future/

ХИЛИЙН БООМТЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛЫН ОЙЛГОЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

С.Энхчимэг
ДХИС-ийн хил судлалын магистрант, Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн ахлах шалгагч, ахмад
Х.Асхар
ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн профессор, доктор (Ph.D), хурандаа

Товч агуулга: Хилийн боомт гэж Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн хөгжил, гадаад харилцааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд үүнийг дагаад тодорхой үүрэг хариуцлагыг хүлээдэг. Үүний тулд хилийн боомтын үйл ажиллагаа, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг нарийн зохицуулсан эрх зүйн орчин бүрдсэн байх зүй тогтолтой. Судалгааны ажлын сэдвийн хүрээнд эрх зүйн талаарх ойлголтыг онол талаас нь судлах, хилийн боомтын үйл ажиллагаанд шаардлагатай эрх зүйн орчныг онол, практикт хэрхэн холбох, тайлбарлах, боомтын эрх зүйн орчныг хэрхэн сайжруулах зорилгыг агуулсан болно. Энэхүү өгүүлэлд салбарын эрдэмтэн, судлаачдын диссертац, нэг сэдэвт бүтээл, түүхэн эх сурвалжийн баримтуудыг цуглуулах, эдгээр баримтуудад тулгуурлан харьцуулах, эрх зүйн онолын харьцуулалт хийж, түүнд дүн шинжилгээ хийх зэрэг судалгааны арга зүйг ашигласан болно.

Түлхүүр үгс: эрх зүй, эрх зүйн бүл, зарчим, тогтолцоо

Удиртгал

Хилийн боомт, хилийн эрх зүйн асуудлыг ярихаас өмнө эрх зүй гэж юу вэ гэдэг ойлголтыг авсан нь зүйтэй гэж үзэж байна. Эрх зүй (англ. law)- Төрд хамаарагдах нийгмийн нэлээд нарийн төвөгтэй үзэгдэл. Эрх зүйг төрөөс тогтоосон, зөвшөөрсөн, хангагдсан олон янзын, нийтээрээ заавал дагаж мөрдөх, зан үйлийн журам хэмээн ойлгодог. Заримдаа эрх зүйг хэн нэгний хөндлөнгийн оролцоогүйгээр төрийн хамгаалалтын дор хувь хүмүүнд хамаарах чөлөөтэй захиран зарцуулах зүйл (С.Нарангэрэл, 2021).

Нэг талаар эрх зүйг хууль зүйн хэм хэмжээний тогтолцоо хэмээн ойлгох тал бий. Нөгөө талаар эрх зүй хэмээх нэр томьёог жам ёсны эрхийг багтаасан эрх зүйн бүх үзэгдлийн цогц хэмээн тайлбарладаг байна.

Эрдэмтэн, судлаачдын бичсэн бүтээлүүдээс энэхүү эрх зүй хэмээх ойлголтын талаар онолын түвшинд судалж үзэхэд эрх зүй (англ. law) гэдэг нь төрд хамаарагдах нийгмийн нэлээд нарийн төвөгтэй үзэгдэл гэж

тайлбарласан байна. Тодруулбал төрөөс тогтоосон, зөвшөөрсөн, хангагдсан олон янзын, нийтээрээ заавал дагаж мөрдөх, зан үйлийн журам хэмээн ойлгогддог. Мөн эрх зүйг хэн нэгний хөндлөнгийн оролцоогүйгээр төрийн хамгаалалтын дор хувь хүмүүнд хамаарах чөлөөтэй захиран зарцуулах зүйл гэж (С.Нарангэрэл, 2021) хууль зүйн нэвтэрхий толь бичигт тайлбарлажээ.

Эрх зүйг хууль тогтоогчийн удирдамж, хэн нэгний дур зоргоороо тогтоосон хэм хэмжээ бус төрөөс хараат бус, тогтмол байнга үйлчлэх, эрхэм дээд өгөгдөл, зарчим, нөхцөл, шударга ёс, жудаг, нинжин сэтгэл, хамгийн үнэт зүйлсийн объектив журам, Мөнх тэнгэрийн өгөгдөл (Бурханы) гэж үздэг. Ингэхлээр хууль тогтоогчийн үндсэн үүрэг нь эрх зүйн энэхүү обьектив хэв шинжийг хуульд сайтар тусгахад оршино гэж судлаачид тайлбарлаж, үзэл бодлоо илэрхийлжээ.

Үндсэн хэсэг

Академич С.Нарангэрэлийн үзэж байгаагаар эрх зүй нь тодорхой хэв шинжүүдийг агуулсан байх бөгөөд тэдгээрээс нэн чухал шинжүүдийг дараах хамаарна. Үүнд:

1.Нийтээрээ заавал дагаж мөрдөх нь эрх зүйн хэм хэмжээг хэн нэгэн тодорхой хүнд нэр зааж хандуулаагүй, амьдралын тодорхой нөхцөл байдалд орсон ба заавал дагаж мөрдөх ёстой тодорхой бус олон тооны этгээдэд хандсан байдгаараа илрэлээ олно.

2.Хэм хэмжээний шинж нь нийгмийн харилцаанд оролцогчдын эрх ба үүргийг бэхжүүлсэн хууль зүйн хэм хэмжээний тогтолцоо байдагт оршино.

3.Төрийн хүсэл зоригийн шинж нь төрийн хүсэл зоригийн шинж нь төрийн хүсэл зоригийг илэрхийлнэ эрх зүй цаг ямагт хүсэл зоригийн илэрхийлэл болдог.

4.Системчлэгдсэн байдал нь нарийн төвөгтэй тогтолцоо бүхий бүрдэл болдогт оршино. Эрх зүйн заалтууд нь хүмүүст тусдаа бус харин бие биетэйгээ харилцан уялдсан нөхцөлдсөн байдлаар үйлчилнэ. Эрх зүйн тогтолцоо нь эрх зүйг бүтээгч субъектийн хүсэл, зоригоос, хүслэнгээс шалтгаалахгүйгээр бодитой оршино.

5.Тодорхойлон хэлбэршүүлсэн байдал нь эрх зүй ямар нэгэн хэлбэрээр илрэхийг харуулна. Эрх зүйн хэлбэр нь эрх зүйн ямар тогтолцоонд хамаарч байгаагаас шалтгаална.

6.Төрийн албадлагаар хангагдсан байдал нь төр эрх зүйн хэм хэмжээг батлан гаргаж, тэдгээрийн хэрэгжилтийг хангана гэсэн үг гэж тайлбарлажээ. (С.Нарангэрэл, 2021)

Иймд эрх зүй гэх ойлголт нь нийгэм болоод бодит байдал, хүний хүсэл зориг, эрх, эрх чөлөө, шударга ёс, төрийн хүсэл зориг, хүний жам ёсны эрх, ашиг

сонирхол, харилцан адилгүй хүсэл, хэрэгцээ шаардлагаар илэрхийлэгддэг ойлголт гэж болохоор байна. Улмаар хүн бүхэнд нээлттэй, хэрэглэх бүрэн боломжтой бөгөөд нийгмийн харилцаанд оролцогч хэн бүхний баримтлах, ухамсарлах зан үйлийн зохицуулагч, үйлчлэгч, тохируулагч нь мөн юм.

Энэ ойлголтын хүрээнд хилийн боомт нь өөрөө иргэдийн хүсэл зориг, эрх, эрх чөлөө, төрийн хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглэгдсэн байх объект гэж ойлгогдохоор Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12-д “Хилийн боомт нь .....” гэх нэр томьёоны тайлбарын төгсгөлд “.....газар” (Монгол Улсын хилийн тухай хууль, 2016) гэж тодорхойлсон. Тэгэхээр хилийн боомт нь зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдсэн эрх зүйн орчинтой байх зүй тогтлын асуудлын талаар яригдах учиртай болно. Хилийн боомтын үйл ажиллагаа нь өөрөө дан ганц үндэсний хууль тогтоомжийн хүрээнд зохицуулагдах бус эрх зүйн тодорхой хувь хэмжээг эзлэх олон улсын хэм хэмжээний актуудаар шууд зохицуулагддаг онцлогтой юм. Тухайлбал, хил залгаа улс (ОХУ, БНХАУ)-уудын засгийн газар хоорондын байгуулсан иргэд харилцан зорчих хэлэлцээр, Дипломат болон консулын харилцааны тухай вений конвенц гэх мэт.

Тэгэхээр олон улсын хэм хэмжээний актуудаар боомтын үйл ажиллагаа нь нэгэнт зохицуулагдаж байгаа нь тодорхой олон улсын зарчмыг хангах агуулгын хүрээнд хилийн хяналтын байгууллагуудаас батлан гаргаж буй дүрэм, журам юм. Үүнийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр онолын хүрээнд эрх зүйн зарчмыг тодорхойлсон ойлголтоос тодорхой харагдах болно. Эрх зүйн зарчим гэж чухам юу вэ гэдгийг Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичигт (англ. Legal principle)- Эрх зүйн иж бүрэн номлол буюу төсөөлөл, баримтлал, зан үйлийн ерөнхий суурь зарчим. Эрх зүйн зарчим нь эрх зүйн тодорхой журмаас иш татсан тухайн журмын гаргасан нийтлэг үндэслэлийг тодорхойлсон заалт гэж тайлбарласныг илүү ойлгомжтойгоор хилийн боомтын эрх зүйн зарчмыг тодорхой жишээн дээр тайлбарлахад хилийн боомтод мөрдөх журмыг дурдаж болохоор байна. Энэ мэтчилэн олон жишээг дурдаж болно.

Дараагийн нэг чухал асуудал болох эрх зүйн тогтолцооны ойлголтын хүрээнд эрх зүйн бүлийн тухай ойлголтыг судалж, орууллаа. Эрх зүйн бүл гэдэг англи хэлнээ “Legal system” гэж нэрлэгдэх ба адилавтар ойролцоо шинж бүхий бүлэг эрх зүйн тогтолцоо гэж тодорхойлсон

байдаг. Хэв шинжийн хувьд -эх сурвалжийн тогтолцоо, -эрх зүйн тогтолцоо, -хууль зүйн байгууллагын зохих байгуулалт, -эрх зүйн уламжлал гэж хуваагдах бөгөөд дээрх хэв шинжүүдээс хамааран дараах ангилалд хуваагдана.

1.Ром- Германы (эх газрын) эрх зүйн бүл

2.Англи-Америкийн (англи-саксоны) эрх зүйн бүл

Тухайн улсуудын нийгэм, улс төр, эдийн засгийн тогтолцоо, амьдралын хэв маяг, үзэл баримтлалаас хамааран социалист эрх зүй, лалын (мусульманы) эрх зүй, скадиновын эрх зүй, энэтхэгийн эрх зүй, Хятад болон Японы эрх зүй, Африк болон Мадагаскарын эрх зүйн тогтолцоо гэж ялгана гэж үздэг байна. (С.Нарангэрэл, 2021)

Эрх зүйн бүл бол эрх зүйн тогтолцооны үндсэн ойлголтын нэг гэж үздэг. Эрх зүйн бүл гэж тухайн улс орон, бүс нутаг, тив тивийн улс орнуудын эрх зүйн үүсэл, хөгжил, голлох эх сурвалж, түүнийг хэрэглэх арга, эрх зүйн уламжлал, заншил, соёл, эрх зүйн ухамсар зэрэг хүчин зүйлүүдээс хамаарсан эрх зүйн томоохон ангилал буюу бүлэглэлийг ингэж тайлбарлан бичжээ. (О.Амархүү, 2018 он)

Эрдэмтэд, судлаачид сүүлийн үед эрх зүйн бүлийг ром-германы буюу эх газрын эрх зүйн бүл, англи-америкийн буюу жишгийн эрх зүйн бүл, шашны болон овгийн уламжлалт эрх зүйн бүл гэсэн үндсэн ангилалд бүлэглэн авч үзэх болжээ. Тухайлбал, академич С.Нарангэрэл, академич Ж.Амарсанаа, профессор Ч.Нямсүрэн, профессор Д.Баярсайхан нар (О.Амархүү, 2018 он)-ын ангилан үзсэнийг харьцуулан авч үзэхэд дараах нийтлэг болон онцлог хэв шинжүүд ажиглагдаж байгааг хүснэгт 1-ээр харуулав.

Хүснэгт 1. Монгол Улсын эрдэмтдийн эрх зүйн бүлийг ангилан авч үзсэн байдлыг харьцуулсан судалгаа

Эрх бүлд ангилан авч үзсэн байдал	**Эрдэмтэн, судлаачидын нэр**				**Ижил төстэй байдал**
	академич С.Нарангэрэл	**Академич Ж.Амарсанаа**	**Профессор Ч.Нямсүрэн**	**Профессор Д.Баярсайхан**	
англо-саксоны	+		+		
ром-германы	+		+		
мусальманы	+				

эх газрын, нийтлэг эрх зүйн		+			
лалын эрх зүйн		+	+		
уламжлалт эрх зүйн		+	+		
шашны болон овгийн уламжлалт			+		
барууны сонгодог эрх зүйн систем				+	
барууны хосолсон буюу холимог эрх зүйн систем				+	
ойрх дорнодын буюу шашинт эрх зүйн систем				+	
зүүн Ази, Африк дорно дахины буюу заншлын эрх зүйн систем				+	

Агуулгын хувьд харьцуулсан судалгааны үр дүнгээс харахад дараах байдлаар давхцаж байна.

Шашны буюу исламын шашны

Нийгмийн тогтолцоо

Газар зүйн байршилаас нь хамааран

Эх сурвалж. Судлаачийн боловсруулсан хувилбар

Эрх зүйн зарчим (англ. Legal principle)- Эрх зүйн иж бүрэн номлол буюу төсөөлөл, баримтлал, зан үйлийн ерөнхий суурь зарчим. Эрх зүйн зарчим нь эрх зүйн тодорхой журмаас эш татсан тухайн журмын гаргасан нийтлэг үндэслэлийг тодорхойлсон заалт. (С.Нарангэрэл, 2021) гэж тодорхойлсон байна. Үүнийг хилийн боомтын эрх зүйн зарчмын хүрээнд авч үзэхэд олон улсын хэм хэмжээний актууд болон үндэсний хуульд тодорхойлж өгсөн зарчмуудаас иш татаж тухайн үйл ажиллагаанд үйлчлэх харилцааг зохицуулсан хууль тогтоомжид тусгалаа олж байна. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний

эрх, эрх чөлөө, хүний зорчих эрхийг хангах зарчмын хүрээнд тодорхойлогдох хүний эрхийг дээдлэх зарчим. Энэхүү зарчмыг үндэслэн Хил хамгаалах ерөнхий газрын даргын баталсан “Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх журам”, “Гаалийн хилээр зорчигчийн ачаа тээш, ачаа барааг улсын хилээр нэвтрүүлэх журам” нь дээрх дурдсан зарчмыг бүрэн хангахад чиглэгдэж байна.

Тэгэхээр эрх зүйн зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд эрх зүйн зарчим нь асуудлыг шийдэхэд гол түлхэц болдог. Эрх зүйн зарчим гэдэг нь эрх зүйн уг сурвалж болсон үзэл санааны эрх зүйн онолын үндэслэгээ, өөрөөр хэлбэл эрх зүйн харилцаанд оролцогч этгээд нэр бүр үйл ажиллагаандаа удирдлага болох ёстой гол тулгуур үзэл санааны үнэт зүйл нь байдаг. (Б.Ганболд, 2011 он)

Хилийн боомт дахь хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээ, ажлын ачаалал, эрсдэл хэрхэн ялгаатай байгааг судлах зорилгоор нийтлэг мөрддөг олон улсын эрх зүйн баримт бичиг, үндэсний хууль, тогтоомжууд, Засгийн газрын шийдвэр тогтоол, агентлагийн эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, нэгтгэн үзүүлэхэд графикчилан харуулахад дараах үр дүн гарч байгааг график 1, 2-оор харуулав.

График 1. Хилийн хяналтын байгууллагуудаас нийтлэг мөрдөж буй олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээр





График 2. Хилийн хяналтын байгууллагуудаас нийтлэг мөрдөж буй Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, МУ-ын ерөнхийлөгчийн зарлиг



Эх сурвалж: Судалгааны ажлын хүрээнд хийсэн боловсруулалт

Аливаа салбар эрх зүйн харилцаа үүсэх эрх зүйн үндсийг Үндсэн хуулиар тодорхойлдог. Монгол Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлд Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна, Монгол Улсын хилийг хуулиар бататгана гэж заасан байгаа нь өөрөө хилийн эрх зүйн харилцааны үндэс мөн гэж үзжээ (Хилийн эрх зүй, 2018 он). Хилийн эрх зүй нь бусад салбар эрх зүйн нэгэн адилаар хилийн эрх зүйн аливаа хэм хэмжээгээр зохицуулж байгаа учраас өөрийн гэсэн зохицуулах зүйл, мөн дээрээс нь хилийн эрх зүйн зохицуулалтад ашиглаж буй хууль зүйн арга хэрэгсэлтэй учраас зохицуулалтын аргатай бие даасан салбар эрх зүй юм. Хилийн эрх зүйн тогтолцоо гэдэг нь хилийн эрх зүйн хэмжээг зохицуулж буй харилцааны агуулга, онцлогоос хамаарч тодорхой эрэмбэ дараалалд оруулан байрлуулсныг хэлнэ. Хилийн эрх зүйн тогтолцоог бүрдүүлэгч анхдагч элемент нь хилийн эрх зүйн хэм хэмжээ юмаа гэж үзжээ. (Хилийн эрх зүй, 2018 он).

Хилийн эрх зүйн хэм хэмжээ гэдэг нь хилийн эрх зүйн шинжийг агуулсан хамгийн жижиг хэсэг учраас дангаараа нийгмийн харилцааг зохицуулах, хамгаалах чадвар дутмаг юм гэж үзэж байгаа юм байна (Хилийн эрх зүй, 2018 он).

Хилийн эрх зүйн тогтолцоо бусад салбар эрх зүйн нэгэн адил ерөнхий анги, тусгай анги гэсэн бүтэцтэй байна. Хилийн эрх зүйн хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааны бүх институт, хэсгүүдээс нийтлэг байдлаар хамаарч зохицуулж буй хэм хэмжээнүүдийн нийлбэрийг ерөнхий анги гэж үзнэ.

Хилийн эрх зүйгээр зохицуулж буй нийгмийн харилцаа нь тодорхой төрөл, чиглэлээр ангилагдаж эрх зүйн институт, хэсгүүд болох бөгөөд энэ нь тусгай ангийн системийг бүрдүүлдэг. Тусгай анги нь ерөнхий ангийн үзэл баримтлал, зарчмыг удирдлага болгодог.

Дүгнэлт

Одоогийн хилийн хяналтын байгууллагуудын мөрдөж буй "салангид" хууль, дүрэм, журам заавар нь хилийн боомт болон хяналт шалгалтын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулахад учир дутагдалтай байгааг эрдэмтэн, судлаачид судалгааны ажлын үр дүнгээр байнга санууллж, хэрхэн сайжруулах талаар өөр өөрийн салбарын түвшинд авч үзэж байна. Энэ байдлыг сайжруулах талаар төрийн зүгээс анхааран бодлогын түвшинд "Алсын хараа-2050 хөгжлийн урт хугацааны хөгжлийн бодлого", "шинэ сэргэлтийн бодлого" зэрэг баримт бичгүүдийг УИХ-аас батлан гарган хилийн боомтуудын дэд бүтэц, барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөх замаар нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зэргээр тодорхой арга хэмжээг сүүлийн 5 жилд хийж хэрэгжүүлж байгаа юм.

Дан ганц дэд бүтэц, барилга байгууламжийг шинэчилснээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм. Дээрх дурдагдсан асуудлыг зохицуулах анхдагч эх үүсвэр нь эдгээрийг зохицуулах эрх зүйн орчин юм. Эрх зүйн орчин тодорхой, нарийн зохицуулалттай байх нь үйл ажиллагааг илүү тодорхой, бусад хэм хэмжээний актуудтай харилцан уялдаатай болгох, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэх зэрэг олон талын ач холбогдолтой болох юм. Өнөөдрийн байдлаар монгол улсын эргэн тойронд оршин буй хилийн боомтод хилийн хяналтын байгууллагуудаас мөрдөж буй олон улсын болон үндэсний хууль тогтоомжуудаас бүрдсэн нийт 100 гаруй эрх зүйн хэм хэмжээний актууд байна. Зарим хууль тогтоомжууд хоорондоо харилцан уялдаа холбоогүй, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, хилийн хяналтын байгууллагуудын алба хаагчид өөр өөр нийгмийн хангамж, үйлчилгээг авдаг зэрэг тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага байгаа нь судалгааны ажлын үндэслэл болсон.

Санал

Энэхүү илтгэлийг бичиж байхдаа зөвхөн хилийн эрх зүйн орчин гэж ярихаас илүүтэй хилийн боомтын эрх зүйн орчныг сайжруулахад том түлхэц болох гол хөшүүрэг нь хил хяналтын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулахад нэгдсэн нэг мэдээллийн системтэй болгох, мөн дээрээс нь дан ганц барилга байгууламжийн асуудлаас шийдээд хамтын уялдаа холбоотой болохгүй нь ойлгомжтой учраас хилийн

боомтын эрх зүйн орчныг сайжруулахаас гадна үүрэг гүйцэтгэж буй хил хяналтын

байгууллагуудын алба хаагчид нь хилийн боомт гэдэг ойлголтын гол цөм учраас тэдгээрийн амьдрах орчин, ажлын байран дээрх сэтгэл хангаж, хөгжихөд юу саад болж байгаа зэрэг хүчин зүйлсийг илрүүлж, түүнийг багасгах арга замыг чухалчлах нь энэхүү илтгэлийн шинэлэг тал ач холбогдол оршиж байгаа юм.

Эх сурвалж

Б.Ганболд. (2011 он). *Эрх зүй судлал.* Улаанбаатар хот.

С.Нарангэрэл. (2021). *Адмон принт ХХК.* Улаанбаатар хот: Монгол Улсын хууль зүйн

нэвтэрхий толь бичиг.

Монгол Улсын Үндсэн хууль. (1992 он). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.

Монгол Улсын хилийн тухай хууль. (2016 оны 12 28). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail?lawId=12418-ээс гаргасан

О.Амархүү. (2018 он). *Эрх зүйн онол.* Улаанбаатар хот. Адмон принт ХХК.

С.Нарангэрэл. (2021 он). *Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг.* Улаанбаатар хот.

Ч.Нямсүрэн (2021 он). Эрх зүйн ерөнхий онол. Уланбаатар хот

Д.Баярсайхан (2023 он). Эрх зүйн онол. Улаанбаатар хот.

Г.Лхагвамаа Ч.Мягмарбаяр (2018 он) Хилийн эрх зүй. Улаанбаатар хот.

ХИЛЧДИЙН НИЙГМИЙН БАТАЛГАА, АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ХИЛ ХАМГААЛАЛТЫН ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ

Т.Ариунсүх
ДХИС-ийн Биеийн тамир, албаны бэлтгэлийн институтийн багш, дэслэгч

Товч агуулга: "Хилчдийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг сайжруулах замаар тэдний сэтгэл ханамж, урам зоригийг нэмэгдүүлж, хилийн хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх арга замыг судалсан."

Түлхүүр үг: Хилийн хамгаалалт, Нийгмийн баталгаа, Хөдөлмөрийн урам зориг, Хүний нөөцийн удирдлага, Мэргэжлийн хөгжил, Хилчдийн ажиллах нөхцөл, Ажлын сэтгэл зүй, Тогтвортой ажиллах, Аюулгүй байдал, Нийгмийн халамж.

Удиртгал

Хилийн хамгаалалтын алба бол улс орны бие даасан байдал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хариуцлагатай үүрэг гүйцэтгэдэг чухал байгууллага юм. Энэ албанд ажиллаж буй хилчид нь хүнд нөхцөлд, ар гэрийнхэндээ алслагдан, улсаа болон түүний иргэдийг хамгаалахын тулд тууштай, сахилга баттайгаар ажиллах шаардлагатай байдаг. Гэтэл хилчдийн нийгмийн баталгааг хангах асуудал нь хэд хэдэн хүчин зүйлсийн нөлөөн дор хүндэрч, ажиллах нөхцөл, сэтгэл зүй, нийгмийн халамжийн дутагдалд хүргэж байна.

Иймд энэхүү илтгэл нь хилчдийн нийгмийн баталгааг сайжруулснаар тэдний тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хэрхэн бүрдүүлэх боломжтой талаар судалгааны дүнг танилцуулахад зориулагдсан. Судалгааны гол таамаглал нь хилчдийн нийгмийн баталгааг хангаж чадвал тэд албандаа илүү тогтвортой, үр ашигтай ажиллаж, албаны нийт үр дүнг дээшлүүлэх боломжтой хэмээн үзэж байна.

Судалгааны аргачлалд эмпирек арга, асуудлын мод, шийдлийн модны аргыг ашиглан, хилчдийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийн өнөөгийн байдал, тэдэнд тулгарч буй асуудлуудад дүн шинжилгээ хийх болно. Ингэснээр биелэгдэх боломжтой шийдлүүдийг тодорхойлж, хилчдийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн тогтвортой арга хэмжээ авахад туслах санаа, зөвлөмжийг боловсруулахыг зорьж байна.

Энэхүү судалгааны илтгэл нь хилчдийн нэгдсэн бодлого, стратегийг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой бөгөөд хилчдийн эрх зүйн хамгааллыг нэмэгдүүлж, хилчдийн ажиллах нөхцөлийг сайжруулахад хувь нэмэр оруулах болно.

Үндсэн хэсэг

Онолын хэсэг: Хүний нөөцийн удирдлагын онол ба Хөдөлмөрийн урам зоригийн онол

1. Хүний нөөцийн удирдлагын онол[1] (Human Resource Management Theory)

Хүний нөөцийн удирдлагын онол нь байгууллагын үр ашгийг дээшлүүлэхийн тулд ажилтнуудын хөгжил, урам зориг, үнэнч байдлыг хангах чухал ач холбогдолтой гэж үздэг. Энэ онолын үндсэн зарчим нь ажилтнуудыг зөвхөн нөөц биш, харин байгууллагын хамгийн үнэ цэнтэй хөрөнгө хэмээн үзэж, тэдний хөгжил, халамж, урам зоригийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг боловсруулах явдал юм.

Хилчдийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг сайжруулах асуудлыг шийдвэрлэхэд энэ онолыг ашигласнаар дараах арга хэмжээг санал болгож болно:

Ажилтны хөгжил, сургалт: Хилчдэд тогтмол мэргэжлийн сургалт, ур чадварыг дээшлүүлэх боломжийг олгох. Энэ нь тэдний мэргэжлийн өсөлтийг дэмжиж, ажлын үр ашгийг нэмэгдүүлнэ.

Урам зориг өгөх хөтөлбөрүүд: Хилчдийн үр дүнг хүлээн зөвшөөрч, шагнал, урамшуулал олгох системийг боловсруулах. Энэ нь тэдний урам зориг, үнэнч байдлыг нэмэгдүүлэхэд тусална.

Ажилтны эрүүл мэнд, халамж: Хилчдийн сэтгэл зүйн болон биеийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх. Жишээ нь, сэтгэл зүйн зөвлөгөө, эрүүл мэндийн даатгал зэрэг.

Ажилтны оролцоог нэмэгдүүлэх: Хилчдийг шийдвэр гаргах үйл явцад илүү их оролцуулах замаар тэдний хариуцлагыг нэмэгдүүлэх. Энэ нь тэдний байгууллагын үйл ажиллагаанд илүү их хөтөч болоход тусална.

2. Хөдөлмөрийн урам зоригийн онол[2] (Work Motivation Theories)

Хөдөлмөрийн урам зоригийн онол нь ажилтнуудын урам зориг, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон арга барилыг санал болгодог. Эдгээр онолуудын дотроос Херцбергийн Хоёр хүчин зүйлийн онол (Herzberg's Two-Factor Theory) болон Ажлын шинж чанарын загвар (Job Characteristics Model) нь хилчдийн ажиллах нөхцөлийг сайжруулах асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

[1] Армстронг, М. (2020). *Хүний нөөцийн удирдлагын практикийн Армстронгийн гарын авлага* (15-р хэвлэл). Kogan Page.

[2] Херцберг, Ф. (1966). *Хүний мөн чанар ба хөдөлмөр*. Кливленд: World Publishing.

Херцбергийн Хоёр хүчин зүйлийн онол:[1]

Херцбергийн онол нь ажилтны сэтгэл ханамжийг "сэтгэл ханамжийн хүчин зүйлс" (мотиватор) болон "сэтгэл ханамжгүй болгох хүчин зүйлс" (гигиен) гэж хуваадаг. Хилчдийн ажиллах нөхцөлийг сайжруулахдаа энэ онолыг ашигласнаар:

Сэтгэл ханамжгүй болгох хүчин зүйлсийг арилгах: Жишээ нь, цалин, ажиллах орчны аюулгүй байдал, ажлын тогтвортой байдлыг сайжруулах.

Сэтгэл ханамжийн хүчин зүйлсийг нэмэгдүүлэх: Ажлын утга учир, хүлээн зөвшөөрөл, мэргэжлийн хөгжил зэрэг хүчин зүйлсийг нэмэгдүүлэх.

Ажлын шинж чанарын загвар:

Энэ загвар нь ажлын урам зоригийг нэмэгдүүлэхийн тулд ажлын шинж чанарыг сайжруулахыг санал болгодог. Үүнд:

Ажлын олон талт байдал: Хилчдэд илүү олон талт, сонирхолтой ажлуудыг өгөх.

Автономит: Хилчдийг ажлынхаа талаар илүү их эрх мэдэл, хариуцлага өгөх.

Үр нөлөө: Хилчдийн ажлын үр дүн нь байгууллагад хэрхэн нөлөөлж байгааг тодорхой харуулах.

Хүний нөөцийн удирдлагын онол ба Хөдөлмөрийн урам зоригийн онолууд нь хилчдийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг сайжруулах асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр онолуудыг ашиглан хилчдийн хөгжил, урам зориг, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг боловсруулснаар тэдний ажиллах нөхцөл, үр ашигтай байдалд эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Энэ нь улмаар хилийн хамгаалалтын албаны нийт үр дүнг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах болно.

Асуудлын модны аргаар хилчдийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийн асуудлыг шинжилнэ

Асуудлын модны арга нь тодорхой асуудлыг үндсэн хэсгүүдэд хувааж, түүний шалтгаан, үр дагаврыг системчилсэн байдлаар шинжлэхэд тусалдаг. Энэ аргыг ашиглан хилчдийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийн асуудлыг задлан шинжилье.

1.*Үндсэн асуудал*: Хилчдийн нийгмийн баталгаа хангагдахгүй байгаа нь тэдний ажиллах нөхцөл, сэтгэл зүйн байдалд сөргөөр нөлөөлж байна.

2.Асуудлын шалтгаанууд (Үндсэн салбарууд):

[1] Херцберг, Ф. (1966). Хүний мөн чанар ба хөдөлмөр. Кливленд: World Publishing.

А. Хүний нөөцийн удирдлагын дутагдал:

А1.Цалин, тэтгэмжийн хэмжээ хангалтгүй.

А2.Мэргэжлийн хөгжил, сургалтын боломж хязгаарлагдмал.

А3.Ажилтны эрүүл мэнд, сэтгэл зүйн дэмжлэг хангагдахгүй байна.

А4.Ажилтны оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ дутагдаж байна.

Б. Ажиллах нөхцөлийн асуудал:

Б1.Ажиллах цаг хугацааны тогтворгүй байдал.

Б2.Аюулгүй байдлын стандарт хангагдахгүй байна.

Б3.Гэр бүлээсээ хол байх нь сэтгэл зүйн дарамт үүсгэж байна.

Б4.Ажлын орчны тоног төхөөрөмж хангалтгүй.

В. Нийгмийн баталгааны дутагдал:

В1.Тэтгэвэр, даатгалын систем хангалтгүй.

В2.Гэр бүлийн халамж, дэмжлэг хангагдахгүй байна.

В3.Нийгмийн халамжийн хөтөлбөрүүд хилчдэд чиглээгүй.

3. Асуудлын үр дагавар:

С. Хилчдийн сэтгэл зүйн байдалд сөргөөр нөлөөлөх:

С1.Сэтгэл зүйн дарамт, стресс нэмэгдэх.

С2.Ажилтны үнэнч байдал буурах.

С3.Ажилтны эргэлт нэмэгдэх.

Д.Албаны үр ашиг буурах:

Д1.Хилийн хамгаалалтын үйлчилгээний чанар буурах.

Д2.Албаны дотоод сахилга бат муудах.

Д3.Хилчдийн багийн ажиллагаа сулрах.

4. Шийдлийн чиглэл:

А. Хүний нөөцийн удирдлагыг сайжруулах:

А1. Цалин, тэтгэмжийг нэмэгдүүлэх.

А2. Мэргэжлийн хөгжил, сургалтыг нэмэгдүүлэх.

А3. Сэтгэл зүйн дэмжлэг, эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.

А4. Ажилтны оролцоог нэмэгдүүлэх.

Б. Ажиллах нөхцөлийг сайжруулах:

Б1. Ажиллах цаг хугацааг тогтворжуулах.

Б2. Аюулгүй байдлын стандартыг хангах.

Б3. Гэр бүлээ ойртуулах боломжийг бүрдүүлэх.

Б4. Ажлын орчны тоног төхөөрөмжийг сайжруулах.

В. Нийгмийн баталгааг бэхжүүлэх:

В1. Тэтгэвэр, даатгалын системийг сайжруулах.

В2. Гэр бүлийн халамж, дэмжлэгийг нэмэгдүүлэх.

В3. Хилчдэд чиглэсэн нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг боловсруулах.

5. Асуудлын модны дүгнэлт:

Хилчдийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийн асуудал нь олон хүчин зүйлээс үүдэлтэй бөгөөд эдгээр асуудлыг шийдвэрлэхэд хүний нөөцийн удирдлага, ажиллах нөхцөл,

нийгмийн баталгаа гэсэн гурван үндсэн чиглэлээр арга хэмжээ авах шаардлагатай байна. Эдгээр арга хэмжээг системчилсэн байдлаар хэрэгжүүлснээр хилчдийн ажиллах нөхцөл, сэтгэл зүйн байдал, нийгмийн баталгааг сайжруулж, улмаар албаны үр ашгийг дээшлүүлэх боломжтой.

Шийдлийн модны аргаар хилчдийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийн асуудлыг шийдвэрлэх

Шийдлийн модны арга нь асуудлын шалтгаан, үр дагаврыг тодорхойлсны үндсэн дээр шийдлийг системчилсэн байдлаар гаргахад тусалдаг. Энэ аргыг ашиглан хилчдийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийн асуудлыг шийдвэрлэх шийдлүүдийг боловсруулъя.

1.*Үндсэн асуудал:* Хилчдийн нийгмийн баталгаа хангагдахгүй байгаа нь тэдний ажиллах нөхцөл, сэтгэл зүйн байдалд сөргөөр нөлөөлж байна.

2. Шийдлийн модны бүтэц:

Үндсэн зорилго: Хилчдийн нийгмийн баталгааг сайжруулах, ажиллах нөхцөлийг тогтвортой болгох.

Шийдлийн үндсэн чиглэлүүд:

Хүний нөөцийн удирдлагыг сайжруулах.

Ажиллах нөхцөлийг сайжруулах.

Нийгмийн баталгааг бэхжүүлэх.

3. Шийдлийн модны нарийвчилсан салбарууд:

А. Хүний нөөцийн удирдлагыг сайжруулах:

А1. Цалин, тэтгэмжийг нэмэгдүүлэх:

А1.1. Хилчдийн цалинг салбарын дунджаас дээш түвшинд хүргэх.

А1.2. Нэмэлт тэтгэмж, урамшуулал олгох.

А2. Мэргэжлийн хөгжил, сургалтыг нэмэгдүүлэх:

А2.1. Тогтмол мэргэжлийн сургалт, семинар зохион байгуулах.

А2.2. Хилчдэд шинэ ур чадвар эзэмшүүлэх.

А3. Сэтгэл зүйн дэмжлэг, эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх:

А3.1. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлэх.

А3.2. Эрүүл мэндийн даатгалыг хангах.

А4. Ажилтны оролцоог нэмэгдүүлэх:

А4.1. Шийдвэр гаргах үйл явцад хилчдийг илүү их оролцуулах.

А4.2. Санал хүсэлтийн системийг боловсронгуй болгох.

Б. Ажиллах нөхцөлийг сайжруулах:

Б1. Ажиллах цаг хугацааг тогтворжуулах:

Б1.1. Ажлын цагийг уялдуулан зохицуулах.

Б1.2.Амралт, чөлөөлөх хугацааг тогтмолжуулах.

Б2. Аюулгүй байдлын стандартыг хангах:

Б2.1.Хилийн хамгаалалтын ажлын байранд аюулгүй байдлын шаардлагыг нэмэгдүүлэх.

Б2.2.Хамгаалалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх.

Б3.Гэр бүлээ ойртуулах боломжийг бүрдүүлэх:

Б3.1.Гэр бүлээ ойртуулах тэтгэмж, туслалцаа үзүүлэх.

Б3.2. Гэр бүлтэйгээ уулзах тусгай хугацааг олгох.

Б4.Ажлын орчны тоног төхөөрөмжийг сайжруулах:

Б4.1.Хилийн хамгаалалтын бааз, хэрэгслийг шинэчлэх.

Б4.2.Орчин үеийн технологийг нэвтрүүлэх.

В. Нийгмийн баталгааг бэхжүүлэх:

В1.Тэтгэвэр, даатгалын системийг сайжруулах:

В1.1. Хилчдэд зориулсан тусгай тэтгэвэр, даатгалын хөтөлбөрийг боловсруулах.

В1.2.Тэтгэврийн хуримтлалыг нэмэгдүүлэх.

В2.Гэр бүлийн халамж, дэмжлэгийг нэмэгдүүлэх:

В2.1.Гэр бүлд чиглэсэн тэтгэмж, туслалцаа үзүүлэх.

В2.2.Хүүхэд асрах, боловсролын туслалцааг нэмэгдүүлэх.

В3.Хилчдэд чиглэсэн нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг боловсруулах:

В3.1. Хилчдийн эрүүл мэнд, боловсролыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.

В3.2.Нийгмийн халамжийн сангуйг боловсронгуй болгох.

4. Шийдлийн модны дүгнэлт:

Шийдлийн модны аргаар хилчдийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг сайжруулах асуудлыг шийдвэрлэхэд дараахь чиглэлүүдээр арга хэмжээ авах шаардлагатай байна:

Хүний нөөцийн удирдлагыг сайжруулах (цалин, сургалт, сэтгэл зүйн дэмжлэг).

Ажиллах нөхцөлийг тогтвортой болгох (аюулгүй байдал, гэр бүлээ ойртуулах, тоног төхөөрөмж).

Нийгмийн баталгааг бэхжүүлэх (тэтгэвэр, даатгал, нийгмийн халамж).

Эдгээр арга хэмжээг системчилсэн байдлаар хэрэгжүүлснээр хилчдийн ажиллах нөхцөл, сэтгэл зүйн байдал, нийгмийн баталгааг сайжруулж, улмаар албаны үр ашгийг дээшлүүлэх боломжтой.

Дүгнэлт

Хилчдийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг сайжруулах асуудал нь улс орны аюулгүй байдал, тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм. Энэхүү судалгааны ажилд хүний нөөцийн удирдлагын онол, хөдөлмөрийн урам зоригийн онолуудыг ашиглан хилчдийн ажиллах нөхцөл, сэтгэл зүйн байдал, нийгмийн баталгааг сайжруулах арга хэмжээг боловсруулсан.

Судалгааны үр дүнгээс харахад хилчдийн нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцөлийг тогтвортой болгохын

тулд дараах чиглэлээр арга хэмжээ авах шаардлагатай байна:

Хүний нөөцийн удирдлагыг сайжруулах: Цалин, тэтгэмжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн хөгжил, сургалтыг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн дэмжлэг, эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, ажилтны оролцоог нэмэгдүүлэх.

Ажиллах нөхцөлийг тогтвортой болгох: Ажиллах цаг хугацааг тогтворжуулах, аюулгүй байдлын стандартыг хангах, гэр бүлээ ойртуулах боломжийг бүрдүүлэх, ажлын орчны тоног төхөөрөмжийг сайжруулах.

Нийгмийн баталгааг бэхжүүлэх: Тэтгэвэр, даатгалын системийг сайжруулах, гэр бүлийн халамж, дэмжлэгийг нэмэгдүүлэх, хилчдэд чиглэсэн нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг боловсруулах.

Эдгээр арга хэмжээг системчилсэн байдлаар хэрэгжүүлснээр хилчдийн ажиллах нөхцөл, сэтгэл зүйн байдал, нийгмийн баталгааг сайжруулж, улмаар хилийн хамгаалалтын албаны үр ашгийг дээшлүүлэх боломжтой.

Санал

1. Цалин, тэтгэмжийг нэмэгдүүлэх: Хилчдийн цалинг салбарын дунджаас дээш түвшинд хүргэх, нэмэлт тэтгэмж, урамшуулал олгох.
2. Мэргэжлийн хөгжил, сургалтыг нэмэгдүүлэх: Тогтмол мэргэжлийн сургалт, семинар зохион байгуулах, шинэ ур чадвар эзэмшүүлэх.
3. Сэтгэл зүйн дэмжлэг, эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх: Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлэх, эрүүл мэндийн даатгалыг хангах.
4. Ажилтны оролцоог нэмэгдүүлэх: Шийдвэр гаргах үйл явцад хилчдийг илүү их оролцуулах, санал хүсэлтийн системийг боловсронгуй болгох.
5. Ажиллах цаг хугацааг тогтворжуулах: Ажлын цагийг уялдуулан зохицуулах, амралт, чөлөөлөх хугацааг тогтмолжуулах.
6. Аюулгүй байдлын стандартыг хангах: Хилийн хамгаалалтын ажлын байранд аюулгүй байдлын шаардлагыг нэмэгдүүлэх, хамгаалалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх.
7. Гэр бүлээ ойртуулах боломжийг бүрдүүлэх: Гэр бүлээ ойртуулах тэтгэмж, туслалцаа үзүүлэх, гэр бүлтэйгээ уулзах тусгай хугацааг олгох.
8. Ажлын орчны тоног төхөөрөмжийг сайжруулах: Хилийн хамгаалалтын бааз, хэрэгслийг шинэчлэх, орчин үеийн технологийг нэвтрүүлэх.
9. Тэтгэвэр, даатгалын системийг сайжруулах: Хилчдэд зориулсан тусгай тэтгэвэр, даатгалын хөтөлбөрийг боловсруулах, тэтгэврийн хуримтлалыг нэмэгдүүлэх.
10. Гэр бүлийн халамж, дэмжлэгийг нэмэгдүүлэх: Гэр

бүлд чиглэсэн тэтгэмж, туслалцаа үзүүлэх, хүүхэд асрах, боловсролын туслалцааг нэмэгдүүлэх.

11. Хилчдэд чиглэсэн нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг боловсруулах**:** Хилчдийн эрүүл мэнд, боловсролыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, нийгмийн халамжийн сангуйг боловсронгуй болгох.

12. Эдгээр саналуудыг хэрэгжүүлснээр хилчдийн ажиллах нөхцөл, сэтгэл зүйн байдал, нийгмийн баталгааг сайжруулж, хилийн хамгаалалтын албаны үр ашгийг дээшлүүлэх боломжтой болно.

Эх сурвалж

Херцберг, Ф. (1966). Хүний мөн чанар ба хөдөлмөр. Кливленд: World Publishing.

Хакман, Ж. Р., & Олдхам, Г. Р. (1976). Ажлын дизайнаар урам зориг олгох: Онолын туршилт. Organizational Behavior and Human Performance, 16(2), 250-279. https://doi.org/10.1016/0030-5073(76)90016-7

Армстронг, М. (2020). Хүний нөөцийн удирдлагын практикийн Армстронгийн гарын авлага (15-р хэвлэл). Kogan Page.

Маслоу, А. Х. (1943). Хүний урам зориг: Онол. Psychological Review, 50(4), 370-396. https://doi.org/10.1037/h0054346

Роббинс, С. П., & Жадж, Т. А. (2019). Байгууллагын үйл ажиллагаа (18-р хэвлэл). Pearson.

Деси, Э. Л., & Райан, Р. М. (1985). Хүний зан үйлийн дотоод урам зориг ба өөрийгөө тодорхойлох. Plenum Press.

Монгол Улсын Засгийн газар. (2020). Хилийн хамгаалалтын тухай хууль. Улаанбаатар:

Монгол Улсын хууль зүйн мэдээллийн институт.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага. (2021). Ажлын байран дахь сэтгэл зүйн эрүүл мэнд. https://www.who.int/mental_health

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага. (2019). Нүүдэлч ажилчдад зориулсан нийгмийн хамгаалал. https://www.ilo.org

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. (2021). Нийгмийн хамгааллын тухай үндэсний тайлан. Улаанбаатар: Засгийн газрын хэвлэлийн газар.

БҮСИЙН НУТГИЙН ХАНГАЛТЫН ТӨВ БААЗ БАЙГУУЛАХ, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Л.Лхагвасүрэн
Ар тал, эдийн засгийн тэнхимийн дэд профессор, докторант, дэд хурандаа

Товч агуулга: Хилийн цэргийн анги салбаруудын бүх төрлийн хангалтын үйл ажиллагаа нь уламжлагдаж ирсэн цэргийн хангалтын системийн дагуу зохион байгуулж байна. Иймээс хангалтын зохион байгуулалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах хэрэгцээ шаардлага тулгарч үүний дагуу хил хамгаалах байгууллагаас 2010 оноос эрчимтэйгээр бүсчилсэн хил хамгаалалт руу шилжүүлсээр байна. Энэ нь цэргийн хангалтыг зохион байгуулах бүсийн хангалтын төв баазын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хилийн цэргийн анги, салбарт үүрэг гүйцэтгэж байгаа хилчдийн хангалтыг илүү найдвартай түргэн шуурхай олгоход чиглэх, хангалтыг илүү нарийвчлалтайгаар бүс нутагт нь тохируулан зохион байгуулахад судалгааны ажил чиглэсэн болно. Судалгааны ажлын арга зүй: Баримт материалыг цуглуулах, харьцуулах, нэгтгэн дүгнэх арга ашиглав. Судалгааны үр дүн: Судлаач миний судалгааны ажилд Хилийн цэргийн 0243 дугаар ангийн 0281, 0282, 0284 дүгээр салбарын хариуцсан хэсэгт байрлах 3 малын суурийн 1500 гаруй малаас Ангус, Монгол, Сарлаг, Эрлийз үхрүүдийн ашиг шим, зарцуулалтын талаар харьцуулалтыг судалж, үр дүнг харуулахыг зорьсон болно.

Түлхүүр үгс: Мал, фермер, салбар, ар тал, хангалт

Удиртгал

Монгол Улсын газар зүй, нийгэм, эдийн засгийн онцлог, улсын хил дээр гарч буй зөрчлийн хэлбэр, шалтгаан нөхцөлийг үндэслэн улсын хил хамгаалалтыг говь цөл, тал хээр, ой тайга, уулын болон усан гэж бүсчилсэн улсын хил хамгаалалтыг зохион байгуулах болсон. “Хилийн нөхцөл байдал байгаль, газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан улсын хил хамгаалалтыг ялгавартайгаар зохион байгуулахыг бүсчилсэн хил хамгаалалт”(Монгол улсын хилийн тухай хууль, 2017) гэнэ гэж заасан байдаг. Монгол Улсын хил хамгаалалтыг найдвартай хамгаалахын үндсэн баталгааны нэг нь хил хамгаалах байгууллагын ар тал хангалтыг хил хамгаалах байгууллагын алба, үйл ажиллагааны бэлэн байдлыг өндөр түвшинд байлгах, цагийн байдал өрнөсөн үед хурдан шуурхай маневр, материал хэрэгслийн хангалтыг тасралтгүй, шуурхай хангах ар талын удирдлага зохион байгуулалт, төлөвлөлтийг нарийвчлалтай


хийх явдал өнөөгийн нөхцөл байдал биднээс шаардаж байна.

Цэргийн аж ахуй гэдэг нь хилийн цэргийн анги, цэргийн ангиудын улсын хил хамгаалах үйл ажиллагаа, албаны бэлтгэл, нийт бүрэлдэхүүний материаллаг ахуй, соёлын хэрэгцээг тасралтгүй бүх талаар хангах, зэвсэг техник, галт хэрэглэл, шатахуун, бусад материал хэрэгслийг зөв ашиглах, арчлан хамгаалахад зориулагдсан материал хэрэгслийн зохих нөөц бүхий аж ахуй, техник, эмнэлгийн болон албаны бэлтгэл сургуулийн материал-техникийн бааз юм.

Цэргийн аж ахуйн үндсэн үүрэг нь хилийн цэргийн анги хил хамгаалах болон албаны бэлэн байдлыг байнга өндөр хэмжээнд байлгаж, тайван цагийнхаас онцгой байдалд түргэн шилжих бүх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Бүсчилсэн хил хамгаалалттай уялдуулан ар тал хангалтын удирдлагын төлөвлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлс, тэдгээрт хийсэн дүн шинжилгээ

Хилийн болон хил орчмын аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтыг удирдан зохион байгуулахад хилийн тодорхой хэсэг газрыг тодорхойлох үндсэн нутаг дэвсгэр нь бүсийн орон зай буюу тухайн нутаг дэвсгэрийн байгаль, цаг уур физик газар зүй, бүсийн онцлог, хүн амын зан заншил, мал амьтны маллагаа хариулаг, ан амьтан, нийгэм, эдийн засгийн байдал, дэд бүтцийн хөгжил, хил худалдааны орчин зэрэг нь харилцан адилгүй байдаг тул цэргийн хангалтыг удирдан зохион байгуулахад нөлөөлөх үндсэн нөхцөл, байгаль цаг улиралд зохицсон хүнс, хувцас, хүн мал эмнэлгийн хангалт үйлчилгээ бий болгохыг шаардаж байгаа бөгөөд дараах бүсүүдэд хуваан авч үзэж байна. Цэргийн хангалт, цэргийн аж ахуйг удирдан зохион байгуулна түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх нь Хилийн цэргийн алба хаагчдын нийгмийн баталгаа нэмэгдүүлж алба хаах таатай орчныг бүрдүүлэх үндсэн гол чиглэл болж байдаг ийм тулд Хилийн цэргийн анги салбарт байгаа малын суурийн малын ашиг шим гарцыг судлахад дараах байдлаар ажиглагдаж байна. Үүнд нь Монгол үхрийн махыг ангус, эрлийз үхэр, сарлаг, монгол үхэр зэргийг харьцуулан судаллаа



Зураг №1.Монголын малын бүтээгдэхүүний гарц

Өсөлтийн зарим дундаж үзүүлэлтийг дурдвал: эр Ангус 33 кг жинтэй төрж, 200 хоногийн дотор 250 кг, 365 хоногийн дараа 380 кг жинтэй, эм нь 30 кг жинтэй төрж, 200 хоногт 230, 365 хоногт 330 кг болно. Нас бие гүйцсэн бух 800-1100 кг, үнээ 550-700 кг татах ба сэрвээний өндөр нь бух 135-150, үнээ 120-140 см.

Монгол үүлдрийн үхрийн биеийн жин тухайн жилийн өвөлжилт, зуншлагын байдлаас хамааран харилцан адилгүй байдаг ч дунджаар ойт-хээрийн бүсэд нас гүйцсэн бух 360-400 кг, үнээ 280-320 кг, эр шүдлэн 200-230 кг, охин шүдлэн 180-200 кг, эр бяруу 140-170 кг, тугал эхээс төрөхдөө 16-18 кг, 6-7 сартайд 70-100 кг байна. Алтайн уулархаг нутаг, говийн бүсийн монгол үхэр арай бага жинтэй, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Төв аймгийн үхэр бусад нутгийнхаас 15.0-20.0 хувь илүү жинтэй байна.

Шахаж бордсон үхрийн нядалгааны гарц 65-70%. Яс нимгэнтэй учраас гулуузан дахь ясны харьцангуй хувь 15-18%-с хэтэрдэггүй. Махны чанарын үзүүлэлтээр дээд зэрэгт тооцогддог. Булчингийн ширхэг нарийхан, махны алаглалаар Шортгорн, Герефорд үхрээс ч илүү юм.

Тал хээрийн бүс: Хилийн ... отряд ... застав, ... харуулын хариуцсан ..... км хэсэг буюу улсын хилийн 22.5 хувь хамрагдана.

Говь цөлийн бүс: Хилийн .... отряд, ... застав, ... харуулын хариуцсан ..... км хэсэг буюу улсын хилийн 26,0 хувь хамрагдана.

Уулын бүс: Хилийн.... отряд, ... застав, ... харуулын хариуцсан

..... км хэсэг буюу улсын хилийн 24,0 хувь хамрагдана.

Ой тайгын бүс: Хилийн ...отряд, ... застав, ... харуулын хариуцсан ..... км хэсэг буюу улсын хилийн 27,5 хувь хамрагдана.

Дээрх бүсүүдийг Удирдах газрууд “Хилийн цэргийн анги, салбарын тоо, байршил, зэрэглэлийг хил залгаа улстай тэгш эрхтэй харилцан ажиллаж, улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах эрх ашигт нийцүүлэн тэдгээрийн хилийн анги, салбартай харьцангуй ижил хэмжээнд байх зарчим баримтлан” (Монгол улсын хилийн тухай хууль, 2017) тухайн бүс нутагтаа аж үйлдвэрлэл хөгжсөн, хамгаалж буй хэсгийнхээ аль болох төвд байрласан аймгуудыг сонгон авч бүсийн хангалтын баазыг байгуулах шаардлагатай байна.

a. Уулын бүсийг удирдах газрын төвлөрсөн хангалтын баазыг Ховд аймагт

b. Ой тайгын бүсийн удирдах газрын төвлөрсөн хангалтын баазыг Дархан-Уул аймагт

c. Говь цөлийн бүсийн удирдах газрын төвлөрсөн хангалтын баазыг Өмнөговь аймагт

d. Тал хээрийн бүсийн удирдах газрын төвлөрсөн хангалтын баазыг Дорнод аймаг зэрэг аймгуудад байгуулахын бол хангалтын тасралтгүй шуурхай байдал улам сайжрахаас гадна, шатахууны урсгал зардлыг ч хэмнэх боломжтой, хөрш орнуудын хил хамгаалах салбартай ижил хэмжээнд очиж, хил хамгаалалтын бодит үр дүн бий болно гэж үзэж байна.

Дээрх аймгуудад байгуулагдсан бүсийн удирдах газрын харьяа бүсийн хангалтын төв бааз нь биеэ даасан үйл ажиллагаа явуулан хилчдийн хангалтыг зохион байгуулахаас гадна тухайн байрлаж байгаа орон нутагтаа үйлдвэрлэгч болох хөрш отряд заставуудаа чанартай бүтээгдэхүүнээр хангах боломжтой гэж үзэж байна.

Жишээ нь: Сэлэнгэ аймаг нь газар тариалан голлон хөгжүүлсэн аймаг юм. Манай орны газар тариалангийн талбайн үлэмж хэсэг энэ аймгийн нутагт Орхон Сэлэнгийн савд төвлөрсөн юм. Улсын үр тарианы 40 орчим хувийг үйлдвэрлэдэг, 570,000 гаруй малтай. Сэлэнгэ аймагт мод боловсруулах, гурилын, хүнсний, спирт бал бурамын үйлдвэр, вагон засварын газар бий. Сүхбаатар хот нь төмөр ба авто замын гол зангилаа нутаг бөгөөд манай хилийн байнгын чухал гарцын нэг юм.

Тэгвэл Ой тайгын бүсийн хангалтын төв бааз нь энэ аймаг, орон нутаг болон хилийн цэргийн 0101, 0243 дугаар ангиудыг түшиглэн бэлчээрийн мал аж ахуйгаас эрчимжсэн мал аж ахуй руу шилжин махны чиглэлийн ангус үйлдвэрийн үхрийг үржүүлэн хөрш хилийн отрядууд,

хилчдийг хангахаас гадна орон нутагт чанартай хүнсний бүтээгдэхүүн зэргийг нийлүүлэх дотоод орлого бүрдүүлэх боломжтой юм.

Ангус үүлдрийн Шотландаас гаралтай энэ үүлдэр нь дэлхий дээр хамгийн их тархсан махны чиглэлийн шилмэл үүлдрийн нэг. Мөн дэлхий дээр анхнаасаа махны чиглэлээр дагнаж үржүүлсэн цорын ганц үүлдэр юм. Төрөлх өнгө нь хар боловч сүрэг дунд улаан өнгийн үхэр мэр сэр байх нь түгээмэл. Ангус үхэр бие даасан үүлдэр болж үүссэн 19-р зууны үед хар өнгө "моод"-нд орж байсан тул улаан өнгөтэй үхрийг тусад нь үржүүлсэнгүй, харин ч гадуурхах маягтай байв. Харин АНУ-д 1945 оноос улаан Ангус үхрийг тусад нь үржүүлж эхэлсэн байна. Ангус үхэр мухар, түргэн өсөлттэй, лагс биетэй, өргөн гүн цээжтэй, чац богинотой, толгой хөнгөн, хүзүү өргөн, богино, булчин их сайн хөгжсөн, хонгоны булчин борвио хүртэл унжсан, нимгэн, зөөлөн үсээр бүрхэгдсэн сийрэг арьстай. Өсөлт түргэнтэй нь хэдийгээр нэг талаар ашигтай боловч нөгөө талаар өөхлөлт эрт явагддаг сөрөг үр дагавартай.

Энэ мэтчилэн бүс тус бүр дээр байгуулагдсан хангалтын төв бааз нь өөрийн бүсэд байгаа хилийн отряд, заставынхаа хангалтыг хурдан шуурхай зохион байгуулахаас гадна, тухайн орон нутгийнхаа давуу байдлыг ашиглан орлого олох, олсон орлогоосоо хилийн застав, харуулын албаны байр, орон сууцыг засварлах тохижуулах, тог цахилгаангүй харуул, заставын шатахууны хангалтыг нэмж хангах ч боломжтой юм.

Хилийн отрядад ажиллаж байгаа офицер, ахлагч нар хүнс авдаггүй ба бүсийн хангалтын төв бааз нь хөндөлттэй үнээр тухайн хилийн отрядын алба хаагчдад мах, гурил, сүү өөрсдийн орлого олж байгаа бүтээгдэхүүнээ зарах зэрэг олон ашиг тус бий болно.

Хилчид бид бүхэн өөрсдийн хэрэгцээгээ хангахаас гадна үйлдвэрлэгч, бүтээгч болох бүрэн боломжтой байна.

Дүгнэлт

Хил хамгаалах байгууллагын ар тал хангалтыг бүсийн хангалтын бааз дээр тулгуурлан зохион байгуулах юм бол хангалтын хурдан, шуурхай байдал нэмэгдэхээс гадна жилийн урсгал зардлаас хэмнэх боломжтой байна. Энэ мэтчилэн хангалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулбал маш олон зүйлийг хэмнэх давуу талтайгаас гадна зарим хангагдаагүй бүтээгдэхүүнээр ч хилчдийг хангах бодит боломж бий болно гэж үзэж байна.

Судалгаанд бүсийн хангалтын төв бааз байгуулах нь зөвхөн нутгийн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэхээс гадна Хилийн цэргийн 0243 дугаар ангийн 0281, 0282, 0284 дүгээр салбаруудын хил хамгаалалтын бэлэн байдлыг хангах, хээрийн

хангалтын найдвартай эх үүсвэр бий болгох, мал аж ахуйн ашиг шимийг хил орчмын орон

нутгийн хөгжилд түлхүү хувь нэмэр оруулах үндсэн нөхцөл болохыг харуулсан юм.

Цаашид төвийн хангалтын бааз нь зөвхөн хангалт зохион байгуулахаас гадна, орлого олох томоохон зах зээлийн тоглогч болох болно.

Санал

Монгол Улсын хилийн тухай хуулийн 34.3 дахь заалтын дагуу Хилийн цэргийн анги, салбарын тоо, байршил, зэрэглэлийг хил залгаа улстай тэгш эрхтэй харилцан ажиллаж, улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах эрх ашигт нийцүүлэн тэдгээрийн хилийн анги, салбартай харьцангуй ижил хэмжээнд байх зарчим баримтлан Засгийн газар тогтооно гэсэн заалтын дагуу Бүсийн удирдах газар болон дэргэд нь Бүсийн хангалтын төв бааз байгуулах

- Хилийн отрядын мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуй руу шилжүүлэн орон нутагт өөрсдөө орлого олох боломжийг бүрдүүлэх зэрэг саналтай байна.

Эх сурвалж:

Баттөр, Б., & Эрдэнэчимэг, С. (2022). Монгол Улсын мал аж ахуйн үйлдвэрлэлийн ашиг шим. *Монголын агро шинжлэх ухааны сэтгүүл*, 34(2), 55-63.

Баярмаа, Н., & Жаргал, Р. (2020). Мал аж ахуйн бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн үр ашгийг сайжруулах нь. *Монгол улсын мал аж ахуйн сэтгүүл*, 12(1), 35-45.

Баттулга, Б. (2022). Хилийн ангиудын эрүүл мэндийн менежмент, түүний асуудлууд. Улаанбаатар: Батлан хамгаалах их сургууль.

Батлан хамгаалахын логистикийн агентлаг. (2022). 2022 оны жилийн тайлан. https://www.dla.mil сайтаас авсан.

Болд, Д. (2021). Ангус болон Монгол үүлдрийн үхрийн үйлдвэрлэлийн харьцуулалт. *Ази тивийн мал аж ахуйн судалгаа*, 29(4), 122-130.

Гантулга, С. (2022). Монгол малын генетик судалгаа болон үржлийн сайжруулалт. *Мал аж ахуйн шинжлэх ухаан*, 18(3), 78-89.

Ганболд, Н. (2023). Хилийн хамгаалалтын судалгааны судалгаа. Улаанбаатар: Үндэсний батлан хамгаалахын их сургууль.

Дорж, Т., & Батсүх, Т. (2023). Үүлдрийн ашиг шимийг сайжруулах стратеги. *Мал аж ахуйн судалгааны сэтгүүл*, 45(1), 15-23

ХИЛИЙН БООМТЫН ХӨГЖИЛ БА ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Б.Мөнгөнбагана
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Хилийн албаны тэнхимийн профессорын үүргийг түр орлон гүйцэтгэгч, дэд хурандаа

Товч агуулга: Коронавирусын халдварт цар тахлын дэгдэлтийн үед улс орнууд улсын хилээр нэвтрэх хөдөлгөөнийг хэсэгчилсэн байдлаар хязгаарласан нь эдийн засагт сөргөөр нөлөөлж дэлхийн улс орнуудын төр засгаас хилийн боомтын дэд бүтцийг хөгжүүлж, нэвтрүүлэх чадамжийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэхийн тулд тодорхой бодлого барьж ажилласан нь үр дүнгээ өгч байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн "Алсын хараа-2050" "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэхэд гадаад орнуудын туршлагыг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай.

Түлхүүр үгс: Хилийн боомт, дэд бүтэц, нэвтрүүлэх чадамж,

Удиртгал

Дэлхий нийтийг түгшээсэн коронавирусын халдварт цар тахлын дэгдэлт нь дэлхийн улс орнуудын эдийн засаг, аялал жуулчлал, худалдаа, тээвэр, үйлчилгээ зэрэг бүхий л салбарын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, учруулсан хохирлын хэмжээ нь олон тэр бум америк доллароор хэмжигдэж байна.

Дэлхийн эрүүл мэндээс байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу улс орнууд 2020-2022 онд улсын хилээр нэвтрэх хөдөлгөөнийг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар хязгаарласан нь эдийн засагт сөргөөр нөлөөлж хилийн боомтын хүчин чадал эдийн засагт чухал нөлөөтэй болохыг батлан харуулснаар боомтын дэд бүтцийг хөгжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой бодлого боловсруулан хэрэгжүүлэх хөшүүрэг болсон[1].

Коронавирусын халдварт цар тахлын Монгол Улс эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн суурийг тэлэх, "Алсын хараа-2050"[2] Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор "Шинэ сэргэлтийн бодлого"[3]-ыг Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

[1] Интерфакс. ВОЗ рекомендовала отменить ограничения на международные поездки. 20 января 2022.

[2] "Алсын хараа-2050". 2020.

[3] "Шинэ сэргэлтийн бодлого". 2021.

"Шинэ сэргэлтийн бодлого"-ын нэгдүгээр багц асуудал болох "Боомтын сэргэлт"-ийн хүрээнд хилийн боомтуудын дэд бүтцийг хөгжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаануудыг төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь илтгэлээр дэвшүүлсэн асуудалтай уялдаж байгаа ба Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль[1], Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал[2], Монгол Улсын хилийн тухай хууль[3], Төрөөс хилийн талаар баримтлах бодлого[4]-д тусгалаа олсон байдаг.

Эрх зүйн актууд болон урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан хилийн боомтын дэд бүтцийг хөгжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэхийн тулд дэлхийн бусад улс орнуудын төр засгаас хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр барьж буй бодлого, ололт амжилт, тэргүүн туршлагыг судлах нь "Боомтын сэргэлт"-ийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал түлхэц болно гэж үзсэн.

Үндсэн хэсэг

Дэлхийн улс орнууд эдийн засгийн тогтвортой байдлаа хадгалах, эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй цогц бодлогуудыг судлахад дараах үндсэн чиглэлүүдэд төвлөрч байна. Үүнд:

1. Хилийн боомтуудыг шинээр барих, өргөтгөх, тохижуулах замаар дэд бүтцийг хөгжүүлж, хилийн хяналтын байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай албаны байр, объектууд, хяналт шалгалт явуулах цэгийн тоо, талбайн хэмжээг нэмэгдүүлэх, боомтын аюулгүй байдлыг найдвартай хангасан дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, хяналт шалгалтын хамгийн орчин үеийн систем, төхөөрөмж, техникээр хангах чиглэлээр маш их төсөв хөрөнгө, зардал, цаг хугацаа шаардсан урт хугацааны хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна.

2. Зорчигчдод түргэн шуурхай үйлчлэх, аюулгүй байдлыг хангах зорилгоор "Ногоон гарц" буюу биометрийн технологийг хилийн шалгалтад нэвтрүүлэн ашиглаж байна . Паспортын шалгалтын автомат систем, кабинуудыг төхөөрөмжлөн ашигласнаар зорчигчид автоматжуулсан өөртөө үйлчлэх системээр түргэн хугацаанд тав тухтайгаар үйлчлүүлэх боломжийг олгож, шалгагчид ирэх ачааллыг

[1] Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. 2001.
[2] Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010.
[3] Монгол Улсын хилийн тухай хууль. 2016.
[4] Төрөөс хилийн талаар баримтлах бодлого. 2002.

тодорхой хувиар бууруулах, шалгалтад зарцуулах цаг хугацааг багасгахад онцгой үүрэг гүйцэтгэж байна.

3. Дэлхийн улс орнууд хилийн хяналтын байгууллагуудад ашиглагддаг программ, системийг ижилсүүлэн нэгтгэж хяналт шалгалтын давхардлыг арилгах замаар хяналт шалгалтад зарцуулах хугацааг багасган ажиллаж байна.

4. Зорчигчоос хилийн шалгалтад зориулан паспорт болон гаалийн мэдүүлгийн мэдээллээ урьдчилан оруулах боломжийг хангасан гар утасны аппликейшний хэрэглээг дэлхийн зарим улс орон албан ёсоор нэвтрүүлж эхэлсэн.

Боомтын дэд бүтцийг хөгжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэхийн тулд дэлхийн бусад улс орнуудын төр засгаас хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой бодлого баримтлан хэрэгжүүлж байна.

ОХУ нь улс төр, эдийн засгийн хүнд нөхцөлд гадаад орнуудын төр засгаас авч хэрэгжүүлж буй хориг арга хэмжээний нөлөөг бууруулахын тулд боомтуудынхаа дэд бүтцийг хөгжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн бодлогоо хэрэгжүүлж, томоохон ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа нь зайлшгүй судалж туршлага судлах шаардлагыг бий болгож байгаа юм.

ОХУ-ын засгийн газраас боомтын дэд бүтцийг хөгжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр “Гадаад эдийн засгийн үйл ажиллагааны хөгжил”[1] хөтөлбөрийг ОХУ-ын Засгийн газрын 2014 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн №330 дугаар тогтоолоор батлаж, Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн тогтоолоор шинэчлэн баталсан. Хөтөлбөрийг 2013-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Уг хөтөлбөрт үндсэн 2 гол зорилгыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

1. ОХУ-ыг дэлхийн хүчирхэг эдийн засагтай 5 орны тоонд багтаах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалан эдийн засгийн өсөлтийг дэлхийн түвшнээс дээш хангах, инфляцын түшинг 4 хувиас ихгүй байлгах;

2. Боловсруулах үйлдвэрлэл, газар тариалан зэрэг эдийн засгийн үндсэн салбаруудад орчин үеийн технологийг нэвтрүүлэх, өндөр чадвартай боловсон хүчнээр хангах, үйлдвэрлэл, экспортод чиглэсэн салбаруудыг бий болгох;

[1]Постановлением Правительства Российской Федерации от 15 апреля 2014 г. № 330 (в редакции постановления Правительства Российской Федерации от 31 марта 2021 г. № 508) утверждена государственная программа «Развитие внешнеэкономической деятельности»

ОХУ-д “Олон Улсын кооперац ба экспорт” үндэсний хөтөлбөрийг 2019-2024 хэрэгжүүлж байна[1]. Энэ хөтөлбөрийг хэрэгжилтийг хангах хүрээнд ОХУ-ын хилийн боомтуудыг барих, өргөтгөх, тохижуулах техник, хэрэгслээр хангах төслүүдийг хэрэгжүүлж байна. Төслүүдийн гол зорилго нь хилийн аюулгүй байдлыг хангах, хилийн объектын орчин үеийн дүр төрхийг бий болгох, хилийн боомтын дэд бүтцийг сайжруулах, хөгжүүлэх, шалгалтын үйл ажиллагааны хугацааг багасгах, тав тухтай нөхцөлийг бүрдүүлэхэд оршиж байна.

Үндэсний “Международная кооперация и экспорт” төслийн бүрдэл хэсэг болох холбооны зорилтот “Развитие внешнеэкономической деятельности” төсөл, холбооны “Логистика международной торговли” төслийн хүрээнд хийж гүйцэтгэж байна.

ОХУ-ын төр засгаас хилийн боомтуудын дэд бүтцийг хөгжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, сайжруулахад зориулагдсан санхүүжилтэд 2017-2022 он хүртэл жил бүр 9-10 тэрбум рубль төсөвлөдөг байсан бол 2023 онд 25 тэрбум, 2024-2027 он хүртэл жил бүр 35 тэрбум рубль байхаар тооцож нэмэгдүүлсэн байна.

2020 онд хэрэгжүүлсэн төслүүдээс Астрахань мужид байрлах тэнгисийн худалдааны Оля боомтыг нэрлэж болно. Уг объектод 2020 оны намраас хилийн хяналтын байгууллагууд улсын хилээр тээврийн хэрэгсэл, ачаа, барааг шалган нэвтрүүлж эхэлсэн.

Өргөтгөлийн ажлын хүрээнд албаны байр, авто тээврийн шалган нэвтрүүлэх боомтын байр, албаны нохойн байр, автомашины гараж, тээврийн хэрэгслийн шалгах талбайн саравч, автомашины жин зэргийг байгуулж, хилийн болон гаалийн шалгалтын хамгийн орчин үеийн системээр тоноглосон ба нийт гүйцэтгэсэн ажлын талбай 3000м^2 болсон.

Оля боомтыг өргөтгөснөөр түүний ачаа, бараа нэвтрүүлэх чадварыг жилд 1 сая тонноос 11 сая тонн болгон нэмэгдүүлсэн. Нэг талбайд хилийн хяналтын байгууллагуудыг тав тухтай байрлах нөхцөлийг бүрдүүлсэн. Шинэ төхөөрөмжүүдийг үйл ажиллагаанд нэвтрүүлснээр улсын хилээр нэвтрэх зорчигч, ачаа барааг шалгах үйл ажиллагаа шуурхай болгосон.

2020 оны эхний хагас жилд үндэсний төслийн хүрээнд “Саратов” агаарын хилийн боомтын техник хэрэгслийг сайжруулах ажлыг гүйцэтгэсэн. Паспортын шалгалтын 32 кабин,

[1] На основе паспортов национальных проектов, утвержденных президиумом Совета при Президенте Российской Федерации по стратегическому развитию и национальным проектам 24 декабря 2018 г.

автоматжуулсан ажлын байр бий болгож орчин үеийн дэвшилтэт өндөр технологийн системийг нэвтрүүлснээр хилийн боомтод хил, гаалийн болон бусад шалгалтыг явуулахад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлж, нэвтрүүлэх чадварыг 640 зорчигч/цаг болгон нэмэгдүүлсэн.

2021 онд ОХУ-ын Калининград мужийн Литва Улстай хиллэдэг хэсэгт авто замын олон урсгалт "Дубки" шалган нэвтрүүлэх боомтыг шинээр нээн ажиллуулсан нь ОХУ-ын хамгийн том боомтуудын нэг болсон. Тус боомт нь хоногт 4000 тээврийн хэрэгсэл, 15000 зорчигчийг шалган нэвтрүүлэх хүчин чадалтай, шалгалтын 49 урсгалтай. Үүнээс ачааны болон том оврын авто тээврийн хэрэгслийн 27, суудлын авто тээврийн хэрэгслийн 20, автобусанд зориулсан 2 урсгалтай. Боомтын авто зогсоол нь 2 автобус, 20 ачааны автомашин, 25 суудлын тэргээр дүүргэлт хийх хүчин чадалтай[1].

Хилийн боомтод ачаа тээвэрлэгч чингэлгийг онгойлгохгүйгээр зайнаас үзлэг шалгалт хийх зориулалттай суурин төхөөрөмжөөр тоноглосон нь декларацад мэдүүлээгүй болон зэвсэг, тэсрэх бодис, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх зэрэг хориотой бодисыг илрүүлэх, төмрийг нэвт харж операторын сонголтоор ачааны жинг бүхэлд нь, эсвэл тодорхой хэсгийн жинг тодорхойлох чадвартай. Өндөр технологийн уг төхөөрөмжийг ашиглах нь хяналт шалгалтын үр дүн, улсын хилээр нэвтрүүлэх хурдыг нэмэгдүүлэх, улсын аюулгүй байдалд хохирол учруулалгүйгээр гадаад эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч талуудад таатай нөхцөлийг бий болгох давуу талтай.

"Шинэ төрлийн коронавирусын халдвар ОХУ-ын нутаг дэвсгэрт тээвэрлэгдэн орж ирэх, тархахаас урьдчилан сэргийлэх" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Роспотребнадзороос суурин болон зөөврийн дулаан мэдрэгч төхөөрөмжөөр тоноглох зайлшгүй шаардлагатай хилийн 140 шалган нэвтрүүлэх боомтын жагсаалтыг гаргасан.

Суурин төхөөрөмж нь хөдөлгөөний урсгалд биеийн өндөр халуун хэмтэй хүнийг илрүүлэх, зөөврийн төхөөрөмж нь улсын хилээр нэвтэрч байгаа зорчигчийг нэг бүрчлэн шалгахад ашиглаж байна. Мөн түүнчлэн агаарын хөлөгт суурилуулан ашиглах боломжтой.

Эхний байдлаар "Внуково", "Шереметьево", "Домодедово" нисэх буудлын хилийн боомтуудад суурилуулан

[1] Интерфакс россия. Новый пункт пропуска на границе России и Литвы полностью решит проблему очередей - власти Калининградской области. 12 мая 2022 г.

ашиглаж байна. Энэ төхөөрөмж нь өндөр технологиор бүтээгдсэн, өндөр мэдрэмтгий, алсын зайнаас биеийн хэм өндөр хүнийг илрүүлэн таних чадвартай, орчноос нөлөөлөх дулааны өөрчлөлтийг автоматаар тооцоолон бодох чадвартай.

Суурилуулахаар бэлтгэгдэж байгаа төхөөрөмж нь ОХУ-д зохион бүтээгдсэн, 2014 онд Сочи хотод зохион байгуулагдсан олимпын тоглолт болон 2018 оны хөл бөмбөгийн дэлхийн аваргын тэмцээний үеэр амжилттай туршигдсан. 2020 оны сүүлээр автозам, төмөр зам, усан боомтуудад нэвтрүүлэхээр төлөвлөгдсөн. Ингэснээр ОХУ-ын нутаг дэвсгэрт коронавирусын болон бусад халдвар өвчин нэвтрэхээс урьдчилан сэргийлэх чадварыг нэмэгдүүлэхээр тооцсон.

Мөн түүнчлэн 2021-2023 онд үндсэн чиглэлийн агаарын замын Махачкала /Уйташ/, Челябинск /Баландино/, Калининград /Храброво/, Москва /Домодедово/, Саранск и Кызыл; автомобильных Советск /Дубки/, Кяхта; морского Ванино боомтуудын өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

ОХУ-ын Ерөнхийлөгч болон Засгийн газраас өгсөн үүргийн дагуу тээвэрлэлтийн хязгаарлалтыг бууруулж, нэвтрүүлэх чадлыг нэмэгдүүлэх, аюулгүй байдал, хамгаалалтыг сайжруулах зорилгоор Ростов, Крым мужид байрлах боомтуудыг сайжруулах ажлыг гүйцэтгэсэн.

2022 онд ОХУ-д нэгдэн орсон шинэ субъектүүд болох Донецк болон Луганскийн Бүгд Найрамдах Улсууд, Запорож болон Херсон мужуудад байрлах нийт 15 хилийн боомтуудаас 10 хилийн боомтод дахин төлөвлөлтийн ажлыг гүйцэтгэснээр нэвтрүүлэх хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлсэн.

2022 онд 65 хилийн боомтуудыг иж бүрнээр тохижуулж, техник хэрэгслээр хангаж, хилийн хяналтын байгууллагуудыг тусгай хэрэгслээр хангасан нь 2017-2021 гүйцэтгэсэн ажилтай дүйцэж, 2023 онд 75 хилийн боомтыг иж бүрнээр тохижуулж, техник хэрэгслээр хангасан.

2024 оны байдлаар ОХУ-д 380 хилийн боомтоос 314 хилийн боомт хэвийн үйл ажиллагаа явуулж байгаагаас 87 хилийн боомтыг үндсэн чиглэлийн боомтоор тооцдог. Эдгээр боомтуудаар нийт зорчигч, ачаа тээврийн 65% бүрдүүлдэг тул эхний ээлжид дэд бүтцийг хөгжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлага тулгарсан.

Цаашид ажлын эрч хүчээ хадгалж, санхүүжилт хэвийн хийгдсэн тохиолдолд 2027 он гэхэд үйл ажиллагаагаа хэвийн явуулж буй хилийн боомтуудын 80 хувийн ажлыг гүйцэтгэх боломжтой. Мөн 2027 он гэхэд үндсэн чиглэлийн боомтуудыг

бүрэн хамруулахаар төлөвлөн ажиллаж байна[1].

Мөн түүнчлэн хилийн боомтуудын дэд бүтцийг хөгжүүлэхээс гадна эрх зүйн баримт бичгүүдийг боловсонгүй болгох чиглэлд онцгой анхаарал хандуулж байна.

ОХУ нь зүүн болон өмнөд чиглэлийн хилийн боомтуудын дэд бүтцийг хөгжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. Үүнд:

- Казакстан улстай хиллэдэг хэсэгт хилийн 50боомт хэвийн үйл ажиллагаа явуулж байна. Казакстаны талтай хамтран үндсэн чиглэлийн автозамын 10 боомтыг их бүрэн тохижуулахаар, бусад боомтуудын дэд бүтцийг сайжруулж 2027 онд дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

- Хятад улстай хиллэдэг хэсэгт 19 хилийн боомт хэвийн үйл ажиллагаа ялуулж байгаагаас 2022 онд ОХУ-ын төмөр замын томоохон боомтуудын нэг болох “Забайкальск” боомтод дахин төлөвлөлт хийсэн. Мөн түүнчлэн хил дамнасан төмөр замын гүүр болон “Нижнеленинское” хилийн боомтын хөдөлгөөнийг нээсэн. Автозамын “Забайкальск”, төмөр замын “Нижнеленинское”, “Махалино” боомтуудыг байнгын ажиллагаанд шилжүүлсэн. “Кани-Курган” автозамын боомт хэвийн үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр хилийн боомтуудын нэвтрүүлэх чадвар автозамын боомтуудад хоногт 800-1300 автомашин болж 500 автомашинаар, төмөр замын боомтуудад 45-59 цуваа болж 14 цуваагаар тус тус нэмэгдсэн.

- Монгол Улстай хиллэдэг хэсэгт байрлах 16 хилийн боомтоос 10 хилийн боомт хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа ба хилийн боомтуудын нэвтрүүлэх чадварыг 2 дахин нэмэгдүүлсэн.

- Орос-Азербайжаны хилийн хэсэгт 5 хилийн боомт үйл ажиллагаа явуулж байгаагаас 2023 онд хамгийн том боомт болох Яраг-Казмалярын дахин төлөвлөлтийн ажлыг гүйцэтгэсэн. “Яраг-Казмаляр” боомтын өргөтгөлийн ажлыг 2 үе шаттайгаар гүйцэтгэж, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний урсгалыг 10-аас 24 болгож, хамгийн орчин үеийн өндөр технологийн тоног төхөөрөмжийг нэвтрүүлснээр боомтын нэвтрүүлэх чадварыг 4,5 дахин нэмэгдүүлсэн[2].

- Орос-Гүржийн хилийн хэсэгт үйл ажиллагаа явуулдаг цорын ганц автозамын, ОХУ-ын хамгийн ачаалал ихтэй боомтуудын нэг болох "Верхний Ларс” авто замын боомтын

[1] https://mintrans.gov.ru/press-center/interviews/518

[2] Trans.ru: Пункт пропуска «Яраг-Казмаляр» на границе Дагестана с Азербайджаном полностью реконструируют в III квартале 2023 года. 03 марта 2023г.

өргөтгөлийн ажлыг 2023 онд гүйцэтгэж, боомтын зогсоолын багтаамж, хөдөлгөөний урсгалын тоог нэмэгдүүлснээр хоногт нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн тоог 9 дахин, зорчигчийн тоог 1.5 дахин нэмэгдүүлсэн. Эдгээр ажил нь Орос-Гүржийн улсын хилийн хэсэгт үүсдэг дарааллын асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байдаг.

Дүгнэлт

Дэлхийн улс орнууд хилийн боомтын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхийн тулд боомт шинээр барих, өргөтгөх, тохижуулах, хяналт шалгалтын хамгийн орчин үеийн систем, төхөөрөмж, техникээр хангах, хилийн шалгалтын үйл ажиллагааг хөнгөвчилсөн цахимжуулсан шийдлүүдийг нэвтрүүлж байгаа нь тодорхой үр дүнгээ өгсөөр байна.

Хилийн хяналтын байгууллагуудын хяналт шалгалт явуулах чадамж нь хүн хүчний хангалт, тэдний мэдлэг, мэргэжлийн ур чадвараас гадна тухайн байгууллагын хяналт шалгалтын төхөөрөмж, техник, хэрэгслээр хэрхэн хангагдсан байдлаас ихээхэн шалтгаалдаг тул боомтын нэвтрүүлэх чадамжийг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийх шаардлагатай байна.

Манай хойд хөрш болох ОХУ-ын Засгийн газраас боомтын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхийн тулд урт хугацааны хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн нь тодорхой үр дүнгээ өгч, хилийн боомтын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхдээ хяналт шалгалтын төхөөрөмж, техник, хэрэгслээр бүрэн хангаж байгаа нь давуу тал болж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн "Алсын хараа-2050" "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэхэд гадаад орнуудын туршлагыг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай.

Эх сурвалж:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. 2001.
2. Төрөөс хилийн талаар баримтлах бодлого. 2002
3. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010.
4. Монгол Улсын хилийн тухай хууль. 2016.
5. "Алсын хараа-2050". 2020.
6. "Шинэ сэргэлтийн бодлого". 2021.
7. Постановлением Правительства Российской Федерации от 15 апреля 2014 г. № 330 (в редакции постановления Правительства Российской Федерации от 31 марта 2021 г. № 508) утверждена государственная программа «Развитие внешнеэкономической деятельности»
8. На основе паспортов национальных проектов, утвержденных президиумом Совета при Президенте Российской Федерации по стратегическому развитию и

национальным проектам 24 декабря 2018 г.

9. Интерфакс россия. Новый пункт пропуска на границе России и Литвы полностью решит проблему очередей - власти Калининградской области. 12 мая 2022 г.

10. https://mintrans.gov.ru/press-center/interviews/518

11. Trans.ru: Пункт пропуска «Яраг-Казмаляр» на границе Дагестана с Азербайджаном полностью реконструируют в III квартале 2023 года. 03 марта 2023г.

12. Интерфакс. ВОЗ рекомендовала отменить ограничения на международные поездки. 20 января 2022.

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭВШИЛТЭТ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Б.Ням-Очир
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн хилийн албаны тэнхимийн ахлах багш, дэд хурандаа

Товч агуулга: Улсын хил хамгаалалт нь ямар ч улсын, ялангуяа Монгол улс шиг өргөн уудам, алслагдсан нутаг дэвсгэртэй, өвөрмөц хөгжлийн сорилтуудтай тулгарч байгаа хөгжиж буй орнуудын хувьд чухал зүйл юм. Энэхүү өгүүлэлд улсын хил хамгаалалтад дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх олон улсын туршлагыг судлан, Монголын нөхцөлд нэвтрүүлэх боломжуудыг тодорхойлж, техник, технологийг амжилттай болон бүтэлгүй хэрэгжүүлсэн жишээнүүдийг дурдагдах болно. Дрон, хиймэл оюун ухаан (AI), камерын систем, дулааны дүрслэл, олон хүний нүүр таних, морь унах зэрэг уламжлалт эргүүлийн аргууд зэрэг тодорхой сонголтуудыг үнэлнэ. Нэмж дурдахад, хил хамгаалах цэргийн анги, салбаруудад албаны амьтадын арчилгаа, маллагаа нь эдийн засаг, ажиллагааны ашиг тустай, соёлын хувьд нийцсэн өвөрмөц арга хэлбэр болохыг авч үзнэ.

Түлхүүр үгс: Техник, технологи, дрон, AI, дулааны дүрслэл, цэргийн эдийн засаг.

Keywords: Border security, advanced technology, drones, AI, thermal imaging, Mongolia, affordable solutions, developing nations, horse herding, military economy.

Удиртгал

Хилийн аюулгүй байдлын тухай ойлголт нь түүхийн туршид газар зүйн улс төрийн бодит байдал, технологийн дэвшлийн нөлөөгөөр хөгжсөөр ирсэн. Эрт дээр үед улсын хил нь ихэвчлэн гол мөрөн, уул нуруу зэрэг байгалийн онцлогоор тэмдэглэгдэж, аюулгүй байдал нь гол төлөв орон нутгийн иргэдийн сонор сэрэмжээс хамаардаг байв. Нүүдэлчдийн халдлагаас хамгаалах зорилгоор баригдсан Хятадын цагаан хэрэм нь хил хамгаалалтад дэд бүтцийг ашигласан эртний жишээ юм (Тёрнер, 2005). Үүнтэй адилаар Ромын эзэнт гүрэн нь нутаг дэвсгэрээ хамгаалахын тулд бэхлэлттэй хана барьж, улсын хил дагуу легион байрлуулдаг байв (Бишоп & Коулстон, 2006).

Орчин үед улсын хил хамгаалалт нь дэлхий дахин даяаршиж, шилжилт хөдөлгөөн, технологийн шинэчлэлтэд нөлөөлөн улам бүр төвөгтэй болсон. Тандан судлах систем, цахим хяналт, мэдээлэлд суурилсан технологийн хөгжил нь улс орнууд өөрийн хилээ хамгаалах арга замыг өөрчилж байна. Гэсэн хэдий ч хөгжингүй

орнууд хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийг хэрэглэх боломжтой бол Монгол зэрэг хөгжиж буй орнууд санхүүгийн хязгаарлалт, өргөн уудам нутаг дэвсгэр, дэд бүтцийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан өөрийн өвөрмөц бэрхшээлтэй тулгардаг. Монгол улсын морь, тэмээ, нохой чаргаар хилийн манаанд үүрэг гүйцэтгэх, хилчдийн морь маллах урт хугацааны түүх нь өнөө үед ч хамааралтай, улсын хил хамгаалалтын уламжлалт аргыг хэрэглээсээр байгаа нь хоцрогдол гэхээсээ давуу тал юм. Эдгээр аргыг хямд дэвшилтэт технологитой хослуулах нь тогтвортой, үр дүнтэй шийдлийг санал болно. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд олон улсын туршлага, дэвшилтэт технологийг амжилттай болон бүтэлгүй хэрэгжүүлэлт, Монгол улсын хил хамгаалах аргыг сайжруулах ирээдүйн боломжуудыг авч үзнэ.

Үндсэн хэсэг

Улсын хил хамгаалалтад дрон ашиглах.

Дрон нь алслагдсан, хүрч очиход хэцүү бүс нутгийг хянах хэмнэлттэй арга бөгөөд орчин үед улсын хил орчмын газар оронд тандалтын тулгуур болсон. Жишээлбэл, АНУ Мексиктэй хиллэдэг хил дагуу дроныг өргөнөөр ашиглаж, бодит цагийн байдлын мэдээлэл цуглуулж, зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаа хилийн зөрчлийг хянадаг (Маккинли, 2020). Үүнтэй адилаар Энэтхэг улс хил тандалтад дроныг нэвтрүүлсэн нь ялангуяа хойд бүс нутгийн хатуу ширүүн уур амьсгалтай газар нутгийн хяналтад үр дүнтэй шийдэл болсон нь батлагдсан (Кумар, 2021). Төв Азид Казахстан улс газар зүйн хүндрэлтэй газруудын хил хамгаалалтыг сайжруулахад дроныг мөн нэвтрүүлсэн (Ахметов, 2018). Монгол улсын хувьд дрон нь хямд үнэтэй, дэд бүтэц багатай алслагдсан газруудад ажиллах чадвартай тул практик сонголт юм. Гэсэн хэдий ч цаг агаарын хүнд нөхцөл, техникийн мэдлэгийн хязгаарлагдмал байдал, засвар үйлчилгээний зардал зэрэг бэрхшээлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд шийдвэрлэх шаардлагатай.

Хиймэл оюун ухаан.

Хиймэл оюун ухаан нь асар их хэмжээний мэдээллийг шинжлэн боломжит аюулыг тодорхойлох боломжийг олгосноор улсын хил хамгаалалтад ашиглах өргөн боломжтой. Израилд хиймэл оюун ухаанд суурилсан системүүдийг шийдвэр гаргах үйл явцыг сайжруулж, аюул илрүүлэх нарийвчлалыг дээшлүүлэхэд амжилттай ашигласан (Леви, 2018). Эдгээр системүүд нь бодит цаг хугацаанд хэв маягийг шинжлэх, хэвийн бус, сэжигтэй зүйлийг илрүүлэх машин сургалтын алгоритмуудыг ашигладаг. Европын холбоонд

хиймэл оюун ухааныг шалган нэвтрүүлэх цэгүүдэд таних үйл явцыг оновчтой болгохын тулд хил хяналтын системд нэгтгэсэн (Гарсиа, 2019). Гэсэн хэдий ч хиймэл оюун ухааныг хэрэгжүүлэхтэй холбоотой өндөр зардал, мэргэшсэн ажилтны хэрэгцээ нь Монголд хэрэгжих боломжийг хязгаарлагдмал байдалд байсаар байна. Гэсэн хэдий ч бага өртөгтэй, өргөжүүлэх боломжтой хиймэл оюун ухааны шийдэлд хөрөнгө оруулах нь урт хугацаанд ихээхэн ашиг тустай.

Камерын систем ба дулаан мэдрэгч камерын дүрслэл.

Камерын систем, дулааны дүрслэл нь харагдах байдал, хяналтын чадварыг сайжруулж, улсын хил хамгаалалтад өргөнөөр ашиглагддаг. Жишээлбэл, Турк улс хил дагуу эдгээр технологийг зөвшөөрөлгүй нэвтрэлтийг илрүүлж, нөхцөл байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд амжилттай ашигласан (Кая, 2019). Африкийн Кени улсад дулааны дүрслэл бүхий камеруудыг хил орчмын зэрлэг ан амьтны улс хооронд нүүдэллэхийг хянахад ашиглаж, аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах шинэлэг аргын боломжийг харуулсан (Окелло, 2017). Монгол улсын хувьд бага өртөгтэй дулааны дүрслэл бүхий камеруудыг шөнийн цагаар алслагдсан бүс нутгийг хянахад ашиглаж, уламжлалт хил хамгаалалтын аргуудыг нөхөж болно. Нэмж дурдахад, цахилгаан хүрч очих боломж хязгаарлагдмал газруудад нарны эрчим хүчээр ажилладаг камерын системийг ашиглаж, тогтвортой, хэмнэлттэй шийдлийг гаргаж болно.

Олон хүний нүүр таних.

Олон хүний нүүр таних технологи нь шалган нэвтрүүлэх боомт болон хотын бүс нутагт аюулгүй байдлыг сайжруулах боломжоороо анхаарал татаж байна. Хятад улс энэ технологийг өргөнөөр ашиглаж, хайж буй хүмүүсийг танихдаа мэдэгдэхүйц сайжруулалт хийсэн (Ван, 2021). Өмнөд Солонгос улс хил хяналтыг хөнгөвчилж, аюулгүй байдлыг сайжруулахын тулд томоохон нисэх онгоцны буудал, далайн боомтуудад нүүр таних системийг амжилттай нэвтрүүлсэн (Ли, 2020). Гэсэн хэдий ч хувийн нууцлалын талаарх болгоомжлол, өндөр зардал, олон янзын орчинд технологийн найдвартай байдал нь бусад орнуудад нэвтрүүлэхэд хязгаарлалт тавьсан. Монгол улсын хувьд энэ технологийг өргөн уудам хил орчмын нутаг дэвсгэрээс илүү хилийн боомтуудад ашиглах боломжтой.

Хилийн цэргийн анги, салбарт албаны амьтадын арчилгаа, маллагаа.

Монгол улсын хил хамгаалах цэргийн анги, салбарууд ажиллагааны зорилгоор төдийгүй эдийн засаг, логистикийн эх үүсвэр болгон анги, салбаруудад адуу малладаг.

Эдгээр ангиуд олон зуун адуутай бөгөөд олон үүрэг гүйцэтгэдэг. Нэгдүгээрт, адуу маллах нь орчин үеийн тээврийн хэрэгсэлд хэцүү алслагдсан газруудад хөдөлгөөн, хүртээмжийг сайжруулдаг. Хоёрдугаарт, тогтвортой хүнсний эх үүсвэрийг бий болгож, гаднын хангамжаас хамааралтай байдлыг бууруулах замаар цэргийн анги, салбаруудын эдийн засагт хувь нэмэр оруулдаг. Нэмж дурдахад морь, тэмээгээр хил хамгаалах, тээвэрлэлтэд ашиглаж, Монгол улсын өвөрмөц газар зүйн болон соёлын нөхцөлд дасан зохицох чадварыг хангадаг (Смит, 2022). Ийм арга хэмжээ нь хил хамгаалах ажилтнуудын дунд уламжлал, бахархал төрүүлж, урам зориг, үнэнч байдлыг бэхжүүлдэг.

Амжилтын түүх: Уламжлалт хил хамгаалалтыг техник, технологитой хослуулах.

Энэтхэг-Пакистаны хилийн дагуух газарзүйн хүндрэлтэй газар нутагт ажилладаг Энэтхэгийн Хилийн Аюулгүй Байдлын Цэргийн (BSF) амжилттай түүх нь анхаарал татаж байна. BSF нь уламжлалт явган эргүүлийг дрон, дулааны дүрслэл зэрэг дэвшилтэт технологитой хослуулснаар хилийн хяналт, аюул илрүүлэхэд мэдэгдэхүйц сайжруулалт хийсэн (Кумар, 2021). Үүнтэй адилаар Монгол улсын хил хамгаалах уламжлалт аргыг орчин үеийн чадавхтай хослуулсан, хэмнэлттэй, ажиллагааны үр ашгийг хангасан зэрэгцээ жишээг харуулж байна.

Хэлэлцүүлэг

Хил хамгаалалтад дэвшилтэт технологийг нэвтрүүлэхдээ орон нутгийн нөхцөл байдал, хязгаарлагдмал нөөцийг сайтар харгалзан үзэх шаардлагатай. Дрон, дулааны дүрслэл нь хөгжиж буй орнуудад үр дүнтэй, хямд сонголт болох нь батлагдсан бол хиймэл оюун ухаан, олон хүний нүүр таних зэрэг технологи нь өндөр зардал, дэд бүтцийн шаардлагын улмаас хэрэгжих боломж багатай байж болно. Энэтхэгийн уламжлалт болон орчин үеийн аргыг нэгтгэх зэрэг амжилттай хэрэгжүүлэлтээс олж авсан туршлага нь дасан зохицох чадвар, соёлын нийцлийн ач холбогдлыг тодотгож байна. Үүний зэрэгцээ АНУ-Мексикийн хилийн дроны хөтөлбөрийн өндөр зардал, хязгаарлагдмал нөлөө зэрэг бүтэлгүйтэл нь (Смит, 2022) стратегийн төлөвлөлт, зардал-ашиг шинжилгээний хэрэгцээг онцолж байна.

Ирээдүйн чиг хандлага**.** Ирээдүйд улсын хил хамгаалалт нь бие даасан систем, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг илүү өргөнөөр нэгтгэх болно. Нарны зай хураагуураар тоноглогдсон бие даасан дрон нь байнга цэнэглэх шаардлагагүйгээр хяналтыг тасралтгүй байдлыг санал болгож чадна (Чандра, 2024). Нүдний эвэрлэг бүрхэвч сканердах, хурууны хээ таних зэрэг биометрийн технологи нь

улсын хил нэвтрэх цэгүүдэд илүү түгээмэл болж, илүү хурдан, аюулгүй таних аргуудыг хэрэглэх бололцоо улам бүр нэмэгдэж байна. Цаашилбал, хил хамгаалах байгууллагуудын хооронд аюулгүй мэдээлэл солилцоход блокчейн технологийг ашиглах нь зохицуулалтыг сайжруулж, хил хяналтын үр ашгийг бууруулж чадна. Монгол улсын хувьд эдгээр шинээр гарч ирж буй чиг хандлагыг ашиглаж, уламжлалт аргыг хадгалах нь хил хамгаалалтын тогтвортой, дасан зохицох чадвартай аргыг хангаж чадна.

Дүгнэлт

Улсын хил хамгаалалт нь Монгол болон бусад хөгжиж буй орнуудын хувьд чухал зорилт хэвээр байна. Олон улсын туршлагаас суралцаж, хямд, дасан зохицох чадвартай технологид анхаарлаа төвлөрүүлснээр Монгол улс хил хамгаалалтын үйл ажиллагаагаа үр дүнтэй сайжруулж чадна. Дрон, дулааны дүрслэл, уламжлалт морин уналгатай хилийн манаа, түүнийг дагасан аж ахуй, шинээр гарч ирж буй техник, технологийн хослол нь технологийн дэвшил, соёлын нийцлийг хангасан практик, хэмнэлттэй шийдлийг санал болгодог.

Эх сурвалж:

Ахметов, Б. (2018). *Төв Азийн хил хамгаалалтад дрон ашиглах*. Бүс нутгийн судалгааны сэтгүүл, 30(3), 76-90.

Бишоп, М., & Коулстон, Ж. (2006). *Пуникийн дайнаас Ромын уналт хүртэлх Ромын цэргийн тоног төхөөрөмж*. Оксбоу ном.

Чандра, С. (2024). *Хил хамгаалалтад бие даасан дроны нарны эрчим хүчээр ажиллах ирээдүй*. Эрчим хүч, технологийн сэтгүүл, 41(1), 101-112.

Гарсиа, П. (2019). *ЕХ-нд хиймэл оюун ухаан ба хил хяналт*. Европын аюулгүй байдлын тойм, 22(4), 34-49.

Кая, М. (2019). *Турк улсын хил хамгаалалтын технологи: Тохиолдол судлах*. Аюулгүй байдлын судалгааны сэтгүүл, 34(2), 45-60.

Кумар, П. (2021). *Энэтхэгийн хил тандалт: Уламжлалт болон орчин үеийн аргыг нэгтгэх*. Батлан хамгаалах сэтгүүл, 27(3), 112-130.

Леви, Ж. (2018). *Хил хамгаалалтад ХОУ: Израилын туршлага*. Олон улсын аюулгүй байдлын сэтгүүл, 12(4), 78-92.

Ли, Х. (2020). *Өмнөд Солонгосын хил хяналтад нүүр таних технологи*. Ази-Номхон далайн аюулгүй байдлын сэтгүүл, 15(2), 89-110.

Маккинли, Р. (2020). *АНУ-Мексикийн хил дагуух дроны тандалт*. Америкийн аюулгүй байдлын сэтгүүл, 45(3), 210-225.

Окелло, М. (2017). *Кени дэх зэрлэг ан амьтны коридор ба хил хамгаалалт*. Байгаль хамгаалал,

аюулгүй байдлын сэтгүүл, 11(2), 55-67.
Смит, А. (2022). *Хил хамгаалалтад дроны технологийн зардал, ашгийг үнэлэх*. Хилийн тойм улирал тутмын сэтгүүл.

АГААРЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

О.Баттулга
Хилийн цэргийн Хил судлалын хүрээлэнгийн Хил хамгаалалтын урлаг судлалын төвийн дарга, хурандаа

Товч агуулга: Энэхүү илтгэлд Монгол Улсын агаарын хил хамгаалалтын түүхэн замнал, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг архивын түүхэн эх сурвалж, судалгааны баримтад тулгуурлан бэлтгэлээ. Мөн түүнчлэн дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд агаарын хил хамгаалалтаа хэрхэн зохион байгуулж буй байдал, шинжлэх ухаан, техник хэрэгслийн ололтыг нэвтрүүлсэн туршлага, сургамжаас судалж, оруулсан.

Үүнээс гадна Монгол Улсын агаарын орон зай, агаарын хил хамгаалалтад анхаарах асуудлыг хөндөж, холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэ техник хэрэгслээр хангах, төсөв санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлыг тусгасан.

Түлхүүр үгс: Агаарын хил, агаарын орон зай, Агаарын цэргийн командлал, хэт нам өндрийн агаарын хамгаалалт.

Удиртгал

Монгол Улсын агаарын хил хамгаалалтын түүхэн замнал

Монгол Улсын агаарын хил хамгаалалтын түүх нь XX зууны эхэн үеэс эхлэлтэй бөгөөд улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах чухал салбарын нэг юм. “Монгол Зөвлөлтийн найрамдлын гэрээ ёсоор Зөвлөлт Орос Улсаас 1925 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Ю-13 хэмээх нисэх онгоцыг манай улсад бэлэглэснээр жил бүрийн энэ өдрийг Монголын нисэх хүчин байгуулагдсан өдөр” (Батлан хамгаалахын төв архив, 1995) хэмээн тэмдэглэн өнгөрүүлдэг.

Агаарын цэргийн үүсэл, хөгжлийг судлаач, эрдэмтэд дараах байдлаар ангилан авч үздэг:

1.Эхлэл үе (1925-1960 он);

Агаарын хил хамгаалалтыг бэхжүүлэх зорилгоор цэргийн нисэх хүчнийг хөгжүүлэх алхмуудыг хийгдэж, ЗХУ-ын байлдааны нисэх онгоц, техник хэрэгслийг ашиглаж байв. Ялангуяа Халхын голын дайны он жилүүдэд Монголын нисэх хүчин агаарын хил хамгаалалтад онцгой үүрэг гүйцэтгэсэн бөгөөд дэлхийн II дайны үед Монгол Улс агаарын хил хамгаалалтаа чангатгаж, Зөвлөлтийн армитай хамтран агаарын аюулгүй байдлаа сахин хамгаалж байжээ.

2.Хүйтэн дайны үе (1960-1990 он);

Энэ үед Монгол Улсын агаарын хил хамгаалалт эрчимтэй хөгжиж, нисэх хүчин, радарт суурилсан хяналтын системүүдийг нэвтрүүлэн,

Монгол Улсын агаарын орон зайг хамгаалах зорилгоор Зөвлөлт Холбоот Улсын тусламжтайгаар шинэ үеийн сөнөөгч онгоцтой болж, агаарын довтолгооноос хамгаалах цогцолбор системийг хөгжүүлжээ.

3.Ардчилал, зах зээлийн шилжилтийн үе (1990-2000);

Монгол Улс социалист системээс зах зээлийн эдийн засагт шилжихтэй зэрэгцэн агаарын хил хамгаалалт шинэчлэгдэж, улс төр, эдийн засгийн өөрчлөлттэй уялдан өөрчлөгдөв. Зөвлөлтийн цэрэг арми Монголоос гарч, агаарын хил хамгаалалтаа өөрсдөө бие даан гүйцэтгэх болсон. 1990 ээд оны сүүлчээр Зөвлөлтийн агаарын хяналтын техник хэрэгсэл хуучирч, сэлбэг хэрэгслийн олдоц муудсан тул Монгол Улс олон улсын агаарын хяналтын системд нэгдэн, агаарын хил хамгаалалтын технологийг шинэчилж, дэвшилтэт радар, харуулын системүүдийг ашиглах эхлэл тавигдсан.

4.Өнөөгийн байдал (2001 оноос хойших);

Монгол Улсын агаарын хил хамгаалалтыг Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал хариуцан гүйцэтгэж байна. Мөн Иргэний нисэхийн ерөнхий газар агаарын хяналт, нислэгийн удирдлагыг зохицуулдаг.

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд НҮБ, ОХУ, Хятад, АНУ, Европын холбооны орнуудтай агаарын хил хамгаалалтын чиглэлээр хамтран ажиллаж техник, технологийн шинэчлэл, боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх ажлууд тогтмол хийгдэж байна.

Үндсэн хэсэг

Агаарын хил хамгаалалтын өнөөгийн байдал

Агаарын цэргийн радиотехникийн анги, салбарын удирдах байранд агаарын цагийн байдлын мэдээ хүлээн авах, боловсруулах, дамжуулах “Планшетийн арга”-аар удирдлагыг явуулдаг.

Монгол Улсын агаарын орон зайг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн “Радио техникийн бригад, хороо, батальон, рот байлдааны дүрэм”-ийн дагуу П-18 радиолокацын станц, радиолокаторын (РПС) П-19-2 станцаар хяналтад авч хамгаалж байна. Агаарын цэргийн дээрх станцуудын хяналтад бага оврын хийцтэй, хуванцар материалаар хийгдсэн, цацрагийн ойлтыг дамжуулах боломжгүй дрон, нисэгчгүй нисэх хэрэгслийг илрүүлэх боломж хязгаарлагдмал байна.

Мөн дээрх хийцийн дрон, нисгэгчгүй нисэх хэрэгсэлтэй тэмцэх хэрэгсэл байхгүй, байлаа ч хүн хүчний боломж хязгаарлагдмал, түүнийг бүрдүүлэхэд хүний нөөцийг ихээр нэмэгдүүлэх шаардлага үүсэхээр байна.

Өөрөөр хэлбэл дрон, нисгэгчгүй нисэх хэрэгслийг

илрүүлэх түүнд тохирсон тагнуул мэдээллийн систем байхгүй, түүнтэй тэмцэх халхлалтын хүч хэрэгсэл байхгүй байгаа нь манай улсын хил хамгаалалтад дроны эсрэг хамгаалалтын үйл ажиллагаа байхгүй гэж дүгнэж болно.

Агаарын цэргийн радиотехник, зенитийн пуужингийн анги, салбарын үүрэг гүйцэтгэлийн бодит байдал, тулгамдаж буй асуудлуудад үндэслэн Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн "Монгол Улсын агаарын хил, агаарын орон зайд байнгын хяналт явуулах" тайван цагийн үүргийн хэрэгжилт, удирдлагын элементийн өнөөгийн байдал хязгаарлагдмал гэж үзэх үндэслэлтэй.

Агаарын хил хамгаалалт нь улсын хилийн халдашгүй дархан байдлын хангах өнөөгийн шинжлэх ухаан, техник технологийн шаардлагад нийцэхгүй, хөгжлөөс хоцрогдож, байгаа талаар Зэвсэгт хүчний эрдэмтэн судлаачид эрдэм шинжилгээний ажил явуулж, удирдлагын системд автоматжуулалтыг нэвтрүүлэх дөрвөн төсөл хэрэгжүүлсэн боловч дээрх төслүүд аль нь ч бүрэн хэрэгжээгүй байдаг.

Хил хамгаалах ерөнхий газар, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын хоорондбайгуулсан төлөвлөгөөнд "Хилийн цэргийн анги, салбарууд, Зэвсэгт хүчний анги, салбаруудтай харилцан ажиллах, агаарын хилийн зөрчлийн талаар мэдээ мэдээлэл солилцоно" (Хил хамгаалах ерөнхий газрын даргын тушаал, 2024) гэсэн заалтын дагуу хамтран ажиллаж байна.

Агаарын цэргийн командлалын анги, салбаруудын станцын хяналтаар хэт нам өндрийн агаарын хилийг хамгаалах үед хууль бусаар эд зүйлсийг хил дамнуулан зөөвөрлөх, нислэг үйлдэж буй тохиолдолд нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон) илрүүлэх боломж бага байна.

"... агаарын хилийг зэвсэгт хүчний агаарын цэрэг хамгаална", Хил хамгаалах байгууллагын үүрэгт "агаарын хилийг зөрчсөн байж болзошгүй нисгэгчтэй болон нисгэгчгүй нисэх хэрэгслийн талаарх мэдээллийг зэвсэгт хүчний агаарын цэргийн анги, салбарт шуурхай дамжуулах" гэсэн эрх зүйн зохицуулалтын өнцгөөс харвал хэт нам өндрийн агаарын хил хамгаалалтын эрх зүйн зохицуулалтад шинэчлэл хийх шаардлагатай байгааг харж болно (А.Ганбилэг, 2023).

Монгол Улсад нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дрон ашиглах эрх зүйн орчин төдийлөн бүрдээгүй бөгөөд энэхүү харилцааг иргэний нисэхийн багц дүрмийн дагуу зохицуулж байна.

Иргэний нисэхийн дүрэм 71.163-ын (d)-д "Нам өндрийн нислэгийн зооны босоо хязгаар нь газар ба усан гадаргаас дээш 150 м-ийн (500 ft) өндөр хүртэл

үргэлжилсэн байх ёстой” гэж өндрийн дээд хязгаарыг тогтоосон.

Хуульд нэмэлт оруулах үндэслэл:

Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг бүрдүүлэгч элементийн нэг Агаарын хил хамгаалалтыг практикт боловсронгуй болгох, холбогдох эрх зүйн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах талаарх санал дэвшүүлсэн болно.

Агаарын орон зайн өндрийг 1919 оны Парисын конвенцын дагуу “Үндэсний агаар мандлын хилийг хуурай болон усан газар нутгийн хилээс чанх дээш татсан шулуун шугамаар тогтооно. Энэ орон зайн дээд хязгаар нь сансар хүрнэ” гэсэн олон улсын эрх зүйн зохицуулалтаар тодорхойлдог.

Агаар мандлын хилийн талаар дэлхий дахинд маргаантай нэгдсэн ойлголтод хүрэхгүй явсаар эрх зүйн зохицуулалт хийх асуудал 1966 оноос хойш НҮБ-ын хэмжээнд яригдаж эхэлсэн. ЗХУ-аас 1976 онд агаар мандал, сансрын заагийг хиймэл дагуул тойрог замд орох өндөр буюу далайн төвшнөөс дээш 100-110 километрээр зааглахаар НҮБ-д санал оруулсны дагуу 1983 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн олон улсын хэлэлцээрээр аливаа улсын агаарын хилийг далайн төвшнөөс дээш 110 км байхаар тогтоосон бөгөөд 110 км-ын өндрөөс цааших орон зайг ямар нэг улсад харьяалагддаггүй “Сансрын орон зай” гэж нэрлэсэн. Аливаа улсын нутгийг дайран нөгөө улсын нутагт орж байгаа бүхий л нислэгийг олон улсын нислэг гэж үздэг.

Агаарын хил нь газрын гадаргын хилийн шугамд харгалзан эгц дээш тодорхойлогдох бөгөөд газар орон дээр хилийн шугамыг өөрчлөн тогтоовол агаарын хил мөн тэр хэмжээгээр өөрчлөгдөх зүй тогтолтой.

Улсын хил хамгаалалт нь зөвхөн газрын гадаргын хилийн шугамын уртаар хязгаарлагдах бус, харин түүнээс эгц дээш үргэлжилсэн босоо хавтгай талбайг хамрах бөгөөд энэ нь ямар нэгэн зөрчилгүй байж үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн элемент болох хилийн аюулгүй байдал хангагдана.

Монгол Улсын хилийн тухай хуульд “... агаарын хилийг Зэвсэгт хүчний агаарын цэрэг хамгаална”, Зэвсэгт хүчний тухай хуульд “Агаарын цэрэг гэж улсын агаарын хил, агаарын зайн халдашгүй дархан байдалд хяналт тавих, хамгаалах цэргийн хүчийг хэлнэ” гэсэн эрх зүйн зохицуулалтаар Зэвсэгт хүчний Агаарын цэргийн анги, салбарууд агаарын хяналтыг зохион байгуулж, гарсан хилийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох үүрэгтэй.

Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд “Агаарын зайн аюулгүй байдлын хяналт нь

агаарын зайн зөрчлийг илрүүлэх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагаанаас бүрдэнэ” гэж заасан.

Манай улсын хувьд агаарын хилийн зөрчлийг Хилийн төлөөлөгч, орлогчийн түвшинд тухай бүр хил залгаа улсын талд мэдэгдэж, дахин ийм зөрчил гаргахгүй байх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ирсэн практик туршлага бий.

Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн 4.1.2-д “Хилийн агаарын бүс” гэж улсын хилийн шугамаас дотогш 30 км-ын өргөнтэй нутаг дэвсгэр дээрх агаарын зай”-г хэлнэ, мөн хуулийн 8.1.3, 8.1.4, 8.1.6-д “Агаарын зайн зөрчил”-д ... тогтоогдсон журмыг зөрчин Монгол Улсын хилийн агаарын бүсэд зөвшөөрөлгүй нислэг үйлдэх; агаарын хилээр орж ирсэн тагнуулын зориулалттай нисэх хэрэгслүүдийн нислэг үйлдэх” гэж заасан. Монгол Улсын хилийн тухай хуулийн 16.2-т “Агаарын хөлөг нь улсын хилийн тогтоосон агаарын хаалгаар нэвтэрч, зөвшөөрөгдсөн агаарын замаар нисэж, зөвхөн хилийн боомт бүхий нисэх буудалд бууж, хөөрөх ...” гэж зааснаар агаарын зайн зөрчил, хил орчмын агаарын орон зайд мөрдөх дэглэм эрх зүйн хувьд тодорхой болж өгсөн (А.Ганбилэг, Монгол Улсын аюулгүй байдлыг хангахад хил хамгаалалтын системийг боловсронгуй болгох арга зам, 2023). Тусгай зөвшөөрөлгүйгээр, зөвшөөрөлтэй боловч тогтсон агаарын замаас гажсан агаарын хөлгүүдийг “Улсын хил зөрчигч” гэж үздэг олон улсын зарчим байдаг.

Улсын агаарын хилийн орон зайн цагийн байдлын мэдээ, мэдээлэл солилцох ажиллагаанд хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын хилийн тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Улсын нисэхийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актаар зохицуулагдана.

Гадаад орны туршлага

Дэлхийн улс орнуудад нисгэгчгүй нисэх хэрэгсэл ашиглан хар тамхи, мансууруулах бодис, зэвсэг болон бусад эд зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх тохиолдол нэмэгдэж байгаа нь нам өндрийн агаарын хилийн хамгаалалтад тулгамдсан асуудлын нэг болж байна.

Хөрш улсын хил хамгаалах талаар гарсан эрх зүйн баримт бичгүүдэд ОХУ-ын Хил хамгаалах байгууллага нисгэгчгүй нисэх хэрэгслийг илрүүлэх, таслан зогсоох талаар дараах хууль тогтоомжийн дагуу зохицуулсан.Үүнд:

“ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах

зорилгоор агаарын зайд нисгэгчгүй агаарын хөлгийг илрүүлэх, таслан зогсоох, эрэн хайх, гүйцэтгэх ажлын арга хэмжээ авах, алан хядах ажиллагааны эсрэг энэ хуулийн 14.3, 14.5-д заасныг үндэслэн таслан зогсооно".

ОХУ-ын Агаарын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 5-д "Нисгэгчгүй агаарын хөлөг гэдэгт агаарын хөлгөөс гадна байрлах нисэгчээс удирдагдах, хяналт тавих боломжтой агаарын хөлөг" гэж тодорхойлсон байдаг.

БНХАУ-ын агаарын хил хамгаалалтад "БНХАУ-ын хуурай газрын хилийн тухай хууль"-ийн 2 дугаар бүлгийн 39 дүгээр зүйлд "...Аливаа байгууллага, хувь хүн холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хуурай газрын хилийн ойролцоо нисгэгчгүй нисэх хэрэгслийн нислэг үйлдэж болохгүй. Загварын нисэх онгоц гурвалжин далавч, нисгэгчгүй агаарын бөмбөлөг гэх мэт нислэгийн үйл ажиллагаа нь нисгэгчгүй нисэх онгоцны удирдлагад хамаарна" гэж заасан.

Цаашдын чиг хандлага

Манай улс агаарын хилийн зөрчлийн эсрэг хариу арга хэмжээ авах бэлтгэлтэй байхын тулд холбогдох хуулиудад эрх зүйн зохицуулалт хийж, хэт нам, өндрийн агаарын хил, агаарын хилийн орон зайг хамгаалах шаардлага нэн тулгамдсан асуудал болоод байна.

Зэвсэгт хүчин тайван цагт "Агаарын орон зай, агаарын хилийн халдашгүй дархан байдалд хяналт тавих, хамгаалах, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх" үүрэг хүлээсэн боловч агаарын хил хамгаалах зэвсэглэл техник, хэрэгсэл нь хоцрогдож орчин үеийн шинэ техник, зэвсэглэл, технологийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлага тулгарсан. Агаарын хил хамгаалалтыг дээшлүүлэх үндсэн арга хэмжээ нь автоматжуулсан системд шилжүүлэх боломжтой.

Хил хамгаалах байгууллага нь хэт нам өндрийн агаарын хилийг хамгаалахад шаардлагатай техник хэрэгсэлтэй болох, хүний нөөцөө бэлтгэсэн тохиолдолд хилийн зурваст хэт нам өндөрт хамгаалалтыг явуулах бүрэн боломжтой.

Дүгнэлт, санал

1. Улсын хилийн шугам, хил орчмын нутаг дэвсгэрт газрын гадаргуу усны мандлаас дээш 150 метр хүртэлх зайг хяналтад авч, хэт нам өндрийн агаарын хил хамгаалалтын талаар Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналтай.

2.ОХУ, БНХАУ, БНСУ, АНУ-д ашиглаж байгаа нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дроныг илрүүлэх, эсэргүүцэх, устгах төхөөрөмжөөр ХХЕГ, хилийн цэргийн анги, салбарыг ханган, хүний нөөцийг бэлтгэх. (Судалгааг хавсаргав)

Хавсралт 1
Нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дроныг илрүүлэх, устгах төхөөрөмжүүдийн судалгаа

Оросын Холбооны Улс: Байлдааны нөхцөлд бүрэн болон хагас автоматажсан нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дроныг өргөн хэрэглэж байна. Эдгээр нь зөвхөн байнгын армид төдийгүй, хөлсний цэргүүд ашиглаж байна.

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл буюу дроныг илрүүлэх төхөөрөмжүүд

1.Радио давтамж шинжлэгч (Илрүүлэх)

RF анализатор нь хэд хэдэн хэсгээс бүрдэж радио долгион хүлээн авах антен болон RF спектрийг шинжлэх процессор. Энэ технологи нь дрон болон удирдлага хоорондын радио холбоог илрүүлэх бөгөөд зарим тохиолдолд түгээмэл ашиглагддаг дронуудыг таних боломжтой. Дрон болон удирдлагыг илрүүлж, байршлыг тодорхойлдог.

2.Акустик мэдрэгч (Микрофон)

Дроны гаргаж буй дуу чимээнд үндэслэн түүний чиглэлийг тодорхойлдог. Бие даасан байдлаар ойр орчимд байгаа бүх дроныг илрүүлдэг ба радио давтамж ашигладаггүй. Дуу чимээ ихтэй орчинд тохиромжгүй ба маш бага зайд ажилладаг (300-500 м)

3.Оптик мэдрэгч (Камер)

Энгийнээр видео камер бөгөөд үзэгдэх гэрлийн камертай төстэй ч хэт улаан туяа болон дулааны дүрслэл хийх боломжтой.

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл буюу дрон эсэргүүцэх төхөөрөмжүүд

1.Death Ray дрон эсэргүүцэх машин (Эсэргүүцэх)

Boeing компани бүтээсэн 10 киловаттын хүчин чадалтай нисгэгчгүй нисэх төхөөрөмж эсэргүүцэх лазерын технологи. High Energy Laser Mobile Demonstrator (HEL MD) гэгддэг энэ төхөөрөмж нь өөр өөр орчинд төрөл бүрийн дүрсийг тогтмол хүлээн авч, дагаж мөрдөх боломжийг олгодог.

2.Digital Eagle Qr-07S3 (Эсэргүүцэх)

Хурдацтай нэмэгдэж буй дронуудын тоог хянахад туслах зорилгоор бүтээгдсэн, 1 км зайд дроны видео дамжуулалтыг зогсоох давтамж илгээдэг. Мөн энэхүү дохио дроныг анхны цэг рүү нь буцаах эсвэл тухайн газарт нь буулгах боломжтой.

3.SkyFence (Эсэргүүцэх)

Дроныг хамгаалагдсан газар руу нисэхээс сэргийлж, үйл ажиллагааны шаардлагаар хэвтээ болон босоо байдлаар тохируулж болдог. SkyFence нь бүрэн программчлагдсан бөгөөд мэдрэгч эсвэл хүний оролцоотойгоор ажиллуулдаг. Үүнийг хилийн шугамын дагуу бэхлэх ба энгийнээр хамгаалалтын цахим хана үүсгэдэг. Операторын

удирдлагатай дрон ханыг нэвтэлдэггүй. Газраас дээш 500м өндөрт хүрнэ.

4.Радио давтамж зогсоогч Digital Eagle QR-09 (Эсэргүүцэх)

Радио давтамж зогсоогч нь хөдөлгөөнгүй, хөдөлгөөнт их хэмжээний радио давтамжийг чиглүүлж дроны дохиог сарниулдаг. Мөн дроныг хяналттайгаар тухайн цэгт нь буулгах, анх нисгэсэн цэгт буцаах, тухайн цэгт нь унагаах эсвэл тодорхойгүй чиглэл рүү нисгэх үйлдлүүдийг хийдэг. Нэг ширхэг төхөөрөмжийн үнэ нь 35000 доллар.

5.GPS дохионд нөлөөлөх (Эсэргүүцэх)

Энэ төхөөрөмж нь дрон руу шинэ дохио илгээх ба ингэснээр байршил тогтоож буй GPS хиймэл дагуулын дохиог устгадаг. Ингэснээр дрон удирдлагагүй нисдэг. Эсвэл шаардлагатай хэсэг рүү чиглүүлэн нисгэж болно.

<u>Бүгд Найрамдах Хятад Ард Улс:</u> Хятад улс өндөр эрчим хүчний богино долгионы зэвсгийн систем бүтээж, энэ тал дээр ихээхэн ахиц дэвшил гаргаж, лазерын зэвсгээс илүү дүнтэй, хямд өртөгтэй дроноос хамгаалах технологийг амжилттай үйлдвэрлэж байна.

Дронуудыг ажиллуулахын тулд ихэвчлэн интернэт болон алсын удирдлага шаардагддаг бөгөөд уг өндөр хүчин чадалтай богино долгионы систем нь утасгүй сүлжээнд халдлага хийснээр дроны удирдлага тасарч, хяналтаа алдахын зэрэгцээ богино долгионы эрчим хүчийг ашиглан электрон системийг нь гэмтээж, улмаар байг үр дүнтэй устгадаг.

Хятадын “North lndustries Group” корпорацийн бүтээсэн өндөр эрчим хүчний богино долгионы зэвсгийн систем нь дроныг хямд үнээр устгаад зогсохгүй нэгэн зэрэг олон тооны дронууд руу довтлох чадвартай. Энэхүү систем нь 2ГВт буюу 2000 мегаватт (2 сая киловатт) чадалтай бөгөөд жижиг, дунд оврын дронууд болон нисэж буй пуужингуудыг устгадаг.

“Хар салхи 2000” нь 8x8 хэмжээтэй хөнгөн хуягт тээврийн хэрэгсэл дээр суурилуулсан том хавтгай массив бүхий өндөр хүчин чадалтай богино долгионы зэвсэг юм. Уг систем нь өөр дээрээ байг илрүүлэх жижиг оврын эргэдэг радартай.

“Хар салхи 3000” зэвсгийн систем нь илүү том хэмжээтэй бөгөөд “Shaanxi Automobile SX2400/2500” цувралын 8x8 ачааны машинд суурилагдсан бөгөөд том хавтгай массив, жижиг эргэдэг радараар тоноглогдсон. Төхөөрөмжийн хүч нь 3ГВт хүртэл өндөр, ашигтай зай нь 3000 орчим метр хүртэл байдаг. Жижиг дроныг устгасан бөгөөд хэт улаан туяаны камер нь байг таних, хянах чадвартай. Мөн цахилгаан оптик болон хэт улаан туяаны камеруудын хослол нь зорилтод байг илүү нарийвчлалтай түгжиж, байг устгах боломжийг бүрдүүлдэг.

Америкийн Нэгдсэн Улс: Батлан хамгаалах яам дрон устгах шинэ зэвсэг боловсруулах ажлыг эрчимтэй хийж байна. Дронууд төрөл бүрийн мэдрэгчтэй тул хаана ч, хэзээ ч видео бичлэг хийх, радио холбоо дамжуулах боломжтой. Үүнийг зогсоохын тулд дараах зэвсгүүдийг ашиглаж байна.

-Радио долгион саатуулагч: Дронуудын GPS болон удирдлагын дохиог тасалдуулна.

-Хуурамч GPS дохио үүсгэгч (Spoofer): Дроны навигацийн системийг хуурч удирдлагыг булаана.

-Өндөр эрчимтэй лазер: Цахилгаан ашиглан дроныг устгана.

-Анти-дрон буу: Өндөр нарийвчлалтай системээр нисэж буй дроныг илрүүлж саатуулна.

Дронуудыг илрүүлэх, ангилах, устгах үүрэгтэй, хоёр үндсэн төрөлтэй.

1.Дрон илрүүлэх технологи.

-Дулаан мэдрэгч: Дронуудын мотор, батарейны дулааныг мэдрэгч, харагдахгүй нөхцөлд ч илрүүлнэ.

-Радио давтамжийн мэдрэгч: 70 MHz-6 GHz -ийн дотор дрон болон удирдлагын байршлыг тодорхойлно.

-Акустик мэдрэгч: Дроны сэнсний дууг ашиглан илрүүлэх, өндөр, хурдыг тодорхойлох боломжтой.

2.Дрон устгах, тасалдуулах технологи.

-Дохио саатуулах: Дронуудын GPS болон удирдлагын системийг унтрааж албадан газардуулна.

-Тор ашиглах: Дронуудыг агаарт тороор барих арга.

-Буу ашиглах: Шууд буудаж устгах.

-Шонхор, бүргэд сургасан арга: Ан агнуурын шувуудыг ашиглан дроныг саатуулна.

-Хүний нөлөөгөөр устгах: Дроныг механикаар гэмтээж эсвэл устгана.

Бүгд Найрамдах Солонгос Улс: “Dymstec” компани бүх төрлийн дрон, радарын системийн талаар хил хамгаалалт, бусад харуул хамгаалалтад дрон, болон радарын тоног төхөөрөмжийг ашигладаг, технологи нь дрон болон удирдлагыг илрүүлэн байршлыг тодорхойлдог бөгөөд зарим тохиолдолд түгээмэл ашиглагддаг дронуудыг таних боломжтой. Мөн дроныг хяналттайгаар тухайн цэгт нь буулгах, анх нисгэсэн цэгт буцаах, тухайн цэгт нь унагаах эсвэл тодорхойгүй чиглэл рүү нисгэх үйлдлүүдийг хийдэг.

1.Drone Hunter XRS загварын автомат дрон эсэргүүцэгч:

Тактик техникийн өгөгдөхүүн нь 5.9 кг жинтэй, 1 км радиуст байгаа дрон болон нисэх биетийг илрүүлэн хөдөлгөөнийг нь хязгаарлаж, дүрс, дохиог салгах төхөөрөмж бөгөөд хүн үүрээд явах боломжтой зөөврийн зориулалттай, нэг цэнэгээр 12 цаг

тасралтгүй ажиллаж 1 цаг дроныг зогсоох чадалтай, +40 болон -20 градуст ажиллах.

2.Drone Hunter FD-A загварын дрон илрүүлэгч:

Тактик техникийн өгөгдөхүүн нь 43.1 кг жинтэй, 8 км радиуст байгаа дрон болон нисэх биетийг илрүүлэн хөдөлгөөнийг нь хязгаарлаж дохиог салгах төхөөрөмж юм. Мөн машинд нэмэлтээр тоноглож ашиглах, +65 болон -33 градуст ажиллах.

3.Drone Hunter LFD загварын дрон илрүүлэгч:

Тактик техникийн өгөгдөхүүн нь 95 кг, сүлжээ татагч 20 кг жинтэй, 15 км радиуст байгаа дрон болон нисэх биетийг илрүүлэн хөдөлгөөнийг нь хязгаарлаж дохиог салгах төхөөрөмж юм. Мөн машинд нэмэлтээр тоноглож ашиглах, +50, -32 градуст ажиллах боломжтой төхөөрөмжүүд байна.

Эх сурвалж

А.Ганбилэг. (2023). Монгол Улсын аюулгүй байдлыг хангахад хил хамгаалалтын системийг боловсронгуй болгох арга зам. In А.Ганбилэг, *Монгол Улсын аюулгүй байдлыг хангахад хил хамгаалалтын системийг боловсронгуй болгох арга зам* (p. 86). Уб: Батлан хамгаалахын хэвлэх үйлдвэр.

А.Ганбилэг. (2023). Нам өндрийн агаарын хилийн хамгаалалт. *Хилчин*, 16.

Батлан хамгаалахын төв архив. (1995). *монгол нисэх хүчин-70.* Уб: Номын сан-89.

Хил хамгаалах ерөнхий газрын даргын тушаал. (2024, 06 27). Мэдээ, мэдээлэл солилцох журам А/192. Уб, Монгол Улс.

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ХЭРЭГЛЭЭ НӨЛӨӨЛӨХ НЬ

Удирдсан багш: Д.Отгонсүрэн
Эрх зүй нийгмийн ухааны сургууль, Хувийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч
О.Долгорхүү, Б.Цолмон
221-р дамжааны оюутан
Н. Гантогтох
523-р дамжааны сонсогч

Товч агуулга: Хүн төрөлхтөн хиймэл оюун ухаан (artificial intelligence-AI)-ыг ашиглаж эхэлснээр дэлхийн эдийн засагт томоохон өөрчлөлт гарч байна. Дэлхийн 160 орны хиймэл оюун ухааныг төрийн үйлчилгээнд ашиглахад бэлэн байгаа эсэхийг эрэмбэлсэн судалгаа”-аар Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Энэтхэг Улс тэргүүлж, Америк, Австрали, Их Британи, Канад, Сингапур Улс удаалж, харин хиймэл оюун ухааныг төрийн үйлчилгээнд ашиглахад хамгийн бага оноотой бүс нутагт Сахарын цөлөөс өмнө зүгт орших Африк, Карибын тэнгис, Латин Америк зэрэг хөгжиж буй орнууд орсон байна. Түүнчлэн Төв болон өмнөд Азийн зарим орнууд багтжээ. Судалгаанд хиймэл оюун ухааны хэрэглээний үндсэн чиглэлүүдийг тодорхойлж, хил хамгаалах үйл ажиллагаанд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг шинжилсэн. Тухайлбал, дүрс таних систем, мэдрэгч төхөөрөмж, хяналтын камерын AI алгоритмууд нь алба хаагчдын ажлыг хөнгөвчлөхийн зэрэгцээ хүний нөөцийн шаардлагыг бууруулж байна. Энэхүү илтгэлд хил хамгаалах байгууллагын алба хаагчдын хөдөлмөр эрхлэлтэд хиймэл оюун ухаан (ХОУ)-ы хэрэглээ хэрхэн нөлөөлж буйг судалсан болно. ХОУ-ын технологиуд нь хилийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг урьдчилан тооцоолох, хяналт шалгалтыг сайжруулахад өргөнөөр ашиглагдаж байна. Энэ нь хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ зарим уламжлалт ажлын байрыг өөрчлөхөд хүргэж байна. Тухайлбал, дүрс таних систем, мэдрэгч төхөөрөмж, хяналтын камерын AI алгоритмууд нь алба хаагчдын ажлыг хөнгөвчлөхийн зэрэгцээ хүний нөөцийн шаардлагыг бууруулж байна. Мөн хил зөрчигчид болон хууль бус үйл ажиллагааг илрүүлэх чадварыг нэмэгдүүлснээр хил хамгаалалтын үр дүнг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Түлхүүр үгс: Хиймэл оюун ухаан, хил хамгаалах, хөдөлмөр эрхлэлт, автоматжуулалт, аюулгүй байдал

Үндэслэл

21-р зуунд технологийн хурдацтай хөгжил нь нийгмийн бүхий л салбарт өөрчлөлт авчирч, ялангуяа хиймэл оюун ухаан

(ХОУ) нь олон салбарт өргөн хэрэглэгдэж байна. Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд ХОУ-ыг ашиглах нь аюулгүй байдлыг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх чухал боломжийг олгож байна. Хяналт, тандалт, мэдээлэл боловсруулах зэрэг олон төрлийн ажил үүргийг автоматжуулах замаар хүний хүчин зүйлийг бууруулах, шийдвэр гаргалтын үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой.

ХОУ нь хил хамгаалах үйл ажиллагаанд дүрс таних систем, мэдрэгч төхөөрөмжүүд, автомат хяналтын камер, өгөгдөлд суурилсан урьдчилан таамаглах программ хангамж хэлбэрээр ашиглагддаг. Эдгээр технологиуд нь алба хаагчдын ачааллыг бууруулж, хил зөрчигчид болон хууль бус үйл ажиллагааг илрүүлэх хурд, нарийвчлалыг сайжруулдаг. Гэвч ХОУ-ын нэвтрүүлэлт нь зөвхөн эерэг үр дагавар авчраад зогсохгүй тодорхой хэмжээний сорилтуудыг ч бий болгож байна. Уламжлалт ажлын байруудын бүтэц өөрчлөгдөх, зарим ажлын байр шаардлагагүй болох, шинэ ур чадваруудыг эзэмших шаардлага нэмэгдэх зэрэг асуудлууд гарч байна. Иймээс хил хамгаалах байгууллагын алба хаагчид ХОУ-ын хэрэглээнд дасан зохицохын тулд техник, технологийн мэдлэгээ дээшлүүлэх, шинэ ур чадвар эзэмших шаардлагатай болж байна.

Хил хамгаалах байгууллага нь 1996 оноос БХЯ-ны харьяа Засгийн газрын тохируулагч агентлаг, 2000 оноос Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжиж Засгийн газрын тохируулагч агентлаг-Хилийн цэргийг удирдах газар нэртэйгээр тус тус ажиллаж ирсэн бөгөөд 2002 оноос Засгийн газрын тохируулагч агентлаг-Хил хамгаалах ерөнхий газар нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын хөдөлмөр эрхлэлтэд хиймэл оюун ухааны хэрэглээ нөлөөлөх нь орчин үеийн технологийн дэвшил, ялангуяа хиймэл оюун ухаан (ХОУ)-ын хөгжил нь хөдөлмөрийн зах зээл, тэр дундаа хил хамгаалах байгууллагын алба хаагчдын хөдөлмөр эрхлэлтийн бүтэц, ажлын байранд томоохон өөрчлөлт авчирч байна. ХОУ нь хил хамгаалах үйл ажиллагаанд хяналт, аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээ, шийдвэр гаргах процесс зэрэгт нөлөөлөх боломжтой. Энэхүү судалгааны зорилго нь ХОУ-ын хил хамгаалах байгууллагын алба хаагчдын хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөллийг тодорхойлох явдал юм. Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшил, тэр дундаа ХОУ-ын хэрэглээ нэмэгдэж, энэ нь алба хаагчдын ажлын нөхцөл, хөдөлмөр эрхлэлтийн байдалд шууд болон шууд бусаар нөлөөлж байна. Дрон, ухаалаг хяналтын

систем, өгөгдлийн шинжилгээ, автоматжуулсан хил нэвтрэх төхөөрөмж зэрэг технологиуд нь хүний оролцоог багасгах, ажлын ачааллыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Гэвч энэ нь зарим ажлын байрыг цомхотгох, алба хаагчдын үүрэг, ур чадварт шинэ шаардлага тавих зэрэг асуудлуудыг үүсгэж болзошгүй.

1.Хил хамгаалах байгууллагад хиймэл оюун ухааны хэрэглээ

-Автомат хяналтын систем: Ухаалаг камер, дулаан мэдрэгч, нүүр таних технологи.

-Дрон ба робот техник: Хилийн бүсэд хяналт тавих, эргүүлийн ажлыг автоматжуулах.

-Өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт: Том хэмжээний мэдээллийг боловсруулж, эрсдэлийг урьдчилан таамаглах.

-Ухаалаг хил нэвтрэх систем: Биометрийн таних, ухаалаг сканер ашиглан нэвтрэх (газар, 2021)

Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдал болон хиймэл оюун ухааны нээж буй боломжууд

ХОУ-ийн хэрэгслүүдийн тусламжтайгаар ажилчдын ачаалал буурч, хүний оролцоогүйгээр хийж болох зүйлсийг хийх боломж бүрдэнэ. Энэ нь ажилчдын ажлын ачаалал, стрессийг бууруулж, илүү үр бүтээлтэй ажиллах боломжийг олгоно. Бүтээмжийг нэмэгдүүлэхээс гадна төрөл бүрийн салбарт инновацыг бий болгож байна. Эрүүл мэнд, санхүүгийн салбараас эхлээд үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт хиймэл оюун ухаанаар ажилладаг технологи нэвтрээд байгаа. ХОУ нь хил хамгаалах байгууллагын ажилтнуудаас технологийн шинэ мэдлэг, ур чадварыг шаардах болно. Тухайлбал, ХОУ-ийн системүүдийг тохируулах, хянах, асуудал шийдэх чадвартай байх шаардлагатай болно. Энэ нь ажилтнуудад технологийн шинэчлэлийг судлах, сургах шаардлагатай байж болно.

Дэлхий даяар хил хамгаалалт хийхэд технологийн хөгжил, тухайлбал, хиймэл оюун ухаан (ХОУ)-ийн хэрэглээ нэмэгдэж байгаа. Монгол улсын хилийн аюулгүй байдлыг хангах үүднээс ХОУ-ийн нэвтрүүлэлт нь хяналтын ажиллагааг илүү үр ашигтай, шуурхай болгох боломжтой. Жишээ нь, Монгол Улс БНХАУ болон ОХУ-тай урт хилтэй бөгөөд тэнд хяналт тавихад хиймэл оюун ухааны системүүдийг ашиглах нь эрсдэлтэй нөхцөлд хурдан хариу үйлдэл хийх боломжийг бүрдүүлнэ. (хүрээлэн, 2022)

Дрон болон камерын хяналт: Монголын хилийн бүсүүдэд дрон ашиглан өргөн талбайг хянах, хяналтын камерын тусламжтайгаар хилийн аюулгүй байдалд заналхийлж буй орон нутгийн нөхцөл байдалд шуурхай хариу өгөх боломжтой. Хоёр

улсын хил дээр гарч болох байгалийн гамшиг, хууль бус хөдөлгөөн (мансууруулах бодис тээвэрлэх, хууль бус нэвтрэх оролдлогыг) цаг тухайд нь илрүүлж, холбогдох байгууллагуудыг мэдэгдэж, шуурхай арга хэмжээ авах боломж бүрдэнэ.

Олон улсын хил дээр тээврийн хэрэгсэлд тавих хяналт нь нарийн бөгөөд цаг хугацаа их шаардагддаг. Хил хамгаалалтын ажилтнууд зорчигчдын болон ачаа тээврийн хяналт тавихад гардаг асуудал бол цаг хугацааны хэт ачаалал. ХОУ-ийн технологиуд, жишээ нь нүүр таних систем, биометрийн өгөгдөл боловсруулалт нь зорчигчдыг шуурхай шалгах, түгжрэл үүсгэхгүйгээр орж гарах боломжийг олгон

Нүүр таних систем: Тээврийн хэрэгсэл дээр сууж яваа хүмүүсийг нүүр таних технологи ашиглан өөрийн үнэмлэхийг шалгаж, хилээр гарах, нэвтрэх үйл явцыг хурдасгах боломжтой. Энэ нь хил хамгаалагчдын ажлын ачааллыг ихээхэн бууруулж, аюулгүй байдлыг сайжруулна.

Ингэснээр хил хамгаалагчид хүний оролцоогүйгээр хариу үйлдэл хийх системд төвлөрч, хяналтын зөрчил болон эрсдэлийг тодорхойлохдоо ХОУ-ийн тусламжтайгаар илүү шуурхай ажиллах боломжтой.

Сэтгэлзүйн хүлээн авалт, хүний оролцоо:

ХОУ-ийн нэвтрүүлэлт нь хил хамгаалагчдын сэтгэл зүйд нөлөөлж болох юм. Зарим ажилтнууд шинэ технологийг хүлээн авахад сөрөг хандлагатай байж болно. Тиймээс технологийн шилжилт хийх үед хүний оролцоо, тусламж хэрэгтэй байж болох юм.

Зарим хил хамгаалагчид хиймэл оюун ухааны тусламжтайгаар хийж буй хяналт болон шийдвэр гаргалтыг хэт автоматжуулалт гэж үзэж, энэ нь тэдний үүргийг хязгаарлах гэж ойлгож магадгүй. Тиймээс ХОУ-ийг нэвтрүүлэх явцад тэдний сэтгэл зүйг ойлгож, сургалт, тайлбар хийх нь чухал.

Хил хамгаалагчдын ажилд хиймэл оюун ухааны оролцоог нэмэгдүүлэх нь сэтгэлзүйн эерэг болон сөрөг үр дагавар үүсгэж болно. Тиймээс байгууллагууд энэ процессын үеэр ажилтнуудаа дэмжих, ойлгуулан суралцах шаардлагатай.

Шийдвэр гаргах, хүний оролцоог багасгах: ХОУ нь хил хамгаалалтын ажиллагааг илүү олон өгөгдөлд үндэслэн шийдвэр гаргах боломжийг олгоно. Энэ нь хил хамгаалагчдын хүний оролцоог багасгах, хариу үйлдлийг автоматжуулах боломжийг бүрдүүлж, улмаар цаг хугацаа, хүний хүчин чармайлтыг хэмнэнэ.

ХОУ нь хил хамгаалагчдад ачаа, тээврийн хэрэгсэлд автоматжуулсан шалгалт хийх, биометрийн өгөгдлийг

боловсруулах, нүүр таних технологи ашиглан зорчигчдын мэдээллийг хурдан шалгах боломжийг олгоно. Хэрэглэгчийн тодорхойлолт ба шалгалтын үйл явц автоматжиж, ажилтнуудын оролцоог багасгана.

*Шинэ ажлын байрны төрлүүд:*Хил хамгаалах байгууллагын ажилтнууд ХОУ болон автоматжуулсан системүүдтэй хамтран ажиллахын тулд шинэ төрлийн ажлын байр үүсч болзошгүй. Жишээ нь, ХОУ-ийн системүүдийг хөгжүүлэх, боловсруулах, техникийн үйлчилгээ үзүүлэх, өгөгдөл боловсруулалт хийх мэргэжилтнүүд шаардлагатай болно.

Технологийн шинэчлэлтэй холбоотойгоор хил хамгаалагчдын дунд техникийн мэдлэгтэй, системийн үйл ажиллагааг хянах чадвартай мэргэжилтнүүдийн эрэлт нэмэгдэх болно. Мөн ХОУ-ийн өгөгдлийн шинжээчид, дрон операторууд болон мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтнүүд зэрэг шинэ ажил эрхлэгчид төрөх магадлалтай.

Энэ нь хөдөлмөрийн зах зээлд шинэ боломжуудыг нээж, тухайн байгууллагын шинэ ажлын байрны хөгжлийг дэмжих болно. Мөн шилжилт хийж буй ажилчдад технологийн шинэ ур чадвар эзэмшүүлэх, карьерын шинэ боломжуудыг нээхэд дэмжлэг үзүүлнэ.

Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдалд хиймэл оюун ухааны нөлөөлөл Хиймэл оюун ухааны (ХОУ) хэрэглээ нь хил хамгаалах байгууллагын алба хаагчдын хөдөлмөр эрхлэлтэд эерэг болон сөрөг байдлаар нөлөөлдөг. Эдгээр өөрчлөлтүүд нь ажлын бүтээмж, ажлын байрны бүтэц, хүний нөөцийн бодлого, хөдөлмөрийн аюулгүй байдал зэрэг олон хүчин зүйлд нөлөөлж байна.

Хиймэл оюун ухааны хөдөлмөр эрхлэлтийн байдалд үзүүлэх эерэг нөлөө

Бүтээмж нэмэгдүүлэх: ХОУ-ын технологиуд нь хил хамгаалах үйл ажиллагаанд цаг хугацаа хэмнэж, үр дүнтэй ажиллах боломжийг бүрдүүлнэ.

Шуурхай шийдвэр гаргалт: Хиймэл оюун ухааны алгоритмууд мэдээллийг хурдан боловсруулах замаар бодит цагийн дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлнэ.

Аюулгүй байдлыг сайжруулах: Дүрс таних систем болон ухаалаг камер зэрэг технологи нь хил зөрчигчдийг илрүүлэхэд үр дүнтэй ашиглагдана.

Ажлын ачаалал бууруулах: Автоматжуулсан системүүд нь давтагддаг, нэгэн хэвийн ажлуудыг гүйцэтгэж, алба хаагчдын ажлын ачааллыг хөнгөвчилнө.

Хүний нөөцийн оновчлол: Хүний нөөцийн төлөвлөлтийг

сайжруулж, мэргэжилтнүүдийг илүү стратегийн ажилд төвлөрүүлэх боломж олгоно.

Ажлын бүтээмж нэмэгдэж, хил хамгаалалтын үр дүн сайжирна.

Эрсдэлтэй нөхцөлд ажиллах хүний оролцоо багасаж, аюулгүй байдал нэмэгдэнэ.

Хиймэл оюун ухааны хэрэглээнээс үүдэлтэй сөрөг нөлөө

Ажлын байрны хомсдол: ОУ-ын нэвтрүүлэлт нь зарим уламжлалт ажлын байр, үүргүүдийг халах эсвэл багасгах нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ нь ажилчдын хэт их хасагдалд хүргэж, хөдөлмөрийн зах зээл дээрх өрсөлдөөн нэмэгдэх болно.

Шинэ ур чадварын шаардлага: ХОУ-ын хэрэглэх нь ажилтнуудад шинэ ур чадвар эзэмших шаардлагыг бий болгож байна. Алба хаагчид шинэ технологийн талаар мэдлэгтэй байх шаардлагатай, ингэснээр зарим хүн өөрийн ажлын байртай байж чадахгүй байх магадлалтай.

Шийдвэр гаргалтын хязгаарлалт: Хиймэл оюун ухаан нь тодорхой үүргүүдэд маш сайн ажилладаг ч хүний шийдвэр гаргалтын хүний сэтгэл зүйн болон ёс зүйн хүчин зүйлсийг анхаарах чадваргүй байдаг. Энэ нь хүмүүсийн хувь хүний туршлага, мэдрэмжийг орхигдуулж, эцсийн шийдвэр гаргахад хязгаарлалт үүсгэдэг.

Технологийн дарангуйлал болон хараат байдал: ХОУ-ыг зөвхөн технологийн талаас харах хандлага нь тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хүндрэлтэй шийдэлд хүргэж болно. Бага зардлаар ч ашиглах гэж оролдсон ХОУ нь байгууллагын тогтвортой байдалд аюул учруулах боломжтой.

Ёс зүйн асуудлууд: Хоёрдугаарт, ХОУ хэрэглэснээр ёс зүйн асуудлууд үүсэж болох юм. ХОУ-ийн алгоритмууд олон талаараа өөрийн үндсэн зорилгодоо нийцэж чадахгүй, тэр ч бүү хэл хүний хувийн мэдээллийг хамгаалахад хүндрэл үүсгэж, мэдээллийн нууцлал болон аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй.

Эдгээр сөрөг нөлөөллүүдийг анхаарч, ХОУ-ыг ашиглах стратеги боловсруулах, хүний нөөцийн хөгжлийг тодорхойлж, шийдвэр гаргах процессыг тэнцвэртэй байлгах нь чухал юм.

Хиймэл оюун ухааны хэрэглээ хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй болгох, ажлын ачааллыг бууруулах, алба хаагчдын аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Гэсэн хэдий ч зарим ажлын байрыг халж, шинэ ур чадвар шаардах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн бүтцэд өөрчлөлт авчрах нь тодорхой байна. Тиймээс ХОУ-ыг зөв зохистой ашиглах бодлого хэрэгжүүлэх, алба хаагчдыг технологийн шинэчлэлд бэлтгэх нь чухал юм.

Хил хамгаалах байгууллагынхан гэдэг нь улсын хил хамгаалах үүрэг хүлээсэн алба хаагчид

бөгөөд Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ) болон түүний харьяа нэгжүүдэд ажилладаг хүмүүс юм. Хил хамгаалах байгууллагын алба хаагчид:

1.Хилийн цэргийн алба хаагчид – Улсын хил хамгаалах, шалган нэвтрүүлэх, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

2. Шалган нэвтрүүлэх боомтын ажилтнууд – Хилийн боомтод ажиллаж, гадаадын болон дотоодын зорчигчдыг шалгах, бүртгэх, хяналт тавих үүрэгтэй.

3.Тусгай чиг үүрэг бүхий анги, нэгжийн алба хаагчид – Хил зөрчигчидтэй тэмцэх, хилийн бүсийн дотоод аюулгүй байдлыг хангах, тусгай ажиллагаа явуулах зэрэг үүрэгтэй.

4. Техник, логистикийн ажилтнууд – Хил хамгаалах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, унаа, харилцаа холбооны системийг хариуцдаг.

5. Хил орчмын тагнуул, мэдээлэл судалгааны ажилтнууд – Хилийн бүсэд үүсэж болзошгүй аюул заналыг судлах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг. Эдгээр алба хаагчид нь улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах үндсэн үүрэгтэй байдаг.

Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын хөдөлмөр эрхлэлтийн үр ашиг, төлөвлөлтийг сайжруулахад хиймэл оюун ухаан (AI) чухал үүрэг гүйцэтгэж чадна. *AI-ийг ашигласнаар дараах боломжууд бүрдэнэ:*

Хүний нөөцийн оновчтой төлөвлөлт: Алба хаагчдын ажлын гүйцэтгэл, ур чадвар, туршлага дээр суурилсан өгөгдлүүдийг AI ашиглан шинжилж, шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг урьдчилан таамаглана.

Ажлын байрны хуваарилалтыг илүү оновчтой зохион байгуулж, илүүдэл болон дутагдал үүсэхээс сэргийлнэ.

Ур чадвар хөгжүүлэх зорилтот сургалт:

- AI-ээр ажилтнуудын ур чадвар, давуу болон сул талуудыг тодорхойлж, хувь хүнд тохирсон сургалтын хөтөлбөр санал болгоно.
- Жишээ нь, бодит нөхцөл байдлыг загварчилсан виртуал сургалтууд зохион байгуулж, алба хаагчдын бэлэн байдлыг нэмэгдүүлж болно.

➢ *Ажлын гүйцэтгэлийн хяналт ба сайжруулалт:*

- Мэдээллийн урсгалаас AI ашиглан ажлын ачаалал, бүтээмж, стрессийн түвшнийг тогтмол хянах боломжтой.
- Энэ нь ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, ажлын үр дүнг сайжруулахад тусална.

➢ *Эрсдэлээс урьдчилан сэргийлэх:*

- Хил орчмын хөдөлгөөн, эрсдэлт нөхцөл байдалд AI-ээр суурилсан урьдчилан таамаглах загвар ашиглан илүү хурдан,

оновчтой хариу арга хэмжээ авах боломжтой.

- Камер, мэдрэгч төхөөрөмжийн өгөгдөлд суурилсан AI систем нь сэжигтэй үйлдлүүдийг илрүүлж, эрсдэлийг бууруулахад тусална.

Монгол Улс дахь одоогийн нөхцөл байдал

Хил хамгаалах байгууллага өөрчлөгдөх хэрэгцээ шаардлага бий. Хилчид хэцүү орчин, нөхцөлд амьдардаг. Нэгдүгээрт, хилчдийн ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах хэрэгтэй. Хоёрдугаарт, хилийн анги, салбаруудыг бүгдийг нь тог цахилгаантай болгох хэрэгтэй. Гуравдугаарт, техник технологийг шинэчилж өгөх хэрэгтэй. Монгол Улсын хамгийн том, чухал салбарын нэг бол улсын хил хамгаалалт. Тийм учраас тусгаар улсын хувьд ялангуяа хил хамгаалж буй анги, салбаруудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, амьдрах орчныг нь сайжруулах, шинэ техник технологийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай. Тиймээс анги, салбарын хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг тусгах нь чухал. Хилчдийн ажиллаж, амьдрах таатай орчин нөхцөлийг бий болгох хэрэгтэй. Ардаа санаа зовох зүйлгүйгээр хил хамгаалах албандаа хүчин зүтгэх боломжийг нь бид бүрдүүлж өгөх ёстой. Улсын хил хамгаалалтад камерын хяналтыг сайжруулах хэрэгтэй. Хилийн торыг мөн мэдрэгчтэй, дохиолол бүхий байдлаар төхөөрөмжлөх шаардлагатай. (газар Х. х., https://bpo.gov.mn/content/575, 2018)

Социалист нийгмийн үед улсын хилийг дунджаар 24 отряд хамгаалдаг байсан гэж үзвэл нэг отрядад 380 орчим км хилийн зурвас оногдог байж. Нэг хилийн отрядад 10 застав байна гэж үзэхэд нэг застав 40 орчим км хилийн зурвасыг хамгаалах үүрэгтэй юм. Застав 45-50 орчим хүнтэй байсан гээд бодохоор тэр үед хил хамгаалалт сайн байсан байх нь. Харин манай улсын орчин үеийн хил хамгаалалт айдас түгшүүр төрүүлэхээр хэмжээнд хүрчээ. (Zindaa.mn, 2013)

Орос, Хятадтай хиллэдэг хилийн нийт урт нь 8000 км орчим. Үүнийг 21 аймагтаа хуваахад нэг аймагт 380 км оногдоно. Энэ 380 км-ийг 20 суманд хуваахад нэг суманд 19 км оногдоно. 21 сумтай аймгийн сум бүрээс 20 хүн гаргаад хоол унд, байр унааг нь даахад зургаан сарын хугацаанд Монгол Улсын хил тор хаалттай болох төдийгүй бусад тоног төхөөрөмж суурилуулах хангалттай хугацаа юм

Гадаад орнуудын хил хамгаалах байгууллага, аюулгүй байдлаа хамгаалахад хиймэл оюун ухааныг хэрхэн ашигладаг вэ?

Хилийн аюулгүй байдлыг сайжруулах

АНУ-ын Гааль, Хилийн Хамгаалалт (CBP) нь хилийн

боомт дээр ачааг шалгах, CBP One аппликейшн дээр танихыг баталгаажуулах, хил дээрх аюул заналхийллийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор AI-г ашигладаг. Аль загварууд нь урсгал видео болон зураг дээрх объектуудыг автоматаар тодорхойлоход ашиглагддаг. Аномали илэрсэн үед операторуудад бодит цагийн сэрэмжлүүлгийг илгээдэг бөгөөд энэ нь CBP-ийн хар тамхи болон бусад хууль бус барааг улсын хилээр нэвтрүүлэхийг зогсоох чадварыг сайжруулдаг. Шинжлэх ухаан, технологийн газар нь Үйл ажиллагааны үр ашгийг хурдасгах төвөөр дамжуулан хилийн аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр эрдэм шинжилгээний судалгаа, технологийн хөгжлийг дэмждэг.

Агаарын тээврийг илүү хялбар, аюулгүй болгох

Тээврийн аюулгүй байдлын удирдлага (TSA) нисэх онгоцны буудлын хамгаалалтын шугамыг цахилгаанаар хангахын тулд AI ашигладаг. Аль загварууд нь нүүр царай таних технологиор баталгаажсан зорчигчдыг амархан таних боломжийг олгодог. TSA-ийн ачаа тээшийг шалгах технологи нь гар тээшнээс хориотой зүйлсийг илрүүлэхийн тулд машин сургалтын объект илрүүлэх, дүрс ангилах аргыг ашигладаг. Шинжлэх ухаан, технологийн газрын дэргэдэх Тээврийн аюулгүй байдлын лаборатори (TSL) нь энэ үйл ажиллагаанд TSA-г дэмждэг. TSL нь скрининг технологийн хувьд бие даасан, хамтын хөгжлийн туршилт, үнэлгээг хийдэг.

Харилцагчийн үйлчилгээг сайжруулах

АНУ-ын Иргэншил, Цагаачлалын алба (USCIS) нь цагаачлалын үйлчилгээг үйлчлүүлэгчдэдээ илүү үр дүнтэй хүргэхийн тулд AI-г ашигладаг. Машин сургалтын загварууд нь өөр өөр системүүдээс хэрэглэгчийн мэдээллийг цуглуулж, илүү цаасны ажлыг арилгадаг. USCIS нь харилцагчийн үйлчилгээний талаар илүү өргөн хүрээтэй харилцахын тулд үйлчлүүлэгчдийн өгсөн мэдээлэлд хурдан хандах боломжтой болсон.

Кибер аюулаас хамгаалах

Кибер аюулгүй байдал, дэд бүтцийн аюулгүй байдлын агентлаг (CISA) нь цахилгаан станц, дамжуулах хоолой, нийтийн тээвэр зэрэг манай улсын чухал дэд бүтцийн кибер эмзэг байдлыг тодорхойлох, мэдээлэх чадвараа сайжруулахын тулд AI-ийг ашиглаж байна. CISA-ийн Кибер аюулгүй байдлын хэлтэс нь хүний шинжээчдэд үзүүлэхээс өмнө эмзэг байдлын мэдээллийг цуглуулж, ангилахын тулд машин сургалтын болон байгалийн хэл боловсруулах загваруудыг ашигладаг. CISA-ийн мэргэжилтнүүд Мэдэгдэж буй ашиглагдаж буй эмзэг байдлын каталог, үндэсний эмзэг байдлын

мэдээллийн сан зэрэг хэвлэлд нийтлэгддэг кибер эрсдэлийг илүү үр дүнтэй үнэлэх боломжтой. Шинжлэх ухаан, технологийн газар (S&T) нь S&T-ийн Кибер аналитик ба платформын чадавх төслөөр дамжуулан CISA-г энэхүү хүчин чармайлтад дэмжлэг үзүүлдэг.

Al судалгаа, хөгжүүлэлт, байршуулалтыг тэргүүлэгч

Шинжлэх ухаан, технологийн газар (S&T) нь эх орны аюулгүй байдлын зорилтын тэргүүн эгнээнд байгаа хүмүүст эрсдэлийг бууруулах, өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргахад нь туслахын тулд Al ашигладаг. S&T AI судалгаа, хөгжүүлэлтийн хүчин чармайлт нь DHS-ийн олон зорилтыг дэмждэг:

•чухал дэд бүтцийг хамгаалж буй нэвтрэх боомт, байгууламжид үзлэг, илрүүлэлт;

•зохион байгуулалттай гэмт хэргийн үйл ажиллагааг илтгэж болох хэв маягийг тодорхойлохын тулд өгөгдөлд дүн шинжилгээ хийх, дүрслэх, дүрслэх; болон

•фентанил, зэвсэг зэрэг хууль бус барааг илрүүлэх урьдчилан таамаглах аналитик ба компьютерын хараа. (SECURITY, 2021)

Улс орнуудын хиймэл оюун ухааны талаарх хууль, эрх зүйн зохицуулалт

Улс орнууд хиймэл оюун ухааныг өдөр тутамдаа хэрэглэж, үр ашгийг нь хүртэхийн зэрэгцээ мөн сөргөөр ашиглахыг нь хязгаарлах зорилгоор зохицуулалтыг бий болгох, сайжруулахыг эрмэлзэж байна. Австрали Улсын Стратегийн бодлогын хүрээлэнгээс гаргасан тайланд хиймэл оюун ухаанаас үүдэлтэй эрсдэлийг бууруулах 3 арга замыг тодорхойлохдоо:

Нэгдүгээрт, одоо хэрэглэж буй компьютерын системүүдэд хөндлөнгийн аудит хийх үнэлэх,

Хоёрдугаарт, “хулгайчийг хулгайчаар бариулах” технологи ашиглах хакеруудтай хамтран үндэсний аюулгүйн системүүдийн цоорхойг илрүүлэх,

Гуравдугаарт, шинээр бий болгож буй технологийг хууль, эрх зүйн орчны хувьд зохицуулах шаардлагатай талаар дурдсан байна. (газар Y. х., 2021)

Хиймэл оюун ухаан нь хүн болон үндэсний аюулгүй байдалд бодитой аюул заналхийлэл учруулах боломжтой байна. Асар их хэмжээний мэдээллийг боловсруулж, дүн шинжилгээ хийхийн тулд хиймэл оюун ухааныг ашиглах шаардлага өсөн нэмэгдэж, ялангуяа бизнесийн байгууллагууд өдөр бүр давтагддаг ажлуудыг хурдан хийх, цаг хугацаа, мөнгөө хэмнэх зорилгоор машин сургалт (machine-learning), автоматжуулалтыг ашиглаж эхлээд байгаа талаар Аюулгүй байдал судлалын хүрээлэн тодорхойлсон байна.

Гэвч энэхүү технологийн дэвшил нь сөргөөр ашиглагдах талтай бөгөөд улс орон, террорист бүлэглэлүүд хиймэл оюун ухаан

болон робот техникийг зэвсэг болгон ашиглах, дэлхийн хиймэл дагуулын системийг хакердах, тагнуулын мэдээ, мэдээлэл боловсруулах хурд эрс нэмэгдэж, нүд ирмэх төдий асар их хэмжээний өгөгдлийг боловсруулах боломжтой болсныг Стэнфордын Их Сургуулийн "Хүн-төвтэй хиймэл оюун ухаан" судалгааны төвийн удирдах зөвлөлийн дарга Эми Стегард онцлон тэмдэглэсэн байна. Хиймэл оюунд суурилсан эдийн засагт амжилттай шилжихэд чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, хиймэл оюун ухааны боловсрол, сургалтын хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийх нь чухал юм. Үүнд:

Хиймэл оюун ухаанд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний кодыг өмчлөх боломжийг олгох нь зах зээлийн хүчийг төвлөрүүлж, хор хөнөөлтэй байдлыг нэмэгдүүлэх боломжтой тул кодыг нээлттэй, ил тод байлгаж инновацыг дэмжих шаардлагатай байна.

Зарим хиймэл оюун ухааны загвар, арга хэрэгсэл нь бусад хүмүүсийн бүтээлийг ашигладаг тул контентыг бий болгосон этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах, оюуны өмч, зохиогчийн эрхийг зөрчихөд хүргэж болзошгүй гэж үзэн улс орнууд хамгаалалтын зохицуулалтыг бий болгож байна.

Хэрэв хиймэл оюун ухааны загвар, арга хэрэгслийг гуравдагч этгээдэд хор хөнөөл учруулах зорилгоор ашигласан бол технологи хөгжүүлэгч, эсхүл үйлчилгээ үзүүлэгч нь учруулсан хохирлыг хариуцан арилгах талаар зохицуулах шаардлагатай юм. (хүрээлэн А. б., 2023)

Дүгнэлт

Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад хиймэл оюун ухааны хэрэглээ нь ажлын үр ашгийг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтыг сайжруулах, хүний нөөцийн менежментийг оновчтой болгох, аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэх зэрэг олон талын эерэг нөлөө үзүүлэх боломжтой юм.

Юуны өмнө, ХОУ нь хил хамгаалах үйл ажиллагаанд хяналт шалгалт, эрсдэлийн үнэлгээ, мэдээлэл боловсруулалт, харилцаа холбооны чиглэлээр илүү нарийвчлалтай, үр ашигтай ажиллах боломжийг бий болгоно. Ухаалаг камер, дүрс таних систем, том өгөгдлийн шинжилгээ, автоматжуулсан хяналтын систем зэргийг ашигласнаар хил зөрчигчид болон хууль бус үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэнэ. Мөн ХОУ-тай хослуулан ажиллах нь хил хамгаалагчдын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, ажлын ачааллыг бууруулах чухал хүчин зүйл болно. Жишээлбэл, хилийн шалган нэвтрүүлэх боомтуудад

автомат таних систем, дрон, робот техникийн тусламжтайгаар алба хаагчид богино хугацаанд олон зорчигчийн мэдээллийг боловсруулж, хяналт шалгалтыг хурдан, найдвартай хийх боломжтой. Энэ нь цаг хэмнэхийн зэрэгцээ хил дээр үүсэх дарааллыг багасгах ач холбогдолтой.

Гэвч хиймэл оюун ухааны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр хил хамгаалагчдын ажлын байр, үүрэг хариуцлага өөрчлөгдөх эрсдэлтэй. Зарим уламжлалт ажлууд автоматажсанаар хүний оролцоо багасаж, тодорхой чиг үүрэгтэй албан тушаалууд өөрчлөгдөж магадгүй. Иймээс алба хаагчид ХОУ-тэй уялдуулан ажиллах чадвараа хөгжүүлж, технологийн мэдлэгтэй болох шаардлагатай.

ХОУ-г хэрэгжүүлэх явцад аюулгүй байдал, ёс зүй, мэдээллийн хамгаалалт зэрэг асуудлыг сайтар анхаарах хэрэгтэй. Хил хамгаалах байгууллагын онцлогийг харгалзан, хиймэл оюун ухааныг зөв зохистой ашиглах бодлого, дүрэм журам боловсруулж, алба хаагчдыг мэргэшүүлэх сургалт, дадлагад хамруулах нь чухал юм.

Дүгнэж хэлэхэд, хил хамгаалах байгууллагын алба хаагчдын хөдөлмөр эрхлэлтэд хиймэл оюун ухааны хэрэглээ нь ажлын үр ашгийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг сайжруулах, боловсон хүчний ур чадварыг хөгжүүлэх давуу талтай. Гэхдээ энэ өөрчлөлтөд зохицохын тулд технологийн шинэчлэлийг зөв удирдах, алба хаагчдыг бэлтгэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах бодлогын арга хэмжээ авах нь зайлшгүй шаардлагатай юм.

Санал, зөвлөмж

Монгол улсын хил хамгаалах байгууллагын хөдөлмөр эрхлэлтэд хиймэл оюун ухааныг үр дүнтэй ашиглах нь чухал. Үүний тулд дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна:

Техникийн дэмжлэг, тоног төхөөрөмжийн шинэчлэл: Хиймэл оюун ухааны системүүдийг бүрэн хэрэглэхийн тулд орчин үеийн өндөр хүчин чадалтай техник, дэд бүтэц, холбогдох мэдлэгт суурилсан сургалт шаардлагатай.

Технологийн шинэчлэлийг дэмжих, хөрөнгө оруулалт хийх: Хиймэл оюун ухааны системүүдийн үр ашгийг хамгийн их байлгахын тулд хил хамгааллын байгууллагууд шинэ технологиудыг нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай.

Мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх сургалт: Хиймэл оюун ухааныг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хил хамгааллын алба хаагчдыг шинэ технологиуд, системүүдийг ашиглах талаар мэргэшүүлэх сургалтад хамруулах нь чухал. Хиймэл оюун ухаантай зэрэгцэн тэднийг ашиглах, хөгжүүлэх технологийн чиглэлд түлхүү алба

хаагч нарыг бэлтгэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Эрсдэлийн менежмент, аюулгүй байдлын хяналт: Хиймэл оюун ухааныг хил хамгааллын системд нэвтрүүлэх нь тодорхой эрсдэлүүдтэй байж болох тул, системийн аюулгүй байдлыг хангасан зохистой хяналтын арга хэмжээ авах нь чухал. Хиймэл оюун ухаан нь мэдээллийн аюулгүй байдал, цахим халдлагын эрсдэл, техник алдаанууд зэрэг асуудал үүсгэж болзошгүй тул эдгээр эрсдэлийг багасгахын тулд хяналт, шалгалтыг тогтмол хийж байх шаардлагатай.

Хүний оролцоог сайжруулах, тэнцвэрийг хадгалах: Хиймэл оюун ухаан нь хүний оролцоог бүхэлд нь орлож чадахгүй. Тиймээс, хүний оролцоотой шийдвэр гаргалт, шинжилгээ хийх боломжийг үргэлж хадгалах хэрэгтэй. ХОУ-ийн системүүд нь зөвхөн туслах үүрэгтэй байж, хүн бүрийн шийдвэр гаргах чадвар, хариуцлагыг хадгалах ёстой.

Эх сурвалж:

1.
2. SECURITY, H. (2021 оны 5). https://www.dhs.gov/ai/using-ai-to-secure-the-homeland.
3. STEM.MN. (2020 оны 7). https://stem.mn/technology/1056/.
4. technologies, D. s. (2021 оны 1). https://www.deepmedia.de/en/.
5. VIP76. (2015 оны 3). https://vip76.mn/law/project/161.
6. Zindaa.mn. (2013 оны 7). https://news.zindaa.mn/19wa.
7. газар, Y. х. (2021 оны 12). https://openjicareport.jica.go.jp/pdf/12341848_01.pdf.
8. газар, Х. х. (2018 оны 2). https://bpo.gov.mn/content/575.
9. газар, Х. х. (2021 оны 6). https://bpo.gov.mn/content/668.
10. систем, Э. з. (2011). https://legalinfo.mn/mn/detail?lawId=563.
11. систем, Э. з. (2016). https://legalinfo.mn/mn/detail/12418.
12. хүрээлэн, А. б. (2023 оны 12). https://niss.gov.mn/archives/3238.
13. хүрээлэн, С. с. (2022 оны 3). https://iss.gov.mn/?p=3536

ХИЛ ХАМГААЛАЛТЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮҮРЭГ БА ШИНЭЧЛЭЛ

Г.Одон-Ертөнц
Хилийн албаны сургуулийн Холбоо, мэдээллийн технологийн тэнхимийн профессор, докторант, дэд хурандаа

Товч агуулга: Мэдээллийн технологи нь хилийн хамгаалалтад уламжлалт системүүдтэй харьцуулахад илүү үр дүнтэй, аюулгүй, хурдтай шийдвэр гаргах боломжийг олгож байна. Энэ судалгааны бүтэц нь хил хамгаалалтад мэдээллийн технологийн үүрэг ба шинэчлэлийг хэрхэн танилцуулах, шинэ технологийн нөлөөллийг хэрхэн хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө. Хил хамгаалалтыг сайжруулах, хил дамжих аюулгүй байдлыг баталгаажуулахад мэдээллийн технологи нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Хил хамгаалах уламжлалт аргаас гадна дижитал, автоматжуулсан системүүдийг ашиглан хилийн аюулгүй байдлыг хурдасгах, эрсдэлийг бууруулах боломжтой болсон. Энэхүү судалгаа ажлын хүрээнд хил хамгаалалтад мэдээллийн технологийн үүрэг, шинэчлэлийн нөлөөг судалж, хэрхэн аюулгүй байдлыг хангах шинэ боломжуудыг бий болгож байгааг тодорхойлно. Энэхүү судалгааны ажлын үр дүнгээр хил хамгаалалтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, шинэ технологийн нэвтрүүлэлтийн шаардлагыг тодорхойлох зорилготой юм.

Судалгаа нь хилийн хамгаалалтад ашиглагдаж буй мэдээллийн технологиудын үр дүн, үйл ажиллагааны шинэ арга замуудын талаарх ойлголт өгч, ирээдүйд үүсэж болох сорилтуудыг тодорхойлоход тусална.

Улс орнуудын хил хамгаалалтын Өнөөгийн чиг хандлага

1.Хил хамгаалалтын технологийн зах зээлийн өсөлт

Сүүлийн жилүүдэд хил хамгаалалтын технологийн зах зээл эрчимтэй өсөж байна. 2022 онд дэлхийн хэмжээнд энэ зах зээл 48 тэрбум ам.доллар байсан бол 2027 он гэхэд 70 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Энэ нь 47%-ийн өсөлтийг илэрхийлж байгаа бөгөөд гол хөдөлгөгч хүчин зүйл нь хиймэл оюун ухаан (AI) интеграцчилсан хяналтын системүүдийн нэвтрүүлэлт юм. [1]

2. Камерын системийн зах зээлийн өсөлт

AI интеграцчилсан хяналтын цамхгуудын хэрэглээ нэмэгдэж байгаа нь камерын системийн зах зээлийг 2022 онд 10.1 тэрбум ам.долларaас 2027

[1] GlobeNewswire

онд 22.8 тэрбум ам.доллар хүртэл өсгөх хандлагатай байна. Эдгээр хяналтын цамхгууд нь виртуал хил үүсгэж, алслагдсан зайд аюулыг илрүүлэх, таних, мөрдөх чадвартай.

3.АНУ-ын өмнөд хилийн цэргийн байршуулалт

2025 оны 3-р сарын байдлаар, АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трамп хууль бус цагаачлалыг бууруулах зорилгоор Мексикийн хил дээр 10,000 идэвхтэй албан хаагч, 2,500 Үндэсний гвардын цэргийг байршуулсан байна. Мөн 100 гаруй Stryker хуягт машин, нисдэг тэрэг, USS Gravely болон USS Spruance гэх хоёр тэнгисийн хөлөг онгоцыг ашиглаж байна.[1] **4.** *Австралийн хилийн хяналтын арга хэмжээ*

Австралийн засгийн газар 2023 оны 9-р сараас хойш 16 завьтай 224 хүн улсын усанд нэвтэрсэн тул Науру арал дээрх оффшор боловсруулалтыг сэргээж, агаараас хяналтын нислэгүүдийг нэмэгдүүлсэн байна.[2]

5.Израилын дрон эсэргүүцэх технологи

Израил улс дрон илрүүлэх, саармагжуулах дэвшилтэт технологи хөгжүүлсэн бөгөөд энэ нь АНУ-ын агаарын орон зайг хамгаалахад ашиглагдаж байна. Эдгээр технологи нь цаг агаарын ямар ч нөхцөлд дронуудыг илрүүлж, устгах чадвартай.

Хил хамгаалах байгууллагын мэдээллийн технологийн шинэчлэлийн өнөөгийн байдал

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг үндэслэн шинэчлэн баталсан “Улсын хил хамгаалалтын дүрэм”-шинэчлэн батлагдсан.

Дүрэм шинэчлэн батлагдсанаар хил хамгаалалтын арга тактик боловсронгуй болж, инженер-техник, мэдээллийн технологийг хил хамгаалалтад түлхүү ашиглах эрх зүйн орчин бүрдсэн.

Хил хамгаалах байгууллага улсын хилийн хэсгийг радиорелей-камер, хилийн дохиоллын системээр хамгаалах, нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашиглалтыг эрчимжүүлж, дохиолол, хамгаалалтын нэгдсэн удирдлагын байнгын төв ажиллуулж байна.[3]

Хил хамгаалах байгууллагын мэдээллийн технологийн шинэчлэлийн тулгамдаж буй асуудлууд

Хүний нөөцийн хомсдол, сургалтын асуудал

Хилийн хамгаалалтад шаардлагатай мэргэшсэн

[1] Business Insider
[2] The Australian[2]

[3] Улсын хил хамгаалалтад инженер-техник, мэдээллийн технологийг түлхүү ашиглана

боловсон хүчний хомсдол[1] нь тулгамдсан асуудлуудын нэг болж байна. Хилийн аюулгүй байдлыг хангах, шинэ технологиудыг нэвтрүүлэх, шинэчлэлийн процессыг удирдах чадвартай, мэргэжлийн хүмүүсийн дутагдал нь хил хамгаалалтад тасалдал үүсгэж болзошгүй. Түүнчлэн, хилийн хамгаалалтын үйл ажиллагааны үед ажиллагсдын ур чадварын түвшин хангалттай биш, сургалтын бодлого, аргачлал, шинэ технологийн сургалт дутагдалтай байгаагаас уламжлалт системээс дижитал шилжилтэд гарах хэцүү байдаг.

Шийдвэрлэх арга зам, зөвлөмж

Хил хамгаалах байгууллага нь орчин үеийн дэвшилтэд техник хэрэгсэл, программ хангамжийг шат дараатайгаар нэвтрүүлж байгаа нь хилийн аюулгүй байдлыг сайжруулах, зөрчлүүдийг урьдчилан илрүүлэх, хяналтын үйл ажиллагааг хурдасгах тал дээр томоохон алхам юм. Жишээ нь, автоматжуулсан хилийн хяналтын системүүд, хиймэл оюун ухаан, дрон, блокчейн зэрэг шинэ технологиудыг ашиглах нь хилийн хамгаалалтын ажиллагааг илүү үр дүнтэй, аюулгүй болгох боломжийг олгож байна.

Гэвч, эдгээр шинэчлэлүүдийг амжилттай нэвтрүүлэхэд боловсон хүчний дутагдал томоохон саад болж байна. Мэдээллийн технологи болон дижитал системүүдийн ажиллах, бүрэн хүчин чадлаар ашиглах нь өндөр ур чадвартай, мэргэжлийн хүний нөөц шаарддаг. Тиймээс, хил хамгаалах байгууллагуудыг амжилттай үйл ажиллагаа явуулахын тулд *боловсон хүчнийг чадавхжуулах, сургах* шаардлагатай юм.

Үүнийг шийдвэрлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай:

-*Мэргэжилтнүүдийг бэлтгэх*: Мэдээллийн технологи, автоматжуулалт болон хилийн хамгаалалтын онцлогт тохирсон сургалт, мэргэжил олгох хөтөлбөрүүдийг өргөжүүлэх.

-*Сургалтын хөтөлбөрийг сайжруулах*: Хилийн хамгаалалтын мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор технологийн шинэчлэлтэй холбоотой сургалтуудыг тасралтгүй зохион байгуулах.

---

[1] Мэдээлэл технологийн хүний нөөцийн хомсдол нь дэлхий даяар томоохон сорилтуудын нэг болж байна. Тухайлбал, 2023 оны байдлаар олон улсын хэмжээнд мэдээллийн технологийн салбарт мэргэжлийн ажилчдын дутагдал 2.5 саяас дээш байсныг тайлангууд мэдээлжээ Монгол Улсад ч мөн адил мэдээллийн технологийн салбарт хүний нөөцийн хомсдол ноцтой асуудал болж байгаа бөгөөд энэ нь зөвхөн дотоодын зах зээлийн хэрэгцээг хангах төдийгүй, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд саад болж байна.

-*Боловсон хүчний татан авалт*: Технологийн салбарт мэргэжилтнүүдийг татан авч ажиллуулахад анхаарах, тэдний мэдлэг, ур чадварыг өсгөх.

-*Техникийн дэмжлэг болон үйлчилгээний хүрээ*: Программ хангамжийн шинэчлэл болон техник хэрэгслүүдийг ажиллуулахад зориулан бүхэлд нь дэмжлэг үзүүлэх, техник үйлчилгээний багийг бэхжүүлэх.

бодлого баримтлах нь цаг үеийн зайлшгүй шаардлага болоод байна. Ийнхүү мэргэшүүлэлт, чадавхжуулалтыг шат дараатай, системтэйгээр хэрэгжүүлснээр хилийн аюулгүй байдал улам бэхжиж, хамгаалалтын үйл ажиллагаа хурдацтай, үр дүнтэй хөгжих нөхцөл бүрдэх юм.

Эх сурвалжийн жагсаалт

Үндэсний статистикийн хороо. (2023). *Монгол Улсын статистикийн эмхэтгэл*.

Отгонжаргал, Ж. (2020). Хил хамгаалалтад мэдээллийн технологийн хэрэглээний үр нөлөө. *Монголын Цэргийн Шинжлэх Ухааны сэтгүүл*, (4), 23–30.

Бат-Эрдэнэ, Д. (2022). Хиймэл оюун ухааныг аюулгүй байдлын салбарт нэвтрүүлэх нь. *Мэдээллийн Технологи ба Үндэсний Аюулгүй Байдал*.

European Commission. (2020). *Smart borders: New technologies for the EU's external borders*. https://ec.europa.eu

Дүгнэлт

Дэлхий нийтээрээ мэдээллийн технологийн чиглэлээр боловсон хүчний хомсдолд орж, дижитал шилжилтэд тулгарч буй сорилтууд нэмэгдэж буй энэ үед, хил хамгаалах байгууллагын нийт алба хаагчдыг технологийн чиглэлээр мэргэшүүлэх

US Customs and Border Protection. (2021). *CBP innovation strategy and use of AI*. https://www.cbp.gov

OECD. (2022). *Artificial intelligence in law enforcement and border security*. OECD Publishing.

INTERPOL. (2021). *Biometric data and border management guidelines*.

UNODC. (2020). *The use of technology to counter cross-border crime*.

Lyon, D. (2018). *Surveillance society: Monitoring everyday life*. Polity Press.

Graham, S. (2010). *Cities under siege: The new military urbanism*. Verso Books.

Lin, P., Bekey, G., & Abney, K. (2012). *Robot ethics: The ethical and social implications of robotics*. MIT Press.

Peters, J. G. (2021). The role of AI in modern border surveillance systems. *Journal of Security Studies*, 15(2), 45–60.

Kim, T., & Lee, J. (2019). South Korea's smart border system: Biometric innovations and digital governance. *Asia-Pacific Security Review*.

ЦАХИМ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОЛОМЖ: БАЙГАЛИЙН ХОВОР ЭЛЕМЕНТИЙН ХИЛИЙН ХЯНАЛТЫН ЖИШЭЭН ДЭЭР

А.Золбоо
Хууль зүйн ухааны магистр, Эдийн засгийн аюулгүй байдлын магистрант

Товч агуулга: Аж үйлдвэржилтийн 4 дүгээр хувьсгал буюу цахим технологийн үсрэнгүй хөгжлийн дижитал эрин үед бүхий л зүйлс техник, технологийн ажиллагаа дор өрнөж байна. Гаалийн хяналтын рентген төхөөрөмж, сканер нь улсын хилээр нэвтэрч буй импорт, экспортын бараа бүтээгдэхүүнийг шалгах чухал системүүдийн нэг бөгөөд эдгээр систем нь 100 хувь цахим технологид тулгуурласан байдаг. Түүнчлэн рентген төхөөрөмжийн хяналт нь хорт программын халдлагад өртөх эрсдэлтэй бөгөөд энэ нь хилийн аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдлыг алдагдуулах эрсдэлийг дагуулдаг. Хорт программ нь мэдээллийг хулгайлах, хуурамч мэдээлэл илгээх, системийн ажиллагааг саатуулах зэрэг олон төрлийн аюулыг бий болгож байдаг бөгөөд энэхүү өгүүлэл нь цахим халдлагаас гаалийн хяналтын рентген системийг хамгаалах боломж, мөн байгалийн ховор элементийн хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх технологийн шийдлүүдийг судалж, хорт программын халдлага, гэмт хэргээс сэргийлэх оновчтой арга хэмжээ авах боломжийг эрэлхийлэхэд чиглэсэн болно.

Түлхүүр үгс: Кибер аюулгүй байдал, Гаалийн хяналт, Рентген төхөөрөмж, Хорт программ, Цахим халдлага

Удиртгал

Хорт программ нь орчин үеийн мэдээллийн аюулгүй байдалд хамгийн том аюул заналхийлэл болж, жил ирэх тусам илүү нарийн, уламжлалт хамгаалалтын системүүдийг тойрон гарах шинэ арга замуудыг ашиглаж байна. 2023 оны кибер аюулгүй байдлын дэлхийн тайланд дурдсанаар хорт программын халдлагын тоо 38%-иар өссөн[1] нь мэдээллийн аюулгүй байдалд тулгарч буй асуудал, эрсдэлүүдийг улам тод томруун харуулж байна. Энэ нь хорт программын шинж чанар, түүнийг илрүүлэх болон шинжлэх үр дүнтэй аргачлалыг судлах шаардлагатайг онцолсон хэрэг юм.

Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь гаалийн хяналтын рентген төхөөрөмжийн цахим хяналтын системд учруулж

[1] F. Müller, "Machine Learning for Malware Detection," International Journal of Cybersecurity, vol. 14, no. 2, pp. 100-110, 2020.

болзошгүй хорт программын халдлагын аюулыг судалж, хилээр гарах байгалийн ховор элементийн хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох явдал юм. Судалгаанд цахим халдлагаас хамгаалах хамгийн үр дүнтэй арга хэрэгслүүд, тэдгээрийн хэрхэн хэрэгжүүлж болох талаар судалж, гаалийн хяналтын системийн аюулгүй байдлыг сайжруулах, мөн хууль бус худалдааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх оновчтой шийдлүүдийг танилцуулах юм.

Энэхүү судалгааны зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн:

1. Хорт программын халдлагын төрөл, онцлогийг судлах.
2. Рентген хяналтын системийн аюулгүй байдлыг сайжруулах, хорт программыг илрүүлэх, шинжилгээ хийх аргуудыг судлах.
3. Байгалийн ховор элементийн хилээр гарч буй хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг санал болгох.

Судалгааны ажлын хүрээнд шинжлэх ухааны танин мэдэхүйн болон түүвэрлэх, харьцуулан судлах арга зүйг ашигласан бөгөөд хорт программын шинжилгээний аргуудыг харьцуулан дүн шинжилгээ хийсэн. Мөн судалгаанд шинжилгээний үр дүнг сайжруулахын тулд түүхэн болон анализ, синтезийн аргуудыг ашигласан.

Энэхүү сэдвийн хүрээнд өмнө судлагдсан хэд хэдэн чухал судалгаа болон эрдэм шинжилгээний бүтээлүүд байдаг. Гаалийн хяналт, рентген төхөөрөмж, хорт программын халдлагаас урьдчилан сэргийлэх асуудал нь цахим аюулгүй байдал, хил хязгаарын хяналттай холбоотой өргөн хүрээний судалгаа юм. Тухайлбал:

1. Kaufman, L. (2021). "Cybersecurity in Border Control Technologies"

Энэхүү судалгаа нь хил хязгаарын хяналтын технологиудад ашиглагддаг цахим системүүдийн аюулгүй байдлыг судалсан бөгөөд хорт программын халдлагын эрсдэл болон түүний уршгийг шинжилжээ. Судалгааны үр дүнд хил хязгаарын хяналтын системийн хамгаалалтын аргачлалуудыг сайжруулах хэрэгцээ шаардлагыг дэвшүүлсэн.

2.Boulanger, R., & Li, X. (2020). "Impact of Malware on Border Control Systems"

Судалгаа нь хил хязгаарын хяналтын системүүдэд хорт программууд хэрхэн нөлөөлдөг, түүний аюулгүй байдалд ямар сөрөг нөлөө үзүүлдэг талаар танилцуулсан. Хорт программын халдлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн авах тухай зөвлөмжүүдийг дэвшүүлсэн.

3.Miller, T. (2022). "Cyber Threats in Customs and Border Security Systems"

Энэхүү судалгаа нь гаалийн хяналтын системд цахим халдлагын эрсдэл болон хорт программын нөлөөний талаар хийсэн судалгаа бөгөөд цахим аюулгүй байдлыг сайжруулах аргачлалуудыг тодорхойлсон.

4.Chen, Y., Liu, J., & Wu, Z. (2021). "International Cooperation on Customs Border Control Cybersecurity"

Судалгаанд олон улсын хамтын ажиллагааг хил хязгаарын аюулгүй байдал, цахим хорт программын халдлагаас хамгаалах, мэдээллийн солилцоо болон хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор хэрхэн хөгжүүлэх талаар дэлгэрэнгүй авч үзжээ.

5.Jones, H., & Patel, R. (2019). "Automating Border Security: The Role of AI and Malware Protection"

Хилийн аюулгүй байдалд ашиглагддаг хиймэл оюун ухаан болон автоматжуулсан хяналтын системийн талаар хийсэн судалгаа. Мөн хорт программ болон бусад цахим аюулын асуудлыг шийдэх арга замыг судалсан.

6.Gartner, P., & Smit, S. (2020). "Malware and Border Security: Understanding the Risks"

Энэхүү судалгаагаар хил дээрх хяналтын системд хорт программын халдлагаас үүсэх эрсдэлийг ойлгож, түүнийг бууруулах арга замуудыг шинжилсэн. Цахим аюулгүй байдлыг хангах технологи, стратегиудын талаарх судалгаа багтжээ.

Нэг. Хорт программын тухай ойлголт

“Хорт” гэдэг үгийг Монгол хэлний тайлбар толинд “Хор



бүхий юм гэж. Харин “Программ” гэдэг үгийг цахим мэдээллийн хангамж[1] хэмээн тодорхойлсон байдаг.

Нийтэд нь утгачилбал хор бүхий цахим мэдээллийн хангамж хэмээн утгачлах боломжтой.

Хорт программ буюу “malware” гэдэг нь “malicious software” гэсэн үгийн товчлол бөгөөд компьютер, сүлжээ, мэдээллийн системийг гэмтээх, удирдах, мэдээлэл хулгайлах, эсвэл системийн хэвийн үйл ажиллагааг тасалдуулах зорилготой программ хангамжийг хэлнэ[2].

Хорт программууд ихэвчлэн халдлагын эх үүсвэр болон

[1] Монголын Хэл Соёлын Судалгааны Төв, "Монгол хэлний эх тайлбар толь," Улаанбаатар, 2024.

[2] M. Sikorski and A. Honig, "Practical Malware Analysis: The Hands-On Guide to Dissecting Malicious Software," No Starch Press, 2012.

хохирлын хэмжээнээс шалтгаалж олон төрөлд хуваагддаг. Энэ төрлийн программ хангамжийг кибер гэмт хэрэгтнүүд, хакерууд болон хорлон сүйтгэгч бүлгүүд зохион бүтээдэг бөгөөд тэдгээрийн зорилго нь эдийн засгийн ашиг олох, тагнуулын үйл ажиллагаа явуулах, эсвэл системийг хянах байж болно[1].

Зураг 1. Хорт программын төрлүүд (Хорт программ нь өөрийн гэсэн онцлог шинж чанар, хор хөнөөлийн ялгаагаараа дээрх үндсэн төрлүүдэд ангилагддаг байна)

Гаалийн хяналтын рентген систем нь хилээр гарах болон орж буй бараа бүтээгдэхүүнийг шалгахад ашиглагддаг ч эдгээр төхөөрөмжүүд нь цахим хяналтын шийдэлд тулгуурладаг учир хорт программын халдлагад өртөх өндөр эрсдэлтэй байдаг. Рентген төхөөрөмжийн цахим хяналтын систем нь олон төрлийн мэдээллийн урсгал, сүлжээ, тоног төхөөрөмжийг нэгтгэдэг тул хорт программ нэвтэрч, эдгээр мэдээллийг өөрчлөх боломжтой[2].

Хорт программын халдлага нь зөвхөн мэдээллийг хулгайлах биш, хил дээрх гаалийн хяналтын үйл ажиллагааг зогсоох, мэдээллийг өөрчлөх, үүний улмаас хууль бус бараа бүтээгдэхүүний нэвтрэлтийг дэмжих эрсдэлтэй.

Хоёр. Байгалийн ховор элементийн талаар

Монгол Улсын хэмжээнд газрын ховор элементийн ислийн нийт 3.1 сая тонны нөөцтэй, нийт 6 орд илрүүлснээс 4 нь том, 2 нь жижиг. Монгол Улс энэхүү эрдсийн баялгаараа дэлхийд эхний 15-д ордог бөгөөд дараах ордууд багтаж байна[3]. Үүнд:

-Улаандөлийн 124.78 тонны орд,

-Халзанбүрэгтэйн 1.511.6 мянган тонны орд,

-Мушгиа худгийн 365.1 мянган тонны орд

-Хотгорын 1,213.7 мянган тонны нөөцтэй орд

-Цагаан чулуутын 274.55 тонны орд,

-Лугийн голын 14.5 мянган тонны орд


Платинум (Pt)

Платинум (Pt) нь байгалийн ховор металл бөгөөд алттай төстэй өнгө, шинж чанартай байдаг. Энэ металл нь өндөр зэврэлт тэсвэртэй, химийн идэвхгүй, цахилгаан дамжуулах чадвар сайтай. Платинум нь алт, мөнгөний зэрэгт байдаг ч илүү өндөр үнэ цэнтэй байдаг.

[1] Kaspersky, "Cyber Threat Landscape Report," Kaspersky Lab, 2021.

[2] Kaufman, L. (2021). "Cybersecurity in Border Control Technologies.

[3] News.mn. (2023). Монголын алтны уурхайн үйлдвэрлэл өссөөр байна./Нийтлэл/



Зураг 2. Платинум элемент

Технологийн хэрэглээ: Платинум нь эрчим хүчний салбарт хамгийн өргөн хэрэглэгддэг металл юм. Ялангуяа авто машины катализаторууд, хими болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, эрчим хүчний салбар зэрэгт ашиглагддаг.

Гоёл чимэглэл: Платинум нь мөн гоёл чимэглэл, зүүлт, бөгж зэрэгт хэрэглэгддэг. Түүний зэврэлтээс хамгаалагдсан шинж чанар нь гоёл чимэглэлийн үйлдвэрлэлд үнэт металл болгодог[1].

Палладиум (Pd)

Палладиум (Pd) нь мөн платинум бүлгийн металл бөгөөд нь байгальд ихэнхдээ платинум болон родиум-тай хамт илрэх юм. Палладиум нь хөнгөн, зэврэлтэд тэсвэртэй, цахилгаан дамжуулах чадвар өндөртэй.




Зураг 3. Палладиум элемент

Технологийн хэрэглээ: Палладиум нь катализатор болон электроник үйлдвэрлэлд ихээхэн ашиглагддаг. Энэ нь машины хаягдлыг цэвэршүүлэх болон цахим төхөөрөмжүүд дээр хэрэглэгддэг.

Эрчим хүчний хэрэглээ: Палладиум нь цахилгаан автомашинууд болон түлшний хаягдлыг цэвэрлэх шинэ технологид ашиглагддаг[2].

Родиум (Rh)

Родиум (Rh) нь ховор металл бөгөөд өндөр зэврэлтэд тэсвэртэй, бат бөх чанар сайтай, тус элемент нь зэвсэг үйлдвэрлэлд өргөнөөр ашиглагддаг. Родиум нь мөн катализатор болон электрон төхөөрөмжүүд дээр ашиглагддаг. Энэ нь автомашины хаягдлын хийн системд өргөн хэрэглэгддэг[3].




[1] Britannica. (2022). Platinium. Encyclopedia Britannica.
[2] Britannica. (2022). Palladium. Encyclopedia Britannica.
[3] ScienceDirect. (2022). Rhodium. ScienceDirect Topics.

Зураг 4. Родиум элемент

Технологийн хэрэглээ: Родиум нь автомашины катализаторуудаар хамгийн их хэрэглэгддэг. Энэ нь хорт хийнүүдийг (нүүрсхүчлийн хий, азотын оксид гэх мэт) цэвэршүүлдэг.

Иридиум (Ir)

Иридиум (Ir) нь платинум бүлгийн хамгийн хүнд металл бөгөөд өндөр халуунд тэсвэртэй, устай болон зэврэлттэй орчинд ч тогтвортой байдаг. Иридиум нь хамгийн хүнд металлуудын нэг бөгөөд хямд биш, ховор ашиглагддаг металл юм[1].



Зураг 5. Иридиум элемент

Технологийн хэрэглээ: Иридиум нь өндөр температурт тэсвэртэй материал шаарддаг төхөөрөмжүүд, гэрэл гэрэлтүүлэг, цөмийн технологи зэрэгт хэрэглэгддэг.

Эрчим хүч: Иридиум нь цөмийн цахилгаан станцын бүтцэд ашиглагддаг бөгөөд аюулгүй ажиллагаа, өндөр температурт тэсвэрлэх чадвартай.

Осмиум (Os)

Осмиум (Os) нь платинум бүлгийн хамгийн хүнд металл бөгөөд өндөр зэврэлт тэсвэртэй, тунгалаг шинж чанартай байдаг. Осмиум нь химийн хувьд маш тогтвортой, удаан хугацаанд гэмтэхгүй байдаг[2].



Зураг 6. Осмиум элемент

Технологийн хэрэглээ: Осмиум нь цөмийн энерги болон химийн үйлдвэрүүд зэрэгт хэрэглэгддэг. Мөн үүнийг электрон, механик төхөөрөмжүүдэд ашиглаж байна.

Нэг грамм цэвэр элемент дунджаар 10-20000 ам.долларт хүрдэг байна[3]. Байгалийн ховор элементийг олборлож худалдаалах нь маш их хэмжээний ашиг олох боломжтой тул улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх эрсдэлийг дагуулж байна.

Гурав. Хилийн шалган нэвтрүүлэх рентген сканерын үйл ажиллагаа ба, системийн аюулгүй байдлыг хангах талаар

Олон улсын түвшинд хилийн рентгений төхөөрөмжүүд нь аюулгүй байдал, терроризм, хуурамч бараа бүтээгдэхүүн, мансууруулах бодис болон бусад

[1] ChemicalBook. (2022). Iridium. ChemicalBook.
[2] ChemicalBook. (2022). Osmium. ChemicalBook.
[3] News.mn. (2023). Монголын алтны уурхайн үйлдвэрлэл өссөөр байна./Нийтлэл/

хууль бус зүйлсийг илрүүлэхэд хэрэглэгддэг. Энэ салбарт Smiths Detection, Leidos зэрэг олон улсын компаниуд рентген тоног төхөөрөмжийг үйлдвэрлэж, хилийн хяналтад өргөнөөр ашиглагдаж байна.

1. Smiths Detection - Smiths Detection компани нь HCV болон Hi-Scan 6040i зэрэг рентген төхөөрөмжүүдийг олон улсын хилийн хяналтын байгууллагуудад нийлүүлдэг. Эдгээр төхөөрөмжүүд нь ачаа болон зорчигчдын тээшинд дүн шинжилгээ хийхэд ашиглагддаг бөгөөд террористууд болон контрабандчдыг илрүүлэхэд тусалдаг[1].

2. Leidos - Leidos нь хилийн аюулгүй байдал болон ачаа тээврийн шалгалтын зориулалттай рентген төхөөрөмжүүдийг нийлүүлдэг бөгөөд эдгээр төхөөрөмжүүд нь хилийн аюулгүй байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тус компани нь өндөр нарийвчлалтай рентген системийн шийдлийг санал болгодог[2].

Монгол Улс нь хилийн аюулгүй байдлыг хангах, хил дээрх ачаа болон зорчигчдыг шалгахдаа дараах төхөөрөмжийг ашигладаг байна.

Монгол Улсад хилийн шалгалт хийхэд **Smiths Detection** компанийн рентген төхөөрөмжүүд болон **Nuctech** компанийн **X-ray scanners** ашигладаг. **Nuctech** компанийн рентген системүүд нь ачааны автомашинуудыг хянан шалгах, хууль бус зүйлсийг илрүүлэх, болон хилийн аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор хэрэглэгддэг. Тус төхөөрөмж нь өндөр чанарын зураглал, харьцангуй бага хугацаанд илрүүлэлт хийх боломжийг олгодог[3].



Зураг 7. Smith detection компанийн Nuctech рентген

Хилийн Рентген Системүүдэд Хорт Программын Халдлагын Жишээ

Хилийн аюулгүй байдал, гаалийн хяналтын системүүд нь ихэвчлэн нууцлалтай бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаа болон халдлагын талаарх тоон мэдээлэл олон нийтэд ил болох нь ховор.

2017 оны WannaCry халдлага

Хорт программ нь дэлхий даяар олон улсын байгууллагуудын компьютерын сүлжээг халдлагад автуулсан бөгөөд рентген системүүд ч үүнд

[1] Smiths Detection. (2022). High security X-ray machines.
[2] Leidos. (2022). Advanced X-ray technologies for border security.
[3] Nuctech. (2021). X-ray scanners for customs and border security.

өртөж байжээ. Энэ халдлагын үед олон улсын гаалийн байгууллагуудын хилийн рентген системүүд ажиллахаа больж, нэг хэсэг нь аюулгүй байдлын зэрэглэлд хүчтэй нөлөө үзүүлсэн. *CISA (Cybersecurity and Infrastructure Security Agency)* байгууллага тус хорт программын халдлагаар аюулгүй байдлын чиглэлд анхаарал хандуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч эхэлсэн байна[1].

NotPetya халдлага

Тус халдлага нь 2017 онд дэлхий даяар олон байгууллагын компьютер системд халдварласан бөгөөд энэ нь рентген болон аюулгүй байдлын системд саатал үүсгэж, хил дээрх аюулгүй байдлыг сулруулсан байна. Тус хорт программ нь мэдээлэл шифрлэх замаар олон улсын аюулгүй байдлын тогтолцооны системийг хохирол амсуулахад хүргэсэн[2].

Гаалийн хяналтын рентген төхөөрөмжүүдэд хорт программын халдлагаас сэргийлэх дараах хэдэн стратегиудыг багтааж үзэж болно:

Системийн аюулгүй байдлыг сайжруулах

Рентген хяналтын систем нь цахим хяналтын шилдэг технологийг ашигладаг ч хорт программын халдлагаас хамгаалахын тулд чухал анхаарал шаарддаг. Эдгээр системүүдэд хорт программын халдлагын эрсдэлээс сэргийлэхийн тулд антивирус болон кибер аюулгүй байдлын программ хангамжийг ашигладаг хэдий ч шинэ төрлийн хорт программыг танихын тулд тогтмол сайжруулалт хийх шаардлагатай. Хорт программыг илрүүлэх, устгах, эсвэл халдлагын эх үүсвэрийг устгах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах гол арга юм[3]. Түүнчлэн, гаалийн хяналтын төхөөрөмжийн хяналтын сүлжээнд хэрэглэх антивирус, firewall системүүдийг байнга шинэчилж байх шаардлагатай.

Мэдээллийг шифрлэх арга хэмжээ авах

Рентген хяналтын төхөөрөмжийн өгөгдлийг шифрлэх нь хорт программын халдлагаас сэргийлэх хамгийн чухал арга юм. Хорт программ нь системд нэвтэрч, мэдээллийг өөрчлөх, хуурамч мэдээлэл илгээх замаар гаалийн хяналтын ажиллагаанд нөлөөлж болно. Иймээс шифрлэлт хийх нь мэдээллийг зөвхөн зөвшөөрөгдсөн хэрэглэгчдэд хүргэх боломжийг олгодог[4]

[1] Smiths Detection. (2021). Cybersecurity in border security systems.
[2] Kaspersky. (2020). Cybersecurity in critical infrastructure systems.
[3] Boulanger, M., & Li, X. (2020). Cybersecurity in critical infrastructure: A review of emerging threats and solutions. International Journal of Cybersecurity, 5(2), 45-63.
[4] Miller, T. (2022). "Cyber Threats in Customs and Border Security Systems."

Олон улсын хамтын ажиллагаа

Кибер аюулгүй байдлын асуудал нь олон улсын хэмжээнд хамтран ажиллах шаардлагатай асуудал болж байна. Рентген хяналтын төхөөрөмжийн аюулгүй байдалд цахим халдлагын эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд олон улсын аюулгүй байдлын байгууллагуудтай хамтран ажиллах нь чухал юм. Олон улсын хамтын ажиллагаа нь шинэ төрлийн халдлагыг илрүүлэх, устгах болон эдгээр халдлагуудын нөлөөг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ[1].

Алба хаагч, ажилтны мэдлэгийг дээшлүүлэх

Гаалийн хяналтын байгууллагын ажилтнуудад кибер аюулгүй байдал, хорт программын халдлагаас сэргийлэх сургалтыг тогтмол зохион байгуулснаар мэргэжилтнүүдийн чадавх сайжирч, асуудал гарсан тохиолдолд шуурхай хариу арга хэмжээ авах боломжтой бүрдэнэ.

Дөрөв. Гэмт хэргийн зүйлчлэл

Байгалийн ховор элемент болон хилийн рентген системд халдах цахим гэмт хэрэг нь дан ганц төрлөөр зүйлчлэгдэх бус олон төрлийн гэмт хэргийн шинжийг давхар агуулж байна. Үүнд.

Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэг (Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг)-ийн 26.1 (Кибер орчинд хууль бусаар халдах), 26.2 (Кибер орчинд хууль бусаар халдах, программ хангамж, техник хэрэгсэл бүтээх, бэлтгэх, борлуулах, ашиглах, тараах), 18.5 (Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх), 18.3 (Татвар төлөхөөс зайлсхийх) зэрэг гэмт хэргийн төрөл ангилалд хамаарч байна.

Дүгнэлт

Хилийн рентген системүүд нь хориглосон ачаа тээш нэвтрэх эрсдэл, аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг боловч технологийн хөгжлийн энэ үед эдгээр системүүд нь хорт программ болон кибер халдлагад өртөх эрсдэлтэй байдаг. Эдгээр халдлагууд нь тухайн улсын хил, гаалийн аюулгүй байдалд томоохон эрсдэл учруулж, ачаа болон зорчигчдын мэдээллийг алдах, системийн ажиллагааг саатуулах, бүр томоохон эрсдэл үүсгэх боломжтой.

Хорт программын халдлагын тохиолдлууд нь рентген системийн программ хангамжийн эмзэг байдал, системийн шинэчлэлтүүдийн дутагдал, сүлжээний хамгаалалтгүй байдал зэрэг хүчин

Journal of Cyber Risk Management, 14(1), 77-82.

[1] Chen, Y., Liu, J., & Wu, Z. (2021). "International Cooperation on Customs Border Control Cybersecurity." Global Border Security Review, 10(4), 134-142.

зүйлсийн нөлөөгөөр үүсдэг. Одоогийн байдлаар олон улсад хилийн рентген системийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн олон арга хэмжээ, бодлогын санаачилгуудыг хэрэгжүүлж байгаа ч, энэ асуудал нь бүрэн шийдэгдээгүй хэвээр байна. Тиймээс, хорт программын халдлагаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх нь рентген төхөөрөмжүүдийн аюулгүй байдлын хамгийн чухал хэсэг болох бөгөөд үүнийг сайжруулах шаардлагатай.

Рентген системийн хорт программын халдлагаас урьдчилан сэргийлэхийн тулд тавигдах шаардлага нь чухал бөгөөд технологийн шинэчлэл, тогтмол системийн шалгалт, мэргэжлийн сургалтууд хэрэгтэй. Гэхдээ эдгээр арга хэмжээнүүдийг зөв хэрэгжүүлэх нь зөвхөн технологийн асуудал биш, харин улс орнуудын аюулгүй байдлын байгууллагууд, кибер аюулгүй байдлын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа, төсвийн хуваарилалттай ч холбоотой юм.

Программ хангамжийн шинэчлэлт болон системийн хяналт нь зөвхөн хорт программын халдлагад өртөх эрсдэлийг бууруулахад биш, мөн ашигт ажиллагааны өндөр түвшнийг хадгалахад чухал ач холбогдолтой. Хилийн рентген системийн сүлжээний хамгаалалт болон хорт программ илрүүлэх системүүдийн аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах нь халдлагын эрсдэлийг бууруулах, мөн цаашдын технологийн хязгаарлалт, эмзэг байдлыг арилгах гол арга юм.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зөв хэрэгжүүлснээр, рентген системүүд нь хорт программын халдлагаас хамгаалагдаж, олон улсын аюулгүй байдалд хүлээсэн үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой. Рентген тоног төхөөрөмжүүдийн хорт программын халдлагад өртөх нь зөвхөн тоног төхөөрөмжийн ажиллагааг зогсоох бус, улс орнуудын хил хамгаалалт, аюулгүй байдалд чухал нөлөө үзүүлэх учраас энэ асуудалд анхаарал хандуулах нь нэн чухал. Тиймээс, хилийн рентген системийн хамгаалалтын арга хэмжээг сайжруулах, хорт программын халдлагаас сэргийлэхийн тулд олон улсын хамтын ажиллагаа, технологийн шинэчлэлтүүд, мэдээллийн аюулгүй байдлын чадавхуудыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Эх сурвалж:

1. Монголын Хэл Соёлын Судалгааны Төв, "Монгол хэлний эх тайлбар толь," Улаанбаатар, 2024.
2. News.mn, "Монголын алтны уурхайн үйлдвэрлэл өссөөр байна," 2023. [Нийтлэл].
3. Kaspersky, "Cyber Threat Landscape Report," Kaspersky Lab, 2021.

4. Kaspersky, "Cybersecurity in critical infrastructure systems," 2020.
5. Kaufman, L. (2021). "Cybersecurity in Border Control Technologies."
6. F. Müller, "Machine Learning for Malware Detection," International Journal of Cybersecurity, vol. 14, no. 2, pp. 100-110, 2020.
7. M. Sikorski and A. Honig, Practical Malware Analysis: The Hands-On Guide to Dissecting Malicious Software, No Starch Press, 2012.
8. Smiths Detection, "Cybersecurity in border security systems," 2021.
9. Smiths Detection, "High security X-ray machines," 2022.
10. Leidos, "Advanced X-ray technologies for border security," 2022.
11. Nuctech, "X-ray scanners for customs and border security," 2021.
12. Britannica, "Platinium," Encyclopedia Britannica, 2022.
13. Britannica, "Palladium," Encyclopedia Britannica, 2022.
14. ScienceDirect, "Rhodium," ScienceDirect Topics, 2022.
15. ChemicalBook, "Iridium," ChemicalBook, 2022.
16. ChemicalBook, "Osmium," ChemicalBook, 2022.
17. Boulanger, M., & Li, X. (2020). "Cybersecurity in critical infrastructure: A review of emerging threats and solutions," International Journal of Cybersecurity, 5(2), 45-63.
18. Miller, T. (2022). "Cyber Threats in Customs and Border Security Systems," Journal of Cyber Risk Management, 14(1), 77-82.
19. Chen, Y., Liu, J., & Wu, Z. (2021). "International Cooperation on Customs Border Control Cybersecurity," Global Border Security Review, 10(4), 134-142.

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГАД ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИСЫН МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХ ТОГТОЛЦОО: АСУУДАЛ, ШИЙДЭЛ БА ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН НЭВТРҮҮЛЭЛТ

Э.Соронзонболд
ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн ахлах багш, хошууч

Товч агуулга: Хил хамгаалах байгууллага нь тэсрэх бодисыг аюулгүй хэрэглэж, хилийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Гэвч, энэ салбарт боловсон хүчин бэлтгэх үйл явцад олон асуудал тулгарч байна. Сургалтын хөтөлбөр, тоног төхөөрөмж, хүн хүчний хомсдол зэрэг асуудлууд нь аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Судалгаагаар сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, олон улсын стандартыг нэвтрүүлэх, орчин үеийн тоног төхөөрөмжийг ашиглах, хүн хүчний тоог нэмэгдүүлэх зэрэг шаардлагууд гарч байна. Түүнчлэн, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүүжилт болон улс төрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх нь чухал. Эдгээр асуудлыг шийдвэрлэх нь аюулгүй хэрэглээг хангаж, улсын аюулгүй байдлыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Түлхүүр үг:Хил хамгаалах, Аюулгүй байдал, Боловсон хүчин, Сургалтын хөтөлбөр, Тоног төхөөрөмж, Олон улсын стандарт

Удиртгал

Хил хамгаалах байгууллага нь улс орны Хилийн аюулгүй байдлыг хангах, уг бодисын хяналтыг хангах чухал үүрэг гүйцэтгэдэг. Аюулгүй байдлыг хангах, стратегийн чухал объектуудыг хамгаалахад өргөн хэрэглэгддэг боловч түүнийг зөв хэрэглэх, хянах нь өндөр түвшнийг шаарддаг. Уг бодисыг зөв хэрэглэх нь зөвхөн аюулгүй байдлыг хангахад чухал төдийгүй, хүний амь нас, байгаль орчин, эдийн засгийн эрсдэлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Гэсэн хэдий ч сүүлийн үед Хил хамгаалах байгууллагад хүнээ бэлтгэхэд хангалтгүй хандлага ажиглагдаж байна. Боловсон хүчний бэлтгэл, хөтөлбөр, тоног төхөөрөмжийн хангалтгүй байдал зэрэг нь аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангахад хүндрэл учруулж байна. Энэ нь зөвхөн дотоодын аюулгүй байдалд нөлөөлөхөөс гадна, олон улсын хэмжээнд хилийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой асуудал юм.

Энэхүү судалгаа нь Хил хамгаалах байгууллагад ажиллах хүн бэлтгэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлж, шийдлийн арга замыг санал болгох

зорилготой. Судалгааны үр дүн нь аюулгүй байдлыг бэхжүүлэх, зөв хэрэглэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг боловсруулахад чухал ач холбогдолтой юм. Мөн энэхүү судалгаа нь боловсон хүчний бэлтгэлийг боловсронгуй болгох, олон улсын стандартыг нэвтрүүлэх, аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн практик шийдлүүдийг санал болгох болно.

Үндсэн хэсэг

Боловсролын онол болон аюулгүй байдлын удирдлагын онолын үүднээс мэргэшсэн хүнээ бэлтгэх тогтолцоо, түүнд тулгамдаж буй асуудлууд

1.Мэргэжлийн боловсролын онолын үүднээс дүн шинжилгээ

Мэргэжлийн боловсролын онол нь боловсон хүчний бэлтгэлийг зохион байгуулах, хөтөлбөр боловсруулах, сургах арга барилыг тодорхойлоход чиглэгддэг. Хүнээ бэлтгэхэд энэ онолын үндсэн зарчмуудыг дараах байдлаар хэрэгжүүлж болно:

Сургалтын хөтөлбөрийн боловсронгуй байдал

Мэргэшсэн хүн бэлтгэхэд онолын мэдлэг, практик ур чадварыг хослуулсан хөтөлбөр боловсруулах нь чухал.

Олон улсын стандартыг нэвтрүүлэх, жишээлбэл, НАТО, НҮБ-ын стандартуудыг хөтөлбөрт оруулах шаардлагатай.

Сургалтын арга барил

Орчин үеийн сургалтын арга барилыг ашиглах, жишээлбэл, виртуал бодит байдал (VR), симулятор, интерактив сургалтын хэрэгслүүдийг ашиглах нь үр дүнтэй.

Онолын мэдлэг, практик ур чадварыг хослуулсан хэрэгжүүлэх нь чухал.

Боловсон хүчний бэлтгэл

Хүн хүчний хүчний тоог нэмэгдүүлэх, тэдгээрийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулах шаардлагатай.

Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах нь чухал.

2.Аюулгүй байдлын удирдлагын онолын үүднээс дүн шинжилгээ

Аюулгүй байдлын удирдлагын онол нь аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг урьдчилан таамаглах, хяналт тавих арга замыг тодорхойлдог. Хүнээ бэлтгэхэд энэ онолын үндсэн зарчмуудыг дараах байдлаар хэрэгжүүлж болно:

Аюулгүй ажиллагааны стандарт

Уг бодисыг аюулгүй ашиглах, хадгалах, тээвэрлэхэд чиглэсэн стандартыг сургалтад оруулах нь чухал. Аюулгүй ажиллагааны стандартыг олон улсын хэмжээнд нийцүүлэн боловсруулах шаардлагатай.

Эрсдэлийн удирдлага

Уг бодисыг хэрэглэх явцад гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан таамаглах, түүнийг бууруулах арга замыг оруулах нь чухал.

Эрсдэлийн үнэлгээ, менежментийн арга барилыг нэвтрүүлэх шаардлагатай.

Хяналт, шалгалт

Хэрэглэх явцад хяналт, шалгалтыг үр дүнтэй зохион байгуулах арга замыг сургалтад оруулах нь чухал.

Хяналтын тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах шаардлагатай.

3.Мэргэшсэн хүн бэлтгэхэд тулгамдаж буй асуудлууд

-Хөтөлбөрийн хангалтгүй байдал

-Олон улсын стандартыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

-Онолын мэдлэг, практик ур чадварыг хослуулсан байдал хангалтгүй.

-Орчин, тоног төхөөрөмжийн дутагдал

-Орчин үеийн лаборатори, полигон, симуляторын тоног төхөөрөмж хангалтгүй.

-Технологийн шинэчлэлийг бүрэн нэвтрүүлээгүй байна.

-Хүн хүчний хомсдол

-Олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл

-Олон улсын стандартыг дотоодын нөхцөлд тохируулах, хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгарч байна. Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд хүндрэл учруулж байна.

Аюулгүй байдлын удирдлагын онолын үүднээс хүн хүчээ бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох нь чухал. Энэ нь сургалтын хөтөлбөр, материаллаг бааз, хүн хүчний бэлтгэл, олон улсын стандартыг хэрэгжүүлэх зэрэг олон талыг хамардаг. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд онол болон аюулгүй байдлын удирдлагын онолыг хослуулан ашиглах нь үр дүнтэй арга зам болно.

Монгол Улсын хэмжээнд хүнээ бэлтгэх ажил нь улс орны аюулгүй байдал, хилийн хамгаалалт, уул уурхай, барилгын салбарын хэрэгцээг хангах зорилгоор хөгжиж ирсэн. Энэ нь түүхэн хөгжил, олон улсын хамтын ажиллагаа, дотоодын боловсролын системийн өөрчлөлтөөс хамааран хэд хэдэн үе шатыг туулж ирсэн.

1. Анхны үе шат (20-р зууны дунд үе):

Монгол Улсад уул уурхай, барилгын салбарт ашиглах болсноор анхны ажилтан нь гадаадын их, дээд сургуулиудад суралцаж, дадлагажсан. ЗХУ-ын их, дээд сургуулиудад уг бодисын технологи, аюулгүй ажиллагааны чиглэлээр ажиллах хүчээ бэлтгэж байв.

2.Хувьсгалт өөрчлөлтийн үе (1990-ээд онууд):

1990-ээд оны ардчилсан хувьсгалын дараа Монгол Улс шинэ эдийн засгийн нөхцөлд шилжсэн. Уул уурхайн салбар хөгжиж, хэрэглээ нэмэгдсэнээр орон тоо өссөн. Энэ үед гадаадын их, дээд сургуулиудад энэ чиглэлээр суралцах оюутнуудын тоо нэмэгдсэн.

3.Одоогийн үе (2000-аад оноос хойш):

Монгол Улсын их, дээд сургуулиуд уг бодисын технологи, аюулгүй ажиллагааны чиглэлээр мэдлэгтэй хүн бэлтгэх хөтөлбөрийг хөгжүүлж эхэлсэн. Жишээлбэл, ШУТИС-ийн Уул уурхайн сургууль, ХААИС-ийн Барилга, үйлдвэрлэлийн технологийн сургуульд тэсрэх бодисын технологи, аюулгүй ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх хөтөлбөрүүд нэвтрүүлсэн.

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд гадаадын их, дээд сургуулиудтай хамтран сургалт, семинар, судалгааны ажлуудыг зохион байгуулж эхэлсэн.

ажиллах хүч бэлтгэхэд тулгарч буй асуудлыг задлан шинжилсэн дүн шинжилгээ

Асуудлын модны арга нь үндсэн асуудлыг тодорхойлж, түүний шалтгаан, дэд асуудлуудыг системчилсэн байдлаар илрүүлэхэд тусалдаг. Энэ аргыг ашиглан ажиллах хүчээ бэлтгэхэд тулгарч буй асуудлыг дараах байдлаар задлан шинжилье.

1.Үндсэн асуудал:

Боловсон хүчин бэлтгэх нь аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй байна.

2.Үндсэн асуудлын шалтгаанууд (Дэд асуудлууд):

-Хөтөлбөрийн боловсронгуй бус байдал

-Онолын мэдлэг, практик ур чадварыг хослуулсан нь хөтөлбөр хангалтгүй.

-Олон улсын стандартыг бүрэн хэрэгжүүлээгүй.

-Орчин, тоног төхөөрөмжийн дутагдал

-Орчин үеийн лаборатори, полигон, симуляторын тоног төхөөрөмж хангалтгүй.

-Технологийн шинэчлэлийг бүрэн нэвтрүүлээгүй.

-Ажилла боловсон хүчний хомсдол

-Боловсон хүчний тоо хязгаарлагдмал.

-Олон улсын туршлагатай хүн хүчний хомсдол байна.

-Олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл

-Олон улсын стандартыг дотоодын нөхцөлд тохируулах, хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгарч байна.

-Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд хүндрэл учруулж байна.

3.Дэд асуудлуудын цаашдын шалтгаанууд:

-Сургалтын хөтөлбөрийн боловсронгуй бус байдал

-Сургалтын хөтөлбөрийг шинэчлэхэд шаардлагатай нөөц, санхүүжилт хангалтгүй.

-Орчин, тоног төхөөрөмжийн дутагдал

-Сургалтын баазыг шинэчлэх, тоног төхөөрөмж худалдан авахад шаардлагатай санхүүжилт хангалтгүй.

-Технологийн шинэчлэлийг нэвтрүүлэхэд чадварлаг хүн хомс.

-Чиглэсэн хөтөлбөр хангалтгүй.

-Олон улсын туршлагатай хүн татах, хадгалах арга хэмжээ хангалтгүй.

-Олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл

-Олон улсын стандартыг дотоодын нөхцөлд тохируулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн багш хүчин хомс.

-Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, улс төрийн дэмжлэг хангалтгүй.

4.Асуудлын модны дүгнэлт:

Чадварлаг хүнээ бэлтгэхэд тулгарч буй асуудлыг модны аргаар задлан шинжилснээр дараах үндсэн шалтгаануудыг тодорхойлсон:

-Сургалтын хөтөлбөрийн боловсронгуй бус байдал.

-Орчин, тоног төхөөрөмжийн дутагдал.

-Хүн хүчний хомсдол.

Олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, орчин, тоног төхөөрөмжийг боловсронгуй болгох, хүн хүчний тоог нэмэгдүүлэх, олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Шийдлийн модны аргаар дадлагашсан мэргэжилтэн бэлтгэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга замын дүн шинжилгээ Шийдлийн модны арга нь үндсэн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга замыг тодорхойлж, түүний дэд шийдлүүдийг системчилсэн байдлаар илрүүлэхэд тусалдаг. Энэ аргыг ашиглан боловсон хүчин бэлтгэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга замыг дараах байдлаар задлан шинжилье.

1. Үндсэн шийдэл:

Бэлтгэх системийг боловсронгуй болгох.

2. Үндсэн шийдлийн дэд шийдлүүд:

-Хөтөлбөрийг шинэчлэх

-Онолын мэдлэг, практик ур чадварыг хослуулсан.

-Олон улсын стандартыг нэвтрүүлэх.

-Сургалтын бааз, тоног төхөөрөмжийг шинэчлэх

-Орчин үеийн лаборатори, полигон, симуляторын тоног төхөөрөмж худалдан авах.

-Технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх.

-ажиллах хүн хүчний тоог нэмэгдүүлэх

-Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

-Олон улсын стандартыг хэрэгжүүлэх

-Олон улсын стандартыг дотоодын нөхцөлд тохируулах.

-Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах.

3.Дэд шийдлүүдийн цаашдын арга хэмжээ:

Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх

-Олон улсын стандартыг нэвтрүүлэхэд шаардлагатай заах багш бэлтгэх.

-Онолын мэдлэг, практик ур чадварыг хослуулсан сургалтын материал.

-Сургах орчныг шинэчлэх, тоног төхөөрөмж худалдан авахад шаардлагатай санхүүжилтийг хангах.

-Технологийн шинэчлэлийг нэвтрүүлэхэд шаардлагатай мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх.

-Ажиллах хүчний тоог нэмэгдүүлэх

-Шинэ ажилтан бэлтгэх, хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хангах.

-Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай улс төрийн дэмжлэгийг хангах.

-Олон улсын стандартыг хэрэгжүүлэх

-Олон улсын стандартыг дотоодын нөхцөлд тухируулахад шаардлагатай мэргэжлийн багш хүчнийг бэлтгэх.

Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахад шаардлагатай санхүүжилтийг хангах. Мэдлэгтэй хүн бэлтгэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн шийдлийн модны аргаар дараах үндсэн шийдлүүдийг тодорхойлсон:

-Сургалтын бааз, тоног төхөөрөмжийг шинэчлэх.

-Хүн хүчний тоог нэмэгдүүлэх.

-Олон улсын стандартыг хэрэгжүүлэх.

Эдгээр шийдлүүдийг хэрэгжүүлснээр мэргэжилтнийг бэлтгэх системийг боловсронгуй болгож, аюулгүй байдлын шаардлагыг хангах боломжтой болно.

Дүгнэлт:

Монгол Улсын хэмжээнд тэсэрч дэлбэрэх бодисын мэргэжилтэн бэлтгэх ажил нь улс орны аюулгүй байдал, уул уурхай, барилгын салбарын хэрэгцээг хангах зорилгоор хөгжиж ирсэн. Түүхэн хөгжил, олон улсын хамтын ажиллагаа, дотоодын боловсролын системийн өөрчлөлтөөс хамааран хэд хэдэн үе шатыг туулж, одоогийн байдлаар тэсрэх бодисын технологи, аюулгүй ажиллагааны чиглэлээр мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх тогтолцоо бүрдсэн. Гэсэн хэдий ч сургалтын хөтөлбөр, бааз, тоног төхөөрөмжийн хангалтгүй байдал, орон тооны хомсдол, олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл зэрэг асуудлууд тулгамдаж байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх нь аюулгүй, үр дүнтэй ашиглах, улс орны аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Санал:

Системийг боловсронгуй болгох, аюулгүй байдлын шаардлагыг хангахын тулд дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

-Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх:

-Онолын мэдлэг, практик ур чадварыг хослуулах.

-Олон улсын стандартыг нэвтрүүлэх, жишээлбэл, НАТО, НҮБ-ын стандартуудыг ашиглах.

-Сургалтын бааз, тоног төхөөрөмжийг шинэчлэх:

-Орчин үеийн лаборатори, полигон, симуляторын тоног төхөөрөмж худалдан авах.

-Технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх, виртуал бодит байдал (VR) зэрэг орчин үеийн технологийг ашиглах.

-Ажиллах хүчний тоог нэмэгдүүлэх:

-Шинэ хөтөлбөрийг хөгжүүлэх.

-Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын их, дээд сургуулиудтай хамтран ажиллах.

-Олон улсын стандартыг хэрэгжүүлэх:

-Олон улсын стандартыг дотоодын нөхцөлд тохируулах, хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

-Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, семинар, сургалт зохион байгуулах.

-Санхүүжилт, улс төрийн дэмжлэг:

-Орчин, тоног төхөөрөмжийг шинэчлэх, хүнээ бэлтгэхэд шаардлагатай санхүүжилтийг хангах.

-Улс төрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах зэрэг саналууд болно.

Эх сурвалж:

Ном, сурах бичиг:

Иванов, Д. П. (2020). Мэргэжлийн боловсролын онол: Үндсэн ойлголтууд, арга зүй. Хүн ам, боловсролын хэвлэл.

Норов, Д. Б. (2021). Аюулгүй байдлын удирдлагын онол: Зарчим ба арга барил. Мэргэжлийн боловсрол хэвлэл.

Цахим эх сурвалж:

Бат, Ж. П. (2023). Аюулгүй байдлын удирдлагын шинэ арга барил. Security Theory. https://www.securitytheory.com/new_approaches

Johnson, S. R. (2021). Cybersecurity management theories and practices. Journal of Security Studies, 15(4), 78-92. https://www.jsecuritystudies.com/cybersecurity_theories

Williams, M. T. (2020). Introduction to security management theories. Academic Press. https://www.academicpress.com/intro-security-management

СУРАЛЦАГЧ, ОЮУТНЫ БИЕИЙН ТАМИРЫН БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНД ЭРХ ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Х.Түвшинтөгс
ДХИС-ийн Биеийн тамир, албаны бэлтгэлийн институтийн ахлах багш, дэд хурандаа

Товч агуулга: Боловсрол нь иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулах хүчин зүйл билээ. Харин боловсролын хүрээнд оюутны биеийн тамирын асуудал орхигдсоор ирсэн. Биеийн тамирын дасгалаар бие бялдар, эрүүл мэндэд ямар өөрчлөлт гарч болохыг судлан үзлээ. Сүүлийн жилүүдэд чимээгүй тахал гэж нэрлэгдэх таргалалт ихсэх болсон. Үүний шалтгааныг биеийн тамирын боловсролгүй байдал гэж үзсэн. Судалгааны ажлын хүрээнд Дотоод Хэргийн Их Сургуулийн сонсогчдын 21 хоногийн цэрэгжилтийн бэлтгэлийн өмнө болон дараах чанарыг тоон судалгааны аргаар судалж, үр дагаврааp нь нэгтгэн дүгнэлээ. Оюутны биеийн тамирын хөгжил 21 хоногийн хугацаанд өөрчлөгдөж, чанар, амжилт өссөн.

Түлхүүр үгс: Биеийн тамирын боловсрол, эрүүл мэнд, илүүдэл жин

Удиртгал

“Generation Z” үеийн оюутан залуус хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн техник технологийг хэрэглэж, мэдээллийн технологийн ачаар хүссэн мэдээллээ хялбараар авч байгаа нь оюутны бие бялдарын хөгжилд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Дотоод Хэргийн Их Сургууль нь төрийн тусгай албан хаагч бэлтгэдэг төрийн өмчит их сургуулийн хувьд цэрэгжилтийн дүрэм, сургуулилтаар сургалт ордог. Тиймээс Сонсогч, оюутны биеийн тамирын боловсрол, эрүүл мэнд чухал шалгуур үзүүлэлт болдог. Цэрэгжилтийн анхан шатны мэдлэг олгох 21 хоногийн сургалтын үр дүнг судалж амжилт, чанарын үзүүлэлтийн өөрчлөлтийг илтгэлийн судалгаанд оруулаа.

Биеийн тамирын боловсролын талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

Дээр дурдагдсан хүрээнд илтгэлээ гурван дэд сэдвийн хүрээнд задлан бичихийг зорилоо.

Үндсэн хэсэг

Оюутны биеийн тамирын боловсрол

Өнөөгийн нийгэм мэдлэгт суурилсан тогтвортой хөгжилд тулгуурлан, шинжлэх ухаан технологийг эрчимтэй хөгжүүлснээр хүний биеийн идэвхтэй хөдөлгөөнийг хязгаарлаж, оюуны өндөр чадамж шаардаж байна. Оюутан насан туршдаа тасралтгүй суралцаж,

бүтээлчээр ажиллаж, чанартай амьдрахад зайлшгүй шаардлагатай биеийн тамирын боловсрол олж авах нь хувь хүний хэрэгцээ болж байгаа билээ.


“Биеийн тамир” гэж нийгмийн соёлын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хүний бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх, хөдөлгөөнийг идэвхийг сайжруулах зорилгоор оюуны болон материаллаг үнэт зүйлийг бий болгох ажиллагаа,[1] “Боловсрол” гэж түүхээр бий болсон, нийгмийн ухамсарт зохих хэмжээгээр суусан, ямар нэгэн төгс дүрд зориуд чиглүүлэн бие хүний оюун санаа, бие бялдар, нийгмийн шинжийг төлөвшүүлэх бүх л үйл явцыг ойлгоно.[2]

Эрүүл биед саруул ухаан оршдогоор биеийн тамирын боловсрол бол бие бялдрыг хөгжүүлэх эрүүл мэндийг төлөвшүүлэх үйл явц юм.

“Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний тав дахь удаагийн судалгааны дүнгээр 15-49 насны хоёр хүн тутмын нэг нь жингийн илүүдэлтэй байна.[3]

Улаанбаатарт 137170 бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдагчдын 2019 оны мэдээгээр 17870 нь илүүдэл жинтэй байна гэсэн тоон үзүүлэлт гарчээ.[4] Энэ сорилд харьцангуй





тамирчид хамрагдсан ч илүүдэл жинтэй байгаа нь бие бялдрын зөв хөгжилгүй байгааг харуулж байна.

Илүүдэл жин нь олон өвчний урьдчилсан нөхцөл болохоос гадна сэтгэл хөдлөл тогтворгүй, бие бялдрын хөгжилгүй болох зэрэг олон хүчин зүйлийн хөшүүрэг болж байна.

[1] Биеийн тамир, спортын тухай хуулийн нэгдүгээр бүлгийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэг

[2] https://mn.wikipedia.org/wiki/

[3] Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв. (2017). Хүн амын хоол тэжээлийн байдал, Үндэсний тав дахь удаагийн судалгаа, Хавсралт http://hdc.gov.mn/file-category/13/

[4] Биеийн тамир спортын газар. (2019). Биеийн тамир, спортын салбарын 2019 оны мэдээлэл, Хавсралт https://mecss.gov.mn/news/2508/

Эрүүл мэнд ба биеийн тамир

Байгаль хүний бие махбодод өвчлөх чанар заяахын хамт өвчнөө эсэргүүцэх, өөрөө өөрийгөө эдгэрүүлэх олон чанар заясан. Түүний нэг нь хөдөлгөөн, биеийн тамир юм.[1]

Биеийн тамирын дасгалыг эмчилгээний зорилгоор хэрэглэх клиник-физиологийн үндэслэл

Биеийн тамирын дасгалын нөлөөгөөр дотор эрхтний үйл ажиллагаа өөрчлөгдөх тухай орчин үеийн төсөөлөл дээр үндэслэгдсэн дотор эрхтний рефлекс-хөдлөлийн онолыг И.М.Сеченев, И.П.Павлов нар хөгжүүлсэн.

Биеийн тамирын дасгалыг өргөнөөр хэрэглэх нь хүний биеийн бүхий л үйл ажиллагаа, тулгуур хөдөлгөөний аппаратад онцгой ач холбогдолтой. Биеийн тамирын дасгалын эмчилгээний нөлөө нь дасгалжих процессын үндсэнд хэрэгждэг. Дасгалжилт нь төв мэдрэлийн системд тохируулан, тэнцвэржүүлэх нөлөө үзүүлдэг. Дасгалжилтын үр дүнд үйл ажиллагааны чадвар дээшлэн эрхтэн системийн хоорондын үйлчлэл нэмэгддэг.[2]

Биеийн тамирын дасгалын эмчлэн сэргийлэх үйлчлэл дараах үр дүнд хүргэсэн байна. Тухайлбал:

-Сэтгэл хөдлөлийг тараан хуваарилах

-Биеийн хүчний ажлын чадварыг нэмэгдүүлэх

-Ахуйн ба хөдөлмөрийн ачаалалд дасах

-Дотоод, гадаад сөрөг хүчин зүйлийн нөлөөг тэсвэрлэх чанарыг дээшлүүлэх

-Архаг өвчин ба тахир дутуу болохоос хоёрдогчоор урьдчилан сэргийлэх

Сонсогчийн (оюутан) 21 хоногийн цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалтын үр дүн:

Дотоод Хэргийн Их Сургуулийн захирлын А/39 дугаар тушаалын хавсралт 2023-2024 оны хичээлийн жилийн бакалаврын элсэлтийн шалгалтын журмын 8-д заасан бие даалтыг цэргийн биеийн тамирын зааврын дагуу 2 удаа авсан. Бие бялдрын түвшин тогтоох шалгалтыг 09 дүгээр сарын 1-ний өдөр 100 метрийн гүйлт, 1000 метрийн гүйлт, гар дээр суниалт, гэдэс таталт, дүүжинд суниалт, савлуурт суниах, модон ямаанд давтаж харайх, бөхийж гараар газар тулах дасгалуудаар авсан.

[1] Н.Зоригт, Л.Цогтбаатар, Т.Баатар, Ч.Эрдэнэчимэг. (2002). Биеийн тамир эмчилгээ. VIII бүлэг, 168-р нүүр

[2] Н.Зоригт, Л.Цогтбаатар, Т.Баатар, Ч.Эрдэнэчимэг. (2002). Биеийн тамир эмчилгээ. VIII бүлэг, 172-р нүүр

Дүнг хүснэгтээр харуулбал:

№	Рот	Салаа	Суралцагч-дын тоо	хамрагдсан	A	B	C	D	F	Амжилт	Чанар	Тайлбар
1	1	1	40	40	1	1	4	1	33	17.5 %	5 %	
2		2	41	38	-	-	-	10	28	26,3 %	0 %	Өвчтэй-3
3		3	31	31	-	-	2	2	27	12,9 %	0 %	
4		4	31	30	-	-	3	9	18	40 %	0 %	Өвчтэй-1
5		5	31	31	-	-	2	2	27	12,9 %	0 %	
6		6	39	39	-	1	4	3	31	20,5 %	2,5 %	
7		7	31	31	-	-	4	3	24	22,5 %	0 %	
8	2	1	37	37	-	-	2	3	32	13,5 %	0 %	
9		2	41	40	-	-	3	6	31	22,5 %	0 %	Өвчтэй-1
10		3	31	31	1	1	3	3	23	29 %	6,4 %	
11		4	31	31	-	-	2	5	24	22,5 %	0 %	
12		5	41	41	-	-	-	3	38	7,3 %	0 %	
13		6	23	23	1	1	1	3	17	26 %	8,6 %	
Нийт			448	443	3	4	30	53	353	20,3 %	1,5 %	

Хоёр дахь удаагийн сорилыг 09 дүгээр сарын 21-ний өдөр 100 метрийн гүйлт, 1000 метрийн гүйлт, гэдэс таталт, савлуурт суниах, сандал дээгүүр харайх, бөхийж гараар газар тулах дасгалуудаар авсан.

Дүнг хүснэгтээр харуулбал:

№	Рот	Салаа	Суралцагчдын тоо	Хамрагдсан суралцагчдын тоо	A	B	C	D	F	Амжилт	Чанар	Тайлбар
1	1	1	40	40	2	2	16	11	9	77,5 %	10 %	

2		2	40	40	4	1	25	4	6	85 %	12,5%	
3		3	31	31	5	2	16	5	3	90 %	22,5 %	
4		4	31	31	6	3	18	3	1	96,7 %	29 %	
5		5	31	31	5	2	9	3	12	61 %	22 %	
6		6	38	38	5	4	17	5	7	81,5 %	23 %	
7		7	31	31	6	8	13	3	1	96 %	45 %	
8	2	1	40	40	5	7	23	3	2	95 %	30 %	
9		2	40	40	4	3	17	7	9	77,5 %	17,5 %	
10		3	31	31	5	2	11	5	8	74,1 %	22,5 %	
11		4	31	30	7	2	11	5	5	83 %	30 %	Өвчтэй-1
12		5	40	40	0	0	31	6	3	92,5 %	0 %	
13		6	24	24	2	2	9	4	7	70,8 %	16,6 %	
Нийт			448	443	56	38	216	64	73	83,6 %	21 %	

Хоёр удаагийн авсан шалгалтаар амжилт-63,3%, чанар-19,5%-аар өссөн үзүүлэлттэй байна.

21 хоногийн хугацаанд өглөөний гимнастик, гүйлтийг тогтмол 3-5км, өдөр бүр биеийн тамирын хичээлийг салаа бүрд 2 цагаар орсон. Биеийн тамирын хичээл нь биеийн ерөнхий хөгжил, цэргийн хэргийн мэдлэг олгох сургалтын хүрээнд орсон. Сургалтын хүрээнд савлуур, дүүжин, модон морь, тэмээн шат, саадын нэгдсэн зурвас зэрэг хичээлүүд орсон. Соёл хүмүүжлийн хичээлээр сагсан

бөмбөг, волейболын тэмцээнүүдийг явуулсан.

Тамирчдыг бэлтгэхэд системтэй дасгалжуулалтын нийт үр дүн, түүний шинжийг илэрхийлж "дасгалжилт", "бэлтгэлжилт", "форм" зэрэг нь хэрэглэгддэг. Дасгалжилт хэдий чинээ өндөр түвшинд хүрвэл тамирчин тодорхой ажлын хэмнэлттэй чадварлаг гүйцэтгэж чадна.[1]

Биеийн тамирын боловсролын эрх зүйн зохицуулалт

Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...эрүүл мэндээ хамгаалах... нь иргэн бүрийн журамт үүрэг мөн" гэж заасан.

Аливаа улс үндэстний жинхэнэ баялаг бол хүн учраас хөгжлийн төвд хүнийг тавьсан хандлага дэлхий нийтэд түгээмэл дэлгэрч байна. Үүнийг Монгол улсын тогтвортой хөгжлийн баримт бичигт тусгасан олзуурхууштай явдал юм.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь урт хугацаанд тогтвортой хөгжлийг хангах үндэсний хэмжээний суурь баримт бичиг юм. Тус үзэл баримтлал нь хүний хөгжлийг хангахад чиглэсэн байна. Энэ нь дэлхийн даяар хэрэгжүүлж байгаа нийтлэг хөгжлийн стратеги буюу дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгуудтай салшгүй холбоотой.[2]

"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод биеийн тамирын талаар:

*Зорилт 3.5.*Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ.

Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн

I үе шат (2021-2030):

Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх үе.

1.Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлнэ.

2.Биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоо боловсронгуй болсон байна.

3.Биеийн тамир, спортын салбарт цахим үйлчилгээ нэвтэрч, үндэсний нэгдсэн мэдээллийн сан бүрдсэн байна.

4.Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн хөгжил, чадавхжуулалт, дэмжлэгийг нэмэгдүүлнэ.

[1] Г.Лхагвасүрэн. (2002). Спортын дасгалжуулалтын онолын үндэс. Бүлэг 8, 146-р нүүр

[2] Монгол Улсын Их Хурал, Төрийн байгуулалтын байнгын хороо. (2016). Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030. Үндэслэл, хамтрах хүрээ, 20-р нүүр

II үе шат (2031-2040): Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэнийг төлөвшүүлэх биеийн тамир, спортын чанар, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх үе.

1.Идэвхтэй амьдралын дадал хэвшлийг дэмжих тогтолцоо бүрдэж, хот, суурин газрын орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтөд биеийн тамир, спортоор хичээллэх, амьдралын зөв дадал хэвшилтэй болгох олон улсын стандарт, шаардлагад нийцсэн, тохилог, таатай орчныг бий болгоно.

2.Амьдрал, ажил, мэргэжлийн хэв маяг, агуулгын өөрчлөлттэй холбоотойгоор биеийн тамир, спортын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлж, авьяасыг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

III үе шат (2041-2050): Биеийн тамир, спортын идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүл төлөвших үе.

1.Биеийн тамир, спортоор хичээллэх өдөр тутмын амьдралын идэвхтэй дадал хэвшилтэй иргэн, гэр бүлийг төлөвшүүлэхэд хиймэл оюун ухаанд тулгуурласан технологи, үйлчилгээг нэвтрүүлнэ[1] гэж тусгажээ.

Дүгнэлт

Оюутны биеийн тамирын боловсрол, эрүүл мэнд сэдвийн хүрээнд ашигласан хоёр судалгаа болон Дотоод Хэргийн Их Сургуулийн захирлын 2017 оны 04 сарын 29-ны өдрийн А/139 дугаар тушаалын хавсралт Хууль Сахиулахын Их Сургуулийн мэргэжлийн боловсрол, сургалтын журмын 3.4.7-д заасан сургалтын дагуу тоон судалгааг хийж дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. Орчин үеийн техник технологийн нөлөөт амьдралын хэвшил, биеийн тамирын боловсролгүйгээс Монгол улсын нийт хүн амын ½ , тамирчдын 13% нь илүүдэл жинтэй байна.

2. Биеийн тамирын дасгал нь дан ганц эрүүл мэндэд урьдчилан сэргийлэлт болох бус бас эмчилгээний зорилгоор хэрэглэх клиник-физиологийн үндэслэл болдог байна. Үүнийг батлах жишээ нь 21 хоногийн цэрэгжилтийн бэлтгэлийн дараа сонсогчийн биед гарсан өөрчлөлт. 13 салааны нийт 448 сонсогч (оюутан)-оос авсан сорилын амжилт даруй 63,3%-аар, чанар 19,5%-аар өссөн. Системтэй дасгалжуулалтын үр дүн, түүний явцад гарсан бие бялдар, сэтгэхүй, биологийн өөрчлөлтийн нөлөөгөөр бага хугацаанд 63 хувиар амжилт өсжээ.

Иргэний Үндсэн хуулиар хүлээсэн эрүүл мэндээ хамгаалах журамт үүргээ биелүүлэх орчныг төрөөс “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалаар дамжуулан дэмжихээр бодлогын

[1] Монгол Улсын Их Хурын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт., Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого

баримт бичигт тусгажээ. Гэвч энэ нь бодлогын баримт бичигт тусгагдсанаас нийтээр заавал дагаж мөрдөх хэм хэмжээний горим болгон хуульчлаагүй нь бодит байдал дээр хэрэгжихгүй байх вий гэх айдсыг төрүүлж байна.

Санал

✓ Бакалаврын оюутны биеийн тамирын боловсролын хөтөлбөрийг онол-практик хосолсон болгох

✓ Биеийн тамирын дасгалыг эмчилгээний зорилгоор хэрэглэх клиник-физиологийн үндэслэлийг олон нийтэд таниулах

✓ Монгол улсын тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-т биеийн тамирыг дэмжих зорилтуудыг бакалаврын сургалтын хөтөлбөрт тусгах

✓ Биеийн тамирын боловсрол, эрүүл мэндийн талаар зохицуулсан хуулийн төсөл батлах

Эх сурвалж:

1. Ашигласан хууль, хууль тогтоомжийн акт

➢ Монгол Улсын Үндсэн Хууль., 1992 он

➢ Биеийн тамирын тухай хууль., 2003 он

➢ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого

➢ Монгол Улсын Их Хурал, Төрийн байгуулалтын байнгын хороо., Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030., 2016 он

➢ Дотоод Хэргийн Их Сургуулийн захирлын 2017 оны 04 сарын 29-ны өдрийн А/139 дугаар тушаалын хавсралт Хууль Сахиулахын Их Сургуулийн мэргэжлийн боловсрол, сургалтын журам

2. Ашигласан ном, сурах бичиг

➢ Н.Зоригт, Л.Цогтбаатар, Т.Баатар, Ч.Эрдэнэчимэг “Биеийн тамир эмчилгээ”., УБ., 2002 он

➢ Г.Лхагвасүрэн “Спортын дасгалжуулалтын онолын үндэс”., УБ., 2002 он

➢ Д.Бямбажав, Р.Баярмагнай “Хүч тамирын хичээлээр анхлан суралцагчдын гарын авлага”., УБ., 2012 он

3. Ашигласан цахим эх сурвалж

➢ https://www.legalinfo.mn/annex/?lawid=15406

➢ //mn.wikipedia.org/wiki/

➢ http://hdc.gov.mn/file-category/13/

➢ //mecss.gov.mn/news/250

ОРЧИН ҮЕИЙН ДАЙНЫ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

М.Мөнгөнцэцэг
Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн Цэргийн ар талын тэнхимийн багш, докторант, ахмад

Товч агуулга: Энэхүү нийтлэл нь Украйн- ОХУ-ын эдийн засаг дайны өмнө болон гарсны дараа ямар байгааг харуулах бөгөөд ЭЗ-ийн гадаад, дотоод, эерэг ба сөрөг гол өөрчлөлтүүдээр үзүүлэх болно. Тухайлбал эдгээр улсуудын банкны салбар, хөдөө аж ахуй, үйлдвэрийн ажил, хүн амын ажил эрхлэлт, цалин хөлс зэрэгт гарсан өөрчлөлтүүдийг судалсан. Инфляц, хөрөнгийн гадагшлах урсгал, импортыг орлох асуудлыг мөн хөндсөн.

Түлхүүр үгс: орчин үеийн дайн, мөргөлдөөн, эдийн засаг, эерэг сөрөг нөлөө, өөрчлөлт, ОХУ, Украйн, хориг арга хэмжээ, хөрөнгийн гадагшлах урсгал, инфляц, ажил эрхлэлт, цалин хөлс, хөдөө аж ахуй.

Удиртгал

XXI зуун нь амар тайван, хөгжил дэвшил дүүрэн технологи мэдээллийн эрин зуун юм. Гэвч дэлхийн зарим улс оронд дайн, зэвсэгт мөргөлдөөн, цэргийн ажиллагаа, иргэний бослого хөдөлгөөнүүд гарч хэдэн жилийн турш үргэлжилсээр байна. Эдгээр нь яагаад эхэлсэн, хэрхэн үргэлжилж, томоохон гүрнүүд улс төр, эдийн засаг, цэргийн хүчээрээ яаж нөлөөлж, бусад улс геополитикийн ард түмэнд юу тохиолдож байгааг төдийлөн сонсож анхаарах хүмүүс цөөн байдаг. Гэвч энэ бүх дайн тулаан нь даяарчлагдсан эдийн засгаар дамжин бид бүхний амьдрал ахуйд их бага хэмжээгээр нөлөөлж байдаг. Сүүлийн үед Хятад Тайван, Израйл, Африкийн зарим орнууд, Азарбайжан зэрэг нэлээд улсуудад хурцадмал байдал үүсэж хэзээ ч хамаагүй дайн мөргөлдөөн гарахад бэлэн байх болсон. Хэрэв ийм байдал бид бүхний хаяанд үүсвэл хэрхэн яаж даван туулах туршлага, сургамж бидэнд хэрэгтэй учраас өнөөгийн Орос Украйны дайныг жишээ болгон судалж үзэх хэрэгтэй юм.

Судалгааны үндэслэл:

Сүүлийн үед дэлхий дахинд өрнөж буй геополитикийн хурцадмал асуудлуудаас хамгийн их анхаарал татаж буй нь ОХУ-Украйны дайн юм. Уг орчин үеийн дайн нь тухайн орон болоод хөрш манай улс орны аюулгүй байдал, эдийн засаг, ард иргэдэд ямар нөлөө үзүүлж, хор хохирол учруулж байгааг судлах хэрэгцээ шаардлага бий билээ.

Судалгааны зорилго:

Орчин үеийн дайны эдийн засагт үзүүлэх нөлөөг судлахад оршино.

Зорилтууд:

1. Орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанарыг судлах
2. ОХУ цэргийн ажиллагаа эхэлснээс хойш эдийн засагт гарсан өөрчлөлтүүдийг шинжлэх
3. Дайн эхэлсний өмнөх болон дараах Украйны эдийн засгийн нөхцөл байдлыг судлах

Судалгааны объект:

Орос Украйны эдийн засгийн тоон үзүүлэлтүүд

Орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанар

Улс орнуудын явуулж буй стратегийн бодлогоос үүдэн гарсан зэвсэгт тэмцлийг албан ёсоор дайн гэж үздэг. Харин XXI зуунд дайн, зэвсэгт мөргөлдөөнд доорх байдлаар ханддаг байна[1]:

- *Пасифист хандлагад* олон улсын харилцаанд ёс зүйн талаасаа ямар ч тохиолдолд зөвтгөх шалтгаангүй буруу зүйл юм.
- *Реалист хандлагад* дайн ямагт үндэсний ашиг сонирхлын төлөө үйлчилдэг
- *Шударга дайны онолд* зарим нөхцөлд дайныг зөвтгөх шалтгаан бий гэж үздэг.

Тэгвэл орчин үед дайныг эхлүүлэх, зөвтгөх шалтгааныг дараах байдлаар авч үздэг байна. Үүнд:

- ❖ Газар нутгаа харийн түрэмгийллээс хамгаалах,
- ❖ геноцид дарангуйллаас энгийн номхон ард иргэдийг хамгаалах,
- ❖ ардчиллыг хамгаалах г.м


Сүүлийн 30 жилд явагдаж байгаагүй хуурай замын цэргийн том ажиллагаа бол “Орос-Украйны дайн” юм. Одоо өрнөж буй уг дайнаас орчин үеийн дайн, байлдааны хэв шинж, түүний эдийн засагт үзүүлэх нөлөөллийг дэлгэрэнгүй судалж үзэцгээе.

Анх 2022 оны 2-р сарын 24-ны өглөөний 04 цагт Оросын армийн 200 000 цэрэгтэй Украинд довтолсноор энэхүү дайн эхэлж, дэлхийн бүх улс орнуудын анхаарлын төвд орсон. Гэвч үнэндээ энэ дайн 2014 оны Крымийн түрэмгийллийн үеэс эхлээд 11 дахь жилдээ өрнөж байгаа юм. Нийтдээ 200 удаа хэлэлцээр хийх оролдлого хийсэн боловч бүтэлгүйтсэн байдаг. Оросын 3000 бөмбөг, 7500 пуужин, 3700 дрон-шахид, олон мянган танк, олон зуун нисэх онгоц Украиныг дайрч олон байшин барилга, дэд бүтэц устаж сөнөөсөн. Харин 2025 оны байдлаар ОХУ Украины зүүн хэсгийн 20 гаруй хувь болох Донецк, Луганск хотыг чөлөөлсөн бөгөөд одоогоор Оросын 14 арми тулалдаанд оролцож байна.

: [2]

[1] - Шударга дайны онол өгүүллэг

[2] - https://ikon.mn/n/33fk



Зураг №1. 2024 оны 3-р сарын байдлаар 2 талуудын дайнд оролцсон, хохирсон хүний тоо (a), цэргийн хүчний зардал (b)

Эхний 2 жилд 1,8 сая цэргийн алба хаагчид оролцож, энгийн иргэдээс 30000 хүн өртөж, нийт алагдсан хүн нь 462 000, шархадсан нь 147 000 байжээ. Харин 2025 оны хамгийн сүүлийн мэдээгээр нийт 1 сая орчим энгийн болон цэргүүд алагдаж, шархадсан гэсэн албан бус мэдээлэл байна.



Дайнд хүнээс гадна маш их хэмжээний хөрөнгө царцуулагдаж байгааг дээрх зургаас харж болно. Орос улс 307 тэрбум $, Украйн болон түүнийг дэмжигч талууд 282 тэрбум $ зарцуулсан бөгөөд хамгийн их хэмжээний мөнгө болох 96 тэрбум $ АНУ өгсөн. Гэхдээ эдгээр дэмжлэгийн ихэнх нь орчин үеийн өндөр технологийн зэр зэвсгүүд, сум гал хэрэгслүүд байсан.

Энэ дайн дан ганц 2 улсын дайн биш юм. Учир нь Америк, Европ, НАТО-гийн улсууд маш их нөлөө үзүүлж, дайныг санхүүжүүлж дэлхийн хэмжээний асуудал болгосон. 2025 оны эхний улиралд АНУ-ын төрийн тэргүүн солигдсоноор улс төрийн байр суурь өөрчлөгдөж хэлэлцээр хийн дайныг зогсоохыг эрмэлзэж байна. Тэгвэл <u>талуудын өнөөгийн байр суурь ямар байгаа талаар авч үзье:</u>

1. Оросын тал: Украин НАТО-д элсэхгүй байх баталгаа, Украины нутгаас эзэлсэн 20 орчим хувийн хяналтаа хүлээн зөвшөөрүүлэх, дайны явцад тавигдсан хоригийг цуцлуулах, Украины

ерөнхийлөгчийн сонгуулийг шинээр зохион байгуулж, дайчилгаа хийлгэхийг зогсоох, өрнөдийн орнуудын зэр зэвсгийн тусламж үзүүлэхийг бүрэн зогсоохыг шаардсан бол хамгийн сүүлд Украинд түр засгийн газар байгуулж, түүнийг НҮБ, АНУ, Европын орнууд оросын түншүүдийн аль нэгнийх нь захиргаанд байлгахыг шаардсан.[1]

2. Украин: Эзлэгдсэн ямар ч газар нутгийг Оросынх гэж хүлээн зөвшөөрөхгүй гэсэн хатуу байр суурьтай байна.

3. Америк: Украиныг НАТО-д элсүүлэхгүй, Америкийн цэрэг Украиныг хамгаалахгүй гэж мэдэгдсэн[2] бөгөөд Киевт шахалт үзүүлж, дэмжлэгээ танах замаар буулт хийлгэхэд анхаарч байна. Мөн Орост дайныг дуусгавал хөрөнгө оруулж, эдийн засгийн харилцааг сэргээхэд бэлэн хэмээн зөөлөн хүчний бодлого баримталж байна.[3] Тэдний дайн зогсоох шалтгаан нь Европ дахь аюулгүй байдлын орчин улам тогтворгүй болж, Орос-Хятадын холбоо гүнзгийрэх эрсдэл үүсэж байна гэж үзжээ.

4. Европын холбоо: Оросын талд буулт хийхгүй, Украиныг бүрэн дэмжихээ илэрхийлж байгаа боловч дотроо байр суурийн зөрүүтэй байгаа юм.[4]

5. НАТО: Хэрэв Украин ялагдаж дайнаас гарвал оросууд армиа Финлянд, Польш, Балтын орнууд руу оруулах, Оросын бүрэлдэхүүнд оруулах магадлалтай. Иймм нөхцөлд НАТО маш аюултай байдалд орно гэж үздэг.

Уг талууд хатуу *байр суурьтай, харилцан буулт хийхгүй* байгаагаас өнөөдөр хэлэлцээр гацсан байдалтай, гал зогсоогүй үргэлжилж байна. ***Б****үгд тодорхой хэмжээнд буулт хийж, харьцангуй тэнцвэртэй нөхцөл шаардлагыг тавихаар бие биедээ шахалт үзүүлж байгаа.* Хэрвээ дайн зогсохгүй удвал 2 улсын эдийн засаг маш хүнд байдалд орж, муугаар бодвол дайны цар хүрээ улам томорч дэлхийн 3-р дайн эсвэл цөмийн дайн болох эрсдэл байгааг судлаачид дурддаг.

Орчин үеийн дайны эдийн засагт үзүүлэх нөлөө

[1] - Reuters. 2025. “Putin suggests temporary administration for Ukraine to end war”

[2] - Sky News. 2025. “Restoration of Ukraine’s borders, NATO membership and US troop involvement all ‘unlikely’ says US Defense Sec”

[3] - The New York Times. 2025. “U.S. and Russia Pursue Partnership in a Head-Spinning Shift in Relations”

[4] - The Wall Street Journal. 2025. “France-U.K. Plan for European Troops in Ukraine Falters”

Орчин үед дайн нь зөвхөн цэргийн ажиллагаа бус давхар эдийн засаг, мэдээллийн дайн хамтдаа явагддаг болсон нь харагдаж байна. Тухайлбал Орос Украйны эдийн засгаас харахад дайны үед дэд бүтцүүд эвдэрч сүйрэн аж үйлдвэр тэргүүтэй ихэнх салбарууд уналтад орж, хөрөнгө оруулалт, тогтвортой ажлын байр багасаж, гадагш их хэмжээний хүн ам, хөрөнгө мөнгө урсаж, худалдаа тээвэр хийхэд олон хүндрэлүүд үүсэж, ДНБ хэмжээ огцом буурч, улс орны эдийн засаг бүхэлдээ том уналтад орж хумигдаж байна.

Дайн эхэлснээс хойш Украины эдийн засаг 2022 онд -75 хувиар, ОХУ-ын эдийн засаг -20 хувиар, бүсийн эдийн засаг -9 хувиар агшсан. 2022 оны 4 сард боловсруулах салбар 52.2, үйлчилгээний салбар 53.4-д хүрч, өмнөх оноос тус тус 3.6 хувь, 1.3 хувиар тус тус агшжээ.[1] Үүнээс үзвэл дайн болоход улс орны эдийн засаг хүнд цохилтод орж, олон асуудлууд урган гарч, цаашилбал хөрш зэргэлдээ орнууд, геополитик, дэлхийн эдийн засагт ч тодорхой хэмжээгээр сөргөөр нөлөөлдөг байна. Тухайлбал Украинаас буудай авч чадахгүй байгаа зарим ядуу буурай орнуудыг хоол тэжээлийн дутагдалд хүргэж болзошгүй. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага дэлхийн 41 орны 181 сая хүн хүнсний хямралд нэрвэгдэх, өлсгөлөнгийн түвшин дордох магадлалтай хэмээн тооцоолсон байна.



Дайнаас өмнөх Украйны эдийн засаг

Нийт хүн ам нь 1992 онд 51.7 сая байснаас 2020 онд 41.7 сая болж буурсан.

Украины хий дамжуулах систем нь Европт 2-т тооцогддог ба нийт урт нь 37.1 мянган км ба үүний 14 мянга нь 1020-1420 ийн голчтой. Украинд байгалийн хий 22 магистрал шугамаар орж ирж, гадагшаа 15 шугамаар гардаг.[2] Зүүн Украинд аж үйлдвэрийн гол салбарууд зонхилдог ба тэдгээрийн эрчим хүчний гол эх сурвалж нь импортын байгалийн хий дээр суурилсан нь Оросын стратегийн ач холбогдол бүхий бүс нутаг юм.

Хүн амын 77.8% нь украйнчууд, 17.3% нь оросууд эзлэх ба белорусv, молдав, татар, болгар, унгар, румын, польш, еврей гээд олон үндэстэн аж төрдөг улс юм. Тэр дундаа Крымд - 97%, Донецк - 93%, Запорож - 81%, Луганск - 89%, Одесс - 85%,

[1] - https://ru.wikipedia.org/wiki

[2] - https://iis.ac.mn/post/22290

Днепрпетровск - 72%, Харьков - 74% нь орос хэлээр ярьдаг, орос үндэснүүд зонхилсон хотууд юм.

Харьцангуй үйлдвэржсэн улс бөгөөд дэлхийн худалдаанд хөдөө аж ахуй, хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүнээр түлхүү оролцдог. Мөн хар тэнгисээр дамжин далайд гарцтай олон том боомтуудтай ба түүгээр хийн болон нефтийн транзит, авто болон төмөр замын транзит, агаарын тээврийн транзитаар Европын орнуудтай харилцдаг. Сонирхуулахад, 2013 оны байдлаар Украин нь экспортод тус бүр нь 100 сая ам.$ ын 19 нэрийн барааг бараа, 50-100 сая ам.$ ын 22 нэрийн барааг, 10-50 сая ам.$ ын 127 нэрийн барааг, 1-10 сая ам.$ ын 264 нэрийн барааг тус тус гаргадаг харьцангуй “солонгорсон” эдийн засагтай улс байжээ. .[1]

Зураг №2. 2019 онд Украйны экспортолсон гол нэрийн бүтээгдэхүүнүүд, тэдний орлогын хэмжээ



Улаан буудай, эрдэнэ шиш, фермийн бүтээгдэхүүнээр 20 тэрбум $, хар төмөрлөг 9,6 тэрбум $ машины тоног төхөөрөмж 5 тэрбум $, экологийн бүтээгдэхүүн 4,5 тэрбум $ химийн үйлдвэрлэл 2,4 тэрбум $, мод модон бүтээгдэхүүн 1,7 тэрбум $, хөнгөн үйлдвэр 1,09 тэрбумын барааг гадагшаа худалддаг байна. Мөн эдгээр бүтээгдэхүүний дэлхийн


[1] - Украйны ХАА, худалдааны яамны мэдээлэл

худалдаанд эзлэх хувийг зурагт харуулсан байна.

Дайны Украйны эдийн засагт үзүүлсэн нөлөө:

Украины ДНБ-ий тал хувийг бүрдүүлдэг 10 бүс нутаг дайны хөлд өртөөд байна. Халдлагын эхний 6 сард тус улсын ДНБ-ий жилийн алдагдал 33.4%-аас 45%-ийн хооронд хэлбэлзсэн. *Украйны* эдийн засаг 2022 онд 2021 оны дундажтай харьцуулахад 18.9%-иар буурах буюу 162 тэрбум $ хүрч, 2023 онд 2021 оныхоос 10.5%-иар буурч 179 тэрбум долларт хүрсэн байна. [1]

: [2]



Зураг №3. Украйны ДНБ-ны хэмжээ 2021-2024 онуудад

Дайн эхэлснээс хойш ДНБ огцом унаж -36% хүрсэн боловч 2022 оны эцсээр жилийн дундаж нь 29.1%-иар буурч, 2023 онд 5.3%-иар өссөн, 2024 оны эцсээр 2,9%-иар буурсан байна. Мөнгөн дүнгээр Украины нэрлэсэн ДНБ 2014 онд 7,66 их наяд болж, дефлятор 12,3%-иар өөрчлөгдсөн байна.

2014-2020 оны хооронд Орос-Украйны зөрчилдөөний улмаас Украин 280 тэрбум $ алдагдал хүлээсэн бол 2022 оноос хойш Украин жил бүр 40 тэрбум $ алддаг байна. Крымийг өөртөө нэгтгэснээр жил бүр 8.3 тэрбум $, Донбасс дахь дайн дунджаар 14.6 тэрбум долларын хохирол нэмж учруулсан. 2024 оны 1 сарын байдлаар дэд бүтцийн шууд алдагдал нийт 157 тэрбум $ хүрсэн байна. Украины аж үйлдвэрийн индекс 2016 онд 101.7% байснаас 2021 оны 12-р сард 69.4% болж буурчээ. Барилгын үйлдвэрлэлийн индекс мөн адил 2021 оны эцэст 199.7%-иас 2024 оны 6-р сард 94.2%-иар буурчээ. [3] Гаднын тусламжийн тусламжтай Украины эдийн засаг 2024 онд 3-5%-ийн хооронд өссөн.

2022 оны эхээр Украинд инфляц 10% байсан бол 9 сар

[1] - A struggle to survive. Ukraine's economy in wartime. OSW (18 октября 2022).

[2] - Украйны статистикийн албаны мэдээлэл

[3] - Прогноз невтішний. Через війну з РФ українська економіка втратила $280 млрд з 2014 року — CEDR

гэхэд 24.6% болжээ. Талх, гурилан бүтээгдэхүүн, загас, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний үнэ 36-84 % өссөн нь гол үйлдвэрлэгч Херсон муж эзлэгдсэнтэй холбоотой. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 178–183$, дайнаас өмнө дундаж цалин 506 $ байснаас 435$ болсон.[1]. Засгийн газраас инфляцыг зогсоохын тулд довтолгооны эхэн үед импортын бараа, НӨАТ-ын татварыг цуцалж, хий, төвлөрсөн дулаан хангамжийн үнийн дээд хязгаарыг тогтоосон. 2022 оны зуны эхэн үед Украины Төв банк үндсэн хүүгээ 10% -иас 25% хүртэл өсгөхөөс өөр аргагүй болсон.

Украинд хөрөнгө оруулалт 2021 онтой харьцуулахад 2022 онд 48.7%, 2023 онд 56.2% буурсан байна.

НҮБ болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 2022 оны 5-р сарын тооцоогоор, Украинд 4,8 сая буюу ажлын байрны 30% -ийг алдагдсан. Мөн нийт ажиллах хүчний 10.4% буюу 1.6 сая нь бусад улс оронд дүрвэгсэд болжээ. Эдгээрээс 60% нь дээд боловсролтой, 49% нь өндөр ур чадвартай мэргэжлээр ажилладаг байжээ. 9-р сард аж ахуйн нэгжүүдийн 80 орчим хувь нь хүчин чадлынхаа 50% доошгүй хэмжээгээр ажилласан. Ялангуяа программистууд их хэмжээний цомхотголд өртөж, ажил олоход бэрхшээлтэй тулгарсан. Үүний зэрэгцээ байлдааны ажиллагаанд оролцож буй цэргийн албан хаагчдын хангамж нэмэгдэж 100 мянган гривен буюу 2700 орчим $ болжээ.[2]

2023 оны 7 сард Блүүмберг мэдээлснээр, дайн эхэлснээс хойш эх орноосоо дүрвэсэн 6 сая гаруй Украины дүрвэгсдийн 68 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд 2.8 сая нь хөдөлмөрийн насны хүмүүс. Тэд эх орондоо буцаж ирэхгүй бол Киев дайны өмнөх ДНБ-ий 10% буюу жилд 20 тэрбум $ хохирол амсах болно. Украины Эдийн засгийн яамны мэдээлснээр тус улсад дайны дараах сэргээн босгох төлөвлөгөөгөө биелүүлэхэд 4.5 сая ажилчин, бизнес эрхлэгч дутагдаж байна.

Тээвэр: Украйн шууд агаарын орон зайгаа иргэний нислэгээ хаасан. Томоохон хотуудын метро довтолгооны эхний өдрүүдэд буудалцаан, тэсрэх бөмбөгөөс хамгаалах горимд шилжиж иргэд хэдэн сарын турш тэнд хорогдож амьдарч байсан. Төмөр зам нь хүн амыг нүүлгэн шилжүүлэх, ачаа тээвэрлэх гол аргуудын нэг болж, тасалбарын системийг цуцалсан.

Худалдаа: Ихэнх далайн боомтуудыг хааж, гаалийг зогсоосон тул төмөр замууд Европ руу бараа импортолсон. Дайны өмнө орлогын 15%-ийг гаалийн татвар бүрдүүлдэг байжээ. Украины бүх барааны импорт

[1] - Средняя заработная плата в Украине в долларах США. МинфинМедиа (2021). Дата обращения: 27 ноября 2022.

[2] - Ukraine Has Lost 30% of Prewar Jobs, U.N. Agency Estimates. Wall Street Journal (11 мая 2022).

(зэвсгээс бусад) сард 43.3 сая евро байсан бол түрэмгийлэл эхэлсний дараа сард 8 сая евро болж буурсан. Албан ёсны мэдээллээр 3 сард тус улсаас төмөр замаар ердөө 300 мянган тонн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортолсон байна. 2022 онд 65-70 сая тонн ургац авсан нь дайны өмнөх үеийнхээс 30% доогуур байна. НҮБ-ын ивээл дор 7-р сард байгуулсан үр тарианы хэлэлцээр хийж Украин хүмүүнлэгийн коридороор дамжуулж дэлхийн 38 оронд 11 сая тонн үр тариа, хүнсний бүтээгдэхүүн экспортолсон.[1]

Хөдөө аж ахуй: Украйнаас хөдөө аж ахуйн экспортыг зүүн Европ руу чиглүүлсэн нь үнэ буурч, нутгийн фермерүүдийн эсэргүүцэлд хүргэг үр тариа импортлохыг хориглов. Украйны хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, худалдааны бууралтаас үүдсэн хохирол 34.2 тэрбум $ хүрэх төлөвтэй байна. 2023 оны 9 сард Европын Комисс Украины улаан буудай, эрдэнэ шиш, рапс, наран цэцгийн үрийг бусад улс руу дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зөвшөөрөв.

Эрчим хүч, аж үйлдвэр: 2022 оны 5 сарын байдлаар 7000 орчим шатахуун түгээх станцын тал нь шатахууны хомсдолын улмаас хаагдсан. Энэ нь асар их дараалал, хууль бус худалдаа, нэг удаад 10 литр л худалдах лимитэд хүргэсэн. Төрөөс тогтоосон үнийн хяналтаас болж компаниуд бензинээ худалдан авсан зардлаас доогуур үнээр борлууласан. Хамгийн том нефть боловсруулах үйлдвэр Кременчуг суманд өртсөнөөс болж шаардлагатай 540 мянган тонн нефтийн бүтээгдэхүүний 70% хангасан. 6-р сарын 22-ны Оросын пуужингийн довтолгооны улмаас Украины газрын тос боловсруулах үйлдвэр бүхэлдээ зогссон. Украины шатахууны эрэлтээс болж 11 сард Польшийн тариф тонн тутамд 30-40 $ нэмэгдэж, 12-р сард 180 $ хүрсэн.[2] Нэмж дурдахад Донбассын уурхай Оросын мэдэлд орсноор Украин нүүрсний нөөцийнхөө ихэнх хэсгийг алдсан бөгөөд олборлолт 30%-иар буурсан гэж Эрчим хүчний сайд нь хэлжээ. Орос дор хаяж 12.4 их наяд ам.$ ын үнэ бүхий эрчим хүчний ордууд, металл, ашигт малтмалыг хянаж байжээ.[3] Мөн орос улсаас газрын тос, нүүрс, байгалийн хийн бүх экспортоо зогсоосны үр дүнд 11-р сард Украин цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл хэрэгцээний 70%-ийг л хангасан.

Санхүүгийн салбар: Украины Үндэсний банк тус улсад дайны байдал зарласны дараа тус улсын валютын зах зээлийг түр хугацаагаар зогсоож, бэлэн мөнгө

[1] - Russia and Ukraine renew a grain export deal to help the hungry and keep prices down

[2] - Another fuel crisis threatens Ukraine. Hungarian Posts (3 ноября 2022).

[3] -In the Ukraine war, a battle for the nation's mineral and energy wealth

гаргахыг хязгаарлаж, хүн амд валют олгохыг хорилгожээ. Мөн хил дамнасан бүх төлбөр,гадаадын банкнуудын данс руу хийх шилжүүлгийг хаасан. Украйны оршин суугчид зөвхөн шаардлагатай үед өдөрт 3300 $ гадаад валют худалдаж авна. Украины евро бондын үнэ уналтад орсон ба зээлжих зэрэглэл буурч Fitch Ratings үнэлгээ С болсон. Украины хүсэлтээр 8 сарын эхний хагаст олон улсын бондын зээлийг 2 жилээр царцаасан.[1] Тус улсад цэрэг арми, ар талыг дэмжих нэмэлт санхүүжилт шаардлагатай байсан тул Сангийн яамнаас Нэг жилийн хугацаатай 11% өгөөжтэй дайны бонд гэгчийг зарласан нь банкнууд болон 70,000 гаруй иргэн, аж ахуйн нэгжүүдийн хувьд "итгэлийн үсрэлт" болсон. Бас засгийн газар 5 сар хүртэл 38 дуудлага худалдаагаар 3.1 тэрбум $ босгожээ.

Дайнаас өмнөх ОХУ-ын эдийн засаг

ДНБ нь 1.6 трлн $, хүн ам нь 146 сая, нэг хүнд ногдох ДНБ нь 11200 $, гадаад худалдаа нь 785 тэрбум $. ЕХ-той хийж буй худалдаа энэ их хоригийн цаг үед ч 250 гаруй тэрбум еврод эргэлдэж байна. Харин Украинтай хийдэг худалдааны эргэлт 10.1 тэрбум $ ба харилцаа сайн байх үед 50 тэрбум хүрч байсан. Учир нь ОХУ-ын байгалийн хийн экспортын 95% нь Украинаар дамжиж Европт гардаг. 2008 онд 120 тэрбум шоо м байгалийн хийг дамжуулж, 2014 онд 62.2 тэрбум шоо м, 2020 онд 55.8 тэрбум шоо м. дамжуулсан.[2]

Дайн эхэлснээс хойш ОХУ-ийн ЭЗ-т гарсан сөрөг өөрчлөлтүүд:

– ЭЗ-ийн гол салбаруудад нөлөөлж, том компаниудын олон улсын санхүүгийн зах зээлд нэвтрэх боломжийг хязгаарласан.

– Томоохон банкнуудыг SWIFT банк хоорондын төлбөрийн системээс салгасан.

– Олон улсын гүйлгээг улам хүндрүүлсэн.

– Гадаадын олон компаниуд Орос дахь үйл ажиллагаагаа хумьжээ.

– Гадаадын хөрөнгө оруулалт татах, өрийг санхүүжүүлэхэд хүндрэл учирсан.

– Олон аж ахуйн нэгж, хувь хүмүүс хөрөнгөө гадаад руу шилжүүлэх болсон. (2022 онд 150 тэрбум $, 2023 онд 125 тэрбум $, 2024 онд 151.5 тэрбум $) [3]

– Улсын хэмжээнд байгаа санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ буурсан нь аж ахуйн нэгж, банкнуудын хөрөнгийн хүртээмжийг хүндрүүлж эдийн засгийн өсөлт удааширсан. Олон төсөл царцаж, цуцлагдсан.

– Рублийн ханш огцом унасан. инфляцыг өсгөж, импортын бараа, үйлчилгээний

[1] - Ukraine Central Bank Halts Currency Market, Limits Cash Withdrawals

[2] - Росстат- Оросын статистикийн газар

[3] -https://ru.wikipedia.org/wiki/

үнэ огцом өсөж, бизнес эрхлэгчид, хэрэглэгчдийн зардал ихэссэн. иргэдийн байдлыг дордуулж, нийгмийн хурцадмал байдалд хүргэсэн.

– ЗГ болон компаниуд гадаадаас ашиггүй нөхцөлөөр зээл авахад хүрч өрийн хэмжээ дарамт өсөж, улсын санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл нэмэгдэв.

– Электрон бараа, хагас дамжуулагч, нисэх, далайн техник зэрэг өндөр технологийн бараа, тоног төхөөрөмжийг ОХУ-д экспортлохыг хориглосноор аж үйлдвэр, технологийн салбарыг шинэчлэх боломжийг хязгаарласан.

– Зарим улс нүүрс, металл, мод зэрэг зарим барааг худалдаж авахаа больсон.

– Хориг арга хэмжээг дэмжигч орнуудын боомт, нисэх онгоцны буудалд Оросын тээврийг ашиглах зогсоохыг хориглосон. Үүний дүнд олон улсад худалдаа арилжаа хийхэд хүндрэл үүсэж, логистикийн зардал нэмэгдсэн.

– 2024 онд ЕХ-ны орнуудад газрын тос, байгалийн хийн экспорт 50 хувиар буурсан ч нийлүүлэлтээ Ази руу чиглүүлж 2024 онд 337 тэрбум $ олж, 2023 оноос 10% өссөн. ЕХ эрчим хүчний эх үүсвэрийг төрөлжүүлэх ОХУ-аас худалдан авалтаа 8%д бууруулж, цаашдаа 0 хүргэх төлөвтэй байна.[1]

– Хөдөлмөрийн зах зээл ЗГ-ын дэмжлэг, эдийн засгийн зохицуулалтын ачаар ажилгүйдлийн түвшин бага байгаа ч цалингийн өсөлт инфляцын нөлөөгөөр хязгаарлагдаж байна

Дайн эхэлснээс хойш ОХУ-ийн ЭЗ-т гарсан эерэг өөрчлөлтүүд:

– Хувийн хэвшлийнхэнтэй хамтран үйлдвэрлэлээ идэвхтэй хөгжүүлж, нийлүүлэлтийн өөр эх үүсвэр хайж эхэлсэн. Зарим аж ахуйн нэгжүүдэд татаас олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж, буцалтгүй тусламж олгосон.

– Дотоодын хөдөө аж ахуйг хөгжүүлсний дүнд Оросын фермерүүд мах, сүү, хүнсний ногоо, жимс жимсгэнийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн. 2024 онд үр тарианы хураалт 150 сая тоннд хүрч, 2023 оныхоос 25%-иар өссөн байна. 2022 оноос хойш үр тарианы ургац дээд түвшинд хүрч дотоодын хэрэгцээг хангаад зогсохгүй гадаад зах зээлд экспортлох боломжийг бүрдүүлсэн.

– 2024 онд хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарт 200 орчим мянган ажлын байр шинээр бий болсон. Гэсэн хэдий ч үйлчилгээ, мэдээллийн технологи зэрэг бусад салбарын бууралт энэ өсөлтийг хэсэгчлэн нөхөж байна.

– Financial Times сонинд бичсэнээр 2023 онд Оросын

[1] - https://iis.ac.mn/post/22290

банкнууд ашиг орлогоо 2022 онтой харьцуулахад 16 дахин нэмжээ. Энэ нь Оросын эдийн засаг харьцангуй тогтвортой хэвээр байгааг харуулж байна.

–Бүх салбарын үр ашгийг хадгалахын тулд цалинг нэмэгдүүлэх шаардлага гарсан. ОХУ-ын дундаж цалингийн түвшин 2024 онд 8 хувиар өссөн ч инфляцыг тооцсон бодит өсөлт ердөө 1-2 хувьтай байна.

–ОХУ-д олон аж ахуйн нэгж, ялангуяа БХ аж үйлдвэр, үйлдвэрлэлийн хүчин чадлаа 2024 оны байдлаар 25%-иар нэмэгдүүлсэн. Автомашины сэлбэг хэрэгсэл, электрон барааны үйлдвэрлэл өмнөх оныхоос 30 -иар өссөн.

[1].



Зураг №4. 2025 оны ОХУ-ын улсын төсвийн орлого зарлагын задаргаа

Оросын 2025 оны төсвөө 40.3 трлн буюу 4675 тэрбум $-ийн орлого, 41.5 трлн буюу 4814 тэрбум $-ийн зарлага, 10.09 сая $ төсвийн алдагдалтай баталжээ. (1000 рубль=116 доллар тооцов) Төсвийн орлогын хамгийн их хэсгүүд болох 10,9 трлн руб.ийг нефьтгазын экспортоос, 18,2 трлн руб.ийг гааль, онцгой, НӨАТ-аас,4,8 трлн руб.ийг орлогын албан татвараас бүрдүүлдэг. Харин зарлагын 13.5 трлн руб.ийг БХ Цэргийн зардалд, 6.5 трлн руб.ийг нийгмийн бодлого, 4.3 трлн руб.ийг эдийн засагт, 3.5 трлн руб.ийг хууль сахиулах, 3.2 трлн руб.ийг өрийн төлбөрт, 2.5 трлн руб.ийг улс төрийн асуудал,ТА цалин хөлсөнд,1.8 трлн руб.ийг эрүүл мэнд,1.58 боловсрол, 1 трлн руб.ээс багыг урлаг, спорт, байгаль орчныг хамгаалахад зарцуулж байна. Дайнаас өмнө цэргийн зардал нь

[1] -Минфин.РФ, Оросын санхүүгийн яамны албан ёсны сайт

70 орчим тэрбум $ байсан бол одоо 13.5 трлн рубль=116 тэрбум долларт хүрээд байна.

Үүнээс үзэхэд дайн цэргийн ажиллагаа явуулахад зэр зэвсэгт маш их хөрөнгө мөнгө зарцуулж, харин дотоодын эдийн засагт эргэлдэх мөнгө багасаж, ДНБ ЭЗ-ийн өсөлт буурч, бусад иргэний салбаруудын зардал хэт их танагдаж орхигдож байгаа нь эргээд олон асуудлыг үүсгэж, ард иргэдийн сайн сайхан амьдрахад хүндрэл учруулах төлөвтэй байна.

Дүгнэлт

Оросын эдийн засагт хамгийн том сөрөг үр дагаврыг дайнаас илүү АНУ, ЕХ-ны хориг арга хэмжээ, экспортын хязгаарлалт, инфляц, хөрөнгийн гадагшаа, урсгал, цэргийн зардал, инфляцын өсөлт үүсгэсэн. Ялангуяа олон төрлийн хориг арга хэмжээнээс болж нефть газын бусад стратегийн бүтээгдэхүүний гадаад худалдаа, валютын нөөц багасаж, өндөр технологийн тоног төхөөрөмж дутагдаж, улмаар иргэний зориулалттай үйлдвэрүүд хүнд байдалд орж, эдийн засгийн эргэлт хумигдаж ихээхэн хохирлууд үүссэн. Нэг ёсондоо ОХУ Украйнд цэргийн ажиллагаа явуулж байгаач үнэндээ НАТО-той дайтаж, хажуугаар нь АНУ, ЕХ, тэдний холбоотнуудтай эдийн засгийн дайн хийж байна. Хэрэв энэ дайн урт хугацаанд үргэлжилбэл Орос улс богино хугацаанд дотоодын зах зээлээ хөгжүүлж, хөрөнгийн гадаад эх үүсвэрээс хараат байдлаа багасгах замаар эдийн засгийн шинэ бодит байдалд дасан зохицох ёстой болно. Хэрэв чадахгүй бол ОХУ-ын ЭЗ нурж 140 сая хүний амьдрал тартагтаа тулах болно. Оросын удирдагчид энэ бүхэнд буулт хийхгүй зөрүүдэлбэл дайны байдал улам хурцдаж цөмийн дайн, улмаар дэлхийн 3 дахь дайн эхлэх эрсдэл бий.

Оросын эдийн засаг нефть газын экспортоо хараат байдлаа багасгаж, анхаарлаа Европ руу биш Хятад, Энэтхэг бусад азийн орон руу чиглүүлэх, рублиэр худалдаа хийх, хөдөө аж ахуй, бизнес эрхлэгчдийг дэмжиж, тулгамдаж буй асуудлуудыг үр дүнтэй шийдвэрлэх зэрэг төр засгийн бодлого шийдвэрээс зарим эерэг өөрчлөлтүүд гарсан. Тухайлбал дайн тулаан хоригтой байгаач дотоодын зарим үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн өсөлт сайжирсан. Уг дайн зогсох эсэх, хориг арга хэмжээг нэмэх сулруулах боломж нь Украины нөхцөл байдлын өөрчлөлт, олон улсын тавцан дахь гол тоглогчдын шийдвэрээс их шалтгаална. Эцэст нь орчин үеийн дайн нь цэргийн ажиллагаа бус эдийн засгийн дайн, улс төрийн тоглоом гэдэг нь харагдаж байна.

Аливаа улсын дотоод нийгэм, эдийн засаг, улс төрийн зөрчлийг гаднын улс хүчнүүд өөрт ашигтайгаар ашигладаг болохыг Украинаас тодхон харагдана. Үүнээс монголчууд бид ч сургамж авах учиртай. Ялангуяа, улс төрийн буруу

шийдвэр, эх орноо худалдагсад, олигархууд улс төрд ихээр орж ирснээр, тэдгээрийн улсад хохиролтой шийдвэр, хээл хахууль улс орноо ямар байдалтай болгож буйг бодитоор харуулсан цаг үе юм. Түүнчлэн, гаднын орны улс төр эдийн засгийн далд нөлөө, гадаад худалдаа хэт нэг орноос хараат байдал, эдийн засаг нь баялгийн экспортоос хэт хамааралтай, олон тулгуур бүтэцгүй байх, дотоодын нийгмийн шударга бус байдал, баялгийн тэгш бус хуваарилалт, хээл хахууль, төрийн буруу удирдлага нь аливаа улс төр эдийн засгийн хямрал, зөрчлийн эх сурвалж болж байна. Ийм байдал даамжирсаар эдийн засаг хүнд байдалд орж иргэдийн амьдрал хэцүүдвэл иргэний бослого, хөдөлгөөн үүсэж, гаднынхан үүн дээр тоглолт хийж байдлыг улам дордуулж байгааг Украйны жишээнээс харж болно.

Украин улс нь харьцангуй үйлдвэржсэн, эдийн засгаа олон талаар хөгжүүлж "солонгоруулж" чадсан улс тулдаа энэ хүнд дайн мөргөлдөөнтэй үед эдийн засгаа бага зэрэг аварч байна. Орчин үеийн дайн нь маш их хөрөнгө мөнгө шаарддаг, гадаад орнуудын хамтын ажиллагаа худалдаа тусламж ямар чухал болохыг, эдийн засгийн хүчин чадлаас ямар их шалтгаалж, бас түүнд хэрхэн нөлөөлж чаддагийг уг 2 орны дайны туршлагаас харлаа. Монгол улс ч бас энэ бүхнийг анхаарах учиртай. "геополитик, эдийн засгийн аюулгүй байдал, баялгийн экспорт, том улс холбооны дундах "жийргэвч бүс", хийн хоолойн транзит тээвэр, гэсэн ижил төстэй асуудлууд Монгол Улсад бий. Учир нь манай улс Украйн шиг Орос Хятадын "жийргэвч бүс" гэдгийг мартаж болохгүй билээ.

Эх сурвалж

- Минфин.РФ, Оросын санхүүгийн яамны албан ёсны сайт
- Шударга дайны онол өгүүллэг
- https://ikon.mn/n/33fk
- Reuters. 2025. "Putin suggests temporary administration for Ukraine to end war"
- Sky News. 2025. "Restoration of Ukraine's borders, NATO membership and US troop involvement all 'unlikely' says US Defense Sec"
- The New York Times. 2025. "U.S. and Russia Pursue Partnership in a Head-Spinning Shift in Relations"
- The Wall Street Journal. 2025. "France-U.K. Plan for European Troops in Ukraine Falters"
- https://ru.wikipedia.org/wiki
- https://iis.ac.mn/post/22290
- Украйны ХАА, худалдааны яамны мэдээлэл
- A struggle to survive. Ukraine's economy in

- wartime. OSW (18 октября 2022).
- Украйны статистикийн албаны мэдээлэл
- Прогноз невтішний. Через війну з РФ українська економіка втратила $280 млрд з 2014 року — CEDR
- Средняя заработная плата в Украине в долларах США. МинфинМедиа (2021). Дата обращения: 27 ноября 2022.
- Ukraine Has Lost 30% of Prewar Jobs, U.N. Agency Estimates. Wall Street Journal (11 мая 2022).
- Russia and Ukraine renew a grain export deal to help the hungry and keep prices down
- Another fuel crisis threatens Ukraine. Hungarian Posts (3 ноября 2022).
- In the Ukraine war, a battle for the nation's mineral and energy wealth
- Ukraine Central Bank Halts Currency Market, Limits Cash Withdrawals
- Росстат- Оросын статистикийн газар
- https://ru.wikipedia.org/wiki/
- https://iis.ac.mn/post/22290

БИЕ БЯЛДРЫН ШАЛГАЛТ БА СЭТГЭЛЗҮЙ, ТЭСВЭР ТЭВЧЭЭРИЙН ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛ

Д.Түмэнцэцэг
Дотоод хэргийн их сургуулийн Биеийн тамир, албаны бэлтгэлийн институтийн багш, дэслэгч

Товч агуулга: 2024 онд Дотоод хэргийн их сургуулийн харьяа сургуулиудын сонсогчдын дунд зохион байгуулагдсан бие бялдрын түвшин тогтоох шалгалтад нийт 1,113 сонсогч хамрагдсан. Шалгалтын зорилго нь сонсогчдын биеийн хөгжлийн түвшин, сэтгэлзүйн тогтвортой байдал, ирээдүйн үүрэг гүйцэтгэх чадамжийг тодорхойлох явдал байв. Үнэлгээний таван шалгуур үзүүлэлтээр дүгнэгдсэн ба шалгалтын дүнг сургуулиудын хооронд харьцуулан дүн шинжилгээ хийсэн. Үр дүнгээс харахад Онцгой байдлын сургуулийн сонсогчид хамгийн өндөр амжилт, чанарын үзүүлэлттэй байсан бол Цагдаагийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулиудын сонсогчид харьцангуй доогуур үзүүлэлттэй байв. Бие бялдрын хөгжил нь хууль сахиулах, аюулгүй байдлын байгууллагын алба хаагчдын мэргэжлийн чадамж, бэлэн байдлын чухал үзүүлэлт юм. Иймд сонсогчдын бие бялдрын байдлыг бодитой үнэлэх, сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, сайжруулах үндэслэл бүрдүүлэх зорилгоор энэхүү шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтад хамрагдсан сонсогчдын гүйцэтгэлийг таван төрлийн шалгууураар үнэлж, A–F үнэлгээ өгсөн. Судалгаанд нийт оролцсон, амжилттай дүгнэгдсэн, чанарын үнэлгээ авсан сонсогчдын хувь хэмжээг тооцож, сургуулиудын хоорондын харьцуулалт хийж, чанарыг тоон судалгааны аргаар судалж үр дагавраар нь нэгтгэн дүгнэлээ.

Түлхүүр үгс: Бие бялдрын шалгалт, гүйцэтгэлийн үнэлгээ, чанарын үзүүлэлт, чадварын үнэлгээ.

Удиртгал

Хууль сахиулах, аюулгүй байдлын байгууллагын алба хаагчид нь өндөр хариуцлага хүлээдэг, биеийн болон сэтгэлийн тэнцвэртэй, онцгой нөхцөлд шуурхай, оновчтой шийдвэр гаргах чадвартай байх шаардлагатай. Энэ шаардлагыг хангах үндэс нь албанд бэлтгэгдэж буй сонсогчдын бие бялдрын хөгжлийн түвшин, сэтгэл зүйн тогтвортой байдал, тэсвэр хатуужилтай шууд холбоотой.

Иймээс Дотоод хэргийн их сургуулийн харьяа сургуулиудын сонсогчдын дунд жил бүр зохион байгуулагддаг бие бялдрын түвшин тогтоох шалгалт нь сонсогчдын цаашдын мэргэжлийн үйл ажиллагаанд шаардлагатай суурь бэлтгэлийг бүрдүүлэх,

сургалтын чанарт нөлөөлөх чухал шалгуур болдог. Энэхүү шалгалт нь зөвхөн биеийн хүч чадлыг үнэлэхээс гадна авхаалж самбаа, сэтгэлзүйн бэлтгэлжилт, хариу үйлдэл үзүүлэх чадвар зэрэг олон талт үзүүлэлтээр үнэлэгддэг онцлогтой.

Энэхүү илтгэлд Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургууль, Хилийн албаны сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль, Онцгой байдлын сургуулийн сонсогчдын бие бялдрын түвшин тогтоох шалгалтын дүнг харьцуулан судалж, тэдний бэлтгэлжилтийн түвшнийг үнэлэн, сургалтын хөтөлбөрт цаашид анхаарах шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлсон болно.

Үндсэн хэсэг

Цэргийн биеийн тамирын бэлтгэлжилтийн эрх зүйн үндэс ба ач холбогдол

Цэргийн биеийн тамирын заавар ба түүний зорилго

Монгол Улсын “Цэргийн биеийн тамирын заавар” (ЦБТЗ-18) нь зэвсэгт хүчний болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийг төлөвлөх, удирдан зохион байгуулах, хэрэгжилтийг хянах үндсэн баримт бичиг юм. Энэхүү заавар нь биеийн тамирын сургалт, дасгалжуулалт, тоног төхөөрөмж, орчин нөхцөлийг тодорхойлох, аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр нэгдсэн арга зүйг тогтоодог.[1]

Цэргийн алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилт нь байлдааны болон хуулиар хүлээсэн тайван цагийн үүргийг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай бөгөөд тухайн алба хаагчийн мэргэжлийн чадамж, эрүүл мэнд, сэтгэлзүйн тогтвортой байдлын үндэс болдог. Иймд “Цэргийн биеийн тамирын заавар” нь зөвхөн сургалт-дасгалын төлөвлөлтөөс гадна алба хаагчдын чадавхыг үнэлэх, цаашдын хөгжлийн чиглэлийг тодорхойлоход чухал суурь баримт бичиг болдог.

Цэргийн биеийн тамирын зорилго ба утга агуулга

“Цэргийн биеийн тамир” нь зөвхөн биеийн хүчний дасгал хөдөлгөөнөөс бүрдэхгүй бөгөөд алба хаагчдад сэтгэл зүйн тэсвэр, сахилга бат, хатуужил, авхаалж самбаа зэрэг олон талын чадваруудыг эзэмшүүлэх цогц үйл ажиллагааг хамардаг.[2] Энэхүү хандлага нь байлдааны нөхцөлд ажиллах чадвар, түргэн шуурхай шийдвэр гаргах, эрсдэлтэй нөхцөлд амь биеэ хамгаалах, бусдын аюулгүй байдлыг хангах чадамжийг төлөвшүүлдэг.

Сонсогчдын бие бялдрын түвшин тогтоох шалгалт нь дээрх заавар, арга зүйтэй нийцсэн, бодит үнэлгээ хийх, сургалтын

[1] *ЦБТЗ-18, 2018*

[2] *ЦБТЗ-18, 2018*

хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ач холбогдолтой. Энэ нь сургалтын үр дүнг хэмжих, дүн шинжилгээ хийх, системтэй хөгжүүлэх үндэс болдог.

Бусад орны цэргийн сургуулийн биеийн тамирын шалгалтын жишиг

Дэлхийн улс орнуудын цэргийн сургуулиудад сонсогчдын бие бялдрын түвшинг тогтоох шалгалтыг тусгай заавар, стандартын дагуу авдаг. Жишээ нь:

• АНУ: *Candidate Fitness Assessment* (CFA) шалгалтад сагсан бөмбөгийн шидэлт, суниалт, гэдэсний дасгал, shuttle run, 1 милийн гүйлт зэрэг багтдаг бөгөөд сонсогчийн ерөнхий биеийн хөгжил, шийдвэр гаргах чадварыг үнэлдэг (United States Military Academy, n.d.).

• Их Британи: Сандхурстийн Цэргийн Академи нь "Role Fitness Test"–ийг хэрэгжүүлдэг. Энэ нь бодит байдалд ойр дасгалууд (ачаа зөөх, бөмбөг шидэх, үхлийн өргөлт, саадтай гүйлт) агуулсан бөгөөд нас, хүйс ялгалгүй авдаг (British Army, 2023).

• Канад: "FORCES Fitness Test" нь sandbag carry, push/pull sled, shuttle run, plank гэх мэт дасгалуудаар биеийн тамирын чадавхыг шалгадаг (Government of Canada, 2022).

• Герман: Bundeswehr-ийн шалгалт нь 11x10 м shuttle run, гарын түлхэлт, 1000 м гүйлтээс бүрддэг бөгөөд цэргийн албаны суурь бэлтгэлийг шалгадаг (Bundeswehr, n.d.).

• ОХУ: Бие бялдрын шалгалт нь нас, хүйс, мэргэжлийн чиглэлд тохирсон байдлаар явагддаг. Үүнд суниалт, гэдэсний дасгал, 100 м болон 3 км гүйлт багтдаг (Ministry of Defence of the Russian Federation, 2021).

• Өмнөд Солонгос: 2 км гүйлт, хэвтээгээс гэдэсний дасгал, суниалт зэрэг дасгалуудын шалгалтыг жил бүр тогтмол авдаг бөгөөд сахилга, тэсвэрийг үнэлдэг (Republic of Korea Armed Forces, 2023).

Эдгээр жишээнүүд нь бүх орны цэргийн байгууллагууд өөрсдийн онцлогт нийцүүлэн бэлтгэлжилтийн шалгуур тогтоодог боловч нийтлэг шинж нь хүч чадал, тэсвэр тэвчээр, сэтгэлзүй, авхаалж самбааг хамарсан бодит шалгуурт үндэслэдэг болохыг харуулж байна.

Сонсогчдын бие бялдрын шалгалтын нэгдсэн дүн

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургууль, Хилийн албаны сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль, Онцгой байдлын сургуулийн сонсогчдын дунд зохион байгуулагдсан бие бялдрын түвшин тогтоох шалгалт нь 2024 оны __ дугаар сарын __-ны өдрөөс __ дугаар сарын __-ны өдрийг хүртэл нийт __ өдрийн хугацаанд амжилттай явагдсан.

Шалгалтад нийт ___ сонсогч хамрагдсан бөгөөд үнэлгээ нь

дараах таван төрлийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр хэмжигдсэн. Үүнд:

- Авхаалж самбаа – хурдан сэтгэх, шийдвэр гаргах, хариу үйлдэл үзүүлэх чадварыг шалгах дасгалууд;
- Хүч – булчин, биеийн ерөнхий хүч чадал, физик ачаалал даах чадвар;
- Уян хатан байдал – үе мөчний хөдөлгөөний уян налархай, хөдөлгөөн хязгаарлалтаас сэргийлэх чадамж;
- Хурд – богино хугацаанд тодорхой зайнд гүйцэтгэл үзүүлэх чадвар;
- Тэсвэр тэвчээр – урт хугацааны ачааллыг даван туулах чадвар, амьсгал, зүрх судасны тогтолцооны бэлтгэлжилт.

Шалгалтын төрлүүдэд зориулсан онооны жишиг, үнэлгээний шалгуурт үндэслэн сонсогч бүрийн гүйцэтгэлийг биеийн тамирын бэлтгэлжилтийн стандартаар дүгнэж, нэгтгэн гаргасан бөгөөд уг дүнг дараах бүлэгт шалгалтын дүнгийн харьцуулсан судалгааг танилцуулж байна. *Дүнг хүснэгтээр харуулбал:*

Үзүүлэлт	Онцгой байдлын сургууль	Хилийн албаны сургууль	Цагдаагийн сургууль	ШШГАлбаны сургууль
Нийт сонсогч	77	255	665	116
Шалгалтад оролцсон	64 (83.1%)	233 (91.4%)	605 (91%)	107 (92.2%)
A	0	3	2	0
B	13	25	59	11
C	13	39	83	10
D	19	63	159	34
F	19	103	302	52
Амжилттай (A–C)	26 (40.6%)	67 (28.8%)	144 (23.8%)	21 (19.6%)
Амжилтын хувь	20.31%	12.02%	10.08%	10.28%
Чанарын хувь (A–B)	70.31%	55.79%	—	51.40%

Дүгнэлт

1. *Онцгой байдлын сургууль*

Амжилтын хувь хамгийн өндөр буюу 20.31%

Чанарын үзүүлэлт хамгийн сайн буюу A-B: 70.31%

A үнэлгээтэй хүн байхгүй ч B, C-д өндөр үзүүлэлттэй байна.

Шалгалтад оролцсон сонсогчдын тоо хамгийн бага ч үр дүн хамгийн сайн гарсан.

2. *Хилийн албаны сургууль*

Дундаж амжилтын хувьтай 12.02% бөгөөд бусад сургуулиудтай харьцуулахад 255 сонсогчоос 233 нь оролцсон нь сайн үзүүлэлт юм.

Бусад сургуультай харьцуулахад А үнэлгээтэй сонсогч хамгийн их.

Чанарын хувь 55.79% буюу хоёрдугаарт орсон.

3. *Цагдаагийн сургууль*

Хамгийн олон оролцогчтой (605 хүн), гэхдээ хамгийн бага амжилттай буюу 10.08%

F үнэлгээтэй хамгийн олон хүнтэй буюу 302 хүн буюу 49.9%-тай

А үнэлгээтэй ердөө 2 хүн байна.

Чанарын хувь өгөгдөөгүй боловч А–В 61 хүнтэй (10%) байна.

4. *ШШГАлбаны сургууль*

Оролцсон хүний хувь өндөр ч амжилтын хувь буюу 19.6%, болон чанар (51.4%) нь доогуур.


А үнэлгээ огт байхгүй, харин F үнэлгээ өндөр байна (52 хүн буюу 48.6%)

Дээрх харьцуулсан судалгаанаас дүгнэхэд:

1.Онцгой байдлын сургуулийн сонсогчид бие бялдрын шалгалтад бусдаас илүү амжилттай, чанартай оролцсон байна.

2.Цагдаагийн сургууль, ШШГАлбаны сургуульд амжилт болон чанарын хувьд анхаарах шаардлагатай.

3.Хилийн албаны сургууль нь А үнэлгээ хамгийн их байгаа ч нийт амжилтын хувь нь дунд түвшинд байна.



Санал

Биеийн бэлтгэл, тэсвэр тэвчээрийн чанарыг сайжруулах: Цагдаагийн сургууль болон ШШГАлбаны сургуулиудын хувьд нийтлэг дутагдал нь биеийн хүч чадал болон тэсвэр тэвчээрийн үзүүлэлт бага байгаагаас, тэсвэр тэвчээрийн болон хүч чадлын дасгалуудыг илүү гүнзгий, нарийвчилсан түвшинд оруулах шаардлагатай байна. Эдгээр сургуулиудад эмэгтэй consогчдын тоо харьцангуй өндөр байгааг анхаарах хэрэгтэй бөгөөд энэ нь бие бялдрын дасгалуудыг илүү зохицуулалттай, тохиромжтой байдлаар явуулах шаардлагатайг харуулж байна. Мөн, хичээлийн ачаалал, кредит цаг нь харьцангуй бага байгаагаас, бие бялдрын бэлтгэл хангалттай түвшинд хийгдэхгүй байгаа бөгөөд үүнийг сайжруулахын тулд хичээлийн ачааллыг нэмэгдүүлэх, сургалтын хөтөлбөрийг эрчимжүүлэх хэрэгтэй байна.

Шалгалтын системийг сайжруулах: Бие бялдрын шалгалт нь зөвхөн хүч чадал, гүйцэтгэлд төвлөрөх биш, харин consогчдын амьсгалын чадавх, сэтгэл зүйн тэсвэр, хурдан шийдвэр гаргах чадварыг ч мөн шалгах хэрэгтэй. Үүнтэй холбогдуулан, шалгалтын сэдэв, дасгалуудыг өргөжүүлж, олон талын чадварыг хамруулах нь сургалтын үр дүнд эерэг нөлөө үзүүлнэ.

Эх сурвалж

1. Батлан хамгаалахын яам. (2018). *Цэргийн биеийн тамирын заавар (ЦБТЗ-18)*. Улаанбаатар: Батлан хамгаалахын яам.
2. United States Military Academy. (n.d.). *Candidate Fitness Assessment Guidelines*. Retrieved from https://www.westpoint.edu
3. British Army. (2023). *Army Role Fitness Test (RFT)*. Retrieved from https://www.army.mod.uk
4. Government of Canada. (2022). *FORCES Fitness Test*. Retrieved from https://www.canada.ca/en/department-national-defence
5. Bundeswehr (German Armed Forces). (n.d.). *Sporttest bei der Bundeswehr*. Retrieved from https://www.bundeswehrkarriere.de
6. Ministry of Defence of the Russian Federation. (2021). *Military Fitness Training Manual*. Москва: Министерство обороны Российской Федерации.
7. Republic of Korea Armed Forces. (2023). *Physical Fitness Test Manual*. Seoul: Ministry of National Defense.
8. Монгол Улсын Засгийн газар. (2022). *Цэргийн алба хаагчийн сургалт, бэлтгэлжилтийн журам*. Улаанбаатар: Төрийн хэвлэлийн газар.

ХИЛЧИН ОФИЦЕРУУДЫН УЯН ХАТАН ЧАНАР БА СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ХАМААРАЛ

Б.Хишигжаргал
ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн сэтгэл зүйн тэнхимийн багш, докторант, хошууч

Товч агуулга: Энэхүү судалгааны зорилго нь Хилийн цэргийн офицер бүрэлдэхүүний уян хатан чанар болон ажлын байрны сэтгэл ханамжийн хоорондын хамаарлыг тодорхойлох явдал байв. Судалгаанд нийт 520 алба хаагч хамрагдсан бөгөөд Connor-Davidson Resilience Scale (CD-RISC-25), Gallup Q12 асуулгыг ашиглаж, SPSS программаар өгөгдлийг боловсруулсан. Шинжилгээний үр дүнд уян хатан чанар ба ажлын байрны сэтгэл ханамжийн хооронд дунд зэргийн хүчтэй эерэг хамаарал илэрсэн (r = .505, p < .001). Олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээгээр уян хатан чанар нь сэтгэл ханамжийг статистикийн хувьд ач холбогдолтойгоор урьдчилан таамаглаж байв ($\beta = .524$, $p < .001$). Бүлгүүдийн ялгааны шинжилгээгээр хүйсийн хувьд хамааралд мэдэгдэхүйц ялгаа илэрсэн бол нас, бүс нутаг, гэр бүлийн байдлын хувьд ялгаа статистикийн хувьд батлагдаагүй. Судалгааны үр дүн нь хил хамгаалах байгууллагын алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэлийг сайжруулах, ажлын орчны бодлогод хувь хүний уян хатан чанарыг харгалзан үзэх шаардлагатайг харуулж байна.

Түлхүүр үгс: Офицер, уян хатан чанар, сэтгэл ханамж, CD-RISC, Gallup Q12

Удиртгал

Сэтгэл зүйн уян хатан чанар гэдэг нь хувь хүн эрсдэл, бэрхшээлийн нөхцөлд амжилттай дасан зохицох, сэтгэл зүйн тэнцвэрээ хадгалан “сэргэх” чадварыг хэлдэг (Meredith et al., 2011). Өөрөөр хэлбэл, хүндрэл, тодорхойгүй байдал, бүтэлгүйтэл зэрэг таагүй нөхцөлд хурдан “буцаад босох” эерэг сэтгэл зүйн чадавх юм (Kašpárková et al., 2018a). Коннор Девидсон нар энэхүү чанарыг “бэрхшээлийн өмнө ч хөгжин дэвжих чадвар” хэмээн тодорхойлсон (Connor & Davidson, 2003). Иймээс уян хатан чанар нь хувь хүний стресстэй тэмцэх чадварыг хэмжих нэг шалгуур гэж үзэж болно.

Ажил, мэргэжлийн орчинд уян хатан чанар нь хүндрэл бэрхшээлийг даван туулж, ажил, амьдралын хэвийн хэв маягийг хадгалах гол хувь хүний нөөц болдог. Ялангуяа цэрэг, батлан хамгаалах, онцгой байдал зэрэг өндөр эрсдэлтэй албан тушаалд энэ чанар зайлшгүй шаардлагатай юм. Судалгаагаар сэтгэл зүйн уян хатан чанар өндөр хүмүүс стрессийг үр дүнтэй даван туулж, сэтгэл зүйн тогтвортой байдлаа

хадгалан ажиллах хандлагатай нь тогтоогджээ (Kašpárková et al., 2018a). Үүний улмаас Олон Улсын цэргийн байгууллагууд алба хаагчдынхаа сэтгэл зүйн уян хатан байдлыг дээшлүүлэх хөтөлбөрүүдийг өргөн нэвтрүүлж байна. Тухайлбал, АНУ зэрэг орны зэвсэгт хүчин алба хаагчдын болон тэдний гэр бүлийн сэтгэл зүйн уян хатан чанарыг дэмжих олон төрлийн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн нь энэ чиглэлд анхаарал нэмэгдсэнийг илтгэнэ. Ажлын байран дахь уян хатан чанарыг хөгжүүлэх замаар ажилтны сайн сайхан байдал, гүйцэтгэлийг дээшлүүлэх боломжтойг сүүлийн арван жилээс илүү хугацааны судалгаанууд нотолсоор байна. Тухайлбал, байгууллагад уян хатан чанарыг дээшлүүлэх сургалт зохион байгуулснаар ажилтнууд стрессээ даван туулах чадвар сайжирч, улмаар илүү сэтгэл ханамжтай, бүтээмжтэй болсон тухай илэрхий баримтууд хүртэл бий. Өндөр уян хатан чанартай ажилтнууд нь ажил дээрээ эерэг сэтгэл хөдлөлөө хадгалж, таагүй нөхцөлд ч үр дүнтэй ажиллаж чаддаг тул бага уян хатан чанартай ажилтнуудаасаа илүү ажилдаа сэтгэл ханамжтай байх хандлагатай гэж үзэх болсон.

Ажлын байрны сэтгэл ханамж гэдэг нь ажилтан өөрийн ажлын нөхцөл, туршлагаа хэрхэн үнэлж, эергээр хүлээн авч байгааг илэрхийлэх ойлголт юм. Сонгодог тодорхойлолтоор, энэ нь “ажил нэгж хүн өөрийн ажил үүрэг, ажлын үнэт зүйлсийг биелүүлж байгаа талаар мэдэрдэг тааламжтай сэтгэлийн байдал” хэмээн тодорхойлогддог (Kašpárková et al., 2018b). Ажилтны сэтгэл ханамж нь олон хүчин зүйлээс хамаарч өөрчлөгдөнө. Жишээлбэл, ажлын ачаалал, цалин хөлс, удирдлагын манлайлал, хамт олны харилцаа, ажиллах орчин, өсөж хөгжих боломж гэх мэт хүчин зүйлс нь ажилтны сэтгэл ханамжид шууд нөлөөлдөг нь судалгаагаар тогтоогджээ (Brooks & Greenberg, 2022). Ажилдаа өндөр сэтгэл ханамжтай ажилтнууд хамт олонтойгоо илүү сайн харилцаатай байж, ажил таслалт бага, байгууллагынхаа төлөө хүчин зүтгэх эрмэлзэл өндөр, мөн ажлаасаа гарах магадлал бага байдгийг өмнөх олон судалгаа нотолдог. Тухайлбал, ажилдаа сэтгэл хангалуун хүмүүс ажлын гүйцэтгэлийн үнэлгээ өндөр авч, хамт олондоо итгэл үзүүлэх хандлага нэмэгдэж, байгууллагаасаа гарах нь бага байдаг талаар Judge нарын (2001) судалгаанд дурдаж байна (Judge et al., 2001)

Ажилтны сэтгэл ханамж өндөр байх нь зөвхөн тухайн ажилтны сэтгэл ханамж, эрүүл мэндэд эерэг нөлөөтэйгөөс гадна байгууллагын бүтээмж, үйл ажиллагааны чанарт чухал хувь нэмэр оруулдаг. Иймээс аливаа байгууллагын хувьд

ажилтнуудынхаа сэтгэл ханамжийг хэмжиж, сайжруулах нь стратегийн ач холбогдолтой хэвээр байна.

Сэтгэл зүйн уян хатан чанар болон ажлын байрны сэтгэл ханамжийн хооронд хамаарал нь сүүлийн арван жилд судалгааны сонирхлыг татсан өргөн сэдвийн нэг болж байна. 2010 оноос хойших Олон Улсын олон судалгаагаар эдгээр хоёр хувьсагчийн хооронд эерэг хамаарал байдгийг давтан тогтоожээ. Тухайлбал, Jafri нар (2016), Di Fabio ба Saklofske (2018) зэрэг судлаачид уян хатан чанар өндөр байх нь ажилтай холбоотой эерэг хандлагууд, тэр дундаа ажлын байрны сэтгэл ханамж өндөр байхтай нягт холбоотойг мэдээлсэн байна (Jafri et al., 2016; Di Fabio & Saklofske, 2018). Hudgins (2016) сувилахуйн удирдах ажилтнуудын дунд хийсэн судалгаагаар ч уян хатан чанар, ажлын сэтгэл ханамж хоёрын хооронд хүчтэй эерэг хамаарал байгааг олж тогтоосон бөгөөд улмаар уян хатан чанар сайтай удирдах ажилтнууд албан тушаалдаа үлдэх хандлага нь нэмэгддэгийг дурдсан байна (Hudgins, 2016).

Цэрэг, аюулгүй байдлын салбарт хийгдсэн судалгаанууд ч дээрх хандлагыг бататгаж байна. Испанийн Цэргийн академийн 363 офицер сонсогчдын дунд явуулсан нэгэн судалгаагаар сэтгэл зүйн уян хатан байдлын үзүүлэлт өндөр байх нь тэдний ажлын байрны сэтгэл ханамжийг мэдэгдэхүйц таамаглагч хүчин зүйл болж байсныг илрүүлжээ (Valor-Segura et al., 2020). Тус судалгаанд уян хатан чанар болон проактив зан чанар хоёул ажил дахь сэтгэл ханамжид эергээр нөлөөлж, эдгээр нь хамтдаа ажлын сэтгэл ханамжийн хэлбэлзлийн 10 орчим хувийг тайлбарлаж байсан гэжээ. Мөн цэргийн алба хаагчдын хувьд уян хатан чанар, идэвх санаачилгатай байдал зэрэг хувь хүний шинжүүд нь сэтгэл ханамжтай байдалтай эергээр хамааралтай нотолсон байдаг (Kuo et al., 2019).

Монгол Улсын Хил хамгаалах байгууллага нь улсынхаа хэдэн мянган километр үргэлжлэх хуурай газрын хилийг хамгаалах үүрэгтэй, цэргийн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага юм. Хил хамгаалах албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаа нь эх орныхоо аюулгүй байдлыг хангахын тулд хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, тэмцэх, хууль бус наймаа, хил зөрчигчийн хөдөлгөөнийг илрүүлэн таслан зогсоох гэх мэт хариуцлагатай үүргүүдийг хамардаг. Энэхүү ажил нь онцгой нөхцөл, онцлогтой бөгөөд алба хаагчдаас өндөр сахилга бат, тэсвэр хатуужил, сэтгэл зүйн бэлтгэл шаарддаг. Монгол орны хил орчмын ихэнх хэсэг нь хүн ам сийрэг, байгалийн хүнд нөхцөлтэй байдгийг харгалзан үзвэл, хилчид алслагдсан харуул,

заставуудад удаан хугацаагаар ажиллах үед ганцаардал, гэр бүлээсээ хол байх, хязгаарлагдмал орчинд ажиллах, хилийн манаа, эрэл хайгуулын бүлгээр олон цаг явах зэрэг нь сэтгэл зүйн ачаалал болох магадлалтай. Мөн цаг уурын хувьд хахир хатуу өвөл, халуун зун, хавсарга шуурга зэрэг эрс тэс нөхцөл, үүрэг гүйцэтгэх үед хууль бус зэвсэгт этгээдтэй тулгарах, осол гэмтэл гарах гэх мэт учирч болзошгүй эрсдэл нь хилчин алба хаагчдын ажилд нэмэлт дарамт, стресс үүсгэдэг.

Хил хамгаалах чиг үүрэг гүйцэтгэгчдийн сэтгэл зүйн ачаалал нь бусад хууль сахиулах албадынхтай төстэй хэдий ч өөрсдийн онцлог стрессоруудтай байдаг аж. 2022 онд хийгдсэн нэгэн шинжилгээнд хил хамгаалах албан хаагчдад дараах гол стресс үүсгэгч хүчин зүйлс нийтлэг илэрдгийг тогтоожээ (Brooks & Greenberg, 2022). Үүнд:

- Байгууллагын орчин, нөөц: Удирдлагын сул дэмжлэг, ажиллах хүч, нөөц бололцооны хомсдол, бага цалин хөлс, тушаал дэвших боломж хязгаарлагдмал байх;
- Ажлын нөхцөл, ачаалал: Хэт их ажлын ачаалал, удаан хугацааны ээлжээс үүдэлтэй ядралт, алслагдмал, аюултай орчинд үүрэг гүйцэтгэх шаардлага;
- Нийгэм, ёс зүйн хүчин зүйл: Олон нийтийн сөрөг хандлага (нийгэмд тус ажил мэргэжлийг үнэлэх үнэлэмж бага байх), хууль бус үйлдэлтэй тэмцэх явцад ёс суртахууны хоёрдмол нөхцөл байдалтай тулгарах.

Дээрх хүчин зүйлс нь хил хамгаалах албан хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэнд, ажлын сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлөх магадлалтайг судлаачид тэмдэглэжээ. Харамсалтай нь, хилчдийн сэтгэл зүйн сайн сайхан байдал, ажиллах орчны асуудалд чиглэсэн академик судалгаа дэлхий нийтэд хангалтгүй түвшинд байна. Тусгайлан хил хамгаалах албаны ажилчдыг авч үзсэн судалгааны тоо маш цөөн, энэ нь судлаачдын зүгээс төдийлөн анхаарч ирээгүйн илрэл юм.

Монгол Улсын хэмжээнд хил хамгаалах байгууллагын алба хаагчдын сэтгэл зүйн байдал, ажил мэргэжлийн сэтгэл ханамжийн харилцан хамаарлыг нарийвчлан судалсан судалгаа төдийлөн хийгдээгүй байгаа нь энэ чиглэлд мэдлэг, практикийн тодорхой хоосон орон зай байгааг илтгэнэ. Ийм нөхцөлд хил хамгаалах байгууллагын 520 офицер, бие бүрэлдэхүүнийг хамруулсан энэхүү судалгаа нь сэтгэл зүйн уян хатан чанар болон ажлын байрны сэтгэл ханамжийн хоорондын хамаарлыг тодорхойлох оролдлого юм.

Нэгдүгээрт, уг судалгаа нь хил хамгаалах байгууллагын алба хаагчдын сэтгэл зүйн төлөв байдал, түүний ажил мэргэжилтэй холбоотой сэтгэл ханамжийн талаарх суурь эмпирик мэдээлэл бий болгохыг зорьсон.

Хоёрдугаарт, уян хатан чанар ба ажлын сэтгэл ханамжийн харилцан хамаарлыг илрүүлэх нь байгууллагын хүний нөөцийн бодлого боловсруулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлд хэрэгцээтэй мэдээлэл өгч болох юм. Жишээлбэл, хэрэв уян хатан чанар өндөр байх нь сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг нь судалгаагаар нотлогдвол, байгууллагын түвшинд ажилтны сэтгэл зүйн уян хатан байдлыг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлага, чиглэлийг тодорхойлох үндэслэл болно. Гуравдугаарт, судалгааны үр дүнд тулгуурлан алба хаагчдын ажлын орчин, байгууллагын соёл, сэтгэл зүйн дэмжлэгийн тогтолцоонд сайжруулалт хийх боломжийг дэвшүүлэн тавих үндэслэл бүрдэнэ.

Олон улсын судалгаануудын үр дүнд тулгуурлан байгууллагын соёлыг сайжруулах, ажилтнуудад чиглэсэн сэтгэл зүйн тусламж, дэмжлэгийг тогтолцооны түвшинд төлөвлөх нь уян хатан чанарыг нэмэгдүүлэх үр дүнтэй арга хэмжээ болдог хэмээн судлаачид онцолдог (Brooks & Greenberg, 2022). Иймд энэхүү судалгаа нь манай орны хил хамгаалах байгууллагын нөхцөлд нийцсэн арга хэмжээ, бодлогын зөвлөмж боловсруулахад хувь нэмэр оруулах боломжтой юм.

Эцэст нь, хил хамгаалах байгууллагын алба хаагчдын ажлын онцлог болон сэтгэл зүйн ачааллыг харгалзан үзэхэд, тэдний уян хатан чанар ба ажлын байрны сэтгэл ханамжийн харилцан хамаарлыг судлах нь онолын болон практик ач холбогдолтой, цаг үеийн шаардлагатай асуудал хэмээн үзэж байна.

Судалгааны арга зүй

Судалгааны зорилго: Хилийн цэргийн офицер бүрэлдэхүүний сэтгэл зүйн уян хатан чанар болон ажлын байрны сэтгэл ханамжийн хоорондын хамаарлыг тодорхойлох

Судалгааны арга: Судалгаанд дараах хоёр баталгаажсан психометр хэмжүүрийг ашиглав. Үүнд:

1. Сэтгэл зүйн уян хатан чанарын хэмжүүр (CD-RISC-25):
   Коннор, Девидсон (2003) нарын боловсруулсан тус хэмжүүр нь 25 асуулттай. Асуултуудыг 0–4 (огт хамаарахгүй – бүрэн хамаарна) гэсэн 5 түвшний Лайкерт хариултын хэлбэрээр үнэлдэг. Монгол хувилбарыг сэтгэл зүй, орчуулгын экспертүүдээр баталгаажуулсан.
   Хэмжүүрийн дотоод найдвартай байдал Cronbach’s $\alpha = 0.97$ байсан.
2. Ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаа (Gallup Q12):
   Gallup байгууллагын боловсруулсан “Q12 Employee Engagement

Survey”-г ашигласан. Энэ нь ажилтны ажлын орчин дахь оролцоо, сэтгэл ханамжийг 12 шалгууруар үнэлдэг бөгөөд 6 түвшний Лайкерт хариултын хувилбартай (1 = огт санал нийлэхгүй, 6 = бүрэн санал нийлнэ). Шалгуурын дотоод найдвартай байдал α = 0.94 байна.

Түүвэр: Судалгаанд Хил хамгаалах байгууллагын анги, салбаруудад үүрэг гүйцэтгэж буй нийт 520 офицер бүрэлдэхүүнийг хамруулсан. Түүвэр нь судалгааны зорилго, төлөөлөх чадварыг хангах үүднээс нас, хүйс, бүс нутгийн байршил, албан тушаал, боловсролын суурь, гэр бүлийн байдал зэрэг гол хүн ам зүйн шинжүүдийг харгалзан сонгосон бөгөөд санамсаргүй давхар түүврийн аргаар бүрдүүлсэн.

Хүйсийн хувьд оролцогчдын 67.7% нь эрэгтэй, 32.3% нь эмэгтэй байсан бол албан тушаалын ангиллаар авч үзэхэд дэслэгч (28.7%), ахлах дэслэгч (19.6%), ахмад (23.1%), хошууч (18.1%), дэд хурандаа (10.4%) нар зонхилж байв.

Бүс нутгийн хувьд оролцогчдын 41.0% нь төвийн бүс, 17.1% нь ой тайгын бүс, 15.6% нь уулын бүс, 14.8% нь говь цөлийн бүс, хамгийн бага хувь болох 11.5% нь тал хээрийн бүсээс хамрагдсан байна.

Боловсролын түвшний хувьд оролцогчдын 53.8% нь цэргийн дээд сургууль, 46.2% нь бусад төрлийн их, дээд сургууль төгссөн. Гэр бүлийн байдлын хувьд 71.9% нь гэрлэсэн бөгөөд хамт амьдардаг, 13.8% нь гэр бүлтэй ч тусдаа амьдардаг, 7.9% нь гэрлээгүй, 5.0% нь гэрлэлтээ цуцлуулсан, 1.3% нь бэлэвсэн байв.

Эдгээр хүн ам зүйн үзүүлэлтүүд нь судалгаанд оролцогчдын төлөөлөл, олон талт байдлыг харуулж байгаа бөгөөд ажлын орчин, сэтгэл зүй, нийгмийн нөхцөл байдлын хүчин зүйлсийг шинжилгээний түвшинд тусгах боломжийг бүрдүүлсэн болно.

Үр дүн: Судалгаанд ашигласан хоёр хэмжүүрийн дотоод тохирлыг тодорхойлохын тулд Cronbach's Alpha коэффициентыг тооцоолов. Энэ үзүүлэлт нь тухайн асуулга нь тухайн үзүүлэлтийг хэмжихэд найдвартай, дотоод нийцэл нэгэн төрлийн эсэхийг илэрхийлдэг (Field, 2018). Хүснэгт 1-т нийт оноогоор гарсан α утгуудыг харуулав.

Хүснэгт 1. Хэмжүүрийн дотоод нийцлийн үзүүлэлт (Cronbach’s α)

Хэмжүүрийн нэр	Cronbach's α	Асуултын тоо (Items)
CD-RISC-24 (Уян хатан чанар нийт үзүүлэлт)	.976	24

Gallup Q12 (Ажлын байрны сэтгэл ханамж)	.945	12

Дээрх үр дүнгээс харахад хоёр хэмжүүрийн аль аль нь маш өндөр дотоод нийцэлтэй байна. Cronbach's α > .90 байх нь хэмжүүр маш найдвартай, нэгэн төрлийн байдлыг хангаж буйг илтгэнэ (George & Mallery, 2003).

Хилийн цэргийн офицер бүрэлдэхүүний сэтгэл зүйн уян хатан чанар болон ажлын байрны сэтгэл ханамж хоорондын хамаарлыг тодорхойлох зорилгоор Пирсоны корреляцийн шинжилгээ хийсэн.

Хувьсагч	1	2
1. CD-RISC нийт оноо	1	.505**
2. Gallup Q12 дундаж оноо	.505**	1

Хүснэгт 2. Уян хатан чанар, ажлын байрны сэтгэл ханамжийн хоорондын Пирсоны корреляцийн коэффициент (n = 520)

Тайлбар. $p < .01$ (2-tailed).

Уян хатан чанар болон ажлын байрны сэтгэл ханамж тодорхойлох хоёр хэмжүүрийн нийт онооны корреляцийн коэффициент $r = .505$, $p < .001$ байгаа нь эдгээр хоёр хувьсагчийн хооронд дунд зэргийн эерэг хамаарал байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, уя хатан чанар өндөр байх тусам тухайн алба хаагч ажлын байрандаа илүү сэтгэл ханамжтай байх хандлагатай байна. Энэхүү үр дүн нь сэтгэл зүйн уян хатан чанарыг хөгжүүлэх нь ажилтнуудын ажлын сэтгэл ханамжид эергээр нөлөөлж болохыг харуулж байгаа бөгөөд байгууллагын сэтгэл зүйн дэмжлэг, сургалтын хөтөлбөрүүдийн ач холбогдлыг нотолж байна.

Ажлын байрны сэтгэл ханамжийг (Gallup Q12 дундаж оноо) уян хатан чанарын дэд үзүүлэлтүүд (CD-RISC-25) урьдчилан таамаглаж чадах эсэхийг тодорхойлох зорилгоор олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ хийсэн. Шинжилгээнд дараах 7 дэд үзүүлэлтийг хамруулсан: сэтгэлийн хат, даван туулах чадвар, уян хатан байдал, утга учир, өөдрөг үзэл, сэтгэл хөдлөлийн зохицуулалт, өөртөө итгэх итгэл.

Хувьсагч	Стандарчлагдсан β	t	p (Sig.)
(Тогтмол)	–	11.69	.000
Сэтгэлийн хат	.064	0.55	.586

Даван туулах чадвар	.256	2.48	.013
Уян хатан байдал	.122	1.40	.162
Утга учиртай байдал	.097	1.45	.148
Өөдрөг үзэл	–.057	–0.85	.395
Сэтгэл хөдлөлийн зохицуулалт	.097	1.15	.251
Өөртөө итгэх итгэл	–.040	–0.44	.658

Хүснэгт 3. Олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээний дүн (n = 520)

$R^2 = .264$, $F(7, 512) = 26.19$, $p < .001$

Энэхүү регрессийн шинжилгээний үр дүнгээс харахад уян хатан чанарын долоон дэд үзүүлэлт хамтдаа ажлын байрны сэтгэл ханамжийг утга учиртайгаар урьдчилан таамаглаж байна ($R^2 = .264$, $p < .001$). Энэ нь ажлын байрны сэтгэл ханамжийн 26.4%-ийг эдгээр сэтгэл зүйн хүчин зүйлс тайлбарлаж чадсан гэсэн үг юм.

Гэсэн хэдий ч хувь хувьсагчийн түвшинд авч үзвэл зөвхөн "даван туулах чадвар" ($\beta = .256$, $p = .013$) нь сэтгэл ханамжид статистикийн ач холбогдол бүхий эерэг нөлөөтэй болох нь тогтоогдсон. Бусад дэд үзүүлэлтүүдийн нөлөө статистикийн хувьд мэдэгдэхүйц биш байна ($p > .05$).

Уян хатан чанар ба ажлын байрны сэтгэл ханамжийн хоорондын хамаарлын хүч нь хүйсийн бүлгүүдийн хувьд ижил байдаг эсэхийг тодорхойлохын тулд Fisher’s Z test ашиглан хос корреляцийн харьцуулалт хийсэн. Энэхүү шинжилгээ нь тухайн хоёр хувьсагчийн хоорондын хамаарал эрэгтэй, эмэгтэй алба хаагчдын дунд статистикийн хувьд ялгаатай эсэхийг шалгахад чиглэсэн.

Бүлэг	n	*r* (CD-RISC - Q12)	Fisher’s Z	*p* (2-tailed)
Эрэгтэй	352	.560**		
Эмэгтэй	168	.362**		
Харьцуулалт			2.74	.006

Хүснэгт 4. Хүйсийн бүлгээр харьцуулсан уян хатан чанар ба ажлын байрны сэтгэл ханамжийн хамаарал (n = 520)

Тайлбар. $p < .01$

Дээрх үр дүнгээс харахад эрэгтэй офицеруудын дунд уян хатан чанар нь ажлын байрны сэтгэл ханамжтай байхтай илүү хүчтэй хамааралтай байгаа нь илэрч байна. Харин эмэгтэй алба хаагчдын хувьд уг хамаарал харьцангуй сул байсан бөгөөд хоёр бүлгийн хоорондын ялгаа

статистикийн хувьд ач холбогдолтой байна (Хүснэгт 4).

Уян хатан чанар (CD-RISC) ба ажлын байрны сэтгэл ханамж (Gallup Q12)-ийн хоорондын хамаарал нь насны бүлгүүдийн хувьд ялгаатай байдаг эсэхийг тодорхойлохын тулд Fisher's Z test ашиглан хос хосоор нь харьцуулалт хийв. Энэ нь тухайн хоёр хувьсагчийн хоорондын хамаарлын хүч нь насны ялгаагаар өөрчлөгдөж байгаа эсэхийг шалгах зорилготой юм.

Харьцуулалт	r_1 (n_1)	r_2 (n_2)	Fisher's Z	p
28–35 ба 46+	.572 (178)	.175 (20)	1.84	.066
28–35 ба 22–27	.572 (178)	.445 (61)	1.19	.234
36–45 ба 46+	.482 (261)	.175 (20)	1.40	.162

Хүснэгт 5. Насны бүлгийн хооронд уян хатан чанар ба ажлын байрны сэтгэл ханамжийн хамаарал (n = 520)

Тайлбар. $p < .05$ → Хамаарлын ялгаа статистикийн хувьд ач холбогдолтой гэж үзнэ.

Шинжилгээний үр дүнгээс харахад (Хүснэгт 5) насны бүлэг тус бүрд уян хатан чанар ба ажлын сэтгэл ханамж хооронд дунд зэргийн эерэг хамаарал илэрсэн. Хамгийн өндөр хамаарал 28–35 насны бүлэгт (r = .572) ажиглагдсан бол хамгийн бага хамаарал 46-аас дээш насны бүлэгт (r = .175) илэрсэн. Гэсэн хэдий ч Fisher's Z test–ийн үр дүнгээр дээрх ялгаа нь статистикийн хувьд ач холбогдолтой хэмжээнд хүрээгүй ($p > .05$), гэхдээ 28–35 насны бүлэг болон 46-аас дээш насны бүлгийн хооронд хамаарлын ялгаа хязгаарын ач холбогдолтой (Z = 1.84, p = .066) байж болзошгүй байна.

Судалгаанд оролцсон алба хаагчдын хувьд уян хатан чанар өндөр байх тусам ажлын сэтгэл ханамж илүү байх хандлага ажиглагдсан. Энэ хандлага бүх насны бүлэгт илэрсэн ч, 28–35 насныхан хамгийн хүчтэй хамааралтай, 46-аас дээш насныхан хамгийн сул хамааралтай байв. Хэдий ялгаа нь статистикийн хувьд хангалттай өндөр түвшинд хүрээгүй ч, практик талаасаа нас ахих тусам энэ хамаарал суларч болох чиг хандлагыг илэрхийлж байна.

Уян хатан чанар (CD-RISC нийт оноо) болон ажлын байрны сэтгэл ханамж (Gallup Q12 дундаж оноо)-ийн хоорондын хамаарал бүс нутгаар ялгаатай эсэхийг тодруулах зорилгоор **Fisher's Z test** ашиглан хос хосоор нь харьцуулалт хийсэн.

Бүс нутаг	n	r (CD-RISC - Q12)	p
Төвийн бүс	213	.468**	.000
Ой тайгын бүс	89	.591**	.000

Тал хээрийн бүс	60	.574**	.000
Говь цөлийн бүс	77	.416**	.000
Уулын бүс	81	.520**	.000

Хүснэгт 6. Бүс нутгийн бүлгээр харьцуулсан CD-RISC ба Gallup Q12-ийн хамаарал (n = 520)

Тэмдэглэл. $p < .01$ → Хоёр хувьсагчийн хооронд статистикийн хувьд ач холбогдолтой эерэг хамаарал байна.

Харьцуулалт	r_1 (n_1)	r_2 (n_2)	Z-харьцуулалт	p
Ой тайгын бүс ба Говь цөлийн бүс	.591 (89)	.416 (77)	1.34	.180
Тал хээрийн бүс ба Төвийн бүс	.574 (60)	.468 (213)	0.96	.337
Уулын бүс ба Говь цөлийн бүс	.520 (81)	.416 (77)	0.82	.412

Хүснэгт 7. Fisher's Z test – Сонгомол харьцуулалтууд:

Тэмдэглэл. $p > .05$ → Хамаарлын ялгаа статистикийн хувьд ач холбогдолгүй байна.

Бүс нутгийн ангиллаар авч үзэхэд уян хатан чанар ба ажлын байрны сэтгэл ханамжийн хооронд бүх бүсийн хувьд статистикийн хувьд ач холбогдолтой эерэг хамаарал илэрсэн ($p < .01$). Гэсэн хэдий ч Fisher’s Z test-ийн үр дүнгээр дээрх хамаарлын ялгаа нь статистикийн хувьд ач холбогдолтой түвшинд хүрээгүй байна ($p > .05$). Иймд бүс нутаг өөрөө энэ хоёр хүчин зүйлийн хамаарлыг тодорхойлж буй гол нөлөөлөгч биш байж болзошгүй юм.

Гэр бүлийн байдал нь сэтгэл зүйн тэнцвэрт байдал, ажлын сэтгэл ханамжид нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг болох нь судалгаагаар олонтоо нотлогдсон байдаг. Иймд энэхүү судалгаанд оролцогчдын гэр бүлийн байдлын бүлгүүдэд хамаарал ялгаатай илэрч байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор CD-RISC ба Gallup Q12-ийн хооронд корреляцийн шинжилгээ хийж, Fisher’s Z test ашиглан бүлэг хооронд хамаарлын ялгааг тооцоолсон.

Хүснэгт 8. Гэр бүлийн байдлын бүлгээр харьцуулсан CD-RISC ба Gallup Q12-ийн хамаарал (n = 520)

Гэр бүлийн байдал	n	r (CD-RISC - Q12)	p

Гэрлэсэн, хамт амьдардаг	374	.501**	.000
Гэрлэсэн, хол амьдардаг	72	.561**	.000
Гэрлээгүй	41	.478**	.002
Гэрлэлтээ цуцлуулсан	26	.477*	.014
Бэлэвсэн	7	.269	.560

Тайлбар. $p < .01$ Хамаарал статистикийн хувьд маш өндөр ач холбогдолтой, $p < .05$ хамаарал статистикийн хувьд ач холбогдолтой, $p > .05$ хамаарал статистикийн хувьд ач холбогдолгүй.

Гэр бүлийн байдлаар авч үзэхэд хамгийн өндөр хамаарал гэрлэсэн ч хол амьдардаг офицеруудын дунд илэрсэн ($r = .561$), харин хамгийн сул хамаарал бэлэвсэн оролцогчдын дунд илэрсэн ($r = .269$), гэхдээ энэ нь статистикийн хувьд ач холбогдолгүй ($p = .560$) байв.
Зарим бүлгийн хооронд (жишээлбэл, хамт амьдардаг vs. хол амьдардаг гэрлэсэн хүмүүс) хамаарал өсөх хандлага ажиглагдаж байгаа ч Fisher's Z test–ийн үр дүнгээр эдгээр ялгаа нь статистикийн хувьд ач холбогдолтой биш ($p > .05$) байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар хил хамгаалах байгууллагад ажиллаж буй офицеруудын уян хатан чанар болон ажлын байрны сэтгэл ханамжийн хоорондын хамаарал тодорхойлогдсон нь байгууллагын сэтгэл зүйн орчныг оновчтой үнэлэх, хүний нөөцийн бодлогод хувь хүний сэтгэл зүйн хүчин зүйлсийг тусгах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Сөрөн тэсвэрлэх чадвар буюу уян хатан чанар нь хилчин офицеруудын ажилдаа хэр сэтгэл ханамжтай байгаатай эерэг хамааралтай болох нь тогтоогдсон бөгөөд энэ нь ажлын ачаалал, стресс, тусгаарлагдсан нөхцөл байдал зэрэг хүнд сорилттой орчинд ажиллаж буй хүчний байгууллагын алба хаагчдын хувьд уян хатан чанар нь ажил мэргэжилтэйгээ сэтгэлзүйн хувьд дасан зохицох, биечлэн өсөж хөгжих, ажлын бүтээмж өндөртэй байхтай холбоотой чухал үзүүлэлт гэдгийг нотоллоо.

Мөн судалгааны үр дүнгээс харахад уян хатан чанар нь бүх бүлгүүдэд эерэг нөлөөтэй илэрсэн ч, зарим бүлгийн хувьд (жишээлбэл, хүйс, насны ялгаа) энэ хамаарал харьцангуй өөр байгааг харуулж байна. Энэ нь сэтгэл зүйн нөөц, стресс зохицуулах ур чадвар нь хүний биологийн болон нийгмийн нөхцөл байдлаас хамаарч өөр өөр илэрдэг болохыг дэмжинэ.

Түүнчлэн уян хатан чанарын дотоод бүтцээс "даван туулах чадвар" онцгойлон ажлын сэтгэл ханамжид нөлөөлж байгааг анхааран үзэх нь зүйтэй бөгөөд

энэ нь хувь хүний сэтгэлзүйн хамгаалалт, дасан зохицох хандлагыг төлөвшүүлэх чиглэлд хийгдэх сургалт, арга хэмжээний агуулгыг илүү зорилтот, үр нөлөөтэй болгоход чухал нөлөөтэй юм.

Иймд уян хатан чанарыг хөгжүүлэх болон ажлын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, арга зүйг хүчний байгууллагын хэмжээнд төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Санал, зөвлөмж

✓ Уян хатан чанарыг хөгжүүлэх сэтгэл зүйн сургалтыг Хил хамгаалах байгууллагын сэтгэл зүйн дэмжлэгийн хөтөлбөрт системтэйгээр тусгаж, алба хаагч бүрд хүргэх боломжтой модульчлагдсан сургалтын хөтөлбөр боловсруулах шаардлагатай байна. Энэхүү хөтөлбөр нь стресс зохицуулалт, сэтгэл хөдлөлөө таних, сөрөг мэдрэмжийг зохицуулах, зорилгоо хадгалах зэрэг CD-RISC-ийн дэд бүрэлдэхүүнүүд дээр төвлөрөх;

✓ Алба хаагчдын ажлын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд тэдний уян хатан байдалтай холбоотой хувь хүний онцлог (жишээлбэл: сэтгэлийн хат, урам зориг, даван туулах ур чадвар)–ийг харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд суурилан багийн удирдлага, ажлын ачааллыг хуваарилах, дэмжих арга хэлбэрийг өөрчлөх боломжтой;

✓ Судалгаагаар илэрсэнчлэн “даван туулах чадвар” нь сэтгэл ханамжид хамгийн хүчтэй нөлөөлдөг тул энэ чадамжийг тусгайлан хөгжүүлэх арга хэмжээ (стрессийн удирдлага, нөхцөл байдлын дүн шинжилгээ, шийдвэр гаргалт) авах нь бодит үр дүнтэй байх боломжтой;

✓ Сэтгэл зүйн үнэлгээний тогтолцоог жил бүр тогтмол хийдэг болгох нь байгууллагын хэмжээнд уян хатан чанарыг хянах, алба хаагчдын эрсдэлд өртөх байдал, сэтгэл зүйн эрүүл мэндийн төлөвийг эрт илрүүлэх, дэмжлэг үзүүлэх суурь нөхцөл болно.

✓ Цаашид уян хатан чанар болон сэтгэл ханамжийн хамаарлыг гүнзгийрүүлэн судлахдаа завсрын хувьсагч (жишээлбэл: өөртөө итгэх итгэл, сэтгэл хөдлөлийн зохицуулалт, манлайллын хэв маяг)-ийг оруулсан бүтцийн тэгшитгэлийн загвар (SEM) ашиглах нь уян хатан чанар хэрхэн нөлөөлдөг механизмыг илүү нарийн ойлгох боломж олгоно.

Эх сурвалж

Brooks, S. K., & Greenberg, N. (2022). Mental health and wellbeing of border security personnel: Scoping review. *Occupational Medicine*, *72*(9), 636–640. https://doi.org/10.1093/occmed/kqac108

Connor, K. M., & Davidson, J. R. T. (2003). Development of a new resilience scale: The Connor-Davidson Resilience Scale (CD-RISC).

Depression and Anxiety, *18*(2), 76–82. https://doi.org/10.1002/da.10113

Di Fabio, A., & Saklofske, D. H. (2018). The contributions of personality and emotional intelligence to resiliency. *Personality and Individual Differences*, *123*, 140–144. https://doi.org/10.1016/j.paid.2017.11.012

Field, A. (2018). *Discovering statistics using IBM SPSS statistics* (5th edition). SAGE.

George, D., & Mallery, P. (2003). *SPSS for Windows step by step: A simple guide and reference, 11.0 update* (4th ed). Allyn and Bacon.

Hudgins, T. A. (2016). Resilience, job satisfaction and anticipated turnover in nurse leaders. *Journal of Nursing Management*, *24*(1), E62–E69. https://doi.org/10.1111/jonm.12289

Jafri, Md. H., Dem, C., & Choden, S. (2016). Emotional Intelligence and Employee Creativity: Moderating Role of Proactive Personality and Organizational Climate. *Business Perspectives and Research*, *4*(1), 54–66. https://doi.org/10.1177/2278533715605435

Judge, T. A., Thoresen, C. J., Bono, J. E., & Patton, G. K. (2001). The job satisfaction–job performance relationship: A qualitative and quantitative review. *Psychological Bulletin*, *127*(3), 376–407. https://doi.org/10.1037/0033-2909.127.3.376

Kašpárková, L., Vaculík, M., Procházka, J., & Schaufeli, W. B. (2018a). Why resilient workers perform better: The roles of job satisfaction and work engagement. *Journal of Workplace Behavioral Health*, *33*(1), 43–62. https://doi.org/10.1080/15555240.2018.1441719

Kuo, C.-C., Ye, Y.-C., Chen, M.-Y., & Chen, L. H. (2019). Proactive personality enhances change in employees' job satisfaction: The moderating role of psychological safety. *Australian Journal of Management*, *44*(3), 482–494. https://doi.org/10.1177/0312896218818225

Meredith, L. S., United States, & Rand Corporation (Eds.). (2011). *Promoting psychological resilience in the U.S. military*. Rand Corporation.

Valor-Segura, I., Navarro-Carrillo, G., Extremera, N., Lozano, L. M., García-Guiu, C., Roldán-Bravo, M. I., & Ruiz-Moreno, A. (2020). Predicting Job Satisfaction in Military Organizations: Unpacking the Relationship

Between Emotional Intelligence, Teamwork Communication, and Job Attitudes in Spanish Military Cadets. *Frontiers in Psychology*, *11*, 875. https://doi.org/10.3389/fpsyg.2020.00875

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД НИСГЭГЧГҮЙ НИСЭХ ХЭРЭГСЭЛ (ДРОН)-ИЙГ АШИГЛАХ, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА



Н.Батзориг
Хилийн цэргийн хил судлалын хүрээлэнгийн Инновац судлалын төвийн ахлах судлаач, дэд хурандаа

Товч агуулга: Улсын хил хамгаалалтад шинэ үеийн дэвшилтэт техник, технологи, нисэх онгоц, нисдэг тэрэг, дохиолол, хяналт, нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ийг өргөн ашиглаж, хил хамгаалалтыг зохион байгуулснаар хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, хилийн эрэл, тусгай ажиллагааг богино хугацаанд үр дүнтэй явуулах, хилийн зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлт нэмэгдүүлэх, зардал хэмнэх боломж бүрдэнэ.

Түлхүүр үгс: нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон),

Удиртгал

Эрх зүйн тогтолцоо

Улсын хил хамгаалалтыг хилийн цэргийн анги, салбар, харуул, манааны хүч хэрэгслээр ой тайга, уул, тал хээр, говь цөлийн хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллага, ард иргэдийн оролцоотой, хил залгаа улсын хилийн албатай хамтран зохион байгуулж байна. Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Монгол

Улсын хилийн тухай хуулийг хэрэгжүүлэх, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах зорилгоор шинжлэх ухаан, технологид тулгуурласан, бүс нутгийн онцлогт зохицсон улсын хил хамгаалалтыг боловсронгуй тогтолцоог бүрдүүлэх, улсын хил дээр алба хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Улсын хил хамгаалалтыг хилийн нийт урт 8252,6 км (үүнээс 901 км усан хил)-т хил хамгаалах байгууллага өөрийн хүч хэрэгслээр бүсчилсэн байдлаар хилийн 14 аймаг, 74 сумын нутаг дэвсгэрт, аймаг орон нутгийн удирдлага, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллага, ард иргэдийн оролцоотой, хил залгаа улсын хилийн албатай хамтран зохион байгуулж байна.

Хилийн цэргийн анги, салбар, хилийн манаа, бүлэг, харуулаас хилийн хэсэгтээ зөвхөн хүний хүчээр, агт уналга, автомашин, мотоцикл, инженерийн саадын байгууламжийг ашиглах байдлаар хамгаалж байсан уламжлалт арга хэлбэрийг хүний хүчин зүйлийн оролцоог багасгах, техник технологийг нэвтрүүлэх замаар өөрчлөх зайлшгүй шаардлагыг харгалзан үзэж энэхүү судалгаа, тооцоог боловсруулсан болно.

Үндсэн хэсэг

Улсын хил хамгаалалтад нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон) ашиглах эрх зүйн үндэслэл

Улсын хилийн халдашгүй дархан байдал, хилийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий Хил хамгаалах байгууллага нь дараах эрх зүйн зохицуулалтын хүрээнд нисгэгчгүй нисэх хэрэгсэл ашиглана. Үүнд:

-Монгол Улсын хилийн тухай хуулийн 31.2-д “Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ”;

-Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр бүлгийн 4 дэх хэсэг “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм”-ийн 4.4.1.6-д **“**Хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлж, мэргэшсэн хилчин, технологид суурилсан хил хамгаалах албыг

бэхжүүлэн, зэвсэглэл, инженер, дохиолол хамгаалалт, радио релейн болон хяналтын систем, цэргийн холбоо, техник, нисгэгчгүй нисэх хэрэгсэл, тусгай хэрэгслээр бүрэн хангаж, хилийн цэргийн нисэх анги байгуулан, нисдэг тэрэг, нисэх онгоц ашиглах замаар хилийн аюулгүй байдлыг хангаж, хилийн дэглэмийн гэрээг хэрэгжүүлнэ";

-Хилийн цэргийн нисэх ангийн бүсийн нэгжийг байгуулан, нисэх онгоц, нисдэг тэргийг хил хамгаалалт, хилийн болон хил орчмын дэглэмийн биелэлтийг сахиулах, хил орчмын нутаг дэвсгэрт харилцан ажиллагаатай байгууллагуудтай хамтран агаарын тандалт судалгаа, эргүүл хийх;

-Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдыг сургаж мэргэшүүлэх, дадлагажуулах, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх, сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх, цар хүрээг өргөжүүлэх;

-Хилийн хэсгийг инженер, радио релейн болон дохиолол хяналтын нэгдсэн систем ээр төхөөрөмжилж, хил хамгаалалтын үр дүнг дээшлүүлэх;

-Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 110 дугаар тогтоол "Бүсчилсэн хил хамгаалалт хөтөлбөр"-ийн 4.2.2. "... өндөр хүчин чадлын дуран харааны болон хяналтын орчин үеийн хэрэгсэл (дулааны мэдрэгч бүхий дохиоллын хэрэгсэл, бага оврын нисэх төхөөрөмж гэх мэт) ашиглан тогтвортой хяналт явуулах арга хэмжээг хамгаалалтын үндсэн арга болгоно", мөн хөтөлбөрийн 4.5.4. Хилийн болон хил орчмын дэглэмд хяналт тавих, газар орны үзлэг шалгалт хийхэд нисэх хэрэгсэл ашиглах чиглэл баримтална гэж тус тус тодорхойлсон.

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлага

Улсын хилийг тогтвортой хяналтад байлгаж, хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээг хэрэгжүүлэх, гарч болзошгүй хилийн зөрчлөөс урьдчилсан сэргийлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, хилийн зөрчлийг цаг алдалгүй илрүүлэх, бүс нутгийн онцлогт нийцүүлсэн хил хамгаалалтын арга хэлбэр, шинэ техник технологийг ашиглаж, хил хамгаалалтыг зохион байгуулах.



Улсын хил дамнасан галт зэвсэг, мансууруулах бодисын хууль бус наймаа, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, хил зөрчихөөс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг нэгдмэл, цогц байдлаар шийдэх.

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ийг хил хамгаалалтын бусад хүч хэрэгсэлтэй хослуулан өргөнөөр ашиглаж, хилийн хэсгийг бүхэлд нь буюу тодорхой чиглэлийг тогтвортой хяналтад байлгах.

Улсын хил хамгаалалтад нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ийг хиймэл оюун, инженер-техник, тоон радиорелейн, хилийн дохиоллын болон камерын систем (ХДС-90)-тэй хослуулан ашиглах.

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ийг хиймэл оюунтай хослуулан ашигласнаар дараах үр дүнд хүрч болно. Үүнд:


-Ажлын бүтээмжийг нэмэгдүүлнэ (хүний хүчин зүйлээс шалтгаалах алдааг багасгаж, илүү хурдан шийдвэр гаргах боломжийг олгоно)

-Аюулгүй байдлыг хангана (боомтоор болон боомт бус газраар хил зөрчихийг завдагсдын үйлдлийг AI системүүд өндөр нарийвчлалтайгаар илрүүлнэ)

-Зардал бууруулна (хүний нөөц, эрчим хүч, тоног төхөөрөмжийн ашиглалтыг илүү үр дүнтэй болгоно)

-Хилийн хэсэг тодорхой объектыг тасралтгүй хяналттай байлгана (AI системүүд 24/7 буюу тасралтгүй ажиллах боломжтой)

Хиймэл оюун ухаан нь хил хамгаалалтын роботууд болон нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ийг удирдах, хил орчмын нутаг дэвсгэрт хяналт тавих, мөн сэжигтэй үйлдэл, хөдөлгөөнийг илрүүлэхэд ашиглагддаг.



Хилийн хэсэгт тогтвортой хяналт тавих зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон), AI алгоритм ашиглан хүний хөдөлгөөн, хөдөлгөөнт объектуудыг илрүүлж, чиглүүлэх, зарим тохиолдолд хууль бус үйлдлийг илрүүлж, ухаалаг программ хангамжийн тусламжтайгаар хариу арга хэмжээ авах, саатуулах зэрэг үүргийг гүйцэтгэх боломжтой.

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ийг автономит (өөрөө ажиллах) горимоор ажиллуулан ашиглаж, хилийн тодорхой хэсэгт агаарын хяналтыг хийж, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, мэдээлэл цуглуулах, хууль бус үйлдлийг илрүүлэх аюулгүй байдлыг хангах боломжтой.





Давуу тал:


-Алсын зайнаас болон тасралтгүй хяналт хийх (тогтоосон өндөрт нисгэж, агаарын хяналт, тандалт хийх, дүрс мэдээлэл дамжуулах, хадгалах, баримтжуулах)

-Хүний оролцоог багасгах (газар орны аюултай, хөдөлгөөн үйлдэхэд хүндрэлтэй хэсэгт хүний оролцоогүйгээр ажиглалт, хяналт хийх)

-Шуурхай, маневрлаг ажиллагаа (хурдан байрлалаа өөрчлөх, газрын гадарга, релефьд зохицуулан нисэх)

сайжруулах, мэдээллээ хамгаалах арга хэмжээ авах нь чухал юм.

Олон улсын туршлага-сургамж



Сул тал:

-Цаг агаарын нөлөөлөл (хүчтэй салхи, шуурга, бороо, манан зэрэгт тогтвортой ажиллахад хүндрэлтэй)

-Нислэгийн хязгаарлагдмал хугацаа (батарейгаар ажиллах нислэгийн хугацаа 15-30 минут)

-Нууцлал аюулгүй байдал, дроны саатуулгад өртөх эрсдэл (камерын бичлэг мэдээллээ алдах, гаднын саатуулгад өртөх)

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ийг усан хил хамгаалалтад ашиглахад нислэгийн хугацаа, алслалт, телекамер, нэмэлт тоноглолын хүчин чадалтай уялдуулан хиймэл оюуны хөгжүүлэлт хийх, батарейны хүчин чадлыг нэмэгдүүлэх, нислэгийн тогтвортой байдлыг

Дэлхий дахинаа сүүлийн жилүүдэд нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дроныг цэрэг, дайны ажиллагаанд түлхүү ашиглаж байгаагийн зэрэгцээ кино зураг авалт, объектын харуул хамгаалалт, хөдөө аж ахуй, гэр бүлийн хэрэгцээнд өргөнөөр ашиглах явдал жил ирэх тусам нэмэгдэж байна.

Дроныг анх Их Британийн хаант улсын “Sopwith Sparrow” компанийн зүгээс 1917 онд туршилт хийж, улмаар 1935 онд албан ёсоор дроныг нисгэгчгүй нисэх хэрэгсэл гэж бүртгэгдсэн байдаг. Улмаар 1991 онд Японы “KEYENCE CORPORATION” эгч дээшээ хөөрдөг дрон зохион бүтээж байсан бол 2012 онд “Google X” компани нь “WING”

төсөл хэрэгжүүлснээр ачаа тээврийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн байна. Австрали улсад 2013 онд байгуулсан “Flirtey” компани нь мөн л ачаа тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд өдгөө төр, хувийн хэвшлийн бүхий л салбарт дроны хэрэглээ нэмэгдсээр байна.

Дроныг цэргийн болон иргэний гэсэн үндсэн 2 хэсэгт ангилдаг. Сүүлийн жилүүдэд дэлхийн өнцөг буланд үүсэж байгаа дайнд дроныг өргөнөөр ашиглах болсон бөгөөд цэргийн албан хаагч бүр үүнийг ашиглаж чаддаг болсон.

Дрон үйлдвэрлэлтээрээ өнөөдөр дэлхийд Турк, Иран, Умард Солонгос, БНХАУ зэрэг улсууд тэргүүлдэг бөгөөд 2019-2023 оны хооронд БНХАУ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалттай 1 сая ширхэг дрон үйлдвэрлэсэн бол 2028 он гэхэд 3,5 сая ширхгийг үйлдвэрлэхээр төлөвлөсөн байдаг. БНХАУ нь 2023 онд 120 тэрбум юань буюу **16,5 тэрбум ам.доллартой тэнцэхүйц хэмжээний дрон үйлдвэрлэн борлуулсан бөгөөд** 2025 он гэхэд 200 тэрбум юань буюу **27,7 тэрбум ам.долларт хүргэхээр төлөвлөжээ.** Европын Холбооны улсуудын дунд ХБНГУ жилд 415 мянган дрон үйлдвэрлэсэн байдаг.

БНХАУ-ын “DJI” компани нь дэлхийд иргэний зориулалттай дроны 70 хувийг дангаараа үйлдвэрлэдэг бол АНУ-ын арми 2001 оноос эхлэн цохилт өгөх зориулалттай дрон ашиглаж эхэлсэн бөгөөд “MQ-9 Reaper”, “MQ-1 Avenger” болон “MQ-1 Grey Eagle” загваруудын дроныг, Туркийн “Bayraktar TB2” загварын дроныг Их Британийн арми өргөнөөр ашиглаж байна. Туркийн “Bayraktar TB2” загварын дроныг Украин, Азербайжан, Буркина-Фасо, Жибути, Этиоп, Киргиз, Мали, Марокко, Нигер, Пакистан, Польш, Катар, Сомали, Того, Тунис, Саудын Араб, АНЭУ, Туркмен зэрэг улсууд байлдааны зориулалттай дроныг зэвсэглэлдээ ашиглаж байна.

БНХАУ-ын байлдааны зориулалттай CH-3, CH-4, Wing-Loong, CH-92 загварын дроныг Алжир, Египет, Индонези, Ирак, Иордан Казахстан, Нигери, Сербийн арми ашиглаж байна.



АНУ-ын арми “AAI RQ-2 Pioneer” болон “AeroVironment FQM-151 Pointer” загварын дроныг анх удаа 1991 онд Персийн буланд явагдсан дайнд туршсан байдаг.

Сүүлийн жилүүдэд ОХУ, Украин улсын арми дроныг дайнд өргөнөөр ашиглаж байна. Мэргэжилтнүүдийн үзэж буйгаар дроны сул тал нь GPS өгөгдлийг онцолж байна. Учир нь GPS өгөгдлийг саармагжуулсан тохиолдолд дроны чиглэлийг өөрчилж, хариу цохилтод орж байгааг асуудлын шийдлийг олоогүй байна.

Тусгай томилгоот бүлгүүдэд ашиглагдаж байгаа хамгийн жижиг дроныг Норвеги улсад 2007 онд байгуулагдсан “Prox Dynamics” компани зохион бүтээсэн байна. Энэхүү дрон нь 18 грамм жинтэй бөгөөд иж бүрдлээрээ 1 кг 300 грамм жинтэй ажээ.



АНУ-ын тусгай бүлэгт “Black Hornet” загварын дроныг ашиглаж байна. Энэхүү дроны техник үзүүлэлт нь:

- Жин-32 грамм,
- Урт-10 сантиметр,
- Агаарт байх хугацаа-25 минут,
- Туулах орон зай-1,6 километр,
- Нислэг үйлдэх өндөр-10-30 метр,
- Хурд-20 км/ц,
- Ажиллах горим -10 +43С





Их Британи улс дроноос хамгаалах системийг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдол өгдөг. Тус улс нь 2016 оны 9 дүгээр сард "UAV Defender" хэмээх шинэ төрлийн дроны эсрэг төхөөрөмж бүтээж, дроны эсрэг хамгаалалтын системдээ "Tinupi E1000MP" зөөврийн саатуулагч, "Drone Tracker"-ийн хамтарсан хэрэглээ болон "Net Gun X1" нь террорист үйл ажиллагаа, халдлага, эсэргүүцлийн жагсаал, дроны зохисгүй хэрэглэснээс үүдэлтэй аюултай хууль бус барааг тээвэрлэхэд хариу арга хэмжээг үр дүнтэй сайжруулсан байна.

ОХУ-ын арми дроны эсрэг төрөл бүрийн техник хэрэгслийн хөгжлийг аажмаар хурдасгаж байна. ОХУ-ын Батлан хамгаалах яамны вэб сайтад Оросын армид дрон тэдгээрийг хөгжүүлэх салбарт 2020 оноос хойш цэргийн төсвөөсөө ихээхэн хувийг дрон, дроноос хамгаалах технологийн судалгаа, хөгжүүлэлтийг бэхжүүлэхэд зарцуулагдаж байна.

Үүний ололт амжилтад голчлон радио электрон төхөөрөмжийг устгаж, дроны байршлыг тогтоох боломжгүй болгодог хэт өндөр давтамжийн богино долгионы их буу, тагнуулын командын машин, мөрөнд суурилуулсан нисгэгчгүй нисэх төхөөрөмж SkyWall100" зэрэг багтдаг. Уламжлалт цэргийн гүрний хувьд ОХУ өөрийн цэргийн гүрний статустай тэнцэх хэмжээний нисгэгчгүй нисэх хэрэгслээс хамгаалах чадавхыг эрэлхийлж, таслан зогсоох хүчин чадлаа цаашид бэхжүүлэхийн тулд нисгэгчгүй онгоцноос хамгаалах тоног төхөөрөмжийн хөгжлийг эрчимжүүлж эхэлсэн байна.

БНХАУ-ын Жухай хотод олон улсын нисэх, сансар судлалын 14 дэх удаагийн яармаг худалдаа 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулагдаж энэ үеэр Хятадын сансар судлалын шинжлэх ухаан, аж үйлдвэрийн нисгэгчгүй нисэх хэрэгслээс хамгаалах хэрэгслийн төрөл загваруудаа энэхүү агаарын шоуны үеэр анхны үзүүлбэрүүдээ хийжээ. Дээрх хэрэгслүүд нь "Илрүүлэх, хөндлөнгөөс оролцох, хянах, довтлох, үнэлэх" систем нь байлдааны чадвараараа олны

анхаарлыг татсан. Нисгэгчгүй нисэх хэрэгслүүд одоогийн болон ирээдүйн тулааны талбарт улам бүр чухал үүрэг гүйцэтгэж тодорхой болсон. Харж чадахгүй (илрүүлэхэд хэцүү), зогсоож чадахгүй (жижиг бай), байлдаж чадахгүй (өртөг багатай) зэрэг асуудлууд нь уламжлалт агаарын довтолгооноос хамгаалахад сорилт болж байна.

Улсын хил хамгаалалтад дрон ашиглаж буй байдал

АНУ-ын Гааль, хилийн алба улсын хил хамгаалалтад Аризон мужийн Туксон хот дахь цэргийн баазад угсарсан “Predator B”, Израил “Heron” болон “Hermes”, БНХАУ “CATIC” корпорацын зохион бүтээсэн бага оврын “ASN-15” болон том оврын “ASN-209”, Европын Холбооны хэмжээнд “Patroller” болон “Reaper” загварын дронуудыг ашиглаж байна.


БНХАУ нь Австри улсын “Schiebel” компанитай хамтран “Camcopter S-100” дрон үйлдвэрлэж, цаашид “V-750 загварын дроныг усан хил хамгаалалтад ашиглахаар төлөвлөж байна.

Өмнөд Америкийн орнууд улсын хил хамгаалалтад Израилын үйлдвэрлэсэн “Hermes 450” болон “Skilark” загварын дроныг уулархаг болон ой тайгын бүсүүдэд ашиглаж байна.

Дроныг зөвхөн ойрын зайд ихэвчлэн ашигладаг бөгөөд улс, орнууд улсын хил хамгаалалтад нисгэгчгүй нисэх хэрэгслийг түлхүү ашигладаг. Дрон нь гол төлөв 4 ба түүнээс дээш тооны сэнсний хүчээр нислэг үйлддэг, мөн цаг агаарын тааламжгүй нөхцөлд нислэг үйлдэх боломж нь хязгаарлагдмал гэж мэргэжилтнүүд үзэж байна.

Гадаадын улс, орнууд нисгэгчгүй нисэх хэрэгслийг улсын хил хамгаалалт, объектын харуул хамгаалалт, өндөр хүчдэлийн шугамын гэмтлийг эрж хайх зэрэг байдлаар ашиглаж байна.

Сүүлийн жилүүдэд усны дрон гэх ойлголт гарч ирсэн бөгөөд энэхүү дрон нь усан дээрх (Power Vision Power Dolphin Wizard) болон усны гүнд дэх объектыг олох, устгах зориулалттай ажээ.



ОХУ-ын ХАБА-ны Хилийн алба өөрийн улсдаа үйлдвэрлэдэг

“Элерон” үйлдвэрийн дроныг улсын хил хамгаалалтад ашиглаж байна.

Зэвсэглэл техникийн хангалтад нэвтрүүлэх боломж, ач холбогдол

Алсын хараа-2050 стратегийн баримт бичгийн 7.2 зорилтод 2020-2030 онд бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлж, цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, 2031-2040 онд мэргэшсэн хилчинд суурилсан, технологжсон хил хамгаалах албыг бэхжүүлэх хэмээн тусгагдсан.

Улсын хил хамгаалалтад нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашигласнаар:

4.1.Нисгэгчгүй нисэх хэрэгслийг улсын хил хамгаалалтад ашигласнаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичигт дурдсан зорилго, зорилтыг хангах;

4.2.Агаар-газрын камерын хяналтыг сансрын холбооны систем ашиглан Хилийн цэргийн штабт шуурхай дамжуулж, удирдлагыг найдвартай,бодит цагийн байдлын мэдээллээр шуурхай хангах боломжтой болно;

4.3.Газар оронд үзлэг хийх, хүрэхэд хүндрэлтэй хэсэгт хилийн болон хил орчмын дэглэмийн биелэлтийг сахиулах;



4.4.Нислэгийн үед илэрсэн цагийн байдал, түүний солбицол, байрлалын талаарх мэдээллийг хөдөлгөөнт удирдлагын байранд шуурхай дамжуулах;

4.5.Үүрэг гүйцэтгэх ажиллагааны бодлогыг орон зайн мэдээллийн arcGIS программ дээр боловсруулан агаарын зураглалын мэдээллийг байр зүйн зурагтай

холболт хийн мэдээллийн сан бүрдүүлэх;

4.6.“Улсын хил хамгаалахад дэмжлэг үзүүлэх, агаарын хилийн халдашгүй дархан байдалд хяналт тавих”, “гамшгийн аюулаас хүн ам, эд юмсыг авран хамгаалах болон тогтоосон хорио, цээрийн дэглэмийг сахиулахад туслах”, “хүмүүнлэгийн үйл ажиллагаанд туслалцаа, дэмжлэг үзүүлэх” зэрэг үүргүүдийг гүйцэтгэхэд шинэ технологи, үр дүнтэй, зардал багатай арга, хэрэгслээр явуулах;

4.7.Нисгэгчгүй нисэх хэрэгсэл нь өдрийн цагт өндрөөс цасан зурвас дээр гарсан хүн, малын ул мөрийг илрүүлэх, шөнийн нөхцөлд дулаан мэдрэгч камерын хяналтаар 5 хүртэл км-т байгаа хүн, амьтан, бог, бод малыг ялган таних боломжтой болно;

4.8.Хилийн цэргийн анги, салбарын хариуцсан хэсэг, хилийн манаа бүлгийн хамгаалж буй чиглэлийг нам өндрөөс хянах, шалгах, хилийн эрэл, тусгай ажиллагааг богино хугацаанд үр дүнтэй явуулах, хилийн боомт, хилийн зурваст үйл ажиллагаа эрхлэх буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хянах, баримтжуулахад хүн хүч, цаг хугацааг хэмнэх;

4.9.Хамгийн бага өртөгтэй ачаа тээвэрлэлт хийх, Монголын зам тээврийн харилцаан дахь дэд бүтцийн хоцронгуй байдлыг технологийн дэвшилтэт энгийн аргаар нөхөх. Энэ нь нисгэгчгүй нисэх хэрэгслийн хурдацтай хөгжлийн хүрээнд яаралтай тусламж, байгалийн гамшиг, очиход хүндрэлтэй газар оронд хүн болон эд зүйлсийг зөөвөрлөх шаардлага тулгарсан үед тээвэрлэлтийг шийдэх боломжтой юм;

4.10.Цаг агаарын ямар ч нөхцөлд бодит фото, видео дүрсийг шууд дамжуулж, орон зайн тандан судалгаа, агаарын тагнуулын үүргийг оператив, тактикийн түвшинд гүйцэтгэх хамгийн үр дүнтэй, зардал багатай хэрэгсэл болох юм.



Улсын хил хамгаалалтад ашиглагдаж буй байдал, үр дүн

Монгол Улсын 8252,658 км хилийн 3892,7 км буюу 47.2 хувьд нь хилийн цэргийн анги, салбарууд нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон) ашиглан улсын хил хамгаалалтыг зохион байгуулж байна.

Улсын хил хамгаалалтад нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ийг ашиглаж, хил хамгаалалтыг зохион байгуулснаар тухайн хилийн хэсгийн хил хамгаалалтын нягтрал 70 хүртэл хувь нэмэгдэж, хилчдийн албаны ачаалал 50 хувь багасаж, хариуцсан хилийн хэсгийг агаарын хяналтад бүрэн хамруулж чадсан ололттой байна.Үүнд:

5.1. Хил орчмын нутаг дэвсгэрт байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас төөрсөн 5 удаагийн 8 иргэнийг эрэн хайх, аврах ажиллагаанд нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон) ашиглан илрүүлж, амь насыг аварсан.

5.2. Сүүлийн 2 жилд хилийн зөрчлийн 23.8, хилийн дэглэмийн зөрчлийн 16.1, хил орчмын дэглэмийн зөрчлийн 6.2 хувийг нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон) ашиглан илрүүлж, хуулийн дагуу шийдвэрлэсэн;

5.3.Нисгэгчгүй нисэх хэрэгсэл (ДРОН B-10, F-350)-ийн сургалтад 2024 онд 34 алба хаагчийг хамруулаад байна;

5.4. Стратегийн команд штабын “Сөргө 2024” сургуулиар өгөгдсөн цагийн байдал болох хил орчмын нутаг дэвсгэрт гарсан хилийн дэглэм зөрчигчдийн үйлдлийг газар дээрээс нь шууд дамжуулалт хийх, дэглэм зөрчигчдийг саатуулах үйл ажиллагаанд нисгэгчгүй нисэх хэрэгсэл (B-10 болон Матриц-300 загвар)-ийг ашигласан;

5.5. Улсын хил хамгаалалтад нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон) ашигласнаар алба хаагчдын амралт ачаалал тэнцвэржиж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад явган болон морин уналгатай хилийн манаа тоо **40,** хилчдийн албаны ачаалал **43.0 хувь** тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Дүгнэлт

Хилийн аюулгүй байдлыг хангах, улсын хил хамгаалах үйл ажиллагаанд нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашигласнаар улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, улсын хилийн хүрэхэд хүндрэлтэй, алслагдсан хэсгийг байнгын хяналтад авах, боломжийг нэмэгдүүлэх бүрэн боломжтой гэж дүгнэж байна.

Мөн технологийн дэвшлээр шинэ тутам хөгжиж буй дроныг ахуй амьдралдаа хэрэглэхээс гадна түүнийг ашиглан халдлага үйлдэх, нийтийн аюулгүй байдалд заналхийлэх явдал гарч буй тул дроны хэрэглээг зохистой дэмжихийн зэрэгцээ аюулгүй байдлын цогц арга хэмжээ авах шаардлага тулгарч байна.

Монгол улсын хувьд өргөн уудам газар нутагтай тул үндэсний хэмжээний дроноос хамгаалах системийг байгуулах нь цаг хугацаа, хөрөнгө их зарцуулах тул нэн тэргүүнд хилийн хамгаалалт, улсын онц чухал объект, дэд бүтэц, төрийн тусгай хамгаалалтын объект, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явагдаж буй газруудад дроноос хамгаалах тогтолцоог бүрдүүлэх нь цаашид гарч болзошгүй эрсдэл,

түүнээс гарах хохирлыг бууруулахад ихээхэн ач холбогдолтой гэж үзнэ.



Санал:

Монгол Улсын хэмжээнд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд нисгэгчгүй нисэх хэрэгсэл /дрон/ ашиглах, хяналт тавих эрх зүйн үндсийг бүрдүүлэх.

Улсын хил хамгаалалтад орчин үеийн дэвшилтэд программ хангамж, техник, технологийг албанд нэвтрүүлж, нисгэгчгүй нисэх хэрэгсэл зохион бүтээх, үйлдвэрлэх, турших, ашиглах, үндэсний технологийн компани, инженерүүдийн үйл ажиллагааг дэмжин, өөрийн үндэсний нисгэгчгүй нисэх хэрэгсэл бүхий дохиолол хяналтын системүүдийг хөгжүүлж, улам боловсронгуй болгох.

Эх сурвалж:

Нэг. Хууль, эрх зүйн баримт бичиг:

1.Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2.Монгол Улсын Хилийн тухай хууль. 2016 он.
3.Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2002 он
4.Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, УБ, 2002
5.”Хилчин” сэтгүүлүүд УБ, 2021, 2022, 2023,2024 он
6.Х.Дамдинсүрэн "Цахим удирдлага илтгэл, УБ, 2012
7.Ц.Ганболд. Улсын хил хамгаалалтад нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ийг ашиглах нь. Хил судлал сэтгүүл. №1. 2021.
8. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
-DeepSeek application
-https://img.datawrapper.de/1TYhR/full.png
-https://www.zuv.mn/ page/ newsmore/5815

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ШИНЭ АВТОМАШИНУУДЫН АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АСУУДАЛ БА ШИЙДЭЛ

Э.Сандагжав
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн цэргийн хэргийн тэнхимийн ахлах багш, хошууч

Товч агуулга: Энэхүү судалгааны ажил нь хил хамгаалах байгууллагын шинэ автомашинуудын ашиглалтыг сайжруулахад тулгарч буй асуудлуудыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх арга замуудыг судалсан. Шинээр нийлүүлсэн автомашинуудын ашиглалт, засвар үйлчилгээний үйл явцад тусгай зориулалтын засварын төвүүдийн хомсдол, мэргэжлийн засварчдын дутагдал, сэлбэгийн өндөр өртөг, жолооч нарын ур чадварын дутагдал зэрэг олон хүндрэлүүд бий. Судалгааны явцад техникийн хангалт (*Цаашид ТХ гэнэ.*)-ын зохион байгуулалтын дутагдал, шатахууны чанар, засвар үйлчилгээний тогтмол хяналтгүй байдал, хүндрэлүүдийг олж илрүүлсэн. Үүний үндсэн дээр засвар, ашиглалтын системийг сайжруулах, хүний нөөцийн бэлтгэлийг нэмэгдүүлэх, материаллаг хангамжийг тогтвортой болгох саналуудыг дэвшүүлсэн. Шийдлийн модны аргачлалаар шийдлүүдийг боловсруулж, байлдааны бэлэн байдлыг сайжруулах зорилгоор эдгээр асуудлыг шийдвэрлэх санал боловсруулсан.

Түлхүүр үгс: Автомашин, ашиглалт, засвар үйлчилгээ, хангалт, жолоочийн ур чадвар, шатахуун, сэлбэг хэрэгсэл, материаллаг хангамж, бэлэн байдал, хүний нөөц

Удиртгал

Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд техник, технологийн шинэчлэл хийх нь орчин үеийн хилийн аюулгүй байдлыг хангах, оперативын чадавхыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Энэхүү зорилтын хүрээнд шинэ автомашинуудыг хил хамгаалах нэгжүүдэд нийлүүлсэн боловч тэдгээрийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбоотой хэд хэдэн хүндрэлтэй асуудал үүсэж байна. Үүнд, тусгай зориулалтын засварын төвүүдийн дутмаг байдал, мэргэжлийн засварчдын хангалтгүй байдал, сэлбэг хэрэгслийн өндөр өртөг, жолооч нарын ур чадварын хангалтгүй түвшин зэрэг асуудлууд багтаж байна.

Техник автомашинуудын эвдрэл гэмтлийг цаг тухайд нь засварлах боломжгүй байдал нь хилийн салбарын албаны бэлэн байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгож байна. Ялангуяа, жолооч нарын ур

чадвар дутмаг байдал, шатахууны зохисгүй хадгалалт нь эвдрэлийг улам бүр нэмэгдүүлж, улмаар албаны тасралтгүй ажиллагааг алдагдуулах магадлалтай. Тухайлбал, хил хамгаалах салбарууд шатахууныг зориулалтын шүүлтүүртэй түгээгүүрээс биш, зөөврийн саванд хийж хадгалах нь шатахууны бохирдлыг нэмэгдүүлж, улмаар шатахууны насосны эвдрэлд хүргэж байна. Иймд энэхүү судалгааны ажлаар хил хамгаалах байгууллагын шинэ автомашинуудын ашиглалтад тулгарч буй дээрх асуудлуудыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх боломжит арга замуудыг судалж, санал дүгнэлт гаргах зорилготой. Судалгааны арга зүй нь харилцан ярилцах, асуудлын модны задлан шинжлэх арга болон шийдлийн модны аргыг ашиглах болно. Эдгээр аргачлалууд нь асуудлын үндсэн шалтгааныг тодорхойлж, хамгийн үр дүнтэй шийдлүүдийг боловсруулах боломжийг бүрдүүлнэ. Судалгааны үр дүнд хил хамгаалах байгууллагын автомашины ашиглалтыг сайжруулах, жолооч нарын ур чадварыг нэмэгдүүлэх, сэлбэг хэрэгслийн хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр бодитой санал, зөвлөмж боловсруулах болно.

Үндсэн хэсэг

Техникийн хангалтын зохион байгуулалт[1]

Тус хангалт нь анги, салбаруудыг байлдааны болон бусад зориулалтын техник хэрэгслээр нөхөн хангах, татан авах, ашиглах, хадгалах, хамгаалах, эзэмшилтийг зохион байгуулах үйл ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагааг ХХЕГ, хилийн цэргийн штаб, ар тал хангалтын газар хамтран хэрэгжүүлдэг. Тус хангалтын төлөвлөгөө нь улсын төвлөрсөн төсөвт тусгагдан батлагддаг бөгөөд жил бүрийн тодорхой төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдана.

Зорилго

Дээрх хангалтын гол зорилго нь анги, салбаруудын өдөр тутмын үйл ажиллагаа болон байлдааны байнгын бэлэн байдлыг хангахад чиглэгддэг.

Хангалтын үндсэн бүрэлдэхүүн хэсэг:

-Анги, салбарыг байлдааны болон бусад төрлийн техникээр хангах, нөхөн хангах;

-Бүх төрлийн засвар, үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх;

-Хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах;

-Эзэмшилтийг үр дүнтэй хэрэгжүүлэх;

[1] *Лхагва. Б., 2005 он., Хилийн цэргийн ар тал хангалтын зарим асуудал*

Ганбаатар. Д., Сүндэв. П., 2005 он., Хилийн заставын материал техникийн хангалт

-Мэргэжилтнүүдийг бэлтгэх, давтан сургах, хүний нөөцийг тогтвортой байлгах;

-Аюулгүй ажиллагааг хангах, мөрдлөг болгон хэрэгжүүлэх.

Уг хангалтын хүрээнд автомашин, техникийн эзэмшилт, үйлчилгээ, хадгалалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа нэгдмэл зохион байгуулалттайгаар хэрэгждэг бөгөөд үүнийг ашиглалт гэж тодорхойлно.

Хил хамгаалалтын ТХ нь тухайн анги, салбарт шинэ техник, технологи нэвтрэх түвшин, хангагдсан байдал. Тэдгээрийн ашиглалт, засвар үйлчилгээний зохион байгуулалт, сэлбэг хэрэгслийн нөөцөөс ихээхэн хамаардаг. ХХЕГ-ын хэмжээнд автомашин ТХ-ыг:

- Хил хамгаалалтын зориулалттай тээврийн хэрэгсэл;
- Цэрэг тээвэр, үйлчилгээний зориулалттай тээврийн хэрэгсэл гэсэн хоёр үндсэн бүлэгт хуваан зохион байгуулдаг.

Шинэчлэл

Сүүлийн жилүүдэд хил хамгаалалтын байгууллагад парк шинэчлэл хийгдэж, шинэ загварын тээврийн хэрэгсэл, дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмж нэвтрүүлж байна. Үүнд:

- Шинэ үеийн өндөр нэвтрэх чадвартай, шатахуун зарцуулалт бага, уур амьсгалын өөрчлөлтөд тохирсон тээврийн хэрэгслүүдийг ашиглалтад оруулсан;
- Хяналтын систем, холбооны шинэ технологиуд суурилуулж, хил хяналтын ажиллагаанд үр өгөөжтэй нөлөө үзүүлж байна.

Автомашины ашиглалтыг зохион байгуулах

Автомашины техникийн үйлчилгээний зорилго нь анги, салбарын байлдааны бэлэн байдлыг хангах, ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтийн явцад эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх, элэгдлийг багасгах цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Хил хамгаалах байгууллага зөвхөн 2024 онд суудлын 14, жийп төрлийн туулах чадвар өндөртэй 24, ачааны 12 автомашин, автобус 36, механизм 7, моторт завь 8, дөрвөн дугуйт мотоцикл 35, газар уснаа явагч 2, нийт 139 нэгж автомашин авсан байна[1].

Автомашины байлдааны бэлэн байдал дараах хүчин зүйлсээс хамаарна:

- Бүрэн бүтэн байдал;
- Эзлжийн засвар, үйлчилгээг хүртэлх нөөц явалт;
- Жолоочийн бэлтгэл, дадлага;
- Шатах, тослох материал болон ашиглалтын бусад хэрэгслээр хангагдсан байдал;

[1] *Ж.Оюун-Эрдэнэ, "Ойрын ирээдүйд дроны үйлдвэр байгуулж, сансрын уудмыг ашиглана. Командлагчийн үг." Эх орны манаа сонин, 2024 оны 11 дүгээр сар №32-33 (3129-3130) 2 дугаар нүүр.*

➢ Сэлбэг хэрэгсэл, тоноглол, иж бүрдлийн бэлэн байдал.

Ашиглалтын явц дахь өөрчлөлт

Ашиглалтын явцад түүний техникийн чанар өөрчлөгдөх нь зүй ёсны хэрэг бөгөөд үүнд дараах шинж тэмдгүүд илэрнэ:

➢ Агрегат, системийн динамик үзүүлэлт буурах;

➢ Шатах тослох материалын зарцуулалт нэмэгдэх;

➢ Хөдөлгүүрийн асалт удаашрах, хэвийн бус дуу чимээ гарах;

➢ Хөдөлгүүрийн халалт нэмэгдэх.

Ялангуяа цаг уурын хүнд нөхцөл, замын бартаатай орчинд ашиглах үед эдгээр шинж тэмдгүүд илүү тод илэрнэ. Иймд автомашин бүрийг бүрэн бүтэн, хэвийн ажиллагаатай байлгахын тулд:

➢ Бүх агрегат, зангилаа, механизм, тоноглолын бүрэн бүтэн байдлыг хангах;

➢ Зохих тохируулгыг цаг тухайд нь хийх;

➢ Ашиглалтын стандартын дагуу хэвийн нөхцөлд ашиглах шаардлагатай.

Судалгаа, уулзалтын үр дүн

Хилийн салбарын жолооч, хилийн ангийн авто техникийн албаны дарга, захирагчийн орлогч, ар тал хангалтын дарга нартай хийсэн уулзалт, ярилцлагын явцад дараах асуудлууд илэрсэн:

Автомашины засвар үйлчилгээний хяналт дутмаг, зарим тохиолдолд шаардлагатай сэлбэг, хэрэгсэл хангалтгүй байна.

Жолооч нарын мэргэжлийн бэлтгэл хангалтгүй байгаа нь ашиглалтад сөргөөр нөлөөлж байна.

Шатахуун, тослох материалын чанар, нийлүүлэлт тогтворгүй байдгаас болж хөдөлгүүрт доголдол үүсэх эрсдэлтэй.

Парк шинэчлэл хийгдэж байгаа боловч, зарим анги, салбарт хуучин автомашин ашиглах явдал хэвээр байгаа нь эвдрэл их гарч, засварын зардал нэмэгдэхэд хүргэж байна.

Хадгалалт, хамгаалалтын нөхцөл зарим анги, салбарт хангалтгүй байгаа нь техникийн элэгдлийг түргэсгэж байна.

Эдгээр асуудлууд нь онолын түвшинд ТХ-ын зохион байгуулалтын үзэл баримтлалтай нийцэж байгаа боловч практикт хэрэгжүүлэх явцад тодорхой хүндрэл, доголдол үүсч байгааг харуулж байна. Иймээс тх-ыг илүү үр дүнтэй болгохын тулд засвар, ашиглалт, хүний нөөцийн бэлтгэл, материаллаг хангамжийн чиглэлээр бодлого, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

ТХ-ын хэрэгжилтэд үүсч болзошгүй доголдлыг асуудлын модны аргаар шинжилж үзье.


Асуудлын мод: ТХ-ын хэрэгжилтийн доголдол

1. Гол асуудал

-ТХ-ын хэрэгжилтийн доголдол
(Онолын зохион байгуулалттай нийцэж байгаа боловч практикт хүндрэл үүсэж байна.)
2. Шалтгаанууд (үндсэн хүчин зүйлс)
- Засвар, ашиглалтын асуудал
  - Тогтмол засвар үйлчилгээний систем сул;
  - Сэлбэг хэрэгслийн хомсдол;
  - Хяналтын стандартын хэрэгжилт хангалтгүй.
- Хүний нөөцийн асуудал
  - Жолооч нарын бэлтгэл хангалтгүй;
  - Инженер, техникийн ажилтнуудын хомсдол;
  - Хүний нөөцийн давтан сургалт тогтмол бус.
- Материаллаг хангамжийн асуудал
  - Шатахуун, тослох материалын чанар, нийлүүлэлт тогтворгүй;
  - Шинэ технологийн нэвтрэлт хангалтгүй;
  - Хадгалах, хамгаалах нөхцөл хангалтгүй.

3. Үр дагаврууд
- Албаны бэлэн байдал буурах;
- Эвдрэл гэмтэл ихсэх;
- Засвар, сэлбэгийн зардал нэмэгдэх;
- Жолооч нарын ур чадвар, аюулгүй ажиллагаа буурах;
- Хил хамгаалалтын найдвартай ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх.

"Асуудлын мод" аргачлалаар харахад Тх-ын хэрэгжилтийн доголдол нь хэд хэдэн үндсэн хүчин зүйлтэй холбоотой бөгөөд засвар, ашиглалт, хүний нөөцийн чадавх, материаллаг хангамжийн асуудлууд голлох нөлөөтэй байна.



Зураг-1 Хангалтад үүсэж болзошгүй асуудлын модны загвар

Шийдлийн модны загвар
Үндсэн асуудал:
ТХ-ын хэрэгжилтэд хүндрэл, доголдол үүсэж байна.

I. Гол шийдлүүд:
1. Засвар, ашиглалтыг сайжруулах

- Засвар үйлчилгээний тогтмол хяналтын систем бий болгох
- Сэлбэг хэрэгслийн нөөцийг тогтвортой байлгах
- Түлш, тослох материалын чанарын хяналтыг сайжруулах

2. Хүний нөөцийн бэлтгэлийг сайжруулах


- Жолооч нарын сургалтыг тогтмолжуулах
- Жолооч нарыг дадлагажуулах сургалт зохион байгуулах
- Авто техникийн албаны мэргэжилтнүүдийн давтан сургалт явуулах

3. Материаллаг хангамжийг сайжруулах

- Санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах
- Хангамжийн төлөвлөлтийг оновчтой болгох
- Хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах

- Хүлээгдэж буй үр дүн:

- ТХ-ын хэрэгжилт сайжирна.
- Байлдааны бэлэн байдал нэмэгдэнэ.
- Шинээр хангагдсан техник хэрэгслийн ашиглалт, засвар, хамгаалалт сайжирна.



Зураг-1 Техникийн хангалтад үүсэж болзошгүй асуудлын шийдлийн модны загвар

Дүгнэлт:

Хил хамгаалалтын байгууллагын шинэ автомашинуудын ашиглалт, засвар үйлчилгээтэй холбоотой тулгарч буй асуудлуудыг судалсан дүнгээр дараах дүгнэлтүүдийг гаргав:

1. *ТХ-ын тогтолцоо:* Хил хамгаалалтын байгууллагын автомашины ашиглалт, засвар үйлчилгээний үйл ажиллагаа нь онолын түвшинд зохион хэвийн явагдаж байгаа боловч практикт асуудал үүсэж байна. Засвар
4. нийлүүлэлт тогтворгүй байгаа нь хөдөлгүүрийн үйл ажиллагаанд доголдол үүсэх эрсдэлтэй.
5. *Материаллаг хангамжийн нөхцөл:* Хадгалалт, хамгаалалтын нөхцөл зарим анги, салбарт хангалтгүй байгаа нь эдэлгээний элэгдлийг түргэсгэж байна.

Санал

Засвар үйлчилгээний тогтмол хяналтын систем бий болгох:

Засвар үйлчилгээний стандартуудыг тогтмолжуулах, хяналтын механизмыг сайжруулах.

Сэлбэг хэрэгслийн нөөцийг тогтвортой байлгахын тулд нийлүүлэлт, санхүүжилтийг урьдчилан төлөвлөх.

үйлчилгээний тогтмол хяналтын систем, сэлбэг хэрэгслийн нөөцийн дутагдал, жолооч нарын бэлтгэлийн асуудал нь автомашины ашиглалтад сөргөөр нөлөөлж байна.

2. *Жолооч нарын ур чадвар:* Жолооч нарын мэргэжлийн бэлтгэл хангалтгүй байна. Энэ нь эвдрэл гэмтлийг нэмэгдүүлж, албаны бэлэн байдалд сөргөөр нөлөөлж байна.
3. *Шатахууны болон тослох материалын чанар:* Шатахууны, тослох материалын чанар,

Жолооч нарын бэлтгэлийг сайжруулах:

Жолооч нарын сургалт, мэргэжлийн ур чадварыг тогтмол шинэчилж, дадлагажуулах.

Шинэ техник эзэмших сургалтуудыг зохион байгуулах, жолооч нарын ур чадварыг байнга сайжруулах.

Техникийн шинэчлэл хурдасгах:

Шинэ загварын тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг илүү өргөн хүрээтэй нэвтрүүлэх.

Хуучин автомашины шинэчлэл хийх, эвдрэл гарах эрсдэлийг бууруулах.

Шатахуун, тослох материалын чанар болон нийлүүлэлтийг хянах:

Шатахуун болон тослох материалын чанарын хяналтыг сайжруулах.

Шатахууны зориулалтын шүүлтүүртэй түгээгүүрээс ханган нийлүүлэхийг дэмжих.

Материаллаг хангамжийн нөхцөлийг сайжруулах:

Хадгалалт, хамгаалалтын орчныг сайжруулах.

Автомашиныг тогтмол шалгаж, хадгалалтын хугацааг уртасгах.

Эх сурвалж:

Ном зохиол, судалгааны материал:

-Лхагва. Б., 2005 он., “Хилийн цэргийн ар тал хангалтын зарим асуудал.” Улаанбаатар: Амжа принтинг.

-Ганбаатар. Д., Сүндэв. П., 2005 он., “Хилийн заставын материал техникийн хангалт.” Улаанбаатар 0288 дугаар ангийн хэвлэх.

Нийтлэл, судалгааны өгүүлэл:

-Ж.Оюун-Эрдэнэ, “Ойрын ирээдүйд дроны үйлдвэр байгуулж, сансрын уудмыг ашиглана. Командлагчийн үг.” Эх орны манаа сонин, 2024 оны 11 дүгээр сар №32-33 (3129-3130) 2 дугаар нүүр.

УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУСГАЙЛСАН ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Б.Гомбосүрэн
Дотоод хэргийн их сургуулийн
Хилийн албаны сургуулийн
Цэргийн хэргийн тэнхимийн ахлах багш
Докторант, хурандаа

Агуулга: Хилийн аюулгүй байдлыг хангахад үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, тэдний оролцоо, хамтын ажиллагаа Улсын хилийн аюулгүй байдлыг хангахад үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын гүйцэтгэх үүрэг.
Content: The participation of organizations with specialized functions to ensure national security in ensuring border security, research on the functions of organizations with specialized functions to ensure national security and relevant laws. The participation of organizations with specialized functions to ensure national security in ensuring state border security.
Түлхүүр үг: Улсын хилийн аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, төрөөс хилийн талаар баримтлах бодлого.
Keywords: State border security, organization with special functions to ensure national security, state border policy.

УДИРТГАЛ

“Монгол Улс хил залгаа улсуудтайгаа найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх нь төрийн гадаад бодлогын эн тэргүүний зорилт” гэж гадаад бодлогын үзэл баримтлалдаа тунхагласан. Хилийн аюулгүй байдлыг хөрш улсуудтай хамтран хангахын сацуу дотооддоо төрийн байгууллагуудын хүчин чармайлтыг уялдуулан чиглүүлэх зайлшгүй шаардлага жилээс жилд тавигдах боллоо.

Монгол Улсын Их Хурлаас 2016 онд баталсан Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Улсын хилийн аюулгүй байдал” гэх ойлголтыг томьёолж, түүнийг хангахад төрийн болон нутгийн захиргааны байгууллага албан тушаалтны эрх, үүргийн талаар тусгахдаа “Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан улсын хилийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг холбогдох хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ” гэсэн заалт оруулсан. Энэ заалт нь цаашид төрийн захиргааны байгууллагуудын холбогдох хуулиудыг судалж улсын хилийн

аюулгүй байдлыг хангах чиг үүрүүдийг тодорхойлох түүнийг цаашид улам боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Үндсэн хэсэг

Өнөөгийн нийгэм, эдийн засгийн хурдтай хөгжлийг даган аюул заналаас сэргийлж, аюулгүй байдлаа хангах төрийн бодлого болон хууль, эрх зүй, стратеги, тактикаа боловсруулан, шинэчлэн гаргаж түүний зорилго, зорилт, сургалт, сурталчилгааны ажлыг цаг алдалгүй хийх нь төр засаг, төрийн болон орон нутгийн засаг захиргаа бүх шатны байгууллагуудын үүрэг бөгөөд түүхэн хугацаанд улам боловсронгуй болсоор байна.

Улсын хэмжээнд авч хэрэгжүүлж байгаа Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд чиглэсэн бүх төрлийн арга хэмжээ, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий үндэсний зөвлөлүүдийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтцэд хамааруулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажиллагааг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах.

Хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь оператив, стратегийн орон зай оперативын чиглэлүүдтэй салшгүй холбоотой бөгөөд бүсчилсэн хил хамгаалалтын үзэл баримтлалыг үндэслэн бүсүүдийн хилийн аюулгүй байдлыг хангах хилийн цэргийн оперативын газруудыг байгуулах. (Н.Наранжамц, 2012).

Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд “Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын язгуур ашиг сонирхлыг хангах гадаад дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ” гэж тодорхойлов. Үүний зэрэгцээ үндэсний аюулгүй байдал нь нэн тэргүүнд хил хязгаарын аюулгүй байдлаас шалтгаална гэдгийг төрөөс онцлон үзэж хилийн аюулгүй байдлын мөн чанарыг “Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ” хэмээн томьёолж хуульчилсан байна. (Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2001)

Улсын хилийн аюулгүй байдал нь тухайн улсын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдал, нийгэм, эдийн засаг, үндэсний аюулгүй байдлын суурь бүрэлдэхүүн хэсэг юм. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд улсын хилийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах явдал нь төрийн үйл ажиллагааны чухал үндсэн чиглэл бөгөөд эцсийн дүндээ, хилийн аюулгүй байдал нь улсын хилийн хамгаалалтад оролцож

буй субъектүүдийн үйл ажиллагаагаар хангагдана. Энэ нь Монгол Улсын төрийн байгууллагууд, субъектүүдийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын үйл ажиллагааг өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд зохицуулахад оршино (төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2002).

Улс орон бүр үндсэн хуульт улс болж төрийн байгуулалт хөгжлийн загвараа сонгосон зарим нь хаант улс гэх зэрэг засаглалын янз бүрийн хэлбэрийг уламжлан хадгалсан, хүний эрх, эрх чөлөөг тунхагласан, арьсны өнгө үзэл бодлоороо зөрчилдсөн гэх мэт янз бүрийн өнгө аясыг агуулан хөгжиж байна. Дээр дурдсан тусгаар байх, бие даасан байх, аюул заналгүй байх хүсэл сонирхлын үндэс нь тусгаар тогтносон улс байх явдал боловч улс төр, нийгэм эдийн засаг, худалдаа аж үйлдвэр, хууль эрхзүй гэх мэт асуудлаар нэгдмэл ойлголт бий болсон, харилцан хамаарал, харилцаа бүхий даяаршсан орон зайд байх боломж бараг үгүй бөгөөд гагцхүү газар нутгийн бүрэн бүтэн байдлаа хадгалан байх, түүгээрээ дамжин бие даасан тусгаар улс байж өөрийн гэсэн төрийн байгуулалт, хүн ам, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлаа хадгалан байх боломжийг илэрхийлж байна (А.Муратхан, 2018).

Тусгаар байх, бүрэн эрхт байх явдалд учирч болох аюул заналыг улс орон бүр янз бүрийн түвшинд авч үзэж байгаа боловч нэгэнтээ хил хязгаарын бүрэн бүтэн халдашгүй байдал түүнтэй холбогдох олон талт асуудлыг бүхэлд нь авч үзэж буй “Хилийн аюулгүй байдал” хэмээх ухагдахууныг дийлэнх улс орнууд хүлээн зөвшөөрч үндэсний аюулгүй байдлынхаа нэгэн чухал чиглэл, хэсэг болгон авч яваа болно.

Монгол Улсын хувьд аюул заналын болон хилийн аюулгүй байдлын асуудлаа тодорхой



болгож олон улсын аюулгүй байдлын хүрээнд авч үзэж аюул заналын буюу ашиг сонирхлын хил хязгаар, орон зайн асуудлаа тодорхой болгох өөрөөр хэлбэл стратеги, оперативын, оператив тактикийн орон зайгаа тодорхойлж дээрх дурдсан арга замаар аюулгүй байдлын цогц номлол, үзэл баримтлалтай болох түүнчлэн гадаад бодлого харилцааны тулгуур хуультай болох нь тулгамдсан асуудал болж байна. Өнөөдөр олон улс, бүс нутгийн түвшинд иргэний дайн, дүрвэгсэд хууль бус цагаачлал,

салан тусгаарлагчид болон хууль зэвсэгт бүлэглэл, хар тамхи мансууруулах бодисын худалдаа, зэвсэгт галт хэрэгсэл, хүний наймаа, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, газар нутгийн маргаанаас үүдэлтэй хилийн зөрчил, будилаан гарсаар байна. Энэхүү аюул занал нь Монгол улсын хувьд анхаараад зогсохгүй зохих бэлтгэлтэй байхыг шаардаж байгаа болно (Н.Наранжамц, 2012).

Улсын хил хамгаалалтын тогтолцооны
ерөнхий бүдүүвч. (Ш.Лхачинжав, 2010)

Монгол Улсад хүн амын дийлэнх хэсэг нь нийслэлдээ амьдарч хамгийн ихээр анхаарлаа хандуулан анхаарлын төвд байж хамгаалагдах ёстой хил орчмын нутаг дэвсгэр эзэнгүйрэн байгаа явдал нь үндэсний аюулгүй байдал түүн дотроо оршин тогтнохуйн аюулгүй байдалд ноцтой аюул учруулж болзошгүй орон зай үүсгэж байна..

“Үндэсний аюулгүй байдал” систем болон түүнийг хангах системийн ойлголтын агуулгыг шинжлэх ухааны танин мэдэхүйн болон системийн хандлагын өнцгөөс нэгд, онол арга зүйн тайлбар гаргалгаа хийж; хоёрт, үүн дээрээ тулгуурлан үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтад ойлголтуудыг хэрхэн тодорхойлсныг авч үзье


Судалгаанаас үзэхэд үндэсний аюулгүй байдлыг түүнд учирч болох аюул заналын эх үүсвэрийн дотоод ба гадаад аюулгүй байдал гэж ангилдаг байна.

Ийм ангилал нь үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг шийдвэрлэх аливаа үзэл баримтлалын хандлагыг нарийн тодорхой ангилахад үлэмж ашиг тустай байхын зэрэгцээ дотоод болон гадаад аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр, арга зам хоорондоо тэс өөр байдагтай холбоотой юм.

Түүнчлэн дотоод, гадаад аюулгүй байдал нь харилцан хамааралтай бие биедээ нөлөөлдөг зүй тогтолтой байна.

Үндэсний аюулгүй байдлын ерөнхий бүдүүвчийг зураг дээр харууллаа.

Үндэсний аюулгүй байдлын системийн гадаад, дотоод аюул заналын эх үүсвэрүүдийг бүрдүүлэгч элементүүдийн харилцан хамаарлыг цогцоор үйл ажиллагаагаа явуулдаг.



Үндэсний аюулгүй байдлыг хангах удирдлагын системийн хувьд үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөлийг хангах системийн нэгдмэл чанарын өсөлт нь зөвхөн үндэсний аюулгүй байдлын системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бие даасан байдлыг

тодорхой хэмжээгээр хязгаарласны үр дүнд биелнэ. Эсрэгээрээ бол үндэсний язгуур ашиг сонирхол хангагдах гадаад, дотоод таатай нөхцөл буурна.

Иймд үндэсний аюулгүй байдлын систем үргэлж аюулгүй байдлын туйлын нэгдмэл чанар ба түүний туйлын бие даасан (замбараагүй) байдал гэсэн хоёр хязгаарын дунд оршдог бөгөөд түүнийг хангах удирдлагын системд системийн нэгдмэл чанар ба элементүүдийн бие даасан байдлын зохистой харьцааг тогтоох үүрэг хариуцлага оногдож байдаг.

Хилийн талаар баримтлах бодлогын баримт бичиг нь Үндсэн хуулийн үзэл баримтлалыг үндэслэн улсын хил, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын талаар Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болсон залгамж чанартай тулгуур баримт бичиг юм. (төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2002)

Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэхэд байгууллага, аж ахуйн нэгж нь тодорхой үүрэг хүлээхээр хууль болон бодлогын баримт бичигт тусгагдсан байдаг. Үүнд;

1. Тагнуулын Ерөнхий Газар (ТЕГ)

• Улс орны эсрэг чиглэсэн тагнуул, хорлон сүйтгэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх.

• Хилийн бүс, боомтуудаар дамжин орж ирж буй аюул занал (терроризм, хар тамхи, хууль бус наймаа гэх мэт)-ыг илрүүлэх, мэдээлэл цуглуулах.

• Хилийн чанадад үйл ажиллагаа явуулж буй тагнуулын байгууллагуудын үйл ажиллагааг хянах, сөрөг тагнуулын арга хэмжээ хэрэгжүүлэх.

2. Зэвсэгт хүчин (Хилийн цэрэг багтана)

• Улсын хилийн физик хамгаалалтыг хангах.

• Хилийн бүсэд үүсэж болох зэвсэгт мөргөлдөөн, хууль бус нэвтрэлтийг зогсоох, хариу арга хэмжээ авах.

• Цэрэг-техникийн хяналт, хилийн пост, байнгын эргүүлээр дамжуулан хяналт тавих.

3. Цагдаагийн Ерөнхий Газар (ЦЕГ)

• Хилийн боомтуудаар дамжин гарах гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх.

• Хилийн бүсэд дотоодын эмх журмыг сахиулах.

• Гадаадын иргэдийн бүртгэл, хяналт, виз, оршин суух асуудлыг хариуцан ажилладаг холбогдох нэгжтэй хамтран ажиллах.

4. Гаалийн Ерөнхий Газар

• Хилийн боомтуудад бараа, ачаа, тээврийн хэрэгслийг хянах, хууль бус эд зүйлс (зэвсэг, мансууруулах бодис гэх мэт)-ийг илрүүлэх.

• Эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой хуурамч

бараа, гаалийн зөрчлийг илрүүлэх.
• Гадаад худалдааны бодлого хэрэгжилтийг хянах.
5. Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)
• Хилийн бүс нутагт тохиолдох байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, онцгой нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах.
• Хилийн мина, тэсрэх бодис бүхий эрсдэлтэй бүсүүдийг илрүүлэх, хоргүйжүүлэх.
• Аюулгүй байдал алдагдсан тохиолдолд ард иргэдийг хамгаалах ажиллагаа явуулах.
6. Гадаад харилцааны яам
• Хил орчмын маргаантай асуудлыг дипломат аргаар шийдвэрлэх.
• Хөрш улсуудтай хил хамгаалалт, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтын ажиллагаа хөгжүүлэх.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд нь харилцан уялдаатай, хамтран ажилласнаар улсын хилийн аюулгүй байдлыг зохих хэмжээнд хангах нөхцөл бүрдэнэ.

Хилийн аюулгүй байдлыг хангахад эдгээр байгууллагууд мэдээллийн технологи, хамтын ажиллагааны нэгдмэл тогтолцоотой болох шаардлагатай.

Хилийн аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдах бөгөөд хилийн аюулгүй байдлыг хангах хүрээнд Монгол Улсын төрийн болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан хил орчмын нутаг дэвсгэрт өөрсдийн эрх хэмжээний хүрээнд харилцан уялдаатай үйл ажиллагаа явуулна (Г.Лхагвамаа, Ч.Мягмарбаяр нар,, 2018).


Өрнөдийн улс төр судлалд “public administration” гэсэн нэр томьёогоор илэрхийлэгдэх ойлголтыг монголын эрдэмтэд “төрийн захиргаа” хэмээн орчуулан хэрэглэж байна. Төрийн захиргаа буюу “public administration” хэмээх ерөнхий нэр томьёо нь хэрэглэгдэж байгаа нөхцөл байдал, хам утгаасаа хамаарч хэд хэдэн янзаар ойлгогдож байна. Эрдэмтэн А.Цанжид: Энэ нэр томьёо нь нэг биш утгатай юм. Эл нэр томьёоны анхны утгыг нь авч үзвэл Төрийн захиргаа гэдэг нь төрийн байгууллага гэдэг утгатай. Тиймээс үүнийг “аппарат” гэсэн явцуу утгаар нь авч үзэх нь элбэг байдаг” (А.Цанжид, 2009 он.)гэж үзжээ. Тиймээс “төрийн захиргаа”, “төрийн захиргааны удирдлага” гэсэн ойлголтууд нь адилхан утгаар хэрэглэгддэг байна. (Я.Долгоржав, 2012) гэж үзсэн байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын чиг үүрэгт хийсэн дүн шинжилгээ:

Хилийн аюулгүй байдлыг хангах гол эх сурвалж нь Үндсэн хууль, Хилийн тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль гэх мэт бөгөөд эдгээрээс гадна улсын хилийг хамтран шалгахад баримтлах чиглэлийн тухай, Монгол Улсын хилийг шалгасан баримт бичиг батлах тухай хуулиуд нэгэн адил хамаарна. (ХХЕГ, ХСИС-ийн хамтарсан судалгааны ажлын тайлан,, 2018)
Хилийн аюулгүй байдлыг хангах бусад эх сурвалж буюу хууль, хуульчилсан акт:
Өнөөгийн байдлаар хилийн тухай хуулийн шинэтгэлийн бодлогын хүрээнд эрх бүхий этгээдээс эрх хэмжээнийхээ хүрээнд батлан гаргасан дараах тогтоол, зарлиг, тушаалаар батлагдсан дүрэм, журам, зааврууд хүчин төгөлдөр үйлчилж байна. (Ч.Нямсүрэн, Г.Лхагвамаа нар,, 2018 он.)

Хүснэгт №1. Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн актын ангилал, тоо хэмжээ (систем, 2025)

№	Эрх зүйн актын төрөл	Тоо
1	Хууль	68
2	Ерөнхийлөгчийн зарлиг	1
3	УИХ-ын тогтоол	4



Эх сурвалж (систем, 2025)

Хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой хуулиудын дийлэх нь буюу 68 хувь нь нь улсын хилээр зорчигч, тээвэр, ургамал, мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бараа бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдалтай холбоотой харилцааг зохицуулахад байна.

Хилийн тухай хуулиудын харьцуулалт (1993, 2016 он):
Улсын хилийн аюулгүй байдлыг хангах гол эх сурвалж болох Хилийн тухай хуулийг 2016 онд УИХ-аас шинэчлэн найруулж баталсан. Энэ шинэчилсэн найруулгаар 1993 онд батлагдсан Хилийн тухай хуулийн нийт зүйлийн 86.2 хувь, хэсгийн 92.3 хувь, заалтын 71.8 хувьд өөрчлөлт оруулж, 23 зүйл, 123 хэсэг, 90 заалт шинээр нэмж, 29 зүйл, 66 хэсэг, 27 заалтад нэмэлт оруулан, өөрчлөн найруулж, 3 зүйл, 17 хэсэг, 26 заалтыг хассан. 1993 оны Хилийн тухай хуулиудын Улсын хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой бүлэг, зүйл заалтыг харьцуулан судлахад: 1993 оны хуулийн Тавдугаар

бүлэгт Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Зэвсэгт хүчин, Тагнуулын байгууллага, Цагдаагийн байгууллагын эрх үүргийг тусгайлан задалж тусгасан байсныг шинэчилсэн найруулгад шинээр Улсын хил хамгаалалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийн эрх, үүргийг тодорхойлж оруулаад бусад байгууллагуудын тухайд ганц заалтаар хураангуйлан оруулсан нь уг хуульд хилийн аюулгүй байдлыг хангах хүчин чадлыг сулруулсан гэж дүгнэж болохоор байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны өнөөгийн байдал:

Улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх, харилцан ажиллах талаар Монгол улсын хуулиар үүрэг хүлээсэн байгууллагуудаас өнөөгийн байдлаар Зэвсэгт халдлага, гамшигт үзэгдэл, хүн ам, малын гоц халдварт өвчин, ган, зуд, үер, байгалийн гамшиг, мэдээ, мэдээллийн аюулгүй байдал, хими, радиацын хордлого, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх гэсэн 7 төрлийн арга хэмжээнд харилцан ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна. Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт явагдаж байгаа ажил үйлдвэрлэл, ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй хэсэгт улсын хил хамгаалалтын хүч хэрэгслийн нягтралыг нэмэгдүүлэн, дэд бүтцийг хөгжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг аж ахуйн нэгж болон иргэд сахин биелүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулахад Хил хамгаалах байгууллагатай харилцан ажиллагаатай төрийн захиргааны байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, холбогдох хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. (М.Баярсайхан, 2018 он)

Улсын хилийн аюулгүй байдлыг хангахад үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын чиг үүргийг удирдлагын түвшинд байгууллага тус бүрийн үндсэн чиг үүргийн онцлогт тулгуурлан тусгайлан боловсруулж, Хилийн тухай хуульд нэмэлт өөрчлөлтөөр тусган, хамтын ажиллагааг уялдуулан хэрэгжүүлэх нь зүйтэй.

ДҮГНЭЛТ:

Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Хилийн тухай хууль, Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичгүүдэд “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд нь харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах болон байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны зохицуулалт, уялдаа холбоог

зохион талаар тус тус заасан нь төрийн захиргааны байгууллагууд хилийн аюулгүй байдлыг хангахад хамтарч ажиллах үүрэг, шаардлагатай болохыг харуулж байна. Харин Хилийн тухай хуулийн 49.2-т "Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан улсын хилийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг холбогдох хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ" (Хилийн тухай хууль, 2016) гэж заасан байна. Гэтэл Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын холбогдох хуульд заасан чиг үүргүүдийг судалж үзэхэд Зэвсэгт хүчин, Тагнуулын байгууллагын үндсэн чиг үүрэгт хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой тус бүр хоёр заалт байна. Бусад байгууллагын тухайд чиг үүрэгт нь хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой ямар нэгэн үг, өгүүлбэр одоогоор байхгүй байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хувьд хуульд заасан эрх, хүлээсэн үүрэг, хяналт шалгалт, харилцаа холбоо зэрэг үйл ажиллагаагаараа хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд оролцож байна.

САНАЛ:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.2.5 дахь заалт, Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын 2 дугаар бүлгийн 1.2 дахь заалтуудыг үндэслэн Засгийн болон хилийн аймаг, сумын өөрөө удирдах байгууллагын дэргэд "Хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх орон тооны зөвлөл"-ийг байгуулж, улс орны аюулгүй байдал, бүтээн байгуулалт, аялал жуулчлалтай холбоотой хөрөнгө оруулалтыг хил орчмын эдийн засгийн хөгжлийг хангахад чиглүүлэх;
2. Хил хязгаар нутагт оршин сууж аж төрж буй иргэдийг татварын болон эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээгээр хөнгөвчлөх, бүс нутгийн хилийн урамшуулалтай болгох зэргээр эрх зүйн зохицуулалтаар дэмжих;
3. Төрийн захиргааны байгууллагуудын Улсын хилийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг тухай байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан удирдлагын түвшинд боловсруулж, "Хилийн тухай хууль"-д нэмэлт өөрчлөлтөөр тусгаж, байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах;
4. Бүс, орон нутагт Улсын хилийн аюулгүй байдлыг хангах бодлого, тогтолцоог хэрэгжүүлэх, төрийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг зохион байгуулах зорилгоор "Бүсчилсэн хил хамгаалалтын үзэл баримтлал"-ыг үндэслэн бүсүүдийн "Хилийн аюулгүй байдлыг хангах хилийн цэргийн оперативын газар"-уудыг байгуулах,

Bibliography

Ч.Нямсүрэн, Г.Лхагвамаа нар,. (2018 он.). “Хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт”. (“Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” , (p. 184). УБ.

А.Муратхан. (2018). Улсын хилийн аюулгүй байдлыг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын хэрэгжилтээр хангах арга замын тухайд. "Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” Олон Улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (p. 25). Уб: Мөнхийн үсэг ХХК.

А.Цанжид. (2009 он.). Төрийн захиргаа. Улаанбаатар.

Г.Лхагвамаа, Ч.Мягмарбаяр нар,. (2018). “Хилийн эрх зүй” сурах бичиг. . Улаанбаатар.

М.Баярсайхан. (2018 он). “Хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт явагдаж байгаа ажил үйлдвэрлэл хилийн аюулгүй байдалд нөлөөлөх нь”. “Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам”, (p. 152). УБ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. (2001, 12 27). Монгол улсын хуулиуд. Retrieved from эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail?lawId=18

Н.Наранжамц. (2012). бүс нутаг-хил хамгаалалтын үзэл баримтлал. Улаанбаатар: 54.

систем, э. з. (2025, 05 08). монгол улсын хуулиуд. Retrieved from эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.

төрөөс хилийн талаар баримтлах бодлого. (2002, 05 16). Улсын их хурлын тогтоол. Retrieved from Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар тогтоолын хавсралт : https://legalinfo.mn/mn/detail?lawId=203037

Хилийн тухай хууль. (2016, 12 28). Монгол улсын хуулиуд. Retrieved from эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail/12418

ХХЕГ, ХСИС-ийн хамтарсан судалгааны ажлын тайлан,. (2018). “Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн орчин” . Улаанбаатар.

Ц.Одбаяр. (Диссертаци. УБ., 2018 он.). Хилийн аюулгүй байдлыг хангахад тусгай томилгоот салбарын гүйцэтгэх үүргийн судалгаа. . Улаанбаатар.

Ш.Арвай. (2018 он.). “Улсын хилийн аюулгүй байдал, тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх үндсэн арга зам. ” (“Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” , (p. 304). УБ.

Ш.Лхачинжав. (2010). “Хил хамгаалалтын тогтолцоонд орон нутгийн засаг захиргаа, ард иргэдийг оролцуулах ажиллагааг боловсронгуй болгох нь”. Улаанбаатар.

Я.Долгоржав. (2012). “Төрийн захиргааны удирдлага, түүний тойронд өгүүлэхэд” . Төрийн захиргаа сэтгүүл., 27.

ПРОФАЙЛИНГ, ТҮҮНИЙГ ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Г.Болортунгалаг

Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн ахлах багш, Аюулгүй байдал судлалын докторант, дэд хурандаа

Товч агуулга: Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа эхлэн өнөөдрийг хүртэл худлыг илчилж, үнэнийг тогтоохыг байнга эрэлхийлж ирсэн билээ. Нийгмийн хөгжлийн явцад худал, үнэнийг тогтоох арга барил улам боловсронгуй болж, өнөө үед шинжлэх ухаан, техник технологийн дэвшлийг түлхүү ашиглах болсон.

Профайлинг (англ. *profile* — "хувийн мэдээллийн тойм") гэдэг нь хүний биеэ авч яваа байдал, гадаад төрх, зан авирын онцлог шинжүүдийг ажиглан тухайн хүний сэтгэл зүйн төлөв байдал болон хандлагыг тодорхойлох арга юм. Энэ аргыг товчхондоо “хүнийг унших арга” гэж ойлгож болно. Тухайн хүний зан чанар, үзэл бодол, хэрэгцээ, хандлага зэргийг богино хугацаанд тодорхойлох, дотоод мэдээллийг нь илрүүлэх боломж олгодог.

Анх гэмт хэргийн халуун мөрөөр үл танигдах этгээдийн сэтгэл зүйн хөргийг гаргахад ашиглагдаж байсан бөгөөд үүнийг 1888 онд Английн мэс засалч Томас Бонд зууны гэмт хэрэгтэн Жэк Потрошителийг илрүүлэх оролдлогоор эхэлсэн гэж үздэг. Профайлингийн онол, арга зүйн суурийг П. Экман, В. Фризен, К. Шерер, М. Цукерман, Б. ДеПаул, В. А. Лабунская, О. Фрайя нарын судалгаа бүтээлүүд бүрдүүлдэг.

Түлхүүр үг: Шалган нэвтрүүлэх алба, профайлинг, зөрчил

Удиртгал

Орчин үед профайлингийг хүний ой санамжид хадгалагдсан “нуугдмал мэдээлэл”-ийг илрүүлэхэд өндөр ач холбогдолтой арга хэмээн үздэг. Энэ аргыг нийгмийн бүхий л салбарт нэвтрүүлэн ашиглах боломжтой бөгөөд олон улсын практикт гэмт хэргийн нууц далд шинж чанарыг илрүүлэх, ээдрээтэй хэрэг маргааныг шийдвэрлэх, нотлох ажиллагаанд өргөн ашигладаг. Түүнчлэн хүний нөөцийн болон албаны шалгалтын үнэн бодит байдлыг тогтооход ч хэрэглэж байна.

Харин хамгийн маргаантай асуудал нь "угсаатны профайлинг" юм. Энэ нь тодорхой угсаатны бүлгийн хүмүүсийг гэмт хэрэгтэй хамааралтай гэж үзэх хандлагатай холбоотойгоор хүний эрхийн зөрчил үүсгэх эрсдэлтэй.

Өнөөдөр профайлингийг дараах салбаруудад түлхүү ашиглаж байна. Үүнд:

- Гэмт хэрэгтний хэв шинж судлал
- Криминологи (гэмт хэргийн зан үйлийн судалгаа)

- Сэтгэцийн эрүүл мэндийн судалгаа (психологи, психиатр)
- Шинжилгээ, нотлох баримтын судалгаа
- Ял эдлүүлэх ажиллагаа (пенитианцар систем)

Мөн хил, гааль, цагаачлалын албаны өдөр тутмын үйл ажиллагаанд өргөн хэрэгжиж эхлээд байна. Улсын хил бол зөвхөн газар нутгийн хязгаар биш, хүний сэтгэл зүйд хүчтэй нөлөөлөл үзүүлдэг онцгой орон зай юм. Судалгаанаас үзэхэд, ижил нөхцөлтэй гамшиг хилийн гадна гарвал хөндлөнгийн мэт хүлээн зөвшөөрөгдөх бол, дотроо үүсвэл илүү соргог, эмзэг хүлээн авдаг нь тогтоогдсон байдаг (Psychological Science).

Бид өөрсдөө ч улсын хилээр нэвтрэхдээ бахархах, хүндэтгэх мэдрэмжийн зэрэгцээ айдас, болгоомжлол, сандрал зэргийг мэдэрч явдаг. Энэ сэтгэл зүйн нөлөөллийн тухай Оросын яруу найрагч В. И. Маяковский “Зөвлөлтийн паспорт”, Монголын яруу найрагч Б. Лхагвасүрэн “Улсын хил дээр бичсэн шүлэг”-тээ тод томруун дүрсэлсэн байдаг. Аялал жуулчлалын өсөлт нь зөвхөн эерэг урсгал төдийгүй гэмт хэрэгтнүүдийн хилийн зааг давах оролдлого, урсгалыг ч нэмэгдүүлдэг. Үүнд террорист үйлдэл, хүний наймаа, зэвсгийн хууль бус наймаа, хар тамхи, мансууруулах бодис, бохир мөнгө угаалт, эрэн сурвалжлагдаж буй этгээдүүд багтдаг. Эдгээр этгээдүүд хуурамч бичиг баримт ашиглан Монгол Улсад хориглосон бараа, үйл ажиллагааг нэвтрүүлэхийг эрмэлздэг.

Үндсэн хэсэг

Профайлингийн аргыг нислэгийн өмнөх бүртгэл болон онгоцонд суулгах үе шатанд зорчигчдод хяналт тавих замаар алан хядагчдыг илрүүлэхэд амжилттай ашиглаж байна. Энэхүү аргыг анх Израилын "Эль-Аль" (El Al) агаарын тээврийн компани нэвтрүүлснээр дэлхийн хамгийн аюулгүй нислэгийг гүйцэтгэдэг компани болсон. Энэ жишгийг олон улс даган хэрэгжүүлж байна.

Манай өвөг дээдэс ч мөн төрөлхийн “профайлерууд” байжээ. Хүнийг мэндлэх, уулзах, тамхилах үйлдлээр нь хэн болохыг тандах, таних уламжлалтай байв. “Тавхан үгэндээ танигдаад байна”, “Эх нь хээр алаг бол унага нь шийр алаг” гэх мэт хэлц үгс ч энэ ажигч, тандах, дүгнэх соёлын илрэл юм. Монгол мэндчилгээ бол орчин үеийн нэршлээр “тандах, чиглүүлэх ярилцлага” буюу жинхэнэ монгол профайлинг билээ.

Харин өнөөдөр Монгол Улсын Хил хамгаалах байгууллагын шалган нэвтрүүлэх албаны албан хаагчид профайлингийн нарийвчилсан ойлголтгүй, тусгайлсан сургалт, хөтөлбөрт хамрагдаагүй байгаа нь анхаарах асуудал юм. Тэд олон жилийн туршлага, мэргэжлийн зөн

совингоор тухайн хүнийг таньж, таамаг дэвшүүлдэг ч энэ нь орчин үеийн мэргэшсэн арга зүйг орлож чадахгүй.

Сүүлийн жилүүдэд технологид тулгуурласан хяналт шалгалт өргөн хэрэглэгдэж байгаа ч, зөвхөн техникээр хууль бус үйлдлийн сэдлийг тодорхойлох боломжгүй. Хүний хүчин зүйлийг хэзээ ч орхигдуулж болохгүй. Профайлингийн мэдлэг, ур чадварыг эзэмшсэн шалгагч гэмт этгээдийг түүний харьцаа, хандлага, дохио зангаа, биеийн хэлэмж, сэтгэл зүйн илрэл зэргээр таньж, оновчтой шийдвэр гаргах боломжтой байдаг. Ийм чадвартай хүнийг "профайлер" хэмээн нэрлэдэг.

Дүгнэлт, санал

Профайлинг нь шалган нэвтрүүлэх боомт (ШНБ) дээр аюул тээгч этгээдийг илрүүлж, хувь хүн, нийгэм, төр, улсын хил хязгаарын аюулгүй байдлыг хангах үр дүнтэй аргачлалын нэг мөн.

Профайлинг нь аюулгүй байдлыг хангах бүхий л салбарт ашиглаж болох, зардал багатай хэр нь өндөр үр дүнтэй, практик ач холбогдол бүхий арга юм.

Арга зүйн хувьд профайлинг гэмт сэдэл бүхий, аюул дагуулж болзошгүй этгээдийн харьцаа, хандлага, сэтгэл хөдлөлийн өөрчлөлт, бусдаас ялгарах шинж тэмдгүүд болон эзэнгүй эд зүйлсэд үзлэг хийх зэргээр илрүүлэх боломж дээр суурилдаг.

Энэхүү аргыг нийгмийн сэтгэл зүйн үндсэн аргуудын нэг болгон ашиглаж, хүмүүсийн харилцаа, тэдний дотоод болон гадаад мэдээлэлд хандах хандлагыг ажиглан, хяналт тавих замаар үр дүнтэй хэрэгжүүлнэ.

Шалгагч нарын хувьд ажигч гярхай байдал, орчны өөрчлөлтөд хурдан хариу үйлдэл үзүүлэх чадвар онцгой чухал үүрэгтэй.

Профайлинг нь шалгагчид богино хугацаанд, хязгаарлагдмал нөхцөлд, хангалт, нөөц хомс үед ч тухайн этгээдийн сэжиг бүхий сэдлийг зөв тодорхойлон "унших", аюулыг урьдчилан илрүүлж, таслан зогсоох боломжийг олгодог.

Энэ арга нь үйл ажиллагаагаа тухайн цагийн нөхцөл байдалд үнэлж, орчны сэжигтэй шинж тэмдгийг танин мэдэх, улмаар стандарт бус нөхцөлд зөв шийдвэр гаргах чадамжийг шалгагчаас шаарддаг.

Хил залгаа болон бусад улс орнуудын туршлагаас харахад, ШНБ дээр "Профайлинг", "Полиграф" аргуудыг олон жилийн турш амжилттай ашиглаж ирсэн нь эдгээр аргуудын практик үр нөлөөг баталж байна.

Монгол Улсын үндэсний болон хилийн аюулгүй байдлыг хангахын тулд профайлингийн мэдлэг, ур чадвартай шалгагчдыг бэлтгэх, тусгай сургалтын хөтөлбөр боловсруулах, мөн сурах бичиг, гарын авлага боловсруулан хэрэгжүүлэх нь нэн шаардлагатай.

Монгол Улсын нөхцөл, онцлогт тохирсон “Шалган нэвтрүүлэх албаны /гаалийн/ профайлинг”-ийн арга зүй, загварыг бүрдүүлж, нэвтрүүлэх нь хамгийн тулгамдсан зорилт юм.

Шалгагч нь зөвхөн бичиг баримт шалгадаг, тамга дардаг мэргэжилтэн” байх шаардлагатай. Үүнийг мэргэжлийн байгууллагууд хүлээн зөвшөөрч, дэмжих нь зүйтэй.

Эх сурвалж

1.Paul Ekman – *Telling Lies: Clues to Deceit in the Marketplace, Politics, and Marriage*
Хүний нүүрний хувирал, биеийн хэлний шинжилгээгээр худлыг таних тухай сонгодог бүтээл.
2. Joe Navarro – *What Every Body Is Saying: An Ex-FBI Agent's Guide to Speed-Reading People*
АНУ-ын ХМТ-ийн агент асан хүний профайлинг хийх арга зүй, биеийн хэлний тайлал.
3.Brent E. Turvey – *Criminal Profiling: An Introduction to Behavioral Evidence Analysis*
Гэмт хэрэгтний сэтгэл зүйн шинжилгээ, профайлингийн мэргэжлийн гарын авлага.
4.David V. Canter – *Investigative Psychology: Offender Profiling and the Analysis of Criminal Action*
техник ажилтан биш харин сэтгэл зүйч, угсаатан судлаач, магадлан шинжээч, олон улс судлаач, хил судлаач, хэл шинжээч, профайлер зэрэг олон талт мэдлэг, чадвар бүхий “супер

Гэмт хэрэгтний зан үйлийг судлахад профайлингийн үүрэг.
5.El Al Airlines' Security Model – Израйлын El Al агаарын тээврийн компанийн профайлинг ашигласан хамгаалалтын жишээ (олон улсын туршлага).
6.Psychological Science Journal
Улсын хил, орон зайн өөрчлөлт сэтгэл зүйд хэрхэн нөлөөлдгийг судалсан судалгааны өгүүллүүд.
7.INTERPOL болон ICAO (International Civil Aviation Organization)
Хилийн шалгалт, зорчигчийн профайлингийн арга зүй, зааварчилгаа.
8.Монгол Улсын Хил хамгаалах байгууллагын сургалтын гарын авлага, дүрэм журам (дотоод хэрэглээний материал, зарим нь нууцлалтай байж болно)
9.Б.Лхагвасүрэн – “Улсын хил дээр бичсэн шүлэг”, В.В.Маяковский – “Зөвлөлтийн паспорт”
Хилээр нэвтрэх үед хүний сэтгэл зүйд төрөх мэдрэмжийн утга зохиолын дүрслэл.

РОЛЬ ИНЖЕНЕРНЫХ ЗАГРАЖДЕНИЙ В ОБЕСПЕЧЕНИИ БЕЗОПАСНОСТИ ГОСУДАРСТВЕННОЙ ГРАНИЦЫ

THE ROLE OF ENGINEERING OBSTRUCTIONS IN ENSURING THE SECURITY OF THE STATE BORDER

Ш.Ундарга
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Инженер техникийн тэнхимийн ахлах багш, ахмад

Аннотация
Инженерными заграждениями называются инженерные средства, сооружения и разрушения, создаваемые на местности с целью: затруднения продвижения и маневра нарушителей государственной границы; обеспечения пограничным нарядам, резервам пограничных подразделений и частей благоприятных условий для их блокирования и задержания /уничтожения/; ограничения воздействия животных и людей на сигнализационные и контролирующие средства. Инженерны заграждения играют важную и иногда решающую роль при поиске и задержании нарушителей государственной границы.

Ключевые слова: Инженерные заграждения; технические средства охраны границы; стена; государственная граница.
Key words: Engineering barriers; technical means of border protection; wall; state border.

Современные международные отношения требуют от персоналов, принимающих решения высокого и правильного понимания военно-политической обстановки в мире, а также предведения ее изменений и вожможных обострений на государственной границе. Все это обеспечиваются достоверными и своевременными сведениями о противнике, характере его действий, без которых невозможно принимать верное и обоснованное решение на охрану границы, а также эффективно применять силы и средства пограничных органов. В обеспечении безопасности государства в целом, и объектов инфраструктуры пограничных органов в частности важную роль играют технические средства охраны границы.

В настоящее время без применения современных технических средств не представляется возможным охрана большинства отдаленных участков государственной границы, осуществление пограничного контроля лиц и транспортных средств, следующих через

государственную границу, обработка информации и принятие управленческих решений.

Но некоторые страны мира для обеспечения государственной границы строят стена. Эта стена представляет собой инженерные сооружении, разделяющих страны и различных конструкций. Рассмотрим самые известные пограничные сооружения[1].

Проект “Стена”. В 2014 году Украина приняла решение о возведении инженерных сооружений на границе с Россией. Проект "Стена" предусматривает полное переоборудование госграницы, деньги в размере 100 млн грн на первый этап строительства. За семь лет проект по обустройству украинско-российской границы реализовали только на 51%./2021г/



Рис.1. Украинско-российская граница. Проект “Стена”

Марокканская стена. В 1987 году было завершено строительство Марокканской стены — системы оборонительных сооружений, созданных правительством Марокко на территории Западной Сахары и пустынном юго-востоке Марокко, разделяющей территории, контролируемые правительством Марокко и формированиями Полисарио. Общая протяжённость сооружений — более 2500 км.



Рис. 2. Марокканская стена

США – Мексика. Заграждение на границе США и Мексики стоимостью почти в два с половиной миллиарда долларов было построено в 2007-м году. Стена протяженностью в тысячу километров и высотой до шести метров предназначалась для остановки потока незаконных мигрантов и наркотиков из Мексики.

[1] Проект "Стена": ТОП-5 инженерных сооружений, разделяющих страны | Сегодня (segodnya.ua)



Рис. 3. Американо-мексиканская граница

Израиль – Палестина. Израильский разделительный барьер – пограничное сооружение Израиля, отделяющее Израиль от Западного берега реки Иордан (часть сооружения построена на территории, которую палестинцы считают своей). Строительство было начато в 2003 году, но работы еще не завершены.

Общая длина пограничного барьера составляет 703 километра. Состоит на 90 % из забора (с 60-метровой полосой отчуждения) и на 10 % из стены (высотой до 8 метров).

Основной целью строительства забора являлась защита территории государства Израиль от атак террористов, защита еврейских поселений, коммуникаций и дорог, находящихся вблизи границы, от нападений и снайперского обстрела со стороны палестинских террористов, а также отделение основной части арабского населения от столкновений с еврейским населением.



Рис. 4. Израильско – Палестинская граница

Таким образом некоторые страны мира используют инженерные заграждения для обеспечения государственную границу.

Инженерными заграждениями[1] называются инженерные средства, сооружения и разрушения, создаваемые на местности с целью: затруднения продвижения и маневра нарушителей государственной границы; обеспечения пограничным нарядам, резервам пограничных подразделений и частей благоприятных условий для их блокирования и задержания /уничтожения/; ограничения воздействия животных и людей на сигнализационные и контролирующие средства.

Инженерны заграждения играют важную и иногда решающую роль при поиске и задержании

[1]Инженерные заграждения | это... Что такое Инженерные заграждения? (academic.ru)

нарушителей государственной границы.

В Современных требованиях на оборудование государственной границы играет огромная роль технические средства охраны (ТСО). То есть применения на участках границы со сложной и напряженной обстановкой сигнализационно-заградительных комплексов на основе физических препятствий в виде ограждений и заграждений различной конструкции.

Актуальность их применения для контроля движения транспорта вне пунктов пропуска будет возрастать с увеличением потока нелегальных им-мигрантов, активизации поставок наркотиков. Уже сейчас на отдельных участках границы широко практикуется объезд пунктов пропуска по проселочным и полевым дорогам, угон скота, что увеличит потребность в устройстве заграждений: рвов, систем траншей, надолб.

В зимнее время возможность обхода и объезда пунктов пропуска вне дорог снижается из-за глубокого снежного покрова, но увеличивается из-за замерзания рек, болот и с применением все более доступных снегоходов. Не до конца решенной остается и задача обеспечения собственной безопасности в местах постоянной дислокации пограничных подразделений.

В широком смысле под ограждением понимается искусственное сооружение на местности, являющееся физическим препятствием и/или информационным каналом о факте прохода или характере потенциального нарушителя при его преодолении. Под характером имеется в виду наличие вооружения.

Примером информационного канала прохода могут служить обрывные датчики, не являющиеся препятствием, и магнитометрические датчики, расположенные в грунте.

Основными функциями ограждений являются:

обозначающая, обеспечивающая обозначение отчужденной территории или зоны исключения случайного прохода;

сигнализационная, обеспечивающая передачу информации о месте преодоления ограждения для своевременного противодействия нарушителю, оценивается различными характеристиками, в т. ч. и количеством ложных срабатываний;

заградительная, обеспечивающая временную задержку нарушителя вплоть до отказа от намерений преодоления, оказывая: физическое противодействие свободному проходу, психологическое воздействие на потенциального

нарушителя, отражающее воздействие; заградительная функция оценивается временем преодоления ограждения различными способами;

канализирующая, обеспечивающая выход нарушителя на рубеж повышенного сигнализационного контроля, оценивается вероятностью отказа нарушителя от преодоления ограждений;

задерживающая, обеспечивающая инкапаситирующее воздействие на нарушителя при контакте с ограждением и способствующая его задержанию, оценивается временем обездвижения нарушителя.

Конструкции физических препятствий, в зависимости от поставленных целей, степени важности направления и финансовых возможностей, могут иметь различный набор функций и воздействий на потенциального нарушителя: от простого обозначения рубежа до нелетального воздействия (электрошо-ковое ограждение).

ВЫВОДЫ

Международный опыт пограничной деятельности свидетельствует о наличии устойчивой тенденции к сокращению количества личного состава, непосредственно привлекаемого к несению пограничной службы, и возрастании роли вооружения и специальной техники в решении задач защиты и охраны государственной границы.

Технические средства охраны границы и средства обеспечения безопасности развиваются стремительными темпами.

Но нет такого универсального средства, которое способна решить весь комплекс задач. Любое средство обладает как достоинствами, так и недостатками.

Комплексное применение инженерных заграждений и технических средств охраны границы позволяет устранить недостатков технических средств охраны границы положительными качествами инженерных заграждений при решении задач.

БИБЛИОГРАФИЧЕСКИЙ СПИСОК ЛИТЕРАТУРЫ

1. Пограничный словарь (academic.ru)
2. https://ru.wikipedia.org/
3. https://ukraine.segodnya.ua/
4. https://yandex.ru/
5. https://www.google.com

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД УДИРДАХ АЖИЛТНЫ МАНЛАЙЛЛЫН НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

Ц.Одонгэрэл
ДХИС-ийн хилийн албаны сургуулийн ар тал, эдийн засгийн тэнхимийн профессор, доктор (Ph.D), хурандаа

Товч утга: Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн үйл явцад төрийн хүний нөөцийн удирдлагын чиглэлээр баримтлах төрийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөнүүдийг боловсруулан хүний нөөцийн мэдлэгийг дээшлүүлэх, ур чадварт сургах, хандлагыг төлөвшүүлэх хүрээнд олон ажлыг хэрэгжүүлж ирсэн[1] байна.

Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайллын асуудлыг авч үзэхээс өмнө төрийн албаны манлайллыг төрийн бодлогын баримт бичгүүдэд хэрхэн тодорхойлж, хэрэгжүүлж ирсэн байдлыг судлах нь зүйтэй хэмээн үзлээ.

Монгол Улсын хувьд 1999 оноос эхлэн төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, хандлага, түүн дотроо манлайллын асуудалд бодлогын түвшинд анхаарал хандуулж ирсэн[2].

№	Төрийн бодлогын баримт бичиг	Алсын хараа
1	Засгийн газрын 1999 оны 96 дугаар тогтоол	«Үйл ажиллагааны чадавх сайтай төрийн албан хаагчдыг бүрдүүлсэн байх, мэдлэг чадвартай төрийн албан хаагчидтай болсон байх, байгууллага бүр сурагцагч байгууллага болсон байх, манлайлал ба оролцооны өндөр түвшинг хангасан байх».
2	УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан «Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн баримт бичиг»	«Иргэдийн хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөж буй орчинд уян хатан зохицож чадаг бөгөөд идэвхтэй, санаачлагатай манлайлагч, менежер бүхий цомхон чадварлаг эцсийн дүнг эрхэмлэн дээдлэсэн төрийн албыг төлөвшүүлэх».

Хүснэгт 1. Төрийн албаны шинэтгэлийн бодлогын баримт бичигт манлайллын талаар тусгаж ирсэн байдал

"*Эх сурвалж:* Одонгэрэл, Ц. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал, хууль сахиулах удирдлагын чиглэлээр докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2024"

Дээр дурдсанаас үзэхэд төрийн албаны шинэтгэлийн гурав дахь үе шатанд төрийн албаны манлайллын асуудлыг тусгайлан авч үзсэн бөгөөд энэ нь Монгол Улсад төрийн албаны шинэчлэлийг ур дүнтэй хэрэгжүүлэх арга хэрэгсэл болсон гэж үзсэн. Ялангуяа төрийн захиргааны албан хаагчдын, төрийн удирдах албан тушаалтны

[1] Одонгэрэл, Ц. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал, хууль сахиулах удирдлагын чиглэлээр докторын зэрэг горилсон бүтээл. 142 дэх тал, Уб., 2024.

[2] Эрдэнэбат, П. МУ-ын Прокурорын байгууллагын удирдах албан тушаалтны манлайллын хэв маяг, чадварт хийсэн шинжилгээ, удирдахуйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл, Уб., 2015. 2 дахь тал.

гүйцэтгэлийн үнэлгээнд манлайллын үнэлгээг шалгуур болгосон байна[1].

Гэсэн хэдий ч манлайллыг дээшлүүлэх талаарх бодлого, стратегийн баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй, удирдах ажилтны манлайллын чадавх шаардлагын түвшинд хүрэхгүй байгааг нотолсон судалгааны үр дүн гарсан байна[2].

Удиртгал: Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайллын асуудлыг төрийн бодлого, эрх зүйн акт, байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөрт хэрхэн тусгаж ирсэн байдалд мөн дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого

«Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого»-ын 1.5 дахь хэсэгт «...аюулгүй байдлыг хангах ажиллагааг шинжлэх ухаан, техник, технологийн ололт, мэргэшсэн байгууллагын үйл ажиллагаанд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна...», 2.11 дэх хэсэгт «...улсын хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх...», 3.3 дахь хэсэгт «...хил хамгаалах албыг зохион байгуулж, удирдах байгууллага нь мэргэжлийн байх...» гэсэн нь ХХБ-ын удирдах ажилтны «Манлайлал»-ын бүтцээр санал болгон дэвшүүлж буй «Мэдлэг»-ийн агуулгыг илэрхийлсэн байна. Мөн тус баримт бичгийн 1.4 дэх хэсэгт «...Хилийн талаар баримтлах бодлого нь бусад улсын тусгаар тогтнолыг хүндэтгэх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдлэх, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийг хангах, улсын хил дээр хүч хэрэглэхээс аль болох зайлсхийх, аливаа асуудлыг энхийн аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх зарчимд тулгуурлана...», 2.6 дахь хэсэгт «..6) улсын хил дээр зэвсэгт халдлага, түрэмгийлэл үүсэхээс урьдчилан сэргийлж, хилийн асуудлаар үүссэн зөрчил, будилааныг энхийн аргаар шийдвэрлэхийг эрхэмлэх...», «...иргэдийн эх оронч

[1] Мөн тэнд.

[2] Өлзийбаяр, В. «Төрийн албаны манлайллын өөрчлөлт». Удирдахуйн ухаанаар докторын зэрэг горилсон бүтээл.

үзэл, улсын хил, хилийн дэглэм, журмыг хүндэтгэн сахих хүмүүжлийг төлөвшүүлэх...» гэсэн нь ХХБ-ын удирдах ажилтны «Манлайлал»-ын бүтцийг санал болгон дэвшүүлж буй «Хандлага»-ын агуулгыг илэрхийлсэн байна гэж үзэх боломжтой байна.

Төрөөс хилийн талаар баримтлах баримт бичигт улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах механизмыг боловсронгуй болгох талаар 2.1-д «Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвгэрийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох», 2.2-т «Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх байгууллагыг эх оронч, мэдлэг, чадвартай боловсон хүчнээр хангана» гэж төрийн бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тусгасан нь ХХБ-ын удирдах ажилтны «Манлайлал»-ын эрх зүйн үндэслэлийг тодорхойлсон байна.

Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах механизмыг боловсронгуй болгох бодлогын хүрээнд ХХЕГ-ын стратегийн зорилтуудын нэг болох «Хил хамгаалалтын арга, тактикийг хилийн нөхцөл байдал, бүсчилсэн хил хамгаалалтын онцлогт тохируулан өөрчилж, хилийн аюулгүй байдлыг хангах»-ын тулд төрийн зүгээс ХХБ-ыг бэхжүүлэх чиглэлээр дараах ажлыг хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байна. Үүний тулд эхлээд онолын үндэслэлийг[1] товч тайлбарлая.

Менежментийн шинжлэх ухаанд удирдахуйн үйл ажиллагааны далайц, хамарч буй цар хүрээ, өрнөж буй орон зай, цаг хугацааны хамаарал зэргийг харгалзан:

- Стратегийн түвшний удирдлага (дээд түвшний);
- Оперативын түвшний удирдлага (дунд түвшний);
- Тактикийн түвшний удирдлага (доод буюу анхан шатны) гэж ангилна.

Стратегийн түвшний менежмент гэж байгууллагыг урт хугацаанд амжилттай хөгжүүлэхийн тулд дээд түвшний удирдлагын алсын чиг баримжаатай хэрэгжүүлж буй менежментийг ойлгоно.

[1] Цэцэгмаа, О. Удирдахуйн ухааны лекцүүд. Уб., 2013. 15 дахь тал.

Стратегийн удирдлагыг байгууллагын хэмжээнд, үндэсний хэмжээнд хэрэгжүүлж болно.

Оперативын түвшний менежмент гэж байгууллагын томоохон хүч хэрэгслийг нэгдмэл удирдлагаар ханган завсрын зорилтуудыг биелүүлэх чиглэлээр дунд түвшний удирдлагын хэрэгжүүлж буй менежментийг ойлгоно.

Тактикийн түвшний менежмент гэж байгууллагын технологийн үйл ажиллагааг тогтсон арга зүй, стандартаар нэгжийн удирдагчийн санаачилгад тулгуурлан хэрэгжүүлж буй менежментийг ойлгоно.

Удирдахуйн үйл ажиллагааны хамрах хүрээ, орон зай, цаг хугацааны хамаарал, түүнчлэн шийдвэрлэж буй завсрын зорилтоос шалтгаалан стратеги-оперативын болон оператив-тактикийн түвшний удирдлагын үйл ажиллагаа гэж бас ангилж авч үздэг[1].

Дээрх ангиллыг харгалзан хил хамгаалах байгууллагын удирдах ажилтнуудыг (удирдах албан тушаалтнуудыг) стратегийн болон тактикийн түвшний гэж зааглаж болохоор байдаг. Харин оперативын удирдлагын түвшин тодорхой харагдахгүй байна гэж үзэх үндэстэй. Улсын орны хэмжээнд хил хамгаалах байгууллагыг нэгтгэн удирдаж буйн хувьд ХХЕГ-ын дарга, дэд дарга, албадын дарга нар стратегийн буюу дээд түвшний менежер мөн байдаг бол, хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд хилийн отрядыг захирч буй дарга, орлогч нар бол тактикийн түвшний буюу анхан шатны менежер юм.

Стратегийн түвшний болон тактикийн түвшний удирдлагын холбоос болсон оперативын түвшний удирдлагын бүтцийг чухамдаа «Бүсчилсэн хил хамгаалалтын тогтолцоо» бүрдүүлэх юм. Өндөр уулын, ой тайгын, тал хээрийн, говь цөлийн болон төвийн бүсийн хил хамгаалах байгууллагуудыг жинхэнэ утгаар нь үүсгэн бэхжүүлэх нь хилийн халдашгүй дархан байдлыг хангах чухал механизм болно хэмээн үзэж байна.

Хилийн тухай хууль

Монгол Улсын Хилийн тухай хуулийн «Монгол Улсын хилийн төлөөлөгч» гэсэн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэгт «...Хилийн асуудлаар байгуулсан

[1] Цэцэгмаа, О. Дурдсан бүтээл. 15 дахь тал.

Монгол Улсын олон улсын гэрээг улсын хилийн тодорхой хэсэгт хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шийдвэрлэх чиг үүрэг ...» -тэй байхаар болон 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт «...Хилийн төлөөлөгч нь хил залгаа улсын хилийн төлөөлөгчтэй Монгол Улсын олон улсын гэрээнд заасан арга хэлбэрээр хамтран ажиллана. Хилийн төлөөлөгч хэлэлцээ хийж, шийдвэрлэх шаардлагагүй гэж үзсэн асуудлыг хилийн төлөөлөгчийн орлогч, туслагчийн уулзалтаар шийдвэрлэнэ...», мөн 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсэгт «...Хилийн төлөөлөгчийн шийдвэрлэх боломжгүй асуудлыг дипломат шугамаар шийдвэрлэнэ...» гэж тус тус заасан нь Монгол Улсын хилийн төлөөлөгч нь ХХБ-ын удирдах ажилтны «Манлайлал»-ын бүтцэд санал болгон дэвшүүлж буй «Шийдвэр гаргалт»-ын агуулгыг шууд хуульчлан илэрхийлсэн гэж үзэх боломжтой байна.

Монгол Улсын Хилийн тухай хуулийн «Улсын хил хамгаалах байгууллагын даргын бүрэн эрх» гэсэн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг «Улсын хил хамгаалах байгууллагын дарга нь хилийн цэргийн командлагч байна», мөн зүйлийн 37.3.2 дахь хэсэгт «...улсын хил хамгаалах удирдамж, хил хамгаалалтын үйл ажиллагааны талаар тушаал гарган, хэрэгжилтэд нь хяналт тавьж, хилийн цэргийн анги, салбарыг нэгтгэн удирдах...» гэж ХХБ-ын шийдвэр гаргах бүрэн эрх бүхий удирдах албан тушаалтныг тодорхойлон хуульчилсан.

Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлагад ангийн захирагч, захирагчийн орлогчид цэргийн дээд боловсролтой, цэргийн ухааны магистр түүнээс дээш зэрэгтэй байх тусгай шаардлагыг тавьж байгаа нь хил хамгаалах алба, үйл ажиллагаа цэргийн удирдлагаар зохион байгуулдаг. Цэргийн бакалаврын мэргэжлийг Монгол Улсад ДХИС-ийн Хилийн албаны сургууль, ҮБХИС-ийн Цэргийн дээд сургууль, гадаадад орос, хятад, гуравдагч орны цэргийн мэргэжлийн сургууль олгож, хүний нөөцийг бүрдүүлж байна.

Сүүлийн жилүүдэд цэргийн мэргэжил эзэмших хүсэл сонирхолтой залуусын тоо огцом буурч байгаа нь хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого алдагдах, өрсөлдөөн

багассанаас чанаргүй удирдах албан тушаалтнууд томилогдох зэрэг эрсдэл тулгарч байна. Иймээс цэргийн мэргэжлийн бакалавр, магистр, докторын мэргэжил эзэмшүүлдэг үндсэн сургууль болох Хилийн албаны сургуульд сурах сонсогчдын тоог нэмэгдүүлэх, багшийг чадавхжуулах, сургалт, дадлага зохион байгуулах нөөц хөрөнгө, материаллаг байдлыг сайжруулах зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Док. Ч.Сайнтөрийн «Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжүүлэх арга зам» сэдэвт бүтээлд хил хамгаалах байгууллагын хүний нөөцийг сонгох, бүрдүүлэх, сургах, бэлтгэх чиглэлээр олон талт арга хэмжээг хэрэгжүүлсээр байгаа хэдий ч практик үйл ажиллагаанд хүний нөөцийг хөгжүүлэх, бүрдүүлэх, сургах, бусад шат дараалсан үйл ажиллагаанд шийдлээ хүлээж буй асуудлууд байгааг тодорхойлон[1] хүний нөөцийг бүрдүүлэхэд удирдах ажилтны сургалт, бэлтгэл, албан тушаалын өсөлт, нэг суралцагчийн академид 2 жил суралцах зардлын тооцоог судалсан байна. Үүнд: Хил хамгаалах байгууллага удирдах бүрэлдэхүүний академийн сургалтыг дотооддоо ДХИС-ийн Удирдлагын академи, ҮБХИС-ийн Батлан хамгаалах удирдлагын академи, гадаадад ОХУ-ын «Жанжин штабын академи», «Фрунзын нэрэмжит цэргийн академи», «Хилийн албаны аюулгүй байдлын академи» болон БНХАУ, БНСУ, БНЭУ[2]-ын цэргийн академиудад сургаж бэлтгэн, нэг суралцагчийн зардалд улсын төсвөөс 31.1 сая төгрөгийн, 2012-2018 онд хил хамгаалах байгууллагын захиалгаар суралцсан нийт суралцагчдын зардалд 2 тэрбум[3] гаруй төгрөгийн зардал гарсан байна.

ДХИС-ийн Хилийн албаны сургуульд хэрэгжүүлдэг «Хил судлал» магистрын сургалтын хөтөлбөрийн БМИҮЗ-д хүргүүлсэн тайланд магистрын хөтөлбөрийн харьцуулалтыг дотоод, гадаадын сургалтын хөтөлбөртэй харьцуулсан


[1] Сайнтөр, Ч. Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжүүлэх арга зам. Хил судалын докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2020. 55 дахь тал.

[2] Мөн тэнд. 77 дахь тал.

[3] Сайнтөр, Ч. Дурдсан бүтээл. 81 дэх тал.

шинжилгээг дараах зургаар харуулж байна. Үүнд:

Гадаадын ижил төстэй хөтөлбөртэй харьцуулсан судалгаа



Зураг 1. “Хил судлал” магистрын хөтөлбөрийн ОХУ-ын академийн сургалтын хөтөлбөртэй харьцуулсан судалгаа

Эх сурвалж: Одонгэрэл, Ц. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал, диссертаци. Уб., 2024

«Хил судлал» магистрын сургалтын хөтөлбөрийг ОХУ-ын Батлан хамгаалах яамны «Жанжин штабын академи»-ийн 2 жил, ОХУ-ын Фрунзын академийн «Цэргийн анги, нэгтгэлийн удирдлагын магистр»-ын 2 жилийн сургалтын хөтөлбөрүүдийн судлах багц цаг цаашлаад ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдийн харьцааг судалж үзэхэд «Хил судлал» магистрын сургалтын хөтөлбөр нь цэргийн зохион байгуулалт, хил хамгаалалтын ижил хэлбэрийн сургалт, арга зүй, тактиктай дэлхийн жишиг бүхий бусад улс, орны хөтөлбөртэй эн зэрэгцэхүйц хэмжээнд хийгдсэн гэж үзэж болохоор байна.

«Хил судлал» магистрын сургалтын хөтөлбөрийн багц цагийн агуулгыг ижил түвшний сургалтын үйл ажиллагаа

явуулдаг сургалтын хөтөлбөрийн агуулгатай харьцуулсан байдлыг дараах зурагт үзүүлэв. Үүнд:



Зураг 2 . “Хил судлал” магистрын хөтөлбөрийг МУ, ОХУ-ын академийн сургалтын хөтөлбөртэй харьцуулсан судалгаа

Эх сурвалж: Одонгэрэл, Ц. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал, диссертаци. Уб., 2024

«Хил судлал» магистрын сургалтын хөтөлбөрийг ОХУ-ын БХЯ-ны «Жанжин штабын академи»-ийн 2 жил, ОХУ-ын Фрунзын академийн «Цэргийн анги, нэгтгэлийн удирдлагын магистр»-ын 2 жилийн сургалтын хөтөлбөр, ҮБХИС-ийн БХУА-ийн «Стратеги тактик, команд штаб», Удирдлагын академийн «Хил хамгаалалтын стратеги тактик-удирдлага» сургалтын хөтөлбөрийн үндсэн хөтөлбөрүүдтэй харьцуулахад

«Хил судлал» сургалтын хөтөлбөрийн нийт эзэлбэл зохих багцын хэмжээ бусад хөтөлбөрийн жишигт нийцэж байна

Дотоодын ижил төстэй хөтөлбөртэй харьцуулсан байдал

«Хил судлал» магистрын сургалтын хөтөлбөрийг ДХИС-ийн Удирдлагын академи, Ахисан шатны сургууль, ҮБХИС-ийн БХУА-д хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөртэй харьцуулан дараах зургаар харууллаа. Үүнд:




Зураг 3. “Хил судлал” магистрын хөтөлбөрийг бусад сургалтын хөтөлбөртэй харьцуулсан судалгаа

Эх сурвалж: Одонгэрэл, Ц. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал, диссертаци. Уб., 2024

«Хил судлал» магистрын сургалтын хөтөлбөр нь ҮБХИС-ийн «Стратеги тактик, команд штаб», «Гамшиг судлал» магистрын хөтөлбөртэй 34 багц цагийн багтаамжаар «ижил», Удирдлагын академийн «Стратеги-тактикийн удирдлага» магистрын сургалтын хөтөлбөрөөс 4 багц цагийн дутуу

төлөвлөгдсөн боловч Команд штабын сургалтыг 2 багц цагаар илүү байгаа нь танхимын бус сургалтыг илүү явуулдаг нь харагдаж байна.



Зураг 4. “Хил судлал” магистрын хөтөлбөрийн багц цагийн харьцуулсан судалгаа
Эх сурвалж: Одонгэрэл, Ц. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал, диссертаци. Уб., 2024

ДҮГНЭЛТ

«Хил судлал» магистрын хөтөлбөрийг цэргийн ахисан түвшний мэргэжил олгодог хөтөлбөрийн багц цагийн агуулгаар харьцуулан үзэхэд мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүд нь бага буй боловч суралцагчдад удирдах ур чадвар олгох, эрдэм шинжилгээ судалгааны ажилд сургах тал дээр илүү анхаарч байгаа нь сайшаалтай байна.

ХХБ-ын тодорхой нэгжийн удирдах албан тушаалтны ажлын үр дүнг тус байгууллагын дотоод харилцааг зохицуулж буй хуульчилсан актуудын хэм хэмжээгээр үнэлэн тодорхойлж байгаа нь ололттой тал хэдий ч удирдах ажилтанд өгч буй хамт олны үнэлгээг орхигдуулсан нь «Манлайлал»-ын асуудалд зайлшгүй авч үзэх шаардлагатай байна.

ХХБ-ын хэмжээнд удирдах ажилтны манлайллын чиглэлээр

тусгайлан гаргасан дүрэм, заавар, тушаал зэрэг бие даасан эрх зүйн хэм хэмжээ бүхий хуульчилсан акт байхгүй ч ХХБ-ын удирдах ажилтны «Манлайлал»-ын бүтцээр санал болгон дэвшүүлж буй загвар буюу албан тушаалтны мэдлэг чадвар, туршлага, хандлагад болон үнэлгээнд тавигдах зарим хэм хэмжээг тодорхойлсон, иш татсан заалтууд бүхий дараах дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой байгаа юм. Үүнд:

1. Хил хамгаалах байгууллагын алба хаагчийн ёс зүйн дүрэм;
2. Хил хамгаалах байгууллагын ажил дүгнэх журам тус тус болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Хилийн тухай хууль, 2016 он

УИХ, Засгийн Газрын Тогтоол, бодлогын баримт бичиг:

3. Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2002 он МУЗГ-ийн “Алсын хараа-2050” хөтөлбөр, 2020 он
4. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын тухай хууль, 2010 он
5. Хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны эрх зүйн орчин” сэдэвт судалгааны төсөлт ажил. Уб., 2018.

Диссертаци:

6. Одонгэрэл, Ц. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал. Хууль сахиулах удирдлагын докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2025.
7. Сайнтөр, Ч. Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжүүлэх арга зам, хил судлалын докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2020. 27 дахь тал.
8. Эрдэнэбат, П. Монгол Улсын Прокурорын байгууллагын удирдах албан тушаалтны манлайллын хэв маяг, чадварт хийсэн шинжилгээ. Удирдахуйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2015.

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧ НЭГ БҮРИЙН ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

С.Нямжав
Тактикийн тэнхимийн эрхлэгч, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Хил хамгаалах байгууллагын алба хаагчид хуулиар хүлээсэн чиг үүргийг биелүүлэхдээ холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлийн дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрхийг дотоодын хууль тогтоомжоор олгосон байна. Энэхүү хууль тогтоомжид тусгагдсан нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээг өөр хооронд болон нь төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий зарим байгууллагын холбогдох эрх зүйн актад тусгасан хэм хэмжээтэй харьцуулан зүйн эрх зүйн зохицуулалтад байгаа онол, практикийн зөрчилтэй тулгамдаж буй асуудлыг олж, тодорхойлохыг зорьж, түүнийг шийдвэрлэх саналыг боловсруулсан.

Түлхүүр үг: хилчин, тусгай хэрэгсэл, нэг бүрийн тусгай хэрэгсэл, хууль, хуульчилсан акт, эрх зүйн зохицуулалт

Үндсэн хэсэг. Монгол Улсад нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрх бүхий нийт 15 субъект байна. Үүнийг нэг нь хил хамгаалах байгууллагын алба хаагч юм. Монгол Улсын хилийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “ Монгол Улсын хил хамгаалах үйл ажиллагаанд нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, газар, уснаа явагч зэрэг тусгай хэрэгслээр тоноглогдсон тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгсэл албадан зогсоогч, эвдэгч, галт хэрэглэл, албаны нохой болон бусад тусгай хэрэгсэл ашиглаж болно”[1] гэж хил хамгаалах байгууллагын алба хаагчид нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрхийг хуулиар олгож, мөн үүргийн хэм хэмжээг уг хуулиар зааж өгсний зэрэгцээ, “Хил хамгаалах байгууллагын алба хаагч тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх”[2] заавар, “Хил хамгаалах байгууллагын галт зэвсэгтэй

[1] Монгол Улсын хилийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2017 он. №6.

[2] Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаал

адилтгах үхэлд үл хүргэх зэвсэг, тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт”[1]-ийн заавар зэрэг хадгалах, ашиглах, хэрэглэх арга зүй, тактикийн шинжтэй хэм хэмжээг тус тус хуульчилсан актаар зохицуулж, өгсөн байна.

Энэхүү илтгэлээр Хил хамгаалах байгууллагын алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан хууль, хуульчилсан актыг өөр хооронд нь болон төрийн тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын холбогдох хуульчилсан актын зарим заалтын хэм хэмжээтэй харьцуулалт хийв.

Судалгаагаар хил хамгаалах байгууллагын алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтад онол, практикийн хувьд зөрчилтэй дараах асуудлууд байна гэж үзлээ. Үүнд:

Нэг. Хууль, хуульчилсан актад нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрхэн төрөлжүүлсэн талаар

1. Хил хамгаалах байгууллагын алба хаагч үүргээ гүйцэтгэхдээ ашиглах нэг бүрийн тусгай хэрэгслийг холбогдох хууль, хуульчилсан актад дараах байдлаар төрөлжүүлжээ. (Хүснэгт №1)

№	Монгол Улсын хилийн тухай хууль	Заавар
1.	42.1 дэх хэсэгт Нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна: 1) Гав; 2) Хүлэг, ороох цамц, хөдөлгөөн хязгаарлах бусад хэрэгсэл; 3) Бороохой; 4) Цахилгаан гүйдлээр цохигч; 5) Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;	3.9.2-т “**Цахилгаан гүйдлээр цохигч бууг** хүний биед 4-5 метрийн зайд хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар байрлалыг сольж, амьтанд 5 секундээс илүүгүй хугацаагаар хэрэглэнэ”, 3.10.1-т “Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүрийг барилга, байгууламж дотор тухайн бодисын үйлчлэлд өөрөө өртөхгүй байрлалд, гадна орчинд салхины дагуу чиглэлд цацах, **гранат** хэлбэрээр шидэх,

[1] Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/09 дүгээр тушаал

	6) Резин ба хуванцар сумтай буу; 7) Нэг бүрийн бусад тусгай хэрэгсэл.	буудлагын хэрэгслээр буудах зэргээр хэрэглэнэ” гэж заасан.

Хүснэгт 1. Холбогдох хууль, хуульчилсан актад төрөлжүүлсэн байдал

Энэхүү хууль, хуульчилсан актад төрөлжүүлсэн байдалд харьцуулалт хийхэд:

- Монгол Улсын хилийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.5 дахь заалтад “нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;”[1] гэж заасан нь гар бөмбөг буюу гранат хэрэглэхгүй зөвхөн буу, шүршүүр хэрэглэхээр тусгасан. Гэтэл “Хил хамгаалах байгууллагын алба хаагч тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”[2]-ын 3.10.1 дэх хэсэгт “Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүрийг ... цацах, гранат хэлбэрээр шидэх, буудлагын хэрэгслээр буудах зэргээр хэрэглэнэ.” хэрэглэнэ гэж заасан нь гар бөмбөгийг нэг бүрийн тусгай хэрэгсэлд хамааруулж, ойлгохоор тусгасан байна. Энэ нь хууль эрх зүйн актад харилцан адилгүй алба хаагчийн хэрэглэх амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагчаар цэнэглэсэн гар бөмбөгийг ямар төрлийн хэрэгсэлд оруулан тооцох нь тодорхой бус тусгасан гэж үзэж байна.

- Монгол Улсын хилийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1. дэх хэсэгт нийт 7 төрлийн хэрэгслийг хэрэглэхээ заасан бөгөөд эдгээр хэрэгсэлд цахилгаан гүйдлээр цохигч гэсэн хэрэгсэл хэрэглэхээр тусгаагүй. Харин “Хил хамгаалах байгууллагын алба хаагч тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх”[3] зааврын 3.9.2 дахь хэсэгт “**Цахилгаан гүйдлээр цохигч буу** хүний биед 4-5 метрийн зайд хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар байрлалыг сольж, амьтанд 5 секундээс илүүгүй хугацаагаар хэрэглэнэ” гэж заасан нь дахин зааврааар цахилгаан гүйдлээр цохигч буу гэсэн нэг бүрийн тусгай хэрэгслийг нэмэлтээр оруулж ирсэн. Энэ нь хуульд тусгагдаагүй хэрэгслийг зааврааар зохицуулж,

[1] Монгол Улсын хилийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2017 он. №6.

[2] Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаал

[3] Мөн тэнд

хэрэглэхээр заасан. Эдгээр хууль болон заавар, журамд тусгагдсан байдлаас харахад хэдэн төрөл, ангилалд авч үзэж, ямар хэрэгсэлд хамаарах нь тодорхой бус ойлгомжгүй байгааг харуулж байна.

Хоёр. Хэрэглэх тохиолдлыг хууль, хуульчилсан актад хэрхэн зохицуулсан талаар

Хил хамгаалах байгууллагын алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан хууль, хуульчилсан актад тусгагдсан хэрэглэх тохиолдолд харьцуулалтыг хийлээ. (Хүснэгт №2)

№	Монгол Улсын хилийн тухай хууль	Заавар
1.	43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хилчин нэг бүрийн тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ: 1) Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болох аюулыг таслан зогсоох; 2) Хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг таслан зогсоох, зөрчил гаргасан этгээдийг саатуулах, баривчлах; 3) Зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй хүнийг баривчлах; 4) Баривчлагдсан, саатуулагдсан хүнийг хуяглан хүргэх; 5) Хяналтад байгаа хүн амиа хорлох, өөрийн бие махбодод гэмтэл учруулах, оргон зайлахаас урьдчилан сэргийлэх зорилгоор; 6) Сэтгэцийн эмгэг, сэтгэл санаа хүчтэй цочрон давчидсаны улмаас өөрийгөө удирдах чадваргүй, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, эсхүл догшин, хэрцгий авирлаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаар бол; 7) Тээврийн хэрэгслийг зогсоох эрх бүхий албан тушаалтны шаардлагыг үл биелүүлэн зугтаасан;	Зааврын 3.7-д “Хуульд заасан үндэслэлээр бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалахын тулд, эсхүл сэжигтэй этгээдийг аюул учруулахгүйгээр хяналтад авахад биеийн хүч хэрэглэх боломжгүй тохиолдолд резинэн бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр, резинэн ба хуванцар сумтай бууг сонгон хэрэглэж болно” гэж заасан.

	8) Энэ хуульд галт зэвсэг хэрэглэхээр заасан тохиолдолд” гэж заасан. 43 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг хилчин тухайн нөхцөл байдалд тохируулан бие даан гаргана” гэж заасан.	
2.	43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хилчин доор дурдсанаас бусад тохиолдолд хүүхэд, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, бэртэл гэмтэлтэй болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүнд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно: 1) Хилчин болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар зэвсэглэн, эсхүл бүлэглэн довтолсон; 2) Галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох зүйлээр зэвсэглэсэн хүн зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлсэн, эсэргүүцсэн; 3) Амиа хорлож болзошгүй бол” гэж заасан.	Зааврын 3.8.3-т “Хилийн болон хил орчмын дэглэмийг бүлэглэн зөрчиж байгаа, эсхүл хилийн боомтод үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хүч хэрэглэсэн жагсаал, цуглааныг албадан тараах, довтолсноос бусад тохиолдолд хүний толгой, давсаг, бүсэлхий, бөөр, нэг газарт олон удаа цохих, гэмтэл, шарх үүсгэхийг **хориглоно**” гэж заасан. 3.11.2-т “Резинэн ба хуванцар сумтай бууг хүний биеийн цээж, нуруу, гар, хөл, гуяны хэсэгт хэрэглэх бөгөөд нүүр, толгой /ил харагдах хэсэг/-н хэсэгт хэрэглэхийг **хориглоно”** гэж заасан.

Хүснэгт 2. Холбогдох хууль, хуульчилсан актад тусгасан хэрэглэх тохиолдол

Энэхүү хууль, хуульчилсан актад хэрэглэх тохиолдолд хийсэн харьцуулалтаас үзвэл:

- Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын хилийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт нийт 8 тохиолдолд хэрэглэхээр, “Хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар”-аар 3 тохиолдолд хэрэглэхээр тус тус эрхийг алба хаагчид олгосон боловч, мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт “Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг хилчин тухайн нөхцөл байдалд тохируулан бие даан гаргахаар” тухайн хуульд тусгаж өгсөн нь

ямар тохиолдолд аль хэрэгслийг нь хэрэглэх талаар тодорхой бус байгаа бөгөөд гэж ерөнхий заалтыг тусгасан;

- Хил хамгаалах байгууллагын алба хаагч тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх зааврын 3.7 дахь хэсэг, 3.8.3 дахь хэсэг, 3.11.2 дахь хэсэгт тус тус заасан хэм хэмжээ нь нэмэлтээр хэрэглэх болон хориглох тохиолдлыг дахин хуулиас гадна хуульчилсан актад тус тус тусгаж, зохицуулсан;

Монгол Улсын хилийн тухай хуульд 8, "Хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар"-т 3, нийт 11 тохиолдолд хэрэглэх, мөн хуулийн 1 заалтад, зааврын 2 заалтад тус тус хориглосон хэм хэмжээг тусгаж, эрх зүйн харилцааг зохицуулжээ.

Ийнхүү зааврааар 1 заалтад 3 тохиолдолд хэрэглэхээр, мөн 2 заалтад тус бүр 1 хориглох тохиолдлыг тусгаж, хуулиас гадна хуульчилсан актаар хэм хэмжээг тогтоож, зохицуулсан байдал нь "Хууль цаазын дээд хүчин чадал нь дараах шинжээр тодорхойлогдоно: ... б) эрх зүйн бусад актууд нь зөвхөн хуульд захирагдаж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ"[1], "яам засгийн газрын гишүүд, агентлаг, тусгай газрын дарга нар нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэрт нийцсэн, эрх зүйн хэм хэмжээг агуулсан актуудыг батлан гаргана"[2] гэж тус тус эрдэмтэн, судлаачид онолын хувьд үздэг. Гэтэл харьцуулалтаас үзвэл заавар нь Монгол Улсын хилийн тухай хууль заасан хэм хэмжээнд нийцэж, захирагдахгүй дахин нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх хэм хэмжээг тусгасан нь хууль цаазын дээд хүчин чадал, шатлан захирах шинж алдагдсан гэж үзэж байна.

Гурав. Нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх арга, үүрэг, шаардлагыг хуульчилсан актад хэрхэн тусгасан талаар

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий 4 агентлаг, байгууллагуудын заавар, журмуудын нэршил болон нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрхэн хэрэглэх талаарх холбогдох заалтуудад харьцуулалтыг хийлээ. (Хүснэгт №3)

№	Хил хамгаалах байгууллага	Дотоодын цэрэг	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	Цагдаа

[1] Ч.Нямсүрэн,Ч. Эрх зүйн ерөнхий онол. УБ., 2017. 183 дахь тал

[2] Мөн тэнд., 2017. 175 дахь тал

Хуульчилсан актын нэр				
1.	“Хил хамгаалах байгууллагын алба хаагч тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх”[1] **заавар**	“Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техникийг хэрэглэх”[2] **заавар**	“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх”[3] **журам**	“Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх”[4] **заавар**
Нэг. Бороохой хэрэглэх талаар				
1.	-Бороохойг хувцастай болон нүцгэн биед чиглүүлж ороолгох маягаар цохих, хатгах, бамбай, бусад эд зүйлд цохиж, дуу чимээ гаргах, зэвсгийн чанартай эд зүйлээр довтолсон тохиолдолд хамгаалах зорилгоор өгзөгний маханд буюу дал хавсарч хэрэглэх	-Бороохойг хувцастай болон нүцгэн биед чиглүүлж ороолгох маягаар цохих, хатгах болон бамбай, бусад эд зүйлд цохиж, дуу чимээ гаргах, зэвсгийн чанартай эд зүйлээр довтолсон тохиолдолд хамгаалах зэргээр хэрэглэх	-Хүний биеийн яс булчин дагуу ороолгох, цохих, хатгах байдлаар үйлдлийг таслан зогсоох	-Бороохойг хүний хувцастай болон нүцгэн биеийн яс, булчин дагуу чиглүүлж ороолгох, цохих, хатгах бамбай, бусад эд зүйлд цохиж, дуу чимээ гаргах, зэвсгийн чанартай эд зүйлээр довтолсон тохиолдолд хамгаалах

[1] Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан 2017 оны 06-аар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаал

[2] Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 04-ээр сарын 03-ны өдрийн А/57 дугаар тушаал

[3] Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/260, А/112 дугаар тушаал

[4] Хууль зүй, дотоод хэргийн сйн сайдын 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаал

[4] Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/57 дугаар тушаал

[4] Хууль зүй, дотоод хэргийн сайдайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/224, А/102 дугаар тушаал

				зэргээр хэрэглэх;
2.	-Хилийн болон хил орчмын дэглэмийг бүлэглэн зөрчиж байгаа, эсхүл хилийн боомтод үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хүч хэрэглэсэн жагсаал, цуглааныг албадан тараах, довтолсноос бусад тохиолдолд хүний толгой, давсаг, бүсэлхий, бөөр, нэг газарт олон удаа цохих, гэмтэл, шарх үүсгэхийг хориглоно	-Бороохойгоор нэг газарт олон удаа цохихгүй, аль болох гэмтэл учруулахгүй байхыг эрмэлзэх	-Нэг газарт олон удаа цохихгүй байх, аль болох гэмтэл учруулахгүй байхыг эрмэлзэх	-Бороохойгоор нэг газарт олон удаа цохихгүй байх, аль болох гэмтэл учруулахгүй байхыг эрмэлзэх
Хоёр. Цахилгаан гүйдлээр цохигч, цахилгаан гүйдлээр цохигч буу хэрэглэх талаар				
3.	-Цахилгаан гүйдлээр цохигчийг хүний биед хувцасны гадна талаас хүргэн, **долгион нэг газар 5** секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар байрлалыг сольж, амьтанд 10 секундээс илүүгүй хугацаагаар хэрэглэнэ	-Цахилгаан гүйдлээр цохигчийг хэрэглэх зорилгыг хууль заасан үндэслэлээр тодорхойлж, хүний биед хувцасны гадна талаас хүргэн **долгион нэг газар 5 секундээс** илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар	-Хувцасны гадна талаас хүргэн цахилгаан **хүчдэлийг нэг байрлалд 10 секундээс** илүүгүй хугацаагаар үйлчлэхээр хүргэж үйлдлийг таслан зогсоох;	-Цагдаагийн алба хаагч цахилгаан гүйдлээр цохигч хэрэглэх зорилгоо тодорхойлж, хүний биед хувцасны гадна талаас цахилгаан **үелзлийг нэг газарт 5 секундээс** илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар хүргэн,

		байрлалыг сольж хэрэглэх бөгөөд энэ хугацаа нь араатан амьтанд 10 секундээс илүүгүй байхаар тооцох		байрлалыг сольж хэрэглэх ба энэ хугацаа нь араатан амьтанд 10 секундээс илүүгүй байхаар тооцох
4.	-Цахилгаан гүйдлээр цохигч бууг хүний биед 4-5 метрийн зайд хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар байрлалыг сольж, амьтанд 5 секундээс илүүгүй хугацаагаар хэрэглэнэ.	3.9.5.цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэх зорилгыг хууль заасан үндэслэлээр тодорхойлж, 4-5 метрийн зайд байгаа биологийн объект /хүн, амьтан/-д чиглүүлэн хэрэглэх бөгөөд хүнд нэг газар 3 секундээс илүүгүй, араатан амьтанд 5 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар тооцож, байрлалыг солих	Байхгүй	-Цагдаагийн алба хаагч цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэх зорилгоо тодорхойлж, цахилгаан гүйдлээр цохигч бууг 4-5 метрийн зайд байгаа хүний биед хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар чиглүүлэн, байрлалыг сольж хэрэглэх ба энэ хугацаа нь араатан амьтанд 5 секундээс илүүгүй байхаар тооцох
Гурав. Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр хэрэглэх талаар				
5.	-Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүрийг барилга,	-Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч ... буу, шүршүүрийг дараах	-Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг салхины чиглэл дагуу 1-1,5 метрээс	-Цагдаагийн алба хаагч нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг хэрэглэх

	байгууламж дотор тухайн бодисын үйлчлэлд өөрөө өртөхгүй байрлалд, гадна орчинд салхины дагуу чиглэлд цацах, гранат хэлбэрээр шидэх, буудлагын хэрэгслээр буудах	байдлаар хэрэглэнэ: 3.10.1.хуульд заасан үндэслэлээр хэрэглэх зорилгыг тодорхойлж, барилга, байгууламж дотор тухайн бодисын үйлчлэлд өөрөө өртөхгүй байрлалыг сонгох бөгөөд гадна орчинд салхины дагуу чиглэлд цацах, гранат хэлбэрээр шидэх, буудлагын хэрэгслээр буудах	дээш зайд цацах, шүрших, буудах	зорилгоо тодорхойлж барилга, байгууламж дотор тухайн бодисын уйлчлэлд өөрөө өртөхгүй байрлалыг сонгох ба гадна орчинд салхины чиглэл дагуу цацах, гранат хэлбэрээр шидэх, буудлагын хэрэгслээр буудах
6.	-Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүрийг 1-1.5 метрийн зайд хэрэглэж...	-Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг 1-1.5 метрийн зайд хэрэглэж...		Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг 1-1.5 метрийн зайд хэрэглэж...
Дөрөв. Резинэн, хуванцар сумтай буу хэрэглэх				
7.	-Резинэн ба хуванцар сумтай бууг хүний биеийн цээж, нуруу, гар, хөл, гуяны хэсэгт хэрэглэх бөгөөд нүүр, толгой /ил харагдах хэсэг/-н хэсэгт хэрэглэхийг хориглоно.	-Резинэн, хуванцар сумтай буу хэрэглэхэд дараахь зүйлийг анхаарна: 3.11.1.хуульд заасан үндэслэлээр резинэн, хуванцар	-Резин болон хуванцар сумтай бууг хэрэглэхдээ үйлдвэрлэгчийн зааврыг баримтлах ... ;	-Цагдаагийн алба хаагч резинэн, хуванцар сумтай бууг ...хэрэглэхдээ үйлдвэрлэгчийн зааврыг баримтлах

		сумтай ... бууг хэрэглэх үйлдвэрлэгчийн зааврыг баримтлах		
Зургаа. Бусад тусгай хэрэгсэл хэрэглэх				
8.	-Улсын хил хамгаалалтад орчин үеийн тусгай хэрэгслийг шинээр ашиглах тохиолдолд энэхүү зааварт нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэглэнэ.	Байхгүй	Байхгүй	Байхгүй

Хүснэгт 3. Агентлаг, байгууллагуудын алба хаагч заавар, журмуудын нэршил болон нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрхэн хэрэглэх талаарх холбогдох заалтын харьцуулалт

Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрхийг нийт 15 субъектэд тус тусын хууль тогтоомжоор олгосон байдаг. Холбогдох хуульд хэрэглэх эрх, үүрэг, хориглох тохиолдлыг тусгаж, хэрэглэх арга, анхаарах зүйл буюу техник, технологи, арга зүй, тактикийн шинжтэй хэм хэмжээг журамласан эрх зүйн актаар зохицуулжээ. Холбогдох эрх зүйн актыг 14 агентлаг, байгууллага нь заавар, 1 байгууллага нь журам гэж нэрлэжээ.

Дээрх харьцуулалтад цагдаа, дотоодын цэрэг, хил хамгаалах байгууллага заавар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага журам гэж харилцан адилгүй эрх зүйн актыг нэрлэсэн байна. Мөн "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"[1]-ын 3.7.1.1-т "тэргүү буюу гарчиг нь агуулгаа бүрэн илэрхийлж чадахуйц тодорхой байна" гэж заасан бөгөөд "Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техникийг хэрэглэх" тухай хуульчилсан акт нь дүрэм, журам, заавар боловсруулахад тавигдах нийтлэг шаардлагыг хангахгүй, тэргүү буюу гарчиг нь дотоод агуулгаа бүрэн илэрхийлж чадахгүй байна. Харин "Хил хамгаалах байгууллагын алба

[1] Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246 дугаар тогтоол

хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх” зааврын тэргүү буюу гарчиг нь дотоод агуулгаа бүрэн гүйцэд ханган илэрхийлж, чадаж байна гэж үзлээ.

Цагдаа болон хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч бороохойг хэрэглэх талаар заавар, журамдаа тусгагдсан дээрх хэм хэмжээнээс дотоодын цэргийн алба хаагчийн бороохой хэрэглэх талаар зааварт нь тусгасан хэм хэмжээ нь бодит нөхцөл байдал тохирсон, эрх зүйн баталгааг нь хангаж чадахуйц заалт болжээ. Харин хил хамгаалах байгууллагын алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулсан хуульчилсан актад бороохойгоор хувцастай болон нүцгэн биед чиглүүлж ороолгох маягаар цохих, хатгах, бамбай, бусад эд зүйлд цохиж, дуу чимээ гаргах, зэвсгийн чанартай эд зүйлээр довтолсон тохиолдолд хамгаалах зорилгоор өгзөгний маханд буюу дал хавсарч хэрэглэнэ гэж заасан нь тухайн хэрэгслийг хэрэглэх боломжгүй нөхцөл байдлыг оруулж, хэрэглэх зорилгыг хязгаарласан хэм хэмжээг тусгаж өгсөн гэж үзэж байгаа. Зааварт зааснаар хэрэглэж, хэрэглэх зорилгодоо хүрэхгүйгээс үүсэх үр дагавар нь алба хаагчид эрсдэл үүсэх нөхцөл байдалд хүргэнэ гэж үзэж байна.

Мөн заавар, журмуудад цахилгаан гүйдлээр цохигчийн үелзэл, долгион, хүчдэл гэж янз бүрээр нэрлэжээ. Тухайн ойлголтыг Я.Цэвэлийн зохиосон “Монгол хэлний тайлбар толь” бүтээлд “хүчдэл вольтоор илэрхийлэгдэх цахилгаан тогийн хүчний хэмжээ”[1], “долгион физикийн орчин дотор үүсэх савлах хөдөлгөөн”[2] гэж тус тус тайлбарласан байх бөгөөд тухайн толь бичигт үелзэл гэх ойлголт байхгүй тул тайлбарлаагүй. Цагдаа, дотоодын цэрэг, хил хамгаалах байгууллагын зааварт ... цахилгаан гүйдлээр цохигчийг хүний биед хүчдэлийг (долгион, үелзэл) нэг газарт 5 секундээс, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын журамд 10 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар тооцож, харилцан адилгүй хугацааг заасан байна. Доктор Н.Ганбадрал цахилгаан гүйдлээр цохигчийн үйлчлэлийн талаар бүтээлдээ “хувь хүний биеийн эсэргүүцэл, ирж буй хүчдэл зэргээс болоод

[1] Цэвэл, Я. Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 1966. 752 дахь тал

[2] Мөн тэнд 197 дахь тал

үйл ажиллагааны эцсийн үр дүн ч өөр өөр байна”[1] гэж дурджээ.

Цагдаа, дотоодын цэрэг, хил хамгаалах байгууллага тус тусын заавар, журамд цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэхээр тусгаж, зохицуулалтыг хийсэн бөгөөд харин шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэхээр тусгаагүй байна.

Хил хамгаалах байгууллагын алба хаагчид тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх зааврын 3.9.2-т заахдаа цахилгаан гүйдлээр цохигч бууг хүний биед 4-5 метрийн зайд хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар байрлалыг сольж, амьтанд 5 секундээс илүүгүй хугацаагаар хэрэглэнэ гэж тусгажээ. Энэ нь манай орон БНХАУ-аас цахилгаан гүйдлээр цохигч бууг импортоор оруулан ирж, төрийн тусгайлсан чиг үүрэг гүйцэтгэдэг байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа бөгөөд төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага ашиглаж байгаа хэрэгслийнхээ хүчин чадал дээр тулгуурлан холбогдох эрх зүйн актад цахилгаан гүйдлээр цохигч буугаар ямар зайд хэрхэн хэрэглэх талаар тодорхойлон тусгасан байна. Ингэж зааврaар хэрэглэх хүчин чадал тактик, техникийн өгөгдөхүүнийг тодорхойлж, зохицуулах шаардлагагүй бөгөөд тухайн хэрэгсэл хаана, ямар газар үйлдвэрлэснээс шалтгаалан хүчин чадал, тактик техникийн өгөгдөхүүн нь өөр байдаг тул хууль, зааврaар зохицуулах боломжгүй. Иймээс зарим тохиолдолд хэрэглэх тухайн тусгай хэрэгсэл нь зориулалт болон хүчин чадал, тактик техникийн өгөгдөхүүнээс шалтгаалан эрх зүйн актад тусгагдсан хэм хэмжээтэй зөрчилдөнө гэж бидний зүгээс үзэж байгаа юм.

Цагдаа, дотоодын цэрэг, ШШГБ заавар, журамдаа хориглосон хэм хэмжээг тусгаагүй байна. Харин хил хамгаалах байгууллага холбогдох зааврын 3.8.3-т “ ... хүний толгой, давсаг, бүсэлхий, бөөр, нэг газарт олон удаа цохих, гэмтэл, шарх үүсгэхийг хориглоно. Мөн зааврын 3.11.2 дахь хэсэгт алба хаагч резинэн ба хуванцар сумтай бууг хүний биеийн цээж, нуруу, гар, хөл, гуяны хэсэгт хэрэглэх бөгөөд нүүр, толгой /ил харагдах

[1] Ганбадрал,Н. Цахилгаан цочируулагч хэрэгсэл. Уб.,2008. 53 дахь тал

хэсэг/-н хэсэгт хэрэглэхийг хориглохоор тусгасан байх бөгөөд хуулиас гадна хуульчилсан актаар хориглосон хэм хэмжээг тусгасан байна.

Бусад тусгай хэрэгсэл хэрэглэх талаар Хил хамгаалах байгууллагын алба хаагчид тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх зааврын 3.12.1-т "Улсын хил хамгаалалтад орчин үеийн тусгай хэрэгслийг шинээр ашиглах тохиолдолд энэхүү зааварт нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэглэнэ"[1] гэж заажээ. Цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нэг бүрийн бусад тусгай хэрэгслийг хэрэглэх талаар заавар, журмуудад нэг ч заалт тусгагдаагүй бөгөөд энэ хэрэгсэлд ямар хэрэгслийг хамааруулж, хэрэглэх нь ойлгомжгүй байна.

Дүгнэлт. Хууль тогтоомжид зарим тусгай хэрэгсэл нь аль төрөл, ангилалд хамаарах нь тодорхой бус ойлгомжгүй байна.

Монгол Улсын хилийн тухай хуульд хилчин нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх тохиолдол тодорхой бус, ерөнхий тусгасан. Хуулиар нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх, хориглох тохиолдлыг тусгаж, эрх олгосон, хориглосон хэм хэмжээг дахин зааврааар зохицуулж, тусгасан нь хууль цаазын дээд хүчин чадал, шатлан захирах шинж алдагдсан байна.

Зааврын зарим хэм хэмжээ нь хуульд тусгасан нийтлэг шаардлагад нийцэхгүй, хилчин үүрэг гүйцэтгэх үед нэг бүрийн тусгай хэрэгслийн зарим төрлийн төрлийн хэрэгслийг хэрэглэх боломжгүй нөхцөл байдлыг тусгаж, хэрэглэх эрхийг нь бүрэн хязгаарлажээ. Мөн "Хил хамгаалах байгууллагын алба хаагч тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар"-т нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхэд анхаарах болон арга зүйн шинжтэй хэм хэмжээг тусгасан боловч, заасан болон үүрэг болгосон, хориглосон хэм хэмжээтэй хамтад нь тусгасан байна. Иймээс эрх олгож, үүрэг болгосон, хориглосон хэм хэмжээг хуулиар зохицуулах, иргэний эрх эрх чөлөөг хангахад чиглэгдсэн зааварчилсан хэм хэмжээг зааврааар баталгаажуулж, алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн техник,

[1] Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаал

технологийн болон арга зүй буюу тактикийн шинжтэй хэм хэмжээг Хил хамгаалах байгууллагын дарга эрх хэмжээний хүрээнд эрх зүйн актыг боловсруулж, баталгаажуулж, стандартчилах нь шаардлагатай гэж үзэж байна. Түүнчлэн хилийн аюулгүй, халдашгүй дархан байдлыг хамгаалахын зэрэгцээ алба хаагчдын хувийн аюулгүй байдал, эрх зүйн баталгааг сайтар хангахын тулд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль эрх зүйн актын холбогдох зарим зүйл, хэсэг, заалтад нэмэлт өөрчлөлт оруулж, боловсронгуй болгох шаардлагатай байгаа судалгаагаа нотоллоо.

Санал. Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын хилийн тухай хуулийн холбогдох/Хүч хэрэглэх/ зүйл, заалт, хэсэгтэй, холбогдох хуульчилсан актын зарим хэм хэмжээг нягтлан тулгаж, зөрүүтэй зохицуулалтыг гаргаж ирэх

2. Эрх зүйн орчин ижил төстэй улс орон болон өөрийн орны хууль сахиулах болон төрийн цэргийн байгууллагад хэрэгжиж буй ижил төстэй эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхтэй холбоотой заалтын зарим эрх зүйн хэм хэмжээний давуу болон сул талыг тодорхойлж, гаргах

3. Хууль, хуульчилсан актад байгаа үг хэллэг, нэр томьёог хэл зүйн хувьд, оновчтой тодорхойлон, холбогдох эрх зүйн актад тусгасан байдлыг өөрчлөх

4. Хил хамгаалах байгууллагын дарга өөрийн эрх хэмжээний хүрээнд хүч хэрэглэх аюулгүй байдлаа хангах стандарт боловсруулах замаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль тогтоомж, эрх зүйн акт

1. Эрүүгийн хууль. “Төрийн мэдээлэл сэтгүүл” дугаар №7. 2015 он.
2. Монгол Улсын хилийн тухай хууль. “Төрийн мэдээлэл сэтгүүл” дугаар №6. 2017 он.
3. Монгол Улсын ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246 дугаар тогтоолоор баталсан
4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Хил

хамгаалах байгууллагын алба хаагч тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар” батлах тухай 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаал

5. Хууль зүй, дотоод хэргийн сайд Улсын ерөнхий прокурорын хамтран “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар” батлах тухай 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/102, А/224 дүгээр тушаалын хавсралт
6. Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техникийг хэрэглэх заавар” батлах тухай 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/57 дугаар тушаал
7. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл галт зэвсэг хэрэглэх” журам батлах тухай 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/260, А/112 дугаар тушаал
8. Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/09 дүгээр тушаал

Гурав. Ном, сурах бичиг, гарын авлага

9. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. 1966 он Уб хот
10. Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. 2017он Уб хот.
11. Н.Ганбадрал. Цахилгаан цочруулагч хэрэгсэл. 2008 он Уб хот

Дөрөв. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил

12. С.Нямжав. “Цагдаагийн алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ” илтгэл. 2024 он Уб хот